5.4.3. Газар доорх усны дээж авах 18
5.5. Газар доорх усны түвшингийн хэмжилт 19
5.6. Гидродинамикийн сорьцлолт 19
5.6.1. Шавхах туршилт 19
5.6.2. Нэмэгдүүлэх туршилт 20
5.7. Судалгааны ажлын хэмжилт 20
5.8. Лабораторийн ажил 20
5.9. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ 24
5.10. Хог хаягдлыг тодорхойлох, тооллого хийх 25
5.11. Өгөгдлийн үнэлгээ 26
5.11.1. Судалгааны ажлын үнэлгээ, дүгнэлт 26
5.11.2. шавхах туршилтаар олсон өгөгдлийг тэмдэглэх, үнэлж дүгнэх 27
5.12. Сэлбэн засах арга хэмжээний талаар өгөх зөвлөмж 27

6. Чанарыг хангах асуудалд 28
7. Ажлын төлөвлөж буй цагийн хуваарь 28
8. Товчлолын тайлбар 29

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1 Судлагдаж буй тэмдэглэгдсэн талбайг нисэх онгоцноос авсан зураг

Хавсралт 2 2014 онд хэрэгжүүлсэн судалгааны ажлын план зураг

Хавсралт 3 Бохирдлын боломжит эх үүсвэрийг тэмдэглэсэн талбайн байдал

Хавсралт 4 Төлөвлөж буй судалгааны ажлын байдал

1. Өмнөх үг

Энэхүү баримтад Булган аймгийн Булган нэртэй талбайд хийгдэх судалгааны ажлын үйл явц, цар хүрээ тусгагдсан байна. Байгаль орчны бохирдлыг судлах зорилго бүхий энэхүү ажлыг тус талбайд урьд өмнө хадгалж, ашиглаж байсан пестицидээр өндөр хэмжээгээр бохирдсон талбайд хийхээр төлөвлөж байна.

Тус талбайд 2014 онд хийгдсэн урьдчилсан судалгааны үр дүнд пестицидийн бохирдол маш их байгаа нь тогтоогдсон**.**

Судалгааны ажлын төслийг 2005 оны 9 дүгээр сард БОЯ-ны Мэдээллийн 9-р дугаарт нийтлэгдсэн Байгаль орчны яамны бохирдсон талбайн судалгааны аргачлалын удирдамж, төслийн 1.1.2.-рт тусгагдсан ажилбарын хүрээнд боловсруулсан Бохирдсон талбайн судалгааны аргачлалын удирдамж тус тусын дагуу боловсруулан бэлтгэсэн. Үүнд мөн “Геологийн ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, үнэлж дүгнэх тухай” 369/2004 тоот тогтоолыг харгалзсан болно.

2. Талбайн тухай мэдээлэл

2.1. Ерөнхий мэдээлэл

Булган хот бол Монгол Улсын төв-хойд нутгаар оршдог Булган аймгийн захиргааны төв болохын зэрэгцээ Булган сумын төв юм. Улаанбаатараас баруун тийш 468 км-н зайд оршдог, 1938 онд байгуулагдсан Булган хот Дайчин вангийн хүрээний бууринд оршдог юм.

2008 оны мэдээллээр Булган сум 12 323 хүн амтай, Булган хотод 11 198 хүн амтай байна.

Булган хот Орхон голын өргөн уудам хөндийн баруун хойд энгэрт, голын зүүн эрэг дээр оршдог. Хотын зарим захын хэсэг голын баруун эрэг дээр ч тэлсэн байна. Зуслан болох дүнзэн байшин, түүний хажуудахь гэрүүд хотын хамгийн том талбайг эзэлсэн.

Судалгааны зорилго болох талбай Булган хотын төвөөс 500 м зайд оршдог. Хуучин мал эмнэлэг нийтийн худаг бүхий хоосон талбайн хажууд 50 х 70 м талбайг эзэлдэг. Орхон голоос баруун урагшаа 500 – 600 орчим м зайтай.

Хуучин мал эмнэлгийн талбайд урьд өмнө пестицидийг хадгалан ашигладаг байсан. Уугуан нутаг дэвсгэрт нь мал эмнэлгийн лаборатори, талбайтай хамт, амины сууцтай гурван талбай багтдаг. Мал эмнэлгийн лабораторийн баруун талд орших амины сууц, гэр бүхий талбай бохирдолд хамгийн ноцтойгоор өртсөн байна.

Мал эмнэлгийн хүрээнд 1990 орчим он хүртэл пестицидийн агуулах байсан гэлцдэг. Орос үйлдвэрийн пестицидийг энд 80-д оноос эхлэн хадгалдаг байсан ба тодруулбал, пестицидийг бохирдсон талбайн баруун хойд буланд (өнөөдөр хаягдсан барилга, барилгын үлдэгдэл) модон шалан дээр ил тавьсан байсан (60 л хуванцар торх, цаасан уут). Үүгээр барахгүй энд мөн мал эмнэлгийн креолин зэрэг ариутгалын уусмал хадгалдаг байсан. Олдсон мэдээллээр 1994 оноос хойш пестицид хадгалахаа больсон. Пестицидийн хэрэглээ жилд 2-с 4 тонн байсан гэж мал эмнэлгийн ажилтан мэдээлсэн юм. Хаягдсан бууринд лабораторийн эсвэл мал эмнэлгийн химийн бодис булсан байна гэнэ.

2.1.1. Эд хөрөнгийн өмчийн эрхийн асуудал

Хуучин талбай өнөөдрийн байдлаар хэд хэдэн талбай болгон хуваагдсан бөгөөд заримд нь хувийн эзэмшлийн амины сууц, гэр байна.

2.1.2. Талбайн одоогийн ашиглалт

Уг талбайг өнөөдөр хувь хүмүүс сууцны зориулалтаар ашигладаг юм. Талбайд барагцаалбал хэдэн арван хүн суудаг амины сууц, гэр байрладаг. Талбай нь Булган хотын барилгажсан хэсэгт оршдог юм.

2.1.3. Талбайд хүн амын оршин суугаа байдал

Хамгийн ихээр бохирдсон талбай дээр 3 өрх буюу насанд хүрсэн болон хүүхэд нийт 10 орчим хүн түрээсээр суудаг бөгөөд амины сууц, гэр, нэг хэсэг нь бас сууцны зориулалтаар ашиглагддаг нийтийн халуун усны газар байна. Амины сууц нисэх онгоцны буудлаас ойрхон байдаг худгаас буюу 5 орчим км газраас ундны усаар хангагддаг. Тухайн талбай дээр хувийн худаг байхгүй хэдий ч ойр орчимын байшин барилгыг баруун хойшоо 250 орчим м-н зайд 60-70 м гүнзгий худаг байдаг. Бусад худаг зүүн урагшаа 240 м, 330 м-н зайд тус тус оршдог юм.

Тухайн талбайн ойр орчим нэлээд их барилгажсан байгаа ба бохирдсон талбайн захаас холгүй шинэ сургуулийн барилгын ажил явагдаж байна. Хоёр жилийн өмнө талбайн хойд талд бороony ус зайлуулах шуудуу бетондож, шуудууны уртын дагуу шороон далан байгуулсан.

Тухайн талбайн баруун талд өөр хоёр байр бий. Наад талын байр эзэнгүй, цэцэрлэг бүхий цаад талын байранд жаахан хүүхэдтэй айл суудаг. Цэцэрлэгийн баруун хойд хэсэгт 4 х 3 орчим м бүхий талбай дээр ургамал маш хомс ургадаг. Модон хашааны нөгөө талд, гудам талаасаа хоёр бетон суурийн хавтан байгаа нь мэдэгдэж байгаа бөгөөд тэнд пестицидийн үнэр их хурц байна. Мал эмнэлгийн лабораторийн ажилтны мэдээлснээр пестицид хадгалдаг байсан тоосгон амбаар байсан газар юм.

2.2. Байгалийн нөхцөл байдал

2.2.1. Геоморфологийн болон уур амьсгалын нөхцөл

Тухайн газар Монголын төв нутагт оршдог тул өвөл, зуны болон өдөр, шөнийн температурын ялгаа их, хур тунадас багатай эх газрын уур амьсгалтай газар юм. Тухайн талбай, түүний ойр орчимд хээр талын газрын шинж чанартай байна.

Булган хот Орхон голын өргөн уудам хөндийн баруун хойд энгэрт оршдог бөгөөд гадаргын ихэнх хэсэг нь дөрөвдөгчийн хучилт болох химэрлэг (лёсс), химэрлэг шавар (хотын нутаг дэвсгэрт) зэргээс бүрдсэн байна. Хотын зарим хэсэг, түүний зах Орхон голын аллювийн хурдас дээр оршдог.

Судлагдах талбай голын хөндийн дээрх энгэрт оршдог.

2.2.2. Талбайн геологийн, гидрогеологийн болон гидрологийн тогтоц

Олдож байсан эх сурвалжаас тухайн талбайн геологийн, гидрогеологийн болон гидрологийн тогтоцын тухай дэлгэрэнгүй мэдээлэл олдоогүй. Доор дурдсан мэдээллэл газар дээр хийсэн үзлэг, судалгаа буюу тайлан дээр үндэслэсэн байна (MRAM – Ашигт малтмалын газар, 1998).

Тухайн талбайн гадаргуу нь дөрөвдөгчийн хурдасаас бүрдсэн бөгөөд дөрөвдөгч галавын хурдасын сууринд шинж чанарыг нь нарийвчлан тогтоогдоогүй пермийн үеийн хурдас байна. Хотоос баруун урд талын нутаг буюу Орхон голын баруун эрэг дээрх уул толгод 256-с 245 сая хүртэл настай исэглэн плутонийн чулуулгаар бүрдсэн байна.

Ус хотын нийт нутаг дэвсгэрээс Орхон гол руу шууд эсвэл голын салаагаар дамжин цутгадаг. Хүн суурьшсан хотын нутаг дэвсгэрт байнгын ямар нэг усны урсгал байхгүй боловч зарим хэсгээр бэхжсэн, хур тунадас ихтэй үед усаар дүүрдэг хэд хэдэн сайр байгаа нь ажиглагдсан.

Түүнчлэн гүехэн коллекторын газрын доорх усны урсгал Орхон гол руу буюу баруун урагшаа чиглэж байгаа бололтой. Олдож байгаа мэдээллийг үндэслэн голын дээгүүрх энгэр дэх хотын нутаг дэвсгэрийн ихэнх худгийг тэжээдэг арай гүн коллекторын усны урсгалын чиглэлийг таамаглах боломжгүй байна. Албан бус, аман мэдээллийн дагуу гүн коллектор 40-с 70 м гүн оршдог.

Судлах гэж буй талбай голын хөвөөний энгэрт оршдог бөгөөд жорлонгийн нүх ухах ажлын үед 2 м хүртэл гүнд ухсан ч гүехэн коллекторт хүрээгүй болно.

3. Судалгааны зорилго

Тус талбайд нарийвчилсан судалгааны төслийн гол зорилго нь бохирдлын эх үүсвэр, голомт, бохирдуулагч бодисын тархалтыг тогтоохын зэрэгцээ бохирдлын хорт нөлөөнд өртсөн байж болзошгүй бүлэг иргэд, экосистемийн бүрэлдүүлэгч хэсгийг тодорхойлж, тогтоогдсон эрсдэлийг багасгахад чиглэсэн арга хэмжээг санал болгоход оршино. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй судалгааны төсөл талбайн тухай дараах үндсэн мэдээллийг олж авах боломж олгоно. Үүнд,

- талбайн геологийн болон гидрогеологийн үндсэн шинж чанарыг тодорхойлох,
- бохирдлын эх үүсвэрийг баттай тогтоох,
- бохирдлын орон зайн тархалтын тухай мэдээллийг олж авах,
- бохирдлын хэмжээний тухай мэдээллийг олж авах,
- бохирдлын улмаас үүдэн гарч буй эрсдэлийг үнэлж дүгнэх,
- бохирдуулагч бодисын баллансыг тогтоох,
- бохирдлыг тархалтын нөхцөл байдлыг тогтоох,
- хийвэл зохих сэлбэн засах арга хэмжээг тодорхойлох,
- лабораторийн шинжилгээ хийх
- хийвэл зохих сэлбэн засах арга хэмжээний урьдчилсан туршилт,
- хийвэл зохих сэлбэн засах арга хэмжээний талаар зөвлөмж өгөх

Цооног, тоноглоогүй зондын байршлыг төсөл эхлүүлсний дараа талбай дээр үзлэг хийж, нөхцөл байдалтай нь танилцах явцад нарийн тодорхойлохоор төлөвлөж байна.

4. Талбайн өнөөг хүртэл судлагдсан байдал

Тус талбайн тухай мэдээллийг 2014 оны 5, 6 дугаар сард хийсэн асуулгын кампанит ажил, хээрийн судалгаагаас гадна Булган аймгийн захиргааны байгаль орчныг хамгаалах хэлтсийн дарга, одоогийн мал эмнэлгийн лабораторийн ажилтан, бохирдолтой талбайн түрээслэгч нартай хийсэн ярилцлагын үндсэн дээр цуглуулсан болно. Экологийн боломжит хорт нөлөөний талаас авч үзвэл тухайн талбай хангалтгүй судлагдсан гэж дүгнэвэл зохино.

4.1. Талбай дээрх бохирдлын эх үүсвэр

Пестицидийн бохирдлын эх үүсвэр гэвэл тухайн талбайд урьд өмнө пестицидийн хадгалалт, ашиглалт, түгээлт, хяналтгүй устган зайлуулсан байдал, түүнчлэн мал эмнэлэг үйл ажиллагаагаа зогсоох үед пестицидийг газар булсан зэрэг болно.

Судлагдах талбайн нутаг дэвсгэрт одоогоор илрээгүй бохирдлын эх үүсвэр болох булсан пестицид байж болзошгүй юм.

Бохирдсон талбай дээр пестицидийн хүчтэй үнэр ханхалдаг ба тэр нь борооны дараа улам хурц үнэртэнэ. Хамгийн их бохирдсон газар борооны ус урсан зайлах замд илэрсэн. Талбай дээр хийж гүйцэтгэсэн газар шорооны ажлын үед пестицидийг мэргэжлийн бус аргаар ухаж гаргасны улмаас резервуар орчимын газар бохирдсон байх магадлалтай. Пестицидийн бэлдмэлийн үлдэгдэл (өмхий үнэртэй цагаан өнгөтэй хатуу жижиг бүхэл хэсгүүд) ялангуяа бохирдсон талбайн зүүн урд буланд газар дээр байгааг харагдана.

4.2. Одоог хүртэл хийж гүйцэтгэсэн ажлын тойм

Судалгааны ажлын хүрээнд талбай дээр 2014.07.24-ний өдөр хөрсний 10, газар доорх усны 2 дээжийг тус тус авсан болно. Дээжлэлт хийсэн цэгүүд хоорондоо маш ойрхон байх учир тэдгээрийн GPS солбилцлыг тэмдэглээгүй (цэгүүдийн хоорондохь зай ашигладаг багажийн хэмжилтийн алдаанаас бага байна).

Хүснэгт 1. Булган талбай дээр урьдчилсан судалгааны хүрээнд авсан дээжийн тойм (2014)

Дээж	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинжилгээ	Тэмдэглэл
20SD1/1,0 20SD1A/1,0	1,0	ХМ, Hg-Cd, ОХП ХМ, Hg-Cd, ОХП	Зондыг талбайн зүүн урд талын булангийн борооны ус урсан зайлах газарт байрлуулсан. Хүрэн өнгөтэй шаварлаг-тоосорхог химэрлэг (лёсс) хөрстэй. Дээрээс тоосго, шил, модны ширхэгтэй материал зөөвөрлөн овоолсон – бага зэрэг үнэртэй. 1 м орчим

			гүнээс цагаан өнгөтэй өтгөрсөн эвгүй үнэртэй пестицидийн ширхэг олдсон.
20ST1	0 – 0,1	ОХП	1-с 1,2 м хүртэл гүнд өрөмдсөн дөрвөн зондын дээд хэсгээс авсан хөрсний холимог дээж (суурийн чулуулагт хайрга эсвэл том ширхэгт чулуу байсан тул цаашид өрөмдөх боломжгүй байсан). 5-р зондын газрын 15 см-н гүнээс пестицид илэрч, 2-рт зондын газрын гадаргын хавьд пестицидийн үнэр үнэртсэн.
20SD2/0-0,5	0 - 0,5	ХМ, Hg-Cd, ОХП	Талбайн зүүн урд булангийн усны шугам хоолойн холболтын хавьд байрлуулсан зондын хөрснөөс авсан холимог дээж. Пестицид 10-с 25 см-н гүнээс цаасан уутны үлдэгдэлийн хамт олдсон. Түүнээс илүү гүнд энд тэндгүй пестицидийн жижиг ширхэгүүд олдсон. Нийт хэсгээр пестицидийн сул үнэр мэдэгдэж байсан.
			Талбайн зүүн хойд буланд өрөмдөж хийсэн зонд – тус газарт зөвхөн баасны үнэр мэдэгдэж байгаа учир жорлон эсвэл амьтны ялгадас, бордоо хадгалах нүх байсан бололтой. Талбайн зүүн урд булангийн буюу талбайн гадна талд, мал эмнэлгийн лабораторийн модон хашаа, халуун усны барилгын хооронд газрын гадаргаас доош 0,4 м гүнд өрөмдөж хийсэн 8-р зонд. Борооны ус урсгалаар зайлдаг газар, газрын гадаргын орчмоос пестицидийн үлдэгдэл илэрсэн учир борооны усны урсгалаар зөөгдсөн бололтой.
20ST2	0 - 0,2	ХМ, Hg-Cd, ОХП	Хажуугийн талбайн хордсон ургамал ургадаг газарт өрөмдөж хийсэн хоёр зондын дээд хэсгээс авсан холимог дээж. Хоёр зондыг газрын гадаргаас доош 0,5 м гүн хүртэл өрөмдсөн. Тоосорхог, элсэнцэр хөрс, 30 см хүртэлх цайвар шаргал хүрэн, 30 м-с доош гүнд гумус хольц илүү ихтэй (үнэргүй) бор өнгөтэй байна. Газрын гадаргаас доош 0,5 м гүнд элсэн хайрга – цаашид өрөмдөх боломжгүй байсан.
20ST3 20ST3A	0 – 0,05	ХМ, Hg-Cd, ОХП ХМ, Hg-Cd	Бетон хоёр хавтангаас авсан тоос, бетоны холимог дээж (пестицидийн хурц үнэртэй) – модон хашаанаас 3 орчим м-н зайд, 20ST2-ны баруун талд, өөрөөр хэлбэл нийтийн шороон замд. Дээжийг дээжлэлтийн хоёр газраас авсан болно.
20SD3/0-0,5	0 – 0,5	ОХП	Бетон хавтангаас урд талд хучилтгүй замд байрлуулан өрөмдөж хийсэн зондоос авсан холимог дээж. Тоосорхуу хүрэн өнгөтэй шороо, 0,5 м-с гүнд бор өнгөтэй тоосорхог шавар (талбайн уг хэсэгт үнэр байхгүй).
20SD4/0-0,4	0 – 0,4	ОХП	Бетон хавтангийн хооронд хучилтгүй замд байрлуулан өрөмдөж хийсэн зондноос авсан холимог хөрсний дээж. Цайвар хүрэн тоосорхог шороо, 20 см-н гүнд пестицидийн үлдэгдэл илэрсэн (цагаан тоос), газрын гадаргаас доош 0,3 м гүнд бор тоосорхог

			шороо (нийт хэсгээр пестицидийн үнэртэй).
			Урд талын бетон хавтангийн доор, модон хашаанаас 1,4 м зайд бас нэг зондыг 0,6 м хүртэл өрөмдсөн. Дээд хэсэгт 10 см хүртэл гүнд шороотой, цаашид үнсний агууламжтай зөөвөрлөн авчирсан материал (пестицидийн сулхан үнэр), 0,6 м хүртэл гүнд үнстэй шороо.
20SD5/0,2-0,8 20SD5A/0,2-0,8	0,2 - 0,8	ХМ, Hg-Cd, ОХП ХМ, Hg-Cd	Бохирдсон талбайн баруун хойд буланд шороон хогийн цэгт өрөмдсөн зондоос авсан холимог хөрсний дээж. Хогийн хольцтой шавар тоосорхог шавартай. 0,7 м-с доош хайргархаг элсний хольцтой хүрэн, саарал шавар. jíl Нийт хэсгээр үнэр байхгүй хэдий ч өглөө, борооны дараа пестицид илт үнэртэж байсан.
			Хажуугийн талбай дээр, нурсан баригын нөгөө талд хаягдал бүхий талбайд 1,6 м гүн нүх ухаж гаргасан. Зөвхөн жорлонгийн ялгадасны үнэртэй. Хогийн цэгийн талбайд 3 зондыг 30 см-н гүн хүртэл ухаж гаргасан – үнэр байхгүй.
20ST4	0 – 0,1	ОХП	Борооны ус урсаж буй газар дахь хогийн цэгийн гадаргуунаас авсан хөрсний холимос дээж.
20SD6/0-0,4		ОХП	Мал эмнэлгийн барилга байрлаж буй талбайн баруун захын тэнд буюу бохирдсон талбайн зүүн урд буланд борооны ус урсаж залдаг газарт байрлуулсан, газрын гадаргаас доош 1,0 м гүнд өрөмдөж хийсэн зондоос авсан холимог хөрсний дээж. Нийт хэсгээр үнэр илрээгүй. 0,0-0,2 м – тоосорхог бор шавар 0,2-0,6 м –тоосорхог хүрэн шавар 0,6-1,0 м - лагийн хольц ихтэй тоосорхог бор шавар
			Түүнээс холгүй (хойшоо 3 орчим м-д) ижил төстэй профиль бүхий бас нэг зондыг өрөмдсөн – үнэр мэдэгдээгүй.
20GW1		ОХП, NEL, ХМ, Hg-Cd, ХАШШ	Бохирдсон газруудаас баруун хойшоо 250 орчим м-д баригдаж дуусаагүй сургуулийн барилгын цаана оршдог 40 орчим м гүн ерөнхий цооногоос авсан дээж.
20GW2		ОХП	Бохирдсон газраар дамжиж гардаг шугам хоолойгоор авдаг усны дээж. Усыг нисэх онгоцны буудлын тэндэх худгаас авдаг гэсэн. Ойр хавийн бусад (зүүн урагшаа 240 м, 330 м-д оршдог) худгаас газар доорх усны дээжийг авах боломжтгүй байсан.

4.2.1. Бохирдлын тогтоогдсон хэмжээ, түүний тархалт

Дараах хүснэгтээр 2014 оны урьдчилсан судалгааны хүрээнд тухайн талбай дээр авсан хөрс болон газар доорх усны дээжийн шинжилгээний зарим сонгомол дүн.

Хүснэгт 2. Хөрсний дээжид агуулагдсан органик хлорт пестицидийн хэмжээ

Үзүүлэлт	Нэгж	20SD1/1,0	20ST1	20SD2/0-0,5	20ST2	20ST3
1,2,3,4-тетрахлорт бензол	мг/кг-хуурай жин	6,11	0,114	9,38	0,506	0,121
1,2,3,5 болон 1,2,4,5-тетрахлорт бензол	мг/кг-хуурай жин	4,32	0,027	3,54	0,139	0,119
2,4-DDD	мг/кг-хуурай жин	3,33	0,435	7,53	0,361	0,118
2,4-DDE	мг/кг-хуурай жин	0,135	0,054	0,279	0,06	
2,4-DDT	мг/кг-хуурай жин	55,3	3,86	97,8	1,35	0,979
4,4-DDD	мг/кг-хуурай жин	11,7	1,53	32	1,89	0,449
4,4-DDE	мг/кг-хуурай жин	1,77	0,717	3,48	1,6	0,027
4,4-DDT	мг/кг-хуурай жин	168	25	283	3,03	4,64
DDD бүгд дүн	мг/кг-хуурай жин	15,03	1,97	39,53	2,25	0,57
DDE бүгд дүн	мг/кг-хуурай жин	1,91	0,77	3,76	1,66	0,03
DDT бүгд дүн	мг/кг-хуурай жин	223,3	28,86	380,80	4,38	5,62
Гексахлор бензол	мг/кг-хуурай жин		0,0056		0,0072	0,0051
HCH (α)	мг/кг-хуурай жин	862	310	1100	30,6	810
HCH (β)	мг/кг-хуурай жин	65,1	101	67,6	69,8	70,2
HCH (δ)	мг/кг-хуурай жин	736	29	243	2,64	74,6
HCH (ε)	мг/кг-хуурай жин	69,4	5,13	45,4		27,2
HCH (γ)	мг/кг-хуурай жин	1620	48,5	625	1,94	90,5
Пентахлор бензол	мг/кг-хуурай	92,9	0,013	29,7	0,043	

	жин					
Үзүүлэлт	**Нэгж**	**20SD3/0-0,5**	**20SD4/0-0,4**	**20SD5/0,2-0,8**	**20ST4**	**20SD6/0-0,4**
1,2,3,4- тетрахлорт бензол	мг/кг-хуурай жин	0,013	3,67			
1,2,3,5 болон 1,2,4,5-тетрахлорт бензол	мг/кг-хуурай жин		1,4			
2,4-DDD	мг/кг-хуурай жин	0,308	4,88	0,076	0,016	0,024
2,4-DDE	мг/кг-хуурай жин	0,138	0,519			0,013
2,4-DDT	мг/кг-хуурай жин	0,043	58,1	0,137	0,078	0,061
4,4-DDD	мг/кг-хуурай жин	0,769	20,4	0,037	0,025	0,102
4,4-DDE	мг/кг-хуурай жин	0,272	3,5	0,098	0,053	0,032
4,4-DDT	мг/кг-хуурай жин	0,056	183	0,454	0,105	0,14
DDD бүгд дүн	мг/кг-хуурай жин	1,08	25,28	0,11	0,04	0,13
DDE бүгд дүн	мг/кг-хуурай жин	0,41	4,02	0,1	0,05	0,05
DDT бүгд дүн	мг/кг-хуурай жин	0,1	241,1	0,59	0,18	0,2
Гексахлор бензол	мг/кг-хуурай жин				0,302	
HCH (α)	мг/кг-хуурай жин	4,92	877	1,3	1,71	1,28
HCH (β)	мг/кг-хуурай жин	12,3	42,7	4,14	0,095	2,11
HCH (δ)	мг/кг-хуурай жин	0,492	77,9	0,302	0,088	0,077
HCH (ε)	мг/кг-хуурай жин	0,51	31,2	0,237	0,0875	0,077
HCH (γ)	мг/кг-хуурай жин	0,259	246	0,75		0,0688
Пентахлор бензол	мг/кг-хуурай жин		6,02			

Хүснэгт 3. Хөрсөнд агуулагдах металлын хэмжээ (онцолж тэмдэглэсэн утгууд Монгол Улсын MNS 5850:2008 стандартын арга хэмжээ авах хязгаарын дээд утга буюу хүлцэх агууламжаас (Preaction value) хэтэрч байна)

Дээж	Элемент (мг/кг-хуурай жин)					
	As	**Cr**	**Cu**	**Ni**	**Pb**	**Zn**
20SD1/1.0	3,99	89,72	51,84	64,89	**140,90**	160,90
20SD2/0-0.5	5,49	100,60	69,31	76,77	**176,60**	188,10
20SD5/0.2-0.8	4,48	74,70	50,99	40,13	96,36	196,60
20ST2	**11,78**	65,57	43,47	34,61	24,79	144,30
20ST3	**11,11**	97,30	53,16	67,35	23,45	123,5

Органик хлорт пестицид, түүний дотор HCH, DDT, тэдний изомер ба метаболитууд, газрын гадаргуу төдийгүй газрын доорх нэлээд гүнээс авсан хөрсний бүх дээжид илэрсэн гэж үр дүн харуулсан. Ялангуяа амины сууц, гэр бүхий бохирдсон талбай, цаашид баруун талд байгаа зам дээрх суурийн бетон хавтангийн хавийн хөрсөнд агуулагдах хорт бодисын хэмжээ сэлбэн засах арга хэмжээ шаардагдах (Dutch standards) хэмжээнээс хэд дахин хэтэрсэн нь тогтоогдсон байна.

Тухайн талбайгаас авсан хөрсний дээжид агуулагдсан хар тугалга, мышъяк (хүнцэл)-ийн хэмжээ Монгол Улсын MNS 5850:2008 стандартын дагуу хүн ам оршин суух газар, хөдөө аж ахуйн эдэлбэр, газар тариалан, бэлчээрийн эдэлбэр газруудад мөрдөх зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс давсан байна. Хэдий тийм боловч Монгол Улсын эсвэл олон улсын дүрмийн дагуу аюултай агууламж (action value)-аас хэтрээгүй тул ноцтой бохирдолд тооцогдохгүй.

Газар доорх усны дээжид органик хлорт пестицид илрээгүй буюу өөрөөр хэлбэл бүх нэгдлүүдийн концентраци илрүүлэх хэмжээнээс доогуур байсан. Хэдий тийм боловч бохирдлыг ханаагүй бүсээс борооны усаар зайлан чулуулгийн орчин эсвэл гүехэн уст үед зөөгдөж болзошгүйг үгүйсгэх аргагүй юм.

Ерөнхий худгаас авсан газар доорх усны дээжид хар тугалгаас бусад уусдаг (металлын ажиглагддаг үндсэн багц) металл илрээгүй бөгөөд хар тугалгын концентраци нь газар доорх усанд түүний агуулагддаг хэмжээнээс хэтрээгүй ба ундны цэвэр ус түгээхэд ашиглагддаг материалаас чөлөөлдөг хар тугалгын хэмжээг зохицуулдаг Монгол Улсын MNS 900:2010 стандартаар заасан ундны цэвэр усанд хар тугалгын агууламж болох 0,01 мг/л-н түвшинд байсан юм.

Пестицидийн бохирдол газрын гадаргуунаас борооны ус зайлан ойр хавийн талбайд зөөгдөж, бороогүй үед тоос, тоосонцорыг салхиар хийсгэх замаар хүрээлэн буй орчинд хялбархан тархана. Бохирдлын тархах замыг дараах урьдчилсан концепци загвараар тайлбарлаж байна.

4.3. Бохирдлын урьдчилсан концепци загвар

Талбайн урьдчилсан судалгааны явцад олдсон мэдээллийн үндсэн дээр бид хуучин пестицидийн бэлдмэлийг хадгалж, ашигладаг байснаар зогсохгүй хяналтгүй булдаг байсан бололтой мал эмнэлгийн талбайн бохирдлын урьдчилсан концепци загварыг боловсруулсан.

Хорт нөлөөний өртөлтийн гарч болзошгүй бүх боломж, бохирдлын тархалтын замууд судлагддаг талбайн нөхцөл байдал, өнөөгийн болон төлөвлөж буй ашиглалт, бохирдлын тодорхойлсон боломжит эх үүсвэр зэрэгт хамааруулсан байна. Бохирдлын

үзүүлж болзошгүй гэж үзсэн нөлөөг бүх талаас нь харгалзсан тоймыг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулсан байна.

Хүснэгт 4. Судлагддаг талбайн урьдчилсан концепцийн загвар

Бохирдлын эх үүсвэр	**Тархах зам**	**Эрсдэл хүлээн авагч**	**Нөлөөний төрөл**	**Сонголтын үндэслэл**
Талбай дээрх бохирдсон хөрс	- (шууд нөлөө)	Тухайн талбай дээр оршин суудаг, хөрс шороотой харьцдаг хүмүүс хөрсний нөлөөнд өртсөн байдаг	Хөрс, шороо залгих Хөрс, шороо хүний арьсанд хүрч нөлөөлөх Тоос, тоосонцорыг амьсгалах Тарьж хураасан ногоо, жимс, үр тариа, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг идэж уух	Тухайн газарт удаан хугацаагаар амьдардаг хүмүүс бохирдсон хөрс, тоос тоосонцорын нөлөөнд өдөр бүр өртөж байдаг. Бохирдсон тоосонцор зөвхөн гадаа биш, дотор ч нөлөө үзүүлдэг. Бохирдлын хорт нөлөөнд ялангуяа хүүхэд, газар шорооны болон газар тариалан/цэцэрлэгийн ажил хийдэг хүмүүс илүү өртөж байдаг.
	Бохирдсон тоос, тоосонцор салхиар хийсгэнэ	Тухайн талбай дээр ажилладаг хүмүүс	Тоос тоосонцроор амьсгалах	Нийтийн халуун ус, мал эмнэлгийн лаборатори зэрэг газруудад ажилладаг хүмүүс байшингуудын дотор нэвтэрч ордог бохирдсон тоос, тоосонцроор амьсгалсны улмаас хорт нөлөөнд өртсөн байж болзошгүй.
		Тухайн газрын ойр орчимд амьдарч, ажилладаг хүмүүс	Тоос тоосонцроор амьсгалах Тарьж хураасан ногоо, жимс, үр тариа, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг идэж уух	Тухайн талбайн ойр холхи газарт суудаг хүмүүс хүрээлэн буй орчинд салхиар тархдаг бохирдуулагч бодисын нөлөөнд удаан хугацаагаар өртсөн байдаг. Түүний адилаар бохирдсон талбайн хажууд барьсан шинэ сургуулийн багш, сурагчид хорт нөлөөнд өртсөн байж болзошгүй.
		Мал сүрэг	Тоос тоосонцроор амьсгалах Тарьж хураасан ногоо, жимс, үр тариа идэж уух	Тухайн талбайн ойр холхи газарт бэлчдэг мал бохирдсон тоос, тоосонцроор амьсгалж, талбай дээр ургадаг ургамалыг иддэг. Пестицид мах, сүү, өндөгөнд хуримтлаж болзошгүй.
	Газрын гадаргуунаас усаар зөөгдөнө	Ойр орчимын талбайнууд	Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөө	Ялангуяа хүчтэй бороонд үед газрын гадаргууны хөрс ойр орчимд зөөгдөнө.
	Ханаагүй	Тухай газрын ойр орчимын	Газар доорх усны	Тухайн газрын бохирдол бороонд

	бүсээр дамжин газар доорх усанд зөөгдөж орно	усны эх үүсвэр	чанарт үзүүлэх сөрөг нөлөө	усаар зөөгдөж газар доорх усанд орсны улмаас нутгийн иргэдийн ундны усанд ашигладаг газар доорх усны чанар муудаж болзошгүй.

4.3.1. Хүний эрүүл мэнд, байгал орчинд үзүүлэх нөлөөний урьдчилсан үнэлгээ

Алдрин, ДДТ, диелдрин, эндосульфан, эндрин, гексахлор-циклогексан (HCH), линдон, гексанхлор-бензол (HCB), хлордан, метоксихлор, мирекс зэрэг органик хлорт пестицид бол байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд хамгийн хорт нөлөө бүхий пестицидийн бүлэгт багтдаг. Эдгээр бодисын ихэнх нь удаан задардаг органик бохирдуулагч (УЗОБ) зарим бодисыг багасгах зорилготой *Удаан задардаг органик бохирдуулагч бодисын тухай Стокгольмын конвенцийн* дагуу ноцтой бохирдуулагчид тооцогддог. Эдгээр бодис липофил чанар, химийн тэсвэр өндөртэй нийтлэг чанартай юм. УЗОБ бие организмд өөхлөг эд, элэг, тархи, булчин, бөөр, зүрх зэрэг дотоод эрхтэнд хуримтлагддгаас гадна эхийн сүүнд шингэж ордог. Ийнхүү хуримтлагдсан бодис гэнэт чөлөөлөгдсний улмаас бие организмд ноцтой хор хөнөөл учруулахаас эхлээд үхэлд хүргэх магадлалтай юм. УЗОБ-ын хордлогын улмаас сонсгол, хөдөлгөөний координаци ноцтойгоор гэмтсэн, элэг, бөөрөнд байнгын эмгэг өөрчлөлт ажиглагдана. УЗОБ-ын үүсгэдэг архаг хордлого, ялангуяа бие организмын хүнд хордлогын нөхцөлд төв мэдрэлийн системд хор хөнөөлтэй эмгэг үүсгэдэг.

Өнөө үед дээр дурдсан ихэнх бодисыг Европын холбооны хууль тогтоомжийн дагуу ашиглахыг хориглосон.

Тухайн талбайн нөхцөл байдалтай танилцаж, лабораторийн шинжилгээ хийсний үндсэн дээр хөрс хортой болох удаан задардаг органик хлорт пестицидээр өндөр хэмжээгээр бохирдсон байгааг нотлосны зэрэгцээ судлагдах газарт оршин суудаг буюу тодруулбал бохирдсон хөрстэй тогтмол холбоотой байдаг мал эмнэлгийн лабораторийн дэргэдэх бохирдсон талбай дээр оршин суудаг хүмүүсийн эрүүл мэндэд ноцтой нөлөөтэй болохыг тогтоосон. Мөн хөрстэй илүү их холбоотой байдаг ба бие организмын дархлаа нь гүйцэт хөгжөөгүй хүүхдүүдэд хор хөнөөл учруулж болзошгүй юм. Эрүүл мэндэд учруулах хорт нөлөө нь хөрсийг санаандгүй залгих, хөрс арьсанд хүрэх, бохидсон тоос тоосонцроор амьсгалах зэргээс гадна газар тариалангийн үр ногоо, жимс тариа / мал аж ахуйн бүтээгдэхүүн идэж, уух зэргээс үүдэлтэй юм.

Пестицид ойр орчимд хэрхэн тархах боломжтой гэвэл борооны усаар ойр хавийн талбайнуудад зөөгдөх эсвэл газар доорх усанд нэвтэрч орохоор зогсохгүй ялангуяа бороогүй үед салхиар хийсгэн тархах боломжтой.

Судлагдаж буй талбайн хаа нэг хэсэгт булсан пестицидийн бэлдмэл, эм тариа, химийн бусад бэлдмэл, бохирдсон хөрс болон барилгын бүтээц зэрэг одоогоор илрүүлээгүй бохирдлын голомт байх магадлалтай.

4.4. Урьдчилсэн судалгааны дүгнэлт

Хүн ам нягт суурьшсан хотын хэсэгт хортой болон удаан задардаг органик хлорт (ялангуяа HCH болон ДДТ-н изомер, метаболитууд илэрсэн) пестицидийн их хэмжээний бохирдол илэрнэ гэдэг бол ноцтой хэрэг бөгөөд тухайн талбайд бохирдлын байж болзошгүй өөр ямар нэгэн голомтыг илрүүлэх, бохирдсон хөрс, барилгын бүтээцийг зайлуулж хучилтын цэвэр материалыг зөөвөрлөх зэрэг сэлбэн засах арга хэмжээг хийж гүйцэтгэх зорилгоор нарийн судалгаа шаардагдана. Хорт хавдар үүсгэгч бохирдлын нөлөөнд шууд өртсөн оршин суугчид талбайг цэвэрлэх зэрэг зохих арга хэмжээ авах болтол өөр газар луу нүүж шилжих нь зүйтэй.

Сэлбэн засах арга хэмжээ (газар шорооны ажил)-г авах үед тоос тоосонцор ихсэх, ойр орчимын оршин суугчид төдийгүй бохирдсон хөрстэй ажиллах ажилчид улам ч хорт нөлөөнд өртөх эрсдэл гарахыг үгүйсгэхгүй тул сэлбэн засах арга хэмжээний ажилд оролцсон ажилчдыг хөдөлмөр хамгааллын тохиромжтой хэрэгслээр хангах, газар шороо, барилгын ажлын болон тээвэрлэлтийн явцад тоос тоосонцор ихсэхээс сэргийлэх үүднээс ус шүрших, ачааны машиныг зориулалтын даавуу, брезентээр битүүлэх шаардлагатай.

Түүнчлэн хуулсан бохирдсон материалыг хэрхэн зөөвөрлөж, зайлуулж аюулгүй байдлаар устгаж байгаа явдалд хараа хяналт тогтоох зайлшгүй шаардлагатай.

5. Хийж гүйцэтгэх ажлын дараалал

5.1. Талбайтай анхан шатны журмаар танилцах

Юуны түрүүнд бохирдсон талбайн нөхцөл байдалтай танилцна. Энэ үе шат дараах зорилготой байна. Үүнд,

- 2014 оны урьдчилсан судалгааны хүрээнд олж авсан өгөгдөл, мэдээллийг газар дээр нь шалгах,
- Тохиромжтой бүх гидрогеологийн объектыг тогтоох,
- Өрөмдлөгийн ажлыг төлөвлөх,
- Дээжлэлтийн төлөвлөгөөг зохицуулж, гүйцэт боловсруулах,
- Хүртээмжтэй бүх шинэлэг мэдээллийг олж авах

Талбайтай анхан шатны журмаар танилцах явцад олж авсан мэдээллийг талбайн нэмэлт судалгааны эцсийн тайланд тусгана.

5.2. Газар доорх инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг тогтоох

Өрөмдлөгийн болон судалгааны бусад ажлыг эхлүүлэхээс өмнө тухай талбайд газар доор инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг тогтооно. Тус талбайд газар доорх шугам, тэнд урьд өмнө байсан байшин барилга зэргийн суурийн үлдэгдэл байх магадлалтай юм. Газар доорх шугам сүлжээ байгаа эсэхийг зөвхөн өрөмдлөгийн цооног, гүехэн цооног зэрэг судалгааны ажил хийхээр төлөвлөж буй газарт шалгаж тогтооно.

5.3. Өрөмдлөгийн ажил

5.3.1. Судалгааны гүехэн цооног

Бохирдлын талбайн болон гүний хэмжээг тодорхойлохын тулд ханаагүй бүсэд өрөмдлөгийн судалгаа хийхээр төлөвлөж байх бөгөөд өрөмдлөгийн гүехэн судалгааны цооног өрөмдөнө. Цооногийн байршлыг 2014 оны талбайн урьдчилсан судалгааны үр дүнг үндэслэн тогтооно. Өрөмдлөгийн ажлыг талбайтай анхан шатны журмаар танилцах хүрээнд тодорхойлохоор төлөвлөж байна.

Судалгааны өрөмдлөгийн гүехэн цооног
Талбай дээр 3 м гүн хүртэлх буюу нийт 75 у.м бүхий нийт 25 судалгааны гүехэн цооног өрөмдөхөөр төлөвлөж байна. Судалгааны цооног өрөмдөх зорилгоор чөмгөн өрөмдлөгийн эсвэл тохиромжтой өөр систем ашиглана. Өрөмдсөн гүехэн цооног бүрийн гүний өөр өөр түвшингээс хөрсний хоёр дээж авна. Хөрсний холимог дээж авалт хоорондоо 0 – 0,5 м болон 1,5 – 3 м зайтай байхаар төлөвлөж байна (түүнээс илүү гүнээс дээж авах эсэх асуудлыг газар дээр нь геологич хөрсний үзлэг, органолептик дүгнэлт хийж шийдвэрлэнэ).

Судалгааны өрөмдлөгийн гүехэн цооногийн төлөвлөж буй байршлыг энэхүү төсөлд хавсаргасан газрын зурган дээр заасан байна. Өрөмдлөгийн ажлын байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах хүрээнд шинээр тогтоогдсон нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно.

Судалгааны гүехэн цооног өрөмдөх ажлын дараалал:

- Өрөмдлөгийн ажлыг эхлүүлэхээс өмнө талбай дээр төлөвлөсөн бүх гүехэн цооногийн байршлыг тодорхойлсон байна;
- Цооногийг чөмгөн өрөмдлөгийн эсвэл тохиромжтой өөр системийг ашиглан 60 – 110 орчим мм диаметр бүхий татангаар хийнэ;
- Татангийг (чөмгийг) шаардлагатай (3 м-с илүүгүй) гүнээс татаж авсны дараа татангаас чулуулгийн дээжийг гаргаж авна. Уг цилиндрт орсон чулуулгийн дээжийг геологч судалж үзнэ;
- Геологчийн тодорхойлж өгсөн гүний түвшингээс лабораторийн шинжилгээ хийхэд зориулсан хөрсний дээж авна;
- Дээж авалт, геологийн баримтжуулалт хийж дууссаны дараа судалгааны цооногийг хааж, газрын гадаргууг засч тэгшилнэ;
- Цооног бүрийг шороогоор дүүргэсний дараа хэмжилт шууд хийгээгүй тохиолдолд дараа нь хэмжилт хийх боломжтой болохын тулд уг газрыг гадаргуунд ялгаж болохуйц аргаар тэмдэглэнэ.

5.3.2. Гидрогеологийн судалгааны цооног

Талбай дээр нийт 120 у. м бүхий нийт 2 гидрогеологийн судалгааны цооног өрөмдөхөөр төлөвлөж байна (газар доорх усны түвшинд газрын гадаргуунаас холгүй хүрсэн тохиолдолд өрөмдлөгийн ажлыг газар доорх усны хөдлөнги /динамик/ дээжийг

авах боломжтой байдлаар дуусгаж, үлдсэн уртааш метрийг гидрогеологийн дараагийн объектыг өрөмдөхөд ашиглана). Геологийн судалгааны цооног бүрийг эргэлтэт чөмгөн эсвэл эргэлтэт-цохилтот өрөмдлөгөөр 60 орчим м-н гүн хүртэл өрөмдөхөөр төлөвлөж байна. Өрөмдлөгийн ажлыг 194 м-с доошгүй диаметр бүхий өрмийн чөмөглөгч/алхаар хийж гүйцэтгэнэ. Цооногийг 110 мм болон түүнээс илүү диаметртай ПЭ/ПВХ тоноглолоор тоноглоно. Цооногийн ёроолоос 0,5 м-н түвшин хүртэл болон дээд талаас 20 м хүртэлх тоноглол битүү байх ба үлдсэн хэсгийн тоноглолын профил нүхлэсэн байна. Тоноглолын цоолбортой хэсгийн эргэн тойрныг тохиромжтой материалаар дүүргэнэ. Газрын гадаргаас доош 20 м-н гүн хүртэлх тоноглолын битүү хэсгийг шаварлаг-цементэн дүүргэгчээр битүүмжилнэ. Цооногийг газрын гадаргаас дээш 0,5 м-н түвшинд гаргасан тагтай төмөр хамгаалагчаар тоноглох бөгөөд цооног бүрийн тэмдэглэгээг хамгаалагч дээр бичиж тэмдэглэнэ.

Цооног өрөмдөх үед аажим аажмаар асгасан хөрс шороонд геологч үзлэг хийж, дүгнэлт бичнэ.

Гидрогеологийн судалгааны цооногийн төлөвлөж буй байршил энэхүү төсөлд хавсаргасан газрын зурган дээр заагдсан байна. Гидрогеологийн судалгааны цооногийн байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах хүрээнд шинээр тогтоогдсон нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно.

Гидрогеологийн судалгааны цооногийн өрөмдлөгийн ажлын дараалал:

- Өрөмдлөгийн ажлыг эхлүүлэхээс өмнө талбай дээр төлөвлөсөн гидрогеологийн цооногийн байршил тодорхойлогдсон байна;
- Гидрогеологийн судалгааны цооногийг 194 м-с доошгүй диаметр бүхий эргэлтэт чөмгөн эсвэл эргэлтэт-цохилтот өрөмдлөгөөр хийнэ;
- Чөмгөн өрмийг цооногоос татаж авсны дараа дотор агуулагдсан материалыг берзент, хуванцар хавтан зэрэг заасан газарт гаргаж, геологич үзлэг хийж дүгнэлт гаргах ба шаардлагатай бол хөрсний дээж авна;
- Цооногийг 110 мм болон түүнээс илүү диаметртай ПЭ/ПВХ тоноглолоор тоноглогдох бөгөөд нүхлэсэн хэсгийн эргэн тойрныг нь 4-8 мм ширхэгтэй тохирох материалаар дүүргэнэ;
- Газрын гадаргаас доош 20 м-н гүн хүртэлх тоноглолын битүү хэсгийг шаварлаг-цементэн дүүргэгчээр битүүмжилж, цооногийг тагтай төмөр хамгаалагчаар тоноглох;
- Цооногийг тоноглосны дараа лагийг зайлуулна;
- Дараагийн шатанд цооногоос газрын доорх усны дээж авна;
- Бүх шинэ цооногуудад хэмжилт хийнэ.

5.3.3. Цооног хаах арга

Ханаагүй бүсийг судлах зорилгоор өрөмдсөн гүехэн цооногуудыг хөрсний дээж авч, литологийн найрлага судалж дүгнэлт хиймэгц хаахаар төлөвлөж байна. Судалгааны

гүехэн цооногуудыг ууган материалаар дүүргэж шавар-цементэн дүүргэгчээр битүүмжилнэ.
Гүн цооногуудыг цаашдын хяналт мониторинг хийх зорилгоор үлдээнэ (газрын гадаргуунаас дээш гардаг түгжээтэй ган хамгаалагчаар тоноглогдсон).

5.4. Дээжлэлтийн ажил

Дээжлэлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөө буюу дээж авах газрын байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах үе шатны үр дүнг үндэслэн тодорхойлно. Дараагийн бүлэгт матриц тус бүрээс авах дээжийн тоо хэмжээг багтаасан дээжлэлтийн төлөвлөгөө орсон байна. Цаашдаа шинэчлэгдсэн дээжлэлтийн төлөвлөгөөнд дээжлэлтийн газрын байршил, дээж авах гүн зэргийг тодруулж болно.

Дээж авах тухай тэмдэглэл (“дээж авсан тухай протокол”) хөтөлж, хавсралтад газрын өндрийн хэмжээ, фото баримт бүхий дээжлэлтийн газрын план зураг оруулна. Дээжийг лабораторид хүлээлгэн өгсөн тухай “дээж хүлээлгэн өгсөн протокол” үйлднэ.

Судалгааны ажлын хүрээнд хөрс, барилгын хийц, бүтээц, газар доорх усны дээжлэлт хийхээр төлөвлөж байна.

Нийт дээжийн 5 % дээжийг давхар авна. Ямар дээж дээж давхар авах шаардлагатай тухай шийдвэрийг авсан дээжийн органолептик шинжилгээний үндсэн дээр авна. Эдгээр дээжийн шинжилгээ аналитик ажлын чанарын хяналтын магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ.

5.4.1. Хөрсний дээж авах

Хөрсний дээжийг судалгааны гүехэн цооног, газрын гадаргаас авна. Судалгааны ажилд оролцсон геологчийн шийдвэрээр 3,0 м гүн хүртэл хийхээр төлөвлөсөн судалгааны гүехэн цооног тус бүрээс хоёр дээж авна.

Хяналт мониторингийн сүлжээг нэмэгдэх, бохирдлын талбайн хэмжээг тодорхойлох үүднээс газрын гадаргаас дээж авах юм. Дээжийг цэгэн дээж хэлбэрээр авна. Газрын гадаргаас авах дээжийн байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах үзлэгийн дараа тодорхойлно.

Дээжлэлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөө буюу дээж авах газрын байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах үе шатны үр дүнг үндэслэн тодорхойлно. Тухайн талбайгаас судалгааны гүехэн цооногоос нийт 20 дээж, газрын гадаргаас 20 дээж тус тус авахаар төлөвлөж байна.

Гүехэн цооногийн дээжийг чөмгөн өрөм, өрөмдлөгийн багажийн татанга эсвэл гар дээж авагчаар эвдсэн дээж хэлбэрээр авна. Гүний түвшингийн шаардлагатай зайнаас авсан материалыг нэг газарт асган жигд хутган нэгэн төрөл гомоген материал үүсгэнэ. Дараагийн шатанд квартацийн аргаар авагдах эцсийн гомоген дээж үүсгэнэ. Дээжлэлтийг тодорхой гүний интервалаар тэмдэглэнэ. Дээжийг тэмдэглэл бүхий шошготой дээжийн шилэн саванд хийнэ.

Хөрсний дээжийг хөргөх хайрцагт хийж дараах шинжилгээ хийлгэх зорилгоор магадлан итгэмжлэгдсэн лабораторид илгээнэ. Үүнд,

- сонгосон дээжүүдэд ОХБ, хүнд металл (Pb, Cd, (Hg), As, Cr, Cr^{VI} , Zn, Co, Ni, Cu, Sr, V)-ын хэмжээ тогтоох шинжилгээ – агууламж нь мөрдөгдөж буй Монгол Улсын MNS5850 : 2008 стандартын дагуу тодорхойлно.

Ашигласан жоотуу, шүүр, бийр зэрэг бүх багаж, хэрэгслийг дараагийн дээж авахаас өмнө сайтар цэвэрлэн ариутгаж, шаардлагатай тохиолдолд шинэ хэрэгсэл ашиглана.

5.4.2. Барилгын хийц, бүтээцийн дээж авах

Талбай дээр урьд өмнө пестицид хадгалдаг байсан объектуудын суурийн бүтээц үлдсэн тухай мэдээлэл байгааг харгалзан дээрх хийц, бүтээцийн дээж авах шаардлагатай байна. Судалгааны ажлын хүрээнд барилгын бүтээцийн 5 дээж авахаар төлөвлөж байна.

Барилгын бүтээцийн дээж холимог дээж болгож авах бөгөөд дээжийг бүтээцийн ил хэсгийн гадаргуунаас авна. Холимог дээжийг стандарт журмын дагуу үүсгэх буюу тодруулбал сонгож авсан материалыг цэвэр саванд хольж хутгаад 3 орчим см-с том ширхэгийг зайлуулсны дараа квартацийн аргыг ашиглана. Ийм дараалыг шаардагдах эзлэхүүн бүхий дээжийг үүсгэх болтол давтаж хийнэ.

Барилгын хийцийн дээжийг хөргөх хайрцагт хийж дараах шинжилгээ хийлгэх зорилгоор магадлан итгэмжлэгдсэн лабораторид илгээнэ. Үүнд,

- сонгосон дээжүүдэд ОХБ, хүнд металл (Pb, Cd, (Hg), As, Cr, Cr^{VI} , Zn, Co, Ni, Cu, Sr, V)-н хэмжээ тогтоох шинжилгээ – агууламж нь мөрдөгдөж буй Монгол Улсын MNS5850 : 2008 стандартын дагуу тодорхойлно.

5.4.3. Газар доорх усны дээж авах

Ханасан бүсийн хувьд судалгааны ажил тухайн талбайн газрын доорх усны коллекторын усны чанарыг тогтоох эсвэл бохирдлыг илрүүлэх зорилготой.

Талбай дээр байгаа гидрогеологийн объектоос (1 дээж), гидрогеологийн судалгааны шинэ цооногоос (2 дээж) тус тус газар доорх усны дээж авах бөгөөд тухайн талбайгаас газар доорх усны нийт 3 дээж авахаар төлөвлөсөн байна.

Гидрогеологийн цооногоос газар доорх усны дээжийг хөдлөнгө (динамик) аргаар авна. Одоо байгаа цооногоос дээж авахаас өмнө хэрэглэж болох байдал, гүн, лаглайсан, зэвэрсэн байдал, тоноглолын бүрэн бүтэн байдал, хамгааллын бэхэлгээний байдал зэрэг техникийн байдлыг шалгана. Шланг, насос зэргийг дээжлэлт бүрийг эхлүүлэхээс өмнө цэвэр усаар зайлан цэвэрлэж, шаардлагатай үед шинэ шланг, насосыг хэрэглэнэ.

Дээжлэлтийн явцад насосны соролт цооногийн усны баганын 2/3 орчим гүнд суулгана. Ус шавхах үед усны ууссан хүчилтөрөгч, дамжуулах чадвар, pH зэрэг физик, химийн үзүүлэлтүүдийг тогтмол хэмжих бөгөөд (± 0,1 pH, цахилгаан дамжуулах чадвар ± 10 %, температур ± 0,2 °C, исэлдэл-ангижралын түвшин, ууссан хүчилтөрөгчийн агууламж) үзүүлэлтүүд тогтсоны дараа лабораторийн зааврын дагуу дээжийн саванд газар доорх усны дээжийг авна.

Газар доорх усны дээжийг хөргөх хайрцагт хийж дараах шинжилгээ хийлгэх зорилгоор магадлан итгэмжлэгдсэн лабораторид илгээнэ. Үүнд.

- сонгосон дээжүүдэд ОХБ, хүнд металлыг (Al, Sb, As, Ba, Be, B, Br, Cd, $Cr_{нийт}$, Cr^{VI}, Cu, Fe, Pb, Mn, Hg, Mo, Ni, Se, Ag, Th, U, V a Zn) - агууламж нь мөрдөгдөж буй Монгол Улсын MNS5850 : 2008 стандартын дагуу тодорхойлж ГДУХАШШ хийнэ.

Газар доорх усны хөдлөнги дээжлэлтийн хүрээнд хээрийн тохиромжтой багажийн тусламжтайгаар температур, pH, цахилгаан дамжуулах чадвар, чөлөөт O_2, Eh зэрэг усны физик, химийн үзүүлэлтийн хэмжинэ.

5.5. Газар доорх усны түвшингийн хэмжилт

Тухайн талбайн гидрогеологийн шинж чанарыг тодорхойлох, газар доорх усны урсгалын чиглэлийг тогтоох, шаардлагатай газрын зураг бэлтгэх зорилгоор тухай талбайд, түүний ойр орчимд хэмжилт хийж болох гидрогеологийн бүх объектод газар доорх усны түвшингийн хэмжилт хийнэ. Газар доорх усны чөлөөт гадаргууг газар доорх усны түвшин тогтворжсоны дараа хуучин, шинэ аль ч цооногуудад хийнэ. Хэмжилтэнд гадаргуу хэмжигч ашиглана.

5.6. Гидродинамикийн сорьцлолт

Тус талбайд хийгдэх гидродинамикийн сорьцлолтийг 12 + 6 цагийн горимд хийж гүйцэтгэнэ. Сорьцлолт талбайгаас бохирдуулагч бодисын байж болзошгүй тархалтыг харгалзах, сэлбэн засах арга хэмжээг санал болгох үүднээс гидравлик тооцоо болон загварчлалд шаардагдах үндсэн үзүүлэлтийг тогтооход зориулагдана.

5.6.1. Шавхах туршилт

Шавхах туршилтын гол зорилго шүүлтийн илтгэлцүүр *k*, бүүрцын хүнхээлийн радиус *R* зэргийг бодоход шаардлагатай гидравлик утгуудыг тогтооход оршино. Туршилт шавхалтын үр дүн гидрогеологийн цооног/худгийг аль болох их хэмжээгээр ашиглах (цутгаж буй усны тохиромжтой хурдацтай нөхцөлд шавхагдах усны хэмжээ) бололцоог хангах үүднээс нөхөн сэргээлтийн горимыг санал болгох боломж олгодог.

Уг арга хамгийн найдвартай үр дүнг өгдөг усны түрэлттэй горимд зориулан боловсруулагдсан боловч уст үеийн зузаантай харьцуулвал шавхагдах үед газар доорх усны түвшин бага хэмжээгээр буурсан тохиолдолд усны чөлөөт гадаргууны горимд ч ашиглагддаг. Уг аргаар хэмжилт хийх зорилгоор хоёроос доошгүй объектыг согоно: шавхагдах цооног болон усыг нь шавхаж буй цооногоос ойрхон шавхагдсан үеийн түвшингийн хэмжилт хийх бололцоо олгож байгаа нэг эсвэл нэгээс илүү цооног. Насос нь шавхах туршилтын үед тогтмол, урьдчилан тохируулсан хүчин чадалтай ажиллана. Туршилтын явцад шавхагдсан усыг чөлөөтэй газар асгана.

Шавхах туршилт хийх үе шат:

- Ажил эхлэхээс өмнөө шавхагдах болон хяналтын цооногуудад, хэмжилт хийх объектод газар доорх усны түвшингийн хэмжилт хийнэ;
- Ус шавхахад тохиромжтой үзүүлэлт бүхий гүний насос ашиглан цооногийн ул сууриас дээш 1,0 м-н түвшинд байрлуулна; насосны хүчин чадлыг цооногийн таамагласан ундаргын дагуу тохируулан туршилт хийх хугацаанд өөрчлөлтгүй тогтмол ажиллуулна;
- Шавхагдах болон ойр хавийн хяналтын цооногуудын усны түвшингийн өөрчлөлтийг туршилт шавхалтын үр дүнд өгөх үнэлгээг харгалзан урьдчилан тодорхойлсон цаг хугацааны зайтай даталогероор хэмжинэ;
- Газар доорх усны түвшингийн хяналтын хэмжилтийг гадаргуу хэмжигчээр хийнэ (жишээ нь, G-50);
- Шавхах туршилтын явцад тохиромжтой багажаар (жишээ нь, сонгомол электрод бүхий WTW Multi 340i) температур, pH, цахилгаан дамжуулах чадвар, чөлөө хүчилтөрөгчийн агууламж, исэлдэл-ангижралын түвшинг зэргийн хэмжилт хийнэ.

5.6.2. Нэмэгдүүлэх туршилт

Шавхах туршилт хийж дуусмагц ус нэмэгдүүлэх туршилтыг хийнэ. Ус шавхалтыг зогсоосны дараа тодорхой заасан хугацааны зайтай судалгааны бүх объектод (2 орчим объект) газар доорх усны түвшин нэмэгдэх байдлыг хянан тэмдэглэнэ. Шавхах туршилтын адилаар усны түвшингийн өөрчлөлтийг даталогер эсвэл гадаргуу хэмжигчээр хэмжинэ. Нийтдээ тус талбайд шавхах туршилт болон ус нэмэгдүүлэх 2 туршилтыг хийхээр төлөвлөж байна.

5.7. Судалгааны ажлын хэмжилт

Судалгааны бүх ажлыг GPS-н тусламжтайгаар хэмжинэ. Хэмжсэн утгууд газрын зураг бэлтгэх зорилгоор ашиглана. Гидрогеологийн гүехэн болон судалгааны бүх цооног, дээж авсан бүх цэгүүдийг хэмжих бөгөөд цаашид тэмдэглүүштэй баримжааллын цэг, бохирдлын эх үүсвэр зэргийг хэмжинэ.

5.8. Лабораторийн ажил

Лабораторийн бүх шинжилгээ магадлан итгэмжлэгдсэн аргаар хийгдэнэ. Монгол Улсад шаардагдах мэргэжлийн тусгай шинжилгээ бүрэн хэмжээгээр хийх чадвартай лаборатори байхгүй тул лабораторийн ажлыг өөр улсад хийх боломжтой.

Дээжийн шинжилгээний цар хүрээ, төрөл зүйлийг дараах хүснэгтээр харуулсан байна. Шинжилгээний цар хүрээ, судлагдах бодис, үзүүлэлт зэрэг тухайн талбай, түүний бохирдлын шинж чанарын талаарх одоог хүртэл цуглуулсан мэдээлэл дээр үндэслэсэн байна.

Хүснэгт 5. “Булган” тайлбайгаас төслийн ажлын хүрээнд матриц тус бүрээс авсан дээжийн төлөвлөж буй лабораторийн шинжилгээний тойм

Үзүүлэлт	Тодорхойлолтын тоо (ш)	
	Хөрс, барилгын бүтээц	Газар доорх ус
Хүнд металлуд	75 (+ 4 давхар)	3 (+ 1 давхар)
ОХП	75 (+ 4 давхар)	3 (+ 1 давхар)
Газар доорх усны анхан шатны шинжилгээ (ГДУХАШШ)	0	3 (+ 1 давхар)

Матриц тус бүрээс авсан дээжийн бохирдлын шалгагддаг үзүүлэлтийг тогтоох зорилгоор ашиглах аргуудын тойм хүснэгт 6, 7-рт харуулсан байна.

Хүснэгт 6. Хөрс, барилгын хийц, бүтээц зэрэг хатуу матрицын дээжийн шинжилгээний аргын тойм

Судлагдах үзүүлэлт	Аргын зарчим
Хүнд металлууд	Индукцийн холбоот плазмт цөмийн эмиссийн спектрометр (ИХПОЭС-ийн арга) нь цөмийн эмиссийн тусламжтайгаар элементийг илрүүлэх, тодорхойлох зориулалттай хэмжилтийн техникийн хэрэгсэл юм. Шинжилж буй уусмалыг перисталтик шахуургаар мананжуулагч руу шавхах үед үүссэн аэрозолийг зөөгч хийгээр индукцийн холбоот плазмт (ИХП) зөөнө. Мэдрэгчийн тусламжтайгаар спектрометрийн оптик торонд ИХП-н цахилалтын дисперзийнх нь дараах ялгаруулсан цацралтыг судлана. Уг арга ISO 11855, US EPA 200.7 стандарт дээр үндэслэсэн байна.
ОХП	Дээжийг органик уусгагчаар механик сэгсрэлтийн тусламжтайгаар хандлана. Ингэснээр олж авсан хандыг эцсийн эзлэхүүнд хүртэл азотын урсгалаар баяжуулна. Хандын хэмжилтийг GC/ECD-аар хийнэ.

Хүснэгт 7. Газар доорх усны дээжийн шинжилгээний аргын тойм

Судлагдах үзүүлэлт	Аргын зарчим
Хүнд металлууд	Индукцийн холбоот плазмт цөмийн эмиссийн спектрометр (ИХПОЭС-ийн арга) нь цөмийн эмиссийн тусламжтайгаар элементийг илрүүлэх, тодорхойлох зориулалттай хэмжилтийн техникийн хэрэгсэл юм. Шинжилж буй уусмалыг перисталтик шахуургаар мананжуулагч руу шавхах үед үүссэн аэрозолийг зөөгч хийгээр индукцийн холбоот плазмт (ИХП) зөөнө. Мэдрэгчийн тусламжтайгаар спектрометрийн оптик торонд ИХП-н цахилалтын дисперзийнх нь дараах ялгаруулсан цацралтыг судлана. Уг арга ISO 11855, US EPA 200.7 стандарт дээр үндэслэсэн байна.
ОХП	Дээжийг органик уусгагчаар механик сэгсрэлтийн тусламжтайгаар хандлана. Ингэснээр олж авсан хандыг эцсийн эзлэхүүнд хүртэл азотын урсгалаар баяжуулна. Хандын хэмжилтийг GC/ECD-аар хийнэ .

ГДУХАШШ	Ионы хроматографийн (ИХ) аргаар ус дахь хлорид, нитрат, сульфатын агууламжийг тоогтооно (ČSN EN ISO 10304-1, ČSN EN ISO 10304-2 зэрэг стандартын дагуу). Шинжилгээ хийх үед 0,45 μм хэмжээ бүхий сүвшилтэй шүүлтүүрээр шүүсэн эсвэл зохих ёсоор шингэрүүлсэн 30 μл-н дээж ашиглана. WATERS компанийн ионы хроматограф дээжийн хэсэг, ионы солилцооны багана (клонк), хөдлөнгө фазын дамжуулах чанарыг дардаг супрессор (карбонат, гидроген карбонатын хольц), цахилгаан дамжуулах чадварын мэдрэгч, хроматографыг дижитал хэлбэрээр дүрслэдэг компьютер зэргээс бүрддэг. Компьютерийн программ эхлээд ион тус бүрийн зохих оргилын талбайг үнэлээд урьдчилан хэмжсэн калибрацийн муруйг ашиглан мг/л-д агуулагдсан шинжилж буй бодисыг агууламжинд хөрвүүлж тооцно.
	Ус дахь нитрит, аммиак, аммонийн ион, сульфатын агууламжийг тогтмол урсгалын (CFA) шинжилгээгээр тогтооно (ČSN EN ISO 13395, ČSN EN ISO 11732 стандартын дагуу). Гараар хийх спектрометрийн болон бусад аргыг автоматчилсан тогтмол урсгалын (CFA) шинжилгээ нитрит (эсвэл нитрит, нитратын нийт агууламж), аммиак, аммонийн ион, сульфатын агууламжийг тогтооход ашиглагддаг. 0,45 μм хэмжээ бүхий сүвшилтэй шүүлтүүрээр шүүж зохих хэмжээгээр шингэрүүлсэн шинжилж буй усны дээжийг SKALAR компанийн SAN PLUS SYSTEM-ийн шинжилгээний анализаторын autosampler-т байрлуулна. Анализаторын химийн нэгжид дээжийн шавхагдаж буй уусмалд янз бүрийн бодис нэмж, янз бүрийн урвал явагдсны эцэст үүссэн шингэний найрлага, агууламж фотометрийн аргаар тодорхойлно.
	pH, хүчлийн саармагжуулах чадвар - шүлтлэг, шүлтлэгийн саармагжуулах чадвар – хүчилшил зэргийг тогтоох, нүүрстөрөгчийн давхар ислийн хэлбэрийг тооцоолох. pH-г лабораторийн (ČSN ISO 10523) эсвэл хээрийн (ČSN ISO 10523) нөхцөлд тодорхойлоход дэлхийн тэргүүний үйлдвэрлэгчийн (WTW эсвэл Hanna Instruments) pH-метрийг ашигладаг. Хүчлийн (ČSN EN ISO 9963-1) эсвэл шүлтлэгийн (ČSN 75 7372) саармагжуулах чадварыг тогтооход дээжийн сав бүхий автомат ажиллагаатай титратор эсвэл Metrohm компанийн үйлдвэрлэсэн гарын ажиллагаатай титратор хэрэглэнэ. Хэмжиж тогтоосон хүчилшил, шүлтлэгийн утгуудаас ČSN 75 7373 стандартын дагуу гидроген карбонат, карбонат, чөлөөт эсвэл идэвхтэй нүүрстөрөгчийн давхар ислийн агууламж тооцоолдог.
	Спектрофотометрийн гар ажиллагаатай аргууд Шинжилж буй шингэнийг тохиромжтой урвалжтай хольсноор үүссэн нэгдлийн өнгөний хурц тод байдлын хэмжилт дээр суурилуулсан спектрофотометрийн арга нэлээд хэдэн үзүүлэлтүүдийг тогтооход зориулалттай эцсийн арга болж хэрэглэгддэг. Үүнд фосфат эсвэл нийт фосфорын (ČSN EN ISO 6878) агууламж, марганц хүчлийн давсын химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн хэмжээг (ČSN EN ISO 8467) тодорхойлно.
	Дээжийн цахилгаан дамжуулах чадварыг лабораторийн (ČSN EN 27888) эсвэл хээрийн (ČSN EN 27888 стандартын дагуу) нөхцөлд дэлхийн тэргүүлэгч үйлдвэрийн кондуктометрээр хэмждэг. Усанд ууссан хүчилтөрөгчийн агууламжийг (ČSN EN 25814) оксиметрээр хэмждэг. Усанд ууссан бодисын агууламж буюу нийт эрдэсжилтийг гравиметрийн аргаар тогтоодог бөгөөд усны булингарыг (ČSN EN ISO 7027 стандартын дагуу) нефелометрийн аргаар тогтооно.

	Фторитуудын агууламжийг ион сонгомол электродын тусламжтайгаар тодорхойлох Фторитуудын агууламжийг тогтооход тохиромжтой pH-метрт холбогдсон ион сонгомол электродыг ашиглана (ČSN ISO 10359-1 стандартын дагуу).

Матрицын төрөл бүрээс авсан дээжийг талбайн нөхцөлд лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэх лабораторийн зааврын дагуу бохирдлын судлагдах үзүүлэлтүүдээс хамааран сонгосон дээжийн саванд хадгална. Дээжийн зөвлөхүйц хэмжээ, матрицийн дээжийн төрөл тус бүр, бохирдлын судлагддаг үзүүлэлтүүдээс хамааран хэрэглэдэг дээжийн савны тойм 8-р хүснэгтээр харуулсан байна.
Дээжийг хээрийн нөхцөлд бохирдлын судлагдах үзүүлэлтүүдээс нь хамааран шинжилгээ хийж гүйцэтгэх лабораторийн заавар, шаардлагын дагуу бэлтгэн боловсруулна. Хээрийн дээжийг бэлтгэн боловсруулахад зөвлөж буй шаардлагыг 9-р хүснэгтээр харуулсан байна.

Хүснэгт 8. Дээжийн сав, хатуу матрицаас авсан дээжийг хээрийн нөхцөлд бэлтгэн боловсруулах тухай

Судлагдах үзүүлэлт	**Матриц**	**Дээжийн бэлтгэл/хадгалалт**	**Дээжийн эзлэхүүн, дээжийн сав**
Хүнд металлуд	Хөрс, барилгын бүтээц	Дээжийг фракцийн 3 см болтол буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарах), сэрүүн харанхуй нөхцөлд хадгалах	0,2 кг, шил
ОХП		Дээжийг фракцийн 3 см болтол буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарах), сэрүүн харанхуй нөхцөлд хадгалах, эргүүлж таглах тагтай байх шаардлагатай	0,2 кг, шил

Хүснэгт 9. Дээжийн сав, газар доорх усны дээжийг хээрийн нөхцөлд бэлтгэн боловсруулах тухай

Судлагдах үзүүлэлт	**Матриц**	**Дээжийн бэлтгэл/хадгалалт**	**Дээжийн эзлэхүүн, дээжийн сав**
Хүнд металлуд	Газар доорх ус	ПЭ, хөргөлт < 8°C	250 мл, ПЭ
ОХП		боловсруулах шаардлагагүй	бараан өнгөтэй шил; 0,5 л
ГДУХАШШ		боловсруулах шаардлагагүй	1л, ПЭ

5.9. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ

Судалгааны ажлын үр дүн эрсдэлийн судалгаа, бохирдлын тархалтын үнэлгээ боловсруулах зорилгоор ашиглана. Эрсдэлийн судалгааны зорилго нь хүний эрүүл мэнд, байгаль орчны бүрэлдүүлэгч хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлж, сэлбэн засах арга хэмжээний эцсийн параметрийн төсөл гаргахад оршино.

Эрсдэлийн судалгаанд дараах асуудал орно. Үүнд,:

- Хорт нөлөөнд өртөлтийн бодит байдал, хорт нөлөөнд өртөж болзошгүй хүн амын бүлэг, экосистемийн хэсэг.
- Хүний эрүүл мэндэд үзүүлэх хорт нөлөө, өртөлтийн тооцоолол, хүн ам, экосистемийн хорт нөлөөнд өртөж болзошгүй бүлэгт бохирдлын үзүүлэх нөлөө.
- Сэлбэн засах арга хэмжээний төсөл боловсруулах, санхүүжилтын урьдчилсан тооцоолол гаргах. Нөхөн сэргээлтээр хүрэх бодисуудын агууламж. Нөхөн сэргээлтийн хязгаарыг төлөвлөх.
- Сэлбэн засах арга хэмжээний талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлийн судалгааг Чех Улсын 369/2004 тоот тогтоол, БНЧУ-ын БОХЯ-ы 2011 оны 1 дүгээр сарын Аргачлалын удирдамж, тус төслийн эхний үе шатны хүрээнд боловсруулсан “Бохирдсон газрын эрсдэлийн судалгаа” аргачлалын удирдамж тус тусыг удирдлага болгон боловсруулна. Бохирдлын тогтоогдсон хэмжээ хүснэгт, бохирдлын план зурган дээр заасан байна. Мөн ханаагүй болон ханамал бүсийн үзүүлэлтүүдийн шинж чанар, бохирдлын шинж чанар, төрөл зэргийг үндэслэн бохирдлын тархалт, чиглэл, хурдац зэрэг хүчин зүйлийг тодорхойлно.

Химийн бохирдуулагчид болон цацраг идэвхтүүдээр бохирдсон хөрс	Бохирдсон тоосонцор салхиар дамжин тээвэрлэгдэх	Ойр хавийн газар тариалан, мал аж ахуйн газрын хөрс	Хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө, хүнсний сүлжээний бохирдол	Химийн болон цацрагийн бохирдол салхи болон урсацаар дамжин (ялангуяа хүчтэй бороо үеэр) ойр хавийн газарт зөөвөрлөгднө. Хөрс, ургамал бохирдох төдийгүй түүгээр тэжээгддэг мал амьтад хордоно.
	Газрын гадаргаас угаагдаж тээвэрлэгдэх			
	Бохирдсон тоосонцор салхиар дамжин тээвэрлэгдэх	Газрын ойр хавийн оршин суугчид	Тоосоор амьсгалах Тоосонцор залгих Арьсаар хүрэлцэх Үр тариа, мал аж ахуйн амьтад болон тэдгээрийн бүтээгдэхүүнийг идэх	Газартай ойр тойрон оршин суудаг оршин суугчид ойр тойрондоо, тоосонцрын нарийн ширхэг хүртэл нэвтэрдэг дотоод орчинд ч салхиар дамжин тархах химийн болон цацрагийн бохирдолтой тоосонцрын таагүй нөлөөнд удаан хугацааны туршид байж болзошгүй. Мал аж ахуйн бүтээгдэхүүнүүд болох мах, сүү болон тухайн газар дээр тарьж ургуулсан хөдөө аж ахуйн үр тариа ч бохирдсон байж болзошгүй.
	-(шууд харилцаа)	Бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэгчид	Тоосоор амьсгалах Тоосонцор болон шороо залгих Арьсаар хүрэлцэх	Бүсэд зөвшөөрөлгүй/хяналтгүй нэвтэрсэн (ж.нь: хүүхдүүд, хулгайч) ба бохирдсон орчин дахь хөдөлгөөнт байдлын тохиолдолд нөлөөллийн эрсдэл өндөр. Мөн бохирдсон барилгын материалыг дахин ашиглах нь өндөр эрсдэлтэй.
	-(шууд харилцаа)	Барилгын ажилчид	Тоосоор амьсгалах Тоосонцор болон шороо залгих Арьсаар хүрэлцэх	Тухайн газар дээр барилгын засвар болон хөрс шорооны ажил хийж буй ажилчид бохирдсон материалтай хүрэлцэхэд хүрч болзошгүй.
	Газар доорх ус руу ханаагүй бүсээр дамжин тээвэрлэгдэх	Газар нутаг дахь болон ойр хавийн гүехэн уст үе	Газар доорх усны чанарт сөргөөр нөлөөлөх	Газар нутагт ба түүний ойр хавьд газар доорх ус руу борооны усаар зайлагдан аажмаар нэвтрэх, үүний дараа газар доорх усны чанар муудахаас зайлсхийх боломжгүй. Гэхдээ ойр орчимд газар доорх усны ямар ч эх үүсвэр байхгүй.
Химийн бохирдуулагчид болон цацраг идэвхтүүдээр бохирдсон газар доорх ус	Газар доорх усаар хурах объект руу тээвэрлэгдэх	Газрын ойр хавийн оршин суугчид, мал аж ахуйн амьтад	Ус уух Арьсаар хүрэлцэх Үр тариа, мал аж ахуйн амьтад болон тэдгээрийн бүтээгдэхүүнийг идэх	Гэрийн худгийг ундны эсхүл хэрэглээний усны эх үүсвэр болгон, цэцэрлэг услах, мал аж ахуйн амьтадаа услах зорилгоор урт хугацааны туршид ашиглаж байгаа оршин суугчид эрсдэлтэй.

4.3.1. Эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн урьдчилсан үнэлгээ

Газар дээрх гол бохирдуулагч нь хүнцэл буюу хүнцлийн нэгдлүүд бөгөөд тэдгээрийн хортой шинж чанараас шалтгаалан урт хугацааны туршид өндөр анхаарал татаж байна. Уг сонирхол байгаль орчин дахь хүнцлийн өндөр агууламж ба хорт хавдрыг оролцуулаад олон янзын өвчний гаралт нэмэгдсэнтэй шууд холбоотой болох нь батлагдсанаас үүдэлтэй. Өргөн тархсан түгээмэл мэдээллүүдийн дагуу хүнцлийн хорт нөлөө 30 – 50 гр тунгаас эхэлдэг байна. Үхэлд хүргэх тун ойролцоогоор 200 – 300 гр-аас эхэлдэг. Цочмог хордлого маш хурдан үргэлжилж үхэлд хүргэдэг. Архаг хордлого удаан бөгөөд урт хугацаанд үргэлжилж арьс ба салст бүрхэвчийн өөрчлөлтөөр илэрдэг. Өдөрт ойролцоогоор 10 гр орчим хүнцлийн тунг оруулснаар архаг хордлого үүсгэдэг байна. Хүн хүнцлийг амьсгалаар (тоостой үйл ажиллагаа, агаарын эргэн буусан уналт) эсвэл хүнс хоолоор, нэн ялангуяа усаар дамжуулан хүлээн авч болзошгүй.

Газар нутгийн тандалтын ба урьдчилсан судалгаанаас үзэхэд тус газарт хамгийн багадаа 30 см гүнд хөрс хүнцлийн онц бохирдолтой, хуучин шил хайлуулах зуух байрлах газар ба түүний ойр орчин хэсгийн өндөр цацраг идэвхжилт төдийгүй өөр бусад элемэнтүүдээр (Pb, Cr, Cd) бохирдсон болох нь батлагдсан. Бохирдуулагчууд нь хөрснөөс ойр хавийн хүрээлэн буй орчинд нэг бол хуурай салхитай өдрүүдэд агаараар тархах эсвэл их хэмжээний аадар борооны үеэр усаар буюу газар нутагт орших гүехэн уст үед шингэх замаар шилжих боломжтой. Үүний дүнд ойр хавийн оршин суугчид химийн ба цацраг идэвхжилтийн хортой тоосонцрын хэсгүүдээр амьсгалах, арьсанд хүрснээр шууд нөлөөнд автах, цаашлаад бохирдсон хөрс, ус улмаар хүнсний сүлжээгээр (хөдөө аж ахуйн үр тариа ба өсгөж үржүүлж буй мал амьтад эсвэл гэр ахуйдаа идэж буй хоол хүнс) дамжиж шууд бус нөлөөнд орох юм. Тус газар харуултай, түүний бүсэд шууд амьдардаг хүн байхгүй боловч түүнийг тойрон оршин суугчид маш их (хэдэн зуугаас эхний хэдэн мянга хүртэл) бөгөөд ард иргэд бохирдуулагчийн нөлөөний өндөр эрсдэлд байгаа юм.

4.4. Урьдчилсан судалгааны дүгнэлт

Газар нутагт хамгийн багадаа 30 см-ын гүнд, хүнцлээр бохирдсон хөрсний талбайн бохирдол нэлээд их, мөн хэсгийн өөр бусад элемэнтүүдээр (Pb, Cr, Cd) бохирдсон болох нь батлагдсан. Мөн үйлдвэрийн барилгууд дахь барилгын зарим хийцүүд бохирдсон байна. Хэвийн бус цацраг идэвхжилтэй хэсэг газрууд илэрсэн. Газар нутагт химийн бодисуудын үлдэгдэл их хэмжээгээр байгаа. Бохирдсон газар нь ойр орчимд бохирдол тархаснаар аюулд өртөж болзошгүй хүн ам ихээр төвлөрсөн хотын төвд оршдог.

Хүн ам болон байгаль орчинд бохирдлын үзүүлж болзошгүй нөлөө, түүний хүрээ, шинж чанарыг ноцтойд үзэж байгаа учраас нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааны ажил буюу дэлгэрэнгүй судалгааны үе шатыг хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Түүнчлэн газрын гадарга дээр эсхүл чөлөөтэй нэвтрэх боломжтой агуулахын объектууд дахь ил, задгай орхигдсон химийн бодисын үлдэгдлүүдийг түргэн арилгахыг зөвлөсөн. Бохирдсон материалуудтай харьцах, тээвэрлэх үеэр аюулгүй ажиллагааны журам ба хөдөлмөр хамгааллыг чанд баримтлах нь олборлосон бохирдсон материалын ачилтад шалгалт хийх болон түүнийг аюулгүй устгах үйл явцтай адил зайлшгүй чухал.

Дараагийн асуудал нь тус газрыг өөрөөр, жишээлбэл барилгын зорилгоор ашиглах боломжийг бүрэн үгүй хийж байгаа, одоо болтол оршиж буй бохирдол юм, шилний үйлдвэрийн бүс өнөөгийн байдлаар худалдагдахааргүй. Газар эзэмшигчид болон хотын төлөөлөгчдийн стратегийн сонирхол нь тус газрыг нарийвчлан дэлгэрэнгүй судлах, бохирдолгүйжүүлэхэд болон түүнийг шинэ зорилгоор ашиглагдахад төрөөс санхүүгийн тал дээр оруулахыг хичээх байвал зохино.

5. Ажлын үе шат

5.1. Судалгаа ба газрын урьдчилсан тандалт

Газар дээр нэн түрүүнд нэмэлт судалгаа болон урьдчилсан тандалт явагдана. Эдгээр алхмуудын зорилго нь:

- Шилний үйлдвэрийн тухай түүх, үйлдвэрлэлийн технологийн үе шат, ашиглагдаж байсан нэмэлтүүд, халаалтын орчин г.м мэдээллүүдийг олж мэдэх.
- Газрын геологийн бүтэц ба гидрогеологийн шинж чанарын тухай дэлгэрэнгүй мэдээллүүдийг бүрдүүлэх.
- 2014 онд хийсэн судалгаа болон урьдчилсан тандалтын ажлаар олж авсан өгөгдөл мэдээллүүдийг шалгах.
- Өрөмдлөгийн ажлын сүлжээг гаргах.
- Дээжлэлтийн төлөвлөгөөг засах ба дуусгах.
- Хүртээмжтэй өөр бусад бүх мэдээллүүдээр хангах.

Судалгаа ба газрын урьдчилсан тандалтаар олж мэдсэн мэдээллүүдийг газрын судалгааны тухай эцсийн тайланд хураангуйлсан байна.

5.2. Газар доорх шугам сүлжээ байгаа эсэхийг шалгах нь

Газар нутагт газар доорх идэвхтэй шугам сүлжээ байгаа гэж үзэхгүй байна. Судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө тэдгээрийн тухай газар хамтран эзэмшигчдээс тодруулна.

5.3. Өрөмдлөгийн ажил

5.3.1. Судалгааны гүехэн цооног

Бохирдлын талбайн болон гүний тархалтыг зурагжуулах зорилгоор газар нутагт, ханаагүй бүсэд өрөмдлөгийн хайгуул хийж гүйцэтгэнэ. Бохирдлын талбайн ба гүний тархалтыг тодорхойлохын тулд боломжтой бол 2014 онд хийгдэж байсан урьдчилсан судалгааны үр дүн болон судалгааны ажил эхлэхээс өмнө хийгдэх газрын нэмэлт тандалтаас гарсан параметрууд бүхий тогтмол сүлжээний дагуу судалгааны гүехэн цооногууд ухна.

Судалгааны гүехэн цооногууд
Газар дээр нийтдээ 2 – 3 м-ийн гүнд судалгааны 30 гүехэн цооногууд ухах бөгөөд энэ нь дунджаар 2,5 метрийн гүнд нийт 75 ердийн метр болж байгаа юм. Цооногууд нь газрын урьдчилсан тандалт дээр үндэслэн тараагдана. Цооногуудыг эргэлтэт-чөмгөн эсвэл цохилтот өрөмдлөгт зориулсан өрмийн төхөөрөмжөөр нүхлэнэ. Нүхэлсэн цооног бүрийн чөмөгний босоо профилиэс, талбай дээр байгаа геологчийн заасан, өөр хоорондоо холбогдох гүний интервалаар 2, хамгийн ихдээ 3 хөрсний дээж авна (нэг зондонд дундажаар 2,5 дээж, энэ нь нийтдээ 75 дээж).

Судалгааны гүехэн цооног нүхлэх үе шат:

- өрөмдлөгийн ажил эхлүүлэхийн өмнө газар дээр төлөвлөгдсөн бүх судалгааны гүехэн цооногуудыг тэмдэглэнэ;
- судалгааны гүехэн цооногуудыг эргэлтэт – чөмөглөгч эсвэл цохилтот өрөмдлөгийн тусламжтайгаар өөр хоорондоо ойролцоогоор 110 мм зайтай байхаар, хамгийн ихдээ газрын гадаргаас доош 3 м-ийн гүнд нүхлэнэ;
- цооногоос чөмгийг авмагц түүний доторх агууламжийг модон дээжийн саванд эсвэл геологч цооногийн профилд тайлбар бичих өөр зориулалтын газар (хуудас, хуванцар эсвэл лаазан дэвсгэр г.м) аажмаар суллах бөгөөд өрөмдөж авсан материалаас лабораторийн шинжилгээнд зориулан хөрсний дээж авна;
- цооногуудыг тоноглохгүй. Геологийн баримтжуулалт хийгдэж, дээж авах ажил дууссаны дараа судалгааны гүехэн цооногуудыг хааж газрыг тэгшилнэ;
- хэмжилтийг өрөмдлөг хийсэн даруй хийж гүйцэтгэх боломжгүй байвал цооногийн хаасны дараа өрөмдсөн газрыг дараагийн хэмжилт хийх боломжтой болгох үүднээс газрын гадарга дээр тодоор тэмдэглэнэ.

5.3.2. Судалгааны гидрогеологийн цооногууд

Гүехэн усжсан давхарга оршиж байгаа болон шинж чанарыг илрүүлэх зорилгоор газар дээр судалгааны гидрогеологийн 4 цооног нүхлэнэ. Судалгааны гидрогеологийн цооног бүрийг ойролцоогоор газрын гадаргаас доош 20 м гүнд бэлтгэх ба энэ нь нийтдээ 80 ердийн метр цооногуудыг төлөөлж байгаа юм (газар доор бага түвшинд газар доорх усны түвшинг дайрсан тохиолдолд өрөмдлөгийн ажлыг газар доорх усны динамик дээж авах боломжтой байхаар дуусгах бөгөөд үлдсэн метрүүдийг дараагийн гидрогеологийн объект нүхлэхэд ашиглах жишээтэй). Гидрогеологийн цооногуудыг эргэлтэт – чөмөглөгч өрөмдлөгийн зориулалттай өөрөө явагч өрөмдлөгийн төхөөрөмжийн тусламжтайгаар нүхэлнэ. Өрөмдлөгийн ажлыг 194 мм-ийн диаметртай чөмөглөгчөөр хийж гүйцэтгэнэ. Цооногуудыг 110 мм ба түүнээс дээш диаметртай ПЭ/ПВХ тоноглолоор тоноглоно. Цооногийн ёроолоос дээш сүүлийн 0,5 м ба эхний 4 м тоноглол дүүрэн, тоноглолын үлдсэн профиль цоолбортой байна. Тоноглолын цоолбортой хэсэг тохиромжтой материалаар хучигдсан байна. Тоноглолын дүүрэн хэсэг газрын түвшинд – газрын гадаргаас доош 4 м-т шавар цементэн жийргээр жийргэлэгдсэн байна. Цооногуудад газрын гадаргаас дээш 0,5 м-т дамжуулсан, цоожлогддог металл хамгаалагч суулгасан байна. Цооног бүрийг хамгаалагч дээр гаргагдахуйцаар тэмдэглэсэн байна.

Цооног нүхлэх үеэр чөмөглөгчөөс шороог аажмаар асгаж оролцогч геологч тайлбар бичнэ. Цооног бүрээс оролцогч геологчийн шинжлэл дээр үндэслэн гүний интервалд 4 хөрсний дээжийг аажмаар авна.

Судалгааны гидрогеологийн цооногуудыг илэрсэн бодит байдлыг харгалзан үзсэн газрын тандалтын дүгнэлтийн дараа байршуулна.

Судалгааны гидрогеологийн цооног нүхлэх үе шат:

- Өрөмдлөгийн ажил эхлүүлэхийн өмнө төлөвлөгдсөн бүх судалгааны гидрогеологийн цооногуудыг тэмдэглэнэ;
- судалгааны гидрогеологийн цооногуудыг 194 мм-ийн диаметртай эргэлтэт – чөмөглөгч өрөмдлөгийн тусламжтайгаар нүхлэнэ;
- цооногоос дүүрэн чөмгийг авмагц түүний доторх агууламжийг геологч цооногийн профилд тайлбар бичих зориулалтын газар (модон дээжийн сав эсвэл хуудас, хуванцар эсвэл лаазан дэвсгэр г.м) асгах бөгөөд өрөмдөж авсан материалаас лабораторийн шинжилгээнд зориулан хөрсний дээж авна;
- цооног 110 мм-ийн диаметртай ПЭ/ПВС тоноглолын тусламжтайгаар тоноглогдоно, цоолбортой хэсэг 4 – 8 мм фракцын тохиромжтой материалаар хучигдсан байна;
- тоноглолын дүүрэн хэсэг газрын интервалд – газрын гадаргаас доош 4 м-т шавар цементэн жийргээр жийргэлэгдсэн, цооногуудад цоожлогддог металл хамгаалагч суурилуулсан байна.
- цооногийг тоноглосны дараа цооногуудыг шилжүүлж цэвэрлэнэ;
- дараа нь цооногуудаас газар доорх усны дээж авна;
- үүний дараа бүх цооногуудыг GPS-ийн тусламжтайгаар хэмжинэ.

5.3.3. Цооног хаах арга

Ханаагүй бүсийн судалгааны зорилгоор нүхэлсэн судалгааны гүехэн цооногуудыг хөрсний дээж авч, литологийн профилийн тайлбар бичсэн даруйд тэгшлэн хаана.
Судалгааны гүехэн цооногуудыг инерт материалаар хучиж шавар-цементэн жийргээр жийргэлнэ.

5.4. Дээжлэлтийн ажил

Дээжлэлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөө, энэ нь газрын урьдчилсан тандалтын үр дүнд үндэслэн тодорхой болох дээж авах газруудын тодорхой байршил. Үүний дараа боловсруулсан дээжлэлтийн төлөвлөгөө дээжлэлтийн газрыг нарийн тогтоож, дээж тус бүрийг авах нарийн үе шатыг тодорхойлох бөгөөд шаардлагатай шинжилгээний төрлийг ч дурдана.

Дээж авсан тухай "дээж авсан тухай протокол" гэсэн тэмдэглэл хөтлөх бөгөөд түүнд дээж авсан газрын тухай нарийвчилсан схемийг шаардлагатай бол хэмжээс болон фото баримтжуулалтын хамт хавсаргана. Дээжийг лабораторит дамжуулан өгсөн тухай "дээж хүлээлгэн өгөх протокол"-д дурдана.

Судалгааны ажлын хүрээнд дээжлэлт, түүний дараах хөрсний, барилгын хийцийн, газар доорх усны дээжийн судалгаа төлөвлөгддөг. Хөрсний дээжийн бүлгүүдэд мөн дээжлэлтүүд, түүний дараах гадарга дээрх болон химийн бодисын газар доорх агуулах дахь аюултай химийн бодисуудыг таних ажил ордог.

Дээжлэлтийн ажлын хүрээнд хяналтын дээжийн 5 %-ийг авна. Хяналтын дээжийн сонголтыг хариуцлагатай геологч хийнэ. Дээжүүдийг шинжилгээний ажлын чанарын хяналтын зориулалттай магадлан итгэмжлэгдсэн лабораторит шинжилнэ.

5.4.1. Хөрсний дээж авах

Хөрсний дээжийг газрын гадаргаас, судалгааны гүехэн цооногоос болон гидрогеологийн судалгааны цооногуудаас авна.

Судалгааны гүехэн цооногууд нь хамгийн ихдээ газрын гадаргаас доош 3,0 м түвшин хүртэл нийтдээ 30 ширхэг гүехэн судалгааны цооног төлөвлөгдсөн. Нүхэлсэн цооног бүрээс тохиромжтой хязгаарласан бөгөөд өөр хоорондоо уялдаатай чөмөгний босоо профильд оролцогч геологчийн тайлбараас хамаарч хамгийн ихдээ 3 (дунджаар нэг цооногт 2,5 дээж) хөрсний дээж авна. Дээжүүдийг оновчтой дээжлэлтийн багажаар авна. Дээжүүдийг таних шошготой хуванцар (шилэн) дээжийн саванд авна. Судалгааны гүехэн цооногуудаас нийтдээ 75 хөрсний дээж авна.

Судалгааны гидрогеологийн цооногууд. Газрын гадаргаас доош 20 м-ийн гүний түвшинд 4 цооног төлөвлөгдсөн. Нүхэлсэн цооног бүрээс чөмгийн босоо профильд тухайн нөхцөл байдал, оролцогч геологчийн тайлбараас хамааран гүний интервалаас хамгийн ихдээ хөрсний дээж 4-ийг авна. Дээжүүдийг оновчтой дээжлэлтийн багажаар, таних шошготой, хаалттай хуванцар (шилэн) дээжийн саванд авна. Судалгааны гидрогеологийн цооногуудаас нийтдээ 16 хөрсний дээж авна.

Газрын гадаргаас авах хөрсний дээжүүд. Хүнд металлын бохирдлын талбайн хүрээг баталгаажуулах зорилгоор судалгааны гүехэн цооногуудын сүлжээний цэгүүдийн хоорондох, нүдэнд илт бохирдсон, сонгосон газруудад газрын гадаргаас шууд дээж авна. Энэ нь ялангуяа задгай талбай эсвэл үйлдвэрийн барилга, хуучин агуулахын нурангинд байдаг хөрс, шороо, барилгын хог, үнс гэх зэрэгтэй холилдсон химийн бодисуудын үлдэгдэл. Дээжүүдийг цэгэн аргаар зэвэрдэггүй ган, халдваргүйжүүлсэн утгуураар газрын гадаргаас доош 0 – 0,2 м гүнээс тухайн нөхцөл байдал, оролцогч геологчийн тайлбараас хамааран авна. Дээжүүдийг таних шошготой, шилэн дээжийн саванд авч хаалттай байлгана. Газрын гадаргаас хөрсний дээж авах байршил газрын урьдчилсан тандалтын дараа тодорхой болно. Газрын гадаргаас нийтдээ 14 хөрсний дээж авна.

Нийлбэр дүнгээр Налайхын байршилд судалгааны гүехэн цооног, судалгааны гидрогеологийн цооног болон гадаргаас авсан дээж 105 ширхэг тооцоологдсон байна. Хяналтын дээжийн зориулалттай 5 % ноогдлын хүрээнд хөрсний дээжээс дахин 7-г, газар доорх агуулахаас химийн бодисын 15 дээж авна. Ингээд нийтдээ тус газар дээрээс хөрсний болон хог хаягдлын 127 дээж авах болно.

Авсан хөрсний дээжүүдийг лабораторийн шинжилгээ хийлгэх зорилгоор магадлан итгэмжлэгдсэн лаборатори руу илгээнэ. Хөрсний бүх дээжийг хүнд металлын буюу эрсдэлт элемэнтүүдийн агууламжид шинжлүүлнэ. 30 дээжинд NEL ба ПАН анорганик бохирдуулагчуудын агууламжийг шинжлэх болно. Химийн дээжүүдэд тэдгээрийн химийн нэгдлүүдийг тодорхойлно.

5.4.2. Газар доорх агуулах дахь хог хаягдлын дээж авах

Химийн бодисын газар доорх агуулахад хог хаягдлын үндсэн тодорхойлолт ба тооллогыг хийж гүйцэтгэнэ. Оновчтой сонгосон газрын детекторуудыг (ж.нь: Раманы спектрометр) ашиглан талбайн хэмжилтийг хийж гүйцэтгэнэ. Үүний дараа хэрэгцээ шаардлагын дагуу 15 дээж авч, магадлан итгэмжлэгдсэн лабораторит шинжлэх болно. Дээжүүдийг оновчтой дээжлэгчээр шилэн дээжийн саванд авч хаалттай байлгах ба шошгожуулна. Давхардсан дээж уг тохиолдолд авахгүй. Хог хаягдлын дээжүүдэд эдгээр шинжилгээний зорилго нь хог хаягдлын, голчлон аюултай шинж чанар үзүүлж буй химийн бодисын, цаашлаад хог хаягдлыг тодорхой ангилж, тэдгээрийг дахин ачихад туслах бодисуудын химийн найрлагыг тодорхойлох мөн.

5.4.3. Барилгын хийц, бүтээцийн дээж авах

Барилгын хийцийн дээжийг голдуу шил хайлуулах зуухны орчноос, цаашлаад үйлдвэрийн объектын бусад хэсгүүдээс авна. Нийт 22 дээж авахаар төлөвлөсөн ба үүнээс 20 дээж үндсэн, 2 дээж хяналтынх байна. Барилгын хийцийн дээжүүдийг бутдах аргаар холимог дээж хэлбэрээр авна. Дээж тус бүр хоёр хэсэгтэй.

Урьдчилсан судалгааны хүрээнд хэвийн бус хүнд металл болон цацраг идэвхжилтийн гол тээгч нь зуухны галд тэсвэртэй доторлогоо болох нь тогтоогдсон. Галд тэсвэртэй блокууд нь зөвхөн хуучин зуухны орон зайд ч бус, үйлдвэрийн объектын ойр хавьд ч тарсан байгаа бөгөөд тухайлбал газар нутгийн хүрээнд хашааны өрлөгт ашиглагдсан байсан.

Барилгын хийцийн дээж бүрийн нэг хэсэг хүнд металлын буюу эрсдэлт элемэнтийн агууламжид шинжлэгднэ. Дээж тус бүрийн хоёр дахь хэсэгт үндсэн цацраг идэвхт бодисуудын агууламжийг тогтооно (K, U, Th). Цацраг идэвхтүүдийн концентрацийг байгалийн суурь цацрагийг өнгөөр ялгаж үзүүлэх лабораторын гаммаспектрометрт хэмжинэ.

5.4.4. Газар доорх усны дээж авах

Ханасан бүсийн зүгээс судалгааны ажил газар нутаг дахь газар доорх усны дээд коллекторт агуулагдаж буй усны чанарыг шалгахад, өөрөөр хэлбэл бохирдол уг коллекторт нэвтэрч буй эсэхийг олж мэдэхэд чиглэгдсэн байна.

Газар нутаг дээр гидрогеологийн цооног тус бүрээс газар доорх усны дээж авах буюу нийт 2 дээж авна. Бүх дээжийг цооног дахь усны баганын ойролцоогоор 2/3 гүнээс авна. Ус шавхах үеэр физик-химийн параметрууд (ууссан хүчилтөрөгч, редокс боломж, pH, дамжуулах чанар гэх мэт) тасралтгүй хэмжигднэ. Газар доорх усны дээжийг үргэлж эдгээр параметруудын утга тогтворжсон хойно, лабораториос заасан дээжийн саванд авна.

Газар доорх усны дээж авсан савыг тэмдэглэж, хөргөх хайрцагт хийх бөгөөд магадлан итгэмжлэгдсэн лаборатори руу сонгосон хүнд металлын агууламж болон усны химийн үндсэн шинжилгээнд тээвэрлэнэ.

Газар доорх усны динамик дээжлэлтийн нэг хэсэгт талбайн оновчтой багажаар авсан тэдгээрийн физик-химийн параметруудын хэмжилт (дулаан, pH, дамжуулах чанар, чөлөөт O_2, Eh) орно.

5.5. Газар доорх агуулах дахь хог хаягдлыг тодорхойлох ба түүний тооллого

Бүх урьдчилсан зөвшөөрлийг зохицуулсны дараа газар доорх агуулахад хадгалагдаж буй хог хаягдлыг тодорхойлж, тооллого хийнэ. Хог хаягдлыг талбайн оновчтой детекторoор тодорхойлж болно. Эдгээр ажлын хүрээнд агуулахын дэлгэрэнгүй баримтжуулалт хийж, агуулагдаж буй бодисын үндсэн тоймыг боловсруулна. Энэ нь бодисын хэмжээний тухай мэргэшсэн тооцоо, баглаа боодлын шинж чанар – төрөл, тоо ширхэг, хэмжээ, эзэлхүүн, ерөнхий байдал ба хадгалагдаж буй бодисын конзистенц г.м, бичил цаг уурын шинж чанар (дулаан, чийг гэх зэрэг), хэмжээ, төлөв болон агуулахаас эрсдэлт бодисыг газрын хэвлий рүү алдагдуулахаас хамгаалах гэх мэт. Фото баримтжуулалт нь баримтжуулалтын зайлшгүй шаардлагатай хэсэг болно. Эдгээр дээжийг авах үеэр хөдөлмөрийн аюулгүй байдал ба дээж авагчийн эрүүл мэндийн хамгаалалд тавигдах бүхий л шаардлагууд биелсэн байх ёстой.
Газар нутаг дээр агуулагдаж буй нэг тонн хаягдал загвар, үзүүлэх ажлын хувиар Стокгольмын конвенци болон олон улсын өөр бусад конвенци, стандартуудын дагуу контейнерт савлагдана. Бүх ажлыг ноцтой эрсдэлтэй орчин дахь ажилд шаардлагатай аюулгүй байдлын арга хэмжээнд хийж гүйцэтгэнэ. Газар доорх агуулах дахь ажилд зориулан ажлын аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулна.

5.6. Талбайн γ-спектрометр

Цацраг идэвхжилтийг зурагжуулах ба хэвийн бус хүрээг тогтоох зорилгоор газар дээр талбайн гаммаспектрометр хийж гүйцэтгэнэ. Хэмжилтийг гамма цацрагийн зөөврийн оновчтой детекторoор (ж.нь: GT-32, детектор BGO 2x2”, 103 см^3) хийнэ. Судалгааны гүехэн цооногууд байх бүх газруудад ^{40}K, ^{238}U ба ^{232}Th-ын хөдөлгөөнийг тогтооно. Газар бүр дэх эцсийн утгууд үндсэн цэгийн ойролцоо хэрээсэн тохиргоонд зохион байгуулагдсан таван хэсэг хэмжилтээс гарна. Хэмжилтийн зөвлөхгүйц хугацаа 600 секунд. Хэвийн бус цацраг идэвхжилтийн хүрээний ажиллагааны илрүүлэлтэд дозметрийн горимд цацрагийн нөлөөний чадлын тасралтгүй хэмжилт хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

5.7. Газар доорх усны түвшингийн хэмжилт

Газар нутгийн гидрогеологийн шинж чанарыг үнэлэх, газар доорх усны урсацын чиглэлийг тогтоох, шаардлагатай газрын зургийг бэлтгэх гэх мэт зорилгоор газрын ойр хавьд хэмжилтэд зориулсан хүртээмжтэй гидрогеологийн бүх объектуудад болон газар нутагт нүхэлсэн гидрогеологийн цооногуудын дөрөвт газар доорх усны тогтворжсон

хэмжилтийг хийж гүйцэтгэх болно. Хэмжилтэд хүрэлцэх түвшин хэмжигчийг ашиглана.

5.8. Гидродинамикийн туршилт

Газар нутаг дээрх гидродинамикийн туршилтууд нь нүхэлсэн гидрогеологийн цооногуудад 12 + 6 цагийн горимд хийгдэх болно. Эдгээр туршилтууд нь голчлон газар нутгаас шилжиж болзошгүй бохирдуулагчийг харгалзан үзсэн гидравликийн тооцоо ба загварчлалд шаардлагатай гидравликийн үндсэн параметруудыг олоход, цаашлаад нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхөд зориулагдсан.

5.8.1. Шавхах туршилт

Шавхах туршилтын зорилго бол шүүрлийн коэффициент болох k, дамжуулалтын коэффициент ба бүүрцын хүнхээлийн радиус *R*-ын тооцооны гидравликийн утгуудыг олох юм. Мөн шавхах туршилтын үр дүн, шаардлагатай нөхөн сэргээх шавхалтын горимыг гидрогеологийн цооногийн ашиглалт хамгийн дээд хэмжээгээр байх боломжийг хангасан байхаар төлөвлөнө(муруйн оглолцол дээр – усны урсацын үйл явцыг илтгэгч парабол ба цуглуулах шинж чанарын шулуун), энэ нь усны урсацын тохиромжтой хурдны үеэр шавхагдсан усны хэмжээ болно.

Уг арга нь хамгийн хатуу дэглэмд зориулагдан гарсан ба хамгийн найдвартай үр дүнг өгдөг юм. Шавхалтын үеэр гадаргын түвшин усжсан үетэй харьцуулахад харьцангуй бага хорогдож байгаа чөлөөт гадаргуутай горимд ашиглагдах нь ч бий. Энэхүү аргаар үнэлгээ хийхэд шавхалт хийгдсэн цооног болон шавхалт хийгдсэн цооногийн ойр орших ус шавхагдсан давхаргын түвшинг хэмжих боломжийг өгдөг нэг ба түүнээс дээш ажиглалтын цооног – хамгийн багадаа хоёр объект ашиглагдана. Насос шавхах туршилтын турш тогтмол чадамжтай байна. Шавхах туршилтын хүрээнд шавхагдсан усыг газар дээр асгана.

Шавхах туршилтын үе шат:

- ажлыг эхлүүлэхийн өмнө шавхагдсан цооногт болон ажиглалтын цооногт түвшинг хэмжинэ;
- шавхалтанд цооногийн урвуугаас дээш ойролцоогоор 1 м-т байрласан, тохирох үзүүлэлттэй шумбагч насосыг ашиглана; Насосын чадал нь цооногийн тооцоологдож буй чадамжийн дагуу тохируулагдсан байх ба түүнийг туршилт явагдах хугацааны туршид тогтмол түвшинд барина;
- шавхагдсан цооног болон ойр орчмын ажиглалтын цооногуудад газар доорх усны гадаргын түвшний хөдөлгөөнийг шавхах туршилтын дараах үнэлгээг харгалзан үзэж урьдчилан тодорхойлсон цагийн интервалд даталогероор хэмжинэ;
- газар доорх усны хяналтын хэмжилтийг хүрэлцэгч түвшин хэмжигчээр хийж гүйцэтгэнэ (ж.нь: G-50);
- шавхах туршилтын үеэр тохиромжтой багажийн тусламжтайгаар (ж.нь: сонгосон электродуудтай WTW Multi 340i) дулаан, pH, дамжуулах чанар, чөлөөт хүчилтөрөгчийн агууламж ба исэлдэл-ангижралтын чадамжийг хэмжинэ.

5.8.2. Нэмэгдүүлэх туршилт

Нэмэгдүүлэх туршилт нь шавхах туршилт дуусмагц эхэлнэ. Тогтоосон цагийн интервалд шавхалтыг зогсоосны дараа ажиглагдаж буй бүх объектуудад газар доорх усны эхний түвшин тэмдэглэгдэнэ. Гадаргын түвшний хөдөлгөөнийг хэмжихэд шавхах туршилтынхтай адил, даталогер эсвэл хүрэлцэх түвшин хэмжигч ашиглана.

Газар нутаг дээр нүхэлсэн гидрогеологийн цооногуудад нийтдээ 3 шавхах ба нэмэгдүүлэх туршилт хийж гүйцэтгэнэ.

5.9. Судалгааны ажлын хэмжилт

Судалгааны бүх ажлыг GPS-ийн тусламжтайгаар хэмжинэ. Хэмжигдсэн утгууд нь газрын зурган материал боловсруулахад хэрэгтэй. Гүехэн ба судалгааны цооногууд, дээж авсан бүх газруудыг голчлон хэмжих юм. Цаашлаад чухал ач холбогдолтой чиглүүлэгч цэгүүд, шаардлагатай бол бохирдлын эх үүсвэр гэх мэтийг хэмжинэ.

5.10. Лабораторийн ажил

Лабораторийн бүхий л шинжилгээнүүд магадлан итгэмжлэгдсэн аргачлалын журмаар хийгдэх болно. Монгол улсад шаардлагатай бүх шинжилгээг хийх хүчин чадалтай лаборатор байхгүй гэдгээс үзэхэд лабораторын ажлыг хоёрдогч улсад хэрэгжүүлэх шаардлагатай нь тодорхой байна.

Дээжийн шинжилгээний төрөл ба хүрээ дараах хүснэгтэнд бий. Шинжилгээ ба ажиглагдах бодисуудын хүрээ, параметрууд нь газар нутгийн тухай одоо байгаа ойлголт, бохирдлын шинж чанараас гаралтай.
Хүснэгт 5: Төлөвлөгдсөн ажлын хүрээнд Налайхын газар нутаг дээр матриц бүрээс авсан дээжүүдийн төлөвлөгдсөн лабораторын шинжилгээний тойм

Үзүүлэлт	**Тодорхойлох тоо (ш)**			
	Хөрс шороо, барилгын хийц		**Газар доорх ус**	
	Үндсэн	Давхардсан	Үндсэн	Давхардсан
Хүнд металлууд – Al, Ag, Sb, Sn, As, Ba, Be, B, Br, Cd, $Cr_{нийт}$, Cr^{VI}, Co, Cu, Fe, Pb, Mn, Hg, Mo, Ni, Se, Ag, Th, U, V a Zn	149	9	4	---
Цацраг идэвхтүүд (K, U, Th)	20	2	---	---
Химийн бодисын тодорхойлолт	15	---	---	---
Усны химийн үндсэн шинжилгээ (ГДУХАШШ)	---	---	4	---
Газрын тосны нүүрсустөрөгч C10-C40	30	2	---	---
ПАН	30	2	---	---
Нийлбэр дүн	244	15	8	---

Матриц тус бүрээс авсан дээжүүд дэх ажиглагдаж буй бохирдлын үзүүлэлтүүдийг лабораторит тодорхойлоход ашиглагдах шинжилгээний аргуудын тоймыг хүснэгт 6,7,8-д нарийн тодорхойлсон.

Хүснэгт 6: Хатуу матрицын дээжийн шинжилгээнд ашиглагдах шинжилгээний аргуудын тойм (хөрс шороо, барилгын хийц)

Ажиглагдаж буй үзүүлэлт	**Аргын үндсэн зарчим**
Хүнд металлууд	Индукцийн холбоот плазм бүхий атомын эмисийн спектрометр (ICP-OES) нь атомын эмисийн тусламжтай элемэнтүүдийг тогтоож нотлох зориулалттай хэмжигч техник. Шинжлэгдэж буй уусмал нь түүнийг шүрших перисталтик насосоор дамжин мананжуулагч руу сорогдох бөгөөд үүссэн аэросол тээвэрлэгч хийгээр индукцийн холбоот плазм (ICP) руу дамжуулдаг. Детекторын тусламжтайгаар спектрометрийн оптик торон дээрх түүний дисперсийн дараах цэнэгийн ICP үүссэн цацрагийг ажигладаг. Аргачлал нь ISO 11855 а US EPA 200.7 норм стандартаас гаралтай.
Цацраг идэвхжилт	Дээжийг хуванцар саванд (багц хэмжээ ойролцоогоор 400 гр, ширхэгийн хэмжээ 5 мм хүртэлх) 2 долоо хоногийн турш, цацраг идэвхжилтийн тэнцвэртэй байдал Ra-226 ба Rn-222-ын хооронд тогтворжтол байлгана. Th тодорхойлох: байгалийн материалууд нь ихэнхдээ цацраг идэвхжилтийн тэнцвэрт байдаг бөгөөд гамма цацрагийн эрчим V пикийн 239 бөгөөд 2,61 MeV нь шинжлэгдэж буй материал дахь Th агууламжид шууд хамааралтай байдаг. U тодорхойлох: Th-230 ба Ra-226-ын хангалттай удаан хагас задралын үеийн нөлөөгөөр байгаль дээр Ra-226-ын идэвхжилт төрөлх элемэнт болох ураны идэвхжилттэй адилхан байх албагүй. Дараагийн нэг асуудал гэвэл, 3,84 өдрийн хагас задралын үетэй Rn-222 агааржсан дээжүүдээс алдагдан гарч болзошгүй. Иймээс дээжийг лабораторит битүүмжилсэн хаалттай саванд байлгадаг бөгөөд Ra-226 ба Rn-222-ын хооронд тэнцвэртэй болтол хүлээх ба энергид пикийн эрчимээс 295-352 кэВ, 609 кэВ болон 1,76 МэВ нь хэрэглээнээс шалтгаалан ураны эквивалент агууламжаар илэрхийлдэг цацрагийн агууламжийг буюу U(Pa) утгыг тодорхойлдог. U(Pa) утга дээжинд буй ураны бодит агууламжийг хамгийн сайн илэрхийлдэг. Багаж төхөөрөмжийн жишээ: сцинтилляцийн спектрометр PCAP (Nucleus USA) детектортой NaI(Tl) 4 x 4" нягтралтай 7,9 %. Ар талыг нь Pb-аар дарсан -ъ 9 см-ийн зузаан хамгаалалтын хаалттай. Хэмжилтийн хугацаа 15 - 20 минут.

Ажиглагдаж буй үзүүлэлт	Аргын үндсэн зарчим
ГТН С10-С40	Алифатик, алициклик ароматик нүүрсустөрөгчүүдийн нийт агууламжийг C_{10} – C_{40} нэрэх хязгаарт тодорхойлдог, дэгдэмхий бус газрын тосны гаралтай нүүрсустөрөгчийг тодорхойлох журам EN 14039 нормд тайлбарлагдсан журмаас гаралтай. Шинжлэгдэж буй дээжийн хатаасан агууламжаас хамаарч хандыг ацетон/гексан (10-100% хатаасан) эсвэл n-гексаны (1-10% хатаасан) холимгоор хийдэг. Ацетоныг устай сэгсэрч арилгана. Органик фазыг тусгаарласны дараа силикагельтэй сэгсэрч хандлагддаг туйлын бодисыг устгана. Цэвэрлэгдсэн хандны аликвотын харьцааг FID-тэй хийн хроматографд шинжилнэ. n-деканаас n-тетраконтан руу шилжих стандартын хагас задралын үеэс пикээс доошхи нийт талбайг хэмжинэ. Шинжлэгдэхүүнүүдийн тоог гадны стандартын аргаар хийж гүйцэтгэнэ.
ПАН	Хагас дэгдэмхий органик бодис тодорхойлохдоо EPA 8270 ба ČSN ISO 6468 зэргийн аргуудаас гарна. Шинжлэгдэхүүнүүдийг дээжээс харгалзах органик уусгагчид хандална. Концентрацийн дараа хандыг шилэн баганан хоолойгоор цэвэрлэж, дараагийн концентрацийн дараа шинжилнэ. PAU шинжилгээ нь SIM горимд GC/MS аргаар хэрэгжинэ. Тоо хэмжээг дотоод стандартын бүтээмжид засвар хийх боломжтой гадны стандартын аргаар хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 7. Газар доорх усны дээжийн шинжилгээнд ашиглагдах шинжилгээний аргуудын тойм

Ажиглагдаж буй үзүүлэлт	Аргын үндсэн зарчим
Хүнд металлууд	Индукцийн холбоот плазм бүхий атомын эмисийн спектрометр (ICP-OES) нь атомын эмисийн тусламжтай элемэнтүүдийг тогтоож нотлох зориулалттай хэмжигч техник. Шинжлэгдэж буй уусмал нь түүнийг шүрших перисталтик насосоор дамжин мананжуулагч руу сорогдох бөгөөд үүссэн аэросол тээвэрлэгч хийгээр индукцийн холбоот плазм (ICP) руу дамжуулдаг. Детекторын тусламжтайгаар спектрометрийн оптик торон дээрх түүний дисперсийн дараах цэнэгийн ICP үүссэн цацрагийг ажигладаг. Аргачлал нь ISO 11855 а US EPA 200.7 норм стандартаас гаралтай.
ГДУХАШШ	Ионы хроматографийн аргаар усанд хлорид, нитрат, сульфат тодорхойлох – ИХ (ČSN EN ISO 10304-1, ČSN EN ISO 10304-2 зэргээс гаралтай). Хлорид, нитрат, сульфат зэргийг ионы хроматографийн аргаар тодорхойлдог. Ихэнхдээ 0,45 μм хэмжээний нүхтэй шүүгчээр урьдчилан шүүгдсэн, шаардлагатай бол шингэлэгдсэн 30 μл эзэлхүүн бүхий дээжийг шинжилдэг. WATERS компанийн ионы хроматограф нь дээжийн нөөцлүүр сав, ион солилцооны тусгаардах багана, дамжуулагч детекторын хөдөлгөөнт фазын (карбонат ба бикарбонатын холимог) дамжуулах чанарыг дардаг супрессор болон дижитал хэлбэрээр тэмдэглэл хөтлөх компьютер зэргээс бүрдэнэ. Хамгийн эхлээд ионт тус бүрт харгалзах пикийн талбайг компьютерийн программаар үнэлэх ба тэдгээр нь шинжлэгдэхүүнүүдийн агууламжид мг/л-ээр урьдчилан хэмжигдсэн калибрацийн муруйн тусламжтай нэмэгддэг.

Ажиглагдаж буй үзүүлэлт	Аргын үндсэн зарчим
	Урсгал тасралтгүйн шинжилгээний аргаар усанд нитрит, аммиак, аммонийн ион тодорхойлох – CFA (ČSN EN ISO 13395, ČSN EN ISO 11732 зэргээс гаралтай) Гар ажиллагаатай спектрофотометрийн ба бусад аргуудыг автоматжуулсан урсгал тасралтгүйн шинжилгээ CFA нь нитрит (шаардлагатай бол мөн нитрит, нитратын нийлбэр), аммиак, аммонийн ион, сульфат тодорхойлоход ашиглагддаг. 0,45 µм нүхтэй шүүлтүүрээр тохируулан шингэрүүлж шүүсэн шинжлэгдэж буй усны дээжийг SKALAR компанийн SAN PLUS SYSTÉM анализаторын автомат дээжлэгчид байрлуулна. Анализаторын химийн нэгжид дээжийн гавхагдсан уусмалд янз бүрийн бодис нэмж, янз бүхийн урвал явагддаг бөгөөд эцсийн фазад шинжлэгдэхүүний агууламжийг фотометрийн хэлбэрээр үнэлдэг.
	pH, хүчлийн саармагжуулах чадавхи - шүлтлэг, үндсэн саармагжуулах чадавхи - хүчиллэгийн болон нүүрстөрөгчийн давхар ислийн тооцоог тодорхойлно. pH утгыг лабораторит (ČSN ISO 10523) эсвэл талбайд (ČSN ISO 10523-аас гаралтай) тодорхойлоход дэлхийн тэргүүлэгч үйлдвэрлэгчдийн (WTW эсхүл Hanna Instruments) pH-метрийг ашиглана. Хүчиллэгийн (ČSN EN ISO 9963-1-ээс гаралтай) эсвэл үндсэн саармагжуулах чадавхийг (ČSN 75 7372-оос гаралтай) тодорхойлоход Metrohm компанийн дээжийн нөөцлүүртэй автомат титратор эсвэл гар ажиллагаатай титратор ашиглана. Шүлтлэг ба хүчиллэгийн хэмжигдсэн утгуудаас ČSN 75 7373 стандартын дагуу бикарбонат, карбонатлаг, чөлөөт эсвэл түрэмгий нүүрстөрөгчийн давхар исэл зэргийн агууламжийг боддог.
	Гар ажиллагаатай спектрофотометрийн арга Олон янзын параметруудыг тодорхойлоход шинжлэгдэхүүний агууламж тодорхойлох эцсийн аргаар шинжлэгдэхүүний тохиромжтой урвалжтай урвалд орж үүссэн нэгдлийн өнгөний эрчмийн хэмжих зарчим дээр үндэслэсэн спектрофотометрийн аргыг ашигладаг. Фосфатууд ба шаардлагатай бол нийт фосфор (ČSN EN ISO 6878) болон перманганатын хүчилтөрөгчийн химийн хэрэгцээт хэмжээг ПМnXXX тодорхойлоход ашигладаг (ČSN EN ISO 8467).
	Дээжийн цахилгаан дамжуулах чадварыг лабораторит (ČSN EN 27888) эсвэл талбайд (ČSN EN 27888-аас гаралтай) дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэгчдийн кондуктометрийн тусламжтай хэмждэг. Уусан хүчилтөрөгч (ČSN EN 25814) –ийг оксиметрээр хэмжинэ. Уусан бодисыг (ерөнхий эрдэсжилт) гравиметрээр, булингарыг (vychází z ČSN EN ISO 7027) нефелометрээр тодорхойлно.
	Фторидыг ионы сонгомол электродын тусламжтайгаар тодорхойлно. Фторидыг тодорхойлоход тохирох pH-метрт холбогдсон ионы сонгомол электродыг ашигладаг (ČSN ISO 10359-1-ээс гаралтай).

Матриц бүрээс авсан дээжүүд нь тэдгээрийн дараагийн лабораторын шинжилгээг хангах магадлан итгэмжлэгдсэн лабораторын шаардлагын дагуу бохирдлын ажиглагдаж буй үзүүлэлтүүдээс хамаарч талбайд сонгогдсон дээжийн саванд хадгалагдах болно. Дээжийн матриц тус бүрт болон бохирдлын ажиглагдах

үзүүлэлтүүдэд зориулсан дээжийн шаардлагатай хэмжээ болон ашиглагдах дээжийн савны тоймыг хүснэгт 9-д үзүүлэв.

Авсан дээжийг ажиглагдах үзүүлэлтүүдээс хамаарч хээрийн нөхцөлд боловсруулах ажлыг тэдгээрийн дараагийн лабораторын шинжилгээг хангах лабораторын шаардлага, зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Дээжийг талбай дээр засахад тавигдах зөвлөхүйц шаардлага хүснэгт 10-т тодорхой бий.

Хүснэгт 9. Дээжийн сав ба хатуу матрицаас авсан дээжийг засахад тавигдах шаардлагын техникийн тодорхойлолт

Ажиглагдаж буй үзүүлэлт	**Матриц**	**Дээж/хадгалалтын бэлтгэл**	**Дээж, дээжийн савны эзэлхүүн**
Хүнд металлуд	Хөрс шороо, барилгын хийц	Дээжийг 3 см хүртэл ширхэгтэй болгон буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарна)	0,2 кг, шил
Цацраг идэвхтүүд		Дээжийг 3 см хүртэл ширхэгтэй болгон буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарна)	1 кг, хуванцар
ГТН С10-С40	Хөрс шороо, барилгын хийц	Дээжийг 3 см хүртэл ширхэгтэй болгон буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарна), сэрүүн харанхуй нөхцөлд хадгална	0,2 кг, шил
ПАН		Дээжийг 3 см хүртэл ширхэгтэй болгон буталж, гомогенжүүлж, квартацийн аргаар холимог дээж үүсгэх (барилгын бүтээцийн дээжид хамаарна), сэрүүн харанхуй нөхцөлд хадгална	0,2 кг, шил

Хүснэгт 10. Дээжийн сав ба дээжийг хээрийн нөхцөлд боловсруулахад тавигдах шаардлага

Ажиглагдаж буй үзүүлэлт	**Матриц**	**Дээж бэлтгэх/хадгалалт**	**Дээжийн эзэлхүүн, дээжийн сав**
Хүнд металлууд	Газар доорх ус	ПЭ, хөргөлт < 8°С	250 мл, ПЭ
ГДУХАШШ		Боловсруулах шаардлагагүй	1л, ПЭ

5.11. Эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээ

Судалгааны ажлын үр дүн эрсдэлийн судалгаа, бохирдлын тархалтын үнэлгээ боловсруулах зорилгоор ашиглана. Эрсдэлийн судалгааны зорилго нь хүний эрүүл мэнд, байгаль орчны бүрэлдүүлэгч хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлж, сэлбэн засах арга хэмжээний эцсийн параметрийн төсөл гаргахад оршино.

Эрсдэлийн судалгаанд дараах асуудал орно. Үүнд:

- Хорт нөлөөнд өртсөн бодит байдал, хорт нөлөөнд өртөж болзошгүй хүн амын бүлэг, экосистемийн хэсгийг тодорхойлох.
- Хүний эрүүл мэндэд үзүүлэх хорт нөлөө, өртөлтийн тооцоолол, хүн ам, экосистемийн хорт нөлөөнд өртөж болзошгүй бүлэгт бохирдлын үзүүлэх нөлөө.
- Сэлбэн засах арга хэмжээний төсөл боловсруулах, санхүүжилтын урьдчилсан тооцоолол гаргах. Нөхөн сэргээлтийн хязгаарыг төлөвлөх.
- Сэлбэн засах арга хэмжээний талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлийн судалгааг Чех Улсын 369/2004 тоот тогтоол, БНЧУ-ын БОХЯ-ы 2011 оны 1 дүгээр сарын Аргачлалын удирдамж, тус төслийн эхний үе шатны хүрээнд боловсруулсан “Бохирдсон талбайн эрсдэлийн судалгаа” аргачлалын удирдамж тус тусыг удирдлага болгон боловсруулна. Бохирдлын тогтоогдсон хэмжээ хүснэгт, бохирдлын план зурган дээр заасан байна. Мөн ханаагүй болон ханамал бүсийн үзүүлэлтүүдийн шинж чанар, бохирдлын шинж чанар, төрөл зэргийг үндэслэн бохирдлын тархалт, чиглэл, хурдац зэрэг хүчин зүйлийг тодорхойлно.

Олж авсан мэдээллийг үндэслэн тухайн талбайн ханаагүй болон/эсвэл ханасан бүсийн илэрсэн бохирдлын улмаас хүн амын эрүүл мэнд, экосистемд гарч болзошгүй аюулыг үнэлж дүгнэнэ.

Бохирдсон орчины улмаас хүн амын эрүүл мэнд болон/эсвэл байгаль орчинд хорт нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд эрсдэлийн судалгаанд сэлбэн засах арга хэмжээний зорилтот үзүүлэлт буюу өөрөөр хэлбэл бохирдуулагч бодисын зөвшөөрч болохуйц хэмжээг заана. Бохирдуулагч бодисын хэмжээний зорилтот үзүүлэлт гэдэг бол хүн амын тухайн бохирдуулагч бодисын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хорт нөлөө үзүүлэхгүй хөрс, газар доорх усанд агуулагдах дээд хэмжээгээр тодорхойлогдоно.

Хүний эрүүл мэнд, экосистемд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд сэлбэн засах стратегийн төслийг дэвшүүлнэ. Төслийг эрсдэлийн судалгаа, гүйцэтгэгчдийн нөхөн сэргээлтийн ажлын туршлага дээр үндэслэн боловсруулна.

Тогтоогдсон бүх хүчин зүйлийг үндэслэн нөхөн сэргээлтийн арга хэмжээ эсвэл түүний хувилбарт шийдлийн товч төсөл, холбогдох зардлын барагцаалсан тооцооллын хамт бэлтгэнэ.

Боловсруулсан тайлан нэн түрүүнд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд,

- ил тод илэрхийлэгдэж, сайтар найруулсан
- ойлгомжтой
- ажлын дараагийн үе шатны талаарх хариуцлагатай шийдвэр гаргах боломжийг олгосон байдал.

Лабораторийн шинжилгээний үр дүн, газрын зураг зэрэг мэргэжлийн материалыг хавсралтаар хавсаргана. Лабораторийн шинжилгээний үр дүнг хүснэгтэнд оруулж боловсруулах бөгөөд олж авсан өгөгдөл, мэдээллийг бохирдлын талбайн хэмжээг график аргаар дүрслэн харуулах зорилгоор ашиглана.

5.12. Лабораторийн туршилт

Газар нутаг дээрх судалгааны ажлыг нөхөн сэргээх үйл ажиллагааг оновчтой хийж гүйцэтгэхэд зориулсан дэлгэрэнгүй баримтжуулалт боловсруулах зорилготойгоор байгаль орчны бохирдлын хэмжээ, тархалтын тухай зайлшгүй шаардлагатай ойлголтуудыг олж авахын тулд хэрэгжүүлдэг. Иймээс тохирох нөхөн сэргээх технологийн лабораторын туршилтыг хэрэгжүүлэх нь салшгүй хэсэг болно. Налайхд лабораторын хэмжээнд металлын өндөр агууламжтай хөрс шорооны тогтворжуулалт ба хатууралтын туршилт хийгдэнэ. Туршилт ойролцоогоор 25 – 50 кг эзэлхүүн бүхий хөрсний дээжид хийгдэнэ.

Лабораторийнн туршилтын үр дүнг үнэлж дүгнэх ба урьдчилсан шатны туршилт гэгдэх туршилтуудыг хэрэгжүүлэхэд ашиглана.

5.13. Урьдчилсан шатны туршилт

Лабораторын туршилтыг үнэлгээ дүгнэлт дууссаны дараа хатууралт ба тогтворжуулалтын урьдчилсан шатны туршилтыг хийнэ. Уг туршилт ойролцоогоор 2 т жинтэй бохирдсон дээжид хэрэгжих юм. Урьдчилсан шатны туршилтын үр дүнг эцсийн тайлан боловсруулахад, цаашлаад тайлбай дээрх сэлбэн засах ажлын төслийн баримт бичиг боловсруулах үеэр ашиглана.
Үүссэн хатууралтыг сонгосон газар, тохирох аргаар хадгална. Хадгалах газрыг төслийн монгол түнш тодорхойлно. Энэ нь хаягдлын ус хамгаалалттай талбайн сууриар дамжин нэвтрэхгүй байхаар баригдсан хамгаалалттай объект, хамгаалалттай талбай байвал зохино.

5.14. Өгөгдлийн үнэлгээ

5.14.1. Судалгааны ажлын үнэлгээ, дүгнэлт

Судалгааны явцад олж авсан бүх өгөгдөл, мэдээллийг талбайн бохирдлын хэмжээг тодорхойлоход ашиглахаас гадна талбайд байгаа хог хаягдлыг тодорхойлох, тооллого хийж гүйцэтгэнэ. Эдгээр мэдээлэл, дээжийн шинжилгээний үр дүн, чулуулгийн орчны литологийн шинж чанар, дээжлэлтийн цэг тус бүрийн хэмжилт зэргийн хамт судлагдаж

буй бохирдуулагч бодис (органик хлорт пестицид, хүнд металлууд) тус бүрийн бохирдлын талбайн болон гүний хэмжээг тодорхойлоход ашиглана. Бохирдуулагч бодисын нийт хэмжээ, хөрс, барилгын бүтээц, тунадас, хог хаягдал зэрэг талбай дээр байгаа бохирдсон материалын нийт хэмжээг тус тус тодорхойлно.

Үг дүнг боловсруулсан аргачлалын удирдамжийн дагуу, нэн ялангуяа Бохирдсон газар нутгийн судалгаанд зориулсан аргачлалын удирдамжийг баримтлан үнэлж дүгнэнэ.

Газар доорх болон гадаргын усны бохирдлын хэмжээг Монгол Улсын мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тодорхойлох бөгөөд ялангуяа дараах Монгол Улсын стандартыг ашиглана. Үүнд,

- Ундны цэвэр усанд тавигдах шаардлагыг заасан MNS 0900:2010 стандарт,
- Газар доорх усанд агуулагдсан бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг заасан MNS 6148:2010 6148:2010,
- Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын хэмжээг тодорхойлж байгаа MNS 5850:2008 стандарт.

Цуглуулсан өгөгдөл, мэдээллийг түгээмэл хэрэглэгддэг аргаар боловсруулж, үр дүнг нь хүснэгт, графикаар харуулах бөгөөд үр дүнг боловсруулах зорилгоор MS office, Grapher зэрэг программ ашиглагдана.

Цуглуулсан мэдээллийг цаашид хөрс, гадарга болон газрын доорх усанд агуулагдсан бохирдуулагч бодис тус бүрийн концентрацийн изо шугам зэргийн газрын зураг болгон боловсруулах юм. Газрын зургийг ARC View GIS программ эсвэл газрын зураг зохиоход ашиглагддаг өөр программаар зохионо.
Төслийн явцад цуглуулсан өгөгдөл, мэдээллийг бохирдсон газрын мэдээллийн санд оруулахаар төлөвлөж байна.

5.14.2. Шавхах туршилтаар олсон өгөгдлийг тэмдэглэх, үнэлж дүгнэх

Шавхагдах усны түвшин, температурыг хэмжилтийн хоорондох зай тохируулах боломжтой даталогероор хэмжиж, туршилт дууссаны дараа өгөгдлийг компьютерт шилжүүлж дүгнэлт хийнэ.

Үнэлгээ, дүгнэлтийг Aquifer Test Pro (Waterloo Hydrogeologic, Inc.) мэргэжлийн программын орчинд түгээмэл хэрэглэгддэг аргаар (жишээ нь, Жейкоб, Тейс гэх мэт) хийнэ. Үг дүнг шавхагдсан цооногийн орчимын чулуулгийн орчны нэвтрэх чанарын, шүүрлийн болон нөөцлөлтийн илтгэлцүүрээр илэрхийлэн, хүснэгт, график схем зэргээр харуулахаар төлөвлөж байна.

5.15. Сэлбэн засах арга хэмжээний талаар өгөх зөвлөмж

Эрсдэлийн судалгаанд хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж байгаа хэмээн тогтоогдсон хорт нөлөөг багасган устгахад чиглэсэн сэлбэн засах арга хэмжээний тойм орсон байна. Сэлбэн засах арга хэмжээний зөвлөмж нь судалгааны ажил, лабораторын, урьдчилсан шатны туршилтын үр дүн болон цаашлаад хог хаягдлыг тодорхойлох,

түүний тооллого зэргээс олж авсан дүгнэлтүүдээс гаралтай. Эдгээр арга хэмжээний тухай техникийн талаас нь товч мэдээлэл өгч, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах барагцаалсан зардлыг тооцоолон гаргана. Цаашилбал, талбай дээрх бохирдуулагч бодисын нөлөөнд өртсөн тус нутгийн хүн амын эрүүл мэнд болон экосистемд учруулж болзошгүй үр дагаварыг тайлбарласан байна. Сэлбэн засах арга хэмжээний төсөл (зөвлөгөө) яаралтай, дунд болон хэтийн хугацаанд хийгдэх арга хэмжээ, бодит (хог хаягдал зайлуулах, хаалт, тусгаарлалт, бэхжүүлэх талбай барих, усны эх үүсвэрийн аюулгүй байдал гэх мэт), эрх зүйн (орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагад зориулан байгаль орчинд холбогдох эрх зүйн зөвлөгөө), сургалтын (тухайн нутгийн албан хаагчид, иргэдэд үүсч болзошгүй эрсдэл болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх сэдэвт сургалт семинар явуулах тухай зөвлөгөө) гэсэн хэд хэдэн бүлэгт оновчтой хуваана. Гагцхүү Монгол Улсын өвөрмөц нөхцөлд таарсан, хэрэгжүүлэх боломжтой, мөн Монгол Улсын болон орон нутгийн байгууллагын санхүүгийн болон техник, технологийн боломжийг харгалзан тохиромжтой сэлбэн засах арга хэмжээг санал болгож, зөвлөгөө гаргана.

6. Чанарыг хангах асуудалд

Геологийн ажлыг (цэвэршүүлэх) нөхөн сэргээлтийн геологийн салбарт хамаарах геологийн ажлын зураг төсөл боловсруулах, түүнийг хийж гүйцэтгэх, үнэлж дүгнэх ажлыг мэргэшсэн хариуцлагатай гүйцэтгэгч удирдана.

Хөрс, хийц бүтээц, ёроолын тунадас, усны дээжлэлтийг мөрдөгдөж буй ČSN ISO стандартын дагуу хийх бөгөөд дээжлэлтийн ажлыг ажиглагдах орчин (медиум)-н дээжлэлт хийх тусгай зөвшөөрөл бүхий этгээд удирдан явуулна. Дээжлэлтийг хийх үед Монгол Улсын БОНХЯ-ы 2014 оны “Нөхөн сэргээлтийн геологийн дээжлэлт хийх ажил” нэртэй Аргачлалын удирдамжийг баримталж ажиллана.

Хийхээр төлөвлөсөн шинжилгээний бүх ажлыг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ.

Техникийн ажил хийж гүйцэтгэсэн тухай барилын журнал хөтлөж, газар шорооны ажил хийх арга, үүнийг техникийн талаас нь хангахад тавигдах аливаа шаардлага, ажлын төлөвлөгөө, ажлыг бодитойгоор хийж гүйцэтгэсэн цагийн хуваарь зэргээс гадна тухайн талбай дээр хийсэн бусад ажил, хяналт шалгалтын тухай тэмдэглэл үйлдэнэ.

Хийж гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлыг практик туршлага бүхий геологийн алба удирдана. Ажлын явцад цуглуулсан өгөгдөл, мэдээллийг өгөгдлийн файлд хадгалж, түгээмэл хэрэглэгддэг зах зээлд борлуулагддаг программ эсвэл зориулалтын программ хангамж бүхий компьютерт боловсруулна. Ажлыг хэрэгжүүлэх хугацаандаа захиалагч болох ЧХА-ийн төлөөлөгчтэй зохицуулан хийж гүйцэтгэнэ.

7. Ажлын төлөвлөж буй цагийн хуваарь


Ажил	Сар								
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
Талбайн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах									
Өрөмдлөг									
Дээжлэлт									
Объектуудын хэмжилт хийх									
Лабораторийн ажил									
Лабораторийн туршилт									
Урьдчилсан шатны туршилт									
Хогийн загварчилсан тодорхойлолт, тооллого									
Өгөгдлийн үнэлгээ, дүгнэлт									
Эрсдэлийн судалгаа									
Эцсийн тайлан									

8. Товчлолын тайлбар

Ag	.....	мөнгө
As	.....	мышъак
BTEX	.....	бензол, толуол, этилбензол, ксиленууд
C10-C40	.....	10 – 40 тооны нүүрс бүхий галогенжуулаагүй нүүрстөрөгчид
Cd	.....	кадмий
Co	.....	кобальт
Cr	.....	хром
Cu	.....	зэс
ČSN	.....	чехийн техникийн стандарт
ČSN EN	.....	нийцүүлэн нэвтрүүлсэн Европын стандарт
GC/FID	.....	хийн хроматографи
GC/MS	.....	Gas Chromatograph and Mass Spectrometer

Hg	.....	мөнгөн ус
CHSK	.....	химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн хэмжээ
k	.....	калий
MNS	.....	Монгол Улсын стандарт
Mo	.....	молибден
NEL	.....	нэг туйлт хандлах боломжтой бодис
Ni	.....	никель
Pb	.....	хар тугалга
Th	.....	торий
Zn	.....	цайр

АМХЭГ	.....	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
БОНХЯ	.....	Баягаль орчин, ногоон хөгжлийн яам
г.г.д.	.....	газрын гадаргаас доош
ГДУХАШШ	.....	газар доорх усны химийн анхан шатны шинжилгээ
ГТН	.....	газрын тосны нүүрсустөрөгч
НОН	.....	нийт органик нүүрстөрөгч
ПАН	.....	полиароматик нүүрсустөрөгчид
ПВХ	.....	поливинилхлорид
ПЭ	.....	полиэтилен
ҮЦАБГ	.....	Үндэсний цөмийн аюулгүй байдлын газар
ХАБ	.....	хөдөлмөрийн аюулгүй байдал
ХМ	.....	хүнд металлууд
ХХ	.....	хамгааллын хэрэгсэл
ЧГА	.....	Чехийн геологийн алба
ЧХА	.....	Чехийн хөгжлийн агентлаг


Map of wide surroundings of sites of interest
Legend:
sites of interest
6 - Nalaigh glass factory
8 - Nalaigh ash lagoon
7 - Nalaigh army base Gorodok
NALAYH
UBTZ RR
Tov
0 1 2 3 4 5 km
ArcGIS Online Content Resource Center:
http://resources.arcgis.com/content/arcgis-content/about


Site of interest No. 6 - Nalaigh overview scheme
Legend:
sample of ground - point
6ST7
6ST10
6ST8
6ST6
6ST5
6ST16ST2
6ST4
6ST3
ArcGIS Online Content Resource Center:
http://resources.arcgis.com/content/arcgis-content/about
0 10 20 30 40 50 m


Site of interest No. 6 - Nalaigh glass factory
overview scheme
former shelter
storage of chemicals
6ST7
6ST10
storage of
chemicals
6ST8
6ST6
6ST5
glass
furnace
6ST9
6ST1
6ST2
6ST4
6ST3
storage of
chemicals
Legend:
sample of ground
potential source of pollution
0 10 20 30 40 50 m
ArcGIS Online Content Resource Center
http://resources.arcgis.com/content/arcgis-content/about


Site of interest No. 6 - Nalaigh glass factory
projected investigation works
Legend:
projected monitoring well
projected sampling of soil
old sample of ground
6ST7
6ST10
6ST8
6ST6
6ST5
6ST9
6ST1
6ST2
6ST4
6ST3
ArcGIS Online Content Resource Center:
http://resources.arcgis.com/content/arcgis-content/about
0 10 20 30 40 50 m

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

Survey implementation project, Zuunbayan site

Contents

1. Introduction 3
2. Data regarding the territory 3
2.1. General Data 3
2.1.1. Property-legal relations 3
2.1.2. Currently used territory 3
2.1.3. Description of the location of the inhabitants in the territory 4
2.2. Natural conditions 4
2.2.1. Geography, climate, hydrology 4
2.2.2. Geological and hydro-geological composition of the locality 5
3. Objective of the survey 5
4. Existing investigation of the locality 6
4.1. Sources of contamination in the locality 7
4.2. Summary of current work 7
4.3. Preliminary conceptual model of contamination 15
4.3.1. Preliminary evaluation of health and environmental risks 16
4.4. Conclusions from the preliminary survey 17
5. Work procedure 18
5.1. Initial reconnaissance of the site 18
5.2. Verification of the existence of underground networks 18
5.3. Boring work 18
5.3.1. Shallow survey bores 18
5.3.2. Survey of hydro-geological bores 19
5.3.3. Disposal of bores 20
5.4. Sampling 20
5.4.1. Sampling of earth 21
5.4.2. Sampling of underground water 22
5.4.3. Sampling of surface and waste water and bottom sediments 23
5.4.4. Samples of biological matrixes 24
5.5. Measurement of the level of underground water 24
5.6. Hydrodynamic tests 25
5.6.1. Pumping test 25
5.6.2. Raising test 25
5.7. Measuring of survey work 26
5.8. Laboratory work 26
5.9. Evaluation of health and environmental risks 32
5.10. Evaluation of data 33
5.10.1. Evaluation of survey work 33

5.10.2. Record and evaluation of data obtained during pumping tests 34
5.11. Recommendation of corrective measures 34
6. Ensuring quality 35
7. Anticipated time schedule for the work 35
8. List of abbreviations 36

List of Appendixes

Appendix No. 1	Aerial photo with indication of the site of interest
Appendix No. 2	Map of survey conducted in 2014
Appendix No. 3	Layout of the site with the indication of potential sources of contamination sources

1. Introduction

This document describes the procedure and scope of the survey in the Zuunbayan site in the Dornogovi aimag. The survey of the environmental contamination is projected for the site, which is significantly contaminated by the crude oil and partially by oil products due to extensive and insensitive exploitation of crude oil.

A preliminary survey was conducted (2014) in this site, which confirmed the existence of major contamination by oil products.

The survey project is prepared in accordance with the Methodological Instruction of the Ministry of Environment for the Survey of Contaminated Territory, Bulletin of the Ministry of the Environment, No.9, September 2005 and Regulation No. 369/2004 Coll., on projecting, execution and evaluation of geological work. The methodological instruction for the survey of the contaminated territory will be used during the projecting, which was prepared for the ZRS project.

2. Data regarding the territory

2.1. General Data

Судалгааны ажлын үндсэн арга барил нь газар дээрх бохирдлын ач холбогдол бүхий бүх голомтыг тодорхойлох болно. Үүнд голдуу газрын тосны бүтээгдэхүүний хаягдлын сан ба цөөрөм, дүүрэн худаг, цаашлаад бохирдсон тунамалууд ба гадаргын ус цуглардаг хэсгийн хотгор зэрэг орно. Тус газар дээрх бохирдлын бүх голомтын нарийн байршил толорхойгүй гэдгээс үзэхэд судалгааны ажлын уг төсөл дээж авах газрууд төдийгүй, цооног тус бүрийн нарийн тодорхой байршлыг агуулаагүй. Цаашлаад текстэд зөвхөн ерөнхий мэдээлэл, өрөмдлөгийн ажлын нийт метрчлэл, цооногийн тоо, дээжийн тоог дурдсан бөгөөд, тэдгээрийн хүрээг одоо байгаа мэдэгдэхүүнүүд дээр үндэслэн үндэслэлтэйгээр таамаглаж болно.

Ерөхий хандлага нь дараах болно. Бохирдлын ач холбогдол бүхий голомт бүрт ядаж нэг тоноглогдсон судалгааны гидрогеологийн цооногийг гүехэн коллекторт хамгийн ихдээ 10 м гүнд нүхлэнэ. Цаашлаад голомтын орчимд 3-5 гар зондыг газрын гадаргаас доош

ойролцоогоор 2-3 м-т бохирдлын талбайн ба гүний тархалтыг тодорхойлох зорилгоор нүхлэнэ.
Зардал багасгахын тулд их хэмжээний бохирдлын шинж тэмдэг ил харагдах газруудаас дээж авах буюу энэ нь тостой, нүүрсустөрөгчийн хүнд фракцын өндөр агууламжтай, газрын тосны бүтээгдэхүүн илт мэдрэгдэх дээжүүд байна. Ингэж ихээр бохирдсон материалуудаас, голдуу хөрс шороонооос бохирдлын найрлага, цаашлаад бохирдлын дээд утгыг тодорхойлох зорилгоор зөвхөн хязгаарлагдмал тооны дээж авах юм.
Цооногууд ба тоноглоогүй зондуудыг нарийн тогтоох ажил төсөл эхэлсний дараа хийгдэх газар нутгийн урьдчилсан тандалтын хүрээнд хийгдэнэ.

4. Талбайн өнөөг хүртэл судлагдсан байдал

Тус талбайн тухай бүх мэдээллийг 2014 оны 5, 6 дугаар сард хийсэн асуулгын кампанит ажил, хээрийн судалгаагаас гадна Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны дэргэдэх Химийн хорт болон аюултай бодисын үндэсний зөвлөлийн дарга, Сайншанд, Зуунбаяны байгаль орчны мэргэжлийн хяналтын байцаагч, уул уурхайн Доншен компанийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын үндсэн дээр цуглуулсан болно.

Тус газрын мэргэжлийн хяналтын байцаагчдаас авсан мэдээлэл болон санал асуулгын дагуу Доншен компани 2009 онд уг газар нутагт зориулан бохирдлын судалгаа хийлгэсэн байна – „Газрын нөхцөл байдал ба улсын мэргэжлийн хяналтын байгууллагын тайлан“. Тайланг олж авч чадаагүй. Олборлолтын ажил эхлүүлэхийн өмнө газрын лицензийн хүрээнд бохирдлын байдлыг урьдчилан зурагжуулсан бололтой.

Доншены төлөөлөгчдийн өгсөн мэдээллийн дагуу Байгаль орчны тухай өөр нэгэн тайланг 1997 онд АНУ болон Канадын (Cambridge, Stratford University) мэргэжилтнүүд монгол мэргэжилтнүүдийн адилаар боловсруулсан байна. Төслийг Дэлхийн болон Азийн банкнаас санхүүжүүлжээ.

Доншен компанийн төлөөлөгчдийн мэдээлснээр 1994 онд газар нутагт газрын тосны хайгуул хийгдсэн.

Аймгийн байгаль орчны салбарт тус газар нутаг дахь хятадын лицензийн „байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө“ бий (боловсруулсан: ENCO XXK, Улаанбаатар, 2013). Уг баримтад мөн хөрсний хэд хэдэн дээжээс (1 м хүртэлх гүнд зондоос авсан интервалт дээжүүд) авсан хүнд металлын агууламжийн шинжилгээ байгаа бөгөөд 2009 оных бололтой. Дурдсан үр дүнгээс зөвхөн хөрсөнд агуулагдах кобальтын Монгол Улсын 5850:2008 стандартын хязгаартай харьцуулсан өндөр агууламж сонирхол татаж байна.

Дүншен компанийн бүс дэх хоёр цооногийн техникийн баримт бичиг бэлэн байна.

4.1. Газар нутаг дээрх бохирдлын эх үүсвэр

Газар нутгийг сүйтгэсэн, хөрсний, гадаргын болон газар нутагт орших гүехэн уст үед агуулагдах газар доорх усны бохирдлын эх үүсвэр бол түүхий газрын тосны түүхэн ба одоо буй олборлолт, газрын тосны лагийн ачилт тээвэрлэлт мөн. Цооногийн толгойн бат нягт бус байдал, түүхий газрын тосоор талхлагдан хучигдсан өргөн уудам газар ба элстэй холилдсон газрын тосны лаг бүхий хуучин цөөрөм зэрэг нь асуудлыг үүсгэж байгаа юм. Одоогийн олборлолтын үйл ажиллагаа газрын тосны лаг тээвэрлэлтээр –

аюулгүй байдлыг хангалтгүй хийсэн цөөрмөөс уг дэвсгэр чулуулаг болон газар доорх ус руу газрын тосны бүтээгдэхүүн алдагдах замаар эрсдэл учруулж байгаа юм.

Хүрээлэн буй орчин, мал сүрэгт учруулах эрсдэлд хотоос гарах хаягдал усыг, нэн ялангуяа бактерийн бохирдлын үүднээс үзэхэд, газар доорх усыг бохирдуулж болзошгүй халдвартай хаягдал усыг байгальд шууд асгах зэрэг орно.

4.2. Талбай дээр өнөөг хүртэл хийгдсэн судалгаа

2014 оны урьдчилсан судалгааны явцад хөрсний 20, усны 6 дээж авсан. Авсан дээж, түүний байршлын тухай мэдээллийг дараах хүснэгтээр харуулсан байна.

Хүснэгт 1. Авсан дээжийн тойм (2014)

Дээж	Дээжлэлт хийсэн газрын солбилцол	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинжилгээ	Тайлбар
21GW2, 21GW2A	х.ө.44.485147° з.у.110.049240°		ХМ, Hg-Cd, ХҮШ, ПАН, NEL, BTEX ХМ	Доншен компанийн нутаг дэвсгэр дээрх 70 м гүн ундны усны худгаас авсан. Компанийн ашиглалтын зориулалтаар усыг тодорхой бус аргаар боловсруулдаг. үзүүлэлтүүд: 1550 µS/см, 8.5 pH, O_2 -р 100% ханасан, 13° С
21GW3	х.ө.44.485669° з.у.110.052552° (худгийн солбилцол)		ХМ, Hg-Cd, ХҮШ, ПАН, NEL, BTEX	Ус нөөцлүүрээс авсан дээж. Хотын хэрэгцээнд зориулсан усыг худгаас авч, нөөцлүүрт хуримтлуулан ус боловсруулах нэгжид боловсруулдаг. үзүүлэлтүүд: 1425 µS/см, 8.7 pH, O_2 -р 97% ханасан, 13,5° С
21GW4	х.ө.44.455772° з.у.110.030367°		ХҮШ, ПАН, NEL, BTEX	Мал услах онгоцтой гүехэн худгаас авсан дээж. Худгийн гүн 1,4 м, усны түвшин буюу усны баганы өндөр: 0,6 м. үзүүлэлтүүд: 3,88 mS/см, 7,6 pH, O_2 -р 38% ханасан, 22° С
21GW5	х.ө.44.469970° з.у.110.056618°		ХМ, Hg-Cd, ПАН, NEL, BTEX	Хотын бохир усны шугамын бололтой асгах цэгээс авсан бохир усны дээж – хүхэрт устөрөгчийн үнэр. Асгагдаж байгаа уснаас жижиг нуур үүсч (адуу мал, ан амьтны услах газар болсон), орчин тойрондоо тэлсэн газарт ургамал их хэмжээгээр ургадаг. Дээжлэлтийн цэг хүртэл газрын гадаргууд гардаг хяналтын худаг бүхий газар доорх шугам хоолой татсан байна. үзүүлэлтүүд: 1810 µS/см, 7,6 pH, O_2 -р 1%

Дээж	Дээжлэлт хийсэн газрын солбилцол	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинжилгээ	Тайлбар
				ханасан, 15° C
21SW1, 21SW1A 21SW3	х.ө.44.484021° з.у.110.061389°		ХМ, Hg-Cd, ПАН,NEL,BTEX ХМ, Hg-Cd ХМ	Урьд нь хоолой байсан газарт ухсан нүхэнд хуримтлагдсан гадаргын усны дээж. SW1A, 21SW3 хоёр дээж авсан байна. үзүүлэлтүүд: 19.16 mS/ см, 9.4 pH, O_2 -р 127% ханасан, 24° C
21SW2	х.ө.44.488372° з.у.110.054973°		ХМ, Hg-Cd, ПАН, NEL, BTEX	Доншен компанийн ашигладаг газрын тосны лагийн нуурны гадаргын усны дээж. Нууранд газрын тосны цооногоос хаягдал ус асгадаг гэж бидэнд мэдээлсэн. үзүүлэлтүүд: 915 µS/см, 8,85 pH, O_2 -р 110% ханасан, 23° C
21SD1/0,7-1,3 21SD1/2,1-2,6	х.ө.44.486012° з.у.110.057695°	0,7-1,3 2,1-2,6	ХМ, Hg-Cd, ПАН, NEL NEL	Шаварт ул сууриар бэхжүүлсэн элстэй холилдсон газрын тосны хатсан үлдэгдэл бүхий нууранд өрөмдсөн цооногоос (134 х 36 м, 2 м гүн) авсан холимог дээж. 0-1 см байгалийн асфальт 0-0,3 м байгалийн асфальтаар ханасан элс 0,3-0,7 м байгалийн асфальттай элс (гүн болох тусам ханасан байдал багасдаг) 0,7-1,0 м газрын тосоор бохирдсон элс (гүн болох тусмаа бохирдол багасдаг) 1,0-1,3 м газрын тосоор бага зэрэг бохирдсон элс 1,3-2,1 м саарал өнгөтэй, уян хатан шавар 2,1-2,6 м 1 мм-с дээшгүй жижиг ширхэгтэй цайвар элс (газрын тосны сул үнэртэй)
21ST1	х.ө.44.486220° з.у.110.057618°	0 – 0,1	ПАН, NEL	Газрын тосны хатсан лаг шингэсэн нуурын захаас (11SD1 дээж авсан газраас) авсан бор хар өнгөтэй элсний холимог дээж.
21SD2/0,5-0,8	х.ө.44.483502° з.у.110.067525°	0,5 - 0,8	ПАН, NEL	Хотоос хяналтын худаг бүхий шугам хоолой татсан газарт газрын тосны хатсан лагийн хуучин нууранд өрөмдсөн цооногоос авсан хөрсний холимог дээж. Нуур 12 орчим га талбайтай байна. 0,0- 0,4 м газрын тос шингэсэн элс 0,4-0,45 м элс 0,45-0,5 м газрын тосны үнэртэй, саарал өнгөтэй элс 0,5-0,8 м ба түүнээс илүү гүнд газрын тос шингэсэн тосны солонгоор гэрэлтсэн туяатай,

Дээж	Дээжлэлт хийсэн газрын солбилцол	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинж илгээ	Тайлбар
				хар өнгөтэй элс - газрын доорх усны түвшин 0,8 м орчим гүнд байна, усны гадаргад тосны нимгэн давхарга
21ST2	х.ө.44.483502° з.у.110.067525°	0 – 0,1	ПАН, NEL	Газрын тосны хатсан лаг шингэсэн нуурын бор элсний холимог дээж (21SD2-г авсан газраас авсан).
21ST3	х.ө.44.487718° з.у.110.056637°	0,02–0,05	ПАН, NEL	Газрын тосны хатсан лаг бүрхсэн талбайн гадаргын элсэрхэг хөрсний холимог дээж. Дээж авсан газарт гадаргыг лагаас цэвэрлэсэн. Борооны усны урсгалаар зайлдаг газар.
21SD3/0,2-0,6	х.ө.44.487718° з.у.110.056637°	0,2-0,6	ПАН, NEL	21ST3 дээж авсан газарт 1,2 м гүнд өрөмдсөн зондын хөрсний холимог дээж. - зондын дээд тал 0,2 м гүн хүртэл газрын тосны нүүрсустөрөгчөөр ихэд бохирдсон байна, түүнээс илүү гүнд элс, 1 м-с доош шавар нэмэгдэж байгаа ба газрын тосны бүтээгдэхүүний үнэр 0,75 м гүн хүртэл үнэртэж байна.
21ST4	х.ө.44.485293° з.у.110.060858°	0,02–0,05	ПАН, NEL	Газрын тосны хатсан лагаар бүрхсэн талбайн гадаргаас авсан элсэрхэг хөрсний холимог дээж. Дээж авсан газарт гадаргыг лагаас цэвэрлэсэн. Борооны усны урсгалаар зайлдаг газар. 21ST4 дээж авсан газраас холгүй 1 м гүн хүртэл өрөмдсөн зонд хийсэн (үнэргүй, зөөлөн, цайвар хүрэн өнгөтэй элс).
21SD4/0-0,4 21SD4/0,4-1,2	х.ө.44.484760° з.у.110.061197°	0-0,4 0,4-1,2	ПАН, NEL ПАН, NEL	Ойр хавиас борооны ус хуримтлагддаг улирлын чанартай хуурай нуур байдаг газрын 1,2 м гүнд өрөмдсөн зондын хөрсний холимог дээж. Газар доорх ус 1 м гүнд илэрсэн. 0,0-0,4 м газрын тосны нүүрсустөрөгчөөр ханасан хар өнгөтэй элс 0,4-0,7 м бага зэрэг ханасан бор өнгөтэй элс 0,7-1,2 м газрын тосны нүүрсустөрөгчөөр ханасан саарал өнгөтэй элс (хурц үнэртэй)
21ST5	44.457863°s.š. з.у.110.043882°	0 – 0,1	NEL	Газрын тос одоог хүртэл гарсаар байдаг хуучин цооног, бяцхан булаг бүхий, тэмээ зэрэг малын бэлчээр бололтой, ногоон дэнжийн ойр хавийн гадаргуунаас авсан хөрсний холимог дээж Дээжийг шавар устай газраас авсан. Гадаргад хатсан давсны давхарга, газрын тосны бүтээгдэхүүний бага зэрэг үнэртэй, шаварлаг, элсэрхэг хөрстэй, уулын энгэрээс бороонд туугдсан бололтой. Ойр хавьд 1,1 м гүн хүртэл өрөмдсөн зонд байна (гадаргууд шавартай элс, цаашид зөвхөн шавар,

Дээж	Дээжлэлт хийсэн газрын солбилцол	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинж илгээ	Тайлбар
				үнэргүй).
21SD5/0,1-0,4	44.456142°s.š. з.у.110.043920°	0,1 - 0,4	NEL	Доншен компаниас идэвхтэй явуулж буй олборлолтын талбайн бэхжүүлсэн замын хажуудах улирлын чанартай нуурын тэнд өрөмдсөн зондоос авсан хөрсний холимог дээж. Гадаргад хатаж хагарсан шавар, доошоо нь ногоовтор өнгөтэй элсэрхэг шавар.
21SD6/0,6-0,9	44.455545°s.š. з.у.110.043845°	0,6 - 0,9	NEL	21SD5 дээжийн авсан газарт замын доорх холойгоос гардаг улирлын чанартай горхины хавьд 1,2 м гүнд өрөмдсөн зондоос авсан хөрсний холимог дээж. Гадаргад зөөлөн цагаан элс 0,6 м доошгүй гүнд элсэрхэг шавар, уян хатан бага, шаравтар – ногоовтор өнгөтэй 0,6-0,9 м саарал, шар өнгөтэй зөөлөн ширхэгтэй элс (1 мм-с дээшгүй ширхэгтэй), бага зэрэг шаварлаг хольцтой 0,9-1,2 м шавар (үнэргүй)
21SD7/0,3-0,5	44.467774°s.š. з.у.110.057171°	0,3 - 0,5	ПАН, NEL	Хотын бохир усны бололтой шугам хоолойноос гардаг усаар усладаг бэлчээрт ойрхон, жижиг хөндийд ухаж хийсэн зондноос авсан хөрсний холимог дээж. (үнэргүй) 0,0-0,2 м хүрэн шар өнгөтэй элсэрхэг, шаварлаг хөрс 0,2-0,4 м хар өнгөтэй элсэрхэг, шаварлаг хөрс 0,4-0,7 м саарал өнгөтэй элсэрхэг, шаварлаг хөрс
21SD8/1,0-1,2	44.465893°s.š. з.у.110.054827°	1,0 - 1,2	NEL	Хааяа ус урсдаг бага зэрэг хөндий газарт 1,2 м гүнд өрөмдсөн зондоос авсан хөрсний холимог дээж. Газар доорх усны түвшин 1 м гүнд илэрсэн (огт үнэргүй) 0,0-1,0 м саарал өнгөтэй элс 1,0-1,2 м усархаг хүрэн шар өнгөтэй элс
21SD9/0,8	44.471465°s.š. з.у.110.060450°	0,8	ПАН, NEL	Ус нөөцлүүр бололтой том оврын бетон сангийн үлдэгдлийн дэргэдэх “бассейны” нэгэнд 0,8 м гүнд өрөмдсөн зондоос авсан хөрсний дээж. Цайвар хүрэн өнгөтэй элс, үнэргүй, газар доорх ус 0,7 м-с доош байна. ус нөөцлүүрт илүү ойрхон, хажуугийн “бассейн”-д хийсэн өөр нэгэн зондоос авсан дээжийн элс цайвар хүрэн өнгөтэй, үнэргүй байсан.
21SD10/0,2-0,5	44.471405°s.š. з.у.110.060447°	0,2 - 0,5	ПАН, NEL	Элстэй холилдож өтгөрсөн газрын тосны хуучин лагийн давхаргыг хуулж авсан хуучин нууранд өрөмдсөн хоёр зондноос авсан холимог дээж. Нэг газарт ургамал их хэмжээгээр

Дээж	Дээжлэлт хийсэн газрын солбилцол	Дээжлэлт хийсэн гүн (м)	Шинжилгээ	Тайлбар
				ургадгийг үзвэл улирлын чанартай нуур байгаа бололтой. Давстай давхарга бүхий гадаргатай, цайвар хүрэн элстэй, зарим хэсгээр шаврын хольцтой.
21ST6	44.468733°s.š. з.у.110.069390°	0,1 - 0,2	ПАН, NEL	Олборлолтын идэвхтэй талбай дээр оршдог хуучин цооногийн орчимд байсан хагалсан бохир хөрсний холимог дээж.
21SD11/0,3-0,5 21SD11/0,8-1,0	44.467167°s.š. з.у.110.070877°	0,3-0,5 0,8-1,0	ПАН, NEL ПАН, NEL	Бохирдсон талбайгаар дамжин Хятад Улсын нутаг дэвсгэрт урсаж байгаа улирлын чанартай голын гүехэн сайранд 1,1 м гүнд өрөмдсөн хоёр зондноос авсан хөрсний холимог дээж. Газар доорх ус 0,9 м гүнд байгааг илрүүлсэн. 0-0,3 м 1 см-с дээшгүй том ширхэгтэй бор хар өнгөтэй элс, бага зэрэг газрын тосны үнэртэй, ойр хавийн газрын гадаргуунд элстэй холилдсон газрын тосны өтгөрсөн лагийн үлдэгдэл байна 0,3-0,5 м эвгүй үнэртэй хар өнгөтэй элс 0,5-0,7 м саарал өнгөтэй зөөлөн ширхэгтэй нойтон элс

Дараах хүснэгтээр тухайн талбай дээр авсан хөрс болон газар доорх усны дээжийн шинжилгээний зарим сонгомол дүнг харуулсан. Тодоор тэмдэглэсэн утгууд нь монголын болон олон улсын зарим тогтоомжид заасан дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

Хүснэгт 2. Хөрс дахь органик бохирдуулагчийн агууламж (ПАН-ы үр дүнг Монгол Улсын MNS 6148:2010 стандартад заасан утгуудтай харьцуулсан байна)

Үзүүлэлт	нэгж	Дээж							
		21ST1	**21SD1/0,7-1,3**	**21SD1/2,1-2,6**	**21ST3**	**21SD3/0,2-0,6**	**21ST4**	**21SD4/0-0,4**	**21SD7/0,3-0,5**
NEL	**мг/кг-хуурай жин**	**47800**	**7760**	97	378	706	31	**38000**	**11400**
ПАН	**мг/кг-хуурай жин**	**16,3**	1,57	-	0,847	0,313	-	6,52	2,4
		Дээж							
		21ST6	**21SD11/0,3-0,5**	**21SD11/0,8-1,0**	**21ST2**	**21ST5**	**21SD6/0,6-0,9**	**21SD2/0,5-0,8**	**21SD7/0,3-0,5**
NEL	**мг/кг-хуурай жин**	**35500**	**12000**	149	**25600**	**4300**	25	**1930**	26
ПАН	**мг/кг-хуурай жин**	1,64	**24,1**	0,163	**10,9**	-	-	**9,74**	-

Газар доорх усанд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрч болохуйц хэмжээг заасан Монгол Улсын MNS 6148:2010 стандарт ПАН бүлгийн 13 бодисыг тодорхойлж өгч байна. Үүнд, аценафтен, антрацен, бензо(а)антрацен, бензо(а)пирен, бензо(b)флуорантен, бензо(k)флуорантен, хризен, дибензо(a,h)антрацен, флуорантен, флуорен, индено(1,2,3-c,d)пирен, нафтален, пирен.

Хүснэгт 3. Хөрсөнд агуулагдсан металлын хэмжээ

Дээж	Элемент (мг/кг-хуурай жин)					
	As	Cr	Cu	Ni	Pb	Zn
21SD1/0.7-1.3	8,59	87,30	29,09	12,70	13,41	43,26

Хөрсний дээжийн химийн шинжилгээгээр газрын тосны агууламжийн өндөр найрлага ба хорт хавдар үүсгэгч бензо(а)пиренийг (4,05 мг/кг хуурай хүртэлх) оролцуулаад ПАН-ы өндөр агууламжтай болохыг газрын гадаргуу дээрх газрын тосны хатсан лаг, газрын гүнд байх газрын тосны хуучин цөөрөм, цаашлаад борооны ус цуглардаг газруудад (улирлын чанартай нуур) авсан дээжүүдээс батласан. Газрын тосны хатсан лагийн талбайгаас гаднах газруудад газрын гадаргын хөрс шороонд агуулагдах газрын тосны бүтээгдэхүүн ба ПАН-ы агууламж бага болохыг үр дүн үзүүлсэн – тэдгээр нь асгарсан болох нь илэрхий хэдий ч гадаргаас доош бохирдол нэмэгдэж байгаа юм. Хүртээмжтэй байгаа өгөгдлүүдийн үндсэн дээр (хязгаарлагдмал тооны хөрс шорооны зондоос) газрын тосны нүүрсустөрөгчийн бохирдол зондууд (цөөрмөөс бусад) дахь гүн нэмэгдэх бүрт (ж.нь: 0,5 м г.г.д гүнээс эхлэн) буурч байгааг батлаж болох юм.
ПАН-ы хамгийн өндөр дүн, мөн бензо(а)пирений агууламж олборлолт явагдаж буй газраар дамжин өргөн уудам, тэгш хөндийд цутгадаг, улирлын чанартай, гүехэн голын голдрилд байх зондын хөрсөнд олдсон нь гайхмаар.
Газрын тосны бүтээгдэхүүн дээр дурдсан хөрсний дээжүүдэд монгол улсын стандарт (яаралтай сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагатай) төдийгүй, дэлгэрэнгүй судалгаа эсхүл нөхөн сэргээх арга хэмжээ авахыг шаардаж буй Dutch standards-ын арга хэмжээний утгыг оролцуулаад бохирдлын харьцуулагч илтгэлцүүрээс хэтэрсэн концентрацитай байна. Энд монгол улсын 5850:2008 стандартын зүгээс газрын тосны бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх хамгийн дээд утгад тавигдах шаардлага маш хатуу (голланд ба чехийн стандарттай харьцуулсныг үзнэ үү) бөгөөд уг бохирдуулагчдын бүлэгтэй холбогдох бодит эрсдэлтэй нийцэхгүй байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.
Хэд хэдэн дээжүүдэд, ялангуяа хатсан газрын тосны лагт бензо(а)пирений концентраци аж үйлдвэрийн бүсэд зориулсан монгол улсын 5850:2008 стандартын дагуу, мөн түүнчлэн БНЧУ-ын Байгаль орчны яамны аргачлалын удирдамжийн дагуу аж үйлдвэрийн бүс дэх хөрсний бохирдлын илтгэлцүүр утгын адилаар аюулын түвшнээс хэтэрсэн болохыг тогтоосон. Ийм бохирдуулагчийн хувьд хүний биед баталгаатай хорт хавдар үүсгэгч мөн байтал MNS 5850:2008 нь маш өгөөмөр хандсан байгаа юм. Металлын агууламж тус газраас авсан хөрсний дээжийн зөвхөн нэгэнд л шинжлэгдсэн. Зөвхөн хөдөө аж ахуйн хөрсөнд тавигдах хязгаараас нэлээд хэтэрсэн хүнцлийн агууламж тэмдэглэгдсэн байна.

Хүснэгт 3 – Газар доорх болон гадаргын усанд агуулагдсан органик бохирдуулагчийн хэмжээ

Бодис	нэгж	Авсан дээж		
		21SW1	21SW2	21GW5
Бензол	µg/l			1,05
Этилбензол	µg/l			2,31
Ксилен	µg/l			11,5
Толуол	µg/l			6,7
BTEX-ы нийлмэл дүн	µg/l			21,5
NEL	mg/l	0,22	0,16	0,54
ПАН	µg/l			2

Газар доорх усны хот ба Доншен компанийн бүсийг хангах зориулалттай 21GW2, 21GW3 дээжүүдэд (гүний уст үеэс авсан) хонь услах зориулалттай гүехэн худгаас авсан 21GW4 дээжийнхтэй адилаар ажиглагдах ямар ч бохирдол илрээгүй. Иймээс үр дүн хүснэгт 3-т байхгүй болно.

Хүснэгт 4. Газар доорх усанд ууссан металлуудын агууламж

Дээж	Элемент (мг/л)											
	As	Cd	Cr	Cu	Ni	Pb	Zn	Hg	Mo	Sb	U	V
21SW1	**0,17**	<0,005	<0,02	<0,01	0,01	<0,01	0,01	<0,001	-	-	-	-
21SW2	**0,03**	<0,005	<0,02	<0,01	<0,01	<0,01	<0,01	<0,001	-	-	-	-
21GW5	<0,01	<0,005	<0,02	<0,01	<0,01	<0,01	0,01	<0,001	0,003	0,001	0,007	0,008
21GW2	0,01	<0,005	<0,02	<0,01	<0,01	<0,01	<0,01	<0,001	-	-	-	-
21GW3	0,01	<0,005	<0,02	<0,01	<0,01	<0,01	<0,01	<0,001	-	-	-	-

Борооны ус цуглардаг хотгороос авсан гадаргын усны дээжүүдэд MNS 4568:1998 стандартын дагуу гадаргын усанд агуулаглах эрдэст тосны агууламжийн зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээг давсан концентрацитай газрын тосны бүтээгдэхүүнүүд л зөвхөн илэрсэн. Гэвч гүйцэтгэгдсэн NEL (туйлт бус хандлагддаг бодисууд) бүлгийг тодорхойлогч ерөнхий шинжилгээ голдуу зөвхөн газрын тосны саяханы бохирдлыг илтгэх зориулалттай. Удаан хугацааны түүхэн бохирдлын хувьд анхны нүүрсустөрөгчийн хэлхээ суларч, үүссэн бүтээгдэхүүн туйлт бодисууд болсон байх боломжтой.

Зарим дэгдэмхий ароматик нүүрстөрөгчүүд болох BTEX (толуол, ксилен) зэргийг оролцуулаад газрын тосны бүтээгдэхүүний өндөр утгууд 11GW5 дээж авсан газрын гадаргуу дээр ундарч гарсан хаягдал усанд илэрсэн байсан. Ялангуяа MNS 4568:1998 стандартын дагуу гадаргын усанд байх эрдэст тосны агууламжийн зөвшөөрөгдөх дээд утгаас хэтэрсэн газрын тосны бүтээгдэхүүний агууламж. Хаягдал усны асгалтад тавигдах шаардлагыг тодорхойлогч монгол улсын стандарт MNS 4943:2011 нь хаягдал усанд илэрсэн органик бохирдуулагчдад хязгаар утга дурдаагүй байна. Ийм хаягдал усыг байгальд шууд асгаж түүнийг мал сүргийн усалгаанд ашиглаж байна.

Хүснэгт 4-өөр үзүүлсэн газар доорх усны дээжүүдэд ууссан металлын концентраци, гадаргын усанд байхыг зөвшөөрсөн хэмжээнээс 17 дахин их хэтэрсэн хүнцлийг эс

тооцвол (усны шугам хоолойн дагуух хонхорт үүссэн нуурын уснаас авсан усны дээж) газар доорх эсхүл гадаргын усны чанарын монголын болон голландын аль ч стандартуудад зааснаас онц чухлаар хэтрээгүй.

21GW2, 21GW3 ба 21GW4 дээжүүдээс авсан усны химийн найрлагын үндсэн шинжилгээнээс тус газар орших газар доорх ус чулуулгийн орчны байгалийн нөхцлүүдээс үүссэн катион болон анионуудаар хүчтэй эрдэсжсэн болохыг илрүүлсэн.

Газрын гадаргуу дээрх нүдэнд ил харагдах бохирдол болон 1,5 м г.г.д гүнд хөрсний бохирдлын илэрсэн түвшнээс үзэхэд газрын тосны бүтээгдэхүүн ба ПАН чулуулгийн орчны гүний давхаргуудад буюу гүехэн газрын зондоор дайрч өнгөрсөн гүехэн уст үе дэх газар доорх усанд хүрч нэвтэрсэн хэмээн үзэж байна. Чулуулгийн бүсийн болон газар доорх усны бохирдлын үүднээс үзэхэд ялангуяа газрын тосны лаг цуглуулах зориулалттай, хамгаалал хийгдээгүй хуучны болон одоогийн цөөрмүүд өмнөх олборлолтын дараах бат нягт бус цооногуудын адилаар эрсдэл учруулж байна.

Хот болон Доншен компанийн бүсэд ундны усны эх үүсвэр болон ашиглагддаг гүний уст үе рүү орох бохирдуулагчийн дамжилт, түүний гүехэн уст үетэй холбогдсон байх магадлал гүехэн уст үеийн суурь дээрх шавар изоляторын таамаглаж буй зузаан бүхий давхаргаас үзэхэд маш бага. Энэ нь гүний уст үеээс авсан газар доорх усны дээжийн шинжилгээнүүдийн өнөөг хүртэлх сөрөг үр дүнг батлаж байгаа юм.

Бохирдлын тархалт газар нутаг дахь нам доор байрлал уруу бороонд усаар зайлагдаж, мөн цаашлаад хотоос өмнө зүгт орших газрын төвд орших гадагшаа урсацгүй хөндий рүү улирлын шинжтэй урсацаар дамжин явагддаг байх магадлалтай.

Газрын тосны бохирдлын тархалт тоосонцрын ширхэгүүдээр салхиар зөөгдөх магадлал маш бага. Газрын гадаргаас тоосонцрын ширхэгийн зөөлөн фракцуудад газрын тосны нүүрсустөрөгч ба ПАН-ы бохирдол илрээгүй – асгарч, нарны илчээр буурсан нь ойлгомжтой.

4.3. Бохирдлын урьдчилсан концепци загвар

Талбайн урьдчилсан судалгааны явцад олдсон мэдээллийн үндсэн дээр бид газрын тосны олборлолт, газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт, ашиглалт, тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны улмаас бохирдсон талбайн урьдчилсан концепци загварыг боловсруулсан.

Хорт нөлөөний өртөлтийн гарч болзошгүй бүх боломж, бохирдлын тархалтын замууд судлагддаг талбайн нөхцөл байдал, өнөөгийн болон төлөвлөж буй ашиглалт, бохирдлын тодорхойлсон боломжит эх үүсвэр зэрэгт хамааруулсан байна Бохирдлын үзүүлж болзошгүй гэж үзсэн нөлөөг бүх талаас нь харгалзсан тоймыг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулсан байна.

Хүснэгт 5. Судлагддаг талбайн урьдчилсан концепцийн загвар

Бохирдлын эх үүсвэр	Тархах зам	Эрсдэл хүлээн авагч	Нөлөөний төрөл	Сонголтын үндэслэл
Газрын тосны лагийн тусгаарлагдаа гүй нуур, суларсан цооногууд	Газрын тосны бодис хүрээлэн буй орчинд шингэсэн	Газрын гадаргуу, чулуулгийн орчин, газар доорх ус	Хөрс, чулуулгийн орчин, газрын доорх ус, холбогдох экосистемүүдийн чанарт сөргөөр нөлөөлөх	Чулуулгийн орчин, газар доорх усны хувьд тусгаарлагдаагүй газрын тосны лагийн шинэ ба хуучин нуур, ЗХУ-ын олборлолтын үеэс үлдсэн суларсан цооногууд хамгийн ноцтой бохирдол үүсгэж болзошгүй.
Талбайн хөрс бохирдсон байна	- (шууд нөлөө)	Олборлолтын компанийн ажилтнууд, малчид, мал сүрэг, ан амьтан	Хөрс, шороо залгих Хөрс, шороо хүний арьсанд хүрч нөлөөлөх Тоос, тоосонцорыг амьсгалах	Уурхайн машин механизмыг ажиллуулж, газар шорооны ажил хийдэг ажилчид бохирдсон хөрсний нөлөөнд өртсөн байдаг. Үүгээр барахгүй нутгийн малчид, мал, ан амьтан, тэдний мах, сүүгээр дамжуулан бусад хүмүүс ч уг талбайн бохирдлын нөлөөнд өртсөн байдаг.
	Бохирдол тус талбайн гадаргын усанд орно	Мал сүрэг, ан амьтан	Ус уух Ус хүний арьсанд хүрч нөлөөлөх	Үхэр, адуу, тэмээ зэрэг мал, ан амьтан тухайн талбайд байдаг бүхий л усыг унданд ашиглан. Бохирдол малын мах, сүүнд хуримтлагдаж болзошгүй.
	Чулуулгийн орчноор дамжиж газрын доорх усанд орно	Түс талбай, түүний ойр хавийн газар доорх ус	Түс талбай, түүний ойр хавийн газар доорх усны чанарт үзүүлэх сөрөг нөлөө	Тухайн газрын бохирдол борооны усаар зөөгдөж газар доорх усанд орсны улмаас газар доорх усны чанар муудаж болзошгүй.
Тухайн талбайн газар доорх ус бохирдсон байна	Бохирдол газар доор усаар зөөгдөнө	Талбай, түүний ойр орчимд оршин суудаг хүмүүс, мал сүрэг	Ус уух Ус хүний арьсанд хүрч нөлөөлөх	Түс талбайн орчимд байдаг худгийн ус ашигладаг малчид төдийгүй мал амьтан бохирдлын сөрөг нөлөөнд өртсөн байж болзошгүй.

Хаягдал ус асгадаг	- (шууд нөлөө)	Уул уурхайн компани, малчид, мал сүрэг, ан амьтан	Ус, тунадас залгин уух Ус, тунадас арьсанд хүрч нөлөөлөх Тоос, тоосонцорыг амьсгалах	Уурхайн машин механизмыг ажиллуулж, газар шорооны ажил хийдэг ажилчид хаягдал усны нөлөөнд өртсөн байдаг. Үүгээр барахгүй нутгийн малчид, мал, ан амьтан, тэдний мах, сүүгээр дамжуулан бусад хүмүүс ч уг талбайн бохирдлын нөлөөнд өртсөн байдаг.
	Газар доорх усаар зөөгдөнө	Тус газрын ойр хавийн иргэд, мал сүрэг	Ус уух Ус арьсанд хүрч нөлөөлөх	Тус талбайн орчимд байдаг худгын ус ашигладаг малчид төдийгүй мал амьтан бохирдлын сөрөг нөлөөнд өртсөн байж болзошгүй.

4.3.1. Эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн урьдчилсан үнэлгээ

Газар нутгийн тандалт болон лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн газрын гадаргын ба хөрсний профилийн гүехэн давхаргын газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон талбайн бохирдлын хэмжээ өндөр байгааг батласан. Газрын тосны бүтээгдэхүүнүүд мөн газрын гадаргын хотгоруудад цугларсан гадаргын усанд ч өндөр концентрацитай илэрсэн. Үүний зэрэгцээ хөрсөнд хорт хавдар үүсгэгчдийн төлөөллүүдийг оролцуулаад өргөн хүрээний ПАН-ы бохирдол бага зэрэг илэрсэн.

Газрын тосны бохирдол нь зөвхөн чулуулгийн орчноор дамжин газар доорх усанд хүрдэг бус, мөн улирлын шинж чанартай үүссэн гол горхиор дамжин бүс нутгийн төв хэсэгт орших, гадагшаа урсацгүй өргөн уудам хөндийд хүрдэг. Үүнээс үзэхэд байгальд учирч болзошгүй эрсдэл буюу өргөн уудам газар нутаг бүхий хүрээлэн буй орчинд учрах хор нөлөө онц ноцтой байна.

Уул уурхайн компанийн ажилчид, орон нутгийн малчдын эрүүл мэндийн эрсдэл ялангуяа газар шороотой шууд харьцдаг (санамсаргүйгээр залрих, арьсанд хүрэх, бохирдсон тоосонцрын хэсгүүдээр амьсгалах) тул хамаатай. Хүний биед үзүүлэх газрын тосны бүтээгдэхүүний хор ба ПАН-ы агууламж бага тул уг эрсдэлийг онц ноцтой хэмээн үзэхгүй байж болох хэдий ч урт хугацааны турш нөлөөж буй тул үл хэрэгсэж болохгүй.

Газрын хотгорт цугларч, газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон усыг цорын ганц усны эх үүсвэр болгон зэрлэг болон аж ахуйн ан амьтад ууж байгаа нь онц ноцтой эрсдэлийг үүсгэж байгаа юм. Бие организд ПАН амьсгалын ба хоол боловсруулах замаар дамжин, арьс ба салст бүрхэвчээр шингэн ордог. Бие организд ПАН нэвтрэх хамгийн түгээмэл замд тамхи татдаггүй хүмүүсийн хувьд бохирдсон хүнс хэрэглэх,

бага насны хүүхдүүдийн хувьд бохирдсон хөрс, тоосыг санамсаргүй залгих зэрэг багтана. ПАН нь өөх тосонд уусдаг, биед маш түргэн шингэдэг бөгөөд цусны эргэлтээр дамжин аль нэг эрхтэнд хүрдэг байна. ПАН өндөр липофилийн шинж чанартай ч өөхөн давхаргад ноцтойгоор хуримтлагддаггүй гэдгийг онцлох нь зүйтэй. ПАН-ы нөлөө хүний бие организмд арьс, амьсгал, зүрх судас, мэдрэлийн болон ходоод гэдэс, элэг, бөөр, цус төлжүүлэх систем, өөхөн давхарга зэргийн алинд нэвтэрснээс шалтгаалан илэрдэг. Ерөнхийдөө, олон ароматик цөмтэй ПАН нь ноцтой нөлөөтэй буюу хорт хавдар үүсгэх нөлөөтэй байдаг.

4.4. Урьдчилсан судалгааны дүгнэлт

Ажиглагдаж буй газар нутаг нь ялангуяа бохирдлын талбайн тархацаараа онцлог. Газрын тосны нүүрсустөрөгчийн, газрын гадарга дээрх ба газрын гүний давхаргууд дахь ПАН бохирдлын илэрсэн түвшин бат нягт бус цооногийн толгой, ойр тойронд тасралтгүй тархах бохирдлын эх үүсвэр болсон газрын тосны лаг бүхий хуучны төдийгүй одоо байгаа цөөрөм зэрэг нь тус газар нутаг, түүний эргэн тойрон дахь газар доорх усны чанарт аюул учруулах эрсдэлтэй.

Усны эх үүсвэр хангалтгүй бүсүүдэд газар доорх ба газрын гадарга дээрх усны чанарт учирч болзошгүй аюул онц ноцтой асуудал мөн.

Газрын гадаргуу дээрх хотгорт тогтож, газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон усыг зэрлэг болон мал аж ахуйн амьтадын услагааны цорын ганц эх үүсвэр болгон хэрэглэх нь мөн ноцтой эрсдэл мөн юм. Ингэснээр бохирдуулагчид ан амьтад, малын мах, сүүнд хуримтлагддаг. Хотоос гарсан хаягдал усыг байгальд ил задгайгаар асгах нь нэн ялангуяа бактерийн бохирдол, хаягдал усны халдвар тархалтын үүднээс байгаль орчин ба мал аж ахуйд эрсдэл учруулна.

Уул уурхайн олборлолт хийж буй ажилчид, ойр хавийн оршин суугчид, орон нутгийн малчдад учрах эрсдэл багаас дунд зэрэг, энэ нь голдуу бохирдсон газар шороотой шууд харьцаж, тус газрын мал амьтадын мах сүү хэрэглэх түвшинтэй холбоотой.

5. Хийж гүйцэтгэх ажлын дараалал

5.1. Талбайтай анхан шатны журмаар танилцах

Юуны түрүүнд бохирдсон талбайн нөхцөл байдалтай танилцна. Энэ үе шат дараах зорилготой байна. Үүнд,

- 2014 оны урьдчилсан судалгааны хүрээнд олж авсан өгөгдөл, мэдээллийг газар дээр нь шалгах,
- Тохиромжтой бүх гидрогеологийн объектыг тогтоох,
- Өрөмдлөгийн ажлыг төлөвлөх,
- Дээжлэлтийн төлөвлөгөөг зохицуулж, гүйцэт боловсруулах,
- Хүртээмжтэй бүх шинэлэг мэдээллийг олж авах

Талбайтай анхан шатны журмаар танилцах явцад олж авсан мэдээллийг талбайн нэмэлт судалгааны эцсийн тайланд тусгана.

5.2. Газар доорх инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг тогтоох

Өрөмдлөгийн болон судалгааны бусад ажлыг эхлүүлэхээс өмнө тухай талбайд газар доорх инженерийн шугам сүлжээ байгаа эсэхийг тогтооно. Тус талбайд газар доорх шугам, ялангуяа олборлогдсон түүхийн газрын тосыг тээвэрлэх зориулалттай шугам хоолой байх магадлалтай юм. Газар доорх шугам сүлжээ байгаа эсэхийг зөвхөн өрөмдлөгийн цооног, гүехэн цооног зэрэг судалгааны ажил хийхээр төлөвлөж буй газарт шалгаж тогтооно

5.3. Өрөмдлөгийн ажил

5.3.1. Судалгааны гүехэн цооног

Бохирдлын талбайн болон гүний хэмжээг тодорхойлохын тулд ханаагүй бүсэд өрөмдлөгийн судалгаа хийхээр төлөвлөж байх бөгөөд өрөмдлөгийн гүехэн судалгааны цооног өрөмдөнө. Цооногийн байршлыг 2014 оны талбайн урьдчилсан судалгаа, судалгааны ажил эхлүүлэхээс өмнө хийхээр төлөвлөж байгаа талбайтай анхан шатны журмаар танилцсаны үр дүнг үндэслэн тогтооно.

<u>Судалгааны өрөмдлөгийн гүехэн цооног</u>
Талбай дээр 2-3 м гүн хүртэлх буюу нийт 250 у.м бүхий нийт 100 судалгааны гүехэн цооног өрөмдөхөөр төлөвлөж байна. Цооногийг өрмийн машин эсвэл гар ажиллагаатай өрмийн багажаар нүхлэнэ. Судалгааны цооног өрөмдөх зорилгоор чөмгөн өрөмдлөгийн эсвэл тохиромжтой өөр систем ашиглана.
Энэхүү систем нь чулуулгийн биетийн урьдчилан тодорхойлсон гүнээс нарийн үелсэн хөрсний дээжийг авах боломжтой байдгаараа давуу талтай. Холимог дээжийн хувьд чөмгөөс шаардлагатай гүнээс гаргасан үеийг авч холимог дээжийг бэлтгэх боломжтой. Зонд тус бүрээс янз бүрийн гүний хоёр дээж авна.

Судалгааны өрөмдлөгийн гүехэн цооногийн төлөвлөж буй байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцсан дүгнэлтийн үндсэн дээр тогтоогдсон нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно.

Судалгааны гүехэн цооног өрөмдөх ажлын дараалал:

- Өрөмдлөгийн ажлыг эхлүүлэхээс өмнө талбай дээр төлөвлөсөн бүх гүехэн цооногийн байршлыг тодорхойлсон байна;
- цооногийг 60 мм-ээс доошгүй диаметртайгаар хийж өрөмдөнө;
- Татангийг (чөмгийг) шаардлагатай (3 м-с илүүгүй) гүнээс татаж авсны дараа татангаас чулуулгийн дээжийг гаргаж авна. Уг цилиндрт орсон чулуулгийн дээжийг геологч судалж үзнэ;
- шаардлагатай гүний түвшингээс лабораторийн шинжилгээ хийхэд зориулсан хөрсний дээж авна;
- Дээж авалт, геологийн баримтжуулалт хийж дууссаны дараа судалгааны цооногийг хааж, газрын гадаргууг засч тэгшилнэ;
- Хэмжилт шууд хийгээгүй тохиолдолд цооног бүрийг шороогоор дүүргэсний дараа хэмжилт хийх боломжтой болохын тулд уг газрыг гадаргуунд ялгаж болохуйц аргаар тэмдэглэнэ.

5.3.2. Гидрогеологийн судалгааны цооног

Талбай дээр нийт 180 у. м бүхий нийт 30 гидрогеологийн судалгааны цооног өрөмдөхөөр төлөвлөж байна. Геологийн судалгааны цооног бүрийг 6 орчим м-н гүн хүртэл өрөмдөхөөр төлөвлөж байна. Өрөмдлөгийн ажлыг явуулын өрмийн төхөөрөмжөөр эргэлтэт чөмгөн өрөмдлөгөөр хийж гүйцэтгэнэ. Өрөмдлөгийн бүх ажлыг 194 мм-с доошгүй диаметр бүхий өрмийн чөмөглөгчөөр хийж гүйцэтгэнэ. Цооногийг 110 мм болон түүнээс илүү диаметртай ПЭ/ПВХ тоноглолоор тоноглоно. Цооногийн ёроолоос 0,5 м-н түвшин хүртэл болон дээд талаас 4 м хүртэлх тоноглол битүү байх ба үлдсэн хэсгийн тоноглол нүхлэгдсэн профильтэй байна. Тоноглолын цоолбортой хэсгийн эргэн тойрныг тохиромжтой материалаар дүүргэнэ. Газрын гадаргаас доош 4 м-н гүн хүртэлх тоноглолын битүү хэсгийг шаварлаг-цементэн дүүргэгчээр битүүмжилнэ (тоноглолын битүү болон цоолбортой хэсгийг газар доорх усны түвшин, чулуулгийн профиль, бохирдлын түвшин зэрэг цооног тус бүрийн өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно). Цооногийг газрын гадаргаас дээш 0,5 м-н түвшинд гаргасан тагтай төмөр хамгаалагчаар тоноглох бөгөөд цооног бүрийн тэмдэглэгээг хамгаалагч дээр бичиж тэмдэглэнэ.

Цооног өрөмдөх үед аажим аажмаар асгасан хөрс шороонд геологч үзлэг хийж, дүгнэлт бичнэ. Цооног тус бүрээс байлцсан геологчийн дүгнэлтийн дагуу янз бүрийн гүний түвшингээс хөрсний 3 дээж авна. Бохирдлын түвшин, талбайн нийт байдлыг харгалзан бүх дээжийн шинжилгээг нэг дор эсвэл талбайн бохирдлын түвшин, тархалтын дагуу хийнэ. Зохих шийдвэрийг судалгааны ажлын хариуцлагатай гүйцэтгэгч авна.

Судалгааны гидрогеологийн цооногийн төлөвлөж буй байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцсан дүгнэлтийн үндсэн дээр тогтоогдсон нөхцөл байдлыг

харгалзан тодорхойлно. Дор хаяж нэг цооногийг газар доорх ус судлагдаж буй талбайд орж ирж байгаа хэсэгт байрлуулсан байна.

Гидрогеологийн судалгааны цооногийн өрөмдлөгийн ажлын дараалал:

- Өрөмдлөгийн ажлыг эхлүүлэхээс өмнө талбай дээр төлөвлөсөн гидрогеологийн цооногийн байршил тодорхойлогдсон байна;
- гидрогеологийн судалгааны цооногийг 194 мм-с доошгүй диаметр бүхий эргэлтэт чөмгөн эсвэл эргэлтэт-цохилтот өрөмдлөгөөр хийнэ;
- чөмгөн өрмийг цооногоос татаж авсны дараа дотор агуулагдсан материалыг берзент, хуванцар хавтан зэрэг заасан газарт гаргаж, геологич үзлэг хийж дүгнэлт гаргах ба шаардлагатай бол хөрсний дээж авна;
- өрөмдлөгийн ажлыг 6 м-н гүнд хийж дуусаад сүүлийн дээжийг авсны дараа авсан нийт дээжээс буюу нэг цооногийн янз бүрийн гүний түвшингээс авсан дээжүүдээс лабораторийн шинжилгээ хийх зорилгоор 3 дээжийг сонгож авна;
- цооногийг 110 мм болон түүнээс илүү диаметртай ПЭ/ПВХ тоноглолоор тоноглогдох бөгөөд нүхлэсэн хэсгийн эргэн тойрныг нь 4-8 мм ширхэгтэй тохирох материалаар дүүргэнэ;
- Газрын гадаргаас доош 4 м-н гүн хүртэлх тоноглолын битүү хэсгийг шаварлаг-цементэн дүүргэгчээр битүүмжилж, цооногийг тагтай төмөр хамгаалагчаар тоноглоно (тоноглолыг цооног тус бүрт тусгайлан тодорхойлно);
- цооногийг тоноглосны дараа лагийг зайлуулж цэвэрлэнэ;
- дараагийн шатанд цооногоос газрын доорх усны дээж авна;
- бүх шинэ цооногуудад хэмжилт хийнэ.

Цаашилбал тухайн талбай дээр 60 орчим м-н гүн хүртэл судалгаа, гидрогеологийн 5 цооногийг гүехэн цооног байгуулсантай ижил төстэй аргаар хийнэ. Гүний уст үе хүрэх магадлалтай энэхүү гүн цооногууд уст үеүдийг хооронд нь холбохоос сэргийлэхийн тулд гүехэн уст үеэс тусгаарлагдсан байна. Дээд уст үеийг ган хамгаалагчаар тоноглох ба хамгаалагчийг бетондсоны дараа жижиг диаметрээр доод уст үе руу өрөмдөнө. Ийм аргаар хийсэн гүн цооногоос 0 – 6 м-ийн хооронд гүнээс хөрсний болон газар доорх усны дээж авна. Цооног тус бүрээс хөрсний нийт 3 дээж авна.

5.3.3. Цооног хаах арга

Ханаагүй бүсийг судлах зорилгоор өрөмдсон гүехэн цооногуудыг хөрсний дээж авч, литологийн найрлага судалж дүгнэлт хиймэгц хаахаар төлөвлөж байна. Судалгааны гүехэн цооногуудыг ууган материалаар дүүргэж шавар-цементэн дүүргэгчээр битүүмжилнэ. Гидрогеологийн зарим цооногуудыг төслийн түнштэй харилцан тохиролцсоны үндсэн дээр талбайн цаашдын мониторинг хийх зорилгоор үлдээнэ. Одоогоор цуглуулсан мэдээллийг үндэслэн цаашид мониторинг хийх зорилгоор бүх цооногуудыг үлдээвэл зүйтэй гэж үзэж байна.

5.4. Дээжлэлтийн ажил

Дээжлэлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөө буюу дээж авах газрын байршлыг талбайтай анхан шатны журмаар танилцах үе шатны үр дүнг үндэслэн тодорхойлно. Цаашдаа боловсруулсан дээжлэлтийн төлөвлөгөөнд дээжлэлтийн газрын байршил, дээж тус бүрийг авах журам, хийлгэх шаардлагатай шинжилгээ зэргийг тусгана.

Дээж авах тухай тэмдэглэл (“дээж авсан тухай протокол”) хөтөлж, хавсралтад газрын өндрийн хэмжээ, фото баримт бүхий дээжлэлтийн газрын план зураг оруулна. Дээжийг лабораторид хүлээлгэн өгсөн тухай “дээж хүлээлгэн өгсөн протокол” үйлднэ.

Судалгааны ажлын хүрээнд хөрс, ёроолын тунадас, гадаргын, газар доорх болон хаягдал усны дээжлэлт, шинжилгээ хийхээр төлөвлөж байна .

Нийт дээжийн 5 хувийг хяналтын дээжийн зорилгоор авна. Ямар дээжийг хяналтын зорилгоор авах шаардлагатай тухай шийдвэрийг авсан дээжийн органолептик шинжилгээний үндсэн дээр авна. Эдгээр дээжийн шинжилгээ аналитик ажлын чанарын хяналтын магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ.

5.4.1. Хөрсний дээж авах

Хөрсний дээжүүдийг газрын гадаргаас, судалгааны гүехэн цооног болон судалгааны гидрогеологийн цооногуудаас авна. Тодорхойлбол,

- газрын гадаргаас доош 3,0 м хүртэлх түвшинд төлөвлөгдсөн судалгааны гүехэн цооногуудаас (биечлэн байлцсан геологчийн мэдэгдлийн дагуу объектоос 2 дээж);
- газрын гадаргаас доош ±6,0 м хүртэлх түвшинд төлөвлөгдсөн судалгааны гидрогеолоийн цооногуудаас (биечлэн байлцсан геологчийн мэдэгдлийн дагуу объектоос 3 дээж);
- газрын гадаргаас доош ойролцоогоор 60 м хүртэлх түвшинд төлөвлөгдсөн судалгааны гидрогеолоийн цооногуудаас (биечлэн байлцсан геологчийн мэдэгдлийн дагуу газрын гадаргаас доош 0-6 м-т объектоос 3 дээж).

Ажиглалтын сүлжээг өргөжүүлэх, бохирдлын талбайн тархалтын хэмжээг шалгах зорилгоор мөн газрын гадаргаас хөрсний дээж авна. Дээжийг цэгэн хэлбэрээр авна. Газрын гадаргаас хөрсний дээж авагдах байршил газар нутгийн урьдчилсан тандалтын дараа тодорхой болно.

Дээжлэлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөө буюу дээж авах байршлыг газар нутгийн урьдчилсан тандалт дээр үндэслэн тодорхойлно. Нийтдээ тухайн газарт судалгааны гүехэн цооногуудаас хөрсний дээж 200 ширхэг, судалгааны гидрогеологийн цооногуудаас 90 дээж, гүний судалгааны гидрогеологийн цооногуудаас 15 дээж тус тус авна.

Гүехэн тоноглоогүй цооногуудаас авах хөрсний дээж

Дээжүүдийг гүехэн тоноглоогүй цооногуудаас холимог хэлбэрээр авч, дээжлэгдсэн гүний интервалыг тэмдэглэнэ. Шаардлагатай гүний интервалаас гарсан материалыг хутгаж, 3 см-ээс дээш хэмжээний фракцыг арилган гомогенжүүлж, квартац хийснээр холимог дээж үүснэ.

Судалгааны цооногоос авах хөрсний дээж

Судалгааны цооногоос хөрсний дээжийг тасралттайгаар, гүний интервалын тодорхой тэмдэглэгээтэйгээр, чөмөгнөөс шууд авна. Дээжүүдийг шилэн дээжийн саванд хийж шошгожуулна.

Газрын гадаргаас авах хөрсний дээж

Газрын гадаргаас дээжүүдийг зэвэрдэггүй ган хүрзний тусламжтай, газрын гадаргаас доош 0 – 0,1 м гүний түвшинд авна. Дээжүүдийг шилэн дээжийн саванд хийж шошгожуулна.

Авсан дээжүүдийг хөргөгч саванд хийж магадлан итгэмжлэгдсэн лаборатори руу дараах лабораторийн шинжилгээнд илгээнэ:

- сонгосон дээжүүдэд C10-C40 нүүрустөрөгчийн агууламж, BTEX, ПАН (Монгол Улсын MNS 6148:2010 стандартын дагуу): аценафтен, антрацен, бензо(a)антрацен, бензо(a)пирен, бензо(b)флуорантен, бензо(k)флуорантен, хризен, дибензо(a,h)антрацен, флуорантен, флуорен, индено(1,2,3-c,d)пирен, нафтален, пирен, газрын тосны бодисын чанар, хүнд металлууд: As, Cd, Co, Cr, Cu, Hg, Mo, Ni, Pb, V, Zn (Монгол Улсын MNS 5850:2008 стандартын дагуу).

Ашигласан жоотуу, шүүр, бийр зэрэг бүх багаж, хэрэгслийг дараагийн дээж авахаас өмнө сайтар цэвэрлэн ариутгаж, шаардлагатай тохиолдолд шинэ хэрэгсэл ашиглана.

5.4.2. Газар доорх усны дээж авах

Ханасан бүсийн хувьд судалгааны ажил тухайн талбайн газрын доорх усны дээд коллекторын усны чанарыг тогтоох эсвэл бохирдлыг илрүүлэх зорилготой.

Талбай дээр байгаа гидрогеологийн объектоос (5 дээж), гидрогеологийн судалгааны шинэ цооногоос (30 дээж) тус тус газар доорх усны дээж авна.
Газар доорх усны дээжүүдийг хоёр үе шаттай авна. Хоёр дахь үе шатанд дээжүүдийг анхны үе шатны үр дүнг олж авсны дараа, уг үр дүнд үндэслэн дээжлэлтийн тохиромжтой цооногийг сонгон авах бөгөөд хоёр дахь үе шат эхний үе шатны дээжлэлтээс хойш 30-аас дээш хоногийн дараа гүйцэтгэгдэнэ. Дээжлэлтийн эхний үе шатанд нийтдээ 35 ширхэг бүх HG объектуудад дээжлэлт хийнэ. Хоёр дахь үе шатанд сонгосон цооногуудаас 20 дээж авах болно.

Нийтдээ, тухайн байршилд газар доорх усны 55 дээж авалтыг төлөвлөсөн байна.

Гидрогеологийн цооногоос газар доорх усны дээжийг хөдлөнги (динамик) аргаар авна. Одоо байгаа цооногоос дээж авахаас өмнө хэрэглэж болох байдал, гүн, лаглайсан, зэвэрсэн байдал, тоноглолын бүрэн бүтэн байдал, хамгааллын бэхэлгээний байдал зэрэг

техникийн байдлыг шалгана. Шланг, насос зэргийг дээжлэлт бүрийг эхлүүлэхээс өмнө цэвэр усаар зайлан цэвэрлэж, шаардлагатай үед шинэ шланг, насосыг хэрэглэнэ.

Дээжлэлтийн үеэр, УХҮШ, ПХБ ба ПАН тодорхойлох зорилгоор дээж авах тохиолдолд цооногийн ёроолоос дээш ойролцоогоор 1,5 м түвшинд насосны соролт суурилагдсан байна. Дээжлэлтийн үеэр С10-С40, АОХ а ВТЕХ тодорхойлох зорилгоор дээж авах тохиолдолд цооног дахь газар доорх усны гадаргаас доош ойролцоогоор 0,5 м түвшинд насосны соролт суурилагдсан байна. Ус шавхах үеэр физик-химийн параметрууд (ууссан хүчилтөрөгч, цахилгаан дамжуулах чанар, pH, дамжуулах чанар ба бусад) тасралтгүй хэмжигдэнэ. Газар доорх усны дээжийг үргэлж эдгээр параметрууд (± 0,1 pH, цахилгаан дамжуулах чанар ± 10 %, редокс чадавхи) тогтворжсны дараа, лабораториос заасан дээжийн саванд авна.

Газар доорх усны дээж авсан дээжийн саванд тэмдэглэгээ хийж, хөргөгч хайрцагнуудад хадгалах бөгөөд магадлан итгэмжлэгдсэн лаборатори руу дараах лабораторийн шинжилгээнд илгээнэ:

- сонгосон дээжүүдэд нүүрсустөрөгчийн С10-С40, BTEX, PAU (монгол улсын стандарт MNS 6148:2010-ын дагуу): аценафтен, антрацен, бензо(а)антрацен, бензо(а)пирен, бензо(b)флуорантен, бензо(k)флуорантен**,** хризен, дибенз(a,h)антрацен, флуорантен, флуорен, индено(1,2,3 c, d)пирен, нафтелен, пирен, газрын тосны бодисын чанар, PCB, AOX, ClU, пестицидүүдийн скрининг, УХАШШ, ТК дараах хүрээнд: As, Cd, Cr, Cu, Hg, Ni, Pb, Zn (MNS 6148:2010 – ын дагуу), уусдаггүй бодисууд (NL), аммонийн азот, $N_{нийт.}$, $P_{нийт}$ хлоридууд ба сульфатууд.

Газар доорх усны динамик дээжлэлтэд тэдгээрийн физик химийн үзүүлэлтүүдийг тохирох талбайн багаж төхөөрөмжөөр хэмжсэн хэмжилт орно (дулаан, pH, цахилгаан дамжуулах чанар, чөлөөт O_2, исэлдэлт, ангижралтын чадавхи).

5.4.3. Гадаргын ба хаягдал ус болон ёроолын тунамал зэргээс дээж авах

Газар нутгийн ойр тойронд усаар зайлагдан тархах бохирдуулагчийн тээвэрлэлтийг хянан шалгахын тулд гадаргын болон хаягдал усны боломжтой хуримтлал, ёроолын тунамлууд, эсхүл газар нутаг ба түүний ойр орчмын түр зуурын урсацын тунамалуудаас дээж авах болно.
Гадаргын ба хаягдал усны дээжүүдийг хоёр үе шаттай авна. Хоёр үе шатны хоёуланд нь тэнцүү тооны дээж авна. Тус газар нутагт нийтдээ гадаргын уснаас 3 дээж, мөн хаягдал уснаас 3 дээжийг үе шат тус бүрт авахаар төлөвлөсөн. Энэ нь нийт 12 дээж гэсэн үг юм. Цаашлаад ёроолын тунамалуудаас 10 дээжийг эхний үе шатны үеэр авах болно.

<u>Гадаргын ба хаягдал уснаас авах дээж</u>
Гадаргын ба хаягдал усны дээжийг лабораториос заасан дээжийн саванд шууд авч хийх бөгөөд зарим тохиолдолд боломжгүй байвал дээжүүдийг хэсэгчилсэн дээжлэгчийн тусламжтайгаар ёроолоос дээш ойролцоогоор 1 м гүний түвшинд эсвэл шийдвэрлэгчийн заасан гүнээс авах болно.

Газар доорх усны дээж авсан дээжийн саванд тэмдэглэгээ хийж, хөргөгч хайрцагнуудад хадгалах бөгөөд магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээнэ:

- сонгосон дээжүүдэд нүүрсустөрөгчийн C10-C40, BTEX, ПАН-ы агууламж (Монгол Улсын MNS 6148:2010 стандартын дагуу): аценафтен, антрацен, бензо(a)антрацен, бензо(a)пирен, бензо(b)флуорантен, бензо(k)флуорантен, хризен, дибенз(a,h)антрацен, флуорантен, флуорен, индено(1,2,3 c, d)пирен, нафтелен, пирен, газрын тосны бодисын чанар, ХМ: As, Cd, Cr, Cu, Hg, Ni, Pb, Zn (Монгол Улсын MNS 4586:1998 стандартын дагуу).
- Хаягдал ус асгах газраас авсан дээжид ClU, пестицидийг илрүүлэх шинжилгээ, АОХ, ПХБ, уусдаггүй бодисууд (УБ), аммонийн азот, $N_{нийт.}$, $P_{нийт}$, хлоридууд ба сульфатуудын агууламжийг тодорхойлно.

Дээжлэлтэд ашигласан бүх багаж, тоноглолыг дараагийн дээжлэлт хийхээс өмнө зохих ёсоор ариутган цэвэрлэх эсхүл шинийг ашиглана.

Ёроолын тунамалуудаас авах дээж

Ёроолын тунамалуудаас дээжийг цэгэн хэлбэрээр, ёроолын тунамалын дээжлэлтэд зориулсан урьдчилан бохирдолгүйжүүлсэн зэвэрдэггүй ган дээжлэгч төхөөрөмжийн тусламжтайгаар авах болно (van Veen төрлийн). Дээжүүдийг шошгожуулсан, хаалттай, шилэн дээжийн саванд авна.

Ёроолын тунамалын дээж авсан дээжийн саванд тэмдэглэгээ хийж, хөргөгч хайрцагнуудад хадгалах бөгөөд магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээнэ:

- сонгосон дээжүүдэд нүүрсустөрөгчийн C10-C40, BTEX, ПАН-ы агууламж (нафтален, фенантрен, антрацен, флуорантен, пирен, бензо(a)антрацен, хризен, бензо(b)флуорантен, бензо(k)флуорантен, бензо(a)пирен, индено(123cd)пирен, бензо(ghi)перилен), газрын тосны бодисын чанар, ХМ: As, Cd, Co, Cr, Cu, Hg, Mo, Ni, Pb, V, Zn (Монгол Улсын MNS 5850:2008 стандартын дагуу).

Дээжлэлтэд ашигласан бүх багаж, тоноглолыг дараагийн дээжлэлт хийхээс өмнө зохих ёсоор ариутган цэвэрлэх эсхүл шинийг ашиглана.

5.4.4. Биологийн матрицуудаас дээж авах

Эрсдэлийн шинжилгээ боловсруулах зорилгоор, голчлон хүнсний хэлхээн дэх бохирдуулагчдын байж болзошгүй урсгалыг тодорхойлох зорилгоор биологийн эдүүд болон биологийн өөр бусад матрицуудаас төлөөллийн дээжүүд авах болно. Хэлхээ тус бүр болон төлөөллийн дээжүүдийг гүйцэтгэгч судалгааны ажлын туршид тодорхойлно.

Тохиромжтой биологийн матрицад мал сүргийн иддэг ургамал, мал сүрэг төдийгүй хүний иддэг жимс, ногоо болон хүний идэж хэрэглэдэг сул чөлөөтэй амьдардаг ан

амьтад (булчингийн эд, цус, өөхөн эд), үсний дээжүүд, шаардлагатай тохиолдолд хүний цус гэх зэрэг. Ингэж авсан дээжүүд нь хүнсний хэлхээн дэх ажиглагдах бохирдуулагчууд, зарим эсхүл хүнсний хэлхээний зарим хэсгүүд дэх эдгээр бодисуудын хуримтлалыг илтгэж байх ёстой.

5.5. Газар доорх усны түвшингийн хэмжилт

Тухайн талбайн гидрогеологийн шинж чанарыг тодорхойлох, газар доорх усны урсгалын чиглэлийг тогтоох, шаардлагатай газрын зураг бэлтгэх зорилгоор тухай талбайд, түүний ойр орчимд хэмжилт хийж болох гидрогеологийн бүх объектод газар доорх усны түвшингийн хэмжилт хийнэ. Газар доорх усны чөлөөт гадаргууг газар доорх усны түвшин тогтворжсоны дараа хуучин, шинэ аль ч цооногуудад хийнэ. Хэмжилтэнд гадаргуу хэмжигч ашиглана.

5.6. Гидродинамикийн сорьцлолт

Тус талбайд хийгдэх гидродинамикийн сорьцлолтыг гүехэн цооногт 12 + 6 цаг, гүний цооногт 72 + 24 цагийн горимд тус тус хийж гүйцэтгэнэ. Сорьцлолт талбайгаас бохирдуулагч бодисын байж болзошгүй тархалтыг харгалзах, сэлбэн засах арга хэмжээг санал болгох үүднээс гидравлик тооцоо болон загварчлалд шаардагдах үндсэн үзүүлэлтийг тогтооход зориулагдана.

5.6.1. Шавхах туршилт

Шавхах туршилтын гол зорилго шүүлтийн илтгэлцүүр, бүүрцын хүнхээлийн радиус, чулуулгийн орчны нэвтрэх чанар, нөөцлөлт зэргийг бодоход шаардлагатай гидравлик утгуудыг тогтооход оршино. Шавхах туршилтын үр дүн гидрогеологийн цооног/худгийг аль болох их хэмжээгээр ашиглах (цутгаж буй усны тохиромжтой хурдацтай нөхцөлд шавхагдах усны хэмжээ) бололцоог хангах үүднээс нөхөн сэргээлтийн горимыг санал болгох боломж олгодог.

Уг арга хамгийн найдвартай үр дүнг өгдөг усны түрэлттэй горимд зориулан боловсруулагдсан боловч уст үеийн зузаантай харьцуулвал шавхагдах үед газар доорх усны түвшин бага хэмжээгээр буурсан тохиолдолд усны чөлөөт гадаргууны горимд ч ашиглагддаг. Уг аргаар хэмжилт хийх зорилгоор хоёроос доошгүй объектыг согоно: шавхагдах цооног болон усыг нь шавхаж буй цооногоос ойрхон шавхагдсан үеийн түвшингийн хэмжилт хийх бололцоо олгож байгаа нэг эсвэл нэгээс илүү цооног. Насос нь шавхах туршилтын үед тогтмол, урьдчилан тохируулсан хүчин чадалтай ажиллана. Туршилтын явцад шавхагдсан усыг чөлөөтэй газар асгана.

Шавхах туршилт хийх үе шат:

- ажил эхлэхээс өмнөө шавхагдах болон хяналтын цооногуудад, хэмжилт хийх объектод газар доорх усны түвшингийн хэмжилт хийнэ;
- ус шавхахад тохиромжтой үзүүлэлт бүхий гүний насос ашиглан цооногийн ул сууриас дээш 1,0 м-н түвшинд байрлуулна; насосны хүчин чадлыг цооногийн

таамагласан ундаргын дагуу тохируулан туршилт хийх хугацаанд өөрчлөлтгүй тогтмол ажиллуулна;

- шавхагдах болон ойр хавийн хяналтын цооногуудын усны түвшингийн өөрчлөлтийг туршилт шавхалтын үр дүнд өгөх үнэлгээг харгалзан урьдчилан тодорхойлсон цаг хугацааны зайтай даталогероор хэмжинэ;
- Газар доорх усны түвшингийн хяналтын хэмжилтийг гадаргуу хэмжигчээр хийнэ (жишээ нь, G-50);
- шавхах туршилтын явцад тохиромжтой багажаар (жишээ нь, сонгомол электрод бүхий WTW Multi 340i) температур, pH, цахилгаан дамжуулах чадвар, чөлөө хүчилтөрөгчийн агууламж, исэлдэл-ангижралын түвшинг зэргийн хэмжилт хийнэ.

5.6.2. Нэмэгдүүлэх туршилт

Шавхах туршилт хийж дуусмагц ус нэмэгдүүлэх туршилтыг хийнэ. Ус шавхалтыг зогсоосны дараа тодорхой заасан хугацааны зайтай судалгааны бүх объектод газар доорх усны түвшин нэмэгдэх байдлыг хянан тэмдэглэнэ. Шавхах туршилтын адилаар усны түвшингийн өөрчлөлтийг даталогер эсвэл гадаргуу хэмжигчээр хэмжинэ.

Нийтдээ тус талбайд шавхах туршилт болон ус нэмэгдүүлэх 8 туршилтыг хийхээр төлөвлөж байгаагаас 6-г нь гүехэн цооног, 2-г нь гүний цооногт хийнэ.

5.7. Судалгааны ажлын хэмжилт

Судалгааны бүх ажлыг GPS-н тусламжтайгаар хэмжинэ. Хэмжсэн утгууд газрын зураг бэлтгэх зорилгоор ашиглана. Гидрогеологийн гүехэн болон судалгааны бүх цооног, дээж авсан бүх цэгүүдийг хэмжих бөгөөд цаашид тэмдэглүүштэй баримжааллын цэг, бохирдлын эх үүсвэр зэргийг хэмжинэ.

5.8. Лабораторийн ажил

Лабораторийн бүх шинжилгээ магадлан итгэмжлэгдсэн аргаар хийгдэнэ. Монгол Улсад шаардагдах мэргэжлийн тусгай шинжилгээ бүрэн хэмжээгээр хийх чадвартай лаборатори байхгүй тул лабораторийн ажлыг өөр улсад хийх шаардлагатай.

Дээжийн шинжилгээний цар хүрээ, төрөл зүйлийг дараах хүснэгтээр харуулсан байна. Шинжилгээний цар хүрээ, судлагдах бодис, үзүүлэлт зэрэг тухайн талбай, түүний бохирдлын шинж чанарын талаарх одоог хүртэл цуглуулсан мэдээлэл дээр үндэслэсэн байна.

Хүснэгт 6. Зуунбаяны талбайгаас төслийн ажлын хүрээнд матриц тус бүрээс авсан дээжийн төлөвлөж буй лабораторийн шинжилгээний тойм

Үзүүлэлт	Тодорхойлолтын тоо (ш)	
	Хөрс, тунадас	Ус (газар доорх, гадаргын болон хаягдал ус)
Нефтийн нүүрсустөрөгч С10-С40	315	71 (67+4 хяналтын дээж)
Нефтийн нүүрсустөрөгч С5 – С40	30	10
Бензол, толуол, этилбензол, ксилен (BTEX)	170	71 (67+4 хяналтын дээж)
ПАН (MNS 5850:2008 стандартад заасан хэмжээ)	170	0
ПАН (MNS 4586:1998, MNS 6148:2010 стандартад заасан хэмжээ)	0	71 (67+4 хяналтын дээж)
AOX	0	13
PCB	0	13
ClU	0	13
Пестицид илрүүлэх шинжилгээ	0	13
Уусангүй бодис (УБ), аммиакийн азот, Nнийт, Рнийт, хлорид, сульфат	0	13
Нефтийн нүүрсустөрөгчийн чанар	30	0
Газар доорх усны үндсэн шинжилгээ (ГДУХҮШ)	0	20
ХМ (MNS 5850:2008 стандартад заасан хэмжээ)	150	0
ХМ (MNS 4586:1998, MNS 6148:2010 стандартад заасан хэмжээ)	0	71 (67+4 хяналтын дээж)

Матриц тус бүрээс авсан дээжийн бохирдлын шалгагддаг үзүүлэлтийг тогтоох зорилгоор ашиглах аргуудын тойм хүснэгт 7, 8-рт харуулсан байна .

Хүснэгт 7. Хатуу матрицын дээжийн шинжилгээний аргын тойм (хөрс, тунадас)

Судлагдах үзүүлэлт	Аргын зарчим
28. U.S. EPA, Characterization of Hazardous Waste Sites: A Methods Manual Vol. II Available Sampling Methods, U.S. EPA-600/4-83-040 Environmental Monitoring and Support Laboratory Las Vegas, NV, 1983.
29. U.S. EPA, Handbook for Sampling and Sample Preservation of Water and Wastewater, U.S. EPA-600/4-82-029 Environmental Monitoring and Support Laboratory, Cincinnati OH, 1982.
30. U.S. EPA, Ground Water Monitoring Guidance for Owners and Operators of Interim Status Facilities, U.S. EPA-SW-963, Office of Solid Waste and Emergency Response Washington, DC, 1983.
31. U.S. EPA, Handbook for Sampling and Sample Preservation of Water and Wastewater, Cincinnati, OH, 1982.
32. U.S. EPA, Method 1669: Sampling Ambient Water for Trace Metals at U.S. EPA Water Quality Criteria Levels, Office of Water Engineering and Analysis Division, April, 1995.
33. U.S. EPA, Suggested Operating Procedures for Aquifer Pumping Tests, U.S. EPA/540/S-93/503, Office of Research and Development, Washington, DC, 1993.
34. U.S. EPA, Immunoassay Guidelines for Planning Environmental Projects, U.S. EPA Quality Assurance Unit Staff, Office of Environmental Measurement and Evaluation, October, 1996.
35. U.S. EPA, Light Non-Aqueous Liquids, U.S. EPA/540/S-95/500, Office of Solid Waste and Emergency Response, 1995.
36. U.S. EPA, Non-Aqueous Phase Liquids Compatibility with Materials Used in Well Construction, Sampling and Remediation, U.S. EPA/540/S-95/503, Office of Solid Waste and Emergency Response, 1995.
37. U.S. EPA, Soil Sampling and Analysis for Volatile Organic Compounds, U.S. EPA/540/4-91/001, Office of Solid Waste and Emergency Response, 1991.

38. U.S. EPA, Test Methods for Evaluating Solid Waste Physical/Chemical, SW-846 Final Update3 to the 3rd Edition, 1996.
39. USGS, Ground–Water Data–Collection Protocols and Procedures for the National Water–Quality Assessment Program: Collection and Documentation of Water Quality Samples and Related Data, U.S. Geological Survey Report 95-399. 1995.

ANNEX

Table 1: Choice of samplers to take non-liquid samples for a selected group of indicators

Sampling device	**Sample type**	**Monitored parameters**		**Limitations of use**
		VOC	Other organic and inorganic indicators	
Sampling scoop, trowel	Disturbed sample	Unsuitable	Suitable	Consolidated materials, taking samples in depths
Hand augers	Disturbed sample	Unsuitable	Suitable	Material compression, consolidated, stony materials
U-shaped sampler	Disturbed sample	Limited use	Suitable	Consolidated, stony, dry and loose materials, small size of a sample
Soil coring device	Intact sample	Suitable	Suitable	Consolidated, stony materials, limited depth reach
Split spoon sampler	Intact sample	Suitable	Suitable	Consolidated, stony materials
Tube sampler	Intact sample	Suitable	Suitable	Consolidated, stony, dry, loose materials, limited depth reach
Special samplers to determine VOC	Intact sample	Suitable	Limited use	The sampler is used to take small amounts of a sample taken from material by means of another sampler

Table 2: Choice of samplers to take sediments/sludge depending on physical properties

Sediment / sludge type	**Sampling device**
Gravel	Grab samplers
Sand	Grab samplers and sediment core samplers
Clay	Sediment core samplers
Peat	Sediment core samplers, Russian / peat sampler
Consolidated muddy sediment	Grab samplers and sediment core samplers
Unconsolidated muddy sediment	Sediment core samplers

Table 3: Gas detector types used in field measuring apparatuses and their use

Detection principle	**Use**	**Limited use**
Thermal conductivity sensors	Binary mixtures or their equivalents formed of gases with sufficient difference of specific heat conductivities (e.g. mixtures of H_2 and N_2, H_2 and O_2, CH_4 and air, SO_2 and air)	
Pellistor (sensor with catalytic burning)	Detectors of flammable gases and vapour	Inhibitors (e.g. halogens, organic halogen-derivatives, SO_2 etc.) reduce the sensor´s efficiency; catalytic poisons (e.g. silicones, alkyl-lead compounds, phosphates etc.) react with the catalyst and destroy the sensor.
Semi-conductor sensors of the oxide type	Detection and determination of low concentrations of vapours of hydrocarbon and their derivatives, halogenated hydrocarbons, alcohols, esters, nitro-compounds, ammonia, carbon monoxide and hydrogen cyanide	Strong dependence on moisture, temperature and concentration of the gas analysed; high concentrations may inhibit the sensor´s activity.

Detection principle	Use	Limited use
Electrochemical sensors	Measuring oxygen concentration and measuring low concentrations of some toxic gases, such as CO, H_2S, NH_4, freons.	The sensors´ rather short life (1 to 3 years) is a disadvantage.
Infrared spectrometers	Gases with permanent dipole moment, e.g. CH_4, CO, NH_4 etc.; high selectivity	Possible distortion of the measurement´s results (e.g. steam, CO_2 in exhaust emissions).
Flame ionisation detector (FID)	Gases that undergo ionisation during burning – mainly hydrocarbons (saturated alkanes, non-saturated alkenes and alkyls and aromatic hydrocarbons)	The detector must not be used to measure inorganic compounds in a gas.
Photo-ionisation detector (PID)	The detector´s sensitivity to detectable groups of substances decreases/increases in the following sequence: 1. Aromatic hydrocarbons 2. Non-saturated aliphatic chlorinated hydrocarbons 3. Non-saturated hydrocarbons 4. Paraffin-based hydrocarbons 5. Ammonia and paraffin-based hydrocarbons	The detector is not selective.

Table 4: Brief summary of solid sorbents and their uses for different compounds

Sorbent type	**Adsorbed substances**
Activated carbon – coconuts basis	Organic solvents (aromatic hydrocarbons, aliphatic chlorinated hydrocarbons), benzyl acetate, bromoform, chloroprene, cyclohexanone etc.
Activated carbon – petroleum processing basis	1,2-dibromo-3-chloropropane, ethylene, methyl bromide, n-propyl nitrate, 1,1,2,2-tetrachloro-ethane
Silica gel	Amines, amides, acetic acid
Molecular sieve 5A	Acrolein
Tenax GC	Allyl glycidyl ether, diphenylethylene glycol, nitroglycerine, dinitrate, white phosphorus, trinitrotoluene (TNT)
Chromosorb 101	PCB, amines, amides
Chromosorb 104	Butyl mercaptan
Poropak Q	Furfuryl alcohol, methyl cyclohexane
XAD-2	Tetramethyl-lead, ethyl silicate, nitroethane, PAH, pesticides
XAD-7	Phenols, cresols
Carbotrap-100, 150, 200 (graphitised black coal)	C2-C12 hydrocarbons, PCB
Carboxen 564 (carbon molecular sieve)	C2-C12 volatile organic compounds, trihalo-methanes
Carbosieve (carbon molecular sieve)	C2 hydrocarbons
PUF (polyurethane foam)	Pesticides (organo-chlorinated, organo-phosphorous)

Table 5: Brief summary of liquid sorbents and their uses for different compounds

Absorption liquid	**Absorbed substances**
0.1 N H_2SO_4	Bases and amines
0.1 N NaOH	Acids and phenols
0.1 N HCl	Nickel carbonyl $Ni(CO)_4$
Alkali cadmium (II) sulphate ($CdSO_4$. NaOH)	Sulphane (H_2S)
Methylene blue	Sulphane (H_2S)
1% KI in 0.1 N NaOH	Ozone (O_3)
4-nitropyridyle propylamine in toluene	Diisocyanates
0.3 N H_2O_2	Sulphur dioxide (SO_2)
0.1 % aniline	Phosgene ($COCl_2$)
1% $NaHSO_4$	Formaldehyde (HCHO)
Distilled water	Acids and bases

Note: 0.1 N NaOH means 0.1 molar solution of NaOH. (Molecular weight of NaOH is 40; then a 0.1-molar solution would have 4 grams of NaOH dissolved in each liter of solution).

Table 6: Recommended groundwater sampling means

Category	**Recommended means**	**Sample type**
1) Springs and boreholes with permanent overflow	B, C, alternatively K, A	composite
2) Sampling of temporary objects	B, C, D H	Composite / simple point */
3) Micropurging in the perforated section	Delivery pumps with controllable pumped amount – D, G, F, (H)	Simple point / composite */
4) Micropurging in the perforated section, with uncontrollable level decrease	Delivery pumps with controllable pumped amount – D, G, F, (H)	Composite / simple point

Category	Recommended means	Sample type
5) Composite, volume-averaged samples	B, C, D, E, F, G	Composite
6) Piezometers and narrow-profile multi-level systems	E, H	Simple point
7) Time-dependent average samples	J	Composite
8) Long-term pumped objects	K (from the fittings valve), B, D, E, H	Composite

Notes: */ depending on the length of the open part and extent of the changes monitored

Explanation:
A – overflow cylinder
B – bailer (zonal sampler with bottom filling)
C – peristaltic pump
D – bladder pump
E – gas delivery pump
F – electric centrifugal pump
G – progressing cavity pump
H – inertial piston pump
I – air lift (gas pump)
J – passive diffusion samplers
K – direct filling of sample container by immersing

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

Геологийн нөхөн сэргээлтэд дээжлэлт хийх аргачлалын удирдамж

Агуулга

1. ЕРӨНХИЙ БҮЛЭГ 5

1.1 АРГАЧЛАЛЫН УДИРДАМЖИЙН ТУХАЙ, ЗОРИЛГО БА АШИГЛАЛТ 5
1.2 ДЭЭЖЛЭЛТИЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ҮНДСЭН ДҮРЭМ 5
1.3 ТӨСЛИЙН АЖИЛ 6
1.4 ДЭЭЖ АВАЛТЫГ БАРИМТЖУУЛАХ 8

2. ДЭЭЖЛЭЛТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТӨХӨӨРӨМЖ, ХЭРЭГСЭЛ БА МАТЕРИАЛ 10

2.1 ДЭЭЖЛЭЛТИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАТЕРИАЛУУД 10
2.2 ХАТУУ (ШИНГЭН БУС) МАТРИЦААС АВАХ ДЭЭЖЛЭЛТИЙН ТӨХӨӨРӨМЖ 11
2.2.1 БЭХЖҮҮЛСЭН МАТЕРИАЛААС ДЭЭЖ АВАХ ТОНОГЛОЛ 11
2.2.2 ХӨРСНӨӨС ДЭЭЖ АВАГЧ 12
2.2.3 ТУНАДАС БОЛОН ШАВРААС ДЭЭЖ АВАГЧ 15
2.2.4 БАГЛАЖ БООСОН ЭСВЭЛ ХОГИЙН ЦЭГ ДЭЭРХ НУНТАГ МАТЕРИАЛААС (Ж.НЬ: ХАЯГДЛЫН) ДЭЭЖ АВАГЧ 17
2.3 ШИНГЭН МАТРИЦЫН ДЭЭЖЛЭЛТИЙН ТОНОГЛОЛ 18
2.3.1 ЭЗЭЛХҮҮНТ ДЭЭЖ АВАГЧ 18
2.3.2 ДЭЭЖЛЭГЧ НАСОС 19
2.4 ХИЙНЭЭС ДЭЭЖ АВАХ ДЭЭЖЛЭЛТИЙН ТӨХӨӨРӨМЖ 22
2.4.1 ХИЙГ ДЭЭЖИЙН САВАНД АВАХ 22
2.4.2 КОЛЕКТОРТ АЖИГЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БАРИХ 24

3. ДЭЭЖ АВАХ АРГУУД – АНГИЛАЛ 25

3.1 ДЭЭЖИЙН ТӨРЛҮҮД 25
3.2 МАТРИЦЫН ТӨРЛҮҮД 27
3.3 АЖИГЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД 28
3.4 ХОЛБООСТ ЧУЛУУЛАГ, БАРИЛГЫН ХИЙЦ 29
3.4.1 ТӨХӨӨРӨМЖИЙН СОНГОЛТ 29
3.4.2 ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛТГЭЛ 30
3.4.3 ДЭЭЖ АВАХ 30
3.5 ХОЛБООСГҮЙ ЧУЛУУЛГУУД БА ХӨРС 31
3.5.1 ТӨХӨӨРӨМЖИЙН СОНГОЛТ 31
3.5.2 ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛТГЭЛ 31
3.5.3 БАРИМТЖУУЛАЛТ, ДЭЭЖИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ 32
3.5.4 ДЭЭЖ АВАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ БА ГҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ 32
3.5.5 ДЭЭЖ АВАХ ЖУРАМ 32
3.5.6 ДЭГДЭМХИЙ ОРГАНИК БОДИС ТОГТООХ ДЭЭЖ АВАХ 33
3.5.7 ДЭГДЭМХИЙ БУС НЭГДЛҮҮД ТОГТООХ ДЭЭЖ АВАХ 35
3.5.8 СТАНДАРТ БУС МАТРИЦЫН ДЭЭЖ АВАХ ЖУРАМ 36
3.6 ХОГ ХАЯГДАЛ 37
3.6.1 ДЭЭЖ АВАХ ҮНДСЭН АРГУУДЫН ХУРААНГУЙ 37
3.7 ГАДАРГЫН ДЭЭЖЛЭЛТ 42
3.7.1 ДЭЭЖ АВАХ ҮНДСЭН АРГУУДЫН ХУРААНГУЙ 42
3.8 ГАДАРГЫН УС 44

3.8.1 ДЭЭЖ АВАХ ҮНДСЭН АРГУУДЫН ХУРААНГУЙ 44
3.9 ГҮНИЙ УС 46
3.9.1 ХАНАСАН БҮС 46
3.9.2 ДЭЭЖ АВАХ ЕРӨНХИЙ ЖУРАМ 47
3.10 ХАЯГДАЛ УС 55
3.10.1 ДЭЭЖ АВАХ ҮНДСЭН АРГУУДЫН ХУРААНГУЙ 55
3.11 АГААР БОЛОН АГААРЫН МАССААС ДЭЭЖ АВАХ 58
3.11.1 СУДАЛГАА, НӨХӨН СЭРГЭЭЛТ БА ХЯНАЛТЫН АЖЛЫН АТМОГЕОХИМИЙН АРГУУД 59

4. ДЭЭЖЛЭЛТИЙН СТАТИСТИКИЙН ХАНДЛАГА 62

4.1 ДЭЭЖЛЭЛТИЙН СТРАТЕГИ 63
4.2 ӨГӨГДЛҮҮДИЙН СТАТИСТИК ДҮГНЭЛТЭНД ШААРДАГДАХ ДЭЭЖИЙН ДООД ХЭМЖЭЭ 67
4.3 ГҮНИЙ УСНЫ МОНИТОРИНГИЙН ТӨРЛҮҮД 67

5. АШИГЛАСАН БА ЗӨВЛӨХҮЙЦ НОМ ХЭВЛЭЛ: 68

Хавсралтын хэсэг

Хүснэгт 1: Шингэн бус дээж авах үеэр тодорхой бүлэг үзүүлэлтүүдэд тохирох дээж авагчийг сонгох

Хүснэгт 2: Тунадас/шавар зэргээс дээж авах үеэр физикийн шинж чанарыг харгалзан дээж авагчийг сонгох

Хүснэгт 3: Талбайн хэмжих багажуудад ашиглагддаг хий илрүүлэгчийн төрлүүд ба тэдгээрийн хэрэглээ

Хүснэгт 4: Хатуу сорбентуудын товч тойм ба тэдгээрийн нэгдэл бүрийн хэрэглээ

Хүснэгт 5: Шингэн сорбентуудын товч тойм ба тэдгээрийн нэгдэл бүрийн хэрэглээ

Хүснэгт 6: Гүний усны дээжлэлтэд тохиромжтой хэрэгслүүд

Товчилсон үгсийн жагсаалт:

AOX	шингээх чадвар бүхий органик галогенидууд
BET	биологийн экспозицийн тест
CRM	баталгаажсан лавлагаа материал
DCE	дихлорэтилен
DNAPL	устай холилддоггүй, усны нягтаас их нягттай шингэн төлөв
EOX	хандлагдах чадвар бүхий органик галогенидууд
EU	Европын Холбоо
FID	дөлт ионжуулалтын детектор
HDPE	өндөр нягттай полиэтилен
ISO	International Organization for Standardization
LDPE	бага нягттай полиэтилен
LNAPL	устай холилддоггүй, усны нягтаас бага нягттай шингэн төлөв
MLA	олон талын хэлэлцээр (multilateral agreement)
MLS	олон түвшинд дээж авагч (multilevel samplers)
MP	аргачлалын удирдамж
NAPL	устай холилддоггүй шингэн төлөв
NIOSH	National Institute for Occupational Safety and Health
NL	уусаагүй бодис
NPK-P	зөвшөөрөгдөх дээд агууламж
OSHA	Occupational Safety and Health Administration
PAU	полиаромат нүүрсустөрөгч
PCB	полихлорт бифенил
PCDD/F	полихлорт диоксин / фуран
PCE	тетрахлорэтилен (перхлорэтилен)
PEL	экспозицийн зөвшөөрөгдөх хязгаар
PHM	түлш
PID	фотоионжуулалтын детектор
POP	удаан задардаг органик бохирдуулагч
PTFE	политетрафлуороэтилен (худалдааны нэр, ж.нь:. Teflon) ®))
PTS	удаан задардаг хорт бодис
PVC	поливинил хлорид
QA	чанарын баталгаа (quality assurance)
QC	чанарын хяналт (quality control)
RM	лавлагаа материал
SOP	стандарт үйл ажиллагааны журам
SVOC	хагас дэгдэмхий органик нэгдлүүд (semivolatile organic compounds)
TCE	трихлорэтилен
TL	дэгдэмхий бодисууд
TOC	нийт органик нүүрстөрөгч
TOL	дэгдэмхий органик бодисууд (volatile organic compounds), мөн VOC
U.S. EPA	АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (Environmental Protection Agency)

1. Ерөнхий бүлэг

1.1Аргачлалын удирдамжийн тухай, зорилго ба ашиглалт

„Геологийн нөхөн сэргээлтэд дээжлэлт хийх" хэмээх аргачлалын удирдамж нь Бохирдсон газар нутгийн судалгааны тухай арга зүйд тулгуурласан бөгөөд 2006 оны 12 сард Чех улсын Байгаль орчны яамнаас гаргасан аргачлалын удирдамжаас гаралтай.

Дээжлэлт нь экологийн ачааллын тухай судалгаа, дүгнэлт ба түүнийг арилгахтай холбоотой төслийн нэн чухал хэсэг, өөрөөр хэлбэл дээжлэлтийн үр дүнгээс хамаарч төслийн дараагийн алхмын зэрэгцээ эдгээр ажлын хэрэгжилттэй холбогдох санхүүгийн зардлыг шийдвэрлэдэг юм. Ийм шийдвэрийн тулд дээжлэлтийн ажлаар найдвартай мэдээллийг олгох нь хамгийн чухал.

Уг аргачлалын удирдамж (цаашид МР) нь дээж авахад шаардлагатай техник тоног төхөөрөмжийн (дээж авагч, дээжлэлтийн төхөөрөмж ба хэрэгсэл) тухай хураангуйг агуулж байгаа юм. Экологийн ачааллын асуудлыг шийдвэрлэх үеэр тохиолддог матрицуудын дээж авах арга тус бүрийн хэрэглээний боломжуудыг нэгтгэн тоймчилсноос гадна, дээж авах үеэр чанарын баталгааг хангах зарчмуудыг, дээжлэлт хийх болон дээж авахад ашиглагддаг үндсэн тодорхойлолтуудын хамт нэгтгэн танилцуулна.

Аргачлалын удирдамжийн утга учир нь экологийн ачааллын тухай судалгаа, дүгнэлт ба түүнийг арилгах явцад оролцогчдод дээж авахад тохиромжтой аргыг төлөвлөн ашиглаж хэрэгжүүлэх боломж өгөх арга зүйг олгох, мөн олж авсан үр дүн нь дараагийн ажлын алхмыг ил тод удирдан зохион байгуулах боломжийг бүрдүүлэхийн тулд төслийн ажлын тодорхой зорилгын төлөөх техник тоног төхөөрөмжөөр хангахад оршино.

Авах дээжийн тооны сонголт, дээжлэлтийн арга барил ба схемчлэл, дээжлэлтийн ажлын төлөөллийг шинжлэх төдийгүй дүгнэх журам зэргийг МР-д шийдвэрлээгүй, өөрөөр хэлбэл эдгээр нь төслийн ажлын тодорхой зорилгоос үүсэх ба төслийн оролцогч талуудын тохиролцооны үндсэн дээр шийдвэрлэгдэж болох юм.

1.2 Дээжлэлтийн ажлыг хэрэгжүүлэхэд тавигдах үндсэн дүрэм

Дээж авах ажлыг үргэлж **тодорхой зорилготойгоор** хийж гүйцэтгэдэг. Дээжлэлтийн ажлыг хэрэгжүүлэхийн тулд тухайн төслийг шийдвэрлэхэд оролцогч талуудын зүгээс уг зорилгыг **тогтоож, нарийн тодорхойлж бас зөвшөөрсөн** байх шаардлагатай.

Дээжлэлтийн зорилго нь дээж авах ажлын төлөвлөлтийн хүрээнд дээж авах ажлын төлөвлөлтөд ойлгомжтой, хоёрдмол утгагүй зааварчилгаагаар боловсруулах **техникийн тодорхой үзүүлэлтэд** хүргэх явдал юм.

Эдгээр зааварчилгаа нь дээжлэлтийн багт дээж авах ажлын бэлтгэлд буюу дээжлэлтийн техникийн бэлтгэл, баримтжуулалт, ажил олгох байгууллагын болон дээж авах ажлын гүйцэтгэл зэрэгт зориулагдана.

Дээж авах үйл ажиллагаа, дээжтэй харьцах, дээжлэлтийн техникийн тээвэрлэлт зэргийг газар дээр нь гүйцэтгэх ажлын үр дүнгийн эргэлзээг арилгах үүднээс **стандартчилсан, эсвэл нормчилсон** журмын дагуу хийж гүйцэтгэх нь зүйтэй.

Дээжлэлтийн ажлыг гол төлөв **шинжилгээний лабораторитой нягт хамтран ажиллаж** гүйцэтгэдэг. Дээжлэлтийн баг ба шинжилгээний лаборатори хооронд, мөн дээжлэлтийн журмыг оновчтой байлгах лабораторийн оролцоог хамруулаад, хамтын ажиллагаа маш чухал.

Үүнээс гадна, практикаар олж авдаг чанарыг хамгаалах чадвар нь дээжлэлтийн ажлын салшгүй хэсэг болдог учир дээж авалтыг гүйцэтгэх ажилтнууд дээжлэлтийн ажлын чанарыг хамгаалах, мөн хянах журамтай танилцсан, практикт хэрэгжүүлдэг байсан байх нь зайлшгүй шаардлагатай.

Дээжлэлтийн баг үргэлж гүйцэтгэсэн дээжлэлтийн ажлаас гарах үр дүнгийн чанарыг батлан үзүүлэх, хамгаалах чадвартай байх ёстой.

Дээжлэлтийн ажлын салшгүй нэгэн хэсэг нь дээж авалтын тодорхойлолт, нөхцөл төдийгүй хэмжилтийн үр дүнд нөлөөлж болзошгүй стандарт бус тохиолдлуудыг боловсруулагчид нарийвчлан баримтжуулсан, итгэл төрүүлэхүйц, найдвартай **баримт бичиг** болно. Өнөөгийн техник хэрэгслүүд баримтжуулах олон аргуудыг санал болгож байна. Тэдгээрийн үндсэн дээр гүйцэтгэсэн ажлын чанарыг шинжлэх боломжтой байх нь зайлшгүй чухал.

Дээжлэлтийн ажил нь түүнийг гүйцэтгэж буй ажилтнуудаас өндөр ур чадвар шаарддаг үйл ажиллагаа юм. Иймээс эдгээр ажилтнууд өөрсдийн мэргэжлийн ур чадварыг ямагт хөгжүүлэн боловсорч, өөрсдийн боловсролын түвшинг нотлох баримтаа хавсаргаж байх нь чухал (мэргэжлийн намтар, дээжлэлттэй холбоотой сургалт дүүргэсэн тэмдэглэл, мэргэжлийн семинарт оролцсон тухай тэмдэглэл, шинэ дээжлэлтийн техник, багажтай танилцах сургалт дүүргэсэн тухай тэмдэглэл гэх мэт).

Байгаль орчны салбарт дээж авах, дээжлэлт зэргийг оролцуулаад аналитик шинжилгээнд магадлан итгэмжлэл байнга шаардагдах болсон.

1.3Төслийн ажил

Дээжлэлтийг гүйцэтгэж буй ажлын **зорилго**, уг зорилгод хүрэх **хэрэгсэл болон арга замыг** тодорхойлж буй тодорхой төслийн хүрээнд хийж гүйцэтгэдэг. Ийм төслийн зорилго тухайлбал, өгөгдсөн газар нутаг бохирдож байгаль орчинд ямар нэгэн агууламж хууль тогтоомжоор тогтоосон хязгаараас хэтэрсэн эсэхийг олж илрүүлэх, батлах, илэрсэн тохиолдлыг арилгах зэрэг байж болно. Өөр нэгэн жишээ нь: хогийн цэг байрлах газарт гүний болон гадаргын усанд байгаа аюул учруулж болзошгүй найрлагын хандлагад урт хугацааны турш ажиглалт хийх, дүгнэх, бохирдсон газрын захаар бохирдуулагчийн жам ёсны бууралтын чадамжийг шинжлэх, эсвэл ундны ус үйлдвэрлэх зорилгоор гүний эсвэл гадаргын усны чанарыг шалгах гэх мэт.

Ажил эхлэхийн өмнө **зорилго**, түүнд **хүрэх хэрэгсэл** ба **арга зам**ыг тодорхойлсон байх шаардлагатай бөгөөд ингэж боловсруулсан төслийг гэрээний эрх бүхий байгууллагад шийдвэрлүүлэхээр бичгэн хэлбэрээр өгнө.

Ихэнх тохиолдолд дээжлэлт нь зорилгодоо хүрэх хэд хэдэн аргын зөвхөн нэг нь болдог. Дээжлэлтээс гадна судалгааны, газрын зурагчлах ба камерын ажил, гидродинамикийн болон цооног дахь техникийн бусад туршилтууд, геофизикийн гэх мэт аргууд түгээмэл хэрэглэгддэг.

Дээжлэлтийн ажлыг нарийвчлах үеэр **төслийн ажил** гарц мэдээллийн чанарын шаардлагыг тодорхойлсон байвал зохино. Энэ нь төсөлд тавьсан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд баримтлах шаардлагатай тоон ба чанарын үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлно гэсэн үг юм. Тухайлбал, практикт үр дүнгийн статистик үнэлгээнд шаардагдах авсан болон шинжилсэн дээжүүдийн тоо хэмжээн доод утгын тодорхойлолт, гүйцэтгэл ба шинжилгээний шаардлагатай хүрээг олох, дээж авах цэгийн цаг хугацааны болон орон зайн нарийвчлалыг тодорхойлох, эсвэл тухайн аналитын тодорхойлогдох дээд утгад тавих шаардлага зэрэг байж болно. Эдгээр шаардлагатай мэдээллүүд нь төлөвлөсөн төсөлд байх ёстой **газар нутгийн концепци загвар**аас үүдэн гарна (MP – Бохирдсон газар дахь эрсдлийн шинжилгээг үз).

Дурдсан шаардлагууд **төслийн ажлын** нэгэн хэсэг болох **дээжлэлтийн программд** агуулагдсан байна. **Дээжлэлтийн программ** нь төлөвлөсөн дээжлэлтийн тухай үндсэн баримтыг тайлбарлана. Үүнд:

- дээжлэлтийн ажлын техникийн өгөгдөл:
  - төслийн шийдвэрлэх зорилгоос хамаарч дээжлэлтийг төлөөлөх чадварт тавигдах шаардлага,
  - төслийн шийдвэрлэх зорилгоос хамаарч гүйцэтгэсэн дээжлэлтийн чанарт тавигдах шаардлага,
  - тодорхойлох хязгаарт тавигдах шаардлага,
- техникийн өгөгдлийг тодорхой нарийвчлалд тусгах:
  - дээжлэлтийн тохиромжтой схемчлэлийг сонгох (магадлалт дээжлэлтийн арга, эсвэл үнэлгээт дээжлэлт),
  - дээж авах газрын байршил, цэг
  - дээж авах цагийн хуваарь, хэрэв дээжлэлтийг хэд хэдэн цагийн интервалд давтан хийвэл,
  - дээж авах аргыг (хэлбэр) сонгох, дээж авах журам ба дээжлэлтэд шаардагдах тоноглол,
  - төлөвлөгөөт шинжилгээний тойм,
  - дээж авалтын чанарыг хангахад тавигдах шаардлага (QA),
- техникийн өгөгдлөөс хамаарч үр дүнг дүгнэх арга:
  - чанарын хяналт (QC)
- ажил хөдөлмөрийн үеэр эрүүл мэндийг хамгаалах, түүний аюулгүй байдалд тавигдах шаардлагын нарийвчлал гэх мэт.

Үүний эсрэг дээж авалт бүртэй холбоотой болон дээжлэлтийн багийн ажлын үндэс болох дэлгэрэнгүй мэдээллүүдийг **дээж авах төлөвлөгөө** хэмээн нэрлэх нь зүйтэй. Эдгээр мэдээллүүд нь ядаж дараах зүйлүүдийг агуулна:

- төслийн нарийвчилсан тодорхойлолт (төслийн нэр, даалгаврын дугаар, ажлыг оноосон этгээд гэх мэт.),
- дээж авсан газар, цаг,
- дээж авсан цэгийн талбайн болон гүний байршил,
- дээж авсан арга (дээжлэлтийн явцыг нарийн тодорхой тэмдэглэл, дээжлэлтийн

тоноглолын тухай тодорхойлолт, стандарт үйл ажиллагааны журмын холбоос – SOP),

- дээжийн төрөл, дээж тус бүрийн болон нийт дээжийн хэмжээ (эзэлхүүн, жин), холимог дээж бэлтгэх арга, дээж засах журам (гомогенжилт, хатуу матрицын дээжийн квартац, усны дээжийн шүүлт гэх мэт.), шаардлагатай бол харъяалагдах SOP холбоос,
- шаардагдах дээжийн савны тойм (төлөвлөсөн шинжилгээний шаардлагын дагуу), дээж тэмдэглэх арга, харъяалагдах SOP холбоос,
- чанарын хяналтын шалгуур (хяналтын дээжийн тодорхойлолт, түүний тоо ба гүйцэтгэх арга),
- ажил хөдөлмөрийн үеэр эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний нарийн тодорхойлолт (ажлын хамгаалах хэрэгсэл, хувцас, гутал гэх мэт.).

Дээж авах төлөвлөгөөг (дээжлэлт) талбайн дээжлэлтийн үеэр үргэлж өөртөө авч явна. Цаг хугацааны хувьд удаан үргэлжлэх төслийн үеэр дээжлэлтийн баг талбайд гарах бүртээ дээж авах төлөвлөгөөг идэвхжүүлэх, шаардлагатай бол төсөлд дурдагдсан дээжлэлтийн программыг өөрчлөлгүйгээр зөвхөн өмнөх шатны дээжлэлтийн үр дүнг харгалзан үзэхийн тулд (ж.нь: цооног цэвэрлэх үеэр шавхагдсан хэмжээг засах, дээж авах цэгийг орлуулах газрыг тодорхойлох гэх мэт.) шинэ төлөвлөгөө боловсруулах нь тохиромжтой.

Төсөл дээжлэлтийг дахин гүйцэтгэхээр төлөвлөөгүй тохиолдолд **дээжлэлтийн программ** болон **дээж авах төлөвлөгөөг** нэг баримт бичгийн хүрээнд нийлүүлж болох юм.

1.4Дээж авалтыг баримтжуулах

Дээжлэлтийн ажлын салшгүй нэгэн хэсэг нь дээж авалтын тодорхойлолт, нөхцөл төдийгүй хэмжилтийн үр дүнд нөлөөлж болзошгүй стандарт бус тохиолдлуудыг боловсруулагчид нарийвчлан баримтжуулсан, итгэл төрүүлэхүйц, найдвартай баримт бичиг болно. Дээж авалтыг зөв баримтжуулаагүй тохиолдолд дээжлэлтийн ажлын үр дүн тэр чигээрээ эргэлзээтэй болох ба төслийн хэрэгцээнд ашиглагдах боломжгүй болно.

Дээж авах ба дээжлэлтийн баримтын үндсэн элемэнтүүд:

- төслийн ажил,
- дээжлэлтийн программ,
- дээж авах төлөвлөгөө,
- дээж авсан тухай тайлан, эсвэл дээж авсан тухай протокол,
- нэмэлт баримт.

Төслийн ажил, дээжлэлтийн программ болон дээж авах төлөвлөгөө зэрэг нь өгөгдлийн шаардлага, дээжийг хэрхэн авах тухай тодорхойлдог бол **дээж авсан тухай тайлан**, өөрөөр дээж авсан тухай протокол болон нэмэлт баримтууд дээж авалт ямар нөхцөлд, яг хэрхэн гүйцэтгэгдснийг тодорхойлдог.

Дээж авсан тухай тайлан, өөрөөр дээж авсан тухай протокол нь хамгийн багадаа дараах мэдээллүүдийг агуулж байх ёстой:

- төслийн нарийвчилсан тодорхойлолт (төслийн нэр, даалгаврын дугаар, ажлыг оноосон этгээд гэх мэт.),
- дээж авах төлөвлөгөөний холбоос,
- дээжийн тэмдэглэгээ,
- дээж авсан газар,
- дээж авсан цаг,
- дээж авсан үеийн цаг агаарын байдал,
- дээж авсан цэгийн талбайн болон гүний байршил, (ж.нь: геодезийн координатуудын тусламжтайгаар, GPS, газрын зураг, схем дээрх тэмдэглэгээ гэх мэт),
- дээж авсан арга (дээжлэлтийн явцыг нарийн тодорхой тэмдэглэл, дээжлэлтийн тоноглолын тухай тодорхойлолт, стандарт үйл ажиллагааны журмын холбоос – SOP),
- дээжийн төрөл, дээж тус бүрийн болон нийт дээжийн хэмжээ (эзэлхүүн, жин), холимог дээж бэлтгэх арга, дээжийн тэмдэглэл – харааны болон мэдрэхүйн тэмдэглэл,
- талбайн хэмжилтийн үр дүн,
- дээж засах журам (гомогенжилт, хатуу матрицын дээжийн квартац, усны дээжийн шүүлт гэх мэт.), шаардлагатай бол харъяалагдах SOP холбоос,
- ашигласан дээжийн савны тодорхойлолт (төлөвлөсөн шинжилгээний шаардлагын дагуу),
- чанарын хяналтын гүйцэтгэсэн элемэнтүүд (хяналтын дээжийн төрөл, түүнийг гүйцэтгэх арга ба тэмдэглэгээ),
- дээж авах төлөвлөгөөний гажилт, мөн авсан дээжийн чанартай холбогдож болохуйц стандарт бус нөхцлийн тэмдэглэл,
- дээж авалтыг гүйцэтгэгчийн тодорхойлолт (ж.нь: нэр ба овог, албан тушаал, байгууллага гэх мэт) болон гарын үсэг,
- дээжийг лабораторид руу хүргэх тээвэрлэлтийн үеэр хамгаалах,
- лабораторит дээж хүлээлгэн өгсөн огноо, цаг болон лабораторийн дээж хүлээн авах хариуцлагатай ажилтны тодорхойлолт, шаардлагатай бол дээжид учирсан гэмтлийн тухай, эсвэл стандарт үйл ажиллагаанаас хазайсан тухай тэмдэглэл.

Дээжийн тухай протокол нь дээж авсан тухай тайлангаас товч байна гэж таамаглаж байна. Энэ нь дээж авсан гүйцэтгэлийн техникийн болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны тэмдэглэл бол, тайлан нь агуулгын хувьд илүү өргөн байдаг ч зайлшгүй баримтлах дүрэм биш юм.

Нэмэлт баримтад (протоколын эсвэл дээжийн авсан тухай тайлангийн нэг хэсэг) дараах зүйлүүд хамаарч болно:

- фото зураг, дүрс бичлэг,
- ноорог зураг (дээж авсан газар буюу цэгийн ноорог зураг, гэх мэт),

- цэгийн геодезийн хэмжилт,
- материаллаг баримт (дээж, эсвэл түүний хэсгүүд),
- тухайн төсөлд зориулагдсан бусад эд баримтууд.

Дээжлэлтийн баг, эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу баримт бичгийн эх хувийг үзүүлэх, хянуулах гэх мэт боломжтой байлгах үүднээс архивчлах журмыг нэвтрүүлж ажиллана. Баримтжуулалтын агуулга ба хүрээнд тавигдах шаардлага хариуцагч, оролцогч талуудын зүгээс төслийн болон дээжлэлтийн ажлын тодорхой хэрэгцээний шийдвэрийн дагуу тодорхойлогдож болох юм.

Дүгнэлт:

Дээжлэгч ажилтан нь дээж авахын өмнө ба дээжлэлтийн үеэр түүнд дээжлэлтийн ямар ямар төхөөрөмж, хэрэгсэл, сав, хамгаалалтын хэрэгсэл хэрэг болох, мөн хаана, яаж, юуны дээж авахыг тодорхой бичсэн бичиг баримтыг (дээж авах төлөвлөгөө) дэргэдээ байлгана. Үүнээс гадна, дээж авах ажлыг гүйцэтгэх үеэр баримтлах ажлын журмыг дэргэдээ байлгана. Шаардлагатай ажлыг хийж гүйцэтгэсний дараа дээж авсан тухай протоколд төлөвлөсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг нарийн тодорхойлох мэдээллийг (огноо, цаг, дээжийн харагдах байдал гэх мэт) бичиж тэмдэглэнэ. Гүйцэтгэх шаардлагатай байсан төлөвлөгөөний (эсвэл тогтоосон журам) эсрэг өөрчлөлтийг бичиж тэмдэглэх нь чухал. Хэрэв дээжийн чанарт нөлөөлөхүйц ноцтой өөрчлөлт бол газар дээр нь хариуцлагатай шийдвэрлэгчтэй холбогдож (ж.нь: утсаар) зөвшөөрөл авна. Хэрэв боломжтой бол дээж авах газар дээр фото баримтжуулалт хийхийг зөвлөж байна.

2. Дээжлэлтийн зориулалттай төхөөрөмж, хэрэгсэл ба материал

2.1 Дээжлэлтийн төхөөрөмжийн зориулалттай материалууд

Дээжлэлтийн тоноглолын хийцэд ашиглагдах материалуудын авсан дээжид агуулагдах ажиглах үзүүлэлтэд нөлөөлөх нөлөө туйлын бага байх ёстой. Энэ нь дээжлэлтийн орчны нөлөөнд физик ба химийн өндөр тэсвэртэй байхын зэрэгцээ дээжийн ажиглах шинж чанарт ямар ч аргаар нөлөөлөх ёсгүй гэсэн үг юм.

Иймээс дараах нөхцлүүд чухал:

a) химийн реакци, уусалт, зэврэлт зэрэгт материалын тэсвэрлэх чанар,

b) түүний шингээх шинж чанар.

Гүний усны бохирдолтод дээжлэлт хийх тохиолдолд чулуулгийн орчин дахь нүүрс-устөрөгчийн шингэн фаз оршиж болох боломжийг авч үзэх шаардлагатай. Нүүрс-устөрөгчийн шингэн фаз нь гүний усны гадаргууд хөндийрсөн давхарга байхгүй тохиолдолд ч чулуулгийн орчинд тусгаарлагдсан, маш жижиг дусал хэлбэрээр илэрч болно.

Хэрэв нийлүүлэгчийн зүгээс тухайн төхөөрөмжийн тухайн матриц ба аналитад тохиромжтой эсэхийг мэдүүлээгүй бол төхөөрөмж болон материалын тухайн зориулалтад тохиромжтой байх эсэхийг шалгах нь чухал.

Аналит тус бүрт тохирох материал бүрийн харьцуулсан олон судалгааны тухай ном, хэвлэлд олж болно. Ерөнхийдөө PTFE (ж.нь: TEFLON®) ба зэвэрдэггүй ган материалыг зөвлөж байна. Бодит байдал дээр дээж авалтыг стандарт, ердийн төхөөрөмжөөр гүйцэтгэх боломжгүй болох үе байдаг учир стандарт бус, өөр төрлийн материалаар хийгдсэн тоноглол ашиглахаас зайлшгүй тохиолдол үүсч болно. Ийм тохиолдолд ашиглагдсан материал дээжтэй нийцэхүйц (ж.нь: уусалт ба зэврэлтийн үүднээс) байх, ажиглаж буй аналиттай ямар ч аргаар нөлөөлөхгүй, эсвэл харилцан үйлчлэхгүй байх ёстой. Огт тохиромжгүй, харьцангуй реактив материалуудыг дурдвал: каучук, силикон каучук, төмөр материалуудаас: төмөр, хайлш, хөнгөн цагаан гэх мэт.

EN ISO 5667-18 стандарт ерөнхийдөө PTFE ба зэвэрдэггүй ган ашиглахыг зөвлөдөг хэдий ч шалгаж үзсэний дараа бэхжүүлсэн PVC, HDPE зэрэг өөр хувилбарт материал ашиглахыг зөвшөөрдөг.

Материалд тавигдах шаардлага нь хоолойн холболт, жийргэвч элемэнтүүд, кабел г.м дээжлэгдэж буй зүйлтэй хүрэлцэх дээжлэлтийн төхөөрөмжийн бүхий л хэсэгт хамаатай.

Янз бүрийн аналиттай нийцэхүйц материал бүрийн тухай мэдээллийг иш татсан ном товхимолд олж үзэж болно.

2.2 Хатуу (шингэн бус) матрицаас авах дээжлэлтийн төхөөрөмж

Хатуу матрицын дээжлэлт нь барель эсвэл контейнэрт ачсан, овоолсон хатуу хаягдлаас эхлээд хөрс шороо, шавар хүртэл бүх төрлийн дээжлэлтийг агуулдаг. Дээжлэгдэж буй материалын төрөлд тохирох төхөөрөмжийн сонголтод нөлөөлдөг олон хүчин зүйл бий.

Хатуу матриц авах үед тавигдах хамгийн чухал шаардлага нь дээжлэлтийн давхарга, материалын хэсэг бүрээс төлөөлөх дээж авах болно. Дээжийн физикийн шинж чанар (материалын чийгшлийн болон бүтцийн өөрчлөлт) болон химийн найрлага (ж.нь: дээжлэлтийн хамгаалалт) алдагдахаас хамгаалахад анхаарал хандуулах нь зохистой. Тохиромжтой дээжлэлтийн төхөөрөмж ашиглах нь эдгээр зорилт (зорилго) хэрэгжих үндсэн нөхцөл болно. Бүлэг дөрвөн дэд бүлэгт хуваагдана:

- бэхжүүлсэн материалууд (хад чулуулаг, барилгын хийц),
- хөрс шороо,
- тунамал/шавар ба контейнэрт ачсан хатуу материалууд,
- бөөнөөр овоолж хаясан материал (хаягдлын цэг).

2.2.1 Бэхжүүлсэн материалаас дээж авах тоноглол

Бэхжүүлсэн материалаас дээж авахад бэхжүүлсэн (хад) чулуулаг болон барилгын материалаас авах дээжлэлт орж болно.

Бэхжүүлсэн материал дээжлэхийн тулд дээжилж буй объектын механик шинжийг алдагдуулах шаардлагатай. Энэ нь дээжлэгдэж буй барилгын объектын шалны бүрэн бүтэн ба тусгаарлах чанар алдагдах, эсвэл бүр нийт объектын статик алдагдахад хүрэх гэх мэт олон сөрөг үр дагавартай байж болно.

Бэхжүүлсэн материалын дээжлэлтүүд төслийн зорилгоос хамааран авагдаж болно:

- материалын гадаргаас (цохиж авдаг дээжүүд)

- дээжлэгдэж буй материалын гадаргын дотор талаас.

Гадаргуугаас үл ялиг доор (эхний нэгжүүд хэдэн арван см) орших дээжлэлтийн цэгээс дараах багажуудын тусламжтайгаар гар аргаар дээж авч болно:

- ердийн эсвэл тусгай багаж хэрэгсэл (геологийн алх, цүүц),
- гар эсвэл цахилгаан багаж (ж.нь: өрөмдлөгийн алх гэх мэт).

Гадаргаас доош гүнд дээж авах цэгээс дээжийг чөмгөн өрмөөр авна.

Үүнтэй уялдуулан геометрийн байрлалаар буюу соронзон хойд туйлтай харьцуулахад мэдэгдэж буй байршлаар чөмгөн дээж авах боломжийг дурдах нь зүйтэй. Энэ нь тухайлбал, ан цавын системийн чиглэл ба өнцөг, тасралт мөн чөмгөн өрөмдлөгийн бусад ерийн бус байдлыг бичих шаардлагатай үед илүү ашигтай байж болно.

Бэхжүүлсэн чулуулгийн өрөмдлөгийн үеэр оройг дээжлэгдэж буй объекттой шүргэж байгаа өрмийн зайлагчаар хөргөх шаардлагатай. Нэг талаас авсан дээжид зайлагч нэвтрэн орох, нөгөө талаас зайлагчийг бохирдуулах ба авсан дээжийг түр зуурын бохирдолд хүргэж болно. Ийм шалтгааны улмаас өрмийн зөвшөөрөгдөх гол зайлагч нь цэвэр ус байна.

2.2.2 Хөрснөөс дээж авагч

Хөрснөөс дээж авахад тохиромжтой дээж авагч сонгохын тулд дээжлэгдэж буй хөрсний шинж чанар, дээж авах гүн ба тодорхойлсон үзүүлэлтийн төрлийг анхаарна.

Хөрсийг гадарга дээр эсвэл гадарга доор шаардаж буй зорилгоос хамааруулж дээжлэнэ. Дээж авах гүнээс хамаарч дээж авах арга хоёр хуваагдана:

- гадаргаас дээж авах (гадарга ба түүнээс доош 15 см бүс),
- гадаргуу доороос дээж авах (15 см-ээс илүү гүнд).

Тодорхойлсон үзүүлэлтийн төрлөөс хамаарч дээж авагчийг ангилсан тойм уг МР-ын хавсралт хэсгийн хүснэгт 1-т бий.

2.2.2.1 Халбага/Хүрз („scoop/trowel“)

Хүрз эсвэл халбагыг гадаргаас хөрсний дээж авахад хэрэглэдэг. Тэдгээрийг мөн хөрс гомогенжүүлэхэд эсвэл хатуу хаягдлаас өргөн хэмжээний дээж авахад ашиглаж болно. Дээжлэлтийн халбага нь хүрзтэй төстэй боловч илүү хумигдсан ирмэгтэй байдаг ба хаалттай дээд төгсгөл нь материалыг авахад илүү хялбар болгодог. Халбага болон хүрзийг янз бүрийн хэмжээ хэлбэртэйгээр үйлдвэрлэдэг.

Дээж авагчийг голдуу зэвэрдэггүй гангаар хийсэн байхыг зөвлөдөг. Өөр материал ашиглахыг тодорхой, цөөн тохиолдлуудад зөвшөөрдөг байна. Нимгэн хромжуулсан эсвэл лакдсан халбага, хүрз ашиглахыг огт зөвшөөрдөггүй, өөрөөр хэлбэл дээж авах үед эдгээр давхаргууд хууларч, дээжийг бохирдуулахад хүрч болзошгүй юм.

Шинжилгээний аргаар тухайн зорилгод тохирох өөр бусад гар багажуудыг (ж.нь: хүрз, хамуур гэх мэт) тэдгээрийн хэрэглээ дээжийн ажиглах шинж чанарт огт нөлөөлөхгүй гэсэн тохиолдолд л ашиглаж болно.

2.2.2.2 Гар өрөм

Гар өрөм нь өрмийн нэгэн төрлийн сегмент (хурцалсан зүсэгч гадаргуутай), уртасгасан иш ба бариулаас бүрдэнэ. Төхөөрөмжийг цагийн зүүний эсрэг, даралттайгаар эргүүлэхэд багаж газар уруу өрөмдөн орох ба өрмийн сегментийн зүсэгч гадаргуу хөрсийг эвдэж, дээж авагчийн биед дээж баригдана. Зүсэгч гадаргуу хоорондын зай дээжлэгдсэн хөрсний төрлөөс хамаарч ялгаатай байна. Дээж авагчийн гүний далайцыг сунгалтын тооны дагуу өөрчилж болно. Хөрсний төрлөөс шалтгаалан 3 төрлийн өрөм бий:

- элсэрхэг хөрс,
- шаварлаг/тоосорхог хөрс,
- нийлмэл төрөл.

15 см-ээс илүү гүнд хөрсний дээж авахад хөрсний шинж чанараас хамаарч дээж авагчийн (өрмийн) тохиромжтой төрлийг сонгоно.

Өрөм нь хөрсний холбоост чанарыг гэмтээх бөгөөд үе давхарга бүрийг хольсноор хөрсний гүний бүтцийг өөрчилж болно.

Дээж авагчийг дэгдэмхий органик бодис тодорхойлохоор дээж авахад ашиглаж болохгүй.

Бусад органик нэгдлүүд болон анорганик нэгдлүүдэд гар өрмийг ашиглах нь тохиромжтой байдаг.

2.2.2.3 Ховилт дээж авагч (хөрсний зүү)

Дээж авагч нь бэхжүүлээгүй тоосорхгоос эхлээд сул биш ширхэглэгт материал бүхий хөрсний дээжлэлтэд ашиглагддаг. Дээж авагчийн үзүүр хүртэл уртынх нь дагуу зүссэн хоолойноос бүрдэнэ. Дээж авагч дээжлэгдэж буй материал уруу хялбархан нэвтрэх, мөн авахын өмнө материал дахь дээж авагчийг суллах үүднээс хоолойн үзүүр ба хажуу тал нь хурц байдаг. Дээж авагч нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн, 60-аас 100 см-ын стандарт урт, болон 1,2-оос 2,5 см-ын диаметртайгаар нийлүүлэгддэг.

Ховилт дээж авагчийн материал уруу хатгах аргаараа ялгаатай олон янзын хийц байдаг.

Дээж авагчийн диаметрыг хөрсний төрөл болон дээжлэгдэж буй материалын ширхэглэгийн хэмжээг харгалзан сонгох хэрэгтэй (дээж авагчийн диаметр хэмжээ дээжлэгдэж буй ширхэгийн хэмжээнээс дор хаяж хоёр дахин том байна).

Бусад органик нэгдлүүд болон анорганик нэгдлүүдэд ховилт дээж авагч ашиглах нь тохиромжтой байдаг.

2.2.2.4 Чөмөглөх төхөөрөмж („soil coring device“)

Гэмтэлгүй дээжийн дээжлэлтэд чулуулгийн орчинд зоосон, хоолойт дээж авагчууд ашиглагддаг. Эдгээр дээж авагчууд нь янз бүрийн хийцтэй байж болно.

Хоолойт дээж авагчийн нэг хэлбэр нь хөндлөн хуваагдсан, хоёр төгсгөлдөө ороомогтой зэвэрдэггүй ган цилиндр, доод төгсгөлдөө зүсэгч толгой болон газар уруу зоогдох зориулалттай цохилтын толгой зэргээс бүрдсэн тусгай чөмөглөх төхөөрөмж юм. Зүсэгч болон цохилтын толгой нь гангаар хийгдсэн. Дээж авагчийн дотор байрлах дээж

хадгалах зориулалт бүхий хуванцар хоолой нь дээжийг салган авахад хялбар болгож өгдөг. Үүнээс гадна, хөрс барих – дээж авагчаас хөрс асгаран унахаас хамгаалсан сагс – буюу дээж авагчийн нэвтрэх хэсэгт байрлах хөрс баригч төхөөрөмжийг ашиглах нь тохиромжтой.

Шаардлагатай гүнд хүрэхийн тулд силонон алх ашигладаг.

2.2.2.5 Хоолойт дээж авагч

Дээж авагчийг гэмтээгүй дээжийг авах зорилгоор голдуу хөрс ба бэхжүүлээгүй чулуулгийн геомеханикийн шинж чанарыг тодорхойлох үед, бас TOL-г тодорхойлох болон химийн анализын зорилгоор дээж авах зэрэгт ашигладаг.

Дээж авагч нь зүсэгч толгой бүхий зузаан ханат хоолойноос бүрдэнэ. Энэ нь дээж авагчийг чулуулагт зоогдох боломжтой болгох ба шаардлагатай гүнээс дээж авагчийг сугалан авах үеэр дээж унахаас хамгаалдаг.

Хоолойт дээж авагчийн диаметр хэмжээ янз бүр байж болно. 10 мм-ээс 200 мм хүртэл диаметртай, урт нь 5-аас 30 см хүрэх нь ч бий. Бага диаметртай (10 мм хүртэлх) богино дээж авагчийг өрөмдлөгийн чөмгөөс дэгдэмхий органик бодис тогтоохоор дээж авахад ашиглах боломжтой.

2.2.2.6 Дэгдэмхий органик бодис тогтоохоор дээж авах зориулалттай тусгай дээж авагч

TOL тодорхойлох шинжилгээг гэмтээгүй чулуулаг, цооногийн гүн, өрөмдлөгийн чөмөг гэх зэргээс нарийн-профиль хоолой бүхий дээж авагчийн тусламжтайгаар авна. Нарийн-профиль хоолой бүхий дээж авагчаар:

- материалыг нарийн тогтоосон хэмжээтэй авна (5 гр орчим хэмжээтэй),
- хөрсний байгалийн бүтцийг алдагдуулалгүйгээр дээжийг дээжний саванд хурдан хийх,
- дээжийн хэмжээ тогтмол, урьдаас мэдэгдсэн байх (дээжлэлт эхлэхийн өмнө газар дээр нь ойролцоо шинж чанар бүхий хөрс шорооны бүлэг тус бүрт тест хийнэ).

Нарийн профильт дээж авагч үйлдвэрлэхэд тохирох материалуудад (хатуу матрицд дэгдэмхий бодис тогтоох зорилгоор) доорх зүйлүүд орно:

- нерж, шил, гууль - хязгаарлалтгүй,
- Viton®, PTFE (TEFLON®), өөр бусад хуванцар – дээж зөвхөн маш бага хугацаагаар дээж авагчид байх тохиолдолд.

Хийцийн хувьд илүү төвөгтэй олон төхөөрөмжүүд бий.

2.2.2.7 Спиральт өрөм („power auger“)

Спиральт өрөм нь дээж авахад тохиромжгүй төхөөрөмж юм. Дээж авахын өмнө урьдчилан нүх ухах зориулалттай ба үүний дараа тохирох дээж авагчаар (ж.нь: чөмөглөх г.м) дээжлэлтийг гүйцэтгэнэ. Спираль нь янз бүрийн диаметр ба урттай байдаг. Гидравлик эсвэл механик эргэлттэй спиралийн тусламжтайгаар дээжлэгдэж буй талбайд нүх өрөмдөнө. Дараа нь чөмөглөх төхөөрөмж эсвэл ашиглагдсан спиралийн диаметрээс бага диаметртай цилиндр бие бүхий өрмийн тусламжтай дээж авна.

2.2.2.8 Чичиргээт өрөм („directpush technology“)

Чичиргээт өрөмдлөгийн технологийг дээж авах зориулалтаар ашиглах нь харьцангуй их бөгөөд улам ч түгээмэл болж байгаа юм. Чичиргээт өрмийн тусламжтайгаар гэмтэлгүй хөрсний дээжийг гадаргаас төдийгүй тодорхойлсон гүнээс ч авахад хялбар. Уг технологийг дэгдэмхий бодис тодорхойлох зорилгоор өрөмдлөгийн чөмгөн дээж авахад ашиглах боломжтой.

Чичиргээт өрөмдлөгийн үеэр чөмөглөгч нь цохилт эсвэл чичиргээний тусламжтайгаар (ж.нь: цахилгаан эсвэл өөр хөдөлгүүртэй алхны цохилтоор) шаардлагатай гүн рүү зоогддог. Чулуулгийн орчны давхарга хооронд бохирдол нэвтрэх эрсдлийг аажмаар багасах диаметртай чөмөглөгч ашигласнаар арилгаж байгаа юм. Чөлөөт фазын бохирдлын илэрцтэй бохирдсон орчноор дайрах үед ажлын тулгуур бэхлэлт ашиглах шаардлагатай.

Дээжтэй шүргэлцсэн төхөөрөмжийн бохирдлыг арилгахад гол анхаарал хандуулах нь зүйтэй.

2.2.3 Тунадас болон шавраас дээж авагч

Тунадас эсвэл шавраас дээж авагч сонгоход нөлөөлөх хүчин зүйлүүдэд:

- дээжлэгдэж буй орчны шинж чанар (өргөн, гүн, урсгалын урсах хурд, эсвэл дээжлэгдэж буй сангийн),
- тунадас/шаврын физикийн шинж чанар (материал үүсгэгч хэсгүүдийн хэмжээ, нэгдлийн хэмжээ гэх мэт),
- дээж авах гүн, уст давхаргын зузаан (эсвэл шингэний),
- дээжийн хэмжээ,
- бусад (ж.нь: ёроолд усны ургамал тохиох гэх мэт) орно.

Эдгээр матрицыг авахдаа дээж авагчтай харьцах үед тунадас/шаврын байгалийн тогтоц алдагдах, дээжийн хэсэг эсвэл түүний аль нэгэн найрлага алдагдах явдлыг хязгаарлахын тулд өндөр анхаарал тавих нь зүйтэй (нэн ялангуяа шингэний орчноор дээжийн савыг татан гаргах үед – хурдан урсах урсгал, сангийн гүн эсвэл усны урсгал өндөр байхад г.м).

Усгүй матриц авах зорилгоор голдуу ашиглагддаг зарим төрлийн дээж авагчуудыг тунадас/ шаврын дээжлэлтэд ашиглаж болно. Тэдгээрийн жишээ:

- дээжийн халбага ба хүрз,
- гар өрөм,
- ховилт дээж авагчууд,
- чөмөглөгч,
- дэгдэмхий нэгдлүүдийн дээж авагч.

Уг төхөөрөмжийг уст орчны гадарга доор ашиглаж болохгүй, өөрөөр хэлбэл эдгээр хэрэгслүүдээр гэмтэлгүй дээж авах боломжгүй (дээж угаагдах, дээжийн найрлага алдагдах, дээжийн физик-химийн шинж чанар өөрчлөгдөнө).

Тунадас/шаврын физикийн шинж чанараас хамаарч тохиромжтой дээж авагч сонгох тойм уг МР-ын хавсралт хэсгийн хүснэгт 2-т бий.

2.2.3.1 Утгуурт дээж авагч („grab samplers“)

Утгуурт дээж авагч нь голдуу гол нуурын ширгэж хатсан хэсэгт амьдардаг амьтдаас авах шинжилгээний зориулалттай. Мөн гадаргын тунадас/шаврын дээж авахад ашиглагддаг. Утгуурт дээж авагчийн олон төрлийн хийц байдаг ба тэдгээрийн сонголт дээж авах гүн, дээжийн хэмжээ, ёроолын ургамал амьтны тархац, урсгалын хурд ба дээжлэгдэж буй материалын физик шинж чанараас (нягтралт, хэсгүүдийн хэмжээ) хамаарч зохицуулагддаг. Утгуурт дээж авагч нь гар ажиллагааны хэсэгт нээгддэг цоожоор бэхлэгдсэн, хаагдах хөдөлгөөн бүхий хоёр ширхэг утгууraас бүрдэнэ. Дээж авагч нь ёроол уруу тавигдах татлаганд бэхлэгдсэн байна. Дээж авагч нь гүнээс бус тодорхойлсон талбайгаас дээж авдаг.

2.2.3.2 Чөмгөн дээж авагч („sediment core samplers“)

Чөмөгт (хоолойт) дээж авагч нь утгуурт дээж авагчаас бүсийн хувьд гэмтэлгүй дээж авдаг, ингэснээрээ анхны бүтэц буюу тунадасын үе давхаргыг бараг гэмтэлгүйгээр хадгалдаг чадвараараа ялгаатай.

Мөн тодорхой байршлаас дээж авах боломжийг өгдөг. Ялангуяа утгуурт дээж авагчаас илүү гүний далайцтай.

Хоолойт дээж авагчийн янз бүрийн нөхцөлд дээж авах болон дээжлэгдэж буй материалд зориулсан олон янзын хийц бий.

2.2.3.3 Хүлэрт зонд („peat sampler“)

Хүлэрт зонд нь дунд зэргээс нарийн ширхэгтэй, өөрөөр хэлбэл хүлэртэй ойролцоо конзистенц бүхий материал, тунадас/шавраас дээж авах зориулалттай. Түүнийг бас эдгээр материалуудаас усны түвшин дор дээж авах, эсвэл усархаг материалаас дээж авахад ашиглана (ж.нь: усархаг шавар). Дээж авагч нь хөндлөн зүсэгдсэн, зүсэгдсэн хоолойн доод ба дээд хэсэгт хөдөлгөөнт хавтангаар бүрхсэн ган хоолойгоос бүтнэ. Хавтан нэг талаасаа дээж авагчийн дэвсгэр зургийг бүрхэх ба энэ нь дээж авагчийг сугалан авах болон усны баганаар дамжих үед авсан дээжийг хучих зориулалттай. Дээжийн хаалт нягт биш учир усаар дамжих үед дээжийн нарийн ширхэгүүд зайлагдахаас сэргийлэх боломжгүй. Түүнчлэн дээж авах арга тунадасын бүтэц алдагдахад хүргэдэг, гэмтэлгүй дээж авах нь боломжгүй.

2.2.3.4 Доороо хаалт бүхий хоолойт дээж авагч

Дээж авагч нь голдуу 1-ээс 3 м урт, зэвэрдэггүй ган эсвэл хиймэл материалаар хийгдсэн хоолойноос бүтнэ. Доод хэсэгт хоолойн дамжих тэнхлэг дээр дээж авагчийн дээд хэсгээс удирдах боломжтой (тэнхлэгийг татах, суллах замаар нэвтрэх амсар хаагдаж эсвэл нээгддэг) хаалт бэхлэгдсэн байдаг. Дээж авагч нь шингэн, уст шавар, шингэн хаягдал зэргээс дээж авах зориулалттай. Зөвхөн дээжлэгдэж буй шингэний багана төлөөлөх холимог дээж буюу шавраас дээж авч болно. Нэвт харагддаг материалаар хийгдсэн дээж

авагч нь дээжлэгдэж буй материалын босоо үечлэлд харааны хяналт хийх боломжийг олгодог.

2.2.4 Баглаж боосон эсвэл хогийн цэг дээрх нунтаг материалаас (ж.нь: хаягдлын) дээж авагч

Уут, саванд боосон нунтаг (тоосжилттой, нарийнаас бүдүүн ширхэгтэй) эсвэл контейнэр дэх овор ихтэй материалаас дээж авахад өмнөх бүлэгт дурдсан дээж авагчуудыг (дээж авагч хүрз, чөмөглөгч г.м) ашиглаж болно. Гэхдээ тэдгээрээр нунтаг материалын дээжийг байнга найдвартай авч болдоггүй, өөрөөр хэлбэл гар ажиллагааны үеэр материал хяналтгүй алдагдах, эсвэл гүнээс дээж авч болохгүй байх тохиолдлууд бий. Нунтаг материалаас дээж авах зориулалттай дараах төрлийн дээж авагчууд бий.

2.2.4.1 Нунтаг материалын зориулалттай давхар ханат (бүсчилсэн) дээж авагч („grain sampler“)

Дээж авагчийг уут, сав эсвэл контейнэрт боож багласан нунтаг, тоосорхог, ширхэглэгт материалуудаас дээж авахад ашигладаг. Дээжлэгдэж буй материалын ширхэглэгийн хэмжээ ихэвчлэн 0,6 см диаметрээр хязгаарлагдана. Дээж авагч нь тогтмол интервалд алслагдсан нүхнүүд бүхий хоёр хоолойноос (гадна хоолойн дотор орших хоолой нь эргэдэг) бүрддэг. Дээж авагчийн гадна хоолойг гууль, эсвэл зэвэрдэггүй гангаар харин дотор хоолойг инерт хуванцар материалаар - PTFE, HDPE голдуу үйлдвэрлэдэг. Гадна хоолой дээжлэгдэж буй материал уруу нэвтрэн ороход хялбар байх үүднээс конусан үзүүртэй. Дотор хоолойг эргүүлснээр дээж авагч нээгдэж хаагддаг.

2.2.4.2 Овоолсон нунтаг материалаас дээж авагч („waste pile sampler“)

Дээж авагч нь 1 м-ээс илүү хөндлөн урттай овоолсон материалын дээжлэлтэд ашиглагддаг. Түүнийг мөн контейнэр, усан онгоцонд агуулсан ширхэглэгт, эсвэл тоосорхог материалаас дээж авахад ашиглах боловч өөр дээж авагч – тухайлбал, хатгуур хоолойн урт хангалтгүй байх тохиолдолд хөрсний дээжлэлтэд ашиглаж болно.

Дээж авагчийн урт янз бүр, голдуу 1-1,5 м байна. Дээж авагч нь зэвэрдэггүй гангаар хийгддэг, гэхдээ бэхжүүлсэн хуванцар, жишээлбэл PVC дээж авагчийг ч ашиглаж болно (хэрэв дээжлэгдэж буй материал бэхжилтгүй, нунтаг бол).

2.2.4.3 Зонд („sampling trier“)

Дээж авагчийг уут, сав эсвэл контейнэрт боож багласан маш бага бэхжилттэй, чийглэг эсвэл наалдамхай, нунтаг, тоосорхог, ширхэглэгт материалуудын дээжлэлтэд ашигладаг. Энэ нь дээж авагчийн уртын дагуу үзүүр хүртлээ зүсэгдсэн хоолой юм. Дээж авагч дээжлэгдэж буй материал уруу хялбархан нэвтрэх, мөн дараа нь дээж авагчийг суллан авахад хялбар байх үүднээс хоолойн үзүүр ба хажуу тал нь хурц байдаг. Дээж авагч нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн, 60-аас 100 см-ын стандарт урт, болон 1,2-оос 2,5 см-ын диаметртайгаар нийлүүлэгддэг. Хийцийн хувьд дээж авагч нь хөрсний зүүтэй (ховилт дээж авагч) ойролцоо боловч илүү нимгэн ханатай. Дээж авагчийг бэхжүүлсэн материал уруу зооход тохиромжгүй (харин хөрсний зүүг ийм материалд хэрэглэж болно).

2.3 Шингэн матрицын дээжлэлтийн тоноглол

Шингэн матрицын дээжлэлтийн тоноглолыг түүний ашиглагдах хэлбэрээс шалтгаалан хэд хэдэн бүлэгт хувааж болно, жишээ нь:

1.дээж авагч (тодохойлсон эзэлхүүн бүхий багажууд),

2.дээжлэгч насос,

3.дээжлэгч хэрэгслүүд.

Дээжлэгч хэрэгслүүдийн дотор жишээлбэл янз бүрийн холбох хоолойнууд, арматурууд (хаалтууд), урсгалын хязгаар, шүүлтүүр, туслах савнууд гэх мэт жижиг материалууд орно.

Бүх төрлийн хэрэгсэл, дээж авагч ба дээжлэгч төхөөрөмжүүдийн тухай тэмдэглэл нь уг арга зүйн хүрээнээс хэтрэх бөгөөд цаашид зөвхөн хамгийн түгээмэл хэлбэрүүдийг бичиж тэмдэглэсэн болно.

2.3.1 Эзэлхүүнт дээж авагч

Дээж авагчууд (эсвэл эзэлхүүнт дээж авагчууд) нь тодорхойлсон эзэлхүүн бүхий ус авах зориулалттай нээлттэй эсвэл хаалттай савнууд юм. Дээж авагчийн эзэлхүүнээс илүү хэмжээний ус авах тохиолдолд үйл ажиллагааг ахин давтаж хийх буюу дээж авах цэгт ахин байрлуулж дүүргээд авна. Хамгийн хялбар тохиолдолд дээж авагч нь өөрөө дээжийн сав болдог. Эзэлхүүнт дээж авагчууд нь тэдгээрт ус юүлэхэд дээжлэгдэж буй ус нэвт гоожих эсэхээс хамаарч **зайлагч** эсвэл **зайлагч бус** гэж хуваагдана.

Дээж авагчийн ашиглалтад түүний хийц ба ашиглагдсан материал холбоотой. Дараах текстэд гол төлөв зонхилох дээж авагчуудыг бичиж тэмдэглэсэн болно.

2.3.1.1 Халих цилиндр

Уг дээж авагч нь гүний болон гадаргын уснаас дээж авах зориулалттай магадгүй хамгийн эртний бөгөөд хялбар багаж юм. Төмөр утсан зүүлтний тусламжтайгаар цооног эсвэл гүний усны дээжлэгдэж буй биет рүү орох, ачаа бүхий энгийн цилиндр сав юм. Эзэлхүүнт зайлагч бус дээж авагчийн төрөлд багтана. Хоосон цилиндрийн нийт жин нь түүний хөвөх хүчтэй тэнцүү буюу илүү байдаг.

Дээж авагчийг зэвэрдэггүй гангаар хийдэг.

Уг төхөөрөмжийн сул тал нь дээж авагчийг дүүргэх үед дээгүүрээ, савны дээд амсраар хальж урсдаг явдал юм. Энэ нь найрлагадаа атмосфероос хамгийн их нөлөөлөл авсан усны гадаргын түвшин буюу усны биетийн хамгийн дээд түвшинд байх шингэнээс дээж авагддаг гэсэн үг. Хэрэв уг дээж авагчаар, жишээлбэл өрөмдсөн цооногийн дээд ирмэг дээгүүрх цэвэрлэгдээгүй хэсгээс (даралтат гадаргын түвшин болон сөрөг даралтын өндөр бүхий цооногоос) авсан гүний усны дээжийн хувьд эцсийн дээж нь гүний усны бодит найрлагын талаар маш бага ач холбогдол бүхий мэдээлэл өгнө.

Нөгөө талаас халих цилиндрийн давуу талыг дээж үнэхээр усны гадаргаас авагдсан байх шаардлагатай үед жишээлбэл, гүний усны гадаргын түвшинд нүүрс-устөрөгчийн бие даасан, чөлөөт фазыг олж илрүүлэх зорилгоор ашиглаж болно.

Ийм төрлийн дээж авагчийг ашиглахын өмнө лабораторын аргаар цэвэрлэсэн байвал зохино. Жишээлбэл, NAPL-ын чөлөөт фазаар бохирдсон дээж авагчийг талбайд хангалттай бохирдолгүйжүүлж болдоггүй.

2.3.1.2 Телескоп утгуур („pond sampler“)

Худалдаанд нуур, резервуар, давст нуур ба үүнтэй төстэй усан сангуудаас дээж авахад ашиглагддаг олон төрлийн телескоп / эвхэгддэг утгуурууд бий. Хоёр эсвэл гурван хэсэг бүхий хөнгөн цагаан телескоп бариулын төгсгөлд дээжний савыг бэхлэх бүслүүр эсвэл хуванцар хувин, эсвэл зэвэрдэггүй ган, тефлон материалаар хийгдсэн сав бэхлэгдсэн байдаг. Дээж авагч нь өргөн хэрэглэгддэг ба түгээмэл байдаг. Уг дээж авагчаар зөвхөн гадаргын түвшнээс дээж авч болох бөгөөд түүнийг бүсчлэн дээж авахад хэрэглэж болохгүй.

2.3.1.3 Нээлттэй, доороосоо дүүргэгддэг дээж авагч („bailer“)

Энэхүү дээж авагч нь (бас гүний эсвэл бүсчлэн дээж авагч гэдэг) гүний болон гадаргын уснаас дээж авах зориулалттай хамгийн эртний бөгөөд хялбар багаж юм. Халих цилиндрээс дээж авах зориулалттай цилиндр савны доод төгсгөлд байрлах хяналтын клапангаараа ялгаатай. Дээж авагчийг гүний усны түвшин доор төмөр утсанд зүүж унагахад хяналтын клапан нээгдэх ба ус дээж авагчаар чөлөөтэй дамжин урсах юм. Унагасны дараа болон дээж авагчийг татан авах үеэр хяналтын клапан хаагдаж, дээж авагчид дээж авагч унасан, ойролцоогоор гүний хамгийн доод хэсгийн ус үлднэ.

2.3.2 Дээжлэгч насос

Дээжлэгч насос гэж өмнөх бүлэгтэй харьцуулахад илүү төвөгтэй төхөөрөмжүүдийг тэмдэглэдэг. Тэдгээр нь суурилуулснаас хойш дээж авах цэг хүртэл ихээхэн хэмжээний ус авдаг. Тасралтгүй эсвэл тасралтгүй бус горим бүхий янз бүрийн хөдөлгүүртэй, насос буюу шахуурга юм.

Үйл ажиллагааных нь төрлөөс хамааран дээжлэгдэж буй усны дээж авах цэгт үүссэн илүүдэл даралтыг дээжийн сав руу шахаж ашигладаг буюу **шахах (positive displacement)** ба сөрөг даралтыг ашигладаг **сорох (suction)** төхөөрөмж хэмээн ангилж болно. Шахах төхөөрөмжид бүхий л шумбадаг дээжлэгч насосууд ордог бол сорох төхөөрөмжид жишээлбэл перисталтик насос, эсвэл гадаргаас ашиглагддаг бүлүүрт сорох дээж авагч орно.

Гүний усны дээжлэлтийн зориулалттай дээжлэгч насосд тавигдах шаардлага:

- бага овортой байх – нарийн профильт цооногт (диаметр < 60 мм),
- насосын хүчин чадлын тохиргоо,
- „бага урсгалаар“ шахах - 0,1 л/мин-аас.

Өөр бусад шаардлагууд нь гадаргын эсвэл хаягдал усны дээж авах зориулалттай автомат дээж авагчдад тавигдана. Дээж авах автомат төхөөрөмж нь дараах дээжүүдийг авах чадамжтай байна:

- цаг хугацаанаас хамаарсан холимог дээж,
- урсгалаас, шаардлагатай бол урсан өнгөрсөн хэмжээнээс хамаарсан холимог дээж,

- өгөгдсөн интервалд дээжийн сав тус бүрт орох нэг удаагийн холимог дээж,
- өгөгдсөн богино интервалд дээжийн сав тус бүрт орох холимог дээж,
- дээжийн сав тус бүрт орох урсгалаас хамаарсан холимог дээж.

2.3.2.1 Перисталтик насос

Перисталтик насос нь газрын гадарга дээр ашиглагддаг сорох (сөрөг даралтын) насосны төрөлд багтдаг. Сорох хоолой дахь сөрөг даралт нь хоолойн уян хэсгийг суурин статорын эсрэг эргэх дискэн дээрх дамраар шахснаар үүснэ. Роторыг дамруудтай эргүүлснээр уян хоолой дахь шахагдсан хэсэг шахагдаж буй зүйлийн урсгал дагуу шилждэг.

Уян хоолойноос бусад насосын аль ч хэсэг шахагдах буй зүйлтэй хүрэлцдэггүй. Уян хоолойн нэг тал сорох хоолойд, нөгөө тал дээжийн савыг дүүргэх гарц хэсэгт холбогддог.

Насос үүссэн сөрөг даралтыг ашигладаг мөн гадарга дээр байрладаг зэргээс үзэхэд ус татаж болох хамгийн доод гүн 8 м орчимд хязгаарлагдаж байна. Үүнээс гадна үүссэн сөрөг даралт нь шахагдсан дээж хийгүйжихэд нөлөөлдөг, жишээлбэл ууссан хүчил-төрөгч, нүүрстөрөгч, метан, этан, винилхлорид ба бусад дэгдэмхий органик бодисын, цаашлаад pH болон төмөр (ерөнхий агуулга, бас Fe^{2+} ба Fe^{3+}-т ноогдох өөрчлөлт) зэргийн концентрацид нөлөөлөх боломжтой. Ийм учраас уг насосыг ашиглах зарим нэгэн аргачлалд дэгдэмхий органик бодис тогтоох зорилгоор гүний болон гадаргын усны дээж авах, эсвэл байгалийн тархалтыг дүгнэх үед бага хэмжээгээр шахах аргаар гүний усны дээж авах зэргийг зөвшөөрөөгүй байдаг.

2.3.2.2 Төвөөс зуртагч цахилгаан насос („centrifugal pump“)

Төвөөс зуртагч цахилгаан насос нь ажиллагааныхаа зарчмаас шалтгаалан бие даасан бүлгийг үүсгэдэг. Олон үйлдвэрлэгчид гүний ус авах зориулалттай өндөр хүчин чадалтайгаас эхлээд маш бага хэмжээний ус татдаг насос (дээжлэлтийн тусгайлсан зориулалттай) хүртэл төрөл бүрийн хэлбэрээр үйлдвэрлэдэг. Уг төрлийн насосны шахагдсан устай хүрэлцдэг гидравлик хэсгүүдийн хийцэд ширмээс зэвэрдэггүй ган, тусгай хуванцар материалаас PTFE хүртэлх олон төрлийн материал ашиглах нь элбэг. Үүний адилаар цахилгаан моторыг тэжээлээр хангах зориулалттай цахилгаан хүчдэл ба насос суурилуулах боломжтой бэхэлгээ хайрцгийн диаметр хэмжээ зэрэг нь ялгаатай байдаг. Дээр дурдсан шалтгаануудын улмаас ийм төрлийн насосыг сонгохдоо үйлдвэрлэгчийн заасан ямар зорилго, ажлын үзүүлэлтийн (ж.нь: pH, дулаан) ямар хязгаарт зориулагдсан болохыг анхаарч үзэх нь чухал.

Төвөөс зуртах цахилгаан насос нь цооног цэвэрлэх, зарим тохиолдолд дээж авахад маш тохиромжтой.

2.3.2.3 Цахилгаан ороомгон насос („progressing cavity pump“)

Уг насос нь өмнөх бүлэгтэй төсөөтэй боловч, хоёрлосон дугариг эрээст хэлбэртэй хөндий бүхий уян харимхай жийргэвчтэй статороос бүрдсэн шахалтын гидравлик хэсгүүдийн хийцээрээ ялгаатай. Уг хөндийд нэг эрээст ороомог эргэдэг. Ороомог эргэлдснээр статор болон ороомог хоорондын хөндий шахах хоолойг чиглэн шилжинэ. Шахах хэмжээг гадаргаас хялбархан удирдах боломжтой. Уг төрлийн насосны

шавхагдсан устай хүрэлцдэг гидравлик хэсгүүдийн хийцэд ширэм, зэвэрдэггүй ган, резин ба тусгай инерт хуванцар материалаас PTFE хүртэлх олон төрлийн материал ашиглах нь элбэг. 12 В-ын хүчдэлтэй акумулятороос тэжээл авдаг загварууд ч бий. Шахах өндөр ойролцоогоор 50 - 80 м-т хүрнэ.

2.3.2.4 Гадаргын ба хаягдал усны дээж авах зориулалттай автомат дээж авагч

Автомат дээж авагч хаягдал ус цэвэрлэгээнээс гарах урсгалаас дээж авахад урт хугацааны туршид маш сайн үр дүнтэй болох нь гэрчлэгдсэн. Автомат дээж авагчийг ашиглах гол нөхцөл нь дээжлэгдэж буй зүйл дээж авах цэгт жигдхэн холилдсон байх явдал юм (шингэний гомогенжилт баталгаатай байх ёстой).

Хэрэв дээж авах тохиромжтой газар байхгүй бол төлөөллийн дээж авах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай ба эсрэг тохиолдолд хамгийн шилдэг дээж авагч төхөөрөмж ашигласан ч төлөөллийн дээжийг олж авахгүй. Ерөнхийдөө хоёр төрлийн автомат дээж авагчууд байдаг:

- зөөврийн дээж авагч (сөрөг даралтын соролт, перисталтик насос),
- суурин дээж авагч, зөөврийнхтэй зарчмын хувьд адил боловч байнга идэвхтэй хөргөгдөж байдаг.

Үүнээс гадна янз бүрийн зарчим дээр тулгуурласан, голдуу суурин системүүд олон байдгийн жишээг дурдвал: даралтат хоолойноос дээж авах, гинжит насос, урсгалын салаанууд, шахагдсан агаарын тусламжтайгаар шахах г.м. Практикт ихэвчлэн сөрөг даралтын систем болон перисталтик насос ашиглагддаг.

Гэвч эдгээр зарчмуудын нэг нь ч дэгдэмхий органик бодисын шинжилгээний зорилгоор найдвартай дээж авах боломжгүй.

Үүнээс гадна, шийдвэр гаргахдаа сорох хоолойн диаметр (9 эсвэл 12 мм) ба дээжлэгдэж буй шингэний хамгийн багадаа 0,5 м/с байх ёстой орох хурдыг хязгаарлахад анхаарвал зохино.

2.3.2.5 Тогтвортой суурилагдсан дээжлэгч техник

Объектын дотор эсвэл дэргэд бат бөх суурилуулсан **шахуургын тоног төхөөрөмж бүрийг** тогтвортой суурилуулалт гэж үзнэ.

Дээжлэгч техникийг объектын дотор суурилуулахын утга учир нь дээж авагчийн, эсвэл объект дахь дээжлэгч төхөөрөмжтэй харьцах аргаас үүдэх эрсдлийг арилгах, мөн дээж авахын өмнө дээж авагдаж буй объектын бохирдох эрсдлийг бууруулах дээжлэлтийн өөрчлөгдөшгүй геометрыг бүрдүүлэхэд оршино.

Тогтвортой суурилагдсан дээжлэгч техник заавал дээж авагдаж буй объект дотор суурилагдах шаардлагагүй (ж.нь: цооног). Хоолойд байрлаж, цооногийн толгой хэсэгт байрлах хавхлагуудын системээс хялбархан нэвтрэх боломжтой гадарга, цооног дахь урсгалын дээж авагч хэлбэрээр байж болно.

Тогтвортой суурилагдсан техникийг салган буулгадаг ба салган буулгаддаггүй (ж.нь: цооногт цементсэн) гэж ангилна.

2.3.2.6 Пассив диффузын дээж авагч

Цооног, усны урсгал, усан санд урт хугацааны туршид суурилагдан байх дээжлэгч төхөөрөмжүүд юм. Голчлон энгийн, цэгэн дээж авах зориулалттай бусад бүх төрлийн дээжлэгч төхөөрөмжүүдээс пассив дээж авагч нь цаг хугацааны хувьд нэгдмэл дээжүүдийг буюу дээж авагчийн байх экспозицийн хугацаанд усан дахь дээжлэгдэж буй аналитуудын дундаж концентрацийг харгалзах хугацааны хамт олгодгоороо онцлог. Энэ талаас үзэхэд тун хэмжигч төхөөрөмж гэх нь илүү зөв юм.

Төхөөрөмжийн зарчим маш энгийн. „Дээжлэгдэж буй“ объект руу дотор нь ажиглах аналит диффузлэх дээж авагчийг (мэдрэмтгий бодис – тохиромжтой дамнуур дээрх сорбент) оруулна. Тогтоосон экспозицийн хугацааны дараа дээж авагчийг авч, сорбентыг шинжлэх ба усан дахь ажиглах аналитын агууламж гүний ус болон сорбент хоорондын мэдэгдэж буй хуваагч коэффициент дээр тулгуурлан тодорхойлогдоно.

Ажиглалтын аналитаас хамаарч янз бүрийн бодисыг сорбент болгон ашигладаг. Жишээлбэл, зарим эсэргүүцэл өндөртэй органик бодисын найрлагыг ажиглахад LDPE мембран дахь синтетик триолейныг, дэгдэмхий органик бодис ажиглах үед мөн LDPE мембран дахь дээд зэргийн цэвэр диминералжуулж, ди-ионжуулсан ус ашиглагддаг. Зарим анорганик аналитуудын ажиглалтад нүхжсэн керамик мембран дахь хатуу сорбентууд ашиглагддаг.

Дээр дурдсан зүйлүүдээс уг технологийн үндсэн хязгаарлалтууд урган гарч байна:

1. Ашиглагдсан дээж авагч нь зарим нэгэн аналитуудад л мэдрэг, ийм төрлийн дээжлэлт нь ажлын судалгааны түвшинд ашиглагдах ёсгүй.
2. Экспозицийн тулд урт хугацааны интервал (хэдэн өдрөөс зуун өдөр хүртэл) шаардлагатай, дээж авагчийг концентрацийн өөрчлөлтөд шаардлагатай хариу үйлдлийг хурдан үзүүлсэн тохиолдолд ашиглаж болохгүй.
3. Дээж авагч нь аналитын хором зуурын хамгийн дээд концентрацийг тэмдэглэн авдаггүй, зөвхөн урт хугацааны экспозиц чухал (цаг хугацаанд харгалзах дундаж концентраци). Энэ нь ажиглагдаж буй аналит тодорхой хугацаанд их хэмжээгээр хэлбэлзэж байвал дээж авагчийн тухайн бохирдуулагчийг тодорхойлох үр дүн бохирдолтой холбогдох эрсдлийн бодит хэмжээтэй тохирох албагүй гэсэн үг.

2.4 Хийнээс дээж авах дээжлэлтийн төхөөрөмж

Агаар болон хийнээс дээж авахад хийн дээжийг (хий, уур, аэросол, тоосонцрын ширхэгүүд г.м) аналитик туршилт хийх боломжтой болгож хувиргах хэрэгтэй. Дээж авах, дээжийг дараагийн хэмжилтийн алхамд бэлтгэх дараах үндсэн аргууд байдаг:

1. хийг дээжийн саванд авах (ж.нь: хуванцар уут, дээжийн шилэн сав,канистрт),
2. колекторт ажиглах аналитыг барих.

2.4.1 Хийг дээжийн саванд авах

Хийн дээжийг дээжийн саванд авах нь авсан дээжийн анализыг ердийн аналитик аргаар гүйцэтгэдэг дээжлэлт хийх уламжлалт арга юм. Хийн дээжийг вакуум, тохирох сөрөг даралт эсвэл гар шахуургын тусламжтайгаар дээжийн саванд шахан авч лабораторын шинжилгээнд тээвэрлэнэ. Уг дээжлэлтийн аргын давуу тал нь маш нарийн төвөгтэй

шинжилгээний аргуудыг гүйцэтгэх, цаашлаад шинжлэгдэх үзүүлэлтийн лабораторт сонгон шийдэх, өөр технологиор авах боломжгүй өргөн хүрээний үзүүлэлтүүдийг шинжлэх боломж зэрэг болно (ж.нь: сорбентод г.м).

Сул талууд нь: хурсан хийний хязгаарлагдмал эзэлхүүн, цаашлаад дээж авсан хугацаанаас лабораторит дээж боловсруулах хүртэлх хугацаа харьцангуй богино, агуулах савнаас алдагдах, өөрөөр хэлбэл аналит дээжийн савны ханаар нэвтрэн гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зэрэг.

2.4.1.1 Хуванцар дээжлэгч уут („air bag“, „gas sample bag“)

Хий хадгалах зориулалттай хамгийн түгээмэл дээжийн сав бөгөөд маш бага шингээх, нэвтрүүлэх чанартай инерт материалаар (ж.нь: TEDLAR®, TEFLON®, TEDLAR® металл ялтасаар хучигдсан) хийгддэг. Уут хийн насос эсвэл шахуургын тусламжтайгаар дүүргэгддэг. Хэрэглэхийн өмнө уут гэмтэлгүй эсвэл өмнөх дээжээс бохирдсон эсэхийг шалгаж үзвэл зохино. Хаалт, түүний ойр орчмын жийрэг нь хамгийн эрсдэлтэй хэсгүүд болно. Уутыг цэвэр агаараар нэвт үлээж бохирдолгүйжүүлнэ.

Хуванцар уутны ханан дээрх ажиглагдах нэгдлийн нэвчилт ноцтой асуудал юм. Түүний шийдэл нь дээжийг агуулах саванд хадгалах зөвшөөрөгдөх дээд хугацааг баримтлахад оршино. (Эдгээр мэдээллийг голдуу үйлдвэрлэгч тал мэдэгддэг.).

2.4.1.2 Шилэн дээжлэгч сав („glass bulb”)

Шилэн дээжлэгч сав нь хоёр төгсгөлдөө тариурын тусламжтайгаар дээжлэгдсэн агаарыг дүүргэх хананцар бүхий тагтай цилиндр сав юм. Хэрэглэхийн өмнө дээжийн савыг урьдчилан соруулсан байна (вакуум орчин үүснэ). Дээж авах өөр нэгэн арга бол дээжийн савны нэг төгсгөлийг зондод, нөгөө төгсгөлийг насост холбох арга юм. Дээж дээжийн саванд сорогдон орж авсан хийгээр дүүрсний дараа хоёр төгсгөл нь хаагдана.Уг дээж авагчийн давуу тал ажиглах нэгдлүүдийн шилэн хананд шингэх шингэлт маш бага байдагт, бас түүний хялбар хэрэглээнд оршино. Сул тал нь эвдэрч гэмтэх, хий хавхлагаар дамжин алдагдах эрсдэл болно. Дээж хадгалах хамгийн дээд хугацаа 24 цаг.

2.4.1.3 Тариур

Тариурыг талбайн хэмжилтийн үеэр дүн шинжилгээний зорилгоор дээж авахад ашиглаж болно. Тариурууд нь янз бүрийн эзэлхүүнтэй, шинжилгээний шаардлагаас хамаарч янз бүрийн материалаар хийгдсэн байдаг. Амархан сольж цэвэрлэх боломжтой. Гэвч дээж хадгалах хугацаа дээж алдагдах эрсдэл болон ханын нэвчилтээс шалтгаалан маш богино (хамгийн ихдээ нэг минут) байдаг. Дараагийн нэг эрсдэл бол нэгдэл гадагш алдагдах эсвэл атмосферийн агаар сорогдож болохуйц бүлүүрийн нягт бус байдал юм.

2.4.1.4 Зэвэрдэггүй ган канистр

Хийн дээж хадгалах зориулалттай дээжийн сав юм. Канистрыг тусгай шахуургын системээр дүүргэх эсвэл канистр дахь агаарыг урьчилан соруулах (вакуум орчин үүснэ) ба хавхлагыг нээснээр түүнд хий сорогдон ордог. Канистрыг бохирдолгүйжүүлэлтийн чанарыг шалгах лабораторит бохирдолгүйжүүлнэ. Дээжийн шинжилгээнд орох хүртэл канистрт хадгалагдаж болох хугацаа 14 хоног.

Мөн түүнчлэн, бага концентрацитай дэгдэмхий органик бодисын шинжилгээнд ч канистр ашиглах нь тохиромжтой (чанарын ба тоон үзүүлэлтийг тогтоох).

Канистр ашигласны давуу тал нь дээжийг удаан хугацаагаар хадгалахад (бусад аргуудтай харьцуулахад) оршино, өөрөөр хэлбэл дээж савнаас алдагдах аюул маш бага. Хамгийн чухал давуу тал бол нарийн төвөгтэй шинжилгээг лабораторит гүйцэтгэх боломж юм.

2.4.1.5 Туслах тоноглолууд

Хийн дээж авах зорилгоор дээжийн сав ашиглахдаа насос, шахуургын төхөөрөмж, эсвэл гар шахуурга зэргийн тусламжтайгаар - идэвхтэй дээж авах аргуудыг хэрэгжүүлдэг.

Ийм зорилгод тохиромжтой төхөөрөмжүүд нь өөрсдийн ажиллагааны зарчмаар хийн хими, физикийн аль ч найрлагад нөлөөлөхгүй, гол төлөв дээжлэгч агуулах савны үйлдвэрлэгчийн зүгээс санал болгон зөвлөсөн төхөөрөмжүүд байна. Төхөөрөмж тохируулж болохуйц тогтвортой урсгалаар хийг шахах боломжийг олгох ёстой. Зэвэрдэггүй ган канистр дүүрсэн тохиолдолд шахагч төхөөрөмж канистрт хаагдсан хийн эзэлхүүнийг илтгэх зориулалттай даралт хэмжигчтэй байна.

2.4.2 Колекторт ажиглах үзүүлэлтүүдийг барих

Агаар ба хийн дээж авах идэвхтэй аргууд нь хурж буй хийг барих тохиромжтой колектороор дамжуулан дээж авах өргөн боломжуудыг ашигладаг. Колектор нь хатуу, шингэн аль ч байж болно. Агаарт агуулагдах хэсгүүдийг (саатуулагдсан хэсгүүд, тоосонцрын хэсгүүд г.м) авах төхөөрөмжүүд тусдаа бүлэг болно.

Хатуу сорбентууд нь хорт бодисын хяналт, ажилчдын экспозиц хэмжилт, ажиллах орчны бохирдлын хэмжилт эсвэл амтогеохимийн хэмжилтийн үеэр агаарт агуулагдах хорт бодисуудыг тодорхойлоход маш өргөн хэрэглэгддэг, түгээмэл аргуудын нэг юм. Тэдгээрийн аналитыг сорбентоор барих давуу талаас үүдэн түгээмэл хэрэглэгдэх болсон. Энэ нь харьцангуй урт хугацааны баталгаатай, хэрэглэхэд хялбар, ажиглах бодисуудын бүлэгт хэрэгжүүлэх өргөн боломжтой колектор юм. Сорбент хоолой дотор хоёр тусдаа ховилд байрлана – нэг дэх нь бодисыг барихад, хоёр дахь нь түүний ард, хийн хоолойгоор дамжих чиглэлд байрлах ба эхний камер дахь сорбентын багтаамж хэтэрч „шүүлтүүрийг цоолсон“ (шүүлтүүрийн багтаамж хэтэрсэн) эсэхийг хянахад зориулагдсан.

Сорбентууд ихэвчлэн шилэн хоолойнуудад хадгалагддаг. Шаардагдаж буй тодорхойлох арга, хийн дэх бодисын концентраци зэргийн дагуу янз бүрийн хэмжээний сорбентуудтай хоолойнуудыг нийлүүлдэг.

Шинжилгээний шаардлагад тохирох сорбентын төрлийн сонголт ажиглагдах бодисоос хамаарна. Дээж авах арга нь (сорбентоор сорох хугацаа, хийн сорогдох урсгал, хэмжилт зохион байгуулах, хадгалах хугацаа г.м) зохих аналитик аргын хамт стандартжуулсан журамд (ж.нь: NIOSH Manual of Analytical Methods) бий.

Хамгийн түгээмэл хэрэглэгддэг сорбентуудад:

- идэвхтэй нүүрс ба бусад нүүрсэн сорбентууд,
- силикагель,

- полимер сорбентууд.

Сорбентуудын тойм ба тэдгээрийн нэгдэл тус бүрт зориулагдах хэрэглээний тухай уг МР-ын хавсралт хэсгийн 4-р хүснэгтэд бий.

2.4.2.1 Шингэн сорбентууд

Шингэн сорбентууд хийг угаах (буюу impingery) төхөөрөмжтэй хослон хэрэглэгддэг. Хий шингэн сорбентуудаар дамжин өнгөрөхдөө сорбентуудад баригдаж дараа нь шинжлэгддэг.

Харьцангуй цөөн тооны аналитик аргууд ялангуяа ажиглах бодисоос хамаарсан маш нарийн сонголт, хадгалалтын богино хугацаа зэргээс шалтгаалж хий барих иймт өрлийн хэлбэрийг ашигладаг.

2.4.2.2 Тоосонцрын хэсгүүдийг барих

Дээжлэгдэж буй хийн хэсгүүд голдуу хуурай шүүлтүүрийн аргаар баригддаг. Янз бүрийн шүүлтүүр материал ашиглан барих нь хамгийн түгээмэл: шилэн ба цахирын микро ширхлэг, органик микро ислэг, целюлозын эфир, PVC, тефлон г.м. Хэсгүүд нь хууль тогтоомжоор шаардагдах хэмжээний фракцын дагуу ($PM_{2,5}$, PM_{10}, амьсгалагдах хэсгүүд) тодорхойлсон нүхний хэмжээтэй циклон, шатласан бутлуур, полиуретан шүүлтүүрүүдийн тусламжтайгаар г.м хуваагдана.

2.4.2.3 Туслах төхөөрөмжүүд

Шинжлэгдэж буй хийн дээжийг авахад харгалзах колекторт насос ашиглах шаардлагатай болдог.

Насос нь ашиглагдаж буй колекторын төрөл, хэмжилтийн эсвэл сорогдсон хийн эзэлхүүнд тавих лабораторийн шаардлагад нийцсэн янз бүрийн хүчин чадалтай байж болно. Насос олон янзын хийцтэй байдгаас мембранан, ламелан насосууд, эргэгч бүлүүртэй насосууд зэрэг нь хамгийн түгээмэл ашиглагддаг.

Дээж авагдах зам дахь тогтворгүй даралтын үед ч тогтмол урсгалаар хангах, хэмжилтийн хугацааг тэмдэглэх боломжтой, эсвэл дээж авах горимыг программчлах тохируулга бүхий насосууд хийн дээжлэлтэд тохиромжтой.

Эдгээр насосуудыг ашиглахад зайлшгүй шаардлагатай нөхцөл нь насосын урсацын тохируулга. Авсан хийн эзэлхүүний найдвартай хэмжилт нь хийд агуулагдах хорт бодисын концентрацийг (шингэсэн хорт бодисын хэмжээ сорогдсон хийн эзэлхүүнээс хамаарна) тодорхойлоход тавигдах үндсэн шаардлага юм.

3. Дээж авах аргууд – ангилал

3.1 Дээжийн төрлүүд

Дээжийг үндсэн хоёр төрөлд ангилна:

- энгийн (цэгэн),
- холимог.

Эдгээр бүлгүүдийн ялгаа **энгийн дээжүүд орон зай, цаг хугацаанд тодорхойлогдох тодорхой нэг цэгт** ажиглагдах шинж чанаруудыг төлөөлдөг бол **холимог дээжүүд** ажиглагдах шинж чанаруудыг дан орон зайд эсвэл цаг хугацаанд **дундажлан** төлөөлдөгт оршино. Заримдаа холимог дээжүүд цаг хугацаа эсвэл орон зайн хувьд нэгдмэл хэмээн тэмдэглэгддэг. Уг хоёр бүлэг хоёулаа тусгай ашиглалттай.

Энгийн дээжүүд

Энгийн дээжүүд дээжлэлтийн зорилго нь орчны ажиглагдах аналитын орон зайн тархац эсвэл түүний концентрацийн цаг хугацааны хөгжлийг үнэлэх тохиолдолд орлуулшгүй чухал. Гүний усны дээжийн хувьд, энгийн дээжүүд орчинтойгоо гидрогеохимийн тэнцвэрт байх ёстой ба тэдгээрийг тухайлбал байгалийн тархалтын өрнөж буй үйл явцын тэмдэглэлд ашиглаж болно.

Холимог дээжүүд

Холимог дээжүүд ажиглагдах шинж чанарын утгуудын тогтмол хяналтын үед үндэслэлтэй. Холимог дээжүүдийг ашиглах ямар ч тохиолдолд тэдгээрийн зарим нэгэн хязгаарлалтуудыг анхаарч үзвэл зохино.

Хэрэв салангид дээж бүрийг хамтад нь нэгтгэвэл аналитын концентраци уусах, авсан дээжүүдийн тоо цөөрөхөд хүрнэ. Зөвхөн уусахад ч бус, харин холимог дээжийн бүрдсэн дэд дээжүүдийн нийт тоонд тэцүү дэд дээж бүрт тодорхойлогдох хязгаар өсөхөд хүрнэ.

Ж.нь: Хэрэв дээж авах төлөвлөгөөнд хоёр тусдаа дээжийг нэг авах шаардлагатай байвал ажиглагдах үзүүлэлтэд шаардлагатай тодорхойлогдох хязгаар 330 ppb (энэ нь: parts per billion, 10^{-9}) байх ба холимог дээжин дэх уг үзүүлэлтийн тодорхойлогдох хязгаар өөрчлөгдөхгүй.

Холимог дээжийг бүрдүүлж буй дэд дээж тус бүрт ажиглагдах үзүүлэлтийн тодорхойлогдох хязгаар **ердийн тодорхойлогдох хязгаараас хоёр дахин их** буюу 2 x 330 = 660 ppb байна.

Үүнийг анхаарч үзэх нь чухал, яагаад гэвэл, хэрэв ажиглагдах үзүүлэлт 330 - 660 ppb хооронд концентрацитай дэд дээжүүдийн зөвхөн нэгэнд нь байвал эцсийн холимог дээжинд уг үзүүлэлтийн агууламж тодорхойлогдох албагүй юм. Холимог дээжинд бохирдол илэрсэн тохиолдолд дэд дээж тус бүрийг бодит бохирдлын тархалтыг илрүүлэх зорилгоор шинжлэх шаардлагатай.

Үүнээс гадна, дээжүүдийг янз бүрийн химийн найрлагатай холих үед шинжилж буй дээжийн (саармагжилт, туналт г.м) найрлагыг үндсээр нь өөрчилж болохуйц үр дагаварт хүргэх, эсвэл ажилтнуудын эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй. Иймээс үргэлж анхаарч ажиллах нь чухал.

Холимог дээжүүдийн бэлтгэлд (тэдгээрийн гомогенжилт) дээд зэргийн анхаарал тавьж ажиллах нь зүйтэй. Нунтаг дээжийн хувьд, квартац эсвэл ховилт (фермэн) хуваарилагч ашиглахыг зөвлөдөг. Зууралдсан материалын холимог дээжийн бэлтгэлийг хээрийн нөхцөлд гүйцэтгэх маш хэцүү. Хэрэв лаборатори тохирох гомогенжүүлэгчээр тоноглогдсон бол ийм дээжийг авч болох ба тохиролцсоны дараа засах ажлыг лабораторит гүйцэтгэж болно.

Холимог дээжийг нэмэх үеэр авсан дээжийн чадамжид бүрэн нөлөөлж болохуйц химийн реакцид хүрч болно. Үүний нэгэн жишээ: дээж саармагжиж болзошгүй тогтмол бус pH утгатай хаягдал усны гоожилт байж болно. Холимог дээжүүд нь дэгдэмхий органик бодисын дараагийн шинжилгээнд огт тохиромжгүй.

3.2 Матрицын төрлүүд

Нөхөн сэргээх ажлын үеэр гол төлөв шинжилгээний өмнөх дээж авах боломж ба дээжийн засварт ихээхэн нөлөөлдөг янз бүрийн физикийн шинж чанартай матрицуудыг дээжилдэг. Ерөнхийдөө дараах бүлгүүдэд хуваана:

- хатуу (бат бөх) ба хагас хатуу,
- шингэн, олон фазын хамт,
- хийн, олон фазын хамт (хий).

Хатуу ба хагас хатуу

Эдгээр матрицуудын дунд ширхэгийн материалын дээжүүд (хатуу фазын), ж.нь: хад чулуу, барилгын хийц, цаашлаад хөрс, нунтаг болон зуурмаг (ж.нь: шавар, тунадасууд) материалуудыг оруулж болно.

Хатуу ба хагас хатуу материалуудын дээж авах асуудлаар үр дүнг дүгнэхэд хамгийн ихээр алдаа гардаг дараах тохиолдлууд бий:

- дэгдэмхий бодис тодорхойлох дээж авах,
- хэмжээний хувьд ялгаатай хэсгүүд бүхий матрицын дээж авах (ж.нь: барилгын хаягдал, хайргархаг элс г.м),
- дээжийн масштаб хэмжээн дэх материалын гетерогенжилт,
- наалдамхай ба зуурмаг материалын дээж авах.

Эдгээр тохиолдлууд III.2 ба III.3 бүлэгт шийдвэрлэгдсэн болно.

Ажиглаж буй матриц дахь бохирдлын тархалтыг дүгнэх зорилгоор ерөнхийдөө энгийн дээж авахыг зөвлөдөг, өөрөөр хэлбэл холимог дээжүүд гетероген материалын шинж чанарын бодит тархалтыг гажуудуулж болзошгүй.

Холимог дээжүүдийг ихэвчлэн хаягдал тодорхойлоход, жишээлбэл тэдгээрийн дараагийн тээвэрлэлтийг тогтоох зорилгоор ашигладаг. Хэрэв аль хэдийн авсан дээжүүдээс холимог дээж бүрдүүлэхээр бол холимог дээж бэлтгэх ажлыг лабораторит (хэрэв үүнд шаардлагатайгаар тоноглогдсон бол) энгийн дээж зассаны дараа гүйцэтгэхийг зөвлөдөг. Ийм бэлтгэлийн үеэр дээж халж, улмаар дэгдэмхий ба хагас дэгдэмхий аналитууд алдагдахад хүрч болохыг анхаарвал зохино.

Хатуу ба хагас хатуу материалын дээж авах үеэр, дээжийн саванд дээж хийхийн өмнө дэгдэмхий бус органик ба анорганик бодисыг тодорхойлох дээжийн бүрэн гомогенжилт нэн чухал. Хэрэв конзистенци ба дээжийн найрлагын ширхэглэг хээрийн нөхцөлд гомогенжилт үүсгэхгүй байвал лабораторит туршилт эхлэхийн өмнө гүйцэтгэх шаардлагатай.

Шингэн, олон фазын хамт

Нэг фазын шингэний дээжлэлт голдуу ноцтой асуудал үүсгэдэггүй. Харин дараах тохиолдлуудад онцгой анхаарвал зохино:

1. дэгдэмхий бодис, ууссан хий тодорхойлох дээж авахад (авах арга ба ашигласан дээжлэгч тоноглолууд, дээжийн сав ба дээжийн тээвэрлэлт зэрэг нь туршилтын буруу үр дүнд хүргэж болзошгүй),
2. дээж авах үеэр дээжтэй хүрэлцэх бүхий л тоноглолын цэвэр цэмцгэр байдалд (усан дээжүүд дэх бодисын ерөнхий агууламж бага байдгийг харгалзан үзвэл),
3. дээж хадгалах нөхцөл ба хугацаанд (тэдгээрийг үргэлж лабораторийнхонтой зөвлөж, ягштал баримтлах).

Гүний усны хувьд, дээжийг түүнд ямар ч хатуу фазууд байхгүй байхаар авна.

Хэрэв ингэхэд хүрвэл, ийм тохиолдолд дээжийн засвар ба шинжилгээний алхмуудыг олон субъектын үр дүнгүүд харилцан жишигдэж болохуйц байхаар тохиролцох нь зүйтэй.

Хий, олон фазын хамт (агаарын масс)

Агаар ба хийн хэмжилтийг гүйцэтгэх нь нэн төвөгтэй мэргэжлийн салбар бөгөөд хэмжилтийн үр дүнд дээж авахад ашиглагдсан арга, аналитик туршилт ихээхэн нөлөөлж болно. Эдгээр шалтгааны улмаас (бусад матрицын дээж авахаас ялгаатай нь) дээж авах аргууд, агаарын ба хийн хэмжилт зэрэг нь хамгийн нарийн боловсруулагдсан бөгөөд хийх алхмууд ба аналитик төгсгөлийн хамт ашиглагдах материалын тэмдэглэлүүд нь стандартчлагдаж норм, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага (NIOSH, OSHA, U.S. EPA) журам, эсвэл хууль тогтоомжийн хэлбэрээр боловсрогдсон байдаг.

Эдгээр шалтгааны улмаас агаар ба хийн дээж авах үеэр хамгийн чухал бөгөөд шаардагдаж буй чанарын үр дүнг олж авахад хамгийн эрсдэлтэй элемэнтүүдэд дараах зүйлүүд орно:

- хийн дээж барих болон аналитик туршилтын оновчтой аргыг сонгох,
- техник тоног төхөөрөмжөөр хангах, чанарын хяналт.

3.3 Ажиглах үзүүлэлтүүд

Ажиглах үзүүлэлтүүдийн хүрээ химийн үндсэн үзүүлэлтүүдээс бусад бохирдуулагч бодисын шинж чанараас үүдэлтэй. Эдгээр үзүүлэлтүүдийг дараах бүлэгт ангилна.

- химийн үндсэн үзүүлэлтүүд,
- анорганик бохирдуулагчид,
- органик бохирдуулагчид (дан TOL ба POP, эсвэл PTS),
- микробиологийн үзүүлэлтүүд,
- экотоксицидүүд.

Дээж авах ба түүний дараах тэдгээрийн тээвэрлэлтээс үзэхэд дээр дурдсан зарим үзүүлэлтүүдэд өндөр анхаарал тавих шаардлагатай.

Жишээлбэл, гадаргын эсвэл гүний усанд ууссан хүчилтөрөгчийн концентрацийг ажиглах үеэр, дээжийн савыг дээжээр дүүргэхдээ савны ханаар урсгахгүй байхыг

зөвлөдөг. Хэмжилтийг зөөврийн шинжилгээний багажаар, газар дээр нь шууд хийж гүйцэтгэхийг зөвлөдөг. Түүнчлэн, ууссан нүүрсхүчлийн хий тодорхойлох ажлыг pH хэмжих, CO_2–оор ханасан усны дамжуулах чанар тодорхойлохтой адилаар, дээж авсны дараа шууд хийж гүйцэтгэнэ.

Сульфан, сульфид тогтооход дээжүүд хүчилтөрөгчийн химийн хэрэглээг (CHSK) тодорхойлох дээжүүдийн нэгэн адил нэн даруй тодорхойлогдсон байна.

Усан дээжин дэх металл (ууссан) тогтоох үеэр дээжийг авсан даруйд, хүчиллэгжүүлэлт болохоос нь өмнө 0,45µм нүхний хэмжээтэй шүүлтүүрээр шүүх зайлшгүй шаардлагатай. Шүүгдсэн даруй дээж харгалзах хүчлээр хүчиллэгжүүлсэн ёстой (лабораторийн зааврыг үз). Мөнгөн усыг тодорхойлоход хадгалах зорилгоор азотын хүчлээс гадна калийн бихроматын уусмалыг хэрэглэдэг.

Усны дээжүүдэд TOL тодорхойлох зорилгоор дээж авах үед агааржилт үүсч болохгүй. Авсан шингэн дээжийн савны ёроолд өргөтгөлөөр дамжин байх ба түүнийг цэвэрлэх ёстой.Энгийн тоног төхөөрөмжөөр TOL тодорхойлох холимог дээж бэлтгэх боломжгүй.

Хатуу матрицуудад TOL тодорхойлох зорилгоор дээж авахдаа дээд зэргийн анхаарал хандуулах ёстой ба тусгай журам, тоног төхөөрөмж ашиглана. Үүнээс гадна ойр орчмоос агшин зуур бохирдох боломжийг ажиглах ба лабораторитой нягт хамтран ажиллах нь зүйтэй.

Суурь утгуудад POP-г ажиглах нь төмрийн маш бага концентрацийг ажиглахтай адил ашиглаж буй дээжийн сав, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн цэвэр байдалд дээд зэргийн анхаарал хандуулах шаардлагатай мөр шинжилгээний салбарт хамаарагддаг. Ариун цэврийг мөн лабораторитой хамтран ажиллах хүрээнд тогтмол хянаж байх шаардлагтай.

Ашиглаж буй хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ариун цэвэртэй холбоо бүхий төсөөтэй асуудлууд микробиологийн үзүүлэлтүүдийг ажиглах салбарт орно.

Экотоксицидын хувьд, дээж авах ба тест бүрийн хооронд дээжийн тогтвортой байдалтай холбоотой асуудал хаяа үүсдэг. Энд бас лабораторитой ажиллах хамтын ажиллагаа болон дээжийн хадгалалт, нэн ялангуяа түүний хөргөлтөд тэдний зааврыг баримтлах нь хязгаргүй чухал.

3.4 Холбоост чулуулаг, барилгын хийц

Бэхжүүлсэн, хад чулуулаг ба барилгын хийц зэрэг бэхжүүлсэн холбоост материалуудын дээж авахад дээжийн гурван бүлгийг ялгаж үзнэ:

1. гадаргын дээж,
2. давхарга дундын (цавчим дээжүүд),
3. өрмийн чөмгөн дээж.

3.4.1 Төхөөрөмжийн сонголт

Тоног төхөөрөмжийн сонголт дээжийн зорилго ба авсан дээжийн төрлөөс хамаарна.

Гадаргын, гадарга дундын цавчмын дээж авахад геологийн алх,цүүц, эсвэл цахилгаан өрөмдлөгийн алх зэрэг ердийн гар багаж хэрэгслүүдийг ашиглаж болно. Чөмгөн дээж авахад тусгай тоноглол буюу төхөөрөмж шаардлагатай (ж.нь: өрөмдлөгийн систем).

Дээжлэлтийн бүх тохиолдлуудад дээжлэгдэж буй материал физик шинж чанарын алдагдалд ордог. Уг алдагдал нь дээжлэгдэж буй материалын харьцангуй гэмтэл багатай дээж олгодог чөмөглөгч өрмийн машины хувьд туйлын бага байдаг бөгөөд хамгийн их зэрэглэлийн гэмтэл цохиж авдаг ба цавчим дээжүүдэд тохиолддог. Ямар ч тохиолдолд дээжлэгдсэн материалын гадаргаас авах хоёрдогч бохирдлын эрсдэл бий.

Өөр нэгэн эрсдэл нь ялангуяа чөмгөн өрөмдлөгөөр дээж авах үед дээж халах үзэгдэл юм. Иймээс дэгдэмхий органик бохирдлыг (TOL) тогтооход төлөөллийн дээжийг тусад нь авах нь зөв.

3.4.2 Төхөөрөмжийн бэлтгэл

Төхөөрөмжийн дээжтэй хүрэлцэж буй бүхий л хэсгүүдийг боломжтой бол төгс бохирдолгүйжүүлэх хэрэгтэй. Үүнийг зөөврийн өрөмдлөгийн системд хийхэд хүндрэлтэй байдаг. Ядаж өрөмдлөгийн багаж ба чөмөглөгчийг тос болон бусад өрөмдлөгийн системийн технологийн шингэн зэрэг бохирдуулагчид хүргэлгүй салангид байлгаж, өрөмдлөгийн аюулгүй зайлагч (ундны ус) ашиглах нь зүйтэй.

3.4.3 Дээж авах

3.4.3.1 Цавчим дээж

Цавчим дээжийг гар багаж хэрэслийн тусламжтайгаар дээжлэгдэж буй материалын гадарга доорх гүнээс шууд авна. Дээж авах газарт шаардлагатай гүнд нүх ухах бөгөөд үүссэн хэлтэрхийнүүд нь уг материалын гэмтэлтэй дээжийг төлөөлнө. Хэрэв дээжлэгдэж буй материал жигд бүтэцтэй байвал цавчим нь үндсэндээ үе давхаргуудад перпендикуляр чиглэлтэй байна.

Дээж авах үеэр дэгдэмхий бодисууд алдагдах учир эдгээрийг тогтооход цавчим дээж нэн тохиромжгүй. Цавчмын дээжийн хувьд, ялангуяа гадаргын маш хүчтэй бохирдол бүхий барилгын хийцийн дээжлэлтийн үеэр дээжийн агшин зуур бохирдох эрсдэл маш өндөр юм.

3.4.3.2 Чөмгөн өрөмдлөг

Чөмгөн дээжүүд нь суурин эсвэл зөөврийн гар болон өрөмдлөгийн системийн машины тусламжтайгаар авагддаг. Өрөмдлөгийн нүхлэлтийн үеэр өрөмдөх багажтай харьцахдаа гадаргын, эсвэл чулуулгийн бэхжүүлээгүй гадарга дундын бохирдлоор бохирдуулахгүй байхыг анхаарвал зохино. Иймээс чөмөглөх ажлыг эхлүүлэхийн өмнө агааржуулалтын хучилтаар дайрах бүх хэсгийг найдвартай бэхлэх хэрэгтэй. Өрөмдөгч багажийн даралтыг чөмгийн хамгийн дээд бүтээмжээс хамаарч удирдана. Ундны усыг зайлагч болгон ашиглах нь зүйтэй. Өрөмдлөгийн уртыг ашигласан чөмөглөгчийн урт, литологи, чулуулгийн орчин дахь геологийн бүтцэд тохируулан өөрчлөх шаардлагатай.

Гарган авсан чөмгийг цэвэрхэн, уг зориулалтад тохирсон хайрцагт хадгалвал зохино. Баримтжуулалтын зорилгоор өрөмдлөг нэг бүрийг салангид байлгах нь зөв.

Дээжлэгдсэн материалын угаагдлын үеэр ашиглагдсан хэрэгсэлтэй шүргэлцэхэд хүрдэг. Иймээс дээжийг ашиглагдсан багажууд эсвэл машин тоног төхөөрөмжийн тосоор бохирдуулахгүй байхад анхаарвал зохино.

3.4.3.3 Баримтжуулалт

Бүрэн гүйцэт, найдвартай баримтжуулалт нь дээжлэлтийг дүгнэх боломжид тавигдах үндсэн нөхцөл юм. Холбоост материалын дээжийн хувьд, дээж авсан газар ба цэгийн нарийн байршлыг газрын зураг дээрх тэмдэглэл, ноорог эсвэл фото баримтжуулалт, нүх эсвэл өрмийн техникийн мэдээ (профиль, гүн г.м), авсан чөмгийн тухай тэмдэглэл (литологи, конзистенци, өнгө, бохирдлын илрэл г.м), ухсан огноо, өрөмдлөгт ашиглагдсан технологи, шаардлагатай бол чөмгийн фотобаримт.

3.5 Холбоосгүй чулуулгууд ба хөрс

3.5.1 Төхөөрөмжийн сонголт

Дээжлэгч төхөөрөмжийн сонголт дээжлэгдэж буй хөрсний төрөл ба ажиглагдаж буй аналитик үзүүлэлтүүдээр тодорхойлогддог.

Дээжлэгч төхөөрөмж дээжлэгдэж буй тухайн материалын төрөлд тохирсон хийцтэй байх ба материалын физик бүтцийг гэмтээлгүй, дээжийг шахаж эсвэл агааржуулалгүйгээр дээж авах нь зүйтэй.

Дээжлэгдэж буй объект дахь концентрацийн эсрэг учирч болох дээжийн аналитын агуулгын хамгийн эрсдэлт өөрчлөлт нь TOL тогтоох дээж авалтын үеэр үүсдэг.

Иймээс TOL тодорхойлох холбоосгүй материалын дээж авахад дээжийн савны оновчтой сонголт хамгийн чухал.

Хөрсний дээж авах зориулалттай түгээмэл дээжлэгч төхөөрөмжүүдэд:

- хүрз, халбага – дэгдэмхий органик бодис тодорхойлоход тохиромжгүй,
- гар өрөм - дэгдэмхий органик бодис тодорхойлоход тохиромжгүй,
- чөмөглөгч,
- хуваагдсан, халбага хэлбэрийн дээж авагч,
- гомогенжүүлэх тавиур эсвэл сав - дэгдэмхий органик бодис тодорхойлоход тохиромжгүй,
- хутгуур, хусуур - дэгдэмхий органик бодис тодорхойлоход тохиромжгүй.

Дээж авагчууд нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн байхыг зөвлөдөг. Өөр материалуудыг нөхцөлдүүлэн хүлээн зөвшөөрч болохч тэдгээрийн олон удаагийн хэрэглээ хязгаарлагдмал байж болно (ж.нь: дээж авагчийн материалд шингэсэн органик бодисыг бүрэн цэвэрлэж болохгүй байх).

3.5.2 Төхөөрөмжийн бэлтгэл

3.5.2.1 Бохирдолгүйжүүлэлт

Бүх тоног төхөөрөмжүүд талбайд хэрэглэгдэхийн өмнө ба тухайн байршил дээрх дээж авалт хооронд цэвэрлэгдэж байх ёстой. Тээвэрлэлтийн үед бохирдохоос сэргийлж гар дээж авагчууд ба дээж авах хэрэгслүүдийг бохирдолгүйжүүлэлтийн дараа хуванцар боодолд хадгалах нь тохиромжтой. Бохирдолгүйжүүлэлтийн журам нь дээжлэгч

төхөөрөмжийн хэмжилтийн үр дүнд үзүүлэх нөлөө шийдвэрлэж буй төслийн хүрээнд тохиролцсон түвшнээс хэтрэхгүй байхаар үр дүнтэй байна.

3.5.3 Баримтжуулалт, дээжийн тэмдэглэгээ

Дээж авсан тухай баримтжуулалт ба дээжийн тэмдэглэл нь дээжлэлтийн ажлын салшгүй хэсэг болно. Чанартай боловсруулсан, агуулгын хувьд бүрэн баримтжуулалт нь хэмжсэн үр дүнгүүдийг найдвартай төлөөлөх нөхцөл юм. Дээжийн макроскопын тэмдэглэлд бэхжүүлээгүй матрицын дээж авах үеэр, ялангуяа ширхэглэгийн бүтцэд тулгуурласан ангиллыг ашиглавал тохиромжтой. Ангилалд зориулагдсан хэд хэдэн систем байдаг (геотехникийн, педологийн, литологийн) ба ашиглагддаг (судалгааны ажлын чиглэлээс хамааруулсан).

Үндсэн ширхэглэгийн фракцууд нь **хайрга, элс, тоос ба шавар**.

Ширхэглэгийн бүтэц ба хэсгүүдийн хэлбэрээс гадна бэхжүүлээгүй дээжүүдийн тэмдэглэл өнгөний тодорхойлолт, бүтэц, чийгшил, макроскопын эсвэл бохирдлын мэдрэг шинж тэмдэг зэргийг агуулах ёстой.

Хатуу өөрөө хэлбэл бэхжүүлсэн чулуулгийн дээжүүдэд ердийн петрологийн дүн ангилал ашигладаг.

3.5.4 Дээж авах цэгийн байршил ба гүнийг тодорхойлох

Дээж авах газар ба цэгийг дээж авах төлөвлөгөөнд үргэлж тусгах ба уг газар дээрх урьд өмнө хийгдэж байсан ажлын (ж.нь: геофизикийн судалгаа) үр дүнгээс шалтгаалан төлөвлөгдсөн байвал зохино. Газар дээрх тодорхой нөхцлүүд нь цэгийн бодит ба дээж авах төлөвлөгөөнд тусгагдсан байрлалыг өөрчлөхөд хүрч болно (ж.нь: газар доорхи инженерийн шугам сүлжээний илрэлээс үүдсэн). Ингэсэн тохиолдолд төслийн хариуцлагатай шийдвэрлэгч талд мэдэгдэж, түүнтэй дээж авах газрын байршлын өөрчлөлтийг авч хэлэлцнэ. **Дээж авах төлөвлөгөөний эсрэг өөрчлөлтийг дээжийн баримтжуулалтад үргэлж тэмдэглэх шаардлагатай.**

3.5.5 Дээж авах журам

Ерөнхий зарчим:

- бохирдлын талбайн эсвэл орон зайн хязгаарлалтыг тодорхойлох үед гол төлөв тухайн цэгт, тухайн цагт бохирдлыг илэрхийлэх энгийн цэгэн дээж авна,
- холимог дээж ерөнхийдөө ашигладаггүй (хаягдал шинжлэх зорилгоор дээж авах тохиолдлоос бусад),
- дээж авалтыг ерөнхийдөө бага бохирдолтой газраас их бохирдолтой газар руу хийж гүйцэтгэнэ,
- хамгаалалтын бээлийгээр дээжинд аль болох бага хүрнэ,
- дээжийн хамгийн багадаа талыг нь нэмэлт шинжилгээ, хяналт г.м шаардлага гарсан тохиолдлуудад зориулан архивлана,
- дээжийг (дэгдэмхий органик бодис тодорхойлох дээжээс бусад) хэрэв боломжтой бол, талбайд дээжийн савand хийхээс өмнө гомогенжүүлсэн байна!!
- Дэгдэмхий бодис тодорхойлох зориулалттай дээжүүдийг дээжийн савнаас матрицыг

авсан даруй авах ёстой.

3.5.5.1 Гадаргын дээж авах журам

- дээж авахын өмнө дээжлэгдэж буй талбайгаас судалж буй хөрснөөс бусад - ж.нь: ургамлын бүрхэц, чулуу г.м - бүхий л хэрэггүй материалуудыг арилгана,
- гадаргын дээж 0 - 15 см гүний интервалд авагддаг. Тодорхойлоход шаардлагатай төрлийн дагуу тохирох дээж авагчийг сонгоно (дээжлэгч хүрз, чөмөглөгч г.м),
- дэгдэмхий бус материал тодорхойлох дээжийг хэрэв лабораторитой өөрөөр тохиролцоогүй бол талбай дээр дээжийн саванд хийхийн өмнө гомогенжүүлнэ,
- дээжийн гэмтлийг багасгах шаардлагын дагуу тохиромжтой саванд дээжийг хийж (хадгалах, тогтворжуулах г.м) лабораторит хүргэж ирнэ.

3.5.5.2 Гадаргын доорх дээж авах журам

Гадаргын доорх дээжийг стандарт өрөмдлөгөөр эсвэл урьдчилан тохируулсан дээжлэгч төхөөрөмжтэй өрмийн багажаар зоон авч болно.

Дээж авах журам дараах алхмуудын дагуу үргэлжилнэ:

- тохиромжтой тоног төхөөрөмжийн тусламжтайгаар шаардагдах түвшин хүртэл нүх нүхлэнэ (өрөмдөгч систем, гар өрөмдлөг г.м),
- тохиромжтой тоног төхөөрөмжийн тусламжтайгаар дээж авах (гэмтэлтэй авсан дээж ба гэмтэлгүй авсан дээж). (Дээж авах төлөвлөгөөнд өөрөөр тусгаагүй бол, цэгэн дээжүүдийг 15 см-ын дээжийн алхамтайгаар авна),
- нүхнээс дээж авагчийг сугалан авна. Хэрэв төхөөрөмжөөс дээжийн хэсэг салж унавал түүнийг дээж болгон ашиглаж болохгүй. Өрөмдлөгийн профилийг шалгах нь чухал. Цооногт гадаргаас эсвэл цооногийн хананаас материал унасан эсэхийг шалгах шаардлагатай. Түүнийг дээжээс арилгавал зохино (ж.нь: гадаргаас нүх рүү унасан асфальтын үлдэгдлүүд),
- дэгдэмхий бус нэгдэл тодорхойлох дээжүүдийг хэрэв лабораторитой өөрөөр тохиролцоогүй дээжийн саванд хийхийн өмнө талбай дээр гомогенжүүлнэ,
- дээжийн гэмтлийг багасгах шаардлагын дагуу тохиромжтой саванд дээжийг хийж (хадгалах, тогтворжуулах г.м) лабораторит хүргэж ирнэ.

Дээжүүдийг авч, тэдгээрийг аюулгүй болгосны дараа цооногийг гүний ус руу бохирдол тараах газар болгохгүйн тулд буцааж битүүлэн нягтруулах ёстой.

3.5.6 Дэгдэмхий органик бодис тогтоох дээж авах

3.5.6.1 Дэгдэмхий органик бодис тогтоох зорилгоор хөрсний дээж авах технологи

Дэгдэмхий органик бодис тогтоох хөрсний дээжүүдийг дэгдэмхий органик бодис урсаж эсвэл биологийн задралаар алдагдахыг хязгаарлахын тулд чулуулгийн орчноос гарган авсны дараа шууд (хэдхэн минутанд) авах ёстой.

Дэгдэмхий органик бодис тогтоохоор дээж авах үеийн критик цэгүүд:

- аналитик шат,

- дээж хадгалах талбайнн арга,
- дээжийн сав,
- дээж авалт ба боловсруулалт хоорондын хугацаа.

Дээжүүдийг үргэлж чанарын хяналтанд зориулан бэлтгэх нь чухал. Тэдгээрийн хэмжээг арга, лаборатори ба хариуцлагатай шийдвэрлэгч сонгоно. Дээж авах, дээжтэй харьцах үеэр дараах зүйлүүдээс зайлсхийнэ:

- дээж авагчид дээж авагчуудын төрөл тус бүрт их дунджаар тодорхойлсон хугацаанаас гадна дээж хадгалах,
- гууль, ацетат, поликарбонатуудаар хийгдсэн хоолойт дээж авагчид дээж хадгалах,
- дээжийг тохиромжгүй дээж авагчид тээвэрлэх ёсгүй – том хөндий зайтай дээжлэгч лонх,хуванцар/гялгар уут, хөнгөн цагаан уут, тор гэх мэт.

Журам:

1. дээжлэлтийн интервалыг тогтоох,
2. элэгдсэн эсвэл механик гэмтэл авсан чөмгийг устгах (дэгдэмхий бодис ууршихмагадлал) - ж.нь: хусуурын тусламжтай,
3. хоолойт дээж авагчийн тусламжтайгаар дээж авах (аналитик үе шатаар тодорхойлогдсон хэмжээг авах) дээжийн савны – дээж ба дээжийн савны бүлүүр хооронд хийтэй бөмбөлөг байх ёсгүй!!! Матрицын төрөл, материалын чийгшил, ширхэглэг зэрэг нь дээж авагчийн матрицад зоогдох чиглэлийг – эгц, налуу, олон удаагийн зоолт (шаардлагатай хэмжээний дээж авахын тулд) сонгох нөхцөл болно,
4. дээж авагчийн гадна талыг цэвэрлэж илүү материалыг арилгана,
5. дээжийн савыг нэн даруй нээх ба дээж дээж авагчаас дээжийн сав руу шахагдан орно. Дээж авагч хадгалах бодистой ямар нэгэн байдлаар хүрэлцэхээс сэргийлэх нь чухал!
6. хуурай бодис ба талбайн хэмжилтийг тодорхойлох зорилгоор дараагийн дээжийг авна,
7. дээжийн савны бөглөөс ба хаалтыг, тэдгээр дээр дэгдэмхий органик бодис алдагдуулах бохир байгаа эсэхийг шалгана,
8. дээжийн савны тэмдэглэгээг дээж жигнэх зорилгоор хялбархан арилгаж болох шошгонуудын тусламжтайгаар хийнэ. Наалддаг шошго ашиглахыг зөвлөхгүй, өөрөөр хэлбэл дээжийг жигнэх үед алдаа учруулж болно!
9. дээжийн савыг нэн даруй хөргөгчинд хийнэ (зөвхөн хөргүүрт ч биш!). Өөр өөр газруудаас авсан дээжүүдийг тусад нь хадгална. Ж.нь: тээвэрлэлтийн үеэр бохирдол дамжих боломжийг хязгаарлахын тулд хуванцар/гялгар уутанд хийнэ.

Хэрэв лабораторит материал алдагдсан, эсвэл дээжийн жин хэвийн бусаар буурсныг олж илрүүлсэн тохиолдолд дээжийг шинжилгээнээс гаргана.

3.5.6.2 Дэгдэмхий органик бодис тогтоох зорилгоор дээжийг хадгалах аргууд

Дээжийн хадгалалтыг газар дээр нь шууд эсвэл лабораторит хийж гүйцэтгэнэ.

Хадгалалтын физик аргууд:

- хөргөлт (2 - 6 °C-ийн дулаан) – мөстэй, хөргөгч жийргэвчүүдтэй саванд хийх, (хуурай мөс -78 °C хүртэлх дулаантай учир зөвлөхгүй, учир нь дээжин сав, нягт байдал зэргийг гэмтээж болзошгүй.),
- хөлдөөлт (7 -15 °C-ийн дулаан) – хуурай бодис тогтоох зориулалттай дээжийг хөрдөөж болохгүй!

Сонголт химийн хадгалалт, дээжийн савны төрлөөс шалтгаална.

Дээж авахад зориулсан олон аргууд бий, ж.нь: Химийн конзервантгүй арга („closed-system vials“, „no chemical preservation“), урвалж усаар дээжийг хадгалах арга („closed-system vials“, „no chemical preservation with organic free water (OFW)“), натрийн сульфат ашиглан химийн конзервантаар хадгалах арга („Closed-System Vials, Chemical Preservation – Sodium Bisulphate“) гэх мэт.

Төсөөтэй аргуудын талаар, дээж авах нөхцөл, хэлбэр, ажиглаж буй бодисын концентрацитай холбогдуулан дээж авахаас өмнө лабораторитой зөвлөлдөх нь зүйтэй.

3.5.6.3 Хуурай бодис тодорхойлох ба талбайн хэмжилт

Дээж авах журам нь ердийн – хүрзээр дээжийн саванд авч хийнэ – ж.нь: 60 мл-ийн PTFE хананцар бүхий тагтай бараан шилэн дээжийн саванд. Дээжийн савыг сайтар дүүргэсэн байвал зохино – агааргүй (чийгийн алдагдлыг хязгаарлана). Дээж химийн хувьд тогтворгүй болно. Физик конзервант - 2 - 6 °C-т хөргөөнө.

3.5.7 Дэгдэмхий бус нэгдлүүд тогтоох дээж авах

Дараах үзүүлэлтүүд нь дэгдэмхий бус нэгдлүүдэд орно:

- хагас дэгдэмхий органик нэгдлүүд (өндөр хэмд буцлах газрын тосны бүтээгдэхүүний төрөл),
- пестицидүүд,
- полихлоржуулсан бифенилүүд (PCB),
- полициклик ароматик нүүрсустөрөгч (PAU),
- металлуул,
- цианидууд,
- зэрэг.

Энэ бүлэгт ерөнхийдөө дэгдэмхий бус нэгдлүүдийг талбайн хэмжилтээр хялбархан илрүүлж болохгүй гэсэн ойлголт хүчинтэй.

Дээжлэлтийн ажлын өмнө дараах зүйлүүдийг нарийн тодорхой болгоно:

1. шинжилгээний аргыг сонгох,
2. хадгалах журам,
3. дээжийн сав,
4. дээж боловсруулах цаг,
5. чанарын бүрдүүлэлт ба хяналтад тавигдах шаардлага.

Ажиглагдаж буй бохирдуулагчийн төрлөөс хамаарч дээж авах дараалал:

1. дэгдэмхий бодисууд,
2. дэгдэмхий бус нэгдлүүд.

Дээжийн саванд дээж хийхийн өмнө, хэрэв боломжтой бол талбай дээр дээжийн гомогенжилт хийгдсэн байвал зохино. Лаборатори болон хариуцлагатай шийдвэрлэгчтэй тохиролцсны үндсэн дээр гомогенжүүлэх ажлын хүрээнд төлөвлөж, улмаар лабораторит гүйцэтгэж болно.

Гомогенжилтийг бохирдолгүйжүүлсэн гомогенжилтийн тавиур эсвэл саванд хийж гүйцэтгэдэг.

a) Гомогенжүүлэх үе шат:

- хэрэггүй бодисыг арилгах (ургамлын үлдэгдлүүд, ж.нь: мөчир, үндэс, чулуу болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн зүйлүүд / антропогенийн/ – хугархай, шил, үртэс, тоосго г.м),
- хутгалт (материалыг буланд шилжүүлэн, сэгсэрч, гол руу хутгаж, хажуу тийш нь г.м, ахин хутгана) ба квартац.

b) Дээжийг мөчлөн гомогенжүүлэх:

- материалыг 4 тэнцүү хуваана (ж.нь: кванртац /хуваагч хэрээсийн тусламжтайгаар),
- ¼ хэсэг тус бүрийг тус тусад нь хутган гомогенжүүлнэ,
- дараа нь дөрвөн хэсгийг ахин нэг саванд хийж нийлүүлнэ.

Хутгалт ба мөчлөн гомогенжүүлэх цувралыг ядаж нэг удаа давтана, эсвэл олон удаа давтвал сайн (дээжлэгдэж буй матрицын шинж чанарын дагуу). Үүний дараа кванртацаар багассан дээжийг шаардлагатай эзэлхүүн хэмжээгээр дээжийн саванд шигшин хийнэ.

Дээжийн савыг дүүргэсний дараа резьба, таг болон дээжийн савны гадна ирмэгийг цэвэрлэхэд ихээхэн анхаарна. Тагийг гүйцэт сайн таглана.

Хаасан даруй дээжийн савыг хөргөх хайрцагт хийх нь зүйтэй.

Өөр өөр газруудаас авсан дээжүүдийг хаагддаг хуванцар/гялгар уутанд (ж.нь: цахилгаанаар хаагддаг) хийн тус тусад нь хадгална. Дээжийн тэмдэглэгээ шилжүүлэн өгөх тайлан дахь тэмдэглэгээтэй тохирох ёстой.

3.5.8 Стандарт бус матрицын дээж авах журам

Эдгээр матрицуудын дээжлэлтийн үеэр баримтлах гол зарчим нь үр дүн боловсруулагчид дээж авсан нөхцлийг төлөөлөхүйц, тодорхой болгох дээжлэлтийн ажлын дэлгэрэнгүй баримтжуулалт юм.

Стандарт бус матрицын дээж авах үеэр гардаг хамгийн түгээмэл асуудал бөгөөд үр дүнд эргэлзээ төрүүлдэг гол эх үүсвэрүүдийн нэг нь материалын төлөөллийн дээжийг олох, цаашлаад дэгдэмхий органик бодис тогтоох зорилгоор дээж авах, түүнтэй харьцах зэрэг болно.

3.6 Хог хаягдал

Экологийн ачааллыг шийдвэрлэх үеэр хог хаягдлын үнэлгээг 2 бүлэгт хувааж болно:

1. устгалд оруулах бохирдсон материалын байршил ба орон зайн тодорхойлолт,
   a. дээжлэлтийн үеэр шүүмжтэй дээжлэлтийн аргаар бохирдсон материалын байршил ба нийт хэмжээг үе шаттайгаар алгуур тодруулах (эрх бүхий дээжлэлт),
   б. дээжлэлт нь эрсдэлт шинжилгээний эсвэл нөхөн сэргээх ажлын хариуцлагатай шийдвэрлэгчийн шаардлагын дагуу явагдана,
2. хог хаягдлыг дараагийн менежментийн зорилгоор тодорхойлох (хог хаягдлын үндсэн тэмдэглэлийг боловсруулах үеэр, хог хаягдлын хор хөнөөлийг үнэлэх үеэр г.м),
   a. дээжлэлтийн үеэр статистик дээжлэлтийн аргууд ашиглагддаг.
   б. дээжлэлт нь хог хаягдлын менежментийн тухай хууль тогтоомжоор шаардагдаж болно.

Экологийн ачааллын судалгаа, түүнийг арилгах үеэр үүссэн хог хаягдлууд ерөнхийдөө маш гетерогенийн чанартай байдаг, ийм ч учраас хог хаягдлын шинж чанарыг тодорхойлох, тэдгээрийн каталогжуулалт, өөрөөр хэлбэл ангилал нь маш олон янзын үе шатуудыг шаарддаг.

Янз бүрийн хэмжээтэй баглаа боодолд боосон эсвэл сан, нуур, овоолго г.м янз бүрийн бүлэг ба конзистенцтэй (хатуу, зуурмаган бас шингэн), харьцангуй гомогенийн (ж.нь: шавар) хог хаягдлуудаас гетерогенийн (ж.нь: барилгын хаягдал) хог хаягдлууд байдаг.

Хог хаягдлын дээжлэлтийг хог хаягдлын тухай хууль тогтоомжоор, тухайлбал хог хаягдлын дээжлэлтэд хариуцлага хүлээх этгээд / хог хаягдлын дээж авагч этгээдэд тавигдах шаардлага, аналитик шинжилгээнд мөн хог хаягдлын шинжилгээг хийх лабораторит тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зааж, зохицуулж болно.

3.6.1 Дээж авах үндсэн аргуудын хураангуй

Дээж авах оновчтой аргыг хог хаягдлын физик, химийн шинж чанар, цаашлаад хаягдсан хэлбэр зэргээс шалтгаалан сонгоно. Экологийн ачааллыг шийдвэрлэх үеэр хөрс, холбоост эсвэл холбоосгүй материал, зуурмаг эсвэл шингэн материалууд мэт дээжилж болох олон хог хаягдлуудтай тааралддаг. Эдгээр матрицуудын дээж авах журмыг өмнөх бүлэгт авч үзсэн. Үүнд голдуу хог хаягдлын дээжийг тэдгээрийн хаягдсан байдлыг харгалзан авах тухай бий.

3.6.1.1 Баглаж боосон материалууд ба контейнэр дэх материалууд

Ерөнхий:

- ажлын болон эрүүл мэндийн аюулгүй байдалд тавигдах нарийн чанд шаардлагууд,
- QA/QC журмууд нь шаардлага бүрт нийцсэн байна.

Бага хэмжээний материалууд – барель, тор, уут, лонх, лааз г.м.

Дээж авах үеийн ерөнхий ойлголтууд:

- бүх нэгжүүдийг баримтжуулах (ж.нь: контейнэрийн ерөнхий эзэлхүүн, одоогийн

эзэлхүүн, тэмдэглэгээ, техникийн байдал, өнгө, гарал үүсэл г.м), фото зураг, гар зураг г.м,

- савыг шилжүүлэх шаардлага гарвал баглаа боодлын техникийн байдал ийм боломжтой эсэхийг шалгана,
- одоо болон ирээдүйд таних зорилгоор дээжлэгдэж буй зүйлийг тэмдэглэх,
- баглааг нээхдээ анхаарал болгоомжтой байх, (ж.нь: хаалтны техникийн байдлыг шалгах)
- баглаа боодолд агуулагдаж буй зүйлийн тухай мэдлэгийн түвшнээс шалтгаалан оновчтой төхөөрөмж ашиглах шаардлагатай (ашиглагдаж болохуйц ж.нь: тэсэрч дэлбэрэх орчинд),
- баглаа боодлыг эргүүлэн хааж болохгүйд хүрэх эрсдлийн үед зохих арга хэмжээ авах (ж.нь: зэвэнд гүн идэгдсэн баглаа, хаалт нь эвдэрсэн г.м), эсвэл баглааг нээхэд тусгай арга шаардлагатай байх (ж.нь: орлох баглаа боодол бэлдэх г.м),
- баглааг нээх үеэр дэгдэмхий органик бодис тогтоох зорилгоор талбайн хэмжилт хийж гүйцэтгэхийг зөвлөдөг,
- зарим тохиолдлуудад (ж.нь: хэрэв баглаа бодол түүнийг оролдоох үеэр задрах аюул учрах, дээж авах үүднээс зайлшгүй шаардлага учирвал) шинжилж буй материалыг баглаатай нь шинэ, том баглаанд шилжүүлэх нь тохиромжтой.

Контейнэрт агуулагдсан хатуу материалууд

Дээж авагчид (тодорхой тохиолдлуудаас хамаарч дээж авах боломж):

- хүрз эсвэл халбага,
- ховилт дээж авагч,
- хоёр давхаргат дээж авагч.

Үе шат:

- баглааг нээх,
- боломжтой бол дээж авагчийг дээжлэгдэж буй материалын гол /төв рүү оруулах,
- дээж авагчийг дээжлэгдэж буй материалаас гаргах,
- дээжийг авч дээжийн саванд хийх,
- дээжлэлтэд шаардлагатай хэмжээний дээж авахын тулд үе шатыг шаардлагатай хэмжээгээр давтах,
- шинжлэгдэж буй баглааг эсвэл орлох баглааг хаах.

Дээж авах хооронд төхөөрөмжийг бохирдолгүйжүүлэх шаардлагатай, эсвэл нэг удаагийн дээжлэлтийн төхөөрөмж ашиглана. Контейнэр тус бүрийг тус тусад нь дээжилнэ.

Контейнэрт агуулагдах шингэн материал

Дээж авагч (тухайн нөхцлөөс шалтгаалан сонгох):

- хоолойт дээж авагч (нээлттэй хоолой),
- доороо хаалттай хоолойт дээж авагч,
- шингэн буюу шавар авах дээж авагч (bailer, утгуурт дээж авагч г.м).

Үе шат:

1. баглааг нээх,

2. дээж авагчийг дээжлэгдэж буй материалын гол / төв рүү оруулах,

3. дээж авагчийг дээжлэгдэж буй объектоос гаргах,

4. дээжийг авч дээжийн саванд хийх,

5. дээжлэлтэд шаардлагатай хэмжээний дээж авахын тулд үе шатыг шаардлагатай хэмжээгээр давтах,

6. шинжлэгдэж буй баглааг эсвэл орлох баглааг хаах.

Дээж авах хооронд төхөөрөмжийг бохирдолгүйжүүлэх шаардлагатай, эсвэл нэг удаагийн дээжлэлтийн төхөөрөмж ашиглана. Контейнэр тус бүрийг тус тусад нь дээжилнэ.

<u>Контейнэрт агуулсан их хэмжээний материал – цистерн, сан г.м</u>

Зарчим:

- Хог хаягдал хаясантай холбогдох мэдээллийн баримтжуулалт:
  - контейнэрийн төрөл, нийт эзэлхүүн (эсвэл барагцаагаар), одоо байгаа дүүргэлт, тэмдэглэгээ, өнгө, байрлал (байршил),
- дээж авах үеэр цистерн, сан зэргийн нүхийг ашиглана,
  - доод, ж.нь: асгах нүх. Дээжлэгдсэн материалын анзаарагдахааргүй алдагдлыг анхаар (ж.нь: ажилладаггүй хавхлагаас үүдэх эрсдэл),
  - дээд таг – дээд тагаар дээжлэлт хийхийг зөвлөдөг,
- дээж авалтанд ядаж хоёр хүн оролцоно.

Дээж авах журам:

1. дээжлэлтэд сонгогдсон нүхнээс дээж авах ажлыг эхлүүлэхийн өмнө цистерн эсвэл хаалттай саван дахь хийн илүүдэл даралтын эрсдлийг дүгнэх ба хөдөлмөр, эрүүл мэнд хамгааллын зохих арга хэмжээг авсан байна. Нүхийг цистерн доторх даралтыг атмосферийн даралттай тэнцүүлэхийн тулд маш болгоомжтой нээнэ,
2. талбайн хэмжилтийн тусламжтайгаар хийн алдагдал өөрчлөгддөг (ж.нь: PID детекторын тусламжтайгаар),
3. дээжийг тохирох дээж авагчаар авч гүйцэтгэнэ (II.4 бүлгийг үз),
4. хэрэв дээжлэгдэж буй объектод материал үечилсэн байвал давхарга нэг бүрт тусад нь дээжлэлт хийх шаардлагатай,
5. хэрэв дээжлэгдэж буй объект сегментжсэн байвал сегмент тус бүрт тусад нь дээжлэлт хийх шаардлагатай,
6. дээжлэлтийг объектын ядаж дээд хэсэг, дунд хэсэг болон доод хэсэгт хийж

гүйцэтгэнэ,

7. дээжлэлтийн зорилго нь хог хаягдлыг дараагийн ачилтын тулд хог хаягдлын шинж чанарыг олох бол холимог дээж авч болно.

3.6.1.2 Трансформаторууд

РСВ агуулж болох эсвэл агуулж буй тоног төхөөрөмжийн дээжлэлт (трансформаторуудын, индуктор г.м) РСВ-ын тухай тогтоомжуудаар (ж.нь: бүртгэл ба тооллого) зохицуулагдана.

Зарчим:

- хөдөлмөрийн аюулгүй байдал бүрэн хангагдсны дараа л дээж авч болно – тоног төхөөрөмж өндөр цахилгаан хүчдэлд холбогдоогүй байх ёстой, РСВ-д хүрвэл ноцтой эрсдэл учруулна г.м,
- РСВ алдагдахаас орчин тойрныг хамгаалах – хамгаалалтын уут эсвэл хучилт (ж.нь: хуванцар материалаар хийгдсэн) дээжилж буй нүхний доор, дээжтэй харьцах газарт г.м,
- дээжлэгч ажилтан нь дээжлэгдсэн материалаар бохирдсон материалуудыг цуглуулан хийх савыг үргэлж авч явна,
- хавхлаг эвдэрсэн үед материал алдагдах эрсдлээс шалтгаалан асгах хавхлаг ашиглахыг зөвлөхгүй. Өөр нэгэн шалтгаан нь, трансформаторын тосны давхаргуудаас болж төлөөллийн дээж авч болохгүй байх эрсдэл юм.

Дээж авах үе шат:

1. дээжлэлтийн төхөөрөмжийн оновчтой сонголт – дооroo цорготой дээжлэгч хоолой,
2. дээж авагчийг дээжийн сав ба сан дахь түвшин ижилхэн байхаар аажмаар живүүлнэ. дээжлэгч ёроолд хүрмэгцээ хаагдах ба сангаас гарган авна,
3. дээж авагчийн гадна ханыг цэвэрлэнэ,
4. дээжийг урьдчилан тэмдэглэсэн, тохиромжтой дээжийн сав руу шилжүүлнэ .

3.6.1.3 Сул овоолон хаясан хог хаягдлаас дээж авах

Дээж авах төлөвлөгөөг үргэлж дээжлэлтийн тодорхой зорилготойгоор, дээжлэгдэж буй материалын тухайн шинж чанар, түүний хаягдсан нөхцөлд зориулан бэлтгэх шаардлагатай.

Дээжийн тоог тогтоох зорилгоор овоолон хаясан хог хаягдлын эзэлхүүнийг олж мэдэх нь чухал. Дээжлэгч ажилчдын хөдөлмөр ба эрүүл мэндийн аюулгүй байдлаас авч үзвэл дээжлэлтийн төхөөрөмж ашиглах, дээж авах цэг тус бүрт нэвтрэх боломжийг үргэлж шалгаж үзэх шаардлагатай.

<u>Материалын шинж чанар</u>

Материалын төрөл

Материалын гарал үүсэл, хогийн цэгийн үзлэг, урьдчилсан шинжилгээ зэргийн тухай мэдээллүүдээс үүдэх материалын гетерогенийн түвшин нь чухал юм.

Гомогенийн материалууд нь дээжлэлтийн төвөгтэй схемчлэл шаарддаггүйгээрээ гетерогенийн материалуудаас ялгаатай.

Химийн тогтвортой байдал

Хогийн цэгт хаягдсан материалууд химийн найрлагын орон зайн өөрчлөлтийг илэрхийлж болно – үүссэн ба хаягдсан хугацаа харилцан адилгүй, хогийн цэг дээрх материалын хаягдсан хугацаанд химийн реакци үүссэн, хогийн цэгт хэсэгчилсэн реакци г.м. Энэ нь материалын гетерогенийн шинж чанарыг нэмэгдүүлэх шалтгаан байж болно.

Шинжилж буй материалыг бүрдүүлж буй хэсгүүдийн хэмжээ

Хэсгүүдийн хэмжээ нь шинжилгээнд зориулагдсан материалын хэмжээнд нөлөөлнө. Материалын томоохон хэсгүүд дээжээс хасагдсан бол шинжилгээний үр дүнг илэрхийлэх үеэр эерэг эсвэл сөрөг алдаануудын эх үүсвэр болно. Том хэмжээний материалын шинжилгээний үр дүнг дээжлэгдэж буй бусад материалыг харгалзан үзэж тэдгээрийн төлөөлөлд хамааруулан дурдах шаардлагатай.

Материалын бэхжилтийн бүтэц ба зэрэг

Хогийн цэг дээрх материал бэхжилт ба бүтцийн хувьд ихээхэн өөрчлөгдөж болно. Тоосорхог нунтаг материалаас бүрэн нягтарсан блок материалууд ч бий. Ийм шинж чанар дээжлэх ажлын төлөвлөгөөний бэлтгэл үе шат болон дээж авахад ихээхэн нөлөөлдөг гэдгийг ахин сануулах нь зүйтэй болов уу.

<u>Дээжлэлтийн зорилго</u>

Экологийн ачааллыг шийдвэрлэх шаардлагын дагуу – экологийн ачааллыг арилгах үеэр эрсдлийн шинжилгээ ба үе шатуудыг боловсруулах зорилгоор хогийн цэгт үнэлгээ хийх.

Алхмууд:

1. хог хаягдал үүссэн технологийн тухай мэдлэгийн үндсэн дээр тодорхойлох. Мэдээллийг үргэлж аналитик шинжилгээгээр шалгаж баталгаажуулах шаардлагатай – материал үүссэн технологийн тухай мэдээллүүдийн хүчин төгөлдөр байдлыг шалган үзэх дээж авалт ба шинжилгээний эхний цуврал – тогтоосон хязгаараас доош эсвэл дээш гарсан параметруудыг тодорхойлох,
2. хог хаягдлын аюултай шинж чанарыг тодорхойлох,
3. аюулын шинж чанар бүхий, тогтоосон хязгаараас хэтэрсэн параметруудтай хогийн цэг дэх материалуудын орон зайн хязгаарлалт, нөхөн сэргээх шаардлагатай (газар дээр нь, эсвэл тээвэрлэлтийн үеэр) материалын болон газар нутаг дээр нь нэмэлт засваргүйгээр орхиж болохуйц материалын орон зайн хязгаарлалт.

<u>Дээж авах</u>

Журам:

1. шаардлагатай газар нь дээжлэгдэж буй материалтай холбогдолгүй материалын үлдэгдлүүдийг (ургамлын үлдэгдлүүд – навч, мөчир г.м) арилгана,
2. дээжийг шаардлагатай гүнээс тохиромжтой багажийн тусламжтайгаар авна,
3. дээжийг дээжийн саванд шилжүүлэн хийнэ (голдуу том амсартай – нунтаг зүйлс хадгалдаг шилэн сав), эсвэл дээж авагчтай нь лаборатори руу тээвэрлэнэ (ж.нь:TOL

тогтоох үеэр).

3.7 Гадаргын дээжлэлт

3.7.1 Дээж авах үндсэн аргуудын хураангуй

Энэ бүлэгт дараах техникүүдээр гадаргын дээж авах үед баримтлах журмыг авч үзнэ:

- хусаж,
- огтлох ба хуулах,
- шүүрдэж авах.

Гадаргын дээжийг хөрс, ус, агаараас бусад материалд байгаа/эсвэл бохирдлын тархалтыг дүгнэх зорилгоор авдаг.

Доор дурдагдсан аргууд нь ижил зорилготой боловч тэдгээрийг ашиглах сонголт дээжлэгдэж буй гадаргын төрөл буюу бохирдуулагчийн төрлөөс хамаарна.

3.7.1.1 Хусаж авах дээжүүд

Хэрэглээ:

- дэгдэмхий бус бодисууд (PCB, PCDD/F, PAU г.м),
- сүвэрхэг бус гадаргаа (шил, шаазан, металл эдлэл г.м).

Дээж авах газрын сонголт дараах зүйлүүдээс хамаарна: бохирдлын түүх, үйлдвэрлэлийн арга ба технологи, ажлын арга барил ба дадал, дээж авах газруудын шилжилт ба хүртээмжтэй байдал зэрийн тухай мэдлэг.

Дээж авах газруудын жишээ:

- түүхий эдийн сан,
- агааржуулалтын систем,
- барилгын хийц (дам нуруу г.м),
- цонх, цонхны рам г.м.

Дээжлэгдэж буй талбайн хэмжээ аналитик аргуудын тогтоох хязгаараар хэмжигдэнэ. Тухайн талбай дээрх бохирдлыг үргэлж барагцаалан тооцож, авсан аналитын хэмжээ шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлж байгаа эсэхийг шинжээчтэй зөвлөлдвөл зохино. Шаардлагатай тохиолдолд шинжлэгдэж буй талбайг засаж өөрчилнө.

Туслах хэрэгслүүд:

- дээжлэгдэж буй талбайн хэмжилтэд хэмжигч, шугам,
- чимхүүр,
- нэг удаагийн, дээжлэгч бээлий, шинэ самбайгаар дээжийн сав эсвэл уусгагчтай харьцах, хүрэхээс өмнө сольж өмснө,
- ариутгасан, эвхсэн самбай (ж.нь: 10 х 10 см хэмжээтэй) – шүүлтүүр цаас хэрэглэхгүй байхыг зөвлөж байна – урагдаж дээжийн материалд үлддэг,

- тохиромжтой уусгагч (ажиглагдах үзүүлэлтийн төрлөөс – дээжийг боловсруулах лабораторитой зөвлөлдөх шаардлагатай), ж.нь:
    - ацетон/гексан 1 : 4 (пестицидүүд, хагас дэгдэмхий нэгдлүүд, PCB),
    - нэрмэл ба ионгүйжүүлсэн ус - металл,
    - метанол эсвэл нэрмэл ба ионгүйжүүлсэн ус (будагтай гадаргуу, лааны тосон гадаргуунууд) г.м.

Дээж авах журам:

- дээж авах газарт шаардлагатай талбайг хязгаарлана (ж.нь: 25 x 25 cm^2) -ж.нь: тохирох хэмжээний загваруудын тусламжтайгаар,
- чимхүүрээр самбайг хэрэгслүүдээс гарган авна, уусгагч бодисонд чийглэж гадаргууг хэвтээ чигт, дараа нь босоо чиглэлд дундаж (дунд зэргийн) даралттайгаар арчина. Арчих циклийн тоо нь ажиглагдах бодисын гадаргуу дээрх хэмжээгээр өгөгддөг (циклийн оновчтой тоог туршилтаар шалган гаргана). Цикл тус бүр хэвтээ ба босоо чиглэлд арчигдана,
- экспозицийн самбайг нэн даруй дээжийн саванд хийнэ.

Тэмдэглэл: самбайг хэзээ ч арчихаас өмнө чийглэхгүй (агшин зуур агаараас бохирдох эрсдэл – атмосферийн нөөц).

Чанарын хяналт:

- хоосон дээж („field blank“) – эрсдлийг илрүүлэх – агаараас бохирдох, бээлий, дээжийн сав, уусгагч, ариутгасан самбай г.м.
- циклийн оновчтой тоог дээжлэгдэж буй гадаргуу дээрх ажиглагдах материалын мэдэгдэж буй хэмжээгээр шүршиж туршина (дүүрэн дээжүүд).

3.7.1.2 Цохиж авдаг дээжүүд

Хэрэглээ:

- дэгдэмхий бус бодисууд (PCB, PCDD/F, PAU г.м),
- сүвэрхэг гадаргуу (бетон, тоосго, мод г.м).

Дээж авах газрын сонголт дараах зүйлүүдээс хамаарна: бохирдлын түүх, үйлдвэрлэлийн арга ба технологи, ажлын арга барил ба дадал, дээж авах газруудын шилжилт ба хүртээмжтэй байдал зэрийн тухай мэдлэг.

Дээж авах газруудын жишээ:

Түүхий эдийн агуулахын шал, склад, ачилтын газар г.м.

Дээжлэгдэж буй талбайн хэмжээ аналитик аргуудын тогтоох хязгаараар хэмжигдэнэ. Тухайн талбай дээрх бохирдлыг үргэлж барагцаалан тооцож, авсан аналитын хэмжээ шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлж байгаа эсэхийг шинжээчтэй зөвлөлдвөл зохино. Шаардлагатай тохиолдолд шинжлэгдэж буй талбайг засаж өөрчилнө.

Туслах хэрэгслүүд:

- дээжлэгдэж буй талбайн хэмжилтэд хэмжигч, шугам,

- нэг удаагийн дээжлэгч бээлий, дээж авсны дараа болон дээжлэлтийн хэрэгслүүдтэй харьцах, хүрэхээс өмнө сольж өмснө,
- бохирдолгүйжүүлсэн цүүц (борын силикатжуулсан), алх эсвэл цахилгаан алх,
- байгалийн мяндсан үстэй багс, хэрэв хүрз шинжилгээний үр дүнд нөлөөлж болохуйц материалаар хийгдээгүй бол хөнгөн цагаан уутаар хучигдсан хүрз.
- дээжийн сав.

Дээж авах журам:

1. дээжлэгдэх талбайг тодорхойлох,
2. сонгосон талбайг цүүц, алхны тусламжтайгаар бутлах (анхаар – сонирхож буй талбайн гадна талаас унасан хэлтэрхийг дээжинд ашиглаж болохгүй),
3. цавчмын гүн – дээд тал нь 6 мм, зөвлөхүйц хэмжээ 3 мм,
4. хэлтэрхийнүүдийг (эмтэрхий) бохирдолгүйжүүлсэн хүрзэн дээр багсны тусламжтайгаар шүүрдэн аваад дээжийн саванд хийнэ.

3.7.1.3 Шүүрдэгдсэн дээж (шүүрдсэн)

Хэрэглээ:

- дэгдэмхий бус бодисууд (PCB, PCDD/F, PAU, металлууд г.м.),
- сүвэрхэг (бетон, тоосго, мод г.м) болон сүвэрхэг бус гадаргуу дээрх тоосорхог үлдэгдлүүдээс зөөлөн ширхэглэгтэй материалууд (голдуу тоос)

Хэрэглээ:

1. дээжлэгдэх талбайг тодорхойлох,
2. шүүр, сойз эсвэл багсны тусламжтайгаар нарийн ширхэгтэй материалыг бохирдолгүйжүүлсэн хүрз болон дээжийн саванд шилжүүлэн хийнэ.

Шүүр, сойз эсвэл багс зэрэг нь агшин зуур дээж бохирдоход хүргэж болохгүй. (ж.нь: үс уналт, дээж хооронд бохирдол дамжих г.м).

3.8 Гадаргын ус

3.8.1 Дээж авах үндсэн аргуудын хураангуй

Нөхөн сэргээх ажлын үүднээс дээжлэлтийн зорилго нь нөхөн сэргээлтийн дараа цэвэрлэгдсэн усны асгалтыг авч үзэхэд гадаргын усны чанарын хяналт буюу асгаж буй газрын дээр эсвэл доор чанарын мониторинг хийх, шаардлагатай бол байж болох бохирдлын өөр эх үүсвэрүүдийг хайж олох зэрэг юм.

Хэвийн нөхцөлд усыг хялбархан хүрэх байршилд, энгийн арга хэлбэрээр дээжилж болдог. Голын урсгалт хэсэг, хүрэхэд хэцүү газар, хангалттай хөлдөөгүй гадарга гэх мэт тохиолдлуудад дээжлэлтийн багийн багаж хэрэгсэлд илүү нарийн шаардлагууд тавигддаг, ялангуяа хөдөлмөрийн аюулгүй байдал. Энэ нь дээж авах төлөвлөгөө үүсэх үеэс л нэгдүгээрт байх ёстой ба түүнд арга барилын сонголт, дээж авах ажлыг

гүйцэтгэх ажилтнуудын тоног төхөөрөмжийн хангамж зэргийг нийцүүлсэн байвал зохино.

Дээж авах төлөвлөгөөг боловсруулах үеэр нэвтрэхэд саадгүй газрыг дээгүүрт тавихыг зөвлөдөг. Урсгал/сангийн гүн ба урсгалын хурдыг бодолцож үзэх нь зүйтэй.

Дээж авах төлөвлөгөөнд дээжлэгч ажилтны аюулгүй байдал, гүүрэн дээгүүрх тээвэрлэлт г.м дээж авахтай холбогдох бүхий л эрсдлүүдийг багасгасан байвал зохино.

Дээжийг дээж авахын яг өмнөхөн шаардлагатай шинжилгээг хийж гүйцэтгэх лабораториос авчирсан дээжийн саванд хийнэ.

Дээж авах ажлыг эхлүүлэхийн өмнө усны дулаан, гүн, урсгал, pH, дамжуулах чанар зэрэг мэдээллүүдийг тэмдэглэн авна. Хэмжигдсэн бүхий л мэдээллүүдийг даруйхан баримтжуулна.

Төслийн менежер дээжийн тоо, газар, цаг, дээж авах давтамжыг тогтоохоос гадна, дээж авч болохуйц орчин нөхцөл, дээж авах аргыг техник тоноглолын хамт тодорхойлно.

Дээжлэлтэд ашиглагдах бүхий л тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг дээж авахын өмнө, авсан дээжүүд хооронд бохирдол дамжихаас сэргийлэх зорилгоор бохирдолгүйжүүлсэн байна.

Төхөөрөмжийн оновчтой сонголт нь дээж авах газрын байршил, ажиглах үзүүлэлтүүд зэргээс хамаарна. Дараах хэрэгслүүдийн тусламжтайгаар дээж авна:

- гадаргын дээж авагчууд (дээжийн сав, хувин, сав, утгуур). Тодорхойлсон гүнээс эдгээрээр дээж авах боломжгүй ба ууссан хий болон дэгдэмхий органик бодис (TOL) шинжлэх зорилгоор дээж авахад тохиромжгүй. Хэрэв тохирох шилэн дээжийн савнууд нь ариутгагдсан бол тэдгээрийг микробиологийн шинжилгээний зорилгоор дээж авахад ашиглаж болно,
- хаалттай, шумбадаг дээж авагч. Тодорхойлсон гүн рүү голдуу төмөр утсанд бэхлэн оруулж дээж авахад ашигладаг ба түүнийг ууссан хий болон TOL шинжлэх зорилгоор дээж авахад тохируулан өөрчилж болно (Дусартын лонх),
- шахуургын төхөөрөмжүүд. Энэ тохиолдолд насос тус бүрийн шинж чанар ба техникийн үзүүлэлтүүдийг авч үзэх шаардлагатай,
- автомат дээж авагчууд. Эдгээр дээж авагчууд нь байнгын эсвэл холимог дээж авах, усан доторх өөрчлөлтийг хугацаанаас хамааруулан ажиглахад ихэвчлэн гол, горхинд ашиглагддаг,
- пассив диффузын дээж авагч. Ийм төрлийн дээж авагчууд нь голдуу POP-ын тасралтгүй мониторинг хийхэд тохиромжтой. Дээж авах бусад аргуудаас яг тухайн агшны концентрацийг тогтоох боломжгүйгээрээ ялгаатай ч дээж авагчийн байсан хугацаанд цаг хугацааны дундаж концентрацийг олгодог.

Сүүлийн үед гадаргын усанд мониторинг хийх салбарт усан санд босоо мониторинг хийх боломжтой, мэдээллийг тасралтгүй тэмдэглэн авдаг олон параметртай зондуудыг ихээхэн ашиглах болсон ба тэдгээрийн тусламжтайгаар ж.нь: pH, дамжуулах чанар, ууссан хүчилтөрөгч г.м урьдчилан сонгосон үзүүлэлтүүдэд хүрсэн тохиолдолд дээж авалтыг автомат төхөөрөмжөөр авах боломжтой.

3.9 Гүний ус

Тодорхой газын гүний усны найрлага байгалийн болон антропогенийн янз бүрийн физик, химийн болон биологийн үйл явцаар өгөгддөг. Ерөнхийдөө, ямар нэг нөлөөнд автаагүй гүний ус нь оршин байгаа орчинтойгоо гидрогеохимийн тэнцвэрт оршдог гэж үздэг. Гүний усны найрлагын хөгжих явц нь түүний чулуулгийн орчин дахь хөдөлгөөнийг илэрхийлнэ. Найрлагын хажуугийн өөрчлөлтөөс гадна босоо бүсжилт нь гидрохимид онцгой ач холбогдолтой. Энэ нь байгалийн бохирдолгүй ус төдийгүй чулуулгийн бүс ба гүний усны антрогенийн уршгаар бохирдсон тохиолдолд ч илэрдэг. Иймээс тохиолдолд гүний усны химижилтийн босоо өөрчлөлтийг, эхний хэд хэдэн дециметрт тэмдэглэн авч болно.

Гүний усыг дээжлэх үеэр бусад матрицуудын адил хоёр төрлийн дээжийг ялгана: **энгийн цэгэн дээж** ба **холимог дээжүүд**. Энгийн цэгэн дээжүүд нь дээж авсан цэг дэх гүний усны найрлагыг өгүүлдэг ба орчинтойгоо гидрогеологийн тэнцвэрт байх ёстой бол холимог дээжүүд нь **орон зайн эсвэл хугацаанаас хамаарсан дундаж** хэлбэрээр үүсдэг. Ихэнхдээ тоноглолын бүрэн нүхэлсэн хэсгээр дамжин цооног руу урсан орох гүний усыг хольсноор үүссэн босоо чиглэлээс хамаарсан холимог дээжүүд юм. Хэрэв колектор дахь гүний усны найрлага хүчтэй үечилсэн, ийм холимог дээж гидрохимийн ч тэнцвэрт (харилцан ялгаатай нэгдлүүд зэрэгцэн оршиж болно), орчин тойронтойгоо ч тэнцвэрт байхгүй юм.

Дээр дурдсанаас үзэхэд хоёр төрлийн дээжийн тодорхойлолт, олон төрлийн хэрэглээ үүсч байна:

Холимог дээжүүд бүсийн хэмжээний судалгаанд, усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа, мониторинг хийхэд болон бүрэн гидрогеологийн бүтцийн дүгнэлтэд орлуулшгүй үүрэг гүйцэтгэнэ. Чулуулгийн бүс ба гүний усны антропогенийн бохирдлыг хайх, судалгаа хийх, арилгахтай холбогдуулан гүйцэтгэсэн судалгааны ажлууд нь С бүлгийн судалгаанд (урьдчилсан судалгаа), зарим тохиолдолд мөн А бүлгийн судалгаанд (нөхөн сэргээлтийн мониторинг) ч ашиглагдах нь бий.

Энгийн цэгэн дээжүүд нь байгалийн төдийгүй бохирдсон чулуулгийн орчинд явагдаж буй гидрогеохимийн үзэгдлүүдийг шинжлэхэд зайлшгүй шаардлагатай. Эдгээр дээжүүд шинжлэгдэж буй аналитуудын босоо хуваагдлыг шинжлэхэд шаардлагатай мэдээллүүдийг олохоод, цаашлаад гүний усны колектор дахь гидрогеохимийн судалгаанд зайлшгүй чухал. Энэ нь гүний усны найрлагын байгалийн эволюц төдийгүй бохирдлын байгалийн тархалтын үйл явцыг дүгнэх тухай юм. Иймээс тохиолдолд энгийн цэгэн дээжүүдийн ач холбогдол орлогдошгүй чухал.

Хуучин экологийн ачааллыг арилгах явцад энгийн цэгэн дээжүүд ялангуяа В категорийн судалгаанд (дэлгэрэнгүй судалгаа) ашиглагдана. Энгийн цэгэн дээж авах нь холимог дээж авахаас техник, аргазүйн хувьд илүү төвөгтэй байдаг.

3.9.1 Ханасан бүс

Ханасан бүсийн ус чулуулагт байх бүхий л сул орон зайг дүүргэн, гидравликийн градиентын уналтын дагуу хөдөлгөөнд оршдог.

Аргазүйн үүднээс үзэхэд, гүний усыг дээж авсан аргаас нь хамааруулж статик ба **динамик** гэж **хуваасан** түгээмэл ашиглагддаг, хуучны ангилал нь дээжийн шинж чанарыг бүрэн илэрхийлж чадахгүй учир нэн тохиромжгүй.

Статик гэсэн тэмдэглэгээнд ихэвчлэн гүний усыг хяналтын объектоос шахалгүйгээр авсан дээжийг ойлгодог. Онцгой тохиолдлуудыг эс тооцвол, иймм дээжүүд нь найрлагаараа ойр орчмын колектор дахь гүний усанд тохирдоггүй.

Онцгой тохиолдлууд нь гүний усны урсгал дээжлэгдэж буй объектоор дайран урсаж байгааг нотлож болохуйц объектуудаас авсан, дээж авалт нь иймм урсгал бүхий газруудад (нүхэлсэн эд ангийн хэсэг г.м) хийгдсэн дээжүүд болно. Иймм дээжүүд нь **энгийн цэгэн дээж**ийн шинж чанарт тохирдог.

Динамик дээжүүд (динамик төлөвтэй дээжүүд) гэж дээжлэгдэж буй объектын шахалтын үеэр эсвэл дараа авсан дээжүүдийг хэлнэ. Иймм тохиолдолд дээжийн шинж чанар гүний усны шахагдсан хэмжээ, объектыг цэвэрлэх ба дээж авах үеэр ашиглагдсан дээжлэгч насосын байршил, чулуулгийн бүсийн нэвтрүүлэх чанараар өгөгдөнө.

Шахагдсан ус хангалттай бага (орчны нэвтрүүлэх чанартай уялдан) хэдий ч шахалтын үеэр дээжлэгдэж буй объектод ус босоо чигт холилдоогүй ба дээжлэгч төхөөрөмж нүхэлсэн эд ангийн хэсэгт тавигдсан, дээжүүд энгийн цэгэн дээжүүдийн шаардлагыг биелүүлсэн байна. Эдгээр гурван үзүүлэлтийг биелүүлэх зорилгоор ашиглагдах дээж авах аргыг **бага хэмжээгээр шахах дээжлэлт** - „low flow purging and sampling“, эсвэл **бичил цэвэрлэгээ** - „micropurging гэнэ.

Хэрэв аль нэг нөхцөл биелээгүй бол авсан дээж үргэлж холимог дээжийн шинж чанартай байна.

3.9.2 Дээж авах ерөнхий журам

Гүний усны дээжлэлтийн үеэрх дээж авалт буюу дээжийн багийн байршил дээрх үйл ажиллагааг ерөнхийдөө дараах байдлаар тэмдэглэж болно:

1. дээж авах газар буюу цэг, дээжийн сав болон шаардлагатай хэрэгслүүдийн бэлтгэл ба хяналт,
2. гүний усны гадаргын түвшний хэмжилт ба объектын гүн,
3. дээжлэгч тоноглолын угсралт суурилуулалт,
4. дээжлэгдэж буй объектын цэвэрлэгээ,
5. гидрохимийн параметрын талбай дээрх хэмжилт, гадаргын түвшний хэмжилт,
6. дээж авалт ба дээжийн савны дүүргэлт,
7. дээжийн засвар,
8. баримтжуулалт.

3.9.2.1 Дээж авах газар буюу цэгийн бэлтгэл ба хяналт

Бэлтгэлийн хүрээнд дээж авах газрыг түүний техникийн байдал болон дээж авах аргын зүгээс хүртээмжтэй, тохиромжтой байгаа эсэхийг хянана. Үүнээс гадна дээжийн сав ба дээжлэгч төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

3.9.2.2 Гадаргын түвшний хэмжилт

Дараа нь гүний усны гадаргын түвшний ба объектын гүнийг хэмжинэ. Хэмжилтийн тохирцыг хангах зорилгоор ашигласан хэмжилтийн цэгийг нарийн тодорхойлж

баримтжуулалтад дурдах нь зүйтэй. Үүний зэрэгцээ гүний усны гадарга дээр дангаар оршиж байгаа газрын тосны нүүрсустөрөгчийн фазыг ойролцоогоор шалгаж үзнэ. Хэмжилтэнд цахилгаан гадаргуу хэмжигч эсвэл зэвэрдэггүй ган бүсийн Рейнжийн шүгэл ашигладаг. Гадарга хэмжигчийн дахин ашиглалтаас үзэхэд түүний бохирдолгүйжүүлэлтэд анхаарал хандуулбал зохино.

3.9.2.3 Объектын цэвэрлэгээ

Дээж авахын өмнө ихэнх тохиолдолд дээжлэгдэж буй объектод, тоноглолд зогсонги байх усны баганы цэвэрлэгээг хийж гүйцэтгэнэ. Онцгой тохиолдолд удаан хугацааны турш шахагдсан объектууд ж.нь: нөхөн сэргээлтийн цооног, худаг, булаг, байнгын урсацтай нээлттэй цооног орно. Цооногийн цэвэрлэгээнд хоёр төрлийн арга хэрэглэгддэг:

- эзэлхүүний арга,
- сонгосон үзүүлэлтийн талбайн хэмжилтийн тогтворжилт.

Эзэлхүүний арга

Эзэлхүүний арга нь урьдчилан тогтоосон, дээж авахын өмнө цооногийн тоноглолд агуулагдсан усны эзэлхүүний солилцоон дээр үндэслэсэн. Солилцоо тухайн газар нутгийн нөхцлөөс шалтгаалан объект дахь зогсонги усны 3-5 эзэлхүүн байна. Цэвэрлэгээнд харьцангуй өндөр хүчин чадалтай насос эсвэл лаг шавхагч ашиглагддаг. Уг арга нь авсан дээжийн булингар илт нэмэгдэх ба түүнтэй холбогдон зарим нэг шинжилгээний үр дүнг гажуудуулахад хүргэдэг. Ийм учраас бага хэмжээгээр шахах дээжлэлтийн аргаар дээж авахад тохиромжгүй.

Сонгосон үзүүлэлтийн талбайн хэмжилтийн тогтворжилт

Объектыг тоноглол дахь зогсонги усны баганаас цэвэрлэх үзүүлэлт нь pH, цахилгаан дамжуулах чанар, ууссан хүчилтөрөгчийн агууламж, оксидаци - редукцийн чадамж, дулаан ба булингар зэрэг хэмжигдсэн параметруудын тогтворжилт болно. pH ба дулааны утгууд нь тоноглол дахь зогсонги усны болон колекторын гүний усыг ялгахуйц мэдрэг биш боловч мониторингийн үр дүнгийн дараагийн боловсруулалт ба үнэлгээнд шаардагдах параметруудад гол төлөв ордог бөгөөд ийм ч учраас хэмжигддэг байх ёстой.

Параметрууд нь объектын цэвэрлэгээний зорилгоор ашиглагдсан насосын гарах урсгалын хил дээр хэмжигддэг. Үүний зэрэгцээ дээжлэгдэж буй объектод гадарга тогтворжиж (бууралтыг зогсоох) байх ёстой. Гадаргын бууралт зогсох нь объект руу урсах гүний усны хэмжээ болон цооног цэвэрлэх үеэр авсан хэмжээ тэнцснийг илэрхийлнэ. Хэмжигдэх нэгжүүдийн тогтворжилтын үнэлгээний нөхцөл гадаргын бууралт, шахсан хэмжээ, хэмжилтэд хэрэглэгдсэн тоноглол зэргээс хамаарна. Иймээс тодорхой объектод тогтворжилтын гол үзүүлэлтүүдийг үргэлж тогтоож байвал зохино. Эдгээр нөхцлүүд цаашид өөрчлөгдөхгүй байх ёстой.

Хэмжигдэх нэгжүүдийн тогтворжилтод хүрэхийн тулд шаардагдах цэвэрлэгээний хугацаа олон янзын хүчин зүйлүүдээс хамаардагч, ерөнхийдөө, байнга/суурин суурилагдсан дээжлэлтийн төхөөрөмжтэй объектын хувьд зөвхөн дээжлэлтийн өмнө оруулсан дээжлэлтийн төхөөрөмжтэй объектынхоос харьцангуй богино байдаг. Энэ нь дээжлэлтийн төхөөрөмжийг оруулах үеэр цооногт усны баганын булингар ба холигдол нэмэгддэгийн үр дүн юм.

3.9.2.4 Дээжийн савны дүүргэлт

Дээж авах болон дээжлэлттэй холбоотой үйл ажиллагааны дүнд дээжлэгдсэн гүний усны найрлагад өөрчлөлт орж болох хэдий ч дээжийн савнуудыг хүчтэй дэгдэмхий бөгөөд хялбархан нөлөөнд автдаг нэгдлээс инертийн хий хүртэлх дарааллаар дүүргэх нь тохиромжтой.

Дээжийн сав дүүргэх зөвлөхүйц дараалал:

1. ууссан хий (сульфан, метан, этан, винилхлорид, радон),
2. дэгдэмхий органик бодис (TOL),
3. органик галогенидүүд (AOX, EOX),
4. нийт органик нүүрстөрөгч (TOC),
5. газрын тосны нүүрс-устөрөгчүүд ба бусад органик бодисууд (PCB, PAU, пестицидүүд),
6. бүх төрлийн металл,
7. ууссан металл,
8. фенол ба цианидууд,
9. бусад анорганик ионтууд,
10. цацраг идэвхитүүд,
11. микробиологийн дээжүүд.

Дээжийн савыг дүүргэх үеэр усны урсгалыг аль болох бага хэмжээгээр барих нь зүйтэй. Дээжийн савнуудыг дүүргэх явцад дээж агааржуулагдах ёсгүй бөгөөд дээж авагчийн гарцаас гарах усны урсгал ламинар урсгалын шинж чанартай (усны жигд цацраг) байх ёстой.

3.9.2.5 Дээж авсны дараах засвар

Зарим нэгэн аналитыг тогтоох дээжүүдийг (ж.нь: цианидууд, фенол, металл, сульфан г.м) шууд талбай дээр хадгалах (засах) зайлшгүй шаардлагатай. Зарим тохиолдолд лабораториос хадгалах нэмэлтээр арга хэмжээ авсан дээжийн савнуудыг авч болдог бол зарим тохиолдолд дээжийн савнуудыг дүүргэсний дараа засдаг (ердийн сульфан).

Дээжийг ууссан металл хэсгүүдийг тогтоохын зорилгоор дээж авах үеэр, эсвэл үүний дараа шүүх шаардлагатай. Шүүлтүүрийн сүвэрхэгийн хэмжээ голдуу 0,45 μм байдаг.

Дээжийг хадгалах болон түүнтэй харьцах журам EN ISO 5667-3-т бий.

3.9.2.6 Баримтжуулалт

Баримтжуулалтын хүрээнд, дээжлэлтийн үр дүнд нөлөөлж болох бүхий л байдлыг, ялангуяа цаг агаарын нөхцөл, техникийн нөхцөл (цооногийн төлөв, гадаргын өмнөх түвшин, цооногийн гүн, тоноглолын диаметр г.м) ашиглагдсан төхөөрөмж, объектыг цэвэрлэх болон дээж авах үеэр гүний усны шахагдсан хэмжээний явц ба гадаргын бууралт, дээж авах төлөвлөгөөнд нарийн тодорхойлогдсон арга, үе шатаас хазайсан тухай тэмдэглэнэ.

3.9.2.7 Дээж авах хэрэгсэл ба аргууд

Дээж авах зорилгоор ашиглагдсан үе шат, хэрэгсэл ба тоног төхөөрөмжүүд нь эдгээр хүчин зүйлүүдээс хамааран ялгаатай байна:

- дээжлэлтийн зорилго (ж.нь: колекторын бүсийн судалгаа, хайгуулын бүлэг тус бүрийн судалгаа, бохирдуулагчдын байгалийн тархалт ба ажиглалт, хогийн цэгийн үйл ажиллагааны мониторинг г.м),
- дээжлэгдэж буй объектын төрөл,
- объектын хэмжээ,
- объектын гүн ба гадаргын түвшин,
- ажиглагдаж буй аналит ба шинж чанар,
- тоноглолын нээлттэй хэсгийн урт/тоноглоогүй цооногийн хэсгийн,
- хучлага ба нүхлэлтийн шинж чанар,
- объект руу чиглэсэн, нэмэгдэл урсгалын мэдэгдэж/таамаглаж буй хэсгүүд,
- колекторын мэдэгдэж/таамаглаж буй нэвтрүүлэх чанар.

Дээр дурдсан хүчин зүйлүүдээс үзэхэд ханасан бүсэд гүний усны дээжлэлтийг дараах бүлгүүдэд хамааруулж болно:

1. байнгын урсацтай булаг шанд, нээлттэй цооногийн дээжлэлт,
2. түр зуурын объектын дээжлэлт, дээж авахын өмнө эдгээр объектуудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлахад тавигдах шаардлагагүйгээр,
3. бага хэмжээгээр шахах аргаар цооног дээжлэх / хэмжигдсэн параметруудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлан цооногийн нээлттэй хэсэгт,
4. цооног цэвэрлэх болон дээж авах үеэр гадарга хяналтгүй буурдаг цооногуудад, нүхэлсэн хэсэг дэх бэхэлгээ/цооногийн нээлттэй хэсэгт цооногийн хэмжигдсэн параметруудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлан бага хэмжээгээр шахах аргаар цооног дээжлэх. Эдгээр нь маш бага нэвчилттэй орчинд байрласан объектууд юм. Гадаргын хяналтгүй бууралт нь дээж авахын өмнө хэмжигдсэн параметруудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлаагүйн үр дүн,
5. эзэлхүүний хувьд дундажлагдсан, холимог дээж авах. Цэвэрлэгээ ба дээж авалт нь тоноглолын нүхэлсэн хэсгийн гадуур оруулсан насосоор, дээж авахын өмнө хэмжигдэх параметруудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлалгүй хийж гүйцэтгэнэ,
6. пиезометр ба нарийн профильт олон түвшний дээжлэлтийн систем, хэмжигдэх параметруудын тогтворжилтын үзүүлэлтийг баримтлан,
7. пассив диффузын дээж авагчийн хугацаанаас хамаарсан дээжүүд,
8. удаан хугацааны турш шахагдсан объектууд.

Объектын бүлэг бүрийн дээжлэлт өөр хоорондоо адилгүй хэрэгсэл, тоноглол шаарддаг бөгөөд дараах текстэд бичигдсэн тодорхой нарийвчлалтай. Бүлэг тус бүрт зориулагдсан дээж авах, зөвлөхүйц хэрэгслүүдийг уг МР-ын хавсралтын хүснэлт 6-д дурдсан болно.

3.9.2.8 Байнгын урсацтай ундарга ба цооног

Ундарга гэж газрын доорх ус газрын гадаргатай огтлолцсон газрыг ойлгох ба гадаргын уст колектор усны урсгал руу төвлөрүүлсэн усаа зайлуулахад хүрдэг. Хэрэв боломжтой бол дээж авах газарт усны гүн рүү, оргилох ус руу дээжийн савыг шууд живүүлэн дээж авч болно. Гүний усны байнгын урсацтай нээлттэй цооногийг шууд аналоги аргаар дээжилж болно.

3.9.2.9 Түр зуурын объектын дээжлэлт

Гидрогеологийн ба бохирдлын судалгааны үеэр зарим тохиолдолд түр зуур тоноглогдох, гүний усны дээж авах боломжтой судалгааны цооног, зонд нүхлэдэг. Тогтвортой хяналтын объектоос бага профиль, тоноглолын нүхэлсэн хэсэг орчимд хайрган шүүлтүүр байхгүй (хэрэв тоноглол ашиглагдсан бол), цооног ухах ба дээж авах хоорондын богино хугацааны интервал, цооног нүхлэснээс хойшхи хугацаагаар ялгаатай (эхний хэдэн цагуудад). Ийм объектууд нүхлэгдсний дараа өрөмдөгдсөн чулуулгийн зөөлөн фракцийн шавраас буюу цооног зайлсан үлдэгдлээс цэвэрлэгдээгүй байдаг. Эдгээр бүх байдал дараа нь гүний уснаас авсан дээжийн булингарт болон зарим нэгэн үр дүнд гажуудал илэрдэг. Ийм учраас эдгээр объектыг гол төлөв урьдчилсан судалгааны (В бүлэг) болон байнгын дээжлэгч объект байрлуулах төлөвлөгөөний зорилгоор ашиглах нь тохиромжтой. Дээжлэлтийн өмнө ийм объектуудын цэвэрлэгээнд эзэлхүүний арга ашиглагддаг ба дээжийг дээжлэгдэж буй объектын диаметрээс хамаарч боломжтой хэрэгслүүдээр (доогууруа дүүрдэг дээж авагч, перисталтик насос, инерцийн бүлүүрт насос, өөрөөр хийн шахуургат насос) авдаг.

3.9.2.10 Бага хэмжээгээр шахах арга

Уг аргыг ISO 5667-18 стандартад микропүржинг – micropurging гэж тэмдэглэсэн байдаг. Ном товхимолд дан ганц энэ аргад мэргэшсэн аргазүйн гарын авлагууд олон байдгаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болохуйцыг жишээлбэл: Low-flow (minimal drawdown) ground-water sampling procedures (Puls a Barcelona, U.S. EPA Groundwater Issue, U.S. EPA/540/S-95/504).

Аргын зарчим нь гүний ус тухайн газрын гидрогеологийн нөхцөл ба цооногийн хийцээс хамаарч колектороос тоноглолын нүхэлсэн хэсгийн эсрэг зүг руу урсаж болно гэсэн таамаглал дээр үндэслэсэн. Ийм тохиолдолд тоноглолын нүхэлсэн хэсэгт колекторын ойр орчмын нөхцлийг төлөөлөхүйц ус байж болно. Уг арга нь нүхэлсэн хэсгийн дээрх болон доорх цооног дахь зогсонги ус ба нүхээр байгалиараа урсан өнгөрөх усны маш бага холигдлыг ашигладаг ба 8 см-аас бага тулгуур нүхэлсэн хэсэгтэй цооногт голчлон зориулагдсан.

Дээжлэлтийн зорилгоор тогтмол суурилуулсан төхөөрөмжийг ашигласан тохиолдолд ч гэсэн цооногийг дээж авахын өмнө тодорхой хэмжээнд цэвэрлэх шаардлагатай. Шалтгаан гэвэл, усны баганы дээд хэсэгт хий атмосфертой солилцож болзошгүй, дээжлэгч төхөөрөмжийг оруулах үеэр усны багана холилдох эрсдэл, цооногийн ёроолын зөөлөн тунадаснууд хуйларснаар дээжийн булингар нэмэгдэх эрсдэл зэрэг.

Бага хэмжээгээр шахах аргаар цооног цэвэрлэхдээ тоноглолын нүхэлсэн хэсэгт ойролцоогоор төв рүү нь эсвэл төлөвлөгөөт дээж авах гүн рүү насос оруулан соруулж гүйцэтгэхийг зөвлөдөг. Цооногт насос оруулах үеэр болон насосын үйл ажиллагаанаас үүдэн булингар нэмэгдэж болзошгүй учир цооногийн ёроолд насос байрлуулахыг

зөвлөдөггүй. Гүний усны гадарга тоноглолын нүхэлсэн хэсэгт байгаа, мөн дээж уг түвшнээс авагдах тохиолдолд усны баганы дээд хэсэгт насос байрлуулахыг зөвлөдөг.

Уг аргын үндэс болох бага урсгал нь гарц хоолойноос урсан гарах хурдаас бус, харин дээжлэгдэж буй цооног руу урсан орох усны хурдаас хамаардаг. Дээжлэгдэж буй цооног руу орох усны хурд колектор дахь урсгалын хурдтай ойролцоо байх ёстой. Уг аргын зорилго нь колекторт шахалтаар үүссэн даралтын өөрчлөлтийг багасгахад оршино. дээжлэлтийн үеэр дээжлэгдэж буй объект дахь гүний усны гадаргын бууралт хуучин байсан тогтвортой төлөвтэй харьцуулахад аль болох бага (0,1 м-ээс бага байх нь тохиромжтой) байхад гарсан дээд хэмжээ нь сайн үзүүлэлт болно.

Уг дээжлэлтийн аргад жишээлбэл: хийн шахуургат насос (bladder pump), тохируулах боломжтой хурд бүхий төвөөс зугтагч насос болон цахилгаан ороомгон насос зэрэг шахах усыг удирдах боломжтой шахуургын насосуудыг зөвлөдөг.

Перисталтик насос нь зарим нэг эх сурвалжаар ууссан хүчилтөрөгчийн агууламж, pH ба оксидацийн редукцийн чадамжид нөлөөлж болзошгүй хэмээн анорганик аналитын тулд бага зэргийн гүний шахалтад ашиглагддаг. Цооног цэвэрлэх ба дээж авах зорилгоор шахах зөвлөхүйц хэмжээ нэвчилтийн ердийн нөхцөлд 0,1 - 0,5 л.мин$^{-1}$, хэт их нэвчилттэй тунадасын хувьд 1,0 л.мин$^{-1}$ хүрч болно. 0,1 л.мин$^{-1}$ –с бага хэмжээгээр шахсан тохиолдолд зарим төрлийн насосыг (ялангуяа цахилгаан хүчээр ажилладаг) гэмтээж болзошгүй тул дээжлэх ажилд тохиромжгүй юм. Шахагдсан хэмжээг дээжлэгдэж буй цооног дахь гүний усны гадаргын бууралтаас хамааруулан, уг бууралт 0,1 м-с хэтрэхгүй байхаар зохицуулна.

Цооногийн цэвэрлэгээний шалгуур үзүүлэлтийг үнэлэх зорилгоор параметруудын (pH, цахилгаан дамжуулах чанар, ууссан хүчилтөрөгчийн агууламж, оксидаци – редукцийн потенциаль, дулаан ба булингар) хэмжилтийг урсгалын хил дээр хийх ба дээж авалт тус бүрийн хооронд бохирдолгүй болгон цэвэрлэж байх ёстой. Урсгалын хилийн бохирдолгүйжүүлэлт, цэвэрлэгээг дээж хоорондын бохирдлоос төдийгүй хэмжилтийн үнэн зөв байдал болон хэмжигдсэн параметрууд хурдан тогтворжих үүднээс хийж гүйцэтгэх шаардлагатай.

Хэмжигдсэн параметрууд тогтворжсны дараа дээжлэгч насосын гарах хэсгээс дээжийг дээжийн саванд хийж авна.

3.9.2.11 Цооног дахь түвшний ажиглагдахааргүй бууралттай, бага хэмжээгээр шахах арга

Энэхүү арга нь өмнөхтэй адил таамаглал дээр тулгуурласан болно. Ялгаа нь зөвлөхүйц шахах хэмжээний хамгийн бага утганд ч (0,1 л.мин$^{-1}$) усны түвшин тогтворжилгүй улам буурсаар байдагт оршино. Үүний шалтгаан чулуулгийн орчны нэвтрэх чанар бага, эсвэл хяналтын объектын тохиромжгүй хийцэд орших бөгөөд шахсан хэмжээ ба объект руу орох урсгал тэнцвэрждэггүй. Цооногт их хэмжээний бууралт гарснаар дээжүүд дэх булингар нэмэгдэх үр дагавартай.

Чадамж багатай цооногийн дээжлэлтэд тохирох оновчтой насос сонгох шаардлагатай, учир нь жишээлбэл: эргэлтэт цахилгаан насосын хувьд шахсан хэмжээний бууралт нь түүнийг эвдрэхэд хүргэдэг (насос зогсоно).

Ийм нөхцөлд дээжлэлтийн зорилгоор тогтвортой суурилуулсан дээж авагч болон дээжлэгч насос ашиглахыг зөвлөдөг, яагаад гэвэл, ингэсэн тохиолдолд дээжлэгдэж буй

объектын цэвэрлэгээнд шаардагдах хугацаа богиносох юм (дээжлэгч төхөөрөмжийг оруулах үеэр усны багана холилдохгүй). Хэрэв зөөврийн төхөөрөмж ашиглагдсан бол, түүнийг дээжлэгдэж буй объектод хөвөх хэсгүүд тунахад хүрэлцэхүйц, ядаж 48 цагийн өмнө суурилуулвал (оруулвал) тохиромжтой. 48 цагийн дараа объектыг цэвэрлэж дээж авах ажлыг гүйцэтгэнэ.

Дээж авах ажлыг цооног цэвэрлэгдснээс хойш 2 цагийн дотор хийж гүйцэтгэх нь тохиромжтой.

Ямар ч тохиолдолд цооног шахагдаж дуусах, эсвэл гадарга нүхэлсэн хэсэгт тулгуурын түвшнээс доош буурахаас зайлсхийх нь зүйтэй. Хэрэв энэ нөхцлийг баримтлах боломжгүй бол дээжлэлтэд өөр арга сонговол илүү тохиромжтой, ж.нь: пассив дээж авагчууд.

3.9.2.12 Эзэлхүүний хувьд дундажлагдсан дээж авах

Энэхүү нэр 8 м-с урттай тулгуурын нүхэлсэн хэсэгтэй объектод зориулагдсан, түгээмэл ашиглагддаг дээжлэлтийн аргыг тэмдэглэнэ. Уг арга, цооногуудыг цэвэрлэх үеэр нүхэлсэн хэсгийн зузаанаар дамжин цооног руу орох ус холилдоно гэж тооцоолдог. Зөвхөн **холимог дээж** авах боломжтой. Чулуулгийн бүсийн босоо чиглэл дэх гомогенийн бус байдлаас үзэхэд эцсийн дээжид бага нэвчилттэй давхаргатай харьцуулбал, өндөр нэвчилттэй давхаргаас гаралтай хэсгүүд илүү их хувийг эзэлнэ.

Дээж авахын өмнөх цооногийн цэвэрлэгээнд эзэлхүүний арга ба өмнөх аргад тохирох хэмжээнээс илүү шахсан ус ашиглагддаг. Цэвэрлэгээнд (мөн дээж авалт) цахилгаан, төвөөс зугтагч болон ороомгон насос өргөн ашиглагддаг. Цэвэрлэгээний үеэр цооногийн тоноглолд дээжлэлтийн өмнө хуримтлагдсан, усны баганыхаас 3 – 5 дахин их эзэлхүүнт ус объектоос алга болдог.

Дээжлэлтийн энэ төрлийг харамсалтай нь дээжлэлтийн стандарт аргад тооцдог.

Уг аргыг ашигласан ч объект цэвэрлэх, дээж авахад дээжлэгдэж буй объект дахь гадаргын хэт их бууралтаас сэргийлэх зорилгоор аль болох бага хэмжээний ус ашиглах нь тохиромжтой. Ямар ч тохиолдолд объект хоосроход хүрч болохгүй бөгөөд зөвшөөрөгдөх хамгийн их гадаргын бууралт цооног дахь усны баганы 1/3 болно. Хэт их хэмжээгээр буурах, ялангуяа гүний усны гадарга тоноглолын нүхэлсэн хэсэгт байгаа бол дээжийн булингар нэмэгдэх ба улмаар дээж агааржуулагдах (хэрэв ус цооногийн ханаар урсаж байгаа бол) сөрөг үр дагаварт хүрч болзошгүй юм.

Цооног цэвэрлэгдснээс хойш 2 цагийн дотор дээж авах нь хамгийн тохиромжтой бөгөөд цэвэрлэгээ ба дээж авалт хоорондын хугацаа ямар ч тохиолдолд 24 цагаас хэтрэх ёсгүй. Уг арга нь бага нэвчилттэй орчинд тохиромжгүй бөгөөд зөвхөн холимог дээж олгодог.

3.9.2.13 Пассив диффузын дээжлэлтийн систем

Пассив диффузын дээж авагчууд нь зарим аналитуудын урт хугацааны дээжлэлтэд ашиглаж болохуйц, дээжлэгч төхөөрөмжийн харьцангуй шинэ бүлэг юм.

Дээжлэгч төхөөрөмжийг ажиглагдаж буй объект, тоноглолын нүхэлсэн хэсэг рүү оруулж урт хугацаагаар (хэдэн арван цагаас хэдэн өдөр) экспозицод байна. Дээж авагчийг гүний устай хүрэлцэх бүхий л объектод (худаг,резервуар, ундарга) ашиглах боломжтой. Пассив диффузын дээж авагчуудын хэрэглээ зөвхөн дээжлэгдэж буй объектоор гүний ус илт урсах тохиолдлуудаар хязгаарлагддаг.

Давуу тал нь дээж авалтын өмнө объектыг цэвэрлэх шаардлага үгүй болж байгаа явдал бөгөөд зарим тохиолдолд хугацааны хувьд дундажлагдсан шинж чанартай дээж авч болно. Үүнээс гадна объектоос авсан дээжийн нөлөөнд автаагүй гүний усны урсгалд дээжлэлт хийх боломжийг санал болгодог. Өөр нэгэн давуу тал гэвэл, хэд хэдэн дээж авагчийг нэг цооногт дээр дээрээс нь хийж суурилуулах боломж ба ингэснээр ажиглах аналитын агууламжийн давхаргыг өөрчлөлтгүй, байгалийн чигээр нь шинжлэх боломж юм. Дутагдалтай тал гэвэл, зөвхөн хэдхэн төрлийн аналитуудаар хязгаарлагддаг. Дээж авагч гүний усны үндсэн найрлагын тухай мэдээллийг олгож чадахгүй.

3.9.2.14 Урт хугацааны турш шахагдсан объектууд

Урт хугацааны турш шахагдсан объектуудын (нөхөн сэргээлтийн цооног, худаг) дээжлэлт нь усны ундарга ба урсацтай цооногийн дээжлэлттэй төсөөтэй. Бүх тохиолдолд дээж авахын өмнө цооногийг цэвэрлэх шаардлагагүйгээр холимог дээж авах боломжийг өгдөг.

Урт хугацааны турш шахагдсан объектуудаас тусгай, хоолойн арматурт байрлах, зориулалтын хавхлагаар дээж авдаг. Хэрэв хоолой иймзориулалтын хавхлаггүй бол шахах хоолойн гарц дээр шууд дээж авч болно.

Шахагдсан хэмжээ агааржилтгүйгээр дээж авах боломж олгохгүй тохиолдолд туслах уян (инертийн ба цэвэрлэгдсэн) хоолой ашиглах ба түүний нэг төгсгөлийг шахах хоолойд холбож нөгөө төгсгөлөөр нь дээжийн савыг дүүргэнэ. Дээжийн савыг дүүргэхэд ашиглах усны цацрагийн өргөн дээжийн савны амсрын диаметрийн ⅔-оос хэтрэхгүй байвал зохино. Дүүргэлтийн туслах хоолойноос гоожих урсгал ламинар урсгалын (усны „жигд“ урсгал) шаардлагыг биелүүлэх ёстой.

3.9.2.15 Гүний усны дээжлэлтийн үеэрх онцгой тохиолдлууд

Хийжсэн дээжүүд

Уусан хийнүүд нь байгаль дээр орших бүх усанд байдаг хэсэг юм. Гүний усны бүх дээжүүдэд нүүрс-хүчилтөрөгч байхаас гадна метан, бохирдсон орчинд этан, этилен, винилхлорид, сульфан, радон болон энгийн устөрөгч зэрэг уусан байх нь элбэг тохиолддог. Түгээмэл тохиолдох хийнүүдийн дундаас гүний усны үндсэн найрлагын карбонатын тэнцвэрт нөлөөлдөг тул нүүрс хүчлийн хийн уусан агууламж (гидроген-карбонатын анион нь гүний усны гол ионтуудын нэг) чухал.

Гүний ус, атмосферийнхээс өндөр нүүрс хүчлийн хийн парциал даралттай тэнцвэрт орших нь түгээмэл. Гүний усан дахь CO_2-ын эх үүсвэр ихэнхдээ органик материалын эрдэсжсэн хэлбэр байдаг. Гүний усан дахь CO_2-ын агууламж нэмэгдэх нь органик антропогенийн бохирдлын биологийн задралтай холбоотой.

Зарим тохиолдолд уусдаг хийн хөрсний орчинд элбэг орших тухайн хийн парциал даралтад тохирох хэмжээнээс илүү өндөр концентрацитай гүний устай тааралдаж болно.

Зарим тохиолдолд уусдаг хийн даралт атмосферийн даралт буюу 0,1МПа -аас илүү байж болно. Ийм тохиолдолд, гадаргын нөхцөлд хий дан хийн фазын бөмбөлгөн хэлбэрээр дээжээс чөлөөлөгдөн гарч болзошгүй (хий алдалт).

Дээж хийгүйжих үзэгдэл нь pH-н өөрчлөлт, зарим минералын бөөгнөрлийг оруулаад усны химийн найрлагын эргэлт буцалтгүй өөрчлөлтүүдтэй холбоотой.

Хийжсэн усны дээжийн шинжилгээний чанартай үр дүн дээж авах оновчтой аргаас зайлшгүй хамаарна.

Уусан хийн нийт даралт атмосферийн даралтаас хэтэрч дан хийн фаз чөлөөлөгдөх тохиолдолд хоёр фазыг хоёуланг нь авах нь чухал. Үүнд фазын янз бүрийн сепараторыг ж.нь: Марриотевын лонхны зарчим дээр үндэслэн ашиглаж болно.

Хэрэв нүүрс-хүчлийн хийн өндөр агууламж илэрвэл гидрохимийн параметруудын (ялангуяа pH) талбайн хэмжилт хийж, дээж авсны дараа талбай дээр шууд нүүрстөрөгчийн системийн найрлагын хэлбэрийг KNK4,5 ба ZNK8,3 титрлэлтээр тогтоох шаардлагатай. Маш дэгдэмхий сульфаны агууламжийг дээж авсны дараа шууд ж.нь кадмийн ацетатаар тунадасжуулж хадгалах хэрэгтэй.

Сульфан, нүүрс-хүчлийн хий, метан зэрэг дээжүүд чөлөөлөгдөж болзошгүй тохиолдлуудад хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах нь чухал.

Уусан хий тодорхойлохоор дээж авахад сөрөг даралтын зарчмаар ажилладаг бүх дээжлэлтийн төхөөрөмжүүд (ж.нь: перисталтик насос) болон ашиглалтын үед дээжийг агааржуулж болзошгүй дээж авагчууд (халих цилиндр) тохиромжгүй.

Бохирдсон газар нутаг дахь дээжлэлт

Бохирдсон газар нутагт дээжлэлт хийхдээ бага бохирдолтой объектуудаас эхлэн, их бохирдолтой объектууд руу шилжин ажиллах шаардлагатай. Дээжийн сав, дээж авагчидтай харьцахдаа дээж авалтын хооронд байнга сольж байх ёстой нэг удаагийн, мэс заслын зориулалттай бээлий өмсөхийг зөвлөдөг.

Дээжлэгдсэн объектод, гүний усны гадарга дээр нүүрс-устөрөгчийн дан, шингэн фаз илэрвэл ийм фазад орших гүний усны төлөөллийн дээж авахгүй. Гүний усны гадарга дээр нүүрстөрөгчийн чөлөөт фаз илэрсэн ямар ч тохиолдолд фазын хүрээний цахилгаан детектороор эсвэл нэвт харагдах материалаар хийгдсэн, доогууруа дүүрдэг ус шавхагч ашиглан давхаргын зузааныг хэмжих шаардлагатай.

Бохирдуулагчийн дан шингэн фазаар бохирдсон хэрэгсэл, дээж авагчуудыг газар дээр нь бохирдолгүйжүүлэх боломжгүй. Иймээс бохирдсон газар нутагт нэг удаагийн дээж авагч, хэрэгслүүдийг ашиглавал зохино.

Бохирдуулагчийн аюултай байдлын шинж чанараас үзэхэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнд анхаарал хандуулах шаардлагатай.

3.10 Хаягдал ус

3.10.1 Дээж авах үндсэн аргуудын хураангуй

Хаягдал болон ундны усны дээж авалт нь байгаль орчны салбарт хамгийн түгээмэл хийгддэг дээжлэлтэд ордог ба үүнээс үзэхэд, хаягдал усны дээж авах журам хамгийн нарийн боловсруулагдсан журамд тооцогддог.

Нөхөн сэргээлтийн ажлын үүднээс реципиент рүү асгаж буй нөхөн сэргээсэн усны чанарыг хянах нь чухал.

3.10.1.1 Гар дээж авалт

Гар дээж авалтад дараах зүйлүүд ашиглагддаг:

- дээжийн сав,
- дээжлэлтийн төхөөрөмжид бэхлэгдсэн дээжийн сав (телескопик саваа г.м),
- эзэлхүүнт дээж авагчид (саваа эсвэл төмөр утсанд бэхэлсэн дээжийн савнууд).

Гар аргаар ихэвчлэн энгийн дээж, богино хугацааны интервалд хуримтлагдсан дээж авдаг.

3.10.1.2 Автомат дээж авалт

Автомат дээж авалтад дараах төрлийн дээж авагчуудыг ашигладаг:

1. зөөврийн дээж авагчууд (сөрөг даралтын соролт, перисталтик насос),
2. суурин дээж авагчууд (зөөврийнхтэй зарчмын хувьд адил боловч байнга идэвхтэй хөргөгдөж байдгаараа ялгаатай).

Тэдгээрийг тасралтгүй дээжлэлтэд ашиглаж болох хэдий ч ажиглагдаж буй хаягдал усны гоожих хэлбэрт тохирсон, урьдчилан сонгосон программын дагуу хуримтлагдсан дээж авахад байнга ашигладаг.

Бүхий л тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг сайтар бохирдолгүйжүүлж, дээжийн савнуудыг шаардлагатай туршилт хийж гүйцэтгэх лабораторит үргэлж бэлдсэн байх ёстой.

Хэрэв хаягдал ус уусаагүй бодисууд агуулж байвал тэдгээрийг дээж авсан савнаас дээжийн сав руу юүлэгдэн орох, дээж хуваагдахад ихээхэн анхаарал тавих хэрэгтэй. Үүнийг зарим тохиолдолд тусгай төхөөрөмжгүйгээр гүйцэтгэх боломжгүй. Уусаагүй бодисууд нь хурдан тунах ба дээжийн хэсэг бүр ихээхэн ялгаатай болно. Хэрэв дээжийг автомат дээжийн төхөөрөмжөөр буюу зөвхөн насосоор авбал сорох хурд дээж авч буй усны урсгалын хурдтай адил байх ёстойг бодолцож үзэх нь зүйтэй.

Үүний адилаар зарим нэгэн тохиолдолд холимог дээжийн хуримтлуулах үеэр дээжийн хөргөлтөнд анхаарах хэрэгтэй. Үүнийг голдуу гадны нөлөөгөөр задрах органик бодисын агууламж ихтэй усанд, буюу pH > 8,5 байхад аммиакийн азотыг зөвлөдөг.

Зарим үзүүлэлтүүдэд хаягдал усыг хадгалах хэрэгтэй болдог [EN ISO 5667-3 үзнэ үү].

3.10.1.3 Усан бус шингэн төлөвт дээжлэлт хийх

Дээжлэгдэж буй системд устай холилдохгүй шингэн фаз (буюу NAPL) илрэх нь дээж авах техник төдийгүй, гүйцэтгэсэн шинжилгээний төлөөлөх чанарын үүднээс ч асуудал учруулдаг.

NAPL-ийн фазтай хүрэлцсэн усанд NAPL-ийн ууссан найрлагын концентраци ханасан уусмалд тооцогдох ёстой (олон найрлагат NAPL-ийн хувьд, найрлага тус бүрийн уусалт Раоултын хуулиар зохицуулагддаг). Шинжилгээний үр дүн чөлөөт фазын ямар хэсэг эцсийн шинжилгээний дээжид орохоос хамаарч гажуудна.

Дээжлэгдэж буй орчин дахь NAPL-ийг дээжлэгдэж буй усны гадарга дээр анзаарагдахуйц, хуурсан хальс эсвэл давхарга үүсгэдэг, усныхаас бага нягттай NAPL-

ийн тохиолдолд (буюу L-NAPL), дээжлэгдэж буй системийн (гидрогеологийн колектор, гадаргын усны биет эсвэл усны урсгалын) сууринд бөөгнөрдөг, усныхаас илүү нягттай шингэн фазын тохиолдлоос (D -NAPL) илүү хялбархан илрүүлэх боломжтой байдаг.

Хэрэв орчинд NAPL-ийн фаз илэрсэн бол, чанарын шинжилгээний зорилгоор гадаргаас эсвэл фазын дээжийн системийн ёроолоос (суурь) авбал тохиромжтой. Ямар ч тохиолдолд ийм объектын дээжлэлтийн өмнө усны гадарга эсвэл системийн суурьт байгаа NAPL-ийн фазын давхаргын зузааныг хэмжих шаардлагатай. Уг зорилгод фазын хүрээний цахилгаан детектор, эсвэл тусгай вариант болох нэвт харагдах материалаар хийгдсэн, доогууpаа дүүрдэг дээж авагч ашиглаж болно.

Тэмдэглэл: Гүний усны гадаргад, эсвэл гидрогеологийн цооногийн сууринд илэрсэн NAPL фазын давхаргын зузаан чулуулгийн бүс дэх NAPL фазын давхаргын зузаанаас илүү байдаг. Гүний усны гадарга дээрх NAPL фазын давхаргын бодит зузааныг тогтоохын тулд жишээлбэл „bail–down test“ ашиглавал тохиромжтой. Дэлгэрэнгүйг мэргэжлийн ном хэвлэлд олж болно.

Нүүрс-устөрөгчийн шингэн фазын дээж авалт техникийн үүднээс асуудалтай. Учир нь өөрийн физик – химийн шинж чанараар дээжлэгч төхөөрөмжийн гадаргад шингэх хандлагатай байдаг бөгөөд бохирдсон дээжлэгч төхөөрөмж нь дараагийн авсан дээжийг бохирдуулж болзошгүй юм. NAPL-р бохирдсон дээжлэгч төхөөрөмжийг талбай дээр найдвартай бохирдолгүйжүүлэх боломжгүй ба зарим хэсгүүдийг лабораторийн нөхцөлд ч бохирдолгүй болгох боломжгүй (ж.нь: урт шланк).

Гүний усны гадаргаас дээж авахад халих цилиндрийг давуу талтайгаар ашиглаж болох ба гадаргын усны хувьд эзэлхүүнт дээж авагчуудаас аль нэгийг ашиглах эсвэл дээжийн савнаас шууд дээж авч болох юм.

Дээжлэгдэж буй системийн сууриас D-NAPL дээжийг нээлттэй, доогууpаа дүүргэгддэг дээж авагчаар авч болох бол, дээжлэгч насосуудаас хийн шахуургат насос эсвэл инерцийн насос зэрэг хямд, нэг удаагийн хэрэглээний төрлүүд тохиромжтой. Гидрогеологийн цооногийн сууриас NAPL дээжлэх тохиолдолд бохирдсон дээж авагчтай харьцах үеэр цооногийн тоноглол агшин зуур бохирдож болзошгүй эрсдлийг анхааруулах нь зүйтэй.

NAPL-тай төстэй тохиолдлууд нь хатуу анорганик фазад, саатуулагдсан фазад эсвэл уусмалаас тунах фазад тохиолдож болно.

Эдгээр найрлагууд (жишээ нь: шаврын минерал, тунадас г.м) нь дээжид байх тэдгээрийн жигд бус төлөөллийн дүнд үр дүнг гажуудуулж болох ба үүний зэрэгцээ бусад найрлагуудтай харилцан үйлчлэх харьцангуй том, реактив гадаргууг олгодог (ж.нь: хүнд металлыг шингээх).

3.10.1.4 TOL тогтоох зорилгоор дээж авах

Ууссан хий, TOL тогтоох дээжийг дээжийн авсан хэсэг тус бүрийн хуримтлалыг бүрдүүлж болохгүй. Чанарын үнэлгээг зөвхөн тохирох аргаар авсан энгийн дээжүүдэд үндэслэн гүйцэтгэж болно. Энэ нь дээж авах үеэр хөөсөрч болохгүй ба дээжийн сав дүүрсэн даруй дээжийн савны ёроол руу оруулж, хаах үед дээжийн савнаас агаарыг шахан гаргадаг хоолой эсвэл гуурны тусламжтай, агаарын бөмбөлөг үүсгэлгүйгээр сайтар хаах ёстой гэсэн үг юм.

Энгийн дээжүүдийг ихэвчлэн гар аргаар авдаг боловч „bladder pump“-г ашиглан дээж аваад, авсан дээжүүдийг тусгай хуруу шилэнд хадгалдаг, TOL тогтоох зориулалттай автомат дээжлэгч бий. Тэдгээрийг голдуу тус тусад нь шинжилдэг.

3.11 Агаар болон агаарын массаас дээж авах

Экологийн ачаалалтай холбоотой төслийг шийдвэрлэх үеэр ажиллах орчны агаарын чанарт ажиглалт хийхтэй холбогдуулан агаар болон агаарын массаас дээж авах, хэмжилт хийх нь шинжилгээний харьцангуй төвөгтэй үе шатуудыг техник болон дээж авах мэргэжлийн хувьд хүнд үе шаттай хослуулдаг учраас дээж авах нарийн төвөгтэй технологид ордог. Хатуу ба шингэн матрицаас дээж авдагтай харьцуулвал, дээж авах тохиромжтой аргын нөхцөл нь дээж авах, дээжтэй харьцах үеэр химийн эсвэл физикийн ажиглагдах параметруудыг өөрчлөхгүйн тулд тухайн авсан матрицын материал дээр тогтоох/шинжлэх ажлыг шууд гүйцэтгэх байдаг бол, харин агаар болон агаарын массаас дээж авахад агаарын массын (хий, уур, аэросол, тоосонцрууд г.м.) дээжийг аналитик туршилт хийж болохуйц болгон засварлах (ж.нь: тохирох орчинд шингээн авах, шүүлтүүрээр барих г.м) шаардлагатай байдаг.

Агаар болон агаарын массаас дээж авахад гардаг хоёр дахь чухал ялгаа нь зарим нэгэн үзүүлэлтүүдийн концентраци харьцангуй бага байдаг явдал бөгөөд энэ нь агаарын эзэлхүүнээс ихээхэн хэмжээгээр авахад хүргэдэг (ж.нь: сул агаарт PCDD/F–н агууламжийг тогтоох). Эдгээр тохиолдлуудад их урсгалтай дээжийн төхөөрөмж ашиглах эсвэл цаг хугацааны хувьд хүндрэлтэй хэмжилт хийх, дээжлэлтийн пассив техникүүдийг ашиглах нь тохиромжтой.

Сорогдсон эзэлхүүний, өөрөөр хэлбэл авсан дээжийн хэмжилт нь агаар болон агаарын массын хэмжилтийн чухал хэсэг мөн, өөрөөр хэлбэл шинжилгээний үр дүн эзэлхүүнээс хамаардаг.

Иймээс хэмжилтийн үеэр агаар шахах хурдыг сонгох, түүний тогтвортой байдлыг хангах боломжтой, туршигдаж байсан эсвэл баталгаажсан төхөөрөмж ашиглавал зохино.

Агаар болон агаарын массаас дээж авах үед өөр бусад хэмжигдэх нэгжүүд нь дээжлэгдэж буй матрицын дулаан болон даралт болно. Хэмжилтийн үр дүн голдуу хэмжигдсэн утгуудыг шилжүүлэх ердийн нөхцлөөс хамаардаг.

Агаар болон агаарын массын параметруудын хэмжилт (ж.нь: имис тогтоох шаардлага, ажилтан нарын экспозиц, дотоод агаарын хэмжилт) нь маш нарийн төвөгтэй салбар бөгөөд хэмжилтийн үр дүн дээж авахад ашиглагдсан аргаас (ж.нь: тохиромжгүй колектор, шахалтын урсгал, нийт сорогдох эзэлхүүн, цаг уурын нөхцөл г.м.) ихээхэн хамаарна. Эдгээр шалтгааны улмаас дээж авах журам ба дараах аналитик туршилтууд стандартчлагдсан байдаг (ж.нь: экспозиц хэмжих журам – NIOSH, OSHA, ISO зэргээс боловсруулагдсан аргачлалууд, U. S. EPA-н боловсруулсан имис хэмжих аргазүй г.м). Зарим тохиолдолд (ж.нь: хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай тогтоомжуудын дагуу ажил хөдөлмөрийн ангиллын зориулалтаар ажилтнуудын экспозиц хэмжих үед) туршилт (дээж авалт ба анализ) чанарын аюулгүй системтэй (магадлан итгэмжлэгдсэн, эрх олгогдсон г.м), хүчин төгөлдөр журмаар баталгаажсан байхыг хууль тогтоомжоор шаарддаг.

Агаар ба агаарын массын дээж авалт голдуу зориулалтаасаа шалтгаалан дараах бүлгүүдэд хуваагддаг:

1. хөрсөн дэх агаарын хэмжилт,
2. имисийн хэмжилт (чөлөөт агаар мандал дахь бохирдуулагчийн концентрацийн хэмжилт),
3. эмисийн хэмжилт (хаягдал хийн дэх бохирдуулагчийн концентрацийн хэмжилт),
4. ажиллах орчны агаарын бохирдлыг тогтоох зорилгоор хийх хэмжилт,
5. дотоод агаарын чанарын хэмжилт.

Уг аргачлалын хязгаарлагдмал байдал, ерөнхий асуудлын техникийн болон мэргэжлийн төвөгтэй байдал, экологийн ачааллын асуудлыг шийдвэрлэхэд дээр дурдагдсан дээж авах бүлгүүдийн хэрэглээний хязгаарлагдмал байдал зэргээс шалтгаалан сэдэв хоёр хэсэгт хуваагдсан болно:

- хөрсөн дэх агаарын хэмжилт (атмогеохимийн аргууд)
- ариун цэврийн мониторинг – нөхөн сэргээх ажлын хүний эрүүл мэндэд үзүүлэх чадамжит нөлөөний хэмжилт.

3.11.1 Судалгаа, нөхөн сэргээлт ба хяналтын ажлын атмогеохимийн аргууд

Дэгдэмхий бодисоор бохирдсон чулуулгийн бүс ба гүний усны бохирдлыг дээж авалт дээр тулгуурлан чанар ба тоон хэмжээний хувьд харьцангуй сайн тодорхойлох боломжтой. Хөрсөн дэх дэгдэмхий бодисын (TL) концентрацийг тогтоох тохиолдолд, дээж авалтын үеэр (ж.нь: чулуулаг гэмтэх, түүний хэт халсны дүнд г.м) TL алдагдах, чулуулгийн бүсэд байгаа бохирдлын төлөөлөл буруу гарахад хүрч болзошгүй олон асуудлууд тохиолдоно.

Түүнчлэн өрөмдлөгийн ажилтай холбогдох зардлууд өндөр байдаг. TL бохирдлыг түүний хамрах хүрээний хамт өрөмдлөгийн ажил, хөрсний дээж авалт, хяналтын цооног байгуулах зэргийн тусламжтайгаар тогтоох нь зарим тохиолдолд санхүүгийн хувьд үр ашиггүй байдаг.

Ханаагүй бүс эсвэл гүний ус бохирдсон үед TL эдгээр бодисуудын шинж чанар (уурын даралт, Генрийн тогтмол, усанд уусах чанар г.м) ба хөрсөн дэх агаарт тархсан бохирдлын ерөнхий түвшингээс хамааралтай болдог.

Гадаргын доорх TL бохирдол нь хөрсөн дэх агаарт бохирдлын эх үүсвэрээс эхэлсэн, бохирдуулагчийн концентрацийн градиент /аажим бууралт/ үүсгэдэг.

Зөвхөн гүний ус бохирдсон байвал хөрсний агаарт тэдгээрийн концентраци гүний усны гадаргаас газрын гадарга руу босоо чиглэлд буурна. Үүний адилаар, хөрсний агаарт хэвтээ концентрацийн градиент гүний усны бохирдол багасах чиглэлд буурдаг.

Амтогеохимийн судалгаа нь чулуулгийн орчин дахь бохирдлын урьдчилсан тодорхойлолт, талбайн үндсэн хязгаарлалт хийхэд, литологийн тааламжтай нөхцөлд маш үр дүнтэй, хүлээн зөвшөөрөгдсөн арга юм. Түүнийг мониторингийн ба судалгааны цооногууд байрлуулахад тохиромжтой байршил хайх, чулуулгийн орчин дахь

бохирдуулагч бодисын концентрацийн өөрчлөгдөх хөгжлийг хянах үеэр хэрэгжүүлэх боломжтой.

Атмогеохимийн аргыг ашиглах боломжууд:

- бохирдлын экспозицийг баталгаажуулах,
- бохирдлын тархалтын орон зайн үндсэн хязгаарлалт,
- ханаагүй бүс ба гүний усан дахь бохирдлын тархалтын хязгаарлалт,
- бохирдлын химийн шинж чанарыг олж тогтоох,
- бохирдлын эх үүсвэрийг илрүүлэх,
- гүний усан дахь бохирдлын шилжилтийн загварыг дүгнэх,
- бохирдлын химийн болон биологийн задралтай холбоотой, дагалдах бохирдуулагчуудыг хянах,
- нэг удаагийн бохирдуулагчийг байнгын болон урт хугацааны (үргэлжилж буй) бохирдуулагчуудаас ялгах
- дотор объект руу нэвтрэх нэвтрэлийг баталгаажуулахаар шинжлэх (indoor air sampling),
- нөхөн сэргээх технологийн төлөвлөлтийн зорилгоор хэмжилтийн ажил хэрэгжүүлэх (Soil Vapor Extraction, Bioventing Air Sparging г.м),
- нөхөн сэргээх ажлын үе шатны мониторинг,
- шатахуун түгээх станц РНМ, эсвэл химийн түүхий эдийн агуулахын ойр орчимд хийх бохирдлын алдагдлын мониторинг,
- ахуйн хог хаягдлын цэгийн ойр орчимд, чулуулгийн орчинд хог хаягдлын хийн мониторинг, өөрөөр хэлбэл түүний геологийн бүтэц эсвэл барилгын дотоод орчинд тархах тархацыг ажиглах,
- судалгааны эсвэл хяналтын цооногууд байршлыг оновчтой болгох.

Хөрсний агаарт байгаа дэгдэмхий бодисыг илрүүлэх үндсэн хоёр техникийн шийдэл бий:

1. хөрсний агаарыг дээжийн саванд шууд шахах (канистр, хийн вак, сорбент г.м) эсвэл шууд детектор, анализатороор –атмогеохимийн идэвхтэй аргууд,
hydrogeological structure	part of the geological environment in which groundwater continuously circulates; a particular structural geological unit (part of a geological space), which differs from the other parts of the geological space by self-contained, continuous circulation of groundwater (from supply areas, through the transit area up to the drainage area)
hydrogeologica insulator	a rock body, the permeability of which, compared to the neighbouring rock environment, is so much less that gravitational water cannot move so easily under otherwise identical hydraulic conditions; a rock body with significantly (order) lower permeability than the permeability of the rock mass in the immediate neighbourhood
hydrogeological collector	a rock body, the permeability of which compared to the neighbouring rock environment is so much greater that gravitational water can move more easily under otherwise identical hydraulic conditions; there are simple and composite collectors; this involves an environment enabling significant accumulation, flow or taking of groundwater
hydrogeological object	as a rule a borehole of a well that intervenes into an underground water collector and can be used for a survey or monitoring underground water or its pumping
hydraulic semi-insulator	a hydrogeological insulator situated in a rock environment in such a position that a large flow of undeground water flows under piezometric conditions into the attached collector
hydroisohypses	a line connecting points of equal elevation of the free surface of a ground water body changed at the same time
isopiestic line	a line connecting points of equal piezometric level of the tense levels changed at the same time
hydrogeologic balance	comparison of the increment and decrement of water and changes of water deposits in a basin, area or in a water formation during a stated time interval
hydrosphere	a system consisting of all water on the Earth (including water in the air) in all states of matter and forms
infiltration	process of penetration and movement of rainwater through a porous environment of the soil profile (infiltration)
infiltration area	area in a hydrogeological structure where surface water infiltrates from the earth's surface

	into the rock environment
interpolation	interpretation of results when describing the surface and spatial allocation of contamination, during which values are interleaved between two or more measured points
Jacob approximation of well water	a term from the field of groundwater water hydraulics and evaluating hydrodynamic tests (also imprecise Jacob simplification); simplification of Theis equation of permanent radial inflow to a well proposed by Jacob (1950) and based on an approximate Theis water well function W (u); the simplification can be used in most standard cases
collecting territory	the area in which water is taken (surface or underground) by a collecting object
capillary fringe	full saturation space in a rock environment above the saturated zone in which there is freely not movable, so-called capillary water (i.e. water kept by capillary forces) the pressure of which is lower than atmospheric pressure
coefficient of hydraulic conductance K	is equal numeric Darcy's speed pni unit hydraulic gradient, it has the unit of the speed and is expressed in ms-1; a no longer used synonym is the coefficient of filtration indicated k or kf
storativity coefficient (storage) S	the volume of water that can be removed from a hydrogeological collector; the storativity rate of a collector is defined as the volume of water which is released from the deposit in the collector from the unit area of the pni collector of unit decrease of piezometric level, without dimension, it is distinguished coefficient of flexible storativity Sp (in a ground water body with a tense level) and free storativity coefficient Sv (in ground water bodies with free surface). Sv is numerically equal to the effective porousness and is significantly higher than Sp.
transmissivity coefficient (flow rate) T	the extent of the ability of rock formations to transmit water; it is defined as the product of hydraulic conductivity K and the thickness of the ground water body; numerically equal to the volumetric flow rate per unit width of the collector saturation and watered thickness m at unit gydraulic gradient; expressed in m2s-1; is a measure of the use of a ground water body for collecting groundwater
underground water collector	space in a rock environment in which underground water may accumulate and a ground water body originate
conceptual model	principal information and received simplifying preconditions about defining the parameters of a hydrogeological structure and physico-chemical processes (e.g. related to the flow of groundwater or the the occurrence and spreading of contamination), which is based on compiling a mathematical model
contamination	presence of undesirable foreign substances (contamination) in a rock environment (water, rock, soil atmosphere).
contamination cloud	space in a rock environment where unwanted substances are detected above the level of local background
contaminant (pollutant)	presence of undesirable substances (contamination) in a rock component a rock environment (water, rock, soil atmosphere).
contaminated environment	area in which there are expected or already detected increased occurrences of extraneous (undesired) substances
karst permeability	permeability of the rock according to the existence of cavities
laminar flowing	flow, during which the trajectories of fluid particles are roughly parallel; groundwater flows at low speeds, at higher speeds the laminar character may break down and the flow can change into a turbulent flow.

lithosphere	rock layer of the Earth's crust formed by the uppermost layers of the Earth's shell
LNAPL´s	separate non-liquid phase (organic) substances with a density of less than water; most frequently oil substances and BTEX substances (aromatic hydrocarbons, arena)
specific electric conductance	ability of water to conduct an electric current; rate of the content of dissolved solids (simplified total mineralization); expressed in mS / m.
mineral water	groundwater that has specific physical and chemical properties distinguishing it from standard groundwater; according to Czech legislation (Spa Act no. 163/2001 Coll.), mineral water for medical use means naturally occurring groundwater with an initial purity of dissolved solids of at least 1 g / l, or containing less than 1 g / l of dissolved carbon dioxide, or also with another important for health chemical element or from a spring that has a natural temperature above 20 ° C and radon radioactivity above 1.5 kBq / l.
mobilit of the contamination	ability of an extraneous (undesired) substance to spread in any geological environment
monitoring	continuous or regular repeated monitoring of selected parameters, functions or changes of a system
filling test	type of hydrodynamic test during which the hydrogeological object is filled with water at atmospheric pressure
inhomogeneous geological environment	type of rock environment in which the invested localities contain different parts that cause principal (i.e. order) changes in the flow of underground water, contaminants and other pollutants
unsaturated zone	space in the rock environment between the ground surface and upper levels of the capillary fringe where the humidity is lower than the total porosity and the pressure level is less than 0
incomplete hydrogeological object	gydrological object with an open section that does not pass through the whole thickness of the water collector
area of supply of the watered system	area from which atmospheric rainwater flows out, ground or underground water into a water system
total outflow	sum of all outflow components passing the closure profile over the stated time interval
hypodermic outflow	part of the total outflow which outflows into the network of water that flows closely under the surface of the terrain out of the reach of underground water. This flow can be immediate or delayed according to the depth under the terrain and the throughput of the rock environment
underground water outflow	1. the flow of underground water because of the hydraulic gradient from supply areas into the outflow area, 2. the volume of underground water flowing out from the basin or another territorial unit per unit of time
surface outflow	part of the total outflow which flows from the basin into the network of water flows on the the surface of the relief

contamination point	space with a primary or secondary accumulation of substances in a rock environment
water system boundary conditions	hydraulic conditions governing the replacement of water between a water system and its surroundings (in the theory of hydraulics of underground water, boundary conditions I., II. and III. kind are distinguished). The material implementation of boundary conditions of a water system are the borders of the water system
oxidation - reduction potential Eh	quantitative indicator of oxidation - reduction state of natural water or the environment, expressed in volts or millivolts; can have positive or negative values; it depends on the concentration of the oxidized and reduced forms of the element, on the the temperature of the solution and partially on the pH.
piezometer	borehole designed to monitor the voltage at the selected depth of a ground water body or zonal monitoring water quality, opened only a short section of a defined depth
ground water body piezometric level	ideal area representing the geometric point at which the pressure of a ground water body is equal to the atmospheric pressure, i.e. the geometric place of piezometric levels changed or changeable in boreholes or piezometres in ground water bodies; the piezometric level of a tense ground water body is similar to an actual surface ground water body, i.e. free surface, but both areas can be identified; the piezometric level of a tense ground water body is referred to sometimes as the discharge level.
piezometric height	sum of the pressure and position height (i.e. the height of the pressure line above a selected comparison area).
under-surface water	includes all water in all states in the crust
underground water	liquid water naturally occurring below the Earth's surface in the saturation zone (in the saturated zone) in direct contact with the rock; groundwater is also considered to be water flowing through drainage systems and water in wells. In terms of hydrogeology, groundwater is generally regarded as water that is below the outside surface outside the saturated zone, i.e. in the capillary fringe and unsaturated zone. Sometimes, the incorrect term 'lower water' is used.
pore	a natural cavity in a rock. In the broader sense of the word, all the free spaces in a rock (pores, fissures, caverns); divided by the size of the pore into gravitational pores containing gravitational water, capillary bound water and capillary forces sub-capillary, where the water bound by adsorption forces prevail.
rock porosity	dimensionless number expressing the ratio of the volume of cavities (pores or cracks) in a rock to the total volume of the rock
surface water	water flowing on the Earth's surface or held in artificial tanks or natural depressions on the surface
surface outflow	part of the total outflow that flows from a basin into the network of water flows on the surface of the relief
observation borehole	monitoring borehole, hydrogeological object excavated by machinery used to measure the groundwater level, sampling and terrain measurements
spring	concentrated natural outflow of groundwater to the surface or below the surface of surface of hydrological formation

spring area	1 area with concentrated springs, which are in a mutual hydrological relation 2. inappropriate labelling of an area in water treatment slang
throughput	ability of a rock environment to transmit fluid by the effects of hydraulics
interstitial permeability	permeability of a rock environment, stated by the existence of interconnected pores through which fluid can flow under the influence of the hydraulic gradient
natural healing water	natural mineral water which has properties for healing use for which a certificate according to the spa law has been issued
natural attenuation	natural processes that decrease the content or concentration of a contaminant in a rock environment, for example, dilution, inter-phase changes (volatilization, precipitation), biological or chemical degradation, adsorption, diffusion-dispersion processes, etc..)
soil	natural layer on the surface arising from surface weathering and organic residues; unlike ground it is always enlivened by a crustal layer at the interface with the atmosphere
soil water	part of the sub-surface of water contained in soil, regardless of the state, generally does not create a continuous surface; is divided into water adsorption, capillary and gravity; establishes the overall soil moisture including free water vapour contained in the soil pores
fissure permeability	permeability of a rock environment, stated by the existence of interconnected pores through which fluid can flow under the influence of the hydraulic gradient
underground water outflow regime	summary of quantitative and qualitative changes of the characteristics of groundwater in time and space
groundwater distribution	imaginary line running through the uppermost of the piezometric groundwater level and distributing groundwater flow; it separates individual hydrographic basins; may have a different course from geographic (orographic) distribution
remediation hole	hydrogeological object excavated by machinery used to remedy a contaminated rock environment and groundwater (both remediation pumping, but for example, well water infiltration, injection of other fluids, etc..)
saturation zone	space in a rock environment, containing pores or cracks completely filled with ground water; the pressure altitude is greater than 0 and the humidity is equal to the total porosity
underground water level decrease	increase of the depth of the level of underground water because of artificial interference, most often by pumping or draining
probe	object excavated with hand tools to the unsaturated or saturated zone (probe drilling, classification, excavated)
specific yield	ratio of yield Q taken from the object (borehole, well) by pumping or draining the spillway size corresponding to a steady decrease in the level
rainfall	result of condensation or sublimation of water vapour in the air or on the ground surface, objects and plants
level state	distance to the surface of the selected measuring point (the edge of the casing, rings, etc..)

tracer tests	Examinations, by which the existence of hydraulic communication and the effective speed of the movement of ground water is ascertained so that a certain quantity of indicator is inserted into a borehole or another object (tracer), and by observing objects in the assumed direction of the flow, the presence of the indicator and the time changes of its concentration are monitored
well	excavated collecting object for gathering underground water
Theis equation	basic equations of unsteady flat radial flow into a well from which a constant yield Q is taken
transpiration	1 transition of water due to the physiological process of plants to air 2. volume or height of the layer of water released by plants during transpiration related to the specific surface area and a specific time interval
turbulent flow	flow, where the paths of individual particles are not parallel, they are chaotically woven and fluid particles, unlike laminar flow moving from one layer to another; flow occurs at higher speeds in larger cavities; turbulent groundwater flow occurs in very permeable rock e.g. near a well; a fully turbulent flow of groundwater under normal environmental conditions only occurs in karst rocks; this involves the typical flow of fast flowing water in a surface flow
full hydrogeological object	hydrological object with an open section that does not pass through the whole thickness of the water collector
water level	distance to the surface from the comparison line (typically from sea level) expressed in metres above sea level
infiltration object	hydrogeological object (borehole, well, probe, groove, trench, tank) into the unsaturated or saturated zone used to inject or infiltrate fluids into a rock environment
injection test	type of hydrodynamic test in which a hydro-object is filled with water or air at a pressure higher than atmospheric
yield of the spring (hg. of the object)	volume of ground water flowing out from springs (taken or ouflowing from hg. object) per unit of time (usually a second)
evaporation	volume or height of a layer of evaporated water related to a particular time interval and area
out-flowing	phenomenon or process of underground water out-flowing onto the earth's surface
infiltration borehole	object excavated by machinery into the unsaturated or saturated zone for injecting or infiltrating fluids into a rock environment
basic outflow	part of the overall outflow consisting of the outflow of underground water into the network of water flows
underground water source	groundwater in a hydrogeological collector (ground water body, water formation) used to abstract water; often incorrectly called 'own interceptor object' (well, borehole)

contamination source	place or space where extraneous (unwanted) materials were or are penetrating into individual components of the environment (a contamination source may be the presence of waste on the surface or underground or contaminated building structures)
ground	layer of rock on the Earth's surface, whose particles are not rigidly connected and compacted; it is a term superior to the term soil
contamination	condition where as a result of human activity in the environment, chemicals and other pollutants which is heterogeneous for the environment by their nature or concentration or volume
ground water body	continuous accumulation of groundwater in a rock-forming hydraulic single body (water formation) in the saturation zone; which may be free or tight surface
tense level ground water body	accumulation of ground water, which has a higher hydrostatic pressure than the atmospheric pressure
free level ground water body	accumulation of ground water the level (upper limit) of which is under the atmospheric pressure

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

МЭРГЭЖЛИЙН АРГА ЗҮЙН УДИРДАМЖ

Гидрогеологийн үндсэн зарчим

Агуулга

1 ӨМНӨХ ҮГ....3
2 ГИДРОГЕОЛОГИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ....4
2.1 Дэлхий дээрх усны илэрц ба түүний эргэлт....4
2.2 Газар доорх ус....4
2.3 Газар доорх ус ба чулуулаг хоорондын холбоо....8
2.4 Гидрогеологийн орчин дахь газар доорх усны хөдөлгөөн....10
2.5 Ан цавт чулуулгийн орчин дахь газар доорх усны хөдөлгөөний онцгой төлөв....11
2.6 Карст хөндий дэх газар доорх усны хөдөлгөөний онцлог чанар....11
2.7 Гидрогеологийн тогтоц ба тэдгээрийн горим....12
2.8 Газар доорх усны ундарга ба булаг....13
2.9 Газар доорх усны химийн ба физикийн шинж чанар....14
2.10 Гидрогеологийн судалгаа....14
3 БОХИРДЛЫН ГИДРОГЕОЛОГИ....17
4 ГИДРОГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АРГУУД....19
4.1 Гидрогеологийн зураглалууд....19
4.2 Гидрологийн аргууд....20
4.3 Зондын аргууд....22
4.4 Гидрогеохимийн аргууд....26
4.5 Гидродинамикийн туршилтууд....27
4.6 Математик загварчлал....29
4.7 Геофизикийн аргууд....32

Хавсралт

ЧУХАЛ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

1 ӨМНӨХ ҮГ

Гидрогеологи нь байгаль орчны ачааллыг арилгах үйл ажиллагааны нэгэн тулгуур болсон шинжлэх ухаан юм. Гидрогеологийн аргууд нь гол төлөв бохирдсон газар доорх усны нөхөн сэргээлтийн үеэр ашиглагддаг.

Гидрогеологи нь газар доорх усны үүсэл, илэрц, хөдөлгөөн, физикийн болон химийн шинж чанар зэргийг барилга байгууламж ба газрын хөрс шорооны найрлагатай уялдуулан судалдаг шинжлэх ухаан юм. Энэ нь усны менежмент ба байгаль орчин хамгаалах олон янзын даалгаваруудыг шийдвэрлэдэг, хөгжиж буй хэрэглээний геологийн шинжлэх ухаан юм.

Урьд өмнө түүний гол зорилго нь газар доорх усны эх үүсвэрийг хайх, түүний чанар ба ашиглагдахуйц хэмжээг үнэлэх, түүний тохиромжтой хэрэглээ ба хамгааллыг төлөвлөх зэрэг байв. **Харин одоо байгаль орчныг хамгаалах хүрээнд, мөн бохирдсон газрын (хуучин цэргийн баазын бохирдол, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн бохирдол, уул уурхайн олборлолтын ажлаас үүссэн бохирдол, газрын тос хадгалдаг агуулахын ойр орчмын бохирдол …) нөхөн сэргээлтийг шийдвэрлэх үеэр газар доорх усны хамгаалал ба нөхөн сэргээлтийн ажил зэрэг нь гидрогеологийн багагүй чухал зорилгод орох болсон.**

Дамжуулан өгч буй материал нь бохирдсон газруудыг арилгах үйл ажиллагаа явуулдаг ажилтнуудад тухайн асуудлыг дөхөм болгож өгөх зорилготой.

Уг материал нь бохирдсон газруудын гидрогеологийн судалгаанд ашиглагддаг гол зарчим, ойлголт, журам тус бүрийн хураангуйг агуулна. Түүнчлэн, эдгээр ажлуудын үеэр ашиглагддаг гол нэр томъёонуудын хураангуй тайлбар толь уг материалын нэг хэсэг болно.

Зураг 1: Байгаль дээрх усны эргэлт (эх сурвалж USGS)



2 ГИДРОГЕОЛОГИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

2.1 Дэлхий дээрх усны илэрц ба түүний эргэлт

Дэлхий дээр тохиох усыг **гидросфер / усан мандал** хэмээн ерөнхийлөн нэрлэдэг. Атмосфер дахь уснаас гадна дэлхийн гадаргуу дээрх болон гадаргуу доорх ус, организмуудад агуулагдах ус зэргийг хамруулна. Тэдгээрийн төлвийн өөрчлөлттэй холбогдох тогтвортой бус усны эргэлтийг **гидрологийн цикл** буюу усны эргэлт (маш хялбараар, далайн гадаргуугаас уурших усны ууршилт, хур тунадас, далай руу эргэн урсах урсгал) хэмээн нэрлэдэг.

Ууршилт, шилжилт, хур тунадас, гадаргын урсгал, гадаргуу доорх нэвчилт болон газрын гадарга дээрх ундарга зэргийн хооронд динамикийн тэнцвэртэй харьцаа үүсдэг – **гидрологийн баланс**.

Ус нь амьд бус байгалийн, байгалийн бусад эх үүсвэрүүдээс бүхий л нэгдлүүддээ нөхөн сэргэдгээрээ ялгаатай.

2.2 Газар доорх ус

Газар доорх ус нь газрын гадарга доор шингэн төлөвт орших бүхий л ус юм. Газар доорх ус гэдэг нь эрдэс болон чулуулгийн хэсгүүдтэй химийн эсвэл физикийн холбоостой ус биш юм. Газар доорх усыг **гидрогеологи** судална.

Газар доорх усны бүрэн эргэлт явагддаг геологийн орчинг гидрогеологийн тогтоц гэж нэрлэдэг. Чулуулгийн орчин дахь гүний усны үүсэл, илэрц, хөдөлгөөн ба найрлагад нөлөөлөх зүй тогтлын нэгдэл, мөн цаг хугацааны туршид тэдгээрийн өөрчлөгдөх үзэгдлийг **гидрогеологийн горим** хэмээн нэрлэдэг.

Атмосфертай шүргэлцэх хэсэгт, хөрсөнд агуулагдах усыг хөрсний ус гэх ба үүнийг **педологи /хөрс судлал/** буюу **гидропедологи** судалдаг. Газар доорх ус ба хөрсний усны бүхий л төлвийг цогцоор нь **гадаргын доорх ус** гэж нэрлэдэг.

Уусдаг бодисын ердийн агууламжтай газар доорх усыг ердийн ус гэж нэрлэдэг. Ийм усыг ундны усны эх үүсвэр эсвэл ундны ус болгон нийцүүлэхэд ашиглах түүхий усны эх үүсвэр болгон өргөнөөр хэрэглэдэг. Ердийн уснаас ууссан бодис, хий эсвэл дулаан, эсхүл физикийн өөр параметраараа (цацраг идэвхт) ялгаатай байгалийн усыг эрдэст ус гэж нэрлэнэ.

Газар доорх ус нь чулуулгийн хөндийд, оршдогоос хамгийн ач холбогдол бүхий нь зай завсар (нүх сүв), ан цав ба хөндийлж зэрэг юм. Хөндийн харьцангуй эзлэхүүнийг сүвэрхэг чанараар илэрхийлнэ. Ус нэвтрүүлэх чадварыг ус нэвтрүүлэх шинж чанар гэж нэрлэдэг. Хөндийн төрөл зүйлээс нь шалтгаалан чулуулгийг **зай завсрын, ан цавын ба хөндийлжийн** (Монголд маш бага тохиолддог) нэвтрүүлэх чанартай гэж ангилж болно – Зураг 6-г үзнэ үү.

Ус хураах, улмаар түүнийг дамжуулах эсхүл авах боломжийг олгох чадвартай нэвтрүүлэгч чулуулаг нь **гидрогеологийн коллектор** юм. Үл нэвтрүүлэх чулуулаг нь **гидрогеологийн изолятор** болно.

„Газар доорх усны тодорхой орчинд нэгдсэн хэлбэрээр илэрсэн, эсвэл усны ерөнхий шинж чанараар болон гидрологийн горимын нэгдсэн тэмдгээр тодорхойлогдох тодорхой

орчин дахь гүний усны ач холбогдол бүхий төвлөрөл“ (2001 оны 254-р хуулийн багц) хэлбэрээр коллектор дүүргэх гүний усны биетийг **уст үе** гэж нэрлэдэг.

Газар доорх усны гадарга дээрх коллекторын хөндий дэх даралт атмосферийн даралттай тэнцүү бол уст үе чөлөөт гадаргуутай байна. Хэрэв уст үеийн гадарга дээр атмосферийнхээс илүү даралт байвал гадаргуу түрэлттэй байх ба уст үеийн хөрс чулуулаг дахь изолаторыг нэвтэлсний дараа жишээлбэл, цооногоор түүний даралтад тохирох, **пьезометрийн түвшин** гэж нэрлэгддэг түвшинд оргилно.

Зураг 2: Халих хүнхээлийн нүүрэн дэх газар доорх усны ундарга (эх сурвалж: Эхэн тохой, Ховд аймаг, Манхан сум). Зургийг В. Фюрих.



Чөлөөт түвшинтэй уст үеийн дээд гадаргыг **газар доорх усны түвшин** гэнэ.

Түрэлттэй гадаргуу бүхий уст үеийн хувьд газар доорх усны түвшин нь газар доорх усны уст үеийн дээд түвшнээс дээш орших гадаргын даралтын түвшний (илэрсэн ж.нь: судалгааны цооногууд дахь тогтворжсон даралтын түвшин) цэгүүдийг холбосон геометрийн хавтгай байна (Зураг 5-г үзнэ үү).

Газрын гадаргаас газар доорх усны түвшин хүртэлх босоо зай нь **газар доорх усны түвшний гүн** болох ба газар доорх усны түрэлттэй гадаргын хувьд **пьезометрийн өндөр** болно. Газрын гадаргаас дээш, цооног дахь пьезометрийн түвшин нь эерэг (энд артезийн усны тухай яригдаж байна), газрын гадаргаас доош орших нь сөрөг байна. Газар доорх усны түвшин (пьезометрийн түвшин) буюу гадаргын түвшнээс хэмжилтийн цэг хүртэлх зайг хэмжихэд хамгийн энгийнээс (ж.нь: Рейнгийн шүгэл, ердийн манометр) эхлээд, цахилгаан болон цахилгаан-акустик түвшин хэмжигч, цаашлаад түвшний (пьезометрийн

өндөр) хэлбэлзлийн нөлөөгөөр уст үе дэх гидростатикийн (гидродинамикийн) даралтын өөрчлөлтийн тэмдэглэлд тулгуурласан, орчин үеийн цахилгаан даталогер зэрэг олон төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг ашигладаг.

Газар доорх усны гадаргын ижил түвшинт газруудыг холбосноор (м д.т.д илэрхийлэгдсэн) газрын зураглалд гидроизогипс (түрэлттэй гадаргын түвшин бүхий уст үеийн хувьд гидроизопиез) үүснэ. Газар доорх ус налуу өнцгийн дагуу чигт чөлөөтэй эсвэл гидроизогипс (гидроизопиез)-д перпендикуляр пьезометрийн түвшний (буюу гидравликийн градиент) дагуу урсдаг.

Налуу өнцөг их байхын хэрээр ус илүү хурдан урсана (Дарсийн хуулийн дагуу, шууд хамааралтай).

Ус чулуулгийн орчинд гадны хүчний, голдуу гравитацийн/таталцлын нөлөөгөөр хөдөлгөөнд ордог. Урсгалын хурд нь вектор хэмжигдэхүүн бөгөөд хэмжээ болон чиглэлтэй байна. Газар доорх усны урсгалын чиглэл ба хурдыг хэмжихэд маш олон янзын чиг гаргагчууд буюу усанд ихээр уусгаснаар усны хөдөлгөөнийг ажиглах боломжтой бодисуудыг (NaCl, перманганат, цацраг идэвхт чиг гаргагчууд,……) ашигладаг.


Зураг 3: Өөрөө хальж байгаа, пьезометрийн эерэг түвшинтэй гидрогеологийн цооног (байршил Бор хөөвөрийн говь, Дорноговь аймаг). Энэхүү цооногийн толгойг даралттайгаар хаах, эсвэл гидрогеологийн байгалийн харьцааг тогтмол алдагдуулж байгаа учраас түүнийг даралттайгаар цементлэж устгах шаардлагатай. Зургийг В. Фюрих.




Хур тунадасны усны зарим хэсэг газрын гадарга доор шүүрэн нэвтэрдэг ба газар доорх усны түвшинд хүрсний дараа чулуулгийн орчноор ус шавхах газар руу чиглэн өөрийн эргэлтийг үргэлжлүүлнэ. Нийт урсгалын энэхүү хэсгийг газар доорх **усны гарах урсац** гэж нэрлэдэг. Газар доорх ус газрын гадарга дээр ж.нь: булаг хэлбэрээр ундран гарснаар (Зураг 2-г үз) ахин гадаргын ус болох боловч газар доорх усны ихэнх хэсэг газрын гадарга дээр далд ундарга хэлбэрээр гадаргын урсгал руу, эсвэл гадаргын усан сан руу нэгддэг (хөрсний элэгдэл буюу ус зайлуулах/усгүйжүүлэх суурийн түвшинд).

Үндсэн гарах урсац нь газар доорх усны татаасаас бүрдсэн нийт урсацын нэгэн хэсэг гэж тодорхойлогддог. Газар доорх урсацын хэмжилтэд хэд хэдэн гидрогеологийн аргууд ашиглагддаг. **Усгүйжүүлэх суурь** гэдэг нь түүний өндрийн байршлын дүнд газар доорх усны урсац усан цогцолбороос чиглэн урсах газрыг тодорхойлно (байгалийн тогтоцод голдуу усны урсгал ба нуурын сав газрын ёроол).

Зураг 4: 3 цэгийн хооронд гидроизогипс байгуулах загвар. Сум гидроизогипст перепендикуляр байрлах газар доорх усны чиглэлийг заана.



Зураг 5: Газар доорх усны гадаргууг хэмжихэд шаардлагатай ойлголтууд (зүүн талын цооног – чөлөөт гадаргуу, баруун талын цооног – түрэлттэй гадаргуу). Ф. Пастузек.



2.3 Газар доорх ус ба чулуулаг хоорондын холбоо

Чулуулгийн хөндийлжид орших усанд янз бүрийн хүч (ж.нь: таталцлын хүч, хийн даралт, осмосын дарамт, гигроскопын хүч, капилляр хүч) үйлчлэх ба тэдгээр нь тэнцвэрт оршин байвал газар доорх ус тогтуун, харин тэнцвэрт оршихгүй байвал ус хөдөлгөөнд орох ба – үүний дараа өөр бусад хүч үйлчилдэг (ж.нь: үрэлт).

Чулуулгийн орчин дахь усны агууламж ба хөдөлгөөн хөндийлжийн хэмжээ, сувгархаг байдал, хэлбэр болон эзлэхүүнээс хамаарна. Чулуулгийн хөндийлжийн эзлэхүүний чулуулгийн нийт эзлэхүүнд (нүх сүвийн хамт) харьцуулсан харьцааг **нүх сүвшил *(n)*** гэх ба процентоор (%) илэрхийлнэ. Сүвшлийг олон янзаар тодорхойлсон байх боловч гидрогеологийн практикт чулуулгаас авч болохуйц усны хэмжээг олж болох **эффектив (үр ашигтай) нүх сүвшил**, бас чулуулагт агуулагдаж болохуйц шингэний хэмжээг тодорхойлох **нийт нүх сүвшил** нэн чухал.

Байгалийн байдалдаа чулуулгийн хөндийлжийн нэг хэсэг усаар, бас нэг хэсэг хийн нэгдлээр дүүрсэн байдаг бөгөөд чулуулаг нь хатуу, шингэн, хийн гэсэн гурван фазын системийн нэгдэл болно.

Чулуулгийн ус нэвчүүлэх чадварыг түүний **ус нэвтрүүлэх шинж** гэх ба чулуулаг бүр нь тодорхой хэмжээнд ус нэвтрүүлдэг. Ус нэвтрүүлэх болон үл нэвтрүүлэх шинж чанартай чулуулгуудын тухай авч үзэхийн тулд ус нэвтрүүлэх шинж чанар гэсэн ойлголтыг харьцангуй ойлголт гэж хүлээн авах нь зүйтэй.

Чулуулгийн ус нэвтрүүлэх шинж чанартай холбогдох гидрогеологийн үндсэн ойлголтууд нь коллектор болон изолятор юм.

Гидрогеологийн коллектор нь түүний ус нэвтрүүлэх шинж чанарыг зэргэлдээ орших чулуулгийн орчинтой харьцуулвал гидравликийн ижил нөхцөлд гравитацийн ус маш хялбархан хөдөлгөөнд орших, ус нэвтрүүлэх шинж чанараар илүү чулуулгийн орчин юм (коллектор болон изоляторыг ялгах үзүүлэлтэд голдуу ус нэвтрүүлэх шинж чанарын утгын 1-1,5 дифференциалыг/ялгааг авдаг).

Гидрогеологийн изолятор нь түүний ус нэвтрүүлэх шинж чанарыг зэргэлдээ орших чулуулгийн орчинтой харьцуулвал гидравликийн ижил нөхцөлд гравитацийн ус маш муу хөдөлгөөнд орших, ус нэвтрүүлэх шинж чанараар бага чулуулгийн биет юм.

Чулуулгийн ус нэвтрүүлэх шинж чанарыг Дарсийн хуулийн дагуу тоон утгаараа гидравликийн нэгж градиентэд шүүрэх хурдтай тэнцэх гидравликийн дамжуулагч коэффициент ***K***-аар (урьд нь шүүрлийн коэффициент *k*, эсхүл *kf* гэсэн нэршил хэрэглэгддэг байсан, одоо хуучирсан) илэрхийлдэг бөгөөд хурдны хэмжээг м.с$^{-1}$ нэгжээр илэрхийлнэ. Дарсийн хуулийн үндсэн, хялбаршуулсан хэлбэрийг дараах томъёогоор илэрхийлж болно:

$$v = K.I,$$

үүнд: v бол газар доорх усны урсацын дарсийн хурд (м.с$^{-1}$), K нь 100% усаар ханасан нөхцөлд тодорхой чулуулгийн тогтмол шинж чанар болох гидравликийн дамжуулалтын коэффициент (м. с$^{-1}$) ба I нь гидравликийн градиент (газар доорх усны гадаргын налууг тодорхойлох хэмжээсгүй хэмжигдэхүүн). Уг хууль, газар доорх усны урсацын хурд нь орчны ус нэвтрүүлэх чанар болон гадаргын налуутай шууд хамааралтай байх гидравликийн үндсэн харьцааг илэрхийлдэг.

Чулуулгийн биетийн ус нэвчүүлэх чадварын хэмжээг **нэвтрэх чанарын коэффициент/илтгэлцүүр** (урсацын хэмжээ) ***T***-р тодорхойлно**.**Энэ нь гидравликийн дамжуулах чанар ***K*** ба **уст үеийн зузаан *m***-н (= коллекторын усжсан хэсэг) үржвэрээр тодорхойлогддог.

Хугацаанд ноогдох, талбайн хэмжээстэй бөгөөд тоон утгаараа гидравликийн нэгж градиентэд харгалзах ***m*** усжсан зузаан ба нэгж өргөний усжсан коллектороор дамжих эзлэхүүнт урсалтай тэнцэнэ. Илэрхийлэгдэх нэгж нь м^2.с$^{-1}$. Ус хураах зорилгоор усжсан коллекторын ашиглалтын хэмжүүр болох юм.

Гидрогеологийн коллектороос авч болох усны хэмжээг хэмжээсгүй, **нөөцлөлтийн илтгэлцүүр** (нөөцлөлтийн коэффициент) ***S*** тодорхойлно.

Коллекторын хуримтлуулах хэмжээ пьезометрийн гадаргын түвшний нэгж бууралтын үеэрх коллектор дахь нөөц, коллекторын нэгж талбайгаас чөлөөлөгдөх усны эзлэхүүнээр тодорхойлогдоно. Чөлөөт гадаргын хувьд, нөөцлөлтийн коэффициент ус урсан гарсан нүх сүвний эзлэхүүнтэй тэнцүү байна (буюу чулуулгийн үр ашигтай нүх сүвшил). Түрэлттэй гадаргын түвшин бүхий уст үеийн хувьд, коэффициент S нь ачааллын төлөв дэх усны болон чулуулгийн орчны уян налархайн төлөв байдалтай холбоотой, зарчмын хувьд өөр бөгөөд нилээд бага параметр юм. Иймээс Sv-г чөлөөт гадаргын түвшинт уст үеийн агууламжийн коэффициент (ихэнхдээ 0,1-0,5 интервалд утгуудтай), харин Sp-г агууламжийн уян харимхайн коэффициент гэх бөгөөд ихэнхдээ зууны нарийвчлалтай, хамгийн ихдээ 0,1 хүртэл утгуудтай байдаг.

Дээр дурдагдсан ***K***, ***T*** ба ***S*** параметруудыг гидрогеологийн практикт гидродинамикийн туршилтуудын дүгнэлтээр олж илрүүлдэг. Гидродинамикийн


туршилтуудаар гэдэг нь шавхах, нэмэгдүүлэх, сорох, шахах болон бусад туршилтууд болно (гидрогеологийн судалгааны аргуудыг үзнэ үү). Мөн хээрийн, лабораторийн болон туршлага дээр үндэслэсэн аргууд байдаг хэдий ч хамгийн найдвартай, итгэл төрүүлэх үр дүн олгодог учир гидродинамикийн хээрийн туршилтууд гидравликийн параметруудын тооцоонд орлуулшгүй чухал юм.

2.4 Гидрогеологийн орчин дахь газар доорх усны хөдөлгөөн

Атмосферийн хур тунадасын зарим хэсэг газрын гадаргад нэвчин орсноор газар доорх ус болно. Хамгийн эхлээд агааржилтын (агааржсан) бүсээр, гадаргаас газар доорх усны гадаргын түвшин рүү шингэн орно. Ханасан бүсээр босоо хөдөлгөөн голдуу орон нутгийн эсвэл бүсийн эрозын /идэгдэл, элэгдлийн/ суурь руу чиглэх (мөн газар доорх ус зайлуулах суурь – **Chyba! Nenalezen zdroj odkazů.** бүлгийг үзнэ үү) хажуугийн хөдөлгөөнд шилжинэ. Гидрогеологид голчлон ханасан бүс дэх усны хөдөлгөөнийг судалдаг. Усны хөдөлгөөний чиглэл болон хурд нь чулуулгийн орчны шинж чанар, гидрогеологийн тогтоцод орших коллектор ба изоляторын орон зайн зохион байгуулалт, гидрогеологийн тогтоц дахь шүүрлийн болон ус зайлуулах/ усгүйжүүлэх газруудын хоорондын геоморфологийн харилцаагаар (уналт) голдуу өгөгддөг энергийн үйлчлэл (потенциаль) зэргээр тодорхойлогддог. Чулуулгийн ус нэвтрүүлэх чадвар нь хөндий дэх усны хөдөлгөөн ламинар эсвэл турбулент алин болохыг зэрэг тодорхойлох хөндийн хэлбэр ба хэмжээгээр өгөгднө. Чулуулаг дахь усны хөдөлгөөний чиглэл нь хөндийн орон зайн зохион байгуулалт ба гидравликийн градиентын нөлөөллийн чиглэлээр өгөгддөг.

Гидрогеологийн даалгавар шийдвэрлэх явцад хөндийд орших газар доорх усны урсац ихэнхдээ Дарсийн хууль (гидравлик уналт ба урсгалын хурд хоорондоо шугаман хамааралтай) хамаарах ламинар хэлбэрээр явагддаг гэж үздэг. Газар доорх усны гидравликийн даалгавар шийдвэрлэх үед ус, чулуулгийн орчны урсгалын бүхэл профилиэр дамжин урсдаг гэж үздэг (үүний дараа газар доорх усны урсгалын Дарсийн хурд буюу урсгалын жинхэнэ хурдаас хэд дахин удаан, зохиомол хурдыг авч үзнэ). Гэвч байгаль дээр орших чулуулгууд нь янз бүрийн газар янз бүрийн нэвчүүлэх шинж чанартай, гомогенийн бус, харин гетерогенийн байдаг. Үүний адилаар чулуулгийн орчин янз бүрийн чиглэлд янз бүрийн нэвчүүлэх шинж чанартай, анизотроп байдаг. Үүний нэгэн жишээ нь: үе давхаргуудын дагуух хажуугийн нэвчих шинж чанараар үе давхаргуудад перепендикуляр чиг дэх чанараас хэд дахин илүү байдаг тунамал чулуулаг юм.

Зураг 6: Зай завсар, ан цавт болон карст нэвчилттэй чулуулгийн орчны схем (Е.В.Дател).



2.5 Ан цавт чулуулгийн орчин дахь газар доорх усны хөдөлгөөний онцгой төлөв

Бэхжсэн чулуулгуудад (тунамал, магмын, хувирмал чулуулгууд) ан цав болон гадаргын шилжилт гэгддэг тасралтгүй байдлын талбайнууд үүсдэг. Эдгээр тасралтгүй байдлын талбайнууд нь ан цавын гэж нэрлэгддэг ус агуулж болно. Ан цавын нэвтрүүлэх чанар түүний хэмжээ буюу өргөн болон хоёрдогч, дүүргэгч эрдэс, шаврын ширхэглэг эсвэл хандлалт болон өөр бусад өөрчлөлтүүд гэх зэрэг түүний хоёрдогч өөрчлөлтөөс хамаарна.

Ан цав ба тасралтгүй байдлын талбайнуудыг анхдагч (чулуулагтай нэгэн зэрэг үүссэн) болон хоёрдогч (бэлэн чулуулагт эндогенийн буюу гадаад хүчин зүйл – тектоник хөдөлгөөн ба гадаад хүчин зүйл – таталцлын хүч, өгөршил, суулт, эроз, хүний үйл ажиллагаа) гэж ангилж болно. Ан цавын систем ялангуяа тектоникийн гаралтай ан цав, шилжилтэд тогтмол байх нь ихээхэн тохиолддог. Гэвч энэ нь чулуулгийн орчинг гомогенийн, изотроп шинж чанартай хэмээн үзэж болохуйц байх, ан цав чулуулгаар бүх чигт нэгэн жигд дайран өнгөрнө гэсэн үг биш юм.

Зай завсар агуулаагүй, бэхжсэн хагархай чулуулгийн нэвтрүүлэх шинж чанар нь голдуу зай завсрын зохион байгуулалт, тэр дундаа завсар хоорондын нэвтрүүлэх холбоосын түвшнээр өгөгддөг. Нэвтрүүлэх шинж чанар нь ийм орчинд чулуулгийн бус, харин ан цавын шинж чанар болох юм. Ан цав доторх урсгал зөвхөн ламинар бус, гидравликийн өндөр градиентэд турбулент байж болох бөгөөд үүний дүнд Дарсийн хуулийн хүчинтэй хязгаараас хазайна. Ингэснээр практикт ан цавын орчинд хийсэн гидродинамикийн туршилтаас гарах гидравлик параметруудын тооцоо нилээд их алдаагаар ачаалагдах бөгөөд тэдгээрийг зөвхөн барагцаалсан утгууд хэмээн авч үзэх нь зүйтэй.

2.6 Карст хөндий дэх газар доорх усны хөдөлгөөний онцлог чанар

Карст хөндий нь чулуулагт урсаж буй усаар, тэдгээрийн физикийн элэгдэлд орох ба тэдгээрийн химийн уусалтаар үүсдэг. Маш олон янзын хэлбэр, хамрах хүрээ болон урсгалын хөндлөн огтлолтой байдаг. Уусдаг чулуулгуудаас бүрдсэн карстын бүсэд тэдгээрт газар доорх усны горим холбоотой байдаг чухал ач холбогдолтой. Монгол улсад хэдийгээр өргөн тархсан карстын бүс байхгүй боловч өөр чулуулгуудын тогтоцод хэдэн арваас хэдэн зуун метрийн зузаан карбонат чулуулгууд тохиолддог. Карст үүсэх явц нь газар доорх усны эргэлт эхэлсэн анхдагч ан цавын тогтоцод холбогдох нь элбэг. Ийм тогтоцод карстжсан талбай нь ойр орчмын геологийн нийт орчинтой харьцуулахад ус зайлуулах шинж чанараар харьцангуй их байж болно.

Карстын хөндий (өргөн ангархай ан цав ба бусад хөндий) бага хэмжээтэй байсан ч их хэмжээний ус нэвтрүүлэх зам болно. Гидравликийн үүднээс эдгээр хөндийнүүд нь чөлөөт гадаргын түвшинтэй, хагас эсвэл даралттай, дүүрэн хөндлөн огтлолоор ус урсан орох нээлттэй хотгор эсвэл хоолойн шинж чанартай. Том карстын хөндийг спелеологийн /агуй судлалын/ үүднээс (энэ нь уг хөндийд хүн орж болохуйц хэмжээтэй гэсэн үг юм) агуй/ хонгил гэж тэмдэглэдэг (Зураг 7-г үзнэ үү).

Карст хөндий дэх газар доорх усны хөдөлгөөн турбулент байна. Ерөнхийдөө карст хөндий дэх усны хөдөлгөөнд Бернулийн өргөтгөсөн тэгшитгэл үйлчилнэ. Чөлөөт гадаргын түвшинтэй карст хөндийгөөр дамжих усны хөдөлгөөнд нээлттэй хотгор дахь усны

хөдөлгөөний үндсэн зүй тогтол үйлчлэх бөгөөд газар доорх усны урсгал нь энд гидравликийн зүгээс чулуулгийн орчны шинж чанар бус, харин эдгээр хотгоруудын хэлбэр, хэмжээнээс хамаарна. Тэдгээрийн таних тэмдэг ба спелеологи, геодези, геофизикийн болон бусад тусгай аргуудаар олж авах боломжтой геометрийн нарийн тэмдэглэл нь энэхүү орчинд орших газар доорх усны урсгалын судалгаанд тавигдах үндсэн таамаглал болох юм.

Зураг 7: Карст чулуулгийн нэвтрүүлэх шинж чанарыг үзүүлсэн зураг – чулуулгийн цогцолбор дахь шохойн чулуун сууринд буй карстын суваг (аргиллит, алевролит, элсэн чулуу, конгломерат) – Ховд аймаг, Манхан сум. Зургийг В. Фюрих.



Үүнтэй төстэй ач холбогдол (ойр хавийн гидрогеологийн орчны ус зайлуулалт түргэн байх) бүхий чулуулагт мөн залуу галт уулын бялхмал чулуулгуудын цогцолбор дахь лавын туннель, жишээлбэл, Монгол орны өмнө зүгт орших Дарьганга галт уулын дэвсэг, эсвэл Монгол орны төв хэсэгт орших Хорго галт уулаас халисан базальтын цогцолбор дахь хонгилууд орно.

2.7 Гидрогеологийн тогтоц ба тэдгээрийн горим


Гидрогеологийн тогтоц гэдэг нь ерөнхийдөө газар доорх усны тэжээгдлийн бүс (сав газрын шүүрэл), зам болон түүний нэвчилт (ус зайлуулах) зэргийг ангилж болдог, газар доорх усны тогтворжсон эргэлтээр тодорхойлогдох геологийн орчин юм. Гидрогеологийн тогтоцыг олон зүйлийг харгалзан ангилж болох боловч голдуу геологийн тогтоц харьцаа, уст үе (чөлөөт эсвэл түрэлттэй гадаргын түвшинтэй) агуулагдах гидравликийн харьцаа,

эсвэл газар доорх усны химийн найрлага үүсэх (голдуу эрдэст усанд) аргын дагуу ангилдаг.

Гидрогеологийн тогтоц нь таатай нөхцөлд газар доорх усны ашиглагдаж болохуйц эх үүсвэрийг үүсгэж болох юм.

Усны эх үүсвэрт нэгж хугацаанд хурах усны хэмжээ (чадамж) ба гидрогеологийн тогтоцын таатай газруудад цугларсан эзлэхүүн хэмжээг (нөөц) ялгах нь зүйтэй.

Зураг 8: Сав газрын гидрогеологийн тогтоцын жишээ – зураг дээр чөлөөт гадаргын түвшинтэй, түрэлттэй гадаргын түвшин бүхий усжсан коллектор, мөн бас газар доорх усны хязгаарлагдмал урсгалтай коллектор (газар доорх усны зогсонги бүс), нэвтрүүлэх чанараар бага чулуулгуудаар тусгаарлагдсан гидрогеологийн изолятор (зурааслан тэмдэглэсэн хэсгүүд). (А. Грмела)



2.8 Газар доорх усны ундарга ба булаг

Гүний ус нь гидрогеологийн тогтоцоос газрын гадарга дээр байгалийн эсвэл хиймэл үйл ажиллагааны нөлөөгөөр шүүрэн гарч ирдэг. Байгалийн ундарга нь газар доорх усны эргэлт дуусах газар юм. Ус байгалийн жамаар газрын гадарга дээр далд шүүрэл эсвэл ундарга хэлбэрээр гарч ирдэг (Зураг 2-г үзнэ үү). Ундарга гэдэг нь газрын гадарга дээр төвлөрсөн, усны байгалийн шүүрэл юм. Ундаргыг олон янзын шалгуур үзүүлэлтээр, жишээлбэл: чадамж, шүүрлийн тогтмол байдал (ж.нь: байнгын, хаяа, давтамжтай), урсац руу чиглэсэн газар доорх усны хөдөлгөөний чиг (уруудах, гарах, халих), геологийн тогтоц (үе давхаргын, ан цавын, хугаралын, хөндийлжийн), морфологийн байршил (хөндий, дэнж, орой) гэх зэргийн дагуу ангилж болно.

Нэгж хугацаанд шүүрэн гарч буй усны хэмжээ нь л.с$^{-1}$ эсвэл м^3.с$^{-1}$-ээр илэрхийлэгддэг чадамж юм.

Газар доорх усны нилээд их хэсэг гидрогеологийн тогтоцоос далд хэлбэрээр, гадаргын урсгал эсвэл сав (нуур, далай) руу шууд шүүрэн ордог. Ийм шүүрэл урсгалын өсөлтөөр илрэх ба судалж буй урсгалын хэсгийг хязгаарлаж буй гидрометрийн хоёр хөндлөн огтлолын ялгаагаар тогтоогдож болно. Ийм шүүрлийн чадамж нь үндсэн урсацад хамрагдсан байдаг.

2.9 Газар доорх усны химийн ба физикийн шинж чанар

Гидрогеологийн үүднээс ус нь нэг талаас ус ба ууссан молекул, ионтууд болон тэдгээрийн цогц нэгдлүүдээс нэгдсэн жинхэнэ уусмал, нөгөө талаас баригдсан хэсгүүдээс бүрдсэн нарийн төвөгтэй гетерогенийн систем юм. Уусдаг хийнүүд (O_2, CO_2, Rn ба бусад) ба бичил биетийн амьдрах нөхцөл зэрэг нь байгаль дээр орших усны нэгэн хэсэг мөн (Монгол орны газарзүйн байршил, цаг уурын нөхцөл байдлаас үзэхэд, газар доорх ус маш хүйтэн, 3^o С-ээс бага температурт байдаг учир газар доорх усанд бактерийн болон бичил биетийн амьдрах нөхцөл бүрдэх нь харьцангуй хязгаарлагдмал).

Гидрохимийн гол шинж чанарыг хоёр бүлэгт хувааж болно. Эдгээр нь физик-химийн (ж.нь: дулаан, цахилгаан дамжуулах чанар, pH, оксидац-редукцийн чадавхи Eh) ба химийн шинж чанар (усанд ууссан бодисын химийн найрлага) юм. Эдгээр бүлгүүдийн зааг хязгаар дээр усны изотоп найрлага ба түүний цацраг идэвхт чанар байна.

Усны физик-химийн ба химийн шинж чанарыг талбай дээр шууд, эсвэл лабораторит шинжилгээний, өргөн спектрийн тусламжтайгаар илрүүлдэг. Усны химийн найрлагыг дээж тус бүрийн химижилтийг илэрхийлэх, бас олон тооны дээжүүдийн химийн найрлагыг харьцуулах боломжтой янз бүрийн графикийн тусламжтайгаар (график, тойрог, баганан, цацраг,….) буюу графикийн аргаар (Пиперийн ба Дуровын графикууд,…) илэрхийлнэ. Газар доорх усны химижилтийг илэрхийлсэн график үзүүлэлтийн жишээг Зураг 9, бохирдлын цаг хугацааны хөгжлийг шугаман график (баганан байж болно) хэлбэрээр илэрхийлсэн жишээ Зураг 16 үзүүлэв. Голлох ионтуудын эзлэх хувь (Ca^{2+}, Mg^{2+}, Na^{+}, K^{+}, HCO_3^{-} , SO_4^{2-}, Cl^{-}) дээр үндэслэн усны химийн төрлийг тодорхойлно. Антропогенийн гаралтай нэгдлүүд нь ихэвчлэн усан дахь азотын янз бүрийн хэлбэрийн нэгдлүүд байдаг – нитрат NO^{3-}, нитрит NO^{2-} ба аммонийн азот NH_4^{+}.

Ерөнхий эрдэсжилт буюу газар доорх усанд ууссан бүх бодисын агууламж нь чухал параметр юм.

2.10 Гидрогеологийн судалгаа

Гидрогеологийн судалгаа гэдэг нь чулуулгийн орчинд орших газар доорх усны илэрцийн хэмжээ, түүний ашиглалт ба хамгааллын тухай шаардлагатай мэдээллийг олж авах зорилгоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа юм. Судалгаанд газар доорх усны гидрогеологи, гидрологи, гидравликийн болон гидрохимийн ажиллагааны аргуудыг ашигладаг. Гидрогеологийн судалгааг үндсэн (судлагдаж буй тогтоцын гидрогеологийн үндсэн шинжийг тогтоох), бүсийн (доод ангилал дахь газар доорх усны нөөцийн ашиглалтыг үнэлэх) болон тодорхой зорилтот (газар доорх усны эх үүсвэрийн ашиглалтын дэлгэрэнгүй баталгаажуулалт, мөн бас ж.нь: бохирдлын гидрогеологийн зорилгоор хийх судалгаа) гэж хуваадаг.


Гидрогеологийн судалгаа болон усны эх үүсвэрийг хайх хайгуулын төдийгүй, чулуулгийн орчин дахь антропогенийн бохирдлыг олж илрүүлэх, арилгах судалгааны хайгуулын судалгааны үе шат, дэлгэрэнгүй судалгааны үе шат, нэмэлт судалгааны үе шат зэрэгт хуваагддаг үе шатлалын хэрэгцээг онцлох нь зүйтэй.

Чулуулгийн орчин дахь антропогенийн бохирдлыг олж илрүүлэх, арилгах судалгааны хувьд чулуулгийн орчны бохирдлыг дараах ангиллуудад авч үзнэ:


- Архивын шинжилгээ судалгаа (судалгааны бүхий л ажлуудын үндэс)
- Урьдчилсан судалгаа (ж.нь: экологийн аудитын зорилгоор)
- Дэлгэрэнгүй судалгаа (ж.нь: нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн эрсдэлийн анализ ба бэлтгэлийн зорилгоор)
- Нөхөн сэргээлтийн судалгаа – мониторинг (нөхөн сэргээлтийн мониторинг)
- Нэмэлт судалгаа (судалгааны эсвэл нөхөн сэргээлтийн дараах мониторингийн бүх үе шатыг баталгаажуулах зорилгоор)

Зураг 9: Усны (газар доорх) химижилтийг илэрхийлэх янз бүрийн жишээнүүд (Ховд аймгийн Зэрэг, Мөнх хайрхан, Манхан сумуудаас авсан бодит дээжүүдээс).


Дугуй диаграмм




Стиффийн диаграмм




Цацраг диаграмм




Баганан диаграм



Дуровын диаграмм



Пиперийн диаграмм



Гидрогеологийн үндсэн зарчим

3 БОХИРДЛЫН ГИДРОГЕОЛОГИ

Газар доорх ус нь байгалийн үйл явц болон хүний үйл ажиллагаанаас үүссэн төрөл бүрийн бодисыг дамжуулах тээвэрлэлтийн хүчин зүйл бөгөөд ихэнхдээ хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй байдаг. Иймээс байгаль орчныг хамгаалах, ихэнх тохиолдолд антропогенийн бохирдол байдаг газар доорх усны бохирдлын судалгааны хүрээнд хийгдэх гидрогеологийн чухал ажлуудын нэг мөн.

Орчин цагийн гидрогеологи нь олон мэргэжлийг хамарсан шинжлэх ухааны салбар юм. Судалгааны ажлын шаардлагатай үр дүнд хүрэхэд геологи, хими, физик, математик, метереологи, гидравлик, гидрологи гэх зэрэг шинжлэх ухааны бусад мэргэжлүүд тусалдаг.

Орчны бохирдлын судалгааны үр дүн нь:

- бохирдлын эх үүсвэрийг нарийн тодорхойлох,
- бохирдлын шинж чанарын тоон үзүүлэлт (энэ нь: бохирдуулагч ба түүний хэлбэрийг тогтоох) ба
- илэрсэн бохирдлын чанарын үнэлгээ (бохирдлын орон зайн тархалтын тухай мэдээлэл, энэ нь: судалгааны хугацаанд бохирдол оршиж байсан орон зайг тогтоох, бохирдуулагч бодисын баланс, усжсан чулуулгийн орчин дахь түүний хөдөлгөөн ба хөгжил, бохирдлын шилжих хөдөлгөөнийг бичиж тэмдэглэх,
- ойр орчмын эрсдлийн үнэлгээ (энэ нь: эрсдэл бүхий субъект ба объектод учирч болзошгүй бохирдлын харьцаа болон орон зай ба цаг хугацаан дахь бохирдлын хөдөлгөөний динамик).

Гидрогеологийн судалгаа нь шийдвэр гаргахад шаардлагатай, бохирдол хэр зэрэг аюултай болох, хэрэв шаардлагатай бол тэдгээрийг цаашид судлах ба ямар нэгэн аргаар тэдгээрийг ачих зэрэг мэдээллүүдийг олж авахад хүргэх ёстой.

Орчны бохирдлын судалгааны үүргийг авч үзвэл үндсэн 3 хэсэгтэй:


- **бохирдлын эх үүсвэрийн тодорхойлолт ба судалгаа** – энэ нь: бохирдлын гарал үүсэл ба түүний одоогийн байдлыг тогтоох (бохирдол цаашид үргэлжилж байгаа, эсвэл үгүй, эсвэл бохирдуулагч ахин алдагдах аюул нүүрлэсэн хэвээр байгаа),
- **ханаагүй бүсийн бохирдлын судалгаа** (зуны улиралд ихээхэн ууршиж, өвлийн улиралд хөлдөхөд хүрдэг Монгол орны гандуу ба хагас гандуу цаг уурын байдлаас үзэхэд бохирдлын ихээхэн хэсэг ханаагүй бүсэд хуримтлагддаг) – судалгаа нь гадаргын шинж чанарын тухай мэдээлэл (бэхжсэн, бэхжээгүй), геологийн профилийн ханаагүй бүсээрх найрлага ба давхаргазүй (түүний ерөнхий зузааны хамт) зэргийн тухай мэдээлэл олгох үүрэгтэй ба ханаагүй бүсээрх бохирдлын шилжилтийг дүгнэхэд чухал параметруудын тэмдэглэгээ (ширхэглэг, чийгшил, ус болон агаар нэвтрүүлэх чанар), бохирдол хялбархан тархах зам болж болзошгүй инженерийн шугам сүлжээ болон газар доорх байгууламжийн байдлыг тодорхойлох (ж.нь: ариутгах татуурга, кабелийн ховил гэх зэрэг.) мөн бохирдол тархах бусад боломжуудыг тооцоолох (агаарт, газар доорх ба гадаргын ус).
- **ханасан бүсийн бохирдлын судалгаа** – судалгаа нь бохирдсон уст үеийг тодорхойлсон мэдээлэл ба ханасан бүсээрх бохирдлын шилжилтийг дүгнэхэд чухал параметруудын тэмдэглэлийг олгох үүрэгтэй.

  Судалгааны ажил дараах үндсэн асуудлуудад чиглэсэн байвал зохино:

- судлагдаж буй геологийн орчны геометр, буюу гидрогеологийн коллектор, хагас изоляторууд болон изоляторуудын тодорхойлолт,
- коллектор ба изоляторын гидравликийн шинж чанар (шүүрлийн коэффициент, нүх сүвшил, дамжуулах шинж чанар, дисперсийн шинж чанар,…), таамаглаж буй математик загварчлалд шаардлагатай, судлагдаж буй уст үеийн зааг хязгаарын нөхцлүүдийн тодорхойлолт
- эхний уст үеийн гадарын гүн, түүн дэх урсгалын чиглэл ба хурд,
- гүн уст үед газар доорх усны гадаргын пьезометрийн түвшин, урсгалын чиглэл ба хурд болон урсгалын босоо чиг дэх бүрэлдэхүүнүүдийг тогтоох
- судалж буй газар нутаг дахь газар доорх усны урсгалын горим (шүүрэл, эргэлт, хуримтлал ба ус зайлуулалт явагдаж буй газрууд), гадаргын устай уялдаа холбоотой,
- ойр орчим дахь газар доорх усны ашиглалт,
- бохирдуулагч бодисуудын чанарын спектр ба тэдгээрийн ханасан бүс дэх төлөв байдал (газар доорх усны физикийн ба химийн бусад үзүүлэлтүүдийн нөлөө),
- газар доорх усны гадаргын түвшинд, гадаргаас доош болон коллекторын сууринд ууссан бохирдуулагчийн хэмжээ ба концентраци, эсхүл гадарга дээр болон коллекторын суурин дахь чөлөөт фазын илэрц (балансын тооцоо),
- ханасан бүс дэх чулуулагт бохирдуулагчийн шингэх шингэлт ба сулруулах бусад арга хэмжээний хэрэгжилт (диффузи-дисперсийн процесс, биологийн задрал, фаз хоорондын шилжилт гэх зэрэг),
- ханасан бүс дэх дэд бохирдуулагчдын концентрацийн орон зайн тархалтын одоогийн байдал,
- бохирдлын орон зай ба цаг хугацаанд хөгжих үйл явцын таамаг (ялангуяа усны эх үүсвэр ба гадаргын усны ашиглалтыг харгалзан үзсэн.)

Илэрсэн бохирдлын гидрогеологийн судалгааг зөв хийж гүйцэтгэх нь эрсдлийн анализыг боловсруулах үндэс болно. Нөхөн сэргээх хандлагын хүрээнд нөхөн сэргээлтийн ажлын явц ба амжилттай байдлыг дүгнэх, үүсэн асуудлыг шийдвэрлэх болон шинээр илэрсэн бодит байдлыг шинжлэх зорилгоор гидрогеологийн нэмэлт судалгаа явагддаг. Шаардлагатай зорилгод хүрэхийн тулд дараах гидрогеологийн судалгаануудыг ашигладаг.

Зураг 10: Газар доорх усны бохирдлын хүрээг талбайн газрын зураглал буюу бохирдуулагч үүлээр (байршил Бзенец, БНЧУ) илэрхийлж үзүүлэв. Бохирдуулагч үүл нь судалгааны ба ажиглалтын цооногуудын тоо хэмжээнд үндэслэн хязгаарлагдсан болно. Өнгө тус бүр нь бохирдуулагч үүлний зах руу буурах бохирдуулагч бодисын концентрацийг (энэ тохиолдолд алифатик хлорт нүүрс-устөрөгч) илэрхийлнэ. Бохирдуулагч үүлний дотор байгаа төдийгүй гадна байрлах цооногууд ч чухал ач холбогдолтой, өөрөөр хэлбэл, бохирдуулагч бодисын концентрацийн хүлээн зөвшөөрч болохуйц утга бүхий (эрсдэлийн шинжилгээний дүгнэлтээс үзэхэд) үүлний ойр орчмыг тодорхойлдог юм. (Е.В.Дател).



4 ГИДРОГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АРГУУД

4.1 Гидрогеологийн зураглалууд

Гидрогеологийн судалгааны үндсэн арга бол **гидрогеологийн зураглал** мөн. Энэ нь зураглалын ажлын зорилгоос хамаарсан, янз бүрийн масштабын гидрогеологийн газрын зураг үйлдэх мэргэжлийн үйл ажиллагаа юм. Эдгээр ажлууд нь талбайн/хээрийн судалгааны тойм, баримтжуулалтын цэгүүдийн тэмдэглэгээ, хээрийн зондын болон хэмжилтийн ажил, лабораторын туршилтанд зориулсан дээж авах ажил зэргийг хамарна. Гидрогеологийн судалгааны архивын болон хуучны зураглалын ажлын мэдээний хамт эдгээр мэдээллүүд нь тухайн газар нутгийн гидрогеологийн үндсэн эсхүл зорилтот зураг боловсруулахад ашиглагддаг.

Гидрогеологийн зураг бол топографийн болон геологийн туслах материалд үндэслэн боловсруулсан, мөн зохих хөндлөн огтлолыг нэмсэн тусгай газрын зураг бөгөөд тодорхой газар нутгийн гидрогеологийн харьцааг илэрхийлэх хамгийн тохиромжтой, цогц аргыг төлөөлдөг юм. Газрын зураг нь тайлбар текст ба гидрогеологийн огтлолын хамтаар гидрогеологийн тогтоц дахь газар доорх усны илэрц, тархалт болон газар доорх усны гидрограф ба гидрологи, геоморфологи, геологи, мөн тектоникт хамааруулсан бүсжилт зэргийг харуулна.

. Гилрогеологийн зургийн ангилал:

- ерөнхий (масштаб 1:500 000 болон бага),
- үндсэн (масштаб 1:50 000 –аас 1:200 000 хүртэл) ба
- зорилтот (тодорхой зорилгод чиглэсэн масштабтай, ж.нь: газар доорх усны түрэлтийн зураг, газар доорх усны бохирдлын зураг, уурхайн гидрогеологийн зураг гэх зэрэг...).

Тусгай зургуудад тодорхой нэгэн газар нутаг дахь газар ашиглалтын усны зохицуулалтын асуудлуудыг үзүүлсэн усны менежмэнтийн зургууд орно (булаг шанд, хураах объектууд, хамгааллын бүс, усны болон ариутгах татуургын шугам сүлжээ, далан, усан сан ба гол горхи, гидрологийн сав газар, үерийн муж гэх мэт.).

4.2 Гидрологийн аргууд

Гидрогеологийн судалгааны хүрээнд сонирхсон газраас эхтэй газар доорх урсацын хэмжээ, хур тунадасын нэвчилт, эсхүл бохирдсон газар нутаг дахь транспирацийн хэмжээ зэрэг судалж буй газар нутгийн тухай гидрогеологийн үндсэн ойлголтуудыг олж мэдэх зорилгоор гидрогеологийн аргуудыг ашиглах шаардлагатай болох нь олонтаа. Гидрогеологийн практикт гидрологийн аргуудаар талбай дээр ажиглалт, хэмжилт хийн олж авсан тоон мэдээллийг голчлон боловсруулдаг. Эдгээр мэдээллүүдийн боловсруулалт нь геологийн байгууламж ба сав газрын гидрогеологийн харьцаа, эсхүл түүний хүрээнд газар доорх усны горимын зүй тогтлыг тогтоох тухай мэдлэгтэй холбох боломжийг олгодог.

Өргөн хэрэглэгддэг гидрологийн аргуудад:

- газар доорх усны балансыг боловсруулах,
- хур тунадас (Зураг 11-ийг үзнэ үү) ба ууршилтын хэмжилт,
- урсац тогтоох (гадаргын, гадаргын доорх гиподермийн, газар доорх),
- ундарга ба усны түвшний чадамжийг хэмжих (урсац – Зураг 12 ба Зураг 13-ыг үзнэ үү, гадаргын ба газар доорх усны түвшин).

Зураг 11: DAVIS хөдөлгөөнт цаг уурын станцын тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн цаг уурын үндсэн шинж чанарын хэмжилт. Зургийг В. Фюрих.



Зураг 12: Гадаргын усанд гидрометрийн хөдөлгүүрээр хийж гүйцэтгэсэн урсацын хэмжилт. Зургийг О. Оюун-Энх.



Зураг 13: Цооногийн шавхалтын туршилт – Томсоны гурвалжин хаалтын тусламжтай чадамжийн хэмжилт хийж байгаа нь (урсгал). Зургийг В. Фюрих.



4.3 Зондын аргууд

Ханасан бүсийн гидрогеологийн судалгааг судалгааны зонд ба цооног ухалгүйгээр гүйцэтгэх боломжгүй. Цооног эсхүл зонд нь ундаргаас гадна, газрын гадаргаас хүрэх боломжгүй газар доорх усыг шууд судлах цорын ганц арга мөн.

Өрөмдлөгт өрөмдлөгийн маш олон янзын технологи ашигладаг (цохилтот, чөмгөн өрөмдлөг, эргэлтэт-цохилтот, цохилтот-эргэлтэт, чичиргээт, утгуурт, зэрэг). Технологи бүр нь өөр өөр чулуулгийн орчинд, судалгааны цооногийн өөр, өөр зорилгоор ашиглахад тохиромжтой байдаг гэдгийг дурдах нь зүйтэй.

Цохилтот өрөмдлөг (жишээлбэл, UKS серийн иж бүрдэл – Зураг 14a-г үзнэ үү) нь хуучны хамгийн түгээмэл технологи бөгөөд өнөө үед хатуу чулуулгуудад (өрөмдлөг удаан явагдахыг хүлээн зөвшөөрч, урьдчилан тооцоолох – өдөрт хамгийн ихдээ хэдхэн арван см), өргөн профиль буюу хөндлөн огтлолтой цооног өрөмдөхөд ашиглахад тохиромжтой (Ø 400-500 мм-ээс дээш).


Чөмгөн өрөмдлөг (жишээлбэл, URB серийн иж бүрдэл – Зураг 14b-г үзнэ үү) нь цооногоос чанартай чөмгөн дээжүүд авах шаардлагатай тохиолдолд тохиромжтой байдаг тул илүү үнэтэй (диаметр ойролцоогоор 100-150 мм) – литологийн нарийн тэмдэглэл, тектоникийн гэмтлийг илрүүлэх, лабораторын туршилт хийх зорилгоор гэх зэрэг.

Эргэлтэт-цохилтот өрөмдлөг (жишээлбэл, POWER серийн иж бүрдэл – Зураг 14c-г үзнэ үү) нь хатуу хад чулуулагт боломжийн үнээр өрөмдлөг хийх стандарт өрөмдлөг юм; харин энэ өрөмдлөг нь хамарсан чулуулгийн орчны дэлгэрэнгүй тодорхойлолт хийх зорилгоор чөмөг авах боломжийг бүрдүүлдэггүй, зөвхөн барагцаалсан тодорхойлолт гаргахад л тохиромжтой.

Эргэлтэт-цохилтот өрөмдлөг нь усны байгууламж болох өрөмдсөн худаг барих зорилгод ашиглагдах нь олонтаа, судалгааны өрөмдлөгт ашиглагдах нь ховор (цооногийн диаметрууд өрмийн иж бүрдлийн хүчин чадлаас хамаарч 200-400 мм).

Цохилтот-эргэх өрөмдлөг (жишээлбэл UGB серийн иж бүрдэл – Зураг 14д-г үзнэ үү) нь нарийн диаметртай (100-200 мм), судалгааны, гүехэн цооног (20 м хүртэлх) байгуулах зорилгоор ихэнх геологийн орчинд ашиглагддаг өрөмдлөгийн түгээмэл технологи юм.

Зураг 14: Гидрогеологийн ажилд ашиглагддаг өрөмдлөгийн иж бүрдлийн жишээ.Зургийг В.Фюрих




талбай болон түүний ойр орчмын ачилт тээвэрлэлтийн талбайг багтаах үндсэн талбай шаардлагатай болох нь илэрхий (өрөмдлөгийн багаж, татанга, компрессор, сав ба усаар зайлах бусад бусад хэсгүүд г.м). Иймээс давчуу орон зайд өрөм байрлуулахад асуудал үүсч болзошгүй (ж.нь: барилга байшингийн хооронд, хүмүүс болон эд материалын хөдөлгөөн бүхий талбай гэх зэрэг). Өрмийн иж бүрдлийн өндөр буюу өрмийн цамхаг нь мөн адил дотор орчинд эсвэл газар дээгүүрх цахилгаан дамжуулалт зэргийн ойролцоох өрөмдлөгийн үед хязгаарлагч хүчин зүйл болж болох юм. Газар доорх инженерийн шугам сүлжээ, судалгааны өрөм байрлуулахад тохиолдох хязгаарлагч хүчин зүйл мөн. Шаардлагатай бол зөвхөн босоо чиглэлд бус, мөн ташуу, хэвтээ эсвэл өгсүүр газарт цооног байрлуулах боломжтой (ж.нь: барилгын суурин доогуурх өрөмдлөг, овоолгоны сууринд, уурхайн хонгилд г.м), хэдий тийм боловч эдгээр ажлуудын үнэ ердийн судалгааны цооногуудаас харьцангуй илүү гэдгийг тооцоолох нь зүйтэй (ердийн үнээс 2-3 дахин их байх нь ч бий). Үүнтэй ижил өсөлтийг олон коллекторт орчинд цооног байгуулах тохиолдолд ч гэсэн тооцоолох шаардлагатай ба коллектор тус бүрийн даралтын цементжүүлэлтийг өөр хооронд нь тусгаарлавал зүйтэй. Мөн гүний усжсан коллекторуудын (100-200 м-ээс дээш) судалгааны хувьд, өрөмдлөгийн ажлын нэмэгдэл зардлыг тооцох нь зүйтэй; ийм гүнд өрөмдлөг хийх нь гүехэн газар өрөмдлөг хийхээс илүү үнэтэй ч, гүехэн цооногийн метр тус бүрт ноогдох зардлыг гүн цооногийнхтой харьцуулан экстраполяцийн аргаар хялбархан тооцоолох боломжгүй.

Утгуурт эсвэл чичиргээт өрөмдлөгийн технологиуд нь холбоосгүй эсвэл бага холбоост материал дахь цооногуудад ашиглагддаг (өнгөц давхарга, шавар, хөндий эсвэл өндөр дэнж дэх голын хайргархаг элс, ул чулуулгийн нөмрөг г.м). Чичиргээт арга нь том бул чулуугүй орчинд зориулагдсан (ердийн цооногийн диаметр 50-150 мм), эргэлтэт, эсхүл утгуурт өрөмдлөг нь өргөн профильт цооног болон худгууд байгуулахад зориулагдсан (утгуурт өрөмдлөгийн диаметр 1000 мм). Гидрогеологийн судалгааны хүрээнд зондын, эсвэл геологийн сонирхол бүхий газар нутгийн тухай мэдлэгийг нарийн тодорхойлох өрөмдлөгийн ажил, харгалзах шинжилгээнд хөрс болон газар доорх усны дээж авах, физик-химийн параметруудын талбайн хэмжилт, газар доорх усны гадаргын түвшний төлөв, гидродинамикийн туршилт, мөрдөлтийн туршилт, урт хугацааны мониторинг ба судалгааны ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийн шавхалт, эсхүл цэвэрлэсэн усны эсвэл нөхөн сэргээх бодисуудын нэвчилт зэрэгт зориулагдаж болно. Цооногийн параметрууд (энэ нь: гүн, цооногийн диаметр, ашиглагдсан өрөмдлөгийн технологи, цооног тоноглох арга барил, төхөөрөмжийн нүхлэх интервал, тоног төхөөрөмжийн хучилт ба жийрэг) геологийн орчны шинжээс хамаарч (ж.нь: бэхжсэн, бэхжээгүй чулуулгууд), судалгааны ажлаар тогтоосны дагуу (литологийн хөндлөн огтлол ба чулуулгийн тектоникийн гэмтлийг илрүүлэх, нэг удаагийн дээж авах, урт хугацааны мониторинг, нөхөн сэргээлтийн объект болгон ашиглах боломж г.м) мөн газар доорх усанд байгааг таамаглаж буй бохирдуулагчдын шинж чанараас хамаарч (газар доорх усны гадаргын дагуу бохирдуулагчийг ажиглах – LNAPL, эсвэл коллекторын сууринд – DNAPL (Энэ нь хувийн жингээрээ уснаас бага эсвэл их бодис юм, хавсралт 1, Зураг 15-г үзнэ үү).

Дээр дээрээсээ олон давхарласан уст коллекторууд орших орчинд (ихэнхдээ тунамал сав газар) судалгааны цооног дахь коллектор тус бүрийг хоорондоо холбогдож, коллекторуудын хооронд газар доорх ус болон бохирдуулагчийн шилжих шинэ зам үүсгэхгүйн тулд тохирох тусгаарлагчаар сайтар тусгаарлахад анхаарах нь зүйтэй (ж.нь: даралтын цементжүүлэлт, битүүмжлэгч, бөглөөс гэх зэрэг).

Цооногийг зөв барьж гүйцэтгэхээс түүний урт хугацааны ашиглалт, мөн түүнээс авсан дээжийн найдвартай бөгөөд төлөөлөхүйц байдал, түүн дэх газар доорх усны гадаргын төлөв хамаарна.

Зураг 15: Уснаас хөнгөн ба уснаас хүнд бохирдуулагчийн дан фазын ялгаатай төлөв байдал (эх сурвалж Waterloo Centre for Groundwater Research).



Гадаргын түвшинд агуулагддаг (гадарга дээр бие даасан давхарга үүсгэдэг), уснаас хөнгөн бохирдуулагчийн дан фазын ялгаатай төлөв байдал (ж.нь: газрын тосноос гаралтай нүүрс-устөрөгчийн бохирдол), усанд ууссан фазын тархалтын гүн уст үеийн дээд хэсгээр хязгаарлагддаг, харин уснаас хүнд бохирдуулагчийн (түүний хувийн жин нь усныхаас илүү, буюу 1000 кг/м^3), ж.нь: таталцлын хүчний нөлөөгөөр хлоржуулсан нүүрс-устөрөгч коллекторын ёроолын буурцад (буурсан хэсгүүдэд) хуримтлал (буюу тунамал) үүсгэдэг усжсан орчны (усжсан коллекторын) ёроол хүртэл аажмаар буурах ба уст үеийн бүхий л зузаанд уусдаг. Үүний зэрэгцээ ханаагүй болон ханасан бүсийн геологийн орчны гетерогенжилт явагддаг.


4.4 Гидрогеохимийн аргууд

Гидрогеологийн судалгаанд усны физик-химийн шинжилгээ зайлшгүй чухал. Гидрогеологийн практикт газар доорх усны дээжийг авах бөгөөд шаардлагатай тохиолдолд гадаргын ус болон хур тунадасаас дээж авдаг. Усны химийн найрлагын тухай найдвартай мэдээлэл олж авахын тулд химийн шинжилгээнд усны дээжийг маш зөв авах явдал юм.

Лабораторын ажлын хажуугаар мөн талбайн хэмжилтийг дурдах нь зүйтэй, учир нь, зарим үзүүлэлтүүдийг газар дээр нь шууд хэмжих шаардлагатай байдаг. Эдгээр нь ихэвчлэн усны дээж авах үед болон түүний лаборатори руу тээвэрлэх тээвэрлэлтийн үеэр алдагдах утгууд болох температур, pH, оксидац-редукцийн чадавхи, ууссан хүчилтөрөгч ба бусад параметруудын хэмжилт юм.

Химийн шинжилгээний үр дүнг маш олон аргаар үзүүлж, илэрхийлдэгээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь янз бүрийн графикийн аргууд болно (баганан, тойрог, шугаман ба бусад тусгай графикууд – ж.нь: Пиперийн – Зураг 9-г үзнэ үү). Бид усны эх үүсвэрийн хурах газруудад усны дээж авах хүрээнд олж авсан, үүссэн бохирдлын байдлыг шийдвэрлэхэд ч ашиглаж болохуйц зарим химийн үзүүлэлтүүдийг ажиглах урт хугацаатай байдаг.

Зураг 16: Алифатик хлорт нүүрс-устөрөгчийг тодорхойлоход шаардлагатай газар доорх усны шинжилгээний үр дүнг хугацаанаас хамааруулан үзүүлсэн шугаман график. (Т. Харваат)



Зурагт ажиглах үзүүлэлтүүдийн хэлбэлзлийг хугацааны хамааралтайгаар үзүүлсэн. Энэ нь байгалийн эсвэл антропогенийн нөлөөлөлд автсан (бохирдсон газрууд) чулуулгийн орчны аль ч ажиглагдах параметрын шинж чанар мөн. Үүнээс үзэхэд цэгэн мэдээллүүд нь чухал ач холбогдолгүй (нэг удаагийн тогтоомж), харин хугацааны харгалзах шинжилгээ чухал, өөрөөр хэлбэл харгалзах хугацааны интервалд хэд хэдэн шинжилгээ байдаг бөгөөд тэдгээрийн нийт хугацааны хандлага чухал юм. Шинжилгээ тус бүр нь тогтоосон хязгаар, утгууд болон зорилго зэргийг давж болохын зэрэгцээ ерөнхий хандлага эдгээр параметруудад тохирно хэмээн дүгнэгдэж болно; энэ нь захиргааны шийдвэрийн боловсруулалт, мөн бас янз бүрийн статистик дүгнэлтийн аргуудын хэрэглээ зэргээс шалтгаална. Захиргааны байгууллагууд нь эдгээр байдлын тухай мэдээлэлтэй байх ёстой бөгөөд уг баримт дээр үндэслэн янз бүрийн шийдвэр гаргах ба хоёрдмол утгагүйгээр боловсруулах ёстой юм (өөрөөр хэлбэл, ийм, ийм объектуудад, ийм, ийм газар нутагт, ийм, ийм профильд тогтоосон хязгаар утгуудад хүрнэ, мөн энэ, энэ хугацааны баримтжуулалтыг, статистикийн ийм, ийм аргуудаар, харгалзах урт цаг хугацааны туршид ашиглан гүйцэтгэнэ гэх мэт.)

4.5 Гидродинамикийн туршилтууд

Усжсан чулуулгийн орчны гидравликийн параметруудыг тогтооход зориулагдсан гидродинамикийн янз бүрийн туршилтууд бий (Зураг 13 ба Зураг 137-г үзнэ үү). Энэ нь гидравликийн параметрууд эсвэл геологийн орчны бусад мэдээллүүдийг олж мэдэх зорилгоор туршиж буй цооног эсхүл худгаас шавхан авсан усанд хийгддэг, хээрийн туршилтууд юм (ашиглаж болохуйц чадамж, хязгаарын нөхцлүүд, туршиж буй объектын техникийн байдал ба бусад). Шавхах ба нэмэгдүүлэх туршилтуудыг хамгийн өргөнөөр, цаашлаад жишээлбэл юүлэх, тарих гэх мэт туршилтуудыг хэрэглэдэг. Гидродинамикийн туршилтуудын үр дүнгээс голдуу гидравликийн үндсэн параметруудыг тогтоодог – гидравлик дамжуулах чанарын коэффициент **K**, нэвтрэх чанарын коэффициент **T** ба нөөцлөлтийн коэффициент **S**, эффектив шүвэрхэгшил **eғ** ба тусгай чадамж **q.**

Гидродинамикийн туршилтыг хоёр үндсэн хандлагаар дүгнэж болох ба, тэдгээр нь тогтмол ба тогтмол бус урсгалын аргууд юм. Тогтворжсон урсгалын аргууд нь Дюпюи-Тимогийн тэгшитгэлийг ашигладаг. Гидрогеологийн судалгааны үеэр шавхах ба нэмэгдүүлэх туршилтуудыг дүгнэх, хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг аргуудад хагас-тогтмол урсацын нөхцөлд Тейсийн худгийн үйл ажиллагааны, Жэйкобын ойролцоолох логарифмт тооцоолол хүчинтэй байдаг тогтмол бус аргууд багтана.

Хамгийн түгээмэл хэрэглэгддэг шавхах туршилтын үйл явц нь цооногт тодорхой хугацааны туршид тогтмол хэмжээний газар доорх ус шахагдсан бөгөөд шавхагдсан цооногт цаг хугацааны интервалд харгалзах гадаргын бууралтыг хэмждэгт оршино. Газар доорх усны гадаргуу ахин өөрчлөгдөхгүйгээр тогтворжсоны дараа шавхалтыг дуусгах ба нэмэгдүүлэх туршилт эхлэх юм. Газар доорх усны гадаргын өсөлтийг (нэмэгдэл) ахин тэмдэглэн авах бөгөөд нэмэгдүүлэх туршилтыг гадаргуу шавхах туршилт эхлэхийн өмнө байсан анхны түвшинд хүрмэгц дуусгана. Ингэж хийсэн гидродинамикийн туршилтын дүгнэлтийг ихэнхдээ Жейкобын график-тооцооны аргын дагуу гүйцэтгэдэг боловч өөр олон аргууд бий. Дүгнэлтэд зориулагдсан компьютерийн энгийн болон нарийн төвөгтэй программууд байдаг (ж.нь: Монголд AQUIFERTEST өргөнөөр ашиглагддаг).

Гидродинамикийн туршилтын үргэлжлэх хугацаа буюу шавхах туршилтын үеэр жинхэнэ тогтворжсон байдалд хүрэх хугацаа нь гидравликийн параметруудын тогтоох нарийвчлалд нөлөөлдөг. Нарийн утгуудад судлагдаж буй объект доторх газар доорх усны гадаргаас гадна ойр орчмын ажиглалтын объектууд дахь газар доорх усны гардаргууг ажиглах, гидродинамикийн урт хугацааны (гол төлөв 3-10 өдрийн туршид үргэлжлэх) туршилтын дүгнэлтээр хүрнэ. 14 – 28 хоногийн туршид үргэлжлэх туршилтуудыг хагас-ажиллагааны хэмээн үзэж болох бөгөөд эдгээр нь голдуу цуглуулагч цооногуудын урт хугацааны, тасралтгүй чадамжийг шалган батлахад зориулагдсан.


Олж илрүүлсэн гидравликийн параметрууд нь гидрогеологийн орчны тухай үндсэн мэдээллийг олж авахад, газар доорх усны урсгалын хурдын тооцоонд, газар доорх усны эх үүсвэрийн ашиглаж болохуйц чадамжийг тогтооход, бохирдлын шилжилтийн загвар шийдэл болон түүний дараах бохирдсон газар доорх усны нөхөн сэргээлтийн санаачлагад зориулагдсан байдаг.

Зураг 17: Гидродинамикийн туршилтуудыг хийж гүйцэтгэж байгаа нь. Зургийг Т. Харват.



Туршиж буй цооногийн дэргэд урсгал ба гадагууг хэмжих төхөөрөмжүүд, шахалтын хоолой болон дижитал датуудыг цуглуулан, тэдгээрийг дүгнэх зөөврийн компьютер харагдаж байна.

Зураг 18: Жейкобсын нэмэгдүүлэх туршилтын график-тооцооны дүгнэлтийг үзүүлэв. (Т. Харват).



Зурагт гидродинамикийн туршилтын муруй буюу туршигдаж буй эсвэл ажиглаж буй цооног дахь газар доорх усны гадаргын түвшингийн явцыг тогтмол хэмжээний ус шахах үеэр, хугацаанаас хамааруулан дүрсэлсэн байна. Гидродинамикийн туршилтын (шавхах) дүгнэлтэд олж авсан муруйн төв хэсгийн хэрчим чухал ач холбогдолтой – эхний хэсгийн хэрчим туршигдаж буй объектын нөлөөгөөр гажсан ба төгсгөлийн

хэрчим туршигдаж буй коллекторын зааг хязгаарын нөхцлүүдийн нөлөөгөөр гажуудсан; зөвхөн төв хэсгийн муруй л туршигдсан коллекторын гидравлик шинж чанарыг илэрхийлнэ.
Үүнийг буюу муруйн төлөөллийн хэрчмийг тогтоох нь (бодит байдалд үзүүлсэн жишээн дээрх шиг тодорхой байх нь ховор) гидродинамикийн туршилтыг дүгнэх хамгийн чухал алхам бөгөөд хариуцсан ажилтны туршлагаас ихээхэн хамаардаг ба гидравликийн параметрын тооцоо нь ердөө утгуудыг харгалзах томъёонуудад орлуулан хүрэх механик алхам юм.

Коллекторын гидравликийн үндсэн шинж чанаруудыг түргэн баримжаалан олж мэдэхийн тулд „slug test“-ийг хэрэглэх нь олонтаа. Энэ нь тодорхой эзлэхүүн бүхий усыг цооног руу даруйхан хийдэг (нэг удаагийн юүлэлтийн арга) эсвэл тодорхой эзлэхүүн бүхий усыг цооногоос нэг удаа авдаг (нэг удаа авах арга), уст үед нэг удаа халдах үйлдэл хийх гидродинамикийн экспресс туршилтын нэг төрөл юм. Уст үед нэг удаа халдсанаар, мөн тодорхой эзлэхүүн бүхий усыг гадаргын тэнцвэртэй байдлаас шахаж тодорхойлсон эзлэхүүн бүхий биетийг түлхэн гаргахад хүрч болно. Эдгээр туршилтуудын үргэлжлэх хугацааны асар богино байдал (ихэнхдээ зөвхөн хэдхэн арван минут, эсвэл эхний цаг), тэдгээрийн чадамжийг мөн хязгаарлагдмал болгодог гэдгийг онцлох нь зүйтэй. Бусад бүх гидродинамикийн туршилтуудын адилаар уг туршилтын нөлөөлөл хүрч буй зайд орчны гидравликийн шинж чанарыг бидэнд тодорхойлон өгнө гэсэн зарчим үйлчилнэ. Тодруулбал, туршилт хэдий чинээ богино байна, төдий чинээ цооногт ойрхон орчмыг шинжлэх ба олж авсан үр дүнг томоохон газар нутагт хэрэгжүүлэхэд асуудалтай байх нь элбэг.

Томоохон газар нутаг ба гидрогеологийн тогтоцыг туршихад (ж.нь: коллекторын хязгаарын нөхцлүүд, ашиглаж болохуйц чадамж, ойролцоох худгийн нөлөө гэх зэргийг судлах зорилгоор) илүү урт хугацааны гидродинамикийн туршилтууд (эдгээр зорилгуудад ихэнхдээ 7-10 ба түүнээс олон өдрүүд шаардлагатай) зориулагддаг.

4.6 Математик загварчлал

Математик загварчлал нь гидрогеологийн судалгааны хүрээнд бохирдсон газруудыг шийдвэрлэх үед маш хэрэгтэй хэрэгсэл болдог. Чулуулгийн орчинд болж буй үйл явц болон нөхөн сэргээлтийн технологийг оновчтой зөв сонгоход сайнаар нөлөөлөх, түүний дараагийн санаачилсан нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны загварчлалыг илүү сайн ойлгох боломжийг олгодог. Гэхдээ математик загварчлалын найдвартай байдал анхны өгөдлүүдийн чанар ба тоо хэмжээнээс үргэлж хамаарна гэдгийг ойлгох нь зүйтэй.

Бохирдсон газруудыг шийдвэрлэх үеэр загварчлал 2 алхмаар үргэлжилдэг. Хамгийн эхлээд бохирдлын тээвэрлэлтийн загвар холбогдох газар доорх усны урсгалын бие даасан загварыг байгуулна.

Газар доорх усны урсгалын загвар нь бохирдлын тээвэрлэлтийн тухай үндсэн тогтолцоог үүсгэдэг (энгийнээр хэлбэл, бохирдол тархах чиглэл ба түүний тархалтын хурд нь ханасан болон ханаагүй бүс дэх газар доорх усны урсгалын үндсэн тогтолцоог хэтэрч болохгүй, онцгой тохиолдол нь диффузи-дисперсийн процесс болох ба түүний ач холбогдол нь харин практик дээр шийдвэрлэгддэг бараг ихэнх тохиолдлуудад судалгааны дүгнэлтийн авч үзсэн нарийвчлалаас нэгжээр, заримдаа бүр хэдэн арван метрээр доогуур байдаг; диффузи-дисперсийн процесс бохирдуулагч үүлний хөдөлгөөнд хэдэн арван см-аас хамгийн ихдээ м-ийн нэгж хүртэл нөлөөлдөг; тэдгээрийн харьцангуй ач холбогдол орчны нэвтрүүлэх шинж чанарын бууралтыг даган өсдөг, иймээс бохирдлын шилжилтэд

гидрогеологийн изоляторуудын эсвэл нягт талст чулуулгийн буюу – гидрогеологийн массивын бага нэвчилттэй орчинд байх нь нэн чухал).

Тээвэрлэлтийн загвар нь газар доорх усны урсгалын загвар дээр суурилсан загвар бөгөөд тодорхой нэгэн химийн бодисын (бохирдуулагч) тээвэрлэлтийн үйл явцыг харгалзан үзсэн геологийн орчноор дамжих алхмыг дүрсэлдэг (газар доорх усны урсгалын нөлөөллийн адвекцээс гадна голдуу шингээлт, гидродинамикийн дисперс ба доройтлын үйл явцыг агуулдаг). Ховорхон тохиолддог, дангаар нь шийдвэрлэх шаардлагатай тээвэрлэлтийн үйл явцуудыг (ж.нь: дэгдэлт – дэгдэх, химийн харилцан үйлчлэл гэх зэрэг) арилжааны загварчлалын программ хангамжууд ихэнхдээ агуулаагүй байдаг. Газар доорх усны урсгалын загварчлал хийгээд бодисын тээвэрлэлтийн загварчлалыг агуулсан арилжааны, хамгийн түгээмэл хэрэглэгддэг програмуудаас жишээлбэл, MODFLOW эсвэл FEFLOW-г нэрлэж болно.

Бодисууд, газар доорх ус болон чулуулгийн орчин хоорондын геохимийн үйл явц ба харилцан үйлчлэлийг дэлгэрэнгүй судалдаг **геохимийн харилцан үйлчлэлийн загвар** байдаг талаар дурдах нь зүйтэй. Тэдгээрийн үр дүн ба дүгнэлтүүд нь дээр дурдсан тээвэрлэлтийн загварууд, тэдгээрийн нарийвчлалд сайн ашиглагдаж болно. Ийм загваруудын жишээнд PHREEQC, WATEQ4F эсвэл MINTEQA2 орж болно.

Хэд хэдэн төрлийн загварууд байдаг хэдий ч, геологийн болон гидрогеологийн байдал нь бие даасан, эцсийн блокуудын тусламжтайгаар төлөөлөгдөх тоон загварууд нь хамгийн өргөн дэлгэрсэн төрөл юм.

Эцсийн элемэнт, эцсийн эзлэхүүний эсвэл эцсийн дифференцийн арга – загварчилсан орчин ба үйл явцыг математикаар илэрхийлэх янз бүрийн хандлага дээр үндэслэсэн загварын шийдлийн математик боловсруулалтын хэд хэдэн үндсэн хандлага бий. Ашиглагдсан загварын зарчим, түүний боловсруулалтын алхам нь загварын хэрэглээний тухай тайланд нарийн тодорхойлогдсон байх ёстой. Газар доорх усны урсгалын ба масс хадгалагдах хуулийн үндсэн тэгшитгэл дээр үндэслэн тооцоо хийгддэг.

Математик загварын бүрдүүлэлт хэд хэдэн алхмуудтай:

- загварын шийдлийн хариу өгөх зорилго ба асуултуудыг тодорхойлох (загварын өгөгдөл),
- өгөгдлүүдийг цуглуулах – загварын чанар нь анхны өгөгдлүүдийн хэмжээ ба чанараас шалтгаална; иймээс математик загварыг хангалтгүй хийж гүйцэтгэсэн судалгааг нөхөх зүйл хэмээн ойлгож болохгүй. Ашиглагдсан загварын программ хангамж нь маш бага хэмжээний өгөгдөл дээр үндэслэсэн математик загвар, түүний загварчлал/симуляцийг үүсгэх чадвартай ч, түүний мэдээлэх чадвар нь маш хязгаарлагдмал,
- концепцийн загвар үүсгэх (геологийн орчинд болж буй үйл явц ба тогтоцын тухай үндсэн төсөөлөл, түүнд болж буй орчин ба үйл явцыг математикийн тайлбарын зорилгоор хялбаршуулан бичиж, схемчлэх),
- математик загварыг сонгох – загвар боловсруулдаг шинжээчид оногдох нарийн төвөгтэй асуудал. Геологийн орчин ба асуудлын шинж чанартай танилцсаны дараа ашиглах оновчтой программ хангамжийг сонгоно,
- загварын сүлжээ үүсгэх, параметрууд болон хязгаарын нөхцлүүдийг оруулах – уг орчин ба түүний доторх үйл явцуудыг математикийн аргаар бичих (тодорхойлох) боломжтой болгохын тулд загварын орчныг дискретчилэх буюу бүдүүвчлэх, хялбарчлах,

- загварын шалгалт тохируулга ба баталгаажуулалт: Загварын шалгалт тохируулга гэдэг нь загварчилсан болон бодитоор илэрсэн өгөгдлүүдийн хооронд оновчтой нийцэлд хүрэх зорилготой загварын засвар юм. Загварын шалгалт тохируулгыг загварын анхны үе шатанд буюу загварыг бэлэн, бодит өгөгдлүүдэд тохируулдаг бол, харин дараа нь шалгалт тохируулгын шинэчлэлийг урьд өмнө нь боловсруулсан загвартай нийцсэн эсвэл хэмжээ алдсан байдлыг үзүүлдэг, хэмжигдсэн бусад өгөгдлүүдийн тодорхой эгнээ бэлэн болсон үед хийж гүйцэтгэдэг. Иймээс газар доорх усны урт хугацааны мониторинг бүхий даалгаваруудад (тоо хэмжээний эсвэл чанарын) загварын шинэчлэлийг цаг тухайд нь хийж гүйцэтгэх маш чухал, ингэснээр загвар, ирээдүйд чиглэсэн загварчилсан үзэгдлийн цаг хугацааны загварчлал/симуляцийг үнэн зөвөөр олгоно. Баталгаажуулалт гэдэг нь загварын төлөөлөх байдлыг буюу загварчилсан үйл явцын зүгээс загварчилсан үйл явц ба орчны шинж чанарын тухай онолын мэдлэгтэй тохирч байгаа эсэхийг үнэлэх үнэлгээ юм,
- мэдрэг чанарын шинжилгээ (sensitivity analysis) – энэ нь маш чухал мэдээлэл (нэн ялангуяа балансын тооцоонд), загвар, өгөгдлийн ямар нарийвчлалтай тооцоолж байгаа тухай (анхны ба үр дүнгийн), мөн загвар, хэдий хэмжээний үйл явц ба үзэгдлийг тооцоолох боломжтойг илэрхийлэх юм. Логикоор үзэхэд, загвар хэр зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүдийг тооцоолно, төдий чинээ анхны өгөгдөлд тавигдах шаардлага нэмэгдэх бөгөөд ингэснээр, нийт загварыг тооцоолоход том, хүндрэлтэй болохын зэрэгцээ, цаг хугацааны хувьд ч төвөгтэй бас үнэтэй болно.
- үр дүнгийн тайлал: боловсруулсан загварын зохион бүтээгчийг хайхралгүй өнгөрөөж болохгүй. Ихэнх тохиолдолд загварыг тухайн газар нутгийг мэдэхгүй, зөвхөн хүлээлгэн өгсөн өгөгдлүүдтэй ажилладаг мэргэжилтэн боловсруулдаг учир загварт газар нутагтай холбогдох онцгой нөхцөл байдлуудыг оруулах боломжгүй. Хариуцлагатай шийдвэрлэгч ажилтан нь математик загварын үр дүнг тодорхой газар нутагт хэрэглэх ёстой; Уг ажилтан нь газар нутгийн нөхцлийг дэлгэрэнгүй мэддэг байхын зэрэгцээ, ядаж загварын үе шатуудын тухай ерөнхий мэдлэгтэй байвал зохино. Хариуцлагатай шийдвэрлэгч ажилтан нь олон жилийн дадлага туршлагатай мэргэжилтэн – гидрогеологч байх ёстой.

  Анхны өгөгдөл мэдээллүүд дээр үндэслэн, байгалийн бодит орчны шилжилтийг одоо байгаа программын кодуудын тусламжтайгаар шийдвэрлэх боломжтой, энгийн загварын системд шилжүүлэх боломжийг олгодог концепцийн загвар үүсгэнэ. Олж авсан ба хэмжсэн өгөгдлүүдийн нэгтгэл зайлшгүй чухал, өөрөөр хэлбэл, тэдгээрийг загварт цогцлуулан нэгтгэх нь ихэнхдээ боломжгүй. Нөгөө талаас концепци загвар хээрийн нөхцөлд хэдий чинээ ойр, баталгаатай байна, төдий чинээ нарийвчлал сайтай үр дүнд хүрнэ гэдгийг ойлгох нь зүйтэй.

Анхны параметруудыг оруулсны дараа загварын шалгалт тохируулгын ажил явагддаг. Энэ хэсэг нь голдуу цаг хугацааны хувьд нийт загварчлах үйл ажиллагааны хамгийн хүндрэлтэй хэсэг бөгөөд үүнээс загварын бодит үр дүн өгөх чанар шалтгаална. Шалгалт тохируулгын явцад загвар, талбай дээр хэмжигдсэн өгөгдлүүдийг боловсруулах чадвартай байхын тулд загварын анхны параметруудад өөрчлөлт оруулдаг (газар доорх усны гадаргын түвшин, орох ба гарах урсацын хэмжээ, ажиглалтын цооногууд дахь бохирдлын концентраци г.м).

Загварын шийдлийн үр дүн:

- одоо байгаа системийн үнэлгээ (ж.нь: шавхагддаг цооногийн хамгааллын бүсийг тогтоох, бохирдлын тархалтыг урьдчилан тогтоох, жамаараа саарах үйл явцыг тогтоох),
- цаг-орон зайн загварчлал/симуляци хэлбэрээр орчинд тархах шинэ тархалтын нөлөөг тогтоох (ж.нь: шинэ цооногуудын шавхатын нөлөө, нөхөн сэргээлтийн үйл ажлын хувилбаруудын үнэлгээ).

4.7 Геофизикийн аргууд

Геофизикийн аргууд нь гидрогеологийн судалгаанд өргөнөөр хэрэглэгддэг. Физикийн янз бүрийн оронууд болон хэмжигдхүүнүүдийн хэмжилт дээр суурилсан шууд бус судалгааны аргууд бөгөөд геологийн, гидрогеологийн болон тдорхой нэгэн газар нутгийн бохирдлын харьцаан дээр дүгнэгддэг. Энэ нь үл эвдэх арга, өөрөөр хэлбэл, хэмжилт хийгдсэн газар нутгийг огт гэмтээдэггүй, түүнд түүний дараагийн ашиглалтыг хязгаарлах ямар ч ул мөр эсхүл үлдэгдэл үлдээдэггүй гэсэн үг юм (ж.нь: судалгааны цооногууд шиг). Тодорхой тохиолдлуудад цооногийн судалгаанаас харьцангуй хямд арга байж болох юм. Нөгөө талаас геофизикийн өгөгдлүүдийн оновчтой тайлалд тэдгээрийг зөвхөн цооногийн болон гидрогеологийн судалгаанаас голдуу олж авдаг хэмжилтийн орчны тухай шууд мэдээллүүдтэй уялдуулах шаардлагатай. Бэхэлгээт цооногийн профилиуд нь (параметрт цооногууд) газар нутгийн судалгаанд нэн зайлшгүй, мөн тэдгээрийн хоорондын мэдээлэл (тэдгээрийн хэвтээ ба босоо тайлал) бидэнд геофизикийн судалгааны үр дүнг маш нарийн тодорхойлон өгч болно.

Геофизикийн аргуудын давуу талууд нь ажлын хэрэгжилтийн харьцангуй хурд ба тэдгээрийн байгаль орчинд эелтэй байдал юм. Ажлын арга барил хүнд механизмын үйл ажиллагаатай холбогдолгүй. Геофизикийн багаж хэрэгслүүдийг зөөвөрлөхөд хялбар учир геофизикийн багийн талбай дээрх хөдөлгөөн газар эзэмшигчдийн эзэмшлийн эрхэд ямар ч ноцтой хохирол учруулдаггүй.

Геофизикийн аргуудыг гидрогеологийн судалгаа болон бохирдсон газар нутгийн судалгааны үеэр амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах зарчмуудыг баримтлах шаардлагатай:

- Гидрогеологийн цогц судалгааны хүрээнд төлөвлөгдсөн ажлын цаг хугацааны уялдаа (үе шатлал) (геофизикийн ажлыг хэрэгжүүлэхийн өмнө хэмжигдсэн өгөгдлүүдийн нарийн тодорхой бөгөөд чанартай тайлалыг олгох хэд хэдэн параметрт цооногуудыг байгуулах нь зүйтэй),
- төлөвлөгдсөн геофизикийн аргуудын оновчтой цогц сонголт (геологийн нөхцөл байдал болон геофизизийн аргуудаар хариулах асуултуудаас хамаарч). Геофизикийн судалгаа гэдэг нь зөвхөн тодорхой хязгаарлагдмал хэмжээнд бодит байдлын нарийн учрыг үзүүлэх, физикийн шинж чанаруудын эцсийн тоонд үндэслэн тодорхойлогддог орчин юм. Геологийн ба гидрогеологийн харьцааны нарийн тодорхой тайлалд тэдгээрийн олон физикийн шинж чанаруудын илрэлийг шинжлэх нь тохиромжтой буюу хэд хэдэн геофизикийн аргуудын оновчтой цогцыг үргэлж хэрэглэх явдал юм. Хэмжилтийг янз бүрийн аргуудаар зэрэг үнэлэх нь янз бүрийн физикийн оронуудад өөрөөр илэрдэг хэвийн бус байдлыг тайлах болон геологийн орчныг илүү сайн бөгөөд баттай нарийн таньж мэдэх боломжийг олгодог (чулуулгийн үе давхаргууд, чухал хүрээ, гидрогеологийн харьцаа, ус ба бодисын урсгалын динамик г.м),

- шаардлагатай мэдээллийг шаардсан чанартай олж авахын тулд тодорхойлсон орон зайд геофизикийн аргуудыг шаардлагатай хүрээнд сонгох (профиль хоорондын зайг сонгох, профилийн чиглэлийг сонгох, профилиуд дээр хэмжилтийн алхмыг сонгох).

Гидрогеологд геофизикийн аргууд нь дараах асуудлуудыг голчлон шийдвэрлэдэг:

- газар доорх усны урсац, эсвэл бохирдуулагч бодис төвлөрсөн ан цавт орчинд усжсан, тектоникийн шугамуудыг мөрдөх,
- жишээлбэл, усны урсацын хөндий дэх голын хайргархаг элст хурдасуудыг ашигладаг худаг ба цооногийн гүнийг төлөвлөхөд шаардлагатай үндсэн мэдээлэл болох дөрөвдөгч усан цогцолборын зузааныг тогтоох,
- уст давхаргыг тодорхойлох (жишээлбэл: шавар, шохойнцор, шаварлаг чулуу, шохойн чулуу ба бага нэвчилттэй бусад чулуулгуудын давхаргад чиглэсэн элсэн болон элсэрхэг давхаргыг тодорхойлох); ж.нь: хэд хэдэн уст коллекторууд дээр дээрээсээ орших сав газрын орчны тайлбар тэмдэглэлд зориулагдсан, мөн тодорхой судалгааны судлах зүйл болсон давхаргуудыг таних зорилготой, нэн ялангуяа гадаргуугаас доош орших бүсийн (20-50 м-ээс гүн) тухай маш чухал мэдээлэл юм,
- газар доорх усны урсгалын чиглэлийг ажиглах (судалгааны цооногуудын ажиглалтын торны нягтаршил хангалтгүй тохиолдолд, газар доорх усны дамжуулах шинж ба чулуулгийн орчны дифференци ач холбогдолтой байна гэсэн таамаглалд үндэслэн, геофизикийн тусламжтайгаар, газар доорх усны урсгалын чиглэлийн тухай хангалттай мэдээллийг олж авч болно),
- газар доорх усны хөдөлгөөнд чиглэсэн хаалтны үүрэг гүйцэтгэх тогтоцын явцыг илрүүлэх (усан тогтоцын хязгаарыг тогтоох, гидравликийн хязгаарын нөхцлүүд ба тэдгээрийн талбайн тархалт болон хил хязгаарыг газрын зурагт оруулах).

Геофизикийн аргуудын хэрэглээг хязгаарлагч хүчин зүйлүүд:

- ***талбайд нэвтрэх*** – экологийн ачааллын судалгааг ихэнхдээ инженерийн шугам сүлжээ, шигүү барилга байгууламж, үл нэвтрүүлэх хатуу хучилт гэх зэрэгтэй үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ойр орчимд хийж гүйцэтгэдэг. Энд гадаргын объектуудын (барилга, хашаа) саад бологч физикийн илрэлүүд болох тааламжгүй хязгаарлагч, томхон хэмжээний багаж хэрэгслүүд, операторуудын нэвтрэх боломжийг хязгаарлагч, мөн газардуулагчид зориулагдсан электродын зоолт эсхүл геофон байршуулах боломжийг хязгаарлагч нөхцлүүд илэрдэг,
- ***чичиргээний нөлөө*** (физикийн ба геологийн) – оршиж буй физикийн оронууд хэмжигдсэн өгөгдлүүдийн чанарт тааламжгүйгээр нөлөөлж болзошгүй. Эдгээр орнуудад цахилгаан машин механизмын газардуулагч, инженерийн шугам сүлжээ (хий гүйдэл), газар хөдлөлтийн доргилт, чичиргээ (машин механизмын хөдөлгөөнт хэсгийн механик нөлөө, тээврийн үйл ажиллагаа) гэх зэргээс үүдэлтэй, цаг хугацаа болон орон зайн хувьд саад хийгч, эмх замбараагүй өөрчлөгддөг цахилгаан соронзон орон багтана. Физикийн чичиргээний нөлөө өгөгдлүүдийг цуглуулах үе шат, мөн бас тэдгээрийн тайллын үе шатад сөрөг нөлөөтэйгөөр илэрдэг. Хэвийн бус байдлыг илрүүлэх боломжид, хэрэв эдгээр хэвийн бус байдлууд нь ихэнхдээ гомогенийн бус орчныхтой адил бага, эсвэл харьцуулж болохуйц байвал бас хучилтын шавар (байгалийн бас антропогенийн) болон ул чулуулгийн физикийн гомогенийн бус байдал ноцтойгоор

илэрдэг. Орчны гомогенийн бус байдлын нөлөөг геологийн чичиргээний бүлэгт оруулдаг,

- ***нарийвчлал сайтай өгөгдлүүд олж авах, мөн тэдгээрий н хоёрдмол утгагүй тайлал*** – орчин үеийн геофизикийн ихэнх багаж хэрэгслүүд өгөгдлүүдийн хэмжилтийг маш өндөр чанартайгаар, нарийвчлал сайтай хэмжих чадвартай. Иймээс хэмжилт давтагдах асуудал нь янз бүрийн чичиргээний нөлөөнөөс хамаарна. Ажиглагдаж буй объектын хэвийн бус хариу үйлдлийн хэмжээнээс авч үзэхэд чичиргээний бүтэц ба харьцангуй хэмжээ нь геофизикийн аргуудын эдгээр объектуудыг илрүүлэх чадварт нөлөөлдөг. Үүнээс үзэхэд, чичиргээнд паразитлагч физикийн орнуудын нөлөө төдийгүй, ойр орчмын гомогенийн бус байдлын нөлөөг хамруулдаг. Чичиргээг ерөнхийдөө хамгийн өргөн хүрээнд арилгах нь өгөгдлүүдийг боловсруулах даалгаврууудын нэг мөн. Чичиргээ нь орон зайн хувьсал (гол нь ойр орчмын ажиглагдаагүй объектуудын нөлөө, ихэнхдээ ажиглагдаж буй объектуудынхаас харьцангуй бага боловч чухал байдаг) болон цаг хугацааны хувьсал (хувьсах цаг хугацааны туйлын нөлөө) буюу өөрчлөлтийг үзүүлдэг. Тэдгээрийг арилгах боломжуудаас үзэхэд, тэдгээрийн статистикийн цаг хугацаа болон орон зайн шинж чанар шийдвэрлэх гол үүрэгтэй. Хоёр нөлөөг орон зайн (хэвийн бус байдлын ангилал) болон цаг хугацааны өгөгдлүүдийг статистикийн аргаар боловсруулж арилгадаг.

Гидрогеологийн зорилгоор судалгааны ажил хийх үеэр геоцахилгаан болон чичирхийллийн аргуудыг өргөнөөр ашигладаг.

4.7.1 Геоцахилгаан геофизикийн аргууд

Геоцахилгаан аргуудаас ялангуяа хамгийн түгээмэл хэрэглэгддэг, геофизикийн арга нь **эсэргүүцлийн профильжүүлэлт** (ОР) юм.

Геоцахилгаан аргуудаас, ялангуяа хамгийн түгээмэл хэрэглэгддэг геофизикийн арга бөгөөд чулуулгийн хувийн эсэргүүцэл нэг талаас литологи, нөгөө талаас орчны эсэргүүцлээс шалтгаалдаг тул чулуулгийн орчны нүх сүвэн дэх усны агууламж ба чанарыг маш мэдрэг нарийн харуулдаг. Эсэргүүцлийн аргуудад (профильжүүлэлт ба зонджуулалт) газар уруу зөөгдсөн цахилгаан орны ижил чиглэлтэй урсгал ба хүчдэлийн хэмжигдсэн утгуудаас орчны хувийн эсэргүүцлийг хэмжин тодорхойлдог. Эсэргүүцлийн профильжүүлэлтийн үеэр хэвтээ чигт хувийн эсэргүүцлийн өөрчлөлтийг ажигладаг (газрын зураг дээр), гүний далайц нь зохион байгуулалтын уртаар тодорхойлогддог газрын гадарга дээрх эх үүсвэрийн ба хэмжигч электродуудын зохион байгуулалтын хэмжээний сонголтоор - хуваарилалтаар удирдагдаж байдаг. Электродуудын зохион байгуулалт ихэнхдээ профилийн дагуу, тогтмол алхмаар хөдөлдөг.

Зарчмын хувьд эсэргүүцлийн профильжүүлэлттэй ижил арга бол мөн өргөнөөр хэрэглэгддэг, хэмжигч электрод нэг бүрийн зохион байгуулалтын уртыг аажмаар нэмэгдүүлэх аргаар судалж буй цэгийн доор, босоо чигт эсэргүүцлийн өөрчлөлтийг ажигладагаараа ялгаатай **босоо чигт цахилгаан зонджуулах** арга (VES) юм. Зонджуулалт нь эсэргүүцлийн хувьд эрс тэс, үе давхарга болон байршлын дэд хэвтээ хязгаарыг тогтоох зориулалттай.

Зорилгоор нь ашиглаж болохуйц дараагийн геоцахилгаан арга бол **албадмал бус туйлшралын арга** (SP) бөгөөд түүнийг ашигласнаар гадаргуу дээрх хоёр ба түүнээс олон

цахилгаан орны чадамжит зөрүү (хүчдэл) хэмжигддэг. Газарт байгалийн, хөдөлгөөнгүй, цахилгаан орон үүсэх шалтгаан олон ба эдгээр үзэгдлүүд нь цогцоороо орчны цахилгаан химийн активит хэмээх ойлголтыг тэмдэглэдэг. SP арга нь газар доорх усны хөдөлгөөнийг ажиглах, гидрогеологийн нягтруулах хаалтын гэмтэл, дамжуулагчаас алдагдаж буй г.м чадамжит шүүрэл үүссэн газруудыг тогтоох зэрэг зориулалттай. Ховор тохиолдолд SP аргыг дамжуулагчийн зэвэрсэн газруудын илрүүлэлтэд ашиглагдсан.

Цэнэгтэй биетийн аргад (NT) цооногоор дайралдах, газар доорх коллектор дахь дамжуулалтыг нь нэмэгдүүлсэн (хиймлээр дамжуулах, давжсан) бүс рүү газардуулж, гүйдэлт электродын ойр орчмын гадаргууд хиймлээр оруулсан, цахилгаан орны чадамж эсхүл хүчдэлийг хэмждэг. Нэмэгдүүлсэн бүс, газар доорх усны хөдөлгөөнөөр зөөвөрлөгддөг, ийм учраас нэмэгдсэн хөдөлгөөний хяналт маш өндөр дамжилттай, өөрөөр хэлбэл, гадаргуу дээрх цахилгаан орны өөрчлөлтөөр дамжуулан цахилгаанаар цэнэглэгдсэн бүсүүд оновчтой тохиолдлуудад газар доорх усны урсгалын чиглэл ба хурдыг тогтоох боломжийг бий болгодог. NT аргын амжилт нь газар доорх усны байгалийн эрдэсжилт (бага эрдэсжилтийн үед давсны нэмэгдлээр илүү өндөр дамжуулалтын эрс тэс байдлыг үүсгэнэ) болон цооногийн ойр орчмын геоцахилгаан нөхцлүүдээс (ялангуяа, эсэргүүцлийн нэгэн төрлийн байдлаас) шалтгаална. Хэт эрс тэс, дамжуулалт үүсвэл нэмэгдүүлсэн дамжуулах бүсийн хөдөлгөөнийг гадаргуу дээр, мөн эсэргүүцлийн аргуудаар ажиглаж болно.

Маш урт долгионы арга (VDV) нь чиглүүлэгч радиостанцын (10-30 кГц) цахилгаан соронзон оронг ашигладаг. Эдгээр орнуудын гажилт (хэвийн бус байдал) дамжуулалтын нэгэн төрлийн бус байдалтай холбоотой – дамжуулагч чулуулгууд ба усаар ханасан гэмтэлтэй бүс, мөн хиймэл дамжуулагчуудын (инженерийн сүлжээ, дамжуулагчууд, цахилгаан дамжуулалт гэх зэрэг). Цахилгаан соронзон орнуудын цахилгаан нэгдлүүдийг индукцийн ороомгуудын тусламжтайгаар хэмждэг VDV арга (индукцийн хэлбэрт) нь эдийн засгийн хувьд хамгийн ашигтай геофизикийн аргуудад ордог. Жишээлбэл, газрын хэвлий дэх дамжуулагч, ялангуяа дамжуулагч бус тектоникийн явцыг зурагжуулах үеэр үр дүнтэй (ж.нь: галт уулын, карбонатууд, элсэн чулуулгууд). Орны харьцангуй өндөр давтамжийг орчны дамжуулах чадвараас шалтгаалан эхний хэдэн арван метрийн гүн дэх гүехэн судалгаагаар бий болгодог.

VDV (VDV-R) аргын эсэргүүцлийн хувилбар гэгдэх аргад ороомог ба газардуулагч электродуудын тусламжтайгаар электродын радиостанцын орны соронзон төдийгүй, цахилгаан бүрэлдэхүүнийг хэмждэг. Хоёр бүрэлдэхүүний харьцаанаас орчны хувийн эсэргүүцлийг тогтооно. VDV-R арга нь чулуулгийн зурагжуулах ажлыг хийхэд ч тохиромжтой бөгөөд эхний хэдэн арван метрийн гүн дэх гүехэн судалгаанд зориулагдах эсэргүүцлийн профильжуулалтыг хялбархан хэлбэрээр орлуулж байгаа юм. VDV аргын сул тал гэвэл геологийн дамжуулагчуудын илрэлийг сүүдэрлэх, өргөн хэмжээний, том гажилыг үүсгэдэг хиймэл дамжуулагчуудийн (гол нь өндөр хүчдэлийн дамжуулалт) хүчтэй нөлөө мөн.

Идэвхтэй цахилгаан соронзон арга болох **цахилгаан соронзон профильжуулалтын туйлын арга** (DEMP) нь хоёр оромог ашигладаг (антен) – эх үүсвэрийн болон хэмжигч. Ороомгуудын зай (1 - 10 м, ороомгууд нь тогтоосон урт бүхий кабелаар холбогдоно) болон эх үүсвэрийн давтамжаар (100 Hz - 10 Hz) гүний далайцыг тодорхойлно.

Орчин үеийн багаж хэрэгслүүд нь олон давтамжийнх байдаг (хэд хэдэн давтамжинд, антенийн янз бүрийн зайд хэмждэг). Ороомгийн тэнхлэгийн чиглэлийг ажиглаж буй дамжуулалтын нэгэн төрлийн бус байдлын дагуу сонгодог (эгц тектоникийн шугамын илрүүлэлт, чулуулгийн тархалтын зурагжуулалт, дамжуулах эсхүл үл дамжуулах рельефийн ажиглалт гэх зэрэг).Цахилгаан соронзон аргад шаардагдах тоног төхөөрөмжийн тоноглол нь эсэргүүцлийн аргуудынхаас илүү төвөгтэй байдаг ба дамжуулагч орчинд гүний далайц хязгаарлагдмал байна (10 м орчим). Үүнээс гадна тааламжгүй цахилгаан соронзон шуугианаар хязгаарлагдах нь элбэг. Өөрийн чадварын зорилгоор, бохирдол тархах тээвэрлэлтийн замууд байж болох гүехэн газар агуулагдах дамжуулах бүсүүдийг (жишээлбэл: тодорхой бүтэц бүхий элемэнтүүд дээр суурилсан гүехэн уст үе) таньж мэдэхэд ашиглагдах нь нэлээд элбэг.

Гүехэн газарт агуулагдах, дамжуулагч металл объектын хайгуулд анх нуусан зэр зэвсгийг (мина хайгч) хайхад зориулан хөгжүүлсэн **металл илрүүлэгчийг** (metaldetector MTD) амжилттайгаар ашиглаж болно. Эдгээр илрүүлэгчүүд нь цацах болон хүлээн авах антентай бөгөөд хувьсах, эсвэл пульсын оронгийн индукцийн зарчим дээр ажилладаг.

Георадарын арга эсвэл **георадар** буюу радиолокацийн арга (GPR - ground penetrating radar) нь гадаргуу доор өөрийн өндөр давтамжийн (50 - 1 000 МГц) цахилгаан соронзон пульсыг цацах болон цахилгаан соронзон шинж чанаруудын, голчлон цахилгаан хувийн багтаамжийн өөрчлөлтийн илрэл болох гадаргуу доорх тусгалын хязгаараас ойсноос хойш хүлээн авах хугацааг бүртгэх зарчим дээр суурилсан.

Сүүлийн үеийн багаж хэрэгслүүд ерөнхийдөө ойлтын хязгаарын үйл явцыг хэмжигдсэн профилийн дагуу, ойлтын бүртгэгдсэн цаг тусгалын талбайн гүнд цахилгаан соронзон долгион орчинд тархах хурдны илрүүлсэн эсхүл таамагласан эсэхээс хамаарч шилжих георадарын зүсэлт хэлбэрээр олон метрийн гүн хүртэл ажиглах боломжийг өгдөг.

Энэ хурдыг тодорхойлоход профилийн гомогенийн хэсгүүдэд хоёр антенийн хоорондын зай төвөөс ижил байх зондын хэмжилтийг хийж гүйцэтгэдэг. Гүний далайцад орчны дамжуулалт таагүй нөлөөлдөг. Зуу орчим оммметрийн хувийн эсэргүүцэлтэй орчинд (гүехэн зүсэлтийн ердийн нөхцөл) хэдэн метрээс илүү гүний далайцыг тооцоолж болохгүй. Георадар нь хамгийн түгээмэл гүехэн судалгааны аргуудад ордог – ялангуяа гүехэн хучилттай, эсхүл үл дамжуулах чулуулгийн илэрцтэй бүсүүдэд.

4.7.2 Геофизикийн чичирхийллийн аргууд

Чулуулгийн масс ба түүний хөрс чулуулгийн байдлыг ажиглахад чичирхийллийн аргуудаас **гүехэн, хугаралын чичиргээг** (MRS) ашиглах нь олонтаа. Гадаргууд сулхан ачаалал эсвэл алхны цохилтоор үүсэх чичиргээний дохионы ирэх хугацаа алслагдсан цэгүүдэд геофонуудын тусламжтайгаар механик түлхэлтийг цахилгаан хүчдэлд, бүртгэлийн сейсмографд шилжин бүртгэгддэг. Геологийн орчноор дамжин өнгөрөх чичирхийллийн долгионууд чичирхийллийн хязгаараас ойж, тэдгээр дээр хугарах бөгөөд гүехэн байгууламж, ялангуяа хатуулаг уул чулуулгийн рельефийн тухай мэдээллийг км/с чичирхийллийн өндөр хурдтайгаар авчирдаг. Бэхжүүлээгүй агууламжийн хучилтууд, антропогенийн агууламжууд (ж.нь: хаягдал материал) бага буюу зуугаад м/с хурдтай байдаг.

Гүехэн, тусгалын чичиргээ (RXS) гадаргуу доорх зааг хязгаараас ойсон долгионы бүртгэл болон судалгааг авч үздэг. Энэ нь газрын тосны агууламжийн гүний судалгаанд

өргөн хэрэглэгддэг арга (үүний ачаар хамгийн чанартай программ хангамжаар тоноглогдсон байдаг) боловч гүехэн газрын судалгаанд маш ирээдүйтэй.

4.7.3 Геофизикийн бусад аргууд

Гравиметрийн, соронзонметрийн аргууд, эсхүл радиометрийн аргуудын тусламжтай хийгдэх судалгаанд багахан хэрэглэгддэг.

Геосоронзон орны гажилтууд эрс тэс соронзон шинж чанартай чулуулгийн төрөл ба хиймэл объектуудын байгаагаас шалтгаалдаг. Хэмжилтийг ихэнхдээ протонын соронзонметр, заримдаа атомын (ж.нь: цезийн) нарийн соронзонметрээр хийж гүйцэтгэдэг.

Соронзонметр эсвэл (гео)соронзон хэмжилт (Mag) нь хувийн соронзон багтаамж, эсхүл мэдрэг чанар (ферромагнит материалын, голчлон төмөр ба гангийн) - эрс тэс соронзон шинж чанартай газар доорх объектуудыг илрүүлэх, соронзон эрс тэс литологийн төрөл зүйлүүдийг зурагжуулах зориулалттай. Орны цагийн ялгаатай байдал, бүсийн гажилт ба бусад саад бологчуудын нөлөөг (инженерийн шугам сүлжээний, хийцийн гэх зэрэг) градиентын хэмжилтээр багасгах боломжтой (градиометрүүд - MGM). Газар доорх металл объектуудын байршилд соронзон хэмжилтийг гүехэн газар агуулагдах багахан хэмжээний металл объектуудын хайгуулд ашигладаг металл илрүүлэгчийн хэмжилттэй (металл илрүүлэгч - MTD) хослуулдаг бол Mag-г том бөгөөд гүнд орших ферромагнит эд зүйлийг илрүүлэхэд ашиглана.

Чулуулгийн төрөл зүйлийн ангилалд (ялангуяа дээжүүдэд) түүний соронзон шинж чанарыг (капа соронзон мэдрэх чанар) хурдан олж мэдэх боломжтой **капаметр**-г ашиглана. Уг чанарыг мөн хөрсний бохирдлыг ойролцоогоор тогтооход ашиглаж болно.

Гравиметр (Gra) нь маш өндөр нарийвчлалтай гравиметрийн аргаар хүндийн талбай хэмжих ба хүндийн гажилтаас геологийн орчны нягтыг тараахад суурилсан арга юм. Нягтын эрс тэс байдалд үндэслэн янз бүрийн литологийн төрөл зүйлүүдийг ангилах, эвдрэлтэй - тектоникийн бүсийг хайх, газар доорх хөндийг (хиймэл бас байгалийн, хоосон эсхүл усаар дүүрсэн) илрүүлэх, өндөр нягттай уул чулуулгийн рельефийг ажиглах, хучилтын болон антропогенийн агууламжуудын жишээлбэл, бага нягттай хог хаягдлын овоолгын тархалт ба зузааныг зурагжуулах боломжтой

Дэлхийн дулааны орон нь цацраг идэвхт элемэнтүүдийн задралаар үүсдэг, газрын гадаргуугийн механик хөдөлгөөний үеэр дулаан ялгарах г.м. Гадаргын дулааны гажилтын хэсгийн эх үүсвэрт газар доорх усны (дулаан усны хэт эрс тэс байдал) болон химийн процессууд ба байгаль дээрх бас хиймэл хогийн цэг дэх шаталтуудын гарах гарцууд орно. **Термометр**ээр хэмжих хэмжилтийг хүрэлцэх (термисторууд) эсвэл үл хүрэлцэх термометрүүдээр (хэт улаан туяаны мэдрэгч) хийж гүйцэтгэдэг. Өргөн тархсан бүсүүдэд бас хэт улаан туяаны интервалд (агаарын, сансрын) алсын зайнаас зураг авах аргыг ашиглаж болно. Газрын дулааны хэмжилтийг (Term) цасан хунгар доор гэх зэрэг улирлын болон гүний, дулааны өөрчлөлт бага илэрдэг эсрэг тэсрэг цаг уурын өөрчлөлтийн нөхцөлд хийх нь тохиромжтой.

Цацраг идэвхт туяаны эх үүсвэрийн байгалийн болон хиймэл түгэлтийг тогтоох нь цацрагийн идэвхийг - гадаргуу дээрх, цооног доторх мөн агаараас **радиометр**ээр (Rad) хэмжих боломжийг бүрдүүлдэг. Ихэнхдээ цацраг идэвхжилтийг өөрийн ионжуулалтын нөлөөнд тулгуурлан тохиромжтой багаж хэрэгслүүдээр илрүүлдэг. Нийт идэвхжилтийг бүртгэдэг эсвэл спектрометрүүдийн (**гамма спектрометр** - SG) тусламжтайгаар цөмийн

цацрагийн янз бүрийн эрчим хүчний илрэлүүдийг ялгадаг. **Эманометр** (Em) -г тектоник шугам илрүүлэхэд ховорхон ашигладаг (хэмжилтийн хогилд шавхагдсан хөрсний агаарт цацраг туяаны ионжилтын нөлөөг хэмжихэд). Зарим нэгэн литологийн төрлүүдийг ялгахаас гадна радиометр нь орчны цацраг идэвхт бохирдлыг тогтоох, түүний эрсдэлийг үнэлэхэд зориулагдсан.

Геофизикийн аргууд (буюу цооног дахь геофизикийн хэмжилт) нь гидрогеологийн судалгааны худаг байгуулах үеэр олж авсан мэдээллүүдийн цогц дүгнэлтэд маш хэрэгтэй.

ЧУХАЛ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

анизотропи	орчны шинж чанарын өөрчлөгдөж буй чиглэлээс хамаарах байдал; орчны шинж чанар чиглэлээс хамааран ялгаатай байдаг, жишээ нь гидравлик дамжуулах чадварын коэффициентын утга өөр байдаг; изотропийн эсрэг байдал
артезийн уст үе	дээд талаасаа (изолятор, артезийн тааз) ус үл нэвтрүүлэх давхаргаар хучигдсан түрэлттэй гадарга бүхий уст үе; уг ус үл нэвтрүүлэх дээд талын давхаргад цооног өрөмдсөн тохиолдолд ус гадаргуугаас дээш орших пьезометрийн даралтын түвшинд өснө.
газар доорх усны усгүйжүүлэх суурь	ямар нэгэн уст системээс газар доорх ус урсан гарч, гадаргууд ил гарах буюу гадаргын усанд цутгаж буй газар; газар доорх усны усгүйжүүлэх байгалийн суурь нь гол төлөв гадаргын усны хөндийд оршдог; ингэхэд тухайн газрын газар доорх усгүйжүүлэх суурь нь элэгдлийн суурьтай төстэй байна.
газар доорх усны баланс	газар доорх усны нөөцийн өөрчлөлтөд нөлөөлөх үзүүлэлтүүдийн тоон харилцааны цаг хугацаагаар өөрчлөгдөх зүй тогтол.
биозадрал	гол төлөв бичил биетийн тусламжтайгаар явагддаг бодисын биологийн задрал. Уг задралын явцад бичил биетүүдийн бодисын солилцооны үр дүнд янз бүрийн, ялангуяа органик бодис задарч энгийн бодис болж хувирдаг (жишээ нь, газрын тосны бүтээгдэхүүний биозадрал)
нийт сүвшил	хэлбэр, хэмжээ, үүсэл гарал, хоорондын харилцаанаас үл хамааран бүх нүх сүвийн эзлэхүүнийг орчны нийт эзлэхүүнд харьцуулсан харьцаа, нээлттэй болон хаалттай хоёр янз байдаг
ус шавхах туршилт	Коллектороос газар доорх усыг шавхах, тохиромжтой төхөөрөмж (насос)-н тусламжтайгаар шавхагдах гидродинамик туршилтын нэгэн төрөл
Дарсийн хууль	шүүлтийн хурд **v** (буюу усны урсгалын хэмжээ **Q**), пьезометрийн (гидравлик) градиент **I**-н шугаман хамаарал
буурцын хүнхээл	буурцын талбай, газар доорх ус шавхагдсны улмаас буурсны өмнөх газар доорх усны түвшингийн хоорондох орон зай; газрын доорх усыг гидрогеологийн объектоос авах үед усны түвшин юүлүүр хэлбэртэй буурдаг
диффузи	бөөмсийн дулааны хөдөлгөөний үр дүнд молекул эсвэл ионууд өндөр концентрацитай орчноос бага концентрацитай орчин руу өөрөө нэвчих үзэгдэл
дисперси	газар доорх усанд шилжилтийн судалгаа хийх үеэр урсаж буй газар доорх усанд шилжиж буй бодисын сарнилын үйл явц. Орчны анизотропын дагуу ийм үйл явц дагуу, хөндлөн, босоо - хөндлөн чиглэлд явагддагаас хамааран ялгаатай байдаг.
дисперси чанар	нүх сүвтэй орчны шингэний хөдөлгөөний үед кинематик дисперси үүсгэх чадвар; дисперси чанарын тоон үзүүлэлтийг дагуу, хөндлөн эсвэл босоо зэрэг тухайн чиглэл дэх дисперси чанарын илтгэлцүүлээр илэрхийлдэг
өтгөн усархаг бус фазын шингэн (DNAPL)	уснаас илүү хувийн жин (нягт)-тэй усархаг бус (органик) бодисын шингэний бие даасан фаз (жишээ нь, PCE, TCE зэрэг хлоржуулсан нүүрс-устөрөгчийн төрлүүд).
буурцын нөлөөний хүрээ	ус шавхах объектын босоо тэнхлэг ба ус шавхалтаар нөлөөлөөгүй, газар доорх усны түвшин орших газрын хоорондох зай
шүүрэлтийн (дренажийн) суурь	Тодорхой ямар нэг уст системээс урсан ирсэн газар доорх ус гадаргууд илрэх эсвэл гадаргын усанд цутган орох боломжтой газар
үр нөлөөтэй, ашигтай нүх сүвшил	уулын чулуулаг дахь бүх нүх сүвийн эзлэхүүнийг гравитацийн хүчээр шингэн бодитойгоор урсдаг чулуулгийн нийт эзлэхүүнд харьцуулсан харьцаа
идэглэл, элэгдлийн суурь	байнгын ус өгөмжийн өргөн хүрээ бүхий тодорхой нэгэн бүсийн усгүйжүүлэх түвшин болох ус урсгуурын хамгийн гүн хөндийн ёроол
транспирац ууршилт	1. транспираци буюу ургамлын навчны гадаргуунаас ус ууршихын зэрэгцээ газрын

	гадаргуунаас явагдах ууршилт 2. тодорхой цаг хугацааны туршид ургамалын навчны гадаргуу, газрын гадаргуунаас ууршсан усны эзэлхүүн эсвэл усны дархаргын өндөр
экстраполяци	бохирдлын хавтгай болон орон зайн байршлыг тодорхойлох үед үр дүнг тайлах; үүнд хэмжилт хийсэн цэгүүдээс олж авсан мэдээллийг эдгээр цэгүүдээр хязгаарласан талбайгаас гаднах бохирдлын хэмжээг үнэлж тогтооход ашигладаг
3.1.3 Олон электродтой зохион байгуулалт (MEU) 8
3.1.4 Байгалийн ба хиймэл цахилгаан орны хэмжилт 9
3.1.5 Урт долгионы арга (VDV) 11
3.1.6 Идэвхтэй цахилгаан соронзон арга 12
3.2 Гүехэн буюу бага гүний сейсмо хайгуул 15
3.2.1 Гүехэн хугарлын сейсмо арга (MRS) 17
3.2.2 Гүехэн ойлтын сейсмохайгуул (RXS) 18
3.2.3 Сейсмо томограф (ST) 19
3.3 Магнитометр 20
3.4 Гравиметр 21
3.5 Дулаан хэмжих 22
3.6 Радиометр 23
3.7 Цооногийн геофикикийн хэмжилт (каротаж) 24
3.8 АГААРЫН АРГУУД БА АЛСЫН ЗАЙН ЗУРАГЛАЛ 26

4. ГЕОФИЗИКИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ АГУУЛГА БА ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮНГ АРХИВЛАХ АРГА 28

4.1 Геофизикийн тайлангийн агуулга 28
4.2 Хэмжилтийн үр дүнг архивлах арга 30

5. СУДЛАГДСАН БАЙДЛЫН АНГИЛАЛ 30

6. СУДЛАГДСАН БАЙДЛЫН АНГИЛЛААС ХАМААРАХ ГЕОФИЗИКИЙН АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ 31

6.1 Урьдчилсан судалгааны ажил 31
6.2 Дэлгэрэнгүй судалгааны ажил 31
6.3 Нэмэлт судалгааны ажил 32
6.4 Мэргэжлийн нэгдсэн тайлбар 32

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫГ АРИЛГАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЕОФИЗИКИЙН АРГАЧЛАЛУУДЫН ТОЙМ 32

8. ЗӨВЛӨМЖ БОЛГОХ СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ 34

Ашигласан тэмдэглэгээ, товчилсон нэрийн жагсаалт

Товч нэр	Jednotka	Тайлбар
Cond	mS/m	Цахилгаан дамжуулах чадамж
CPM	-	импульсын тоо 1 минутанд
DEMP	Re, Im (%)	диполын цахилгаан соронзон профилийн хэмжилт
DP	mV	нэвтрүүлэх потенциал
EM	-	цахилгаан соронзон
FP	mV	шүүлтийн потенциал
GK	CPM	гамма каротаж
GPR	MHz	георадар
GPS	-	global positioning systém
Gra	µm/s2	гравиметр
HGR	-	гидрогеологийн горим
MP	-	арга зүйн удирдамж
MPG	-	геофизикийн хэмжилтийн арга зүйн удирдамж
MEU	-	олон электродтой зохион байгуулалт
MRS	m/s	гүехэн хугарлын сейсмо хэмжилт
MTD	nT	соронзон металл илрүүлэх
NT	V (mV)	цэнэгтэй биетийн арга
OP, SOP	Ωm	эсэргүүцлийн профил, тэгш хэмийн профилийн хэмжилт
SOP 20-10-20	-	электродын хооронд метрийн зайтай эсэргүүцлийн профилийн хэмжилт.
ORP	mV	oxidation and reduction potentials
RXS	km/s	гүехэн ойлтын сейсмо хэмжилт
SG	A(Bq)	гамма спектрометр
SP	mV	аяндаа үүсэх туйлшралын арга
ST	m/s	сейсмийн томограф
VDV	kHz	урт долгионы арга
VDV-R	Ωm	VDV аргын эсэргүүцлийн хувилбар
VES	Ωm	эсэргүүцлийн босоо зондын хэмжилт
VP	%	өдөөгдсөн туйлшралын арга

1. АРГА ЗҮЙН УДИРДАМЖЫН ЗОРИЛГО

Бохирдолтой талбайн геофизикийн судалгааны ажлын арга зүйн удирдамжын (ГАЗУ) зорилго нь геофизикийн аргачлалын тусламжтай байгаль орчны бохирдол ялангуяа чулуулгийн орчны бохирдлын тархалтын орон зайн хил хязгаар болон тархалтыг цаашдын явцыг тодорхойлоход оршино. Арга зүйн удирдамж геофизикийн ажлын төслийн ажлын цар хүрээ, ажлын үр дүн, аргачлалд тавигдах шаардлагыг ба эдгээр хүчин зүйлүүд нь геофизикийн аргуудын тусламжтай хурдан хугацаанд өндөр магадлалтайгаар геологи, гидрогеологийн нөхцөл байдлыг тайлбарлахад зайлшгүй шаардлагатай мэдээллийн хэмжээг тодорхойлоно. Эдгээр хүчин зүйлүүд нь байгаль орчны бохирдлын цар хүрээ, цаашдын явц, судалгаа явагдаж буй орчинд бохирдол хэрхэн тархах зэргийг тодорхойлоход нөлөө үзүүлдэг.
Арга зүйн удирдамжыг БНЧех Улсын Байгаль орчны яамны Арга зүйн удирдамжын дагуу боловсруулсан.

2. АРГА ЗҮЙН УДИРДАМЖЫН АГУУЛГА

Энэхүү ГАЗУ хүрээнд байгаль орчны бохирдлын судалгаа явуулахад санал болгох геофизикийн судалгааны арга, мэдээлэл боловсруулах ажлын дараалал ба дүгнэлт гаргана. Геофизикийн хэмжилтийн ажлын цар хүрээг тогтоохдоо тухайн талбайн судлагдсан байдлын ангиллыг харгалзан үзнэ. Ангиллыг бусад арга зүйн удирдамжын адил ашиглана.
Геологийн орчин буюу чулуулгийн орчны бохирдлын цар хүрээ, түвшинг тогтоох ба хянах судалгааны ажлуудыг бохирдлын талаархи цуглуулсан мэдээллийн үндэслэн үндсэн A – D хүртэлх үндсэн 4 ангилалд хуваадаг. Үндсэн ангилал бүр нь тухайн талбайн судлагдсан байдлын түвшинг илэрхийлэх ба судалгааны үр дүнгийн тайлбарын түвшин буюу найдвартай байдал зэргийг тодорхойлно.
Тусгай ангилал болох 5-р ангилал нь нэмэлт судалгааны ажлыг тодорхойлох ангилал ба дээр дурдсан талбайн судлагдсан байдлын ангиллын ажлын нэг хэсэг бөгөөд жигд бус чулуулгийн орчны зарим мэдээллийг нарийвчлан тодорхойлоход эсвэл цэвэршүүлэх, нөхөн сэргээх ажил явагдаж дууссаны дараах мониторинг хийхэд ашиглана.

Энэхүү геофизикийн судалгааны аргазүйн удирдамжын хүрээнд геофизикийн судалгааг дараах байдлаар ангилна:

- Гадаргын геофизикийн судалгаа,
- Цооногийн геофизикийн судалгаа (цооногт хэмжилт хийх),
- Агаарын геофизикийн судалгаа.

Геофизикийн аргачлалыг дараах хэсгүүдэд хуваана:

- геоцахилгаан аргачлал (цахилгаан соронзон, цөмийн соронзон резонанс)
- сейсмохайгуулын арга,
- гравихайгуулын арга,
- соронзон хайгуулын арга,
- цөмийн (радиометрийн арга) арга
- дулааныг хэмжих арга.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ХЭРЭГЦЭЭГ ХАРГАЛЗАН ҮЗСЭН ГЕОФИЗИКИЙН АРГАЧЛАЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Геоцахилгааны аргууд

Геоцахилгааны аргууд нь геофизикийн судалгааны хамгийн их ашиглагддаг ба олон төрөлтэй аргад багтах ба учир нь хиймэл болон байгалийн цахилгаан орныг, диэлектрик тогтмол ба цаг хугацаанд өөрчлөгдөх цахилгаан соронзон мэдрэх чадварын цахилгаан болон соронзон шинжийг үндэслэн орчныг судлахад ашигладаг. Ялангуяа чулуулгийн эсэргүүцэл эсвэл гүйдлийн дамжуулалтыг (дамжуулах чанар буюу эсэргүүцлийн урвуу утга) хэмждэг. Чулуулгийн эсэргүүцэл нь нүх сүвний усны агууламж ба бохирдол зэрэгтэй нягт холбоотой. Бохирдуулагч ба чулуулгийн орчны урвал нь орчны шинж чанар шинж өөрчлөх ба хэмжиж болохуйц эрс ялгааг үүсгэнэ. Эдгээрээс шалтгаалан эсэргүүцлийн арга нь гидрогеологийн нөхцөл, орчны бохирдол зэргийг тодорхойлоход ихээхэн үүрэгтэй. Геоцахилгааны аргачлалаар тодорхойлогдох судалж буй орчны шинж чанартай (литологи, гидрогеологийн параметрүүд гм.) холбоотой байх боломжтой дараагийн параметрүүд: цахилгаан jsou elektrická permitivita, соронзон мэдрэх чадвар ба орчны иж бүрэн цахилгаан химийн үйл ажиллагаа (өдөөгдсөн туйлшрал, исэлдэх буурах - redox, шүүлтүүрийн ба нэвтрүүлэх чадамж гм.). Байгал орчны бохирдлын судалгаанд эвдэж нураадаггүй, эдийн засаг ба технологийн зардал багатай, их хэмжээний мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглана. Геоцахилгааны аргуудыг ашиглахад 0 гүнээс эхлэн профилийг хянах боломжтой ажлын арга зүй, тайлбарыг тодорхойлох боломжтой ба эдгээр аргуудын чухал шинж чанарт багтана.

Гадаргуу дахь хэмжилтийн мэдээлэлд хэмжилт хийсэн он, сар, өдөр ба тухайн цаг уурын байдлын талаар дурдах ба тухайн байдал нь хэмжилтийн чанар, дахин сэргээгдэх байдал зэрэгт нөлөөлдөг.

Бохирдолтой талбайн байгаль орчны геологийн бүтцийг хянаж, шинжлэхэд дараах аргуудыг ашиглана.

3.1.1 Эсэргүүцэл хэмжих арга


Байгаль орчны судалгааны ажилд хамгийн өргөн ашигладаг геофизикийн аргачлал бөгөөд чулуулгийн эсэрэгүүцэл нь литологиос хамаарах ба геологийн орчны сүвэрхэг хэсгүүдийн шингэний чанарыг орчны эсэргүүцэл нь маш их мэдрэмжтэй илэрхийлдэг. Эсэргүүцлийн аргачлалын (профилийн дагуу, зонд ашиглан хэмжих) хэмжилтийн үед тухайн орчны тогтмол гүйдлийн цахилгаан орны газарт дамжих гүйдэл болон хүчдэлийг хэмжиж эдгээр утгаас эсэргүүцлээс тодорхойлдог. Хэмжилтэнд хялбар хэрэгслийг ашигладаг учир хэмжилтэнд өргөнөөр ашиглах шалтгаан болдог. Профилийн дагуу эсэргүүцэл хэмжихдээ хэвтээ чиглэлд эсэргүүцлийн өөрчлөлтийг хянах (газрын зурагт) ба газрын гадаргуу дахь эх үүсвэр болон электродын байршлын зохион байгуулалтын хэмжээнээс уртаас хамаарах хэмжилтийн гүнийг тодорхойлно. Электродын зохион байгуулалт нь ихэнхдээ профилийн дагуу тогтмол алхамаар

байрласан байдаг. Хэмжилт хийгдэх орчны чийгшил багасахад эсэргүүцлийн хэмжээ ихэсдэг. Хөрсний хувьд хөрсний ширхэг томроход орчны эсэргүүцлийн хэмжээ өсдөг. Гүний усны эрдэсжилт ихсэхэд орчны эсэргүүцлийн хэмжээ багасдаг. Хямралын нөхцөл байдлын балансыг тооцох арга зүйн үндэс болгож ердийн бохирдолтой (нүүрсустөрөгч, давс, хүчлүүд, гидроксид) тохиолдолд чулуулгийн ерөнхий физик, цахилгаан шинж чанарыг судалж бэлтгэх нь тохиромжтой.


Профилийн дагуу хэмжсэн эсэргүүцлийн үр дүнг ихэнхдээ дараах байдлаар илэрхийлнэ:

- Эсэргүүцлийн тойм график,
- Эсэргүүцлийн графикийн газрын зураг,
- Изошугамын эсэргүүцлийн газрын зураг mapa.

Эсэргүүцлийн тойм графикт хэвтээ тэнхлэгт хэмжилтийн цэгийг заах ба у тэнхлэгт хэмжсэн эсэргүүцлийн утгыг тэмдэглэнэ. Эсэргүүцлийн графикийн газрын зураг нь эсэргүүцлийн тойм графиктай адил ба хэмжсэн профил хоорондын зайг газрын зургийн хэмжээнд үзүүлсэн байдаг. Изошугамын эсэргүүцлийн газрын зургийг зурахдаа олон компьютерыг нэг зэрэг ашиглах аргын дагуу тухайн талбайн хэмжилтийн утгуудыг тооцолсныг ашиглана. Түүний танилцуулгыг хоёр хэмжээст (нийтлэг тохиолдолд) буюу гурван хэмжээст хэлбэрээр хийж болно.
График үр дүнгийн жишээг зураг . 1a, 1b ба 3-д үзүүлэв.




Зураг 1. Профилийн дагуу хэмжсэн эсэргүүцлийн графикийн зөвлөмж загвар (SOP 20-10-20).



Зураг 2. Эсэргүүцлийн изошугамын графикийн танилцуулгын хоёр хэмжээст зөвлөмж загвар.

3.1.2 Босоо чиглэлд геофизикийн соронзон хайгуул хийх аргачлал (VES):

Зондын арга нь профилд хэмжих аргатай зарчмын хувьд адил бөгөөд ажиглалт хийх цэгийн эсэргүүцлийн өөрчлөлтийг дэс дараалан электродуудын хоорондох уртыг нэмэгдүүлж босоо чиглэлд хянана. Зондын арга нь эсэргүүцлийн ялгаатай давхарга ба байрлалын хэвтээ дэд хил хязгаарыг тогтооход зондын аргыг ашиглана. Тэгш хэмийн зохион байгуулалт нь хамгийн их ашиглагддаг зондын арга болно (Веннер эсвэл Шлумбергерийн электродын зохион байгуулалт).



Зураг 3. VES аргачлалын хэмжилтийн үр дүнгийн муруй. Үргэлжилсэн шугамаар тооцоолсон (загвар) муруйг тэмдэглэнэ. Жижиг тойргуудтай тасархай шугам эсэргүүцлийн хэмжилтийн үр дүнг илэрхийлнэ. Босоо тэнхлэгт эсэргүүцлийн хэмжээг ом-оор үзүүлсэн. Хэвтээ тэнхлэгт AB/2 (электрод хоорондын зайны хагас) хоорондын зайг м-р харуулсан. Хүснэгтэнд эсэргүүцлийн бодит хэмжилтийн утга (ρ), давхаргуудын зузаан (h) ба заагуудын гадаргын гүн (d), үндсэн хатуу цэгтэй харьцах заагуудын гадаргын харьцангуй өндрийг харуулсан байдал. Тод тасархай зураас давхаргуудын зузаан ба эсэргүүцлийн хэмжилтийн үр дүнг харуулна.

Профилийн дагуу эсэргүүцэл хэмжих, цахилгаан зондын босоо чиглэлийн болон тогтмол гүйдлийн цахилгаан орны хэмжилтэнд ашигладаг бусад геоцахилгааны багажууд нь үнэн зөв хэмждэг мөн өндөр мэдрэмжтэй, зөөхөд болон тээвэрлэхэд хялбар байдаг. Багажуудын жишээг зураг 4-т үзүүлэв.


3.1.3 Олон электродтой зохион байгуулалт (MEU)

Судалгаа хийгдэж буй профилийн доорх босоо зүсэлтийн нарийвчилсан судалгааны үед эсэргүүцлийн аргууд дотроос зондын ба профилийн дагуу хэмжих аргыг хослуулан ашиглана. Өмнө нь профилийн дагуу электродыг төрөл бүрийн зайнд байрлуулж эсвэл босоо чиглэлийн соронзон хайгуулыг тогтмол хэмжээтэй богино зайнд хэмжилт хийдэг байсан. Хоёр хэмжилтийн аль алинд нь гүний олон янзын түвшинд профилийн дагуух эсэргүүцлийн утгыг олох ба босоо зүсэлтийг маш дэлгэрэнгүй тайлбарлах боломжтой. Профилийн дагуу эсэргүүцлийг хэмжих зондын хосолсон аргыг профилийн дагуу олон электродыг тогтмол зайтай цэгүүдэд байрлуулж нэгэн зэрэг хэмжих ба эдгээр электродыг эх сурвалжын эсвэл хэмжилтийн болгож ашиглах ба автомат олон сувагтай эсэргүүцлийн багажтай холбоно. Эдгээр хэмжилтүүдийг эсэргүүцлийн томограф гэж нэрлэдэг.

Эсэргүүцлийн томографын хэмжилт хийхэд тохиромжтой багаж (ж-нь: GF Instruments Co., Ltd.- БНЧУ эсвэл ABEM – Швед, IRIS Instruments – Франц ба бусад) ба бэлэн програм хангамж (Locke зохиосон стандарт программ: Res 2D inv) ашиглана. Хэмжилтийн профилийг зохистой хуваариласнаар хяналт хийх талбайн гадаргын сонгодог 2D тайлбараас гадна 3D орон зайн дүрсийг үүсгэж болно (ж-нь: бохирдолтой

манангийн).
Геоцахилгаан эсэргүүцлийн хэмжилтийн тэнцүү зарчим ба эсэргүүцлийн анизотроп чанарын зарчмыг харгалзсан геоцахилгаан эсэргүүцлийн хэмжилтийн геологийн тайлбарын тоон утгын хэсэгчилсэн хоёрдмол байдлын асуудалд анхаарах шаардлагатай. Орчны (хэмжсэн эсэргүүцлийн утга, литологийн давхаргуудын зузаан ба гүн) нэмэлт параметрүүдийг хяналтын цооног болон бусад геологийн баримт бичгүүдийг үндэслэн тодорхойлсноор тайлбарыг илүү сайжруулах боломжтой.

Олон электродтой зохион байгуулалтын тусламжтай дүрсэлсэн эсэргүүцлийн босоо зүсэлтийн жишээг зураг 3-т үзүүлэв (эсэргүүцлийн томограф).



Зураг 4. Эсэргүүцлийн томографын аргаар хэмжсэн эсэргүүцлийн зүсэлт, үр дүнгийн загвар.

3.1.4 Байгалийн ба хиймэл цахилгаан орны хэмжилт

Аяндаа үүсэх туйлшрал (SP):

Байгалийн цахилгаан орны хэмжилтийг ихэнхдээ аяндаа үүсэх туйлшралтын арга гэж нэрлэдэг (SP). Энэхүү аргачлалын үед гадаргуу дээрх хоёр буюу түүнээс дээш цэгүүд хоорондын цахилгаан орны боломжит ялгааг (хүчдэл) хэмждэг (гэрэл зураг 4). Байгалийн цахилгаан орон үүсэх шалтгаан олон бөгөөд эдгээр үзэгдлүүдийг орчны цахилгаан химийн идэвхжил хэмээн нэрлэдэг. Байгалийн орнуудыг нэрлэвэл:

- *исэлдэх - бууруулах потенциал* (ORP) *oxidation and reduction potentials* электролитийн электродын (гүний ус) адил шинжтэй хүдрийн судлууд болон металл объектуудын ойролцоо мөн байгалийн потенциалын босоо градиентын боломжийг гажуудуулдаг.

- *тархалтын (DP) ба шүүлтийн потенциал diffuse* (DP) *and filter potentials* (FP), гүний усан дахь ионуудын тархалтын улмаас ба газрын доорхи сэвсгэр олон төрлийн геологийн орчны усны шүүрэлтийн (цахилгаан цэнэг тээгчтэй – ионт)

дүнд үүсдэг.

Энэ 2 ордууд нь хүний үйл ажиллагааны гаралтай байж болно – ORP металл хоолой, газар доорхи хадгалах сав зэргийн зэвэрсэн хэсэгтэй холбоотой, FP газар доорхи хамгаалалтын хана, далан болон бусад саадны эвдрэлийн ус нэвчилтээс үүснэ. FP орны хэмжээ нь эмх замбараагүй хүчтэй дуу чимээний түвшингээс их хэмжээгээр бага байх ба голдуу цахилгаанжуулалтаас үүсдэг учир тэдгээрийг хэмжихэд маш төвөгтэй байдаг. Галт тэрэг болон тролейбусны цахилгаан дамжуулах шугам мөн бусад цахилгаан дамжуулах шугамын байгууламжуудын ойролцоох сарнисан гүйдэл нь онцгой тохиолдолд багтдаг. Янз бүрийн нөхцөлд дахин давтаж хэмжилт хийх шаардлагатай. Тухайн судалгаа явагдах нхийт талбайн хэмжээнд олон тооны туйлшралгүй электрод газардуулж, статистик боловсруулалт бүхий олон удаа давтан хэмжилт хийж, SP орныг синхрон нэгэн зэрэг мониторинг хийх нь илүү үр дүнтэй байдаг.
SP аргачлалыг гүний усны урсацыг хянахад, гидрогеологийн хаалт, далангуудын битүүмж эвдэрсэн, дамжуулах хоолойны гэмтлийн (зэвэрсэн) байршлыг илрүүлэхэд ашиглана.



Зураг 5. Байгалийн суурин цахилгаан орныг хэмжих багажуд(SP арга). Туйлшрахгүй 2 электродын хооронд хэмжилт хийдэг. Зурагт талбайн доош ухсан хэсгийн буланд туйлшрахгүй 1 электрод газардуулсан байдал.

Байгалийн цахилгаан болон соронзон орны мВ хэмжих нэгжтэй хэмжилтийн график үр дүн нь эсэргүүцлийн график эсвэл эсэргүүцлийн изошугамын зурагтай адил байдаг (зураг 1a, 1b).

Өдөөгдсөн туйлшралын арга (ВП)

Орчны цахилгаан химийн идэвхтэй байдлыг газарт гүйдэл дамжуулж үүсгэх ба энэ аргыг албадмал туйлшрал хэмээн нэрлэдэг (ВП). Суурин цахилгаан импульсийн өдөөлтийг унтраасны дараа (ВП аргын импульсын хувилбар) аажмаар алга болох гадаргын хүчдэлийг хэмждэг (секунд болон минцутаар хэмжинэ). Орны буурах шинж


нь (ВП орны динамик байдал) 3 фазын геологийн орчны физик-химийн нөхцлөөс шалтгаалах учир зарим бодисыг тодорхойлох боломжтой. Албадмал туйлшралын орныг давтамжаар өдөөгдсөн орны тусламжтай тодорхойлно (ВП аргын давтамжийн хувилбар). ВП аргыг усны эх үүсвэрийн хайгуул болон байгаль орчны хуучин бохирдолтой холбоотой арга хэмжээний үед ашиглана.

Гидрогеологийн зориулалттай хувилбарын цэнэгтэй биетийн арга (NT)

Цэнэгтэй биетийн аргачлалын үед зохиомлоор үүсгэсэн цахилгаан орны потенциал эсвэл хүчдэлийг гүний усны коллектортой гүйдэл дамжуулах талбайд газардуулсан гүйдэл дамжуулах (зохиомол дамжуулах чадамж – давс ихтэй) электродын ойролцоох гадаргууд хэмжилт хийнэ.
Subsidised zone нь гүний усны хөдөлгөөнөөр шилжих учраас өндөр дамжуулах чадвартай эсвэл цахилгаан цэнэгтэй бүсийг гадаргуун цахилгаан орны өөрчлөлтийг тусламжтай хянаснаар оновчтой тохиолдолд гүний усны урсацын чиглэл ба хурдыг тодорхйролох боломж олгодог.
Цэнэгтэй биетийн аргачлал нь гүний усны (эрдэсжилт багатай үед давсны хэмжээг нэмэгдүүлснээр гүйдэл дамжуулах ялгааг илүү бүрдүүлнэ) байгалийн эрдэсжилт болон цооногийн ойролцоох талбайн (ялангуяа нэг төрлийн эсэргүүцэл) геоцахилгааны нөхцлөөс хамаарна. Гадаргуу дахь гүйдэл дамжуулах бүсийн хөдөлгөөнийг гүйдэл дамжуулах чадвар эрс ялгаатай тохиолдолд эсэргүүцэл хэмжим аргаар хянаж болно.

3.1.5 Урт долгионы арга (VDV)

VDV аргачлалын хэмжилтийн үед тодорхой давтамжтай (10 – 30 кГц) цахилгаан соронзон орны навигацийн дамжуулагчын цахилгаан соронзон орныг ашигладаг. Эдгээр цахилгаан соронзон орны гажилт нь нэг төрлийн бус цахилгаан дамжуулалт-чулуулгийн гүйдэл дамжуулалт ба ус агуулсан өөрчлөлттэй бүс эсвэл хиймэл дамжуулагч (ж-нь: шугам хоолойнууд, цахилгаан дамжуулах шугам гм.) байгаа эсэхээс шалтгаална. Цахилгаан соронзон орны соронзон хэсгийн индукцын ороомог ашиглах хэмжилт нь геофикикийн VDV аргачлалын эдийн засгийн хамгийн ашигтай хэмжилт юм (зураг. 5). Гадаргуу доорхи ялангуяа гүйдэл дамжуулдаггүй орчны (ж-нь: магмын чулуулаг, карбонат, элсэн чулуу) тектоникийн дамжуулах чадварыг тодорхойлох судалгааны үед ашиглахад илүү үр дүнтэй байдаг. Тухайн орны харьцангуй өндөр давтамж нь орчны гүйдэл дамжуулах чадвараас шалтгаалан хэдэн арван метрийн гүнд хэмжилт хийх боломжтой байдаг. VDV аргачлалын эсэргүүцлийн хэмжилтийн үед соронзон болон цахилгаан орныхоос бусад хэмжилтийг газардуулсан электродын ороомог ашиглан хэмждэг. Хоёр бүрэлдэхүүн хэсгүүдийн харьцаанаас орчны эсэргүүцлийг тодорхойлно. VDV-R аргачлалыг чулуулгийн судалгаанд ашиглах ба хэдэн арван метрийн гүний хэмжилтийн үед эсэргүүцлийн хэмжилтийн оронд ашигладаг.



Зураг 6. VDV аргаар хэмжилт хийсэн үр дүнгийн график (тектоникийн тайлбартай).

Зохиомол дамжуулагчын (өндөр хүчдэлийн шугам) нөлөөгөөр их хэмжээний гажилт үүсч геологийн дамжуулагчын илрэлд саад учруулдаг нь VDV аргачлалын сул тал байдаг. Навигацийн радио дамжуулагч байх боломж хязгаарлагдмал учир хиймэл дагуулын навигацийн GPS системийг ашиглах болсон.

3.1.6 Идэвхтэй цахилгаан соронзон арга

Хоёр туйлт цахилгаан соронзон профилийн хэмжилт (DEMP)

Идэвхтэй цахилгаан соронзон хэмжилтийн арга нь маш том бүлэг арга бөгөөд өөрийн эх үүсвэртэй (идэвхтэй) хувьсах (кондуктометр) эсвэл пульсын (түр зуурын зондын) оронтой байдаг. DEMP аргачлал нь 2 ороомог (антен) – эх үүсвэрийн ба хэмжилтийн ашигладаг (зураг. 6). Ороомог хоорондын зай (l - 10 м хүртэл, ороомгууд нь тогтоосон

урттай кабель утсаар холбогдоно) болон эх үүсвэрийн орны давтамж нь (100 Гц -10 кГц) гүний хэмжилтийн хүрээг тодорхойлно. Орчин үеийн багажууд нь олон давтамжаар ажилладаг. Ороомгийн тэнхлэгийн чиглэлийг нэг төрлийн бус (эгц босоо тектоник шугамыг тогтоох, чулуулгийн хил хязгаарын зураглал, дамжуулагч ба дамжуулагч бус үндсэн чулуулгийн рельефийг судлах) дамжуулах чадамжын шинжээс шалтгаалан сонгодог. Цахилгаан соронзон арга нь дуу чимээний нөлөөний улмаас хязгаарлагдмал байдаг. Энэхүү сул талыг тоон мэдээлэл боловсруулах, мэдээллийн дуу чимээ устгах чадвартай боловсронгуй алгоритм бүхий орчин багаж төхөөрөмжүүд арилгадаг. Тааламжтай нөхцөлд гүехэн байрлалтай дамжуулагч бүсийг (бүтцийн элементэд тулгуурласан гүехэн байрлалтай уст давхарга) тодорхойлоход ашиглана.
Цахилгаан соронзоны тохирох байдлын чанга хатуу дүрэм журмаас хамааран шалтгаалан ачаар зарим улсуудад эдгээр багажын борлуулалт ба ашиглалт хязгаарлагдмал байдаг.



Зураг 7. Үерийн хамгаалалтын даланг цахилгаан соронзон хэмжилтийн GEM-2 багажаар хэмжих байдал. Хээрийн нөхцөлд хэмжилт хийх боломж олгох GPS үүрсэн.

Эдгээр аргуудын цаашдын хөгжил нь үүсгэгдэх дохионы давтамжийн синтез ашигладаг олон давтамжтай дижитал аппаратыг хэмжилтэнд ашиглах мөн хэмжсэн дохионы бие даасан бүрэлдэхүүн хэсгийг тусгаарлах зарчим зэргээс хамааралтай. Багаж төхөөрөмжүүд нь өргөн хүрээтэй давтамжийн спектр буюу хэдэн зуун Гц ба 50 кГц давтамжтай ажиллах ба тасралтгүй хэмжих аргын үед олон давтамжийг нэгэн зэрэг хэмжих боломж олгодог. Цахилгаан соронзон орны сонгодог бүрэлдэхүүн хэсгээс гадна давтамж тус бүрийн гүйдэл дамжуулах чадамж, эсэргүүцлийг тооцох ба соронзон мэдрэх чадвар, 50 Гц үндсэн давтамжтай талбарын идэвхжилт зэрэг үр ашигтай параметрүүдийг тодорхойлж болно. Эдгээр багаж хэрэгслийг үерийн хамгаалалтын далангийн мониторингийн үед бусад геофизикийн аргуудтай хамт туршиж үзсэн. Цахилгаан соронзон хэмжилтүүд нь агаарын геофизикийн аргуудад хамрагдана.

Хэмжилтийн үр дүнгийн графикуудыг тухайн багаж үйлдвэрлэгчийн хэрэглээний програмын тусламжтай боловсруулна.

Георадар


Георадарын буюу радиолакатарын арга нь байгалийн өндөр давтамжтай (20 – 2 000 МГц) цахилгаан соронзон пульсийг гадаргуугаас доош цацаргаж цахилгаан соронзон шинж чанарын өөрчлөлтийг илэрхийлэх газрын доорхи ойх заагаас буцах хугацааг тэмдэглэхэд оршино. Георадарын арга нь сейсмо хайгуулын аргатай адил бөгөөд өөр давтамжыг ашигладаг ба тархалтын хурд өөрчлөгдөх орчингийн радиолакатарын арга болно. Тиймээс тайлбар хийхэд нэлээд хэцүү байдаг. Зарчмын хувьд ойх хязгаар буюу зааг нь цахилгаан соронзон долгион тархах хурдны өөрчлөлтөөс хамаарна. Орчны цахилгаан хувийн багтаамж ба соронзон нэвтлэх чанарыг харьцуулж цахилгаан соронзон долгион тархах хурдыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл энэхүү харьцаа буюу тархалтын хурд нь тухайн орчинд ус байгаа эсэхээс их хэмжээгээр шалтгаална. Их хэмжээгээр ойлгох давхаргад долгион маш бага энергитэй тархах ба түүнийг хүлээн авахад мэдрэгдэх боломжгүй байдаг. Өнөө үеийн багаж төхөөрөмжүүд нь олон метрийн гүнд долгион хугарах, ойх хил хязгаарыг тасралтгүй хянах боломж олгодог ба эдгээр хэмжилтүүдийг георадарын зүсэлтийн тусламжтай гүйцэтгэх ба долгион ойх хугацааг тусгалын гадаргуун гүний хэмжээнд шилжүүлэх ба цахилгаан соронзон долгион орчинд тархах тогтоосон буюу ойролцоо хурдны тусламжтай тодорхойлно (зураг 7).

Хэмжилт хийх гүний хэмжээ нь ашиглах давтамжаас хамаарна. Илүү гүнд хэмжилт явуулах шаардлагатай бол бага давтамжыг сонгоно. Давтамжын хоёслолыг ашиглдаж болно. Хэмжилт явуулах гүний хэмжээ нь багаж төхөөрөмжийн чанар болон антен, орчны цахилгаан дамжуулах чанар ба орчны градиент буюу давхаргын байдлаас хамаарна. Эхний хэдэн зуун омын эсэргүүцэлтэй (БНЧех Улсын гүехэн буюу бага гүний зүсэлтийн ердийн нөхцөл) орчинд арван метр гүн хүртэл гүнд хэмжилти хийх боломжтой.

Георадарын арга нь гүехэн буюу бага гүнд (өнгөцхөн хучилттай, гүйдэл үл дамжуулах чулуулгийн илэрцүүдтэй бүс нутагт) явагдах судалгааны хамгийн түгээмэл арга. Тайлбар буюу тайлалын амжилт нь хэмжилтийн үр дүнгийн мэдээллийн чанараас маш их хамааралтай.



Зураґk 8. Геологийн радарын тусламжтай хэмжилт хийхэд бэлтгэх. Цаад талд нь 80 МГц антен.



Зураг 9. 1500 МГц антенаар хэмжсэн радарын хэмжилтийн бичлэг.

3.2 Гүехэн буюу бага гүний сейсмо хайгуул

Чичихрийллийн арга нь чулуулгийн орчинд харимхай долгион тархах хурдны өөрчлөлтөнд тулгуурласан байдаг. Харимхай долгион тархах хурд нь (тууш эсвэл хөндлөн) долгион тархах орчны жингийн эзэлхүүн ба Пуассоны тооны уян хатан чанарын модуль функц. Хурд нь хэдэн зуугаас мянган м/сек хооронд хэлбэлздэг.

Хэмжилтийн системийн хөгжил болон боловсруулах мэдээллийн олдоц, чанартай холбоотойгоор мөн нүүрсустөрөгчийн эрэл хайгуулын нэгдсэн тайлбар боловсруулах ажлын багийн чармайлтын дүнд гидрогеологи, байгаль орчны салбарын ажилд ашиглах гүехэн чичирхийллийн судалгааны сейсмо аргуудын ашиглалт хурдацтай хөгжиж байгаа. Хэмжилтийн үндсэн стандартанд хэдэн арваас хэдэн зуун сувагтай, хэдэн арван Гц-с олон зуун Гц давтамжын хүрээнд мэдээллийн бичлэг хийж, олон талаас нь авч үзсэн компьютерын боловсруулалт хийх боломж олгодог дижитал аппаратууд багтана. Компьютерын боловсруулалтын дараа интерактив тайлбарын системийн ажил үргэлжлэн явагдана. Өнөө үед гүехэн чичирхийллийн судалгааны ажилд олон сувагтай (ихэвчлэн 24 ба түүнээс их сувагтай) заримдаа цогц эсвэл телеметр хэлбэртэй багаж төхөөрөмжүүдийг ашиглах нь стандарт болсон. Хэмжилтийн эрчим хүчний эх үүсвэрт томоохон дэвшил гарсан. Гехэн чичирхийллийн судалгааны тэсрэх эх үүсвэрийг ялангуяа тууш болон хөндлөн долгион өдөөхөд импульс ба чичирхийллийн эх үүсвэрээр орлуулах болсон. Хэмжилтийн аргачлалыг загварчлалын системийн тусламжтай болорвсруулж, хэмжилтийн үр дүнгийн мэдээллийг бүрэн бүтэн байдал, чанарын үүднээс хянаж, түүний дараа боловсронгуй компьютерийн программ ашиглан 2D болон 3D домэйнд боловсруулна. Гүехэн чичирхийллийн судалгаанд ойлт болон хугаралын сейсмийн арга ашиглана. Ялангуяа тусгалын аргууд нь ихээр хөгжсөн ба жижиг домэйнд ихэвчлэн гүехэн давхаргын томограф ашигладаг. Орчин үеийн тайлбарлах програм хангамж нь цогц шинжтэй учир хэрэгцээний шаардлагын дагуу хэмжилтийн үр дүнг хэд хэдэн дарааллаар зэрэгцүүлэн боловсруулах бололцоотой (тусгал, хугарал, газар хөдлөлтийн томограф) ба ингэснээр судалж байгаа орчны талаархи мэдээллийг өргөжүүлнэ. Гадаргын сейсмийн мэдээллийн тайлалтыг сейсмийн каротажын мэдээлэлтэй хамтруулж болно. Хэмжилтийн үр дүнд профилийн цаг хугацааны зүсэлтийг үүсгэж, тэдгээрийг 3D хэлбэрээр үзүүлнэ.

Гидрогеологийн зорилгоор сейсмо аргыг ашиглах үед дөрөвдөгчийн хурдасны зузааныг эсвэл өгөршсөн чулуулгийг судлах даалгаврыг өгсөн байдаг. Талбайн тектоник бүтцийг, орчны давхаргын байдал, давхаргын байрлал ба налууг тодорхойлох даалгаврууд их тохиолддог.

Орчин үеийн чичирхийллийн багаж төхөөрөмж 144 dB хүртэл динамик багтаамжтай байдаг. Гэхдээ хэмжилтийн чанар ойлтын/ хугарлын хүрээнд шилжих энергийн хэмжээнээс хамааралтай байдаг. Энергийн хэмжээ (бас чанар) нь цаг, энерги, зардал шаарддаг. Тайлал хийхэд чанартай өгөгдлөөс гадна гүний зүсэлтийн спектрийн мэдлэг, геологийн мэргэжилтний хамтын ажиллагаа шаардлагатай.




Зураг 10. 48 сувагтай сейсмийн багажын хэмжилт

3.2.1 Гүехэн хугарлын сейсмо арга (MRS)

Чулуулгийн зузаалаг болон түүний хөрсний чулуулгийг судлахад гүщехэн хугарлын сейсмо аргыг ашигладаг (зураг 10). Газрын гадаргууд сул цэнэг болон туухайн цохилтоор үүсгэх чичирхийллийн дохио хүлээн авах хугацааг хол байрлах цэгүүдэд бүртгэх ба тэдгээр цэгүүдэд геофоны тусламжтай хүлээн авах чичирхийллийн дохионы бичлэг хийнэ. Чичирхийллийн долгион геологийн орчинд тархах ба чичирхийллийн заагийн гадаргууд ойх ба хугарч энэ гадаргуун дагуу тархаж, ингэснээр гүехэн байрлалтай бүтэц ялангуяа чичирхийллийн долгионы илүү хурдтай (1000 м/сек-с илүү хурдтай) хатуухан ул ёроолын рельефийн талаар мэдээллийг өгдөг. эрчим хүчний эх үүсвэр үржүүлэхэд болон дохио/дуу чимээний харьцааг нэмэгдүүлэхэд өгөдлийн нийлбэрийг ашиглах ба ингэснээр хэмжилтийг илүү гүнд хийх боломж олгодог. Шороон хурдас болон хүний үйл ажиллагааны үлдэгдлийн орд (хаягдал материал) хурд багатай байдаг. MRS аргачлалыг уснаас хүнд хлорт нүүрсустөрөгчийн нэмэгдсэн концентрацитай үл нэвтрэх чулуулгийн хотгор илрүүлэхэд илүү ашигтай байдаг.



Зураг 11. дэлбэрэх бодис ашиглан чичирхийллийн долгион дамжуулах MRS хэмжилт. Цаад талд тэсэлгээний мастер. Зургийн дунд хэсэгт OYO 1600 багажыг ажиллулах оператор.




Зураг 12. Сейсмо хугарлын аргын хэмжилтийн үр дүнгийн сейсмо зүсэтийн нийтлэг жишээ

3.2.2 Гүехэн ойлтын сейсмохайгуул (RXS)

Гүехэн ойлтын сейсмохайгуулын үед газар доорхи хэд хэдэн заагийн гадаргуугаас ойсон долгионы анализ ба бүртгэлийн ажил хийгдэх ба нүүрустөрөгчийн ордод зориулагдсан state-of-art аргачлалыг үндэслэн боловсруулсан. Microsoft ® ба Linux үйлдлийн системтэй компьютер ашиглах нь өгөгдлийг боловсруулах ба тайлбар хийх шилдэг арга хэрэгсэл болох бөгөөд бага гүнд хийгдэх судалгаанд ашиглахад маш их ирээдүйтэй.

Эрчим хүчний эх үүсвэрийн хувьд тэсрэх эх үүсвэрийг тууш болон хөндлөн долгионыг өдөөснөөр үүсэх эвдрээгүй импульсийн ба чичирхийллийн эх үүсвэрээр солино. Бага гүний буюу гүехэн хэмжилтэнд илүү сайн нарийвчлалтай өгөгдлийг өгөх хөндлөн


долгионы эх үүсвэрийг ашиглах нь ашигтай.



Зураг 13. Чичирхийллийн ойлтын аргын хэмжилтийн үр дүнгийн сейсмо зүсэлтийн ердийн график. Хучаас хурдсууд дөрөвдөгчийн болон гуравдагчийн хурдсаас бүрдсэн. Ул чулуулаг нь тектоник протерозойн хагаралтай.

3.2.3 Сейсмо томограф (ST)

Цооног эсвэл уурхайн хонгил хоорондын чулуулгийн блокыг рентгенээр гэрэлтүүлэхэд сейсмотомографыг ашиглана (ST). Шалгаж буй блокын нэг талын хэд хэдэн цэгүүдэд чичирхийллийн дохио үүсгэх ба блокын нөгөө талд дохио хүлээн авах цагийг хэмжинэ. Энгийн боловсруулалтын үед долгионыг шулуун тархах байдлаар авч үзэх ба илүү төвөгтэй программ хангамж нь тархалтын замын хазайлтын муруйг тооцоолох боломж олгодог. Хээмжилтийн үр дүнд хэмжилт явагдах блокын орчны чичирхийллийн хурдны зүсэлтийг тодорхойлно. ST аргыг чулуулгийн зузаалгийн хагарал буюу чулуулгийн хөндийг тодорхойлох тусгай болон нарийвчилсан судалгаа явуулахад ашиглана.



Obrázek 14. Typické uspořádání měření při seismické tomografii mezi vrty (dle ASST)

3.3 Магнитометр


Геосоронзон орны гажил нь чулуулгийн төрөл болон соронзон шинж чанарын ялгаанаас хамаарна. Хэмжилтийг 0,1 гамма мэдрэмжтэй хэмжих цезийн болон протоны магнитометр (зураг. 14) ашиглан хийдэг. Магнитометрийн хэмжилтийг соронзон шинж чанарын ялгаатай эсвэл соронзон мэдрэх чанартай газрын гүний обьектуудыг (төмөр, ган зэрэг соронзон чанартай) илрүүлэхэд мөн соронзон литологийн төрлийн зураглалд ашиглана.

Тухайн орны хэлбэлзийн цаг хугацааны өөрчлөлт, бүс нутгийн гажилт нь болон бусад сөрөг нөлөөг (инженерийн шугам сүлжээ гм.) багасгахын тулд градиентын хэмжилт (градиометр – MGM) ашиглана. Соронзон хэмжилтийг газрын гүний төмрийн хайгуулд металл хайгчтай (металл хайгч MTD) хослуулан хийх ба гүехэн байрлалтай бага хэмжээний талбайтай обьектын хайгуулд ашиглахад илүү тохиромжтой. Чулуулгийн төрлийн ялгааг тодорхойлоход капаметрын хэмжилт хэмжилт илүү тохиромжтой ба учир нь соронзон чанарыг (соронзон мэдрэх чанар капа) хурдан тодорхойлох боломжтой байдаг. Энэхүү чанарыг бохирдолтой хөрсний эзэх талбайг ойролцоогоор тогтооход ашиглаж болно.

Өнөөдөр магнитометрийг GPS хамтруулсан байх ба мэдээллүүд нь геодези, зурагзүйн хувьд нарийвчлан ж-нь: тухайн цэгт оноогдсон байдаг. Магнитометрийн хэмжилтийн

багажтай 1 хүн профилийн дагуух болон орон зайн тархалтын мэдээллийг амархан шинэчлэх чадвартай байдаг.

Хэмжилтийн үр дүнг ашиглан график зурах эсвэл хэмжсэн утгын изошугамын план зураг боловсруулна. Танилцуулгыг илүү ойлгомжтой болгохын тулд 3D дэлгэцийг ашиглах нь тохиромжтой (зураг. 15).



Зураг 15. Төмөр савууд болон химийн бохирдолтой хаягдлын цэгт хэмжилт хийсэн нийт босоо соронзон орны гурван хэмжээст (3D) дүрслэл.

3.4 Гравиметр

Гравиметрийн хэмжилт нь хүндийн хүчний орныг (гадаргаас доош орших биеийн массын ялгааг харьцуулах) маш өндөр нарийвчлалтай жин = гравиметрийн тусламжтай хэмжихэд оршино (зураг. 16). Геологийн орчны нягтралын хуваарилалтыг тайлбарласнаар үе давхаргуудыг ялгана. Нягтралын ялгааг үндэслэн литологийн янз бүрийн төрлийн ялгах, тектоникийн хагаралтай бүсийг тогтоох, газар доорх чулуулгийн хонхорыг (хиймэл, байгалийн, хоосон эсвэл устай) илрүүлэх, өндөр нягттай газрын хэвлийг рельеф хянах, тархац, бүрхүүлийн зузаан ба тархалтыг тодорхойлох, хүний үйл ажиллагаанаас гарах хаягдал - бага нягтралтай хог хаягдлын цэг.


Микрогравиметрийн хэмжилтийг гүехэн байрлалтай бага хэмжээний обьектод, хөрөнгө оруулалт багатай үед хийдэг.
Гравиметрийн хэмжилтийн үед маш нарийн хэмждэг механик аппарат ашиглах ба хэмжилтийн аргачлалын хувьд гравиметрийн цагийн шилжилтэнд захирагдана. Өнөөгийн гравиметрийн хэмжилтийн багажууд нь илүү электрон тохируулгатай, ялгах чадвараас бага зөрүүтэй хэмжих ба бүс нутгийн болон инженерийн ажлын даалгаврын үед хэмжилтийг хурдан шуурхай, үнэн зөв хийх боломжтой. Гравиметрийн хэмжилтийн багаж үйлдвэрлэгч нь микрогравиметр үйлдвэрлэдэг Scintex компани (өнөөгийн CG-5 загвар) болно.
Гравиметрийн хэмжилт нь уян хатан байдал болон үйлдвэрийн хөндлөнгийн нөлөөнөөс бага хамааралтай тул ашигтай ба 1 цэгийн хэмжилтэнд зарцуулагдах зардал өндөртэй учир ашиггүй байдаг.



Зураг 16. Гваметрийн хээрийн хэмжилт

3.5 Дулаан хэмжих

Дэлхийн дулааны орон нь дэлхийн гадаргууд явагдах механик хөдөлгөөнөөс ялгарах дулаан болон цацраг идэвхт элементийн задралаас үүсдэг. Хэвийн бус температуртай орон нутгийн эх сурвалжид газрын доорхи усны (халуун рашааны усны эрс тэс ялгаа) ил гарах зам, байгалийн болон хиймэл хог хаягдлын цэгт шаталт явагдах болон бусад химийн үйл явцууд зэрэг багтана. Хэмжилтэнд гараар ажиллуулах дулааны эсэргүүцэл хэмжих багаж, термометр (хэт улаан туяаны мэдрэгч) ашиглана. Томоохон газар нутгийг хамарсан хэмжилтэнд гэрлийн давтамжийн интервалын болон хэт ягаан туяаны алсын дүрслэлийг (агаарын, хиймэл дагуулын) ашиглаж болно. Газрын гадаргуу дээрхи хэмжилтийг температурын улирлын болон гүн өөрчлөлт бага илрэх уур амьсгалын эсрэг тэсрэг өөрчлөлтийн үед явуулдаг (ж-нь: цасан доор гм.).



Зураг 17. Гравиметрийн хэмжилтийн үр дүнгийн жишээ. Буге-гийн гажлын график. Дунд хэсэгт хүндийн хүчний тайлбар загвар. Доод хэсэгт загварын тайлбар.

3.6 Радиометр

Байгалийн болон хиймэл цацраг туяаны тархалтыг тодорхойлоход цооногт, газрын гадаргад болон агаарт цацрагийн тархацын үйл явцыг хэмжих – радиометрийн (Rad) хэмжилтийг ашиглана. Ихэнхдээ цацраг идэвхт байдлын хэмжилтэнд ионжуулагч нөлөөг үндэслэн тодорхойлдог зохих багажуудыг ашигладаг. Нийт идэвхитэй байдлыг тодорхойлох эсвэл спектрометрийн тусламжтай цөмийн цацрагийн эрчим хүчний өөр өөр шинж тэмдгээс ялгах байдлаар тодорхойлно (зураг. 18). Тектоник шугамыг илрүүлэхийн тулд – еманометрийн хэмжилтийг (камерт соруулсан хөрсний агаарын цацраг идэвхт изотопын ионжуулагч нөлөөг хэмжих) бага хэмжээгээр ашигладаг. Литологийн төрлийг ялгахаас гадна тектоник шугамыг, цацраг идэвхт бодисоор бохирдсон орчныг мөн эрсдэлийг тодорхойлоход радиометрийн хэмжилтийг ашиглана.

Радиометрийн хэмжилт нь геологийн ул чулуулгийн бүтцийн талаархи мэдээлэл олж авахад тусалдаг. Цацраг идэвхт бохирдлын хувьд цацраг идэвхт изотопын спектрийг харуулдаг (хэрэв багажны динамик хүрээнээс хэтрээгүй бол).
Өнөө үед зөөхөд хялбар, өндөр мэдрэмжтэй, спектрийг 1024 сувагт хуваасан багажуудыг хэмжилтэнд ашиглах болсон.
Барилгын зориулалтаар хийх хэмжилтийн үед Радоны задралын охин бүтээгдэхүүн тохиолдох нь онцгой байдаг. Ийм нөхцөлд цацралын зарчмыг баримтална. Мэдрэгчийн орчмын чийглэг нь радоны хэмжилтийн үед маш их нөлөөтэй байдгийг дурдах хэрэгтэй.



Зураг 18. Гамма спектрометр.

3.7 Цооногийн геофикикийн хэмжилт (каротаж)

Маш өргөн хүрээтэй геофизикийн аргачлал бөгөөд цооногт хэмжилт хийж цооногийн ойролцоох геологийн орчны тогтоц (дээд тал нь цооногоос 1 м зайд), цооног дахь шингэний параметрүүд, давхаргын эсвэл цооногийн геометрийн нөхцлүүдийг (давхаргуудын налуу, цооногийн диаметр гм.) тодорхойлох ба энэхүү аргыг каротаж гэж нэрлэдэг.

Зарчмын хувьд дараах аргуудад хуваана:
- цахилгаан каротаж
- цөмийн,
- сейсмо ба акустик (дуу авианы),
- техникийн,

- термометрийн,
- георадар (цахилгаан каротажын бүлэгт багтана)
- магнитометрийн

Аргачлал болон технологи мөн зохистой төхөөрөмж болон мэдрэгчийн нарийн төвөгтэй, дутмаг байдлаас шалтгаалан энэ аргачлалыг цооногийн хүндийн хүчний болон соронзон хэмжилтэнд бага ашигладаг.

Каротажын аргачлалыг ашиглалтын зорилгоос хамаарч дараах байдлаар хуваана::

- литологийн зураглалыг магадлах болон коллекторын шинж чанарыг тодорхойлох аргууд,
- цооногийн техникийн нөхцөл байдлыг хянах аргууд,
- гидрокаротажын аргачлалын үед стандарт болон тусгай хэмжилтийн аргуудын үр дүнгийн багц мэдээллүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг үндэслэн гидрогеологийн нарийвчилсан нөхцлийг тодорхойлох боломж олгодог,
- цооногийн хананы чулуулгийн найрлага тодорхойлох аргууд,
- цооногийн ойролцоох чулуулгийн хүчдэлийн нөхцлийг тодорхойлох аргууд ,
- сэвсгэр материалуудын хувьд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд савааны үзүүрт бэхэлсэн механик эсэргүүцэл хэмжих зориулалттай мэдрэгчтэй ба мэдрэгчид алхаар цохиж (динамик хувилбар) даралт үзүүлэхэд эсвэл гидравликаар даралт (статик хувилбар) үүсгэхэд хэмжилт хийдэг. Нэвт хатгах зондын аргыг бодитой хайгуул хийж, геотехникийн тооцооны боломжыг өргөтгөхийн тулд нэвт хатгах аргын хэмжилтийн дараах нүхэнд хэмжилт хийнэ (каротажын хэмжилт). Каротажын зондыг нэвтлэх хос савааны тусламжтай зондын хэмжилтийн дараах нүхэнд оруулж физик параметрүүдийг тасралтгүй бүртгэнэ. Сэвсгэр буюу хатуу бус чулуулагт цооног өрөмдөх нь эдийн засгийн хувьд ашиггүй мөн сонгодог каротажын арга ашиглахад алдаа их гардаг тул нэвт хатгах хэмжилтийг ашиглах шалтгаан болдог. Нэвт хатгах хэмжилтийг хаягдлын овоолгын хайгуул, хог хаягдлын материалын судалгаанд их хэмжээгээр ашигладаг.

Зураг. 19-т байгаль орчны ажлын даалгаврын үед хийгдэх каротажын хэмжилтийн нийтлэг жишээ ба каротажын мэдээллийг танилцуулах аргыг үзүүлэв. Цооногийн орчны эсэргүүцлийн өөрчлөлтийг хувийн эсэргүүцлийн эсвэл каротажын индукцийн туйлшралын аргаар (IP) хэмжилт хийнэ. IP аргачлалын үед хэмжилтийн үр дүнг гүний усны бохирдуулагчын нийт концентрацитай шууд хамааралтай гүйдэл дамжуулах муруй хэлбэрээр илэрхийлнэ. Хойд чехийн нутагт химийн аргаар уран олборлох явцад үүссэн химийн уусмалын бохирдлын нөлөөгөөр сеноманы коллекторын цахилгаан дамжуулах чадвар хэрхэн өөрчлөгдсөнийг зургийн дээд хэсэгт (a) харуулав. Туроны коллекторын (b) элсэн чулууны доод хэсгийн цахилгаан дамжуулах чадвар буурсан нь цэвэршүүлэх ажлын үр дүнд гүний ус аажмаар цэвэршиж байгааг харуулна.

3.8 АГААРЫН АРГУУД БА АЛСЫН ЗАЙН ЗУРАГЛАЛ


Соронзон, радиометрийн болон цахилгаан соронзон мэдээлэл бүрдүүлэх үндсэн арга. Агаарын хэмжилтийн мэдээллийг геодезийн солбицол мөн ихэнхдээ агаараас авсан зурагт хуваарилсан байдаг.

Дээр дурдсан аргуудаас гадна гравиметр, дулаан хэмжих зэрэг аргуудыг ашишладаг. Багаж төхөөрөмжүүдийг нисдэг тэрэг эсвэл сэнстэй онгоцоор тээвэрлэнэ. Тээврийн хэрэгсэл (онгоц, нисдэг тэрэг) нь багаж төхөөрөмж болон багажыг ажиллуулах мэргэжилтнүүдийг тээвэрлэхэд хангалттай даацтай байхаас гадна тохиромжтой аэродинамикын параметрүүдтэй байх шаардлагатай. Нисдэг тэрэгний хувьд хурд багатай (өндөр нарийвчлалтай өгөгдлийг олж авах) мөн нислэгийн уян хатан байдал (онгоцны буудалтай бага хамааралтай) зэргээр ашигтай. Сүүлийн үед хангалттай ачааллын хүчин чадалтай нисгэгчгүй онгоц ашиглах оролдох болсон. Гэвч олон орнуудад аюулгүй байдлын үндэслэлээс хамаарч эдгээр онгоцыг ашиглах хориотой байдаг.


Аль ч тохиолдолд нислэгийг удирдах байгууллагуудын зөвшөөрлөөс агаарын хэмжилтийн ажил хамаарна.

Агаарын цахилгаан магнитометрийн хэмжилтийн үед тодорхойлсон хувийн эсэргүүцлийн газрын зургтийг зураг 20-д үзүүлэв. Нисдэг тэрэгний доод талд бэхэлсэн саг ба цахилгаан соронзон орны хүлээн авах систем нь 4 давтамжид ажиллаж байсан. Мэдээллийн танилцуулгыг цахилгаан соронзон орны график хэлбэрээр (тухайн орны хуурмаг болон бодит бүрэлдэхүүн хэсэг) эсвэл хувийн эсэргүүцлийн утга (танилцуулгын элбэг тохиолдох хэлбэр) болгож хувиргах байдлаар үзүүлэх боломжтой. Экологийн нуугдмал бохирдлын хэмжээ болон нөлөөг тодорхойлох, геологийн бүтцийн зураглалын үед өндрийн олон спектрын дүрслэлийг (онгоцноос, хиймэл дагуулаас гм.) ашиглах ба үүнийг алсын зайны зураглал гэж нэрлэдэг.

Агаарын геофизик нь маш онцлогтой мөн зардал ихтэй. Үндэстэн дамнасан төслийн зохион бүтээгчдийг ажиллуулдаг стандарт жишиг тогтсон. Энэ нь үнийн нөөцийг хуваалцах, үнийг бууруулах баталгаа болдог.



Зураг 19. Каротажын графикийн танилцуулга. Индукцийн каротаж. Гүний усны хүхрийн хүчлийн агууламжын өөрчлөлтийн мониторинг.



Зураг 20. Орчны эсэргүүцлийг тооцоолсны дараах агаарын цахилгаан соронзон хэмжилтийн аргын жишээ. Нислэг хийсэн талбайн төв хэсгээр тектоник хагарлын шугам өнгөрсөн.

4. ГЕОФИЗИКИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ АГУУЛГА БА ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮНГ АРХИВЛАХ АРГА

4.1 Геофизикийн тайлангийн агуулга

Геофизикийн тайланд дараах бүлгүүд болон хавсралтууд зайлшгүй багтана:

Захиалгын хуудас
(Захиалагч ба гүйцэтгэгчийн талаархи мэдээлэл**,** геофизикийн хэмжилтийг хариуцан гүйцэтгэгч болон хамтрагчдын нэр, тайлангийн хуваарилалт зэрэг мэдээллүүдийг агуулсан байна).

1. Оршил
(хэмжилт хийх болсон шалтгааны товч тайлбар, гэрээт гүйцэтгэгчийн танилцуулга мэдээлэл, захиалгыг хэрэгжүүлэх болон геофизикийн ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа)

2. Талбайн газар зүйн байршлын мэдээлэл
(хэмжилт явагдсан талбайг тодорхой харуулсан зургийн хэсэг, хэмжилт хийгдэх талбайн төв цэгийн эсвэл тухайн талбайн хилийг хязгаарлах цэгүүдийн координатууд, талбайн шинж байдлын тайлбар, талбайн өндрийн хэмжээ - алтиметр, талбайн гадаргын байдал, гол горхи).

3. Талбайн геологийн тогтоц

4. Геофизикийн судалгааны зорилго

5. Хээрийн ажлын тайлбар тодорхойлолт

6. Хэмжилтийн үр дүнгийн тайлбар

7. Геофизикийн хэмжилтийн үр дүнгийн геологийн нэгдсэн тайлбар

8. Төгсгөл ба зөвлөмж

Зайлшгүй хавсралтууд:

Хавсралт 1: Геофизикийн профилийн газрын зураг. Хавсралтанд газрын зургийн масштабын талаархи мэдээлэл орсон байна. Координатын топографын сүлжээний талаархи мэдээлэл.

Хавсралт 2: Хэмжилтийн үр дүнгийн график болон баримтууд (хэмжилтийн үр дүнгийн график, сейсмо буюу чичирхийллийн бичлэгүүд, геофизикийн мэдээллийн изошугамын план зураг)

Хавсралт 3: Хамаарлын тайлбар схем - геологийн болон геофизикийн үр дүнгийн хамаарлыг үзүүлсэн. Шаардлагатай тохиолдолд сейсмо, хүндийн хүчний болон бусад загварууд ба зүсэлтүүд.

Зөвлөмж:
Захиалагчид тайланг цаасан дээр хэвлэсэн байдлаар мөн санах байгууламжид хадгалж хүлээлгэн өгөх нь тохиромжтой. Тухайн текстийг сануулах буюу дүрсэлж үзүүлэхэд

extenders бүхий формат - *.pdf, *.jpg, *.tif, *.dxf ашиглана. Бичиг баримтуудыг газар зүйн мэдээллийн системийн давхаргууд хэлбэрээр хүлээлгэн өгөх нь тохиромжтой (ж-нь: ArcGIS эсвэл Geosoft компаний модулиудыг үндэслэсэн).

4.2 Хэмжилтийн үр дүнг архивлах арга

Геофизикийн ажлын гүйцэтгэгч нь захиалгатай ажил бүрт захиалгын дугаартай хавтастай бичиг баримтыг хөтөлнө. Ажлын захиалгын гэрээний анхны баримт бичгийг хавтаст оруулна. Баримтууд нь бичгээр бичсэн материалууд, санах байгууламжид (CD, DVD, hard disc, flash disc) хадгалсан мэдээллүүд зэрэгт хуваагдана. Санах байгууламжид хадгалсан мэдээллийг хэрэглэгчийн тухайн программ байхгүй ч нээж унших боломжтой байдлаар хадгалах шаардлагатай. Ингэхий тулд мэдээллийг ASCI, txt эсвэл xml форматад оруулах шаардлагатай. Захиалгат ажил дууссаны дараа хавтсыг гэрээт гүйцэтгэчийн ажлын байранд эсвэл гэрээний дагуу тохиролцсон тохиолдолд захиалагчын талд хадгална. Баримт бичгүүдийг наад зах нь 10 жил хадгална. Хэрэв хуулийн дагуу төрийн байгууллагын мэдээллийн санд хадгалуулах үүрэгтэй бол мэдээллүүдийг эдгээр мэдээллийн санд хүлээлгэж өгнө.

5. СУДЛАГДСАН БАЙДЛЫН АНГИЛАЛ

Геологийн орчны бохирдлын хэмжээг тодорхойлох, шалгах судалгааны ажлуудыг бохирдлын талаархи байгаа мэдээллийн түвшингээс хамаарч үндсэн 3 ангилалд А – С хуваана. Үндсэн ангилал нь талбайд судалгаа явагдсан байдал, судалгааны ажлын үр дүнгийн найдвартай байдал, судалгааг төлөөлөх түвшинг илэрхийлдэг.

Геофизикийн судалгааны хувьд талбайн судлагдсан байдлын ангилалыг геологийн орчны бохирдлын ангилалтай адил тодорхойлно:

1. **А – Урьдчилсан судалгааны ажил –** Эрсдэлийн анализыг боловсруулахад зориулагдсан
2. **В – Дэлгэрэнгүй судалгааны ажил –** цэвэршүүлэх үйл ажиллагааны төслийн баримт бичгийг боловсруулахад зориулагдсан
3. **С – Нэмэлт судалгааны ажил**

6. СУДЛАГДСАН БАЙДЛЫН АНГИЛЛААС ХАМААРАХ ГЕОФИЗИКИЙН АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

6.1 Урьдчилсан судалгааны ажил

Урьдчилсан судалгааны ажлын хүрээнд тухайн талбайд өмнө хийгдсэн геологийн судалгааны ажлуудын архивын судалгаа хийгдэх ба эдгээр ажлууд бие даасан бүлгийг бүрдүүлдэг. Геофизикийн судалгааны ажил нь холбогдох төрийн мэдээллийн санд багтсан ажлуудын талаархи мэдээллийг ашиглах холбоосуудыг багтаасан байна. Хэрэв боломжтой бол бусад ашиглаж болох нээлттэй мэдээллүүдийг судалгаанд ашиглана. Эдгээр мэдээллүүдэд хувийн компаниудын тухайн талбайд хийж гүйцэтгэсэн ажлуудын мэдээлэл орно. Настай хүмүүсийн аман мэдээллүүд болон бусад тэмдэглэл нь чухал эх сурвалж болдог. Эдгээр мэдээллүүд нь мэдэгдэхүйц найдвартай байдалтай ба төсөтэй хамааралтай байх шаардлагатай. Хэрэв өмнө хийгдсэн геофизикийн судалгааны ажлуудын анхан шатны болон хоёрдогч геофизикийн мэдээлэл байх тохиолдолд тухайн шийдвэрлэх асуудалд тохирох тайлбарлах аргын дагуу эдгээр мэдээллийг дахин хянах болон тайлбарлах, тайлал хийгдэх ажлууд явагдана.

Урьдчилсан судалгааны ажлын хүрээнд тухайн талбайд хийгдэх ажилд тохирох геофизикийн судалгааны ажлын аргачлалыг хянах зорилготой параметрийн хэмжилтүүд явагдана. Геофизикийн судалгааны ажлуудыг хэрэгжүүлэхэд геофизикийн аргачлалуудыг цогц хэлбэрээр ашиглах нь зохистой. Зөвхөн геофизикийн ганц аргачлаыг хэмжилтэнд ашиглах нь хангалтгүй бөгөөд учир нь геофизикийн ганц параметрийг судалж хянаснаар тухайн талбайн тодорхой геологийн загвар боловсруулах боломжгүй байдаг. Хамгийн түгээмэл ашигладаг геофизикийн цогцолбор аргад сейсмохайгуул, геоцахилгаан, магнитометрийн аргууд багтана. магнитометрийн аргыг ашигласнаар олон жилийн өмнө бохирдол үүссэн талбайд геологийн бүтцийг судлах боломж олгохоос гадна хуучин төмрийн бүтэц зарим тохиолдолд хуучин зэр зэвсгийн хаягдал илрүүлэх боломжтой. Параметрийн хэмжилтүүдийн үр дүнд дүгнэлт хийсний дагуу тухайн талбайд бүс нутгийн геофизикийн профилийг тодорхойлно. Судалгааны ажил явагдах талбайн хэмжээнээс хамаарч бүс нутгийн профилийн урт хоорондын зай зэргийг тодорхойлно. Зарчмын хувьд 250 х 250 м хэмжээтэй судалгааны талбайд бүс нутгийн геофизикийн 1 профил байх шаардлагатай.

6.2 Дэлгэрэнгүй судалгааны ажил

Дэлгэрэнгүй судалгааны ажлын өмнө Архивын мэдээллийн судалгааны ажил болон Урьдчилсан судалгааны ажил хийгдээгүй бол эдгээр зорилгыг биелүүлэх геофизикийн хэмжилтүүдийг нэмж хийх шаардлагатай. Дэлгэрэнгүй судалгааны ажил нь геофизикийн аргачлалуудын цогцолборыг ашиглаж явагдана (ерөнхийдөө геофизикийн гурван арга). Геофизикийн профилийн нягт нь 25 - 100 м хооронд (маш цөөн тохиолдолд 200 м) байдаг. Профилд хэмжилт хийх алхамын урт нь 5 - 20 м байдаг. Радарын арга, диполын цахилгаан соронзон профилийн хэмжилтийн арга зэрэг нь хоорондоо салшгүй холбоотой мэдээллийг цуглуулах боломж олгодог (10 см алхамтай скан). Босоо цахилгаан зондын эсвэл давтамжын цахилгаан соронзон зондын аргуудыг

их нягттай профилийн хэмжилтэнд ашиглахад тохиромжгүй байдаг. Эдгээр зондын хэмжилтийн алхамын зай нь хэрэгцээнээс шалтгаалж 100 - 1000 м байдаг. Профил хоорондын болон хэмжилтийн алхамын зайнуудыг геофизикийн ажлын төсөлд тодорхойлсон байх ба геофизикийн ажлын хэсгийн ахлагч захиалагч талтай хамтран тохиролцсоны үндсэнд баталдаг.

6.3 Нэмэлт судалгааны ажил

Геофизикийн судалгааны ажил нь цэвэршүүлэх, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг хянах ажлын салшгүй хэсэг байдаг. Эдгээр ажлуудын цогцолборт геологийн бүтцийн үнэлгээ зэрэг ажлуудыг оруулаагүй болно. Зарчмын хувьд бохирдуулагчийн хэмжээний бууралтыг хянахад ажлын зорилго оршино. Энэ зорилгод судалгаа явагдах орчны цахилгаан дамжуулалт буурахтай, чичирхийлэлийн долгионы тархалтын хурд буурах талбайн хэмжээ багасах зэрэгтэй холбоотой аргуудыг тухайн бохирдлын нөхцөлд эсвэл хөрсний агаарын радоны хэмжээ буурах зэрэг тохиолдолд ашиглах нь тохиромжтой. Далдлагдсан хуучин металл эд зүйлс эсвэл хуучин байлдааны хэрэгслийг зайлуулж, устгах үед металлын хэмжээ буурна (пиротехникийн судалгааны журам үз).

6.4 Мэргэжлийн нэгдсэн тайлбар

Өгөгдлийн бодит тайлбар гэдэг нь асуудлын үнэмшилтэй тайлбар бөгөөд дараагийн хэрэглэгчид ойлгомжтой байх шаардлагатай. Олон жилийн өмнө үүссэн экологийн бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд геологи, гидрогеологи, геофизик, химийн болон бусад мэргэжлийн хүмүүс хамтран ажиллах шаардлагатай. Экологийн асуудалтай холбоотой төслийн эцсийн зорилго нь шийдвэрлэх асуудлын талаар цогц ойлголтыг өгөхөд оршино (тухайн талбайн). Төслийн удирдагч нь мэргэжилтнүүдийн хоорондын хамтын ажиллагаа, ажлын үр дүнгийн цогц дүгнэлтээс бүрдэх ажлын эцсийн үр дүнг (ажлын үр дүнгийн иж бүрэн тайлан) бэлэн болгох зэрэг ажлуудыг хариуцна. Мэргэжилтнүүдийн баг нь нэгдсэн эцсийн тайлбар дүгнэлтийг боловсруулах ба шинжээчдийн санал нэг байх шаардлагатай бөгөөд үр дүнгийн тайлбарыг хянана.

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫГ АРИЛГАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЕОФИЗИКИЙН АРГАЧЛАЛУУДЫН ТОЙМ

Байгаль орчны бохирдлыг арилгах, судлах ажлын хүрээнд шийдвэрлэх асуудал	**Эсэргүүцлийн аргаР**	**Цахилгаан химийн арга**	**Цэнэгтэй биеийн арга**	**VDV**	**DEMP**	Георадар	Металл хайгч	Сейсмо аргууд	Магнитометр	Гравиметр	Радиометр	Термометр	Каротажын аргууд	Литологийн каротаж	Агаарын аргууд
Геологийн зураглал – босоо профил	■	□	X	□	▪	X	X	▪	▪	▪	X	X	□	■	X
Геологийн зураглал – хэвтээ профил	■	□	X	■	■	□	X	□	■	□	■	□	□	□	▪
Хучаасын гидрогеологийн нөхцөл	■	■	■	▪	■	▪	X	▪	□	□	□	▪	■	■	□
Хучаасын зузаан ба литологи	■	□	□	□	▪	▪	X	■	□	▪	▪	□	▪	■	▪
Хагарлын бүсийн зураглал	▪	□	X	■	■	■	X	□	□	▪	■	▪	■	■	▪
Гүний усны гадаргын түвшин	■	X	X	X	□	■	X	□	X	X	X	X	■	▪	X
Гүний усны урсацын хурд ба чиглэл	X	□	■	X	X	X	X	X	X	X	X	□	■	X	X
Ул чулуулгийн литологи	■	X	X	X	□	□	X	■	□	▪	X	X	□	■	X
Орчны гидрогеологийн нөхцөл	■	▪	□	□	□	□	X	□	X	X	X	□	■	■	X
Газар доорхи хиймэл объектуудын байршил тогтоох	▪	□	▪	□	■	■	■	□	▪	■	X	□	X	X	X
Дамжуулах хоолой, нөөцлөх сав, худгийн зэврэлт, цоорох, шингэн алдагдах	▪	■	■	□	▪	□	▪	X	X	X	X	▪	▪	X	X
Газар доорхи хөндийн байршил тогтоох	□	X	X	X	□	■	□	□	X	■	X	□	X	X	X
Байгаль орчны далд бохирдлын байршил тогтоох	■	▪	□	□	■	■	■	▪	▪	■	▪	▪	▪	X	□
Бохирдлын цар хүрээ ба тархалт	■	■	■	□	▪	□	X	X	X	□	□	▪	■	X	□
Цэвэршүүлэх, нөхөн сэргээх ажлын мониторинг	■	■	■	□	▪	▪	X	□	□	□	▪	▪	■	X	X

■ оновчтой ▪ тохиромжтой □ тодорхой нөхцөлд тохиромжтой X тохиромжгүй

8. ЗӨВЛӨМЖ БОЛГОХ СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ

Геофизикийн төслийг зохиогчид нь байгаа дотоод, гадаадын мэргэжлийн ном хэвлэлүүдээс мэдээлэл авдаг. Гадаадын мэргэжлийн ном зохиолуудын хувьд олон улсын байгууллагын нийтлэлүүдийг ашиглахыг зөвлөсөн байдаг:

EAGE (European Association of Geoscientists and Engineers)
SEG (Society of Exploration Geophysicits)
SAGEEP (Environmental and Engineering Geophysical Society).

Энэхүү мэргэжлийн удирдамжыг танилцуулах үед мэргэжлийн суурь мэдлэг олоход туслах дараах геофизикийн сурах бичгүүдэд анхаарал хандуулахыг санал болгож байна:

Butler, D.K. (2005): *Near-Surface Geophysics.* Society of Exploration Geophysicists.

Griffin R.H., commander (1995): *Geophysical Exploration for Engineering and Environmental Investigations*. Engineer Manual, US Army Corps of Engineers

Mareš S., et al., (1984): *Introduction to applied geophysics.* D. Reidel Dordrecht

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

METHODICAL GUIDLINE

Risk analysis of contaminated sites

Table of Contents

1. INTRODUCTION 3
2. RISK ANALYSIS OBJECTIVE 3
3. ELIGIBILITY FOR ELABORATION OF THE RISK ANALYSIS 4
4. PLANNING THE RISK ANALYSIS 4
5. RISK ANALYSIS ASSESSMENT 5
6. BASIC RISK ASSESSMENT APPROACH 6
7. REGISTER OF RISK ANALYSIS RESULTS 7
8. ANNEX 1 – USED ABBREVIATIONS 8
9. ANNEX 2 – MANDATORY OUTLINE OF THE RISK ANALYSIS FINAL REPORT 9
9.1 MANDATORY ANNEXES: 10
9.2 RECOMMENDED ANNEXES: 10
10. ANNEX 3 – FACTUAL CONTENTS OF THE RISK ANALYSIS FINAL REPORT 12
STSC (2002): Derivation Support Document for Total Petroleum Hydrocarbons – PPTRV Support Issue SRC SF 01- 031/10-16-2002, EPA Superfund Technical Support Centre, Cincinnati, OH.

U.S. EPA (2005): Aging and Toxic Response: Issues Relevant to Risk Assessment, EPA/600/P-03/004A

U.S. EPA (2008): Child-Specific Exposure Factors Handbook, EPA/600/R-06/096F.

U.S. EPA (1997): Exposure Factors Handbook, EPA, August 1997.

U.S. EPA (2006): A Framework for Assessing Health Risks of Environmental Exposures to Children, EPA/600/R-05/093F.

U.S. EPA (2005): Guidelines for Carcinogen Risk Assessment, EPA/630/P-03/001F.

U.S. EPA (1998): Guidelines for Ecological Risk Assessment, EPA/630/R-95/002F.

U.S. EPA (1989 - 2009): Risk Assessment Guidance for Superfund. Volume I, parts A – F: http://www.epa.gov/oswer/riskassessment/human_health_exposure.htm

U.S. EPA (2009b): http://www.eea.europa.eu/publications/emep-eea-emission-inventory-guidebook-2009

U.S. EPA (2001): Risk Assessment Guidance for Superfund. Volume III - Part A, Process for Conducting Probabilistic Risk Assessment. http://www.epa.gov/oswer/riskassessment/rags3adt/index.htm

U.S. EPA (1996): Soil Screening Guidance: Technical Background Document, EPA/540/R95/128.

U.S. EPA (1997): Superfund Today. Focus on Risk Assessment.

U.S. EPA (2005): Supplemental Guidance for Assessing Susceptibility from Early-life Exposure to Carcinogens, EP-A/630/R-03/003F.

Significant internet sources of information

International Agency for Research on Cancer (IARC) – database of carcinogenic substances: http://www.iarc.fr/en/publications/list/monographs/index.php
http://monographs.iarc.fr/ENG/Classification/

The Risk Assessment Information System (RAIS) – monthly updated database of toxicological data and models for risks calculation: http://rais.ornl.gov/cgi-bin/tools/TOX_search?select=chem
http://rais.ornl.gov/cgi-bin/tools/TOx_search?select=chem

U.S. EPA Risk-Based Screening Tables for Human Health Risk Assessment:
http://www.epa.gov/reg3hwmd/risk/human/index.htm

U.S. EPA Human Health Risk Assessment Guidance: http://rais.ornl.gov/guidance/epa_hh.html

U.S.EPA Risk Assessment Guidelines:
http://cfpub.epa.gov/ncea/cfm/recordisplay.cfm?deid=55907
http://www.epa.gov/oswer/riskassessment/human_health_exposure.htm

Database of software and environmental models: http://www.scisoftware.com/

Ecological Risk Analysis (ORNL) – references to procedures of risk assessment for ecosystems: http://www.esd.ornl.gov/programs/ecorisk/ecorisk.html

European Exposure Factors Sourcebook (ExpoFacts) – database, references and literature: http://expofacts.jrc.ec.europa.eu/

Guide to Current Literature on Exposure Factors:
http://cfpub.epa.gov/ncea/cfm/recordisplay.cfm?deid=29187

Integrated Risk Information System (IRIS) – database of toxicological parameters for human health administrated by the U.S. EPA: http://www.epa.gov/iris/index.html

U.S. Geological Survey (USGS): database of software and models usable in hydrogeology: http://water.usgs.gov/software/

British Columbia - Guidance on Contaminated Sites:
http://www.env.gov.bc.ca/epd/remediation/guidance/

Total Petroleum Hydrocarbon Criteria Working Group Series Online: Volumes 1-5:
http://www.aehs.com/publications/catalog/contents/tph.htm

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

МЭРГЭЖЛИЙН АРГА ЗҮЙН УДИРДАМЖ

Бохирдолтой талбайн эрсдэлийн анализ

Агуулга

1. ОРШИЛ ... 3
2. ЭРСДЛИЙН АНАЛИЗЫН ЗОРИЛГО ... 3
3. БОХИРДОЛТОЙ ТАЛБАЙН ЭРСДЛИЙН АНАЛИЗ ХИЙХ ЧАДВАР ... 4
4. ЭРСДЛИЙН АНАЛИЗЫН ТӨСЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ ... 4
5. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ДҮГНЭЛТ ... 5
6. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДСЭН АРГА ... 6
7. ЭРСДЛИЙН АНАЛИЗЫН ҮР ДҮНГИЙН БҮРТГЭЛ ... 7
8. ХАВСРАЛТ 1 – ТОВЧИЛСОН ҮГҮЙД ... 8
9. ХАВСРАЛТ 2 – ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ ... 9
9.1 ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ХАВСРАЛТУУД: ... 10
9.2 ЗАЙЛШГҮЙ БУС САНАЛ БОЛГОХ ХАВСРАЛТУУД: ... 10
10. ХАВСРАЛТ 3 – ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН БОДИТ АГУУЛГА ... 12
11. ХАВСРАЛТ 4 – ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗАРЧМУУД ... 39
11.1 ӨРТӨЛТИЙН ХУВИЛБАРУУДЫН БА ТООЦООНЫ ЖУРМЫН ЖИШЭЭ ... 44
12. ХАВСРАЛТ 5 - КОНЦЕПТЫН ЗАГВАРЫН ЖИШЭЭ ... 59
13. ХАВСРАЛТ 6 – АШИГЛАХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР ЗӨВЛӨМЖ ... 63

1. Оршил

Энэхүү арга зүйн удирдамж нь БНЧех Улсын Байгаль орчны яамны Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний арга зүйн удирдамжын (U.S. EPA аргачлалын дагуу боловсруулсан) дагуу боловсруулагдсан ба бохирдолтой талбайн эрсдлийн анализын (цаашид эрсдлийн анализ гэж нэрлэх) ерөнхий зарчмууд, үндсэн агуулга ба хэлбэрийг, хуучин эсвэл шинэ бохирдол, бохирдлын урьдчилсан таамаглал буюу сэжигтэй нөхцөл зэргийг үл харгалзан боловсруулалтын нэгдмэл шинж чанарыг хангасан байх шаардлагатай. Арга зүйн удирдамж нь шийдвэр гаргахдаа эрсдлийн анализыг ашигладаг бүх байгууллагууд ялангуяа байгаль орчин хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн, төрийн захиргааны байгууллагууд, бохирдолтой талбайн одоогийн болон шинэ эзэмшигч, түрээслэгчдэд зориулагдсан.

Газрын гадаргын болон гүний ус ноцтой бохирдох аюултай эсвэл бохирдол хүний эрүүл болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд мөн тухайн хууль тогтоомж зөрчсөнийг тогтоож залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах боломжгүй үед эрсдлийн анализыг боловсруулахыг зөвлөдөг. Эдгээр тохиолдолд эрсдлийн анализ нь талбайн бохирдлын эрсдэлтэй холбоотой үйл ажиллагааны шийдвэрлэх мэдээлэл болдог.

Эрсдлийн анализ нь боловсруулалтын үеийн мэдэгдэж байгаа болон батлагдсан баримтуудыг үндэслэх учир цагийн хувьд хязгаарлагдмал хүчинтэй байдаг.Хэрэв эрсдлийн анализд их хэмжээгээр нөлөөлөх дүгнэлт гарах тохиолдолд (ж-нь: газар ашиглалтын өөрчлөлт, бохирдол тархалт болон цаашдын явц өөрчлөлт, бохирдлын нөлөөний талаархи эрдэм шинжилгээний шинэ мэдээлэл, цэвэршүүлэх ажлын шинэ технологи) шинэчлэгдсэн эрсдлийн анализын дагуу ажиллах ба ингэснээр гарсан өөрчлөлтийг дүгнэх боломжтой.

Эрсдлийн анализ нь хоорондоо холбоотой дараах алхмуудаас бүтнэ:

- Байгаа мэдээллүүдийн судалгаа ба бие даасан мэргэжлийн удирдамжын дагуу талбайн бохирдлыг судалж тогтоох;
- Тогтоосон бохирдлын мэдээллийг үндэслэн эрүүл мэндийн болон байгаль орчны бүрдэл хэсгүүдийн эрсдлийн үнэлгээ хийх;
- Эцсийн зорилго ба параметрүүд, залруулах арга хэмжээнүүд ба тэдгээрийн биелэлт, цэвэршүүлэх ажиллагааны дараах мониторинг зэргийн саналыг боловсруулах;
- Залруулах арга хэмжээний (цэвэршүүлэх) эсвэл эрсдлийг бууруулах өөр арга хэмжээний эсвэл техник эдийн засгийн үндэслэлийн санал боловсруулах;
- Санхүүгийн зардлын тооцоо, санал болгох залруулах арга хэмжээний хувилбарт зарцуулах хугацааг тооцоолох (эрсдэл буурсан хэмжээ ба зарцуулсан эх үүсвэрийн харьцааны анализ).

2. Эрсдлийн анализын зорилго

Эрсдлийн анализын зорилго нь бохирдлын улмаас үүсэх бодит болзошгүй эрсдлийг тайлбарлахад оршино. Эдгээр эрсдэл нь хүний эрүүл мэнд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд (байгалийн эх үүсвэрүүд ба экосистем) одоо аюул учруулах ба бохирдол цаашид үргэлжлэн тархах, газар ашиглалт өөрчлөгдөх зэрэг тохиолдолд

ирээдүйд аюул учруулж болзошгүй байдаг. Эдгээр эрсдлийн ноцтой байдлаас шалтгаалан залруулах арга хэмжээг эсвэл эрсдэлийн менежментийн стратеги бодлогыг тодорхойлно.

Бохирдолтой талбай ба түүний орчмын газруудын одоогийн, урьдчилан тооцсон газар ашиглалтын хэлбэр, бохирдол тархах цар хүрээ, бохирдлын нөлөө зэргийг харгалзан тооцож эрсдлийг үнэлгээг хийдэг. Эрсдлийн урьдчилсан анализ ж-нь: эрсдлийн анализыг бүрэн хэмжээгээр хийх шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргахад нөлөөлнө.

Эрсдлийн анализын төгсгөлийн дүгнэлтийн хэсэгт багтах залруулах арга хэмжээний саналд эцсийн параметрүүдийг тодорхойлох ба эдгээр параметрүүд биелэгдсэн тохиолдолд тухайн газрыг төлөвлөлтийн дагуу эсвэл өмнөх ашиглалттай адил хэлбэрээр ашиглах боломжтой. Эцсийн параметрүүдийн саналд параметрүүд биелэгдэх бодит нөхцлийн талаархи мэдээллийг оруулахаас гадна техникийн, хууль эрх зүйн, санхүүгийн болон цаг хугацааны талаас нь зайлшгүй авч үзнэ.

3. Бохирдолтой талбайн эрсдлийн анализ хийх чадвар

Бохирдолтой талбайн эрсдлийн анализын ажил нь геологийн ажлуудтай салшгүй холбоотой учир зайлшгүй геологийн ажил хийх мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй, дадлага туршлагатай мэргэжлийн хүн төслийг удирдах ба боловсруулах шаардлагатай. Энэ хүн – хариуцан хэрэгжүүлэгч байх бөгөөд судалгааны ба дээж авах ажил ба тэдгээрийн аргачлал, туслан гүйцэтгэгчийн ажил, үр дүнгийн боловсруулалт зэрэг ажлуудын чанарын хариуцлагыг хүлээх үүрэгтэй.

Эрсдлийн үнэлгээ хийхэд эрсдлийн тодорхой хэсгийг цацраг идэвхтэй туяаны эрсдэл эзлэх тохиолдолд цацраг идэвхтэй бодисын асуудалтай холбоотой журмын дагуу үнэлгээ хийгдэнэ.

Лабораторийн шинжилгээний ажил нь магадлан итгэмжлэгдсэн лабораторид магадлан итгэмжлэгдсэн аргачлалын дагуу эхний ээлжинд хийгдэнэ. Зайлшгүй шаардлагатай үед магадлан итгэмжлэгдээгүй аргачлалыг ашиглаж болох ба энэ бодит байдлын үндэслэл болон бусад мэдээллийг эрсдлийн анализын тодорхой бус байдлын тайлбарт оруулна.

4. Эрсдлийн анализын төслийн боловсруулалт

Эрсдлийн анализын иж бүрэн боловсруулалтыг бохирдолтой талбай сүүлийн үед хангалттай судлагдсан, бохирдлын голомтоос бохирдол тархах бүх замуудыг тодорхойлсон гэж үзэх тохиолдолд хийдэг.

Судалгааны ажилтай холбоотой эрсдлийн анализын ажлын үед **концепцийн урьдчилсан загварыг** боловсруулах зайлшгүй шаардлагатай ба загварт тухайн талбайн шинж байдал, бохирдлын бүх эх үүсвэрүүд ба голомтууд, бохирдол тархах бодит замууд, хүлээн авагчдын талаархи мэдээллүүд багтана.

Концепцийн урьдчилсан загварын хүрээнд өртөлт дамжих замуудыг (бохирдлын эх үүсвэрээс хүлээн авагч хүртэлх тархалтын бодит замууд) урьдчилан тогтоох ба өртөлт дамжих зам тус бүрийн хувьд эрсдлийн үнэлгээнд шаардагдах мэдээлэл бүрэн хангалттай эсэхийг авч үзнэ. Эрсдлийн анализын судалгааны ажлын төсөлд дутуу байгаа мэдээллийг судалгааны ажлын явцад бүрдүүлэхийг санал болгодог. Эдгээр судалгааны ажлууд нь бие аргачлалын бие даасан удирдамжын дагуу ихэвчлэн олон шаттай явагддаг.

Эрсдлийн анализын дараагийн хэсгүүдэд бохирдолтой талбайн судалгааны ажлуудын үр дүнг үндэслэн концепцийн урьдчилсан загварыг шинэчилж боловсруулна.

5. Эрсдлийн үнэлгээний ажлын үр дүнгийн дүгнэлт

Эрсдлийн анализын үр дүнг эрсдлийн **анализын эцсийн үр дүнгийн тайланд** санал болгож буй хөтөлбөрийн дагуу боловсруулна (Хавсралт 2). Хэрэв талбайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зарим бүлгүүдийн агуулга асуудалтай хамааралгүй эсвэл илүү тохиолдолд тухайн бүлгийн үндсэн мэдээллийн оронд үндэслэлийг тайлбарласан текстийг оруулж өгнө. Ийм аргыг эрсдлийн анализын зарим хэсгийг санамсаргүйгээр орхигдуулахгүйн тулд мөн эдгээр хэсгүүдийг боловсруулах шаардлагагүй тохиолдлын үндэслэлийг сайн тайлбарлах хэрэгтэй.

Эрсдлийн анализын үр дүнгийн тайлан нь өргөн хүрээний мэргэжлийн болон төрийн захиргааны байгууллагуудад зориулагдах учир бохирдолтой талбайн байдал, эрсдэл, тодорхой бус байдал, эрсдлийг бууруулсны дараах байдал зэрэг мэдээллүүдийг ойлгомжтой цогц хэлбэрээр боловсруулах шаардлагатай. Эрсдлийн анализын стандарт түвшинд боловсруулахад олон төрлийн талбайн мэдээг дүгнэхэд ажлыг хөнгөвчлөхийн тулд арга зүйн журам, тооцооны параметрүүдийн тэмдэглэгээг мөрдөх ба энэ талаар чиглэл болон түүний хавсралтуудад дурдсан.

Эрсдлийн анализын үр дүнгийн тайланг **бохирдолтой талбайн судалгааг хангалттай** хийсэн тохиодолд боловсруулах боломжтой. Өөрөөр хэлбэл концепцийн бүрэн гүйцэд загварыг боловсруулах боломжтой ба энэ тохиолдолд бохирдол тархалтын замын бүх суурь параметрүүд мөн эрсдэл хүлээн авагч бүрийн өртөлтийн хувилбарыг дүгнэх параметрүүд тодорхой байх шаардлагатай. Бохирдлын дэлгэрэнгүй судалгаа хийхэд тавигдах шаардлагууд биелэгдсэн байх (ангилал B “Бохирдолтой талбайн судалгаа хийх мэргэжлийн удирдамж”-ын дагуу). Онцгой ба үндэслэлийг тодорхой тайлбарласан нөхцөлд бохирдолтой талбайн хянаж шалгаагүй параметрүүдийг ашиглаж болох ба ойр орчмын талбайн байгаль орчны өгөгдлийн интерполяц эсвэл мэргэжлийн удирдамж ба хавсралтуудад тодорхойлогдсон хүлээн зөвшөөрөгдсөн үзүүлэлтүүдийг ашиглах боломжтой. Энэ тохиолдолд судалгаа нь бохирдлын урьдчилсан судалгаанд тавигдах хамгийн доод тал нь 2 шаардлагыг хангасан байна (ангилал C).

Бохирдолтой талбайн судалгаа хангалттай хийгдээгүй тохиолдолд эрсдлийн анализын оронд **эрсдлийн урьдчилсан анализыг** боловсруулах ба эдгээр ажлын хүрээнд олдох болмжтой мэдээллүүд, тодорхой бус байдлыг дүгнэх ба ноцтой болзошгүй эрсдлийг үгүйсгэж болохгүй тохиолдолд бүрэн хэжмээний эрсдлийн үнэлгээ хийхэд шаардагдах нэмэлт судалгааны ажлын саналыг боловсруулж үндэслэлийг тодорхой тайлбарлана. Эрсдлийн урьдчилсан анализ хийхэд бодит эрсдэлгүй болох нь тодорхой нотлогдсон бол дараах ажлуудыг үргэлжлүүлэх шаардлагагүй. Эрсдлийн урьдчилсан анализын үр дүнгийн тайлан боловсруулах болон бохирдолтой талбайн мэдээг мэдээллийн санд оруулах ажлын үед энэхүү мэргэжлийн удирдамжын дагуу ажиллах шаардлагатай.

Дараах тохиолдолд судалгаа хангалтгүй хийгдсэнд тооцно:

- *Бохирдол тархалтын чиглэлд бохирдлын манангийн заагийг тогтоогоогүй* – энэхүү нөхцөл нь хяналт хийж байгаа байгаль орчны бүрдэл хэсгийн хүчин төгөлдөр хууль тогтоомжын тогтоосон хязгаараас үзүүлэлтүүдээс хэтэрсэн

үзүүлэлттэй манагийн хэсэгт хамааралтай. Манагийн “духны” хэсэг мэдэгдэхгүй үед болзошгүй эрсдэл хүлээн авагчыг баталгаатай тодорхойлох боломжгүй.

- *Ердийн бохирдлын талаархи мэдээлэлгүй* – суурь байдлын талаархи мэдээлэл байхгүй нөхцөлд үнэлгээ хийж буй талбайн бохирдолтой холбож ойлгох боломжгүй эрсдлийг алдаатай тодорхойлох аюултай ба түүний дараа эрсдлийг бууруулах залруулах арга хэмжээний тохирохгүй саналыг боловсруулах магадлалтай.
- *Өмнөх судалгааны ажлуудын үед батлагдсан эсвэл үндэслэлтэйгээр урьдчилан таамагласан бохирдуулагч бодисын хяналт хийгдээгүй* - их хэмжээний бохирдуулагчын хяналт хийгдээгүй тохиолдолд бодит эрсдлийг дутуу үнэлэх ба дараагийн залруулах арга хэмжээний буруу саналыг боловсруулах байдалд хүргэнэ.
- *Талбайн нөхцлийг дэлгэрэнгүй тодорхойлоогүй, ялангуяа геологи, гидрогеологийн нөхцлүүдийг* – талбайн нөхцлийн талаарх алдаатай эсвэл хангалтгүй тодорхойлолт нь бохирдлын манангийн чиглэл ба тархалтын хурдыг буруу үнэлэхэд нөлөөлөх боломжтой.
- *Судалгаа хайгуулын ажлын үр дүн шаардлагагүй болсон* – эрсдлийн анализын үед өмнөх судалгааны ажлуудын үр дүнгийн үнэн байдлыг зайлшгүй шалгах бөгөөд шалгаагүй тохиолдолд эрсдлийн буруу тодорхойлж, түүний дараа залруулах арга хэмжээний тохирохгүй саналыг боловсруулах магадлалтай.

Шинэчлэгдсэн эрсдлийн анализыг эрсдлийн анализтай адил аргаар боловсруулна. Анх ашигласан баримтууд (бодит цэвэршүүлэх ажилтай холбогдох) өөрчлөгдөх тохиолдолд үнэлгээ хийгдэх учир бага зэргийн өөрчлөлтийн үед өөрчлөлтийн дараагийн үнэлгээний богиносгосон хувилбарыг боловсруулж тэдгээрийн үр дүнг (ж-нь: үлдэгдэл бохирдолтой холбоотой) тодорхойлно. Энэ тохиолдолд эдгээр мэдээллүүдийг эрсдлийн анализын нэмэлт болгон ашиглах ба шийдвэрлэх үйл ажиллагааны үед эдгээр 2 материалыг хамтад нь хянах шаардлагатай.

6. Эрсдлийн үнэлгээний үндсэн арга

Энэхүү мэргэжлийн удирдамжид зориулагдсан бохирдолтой талбайн бохирдуулагч бодисын **эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ** нь АНУ-ын Байгаль орчин хамгаалах агентлагийн U.S. EPA-н арга зүйн дагуу хийгдсэн БН Чех Улсын Байгаль орчны яамны аргачлалыг үндэслэн боловсруулагдсан ба дараах гол гол алхмуудыг багтаана:

1. Эрүүл мэндийн болзошгүй эрсдлийн хувьд бохирдолтой талбайн химийн бодисуудыг тодорхойлох.
2. Бохирдолтой талбайн бохирдуулагч бодисын концентрацийг хууль эрх зүйн зохицуулалтын хязгаар агууламжтай эсвэл санал болгосон ажлын болон байгаль орчны хүчин зүйлүүдийн стандарт буюу дохио утгатай харьцуулах (Хавсралт 6-д багтсан эх үүсвэрийг үзэх) ба энэхүү харьцуулалтын ач холбогдлыг үнэлэх.
3. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг өртөлтийн бодит хувилбарын дагуу тооцох.Өртөлтийн хувилбаруудын загварыг Хавсралт 6 -д оруулсан. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ нь одоогийн мэдлэгт түшиглэсэн сүүлийн үед хүлээн зөвшөөрөгдсөн аргуудын хүрээнд явагдана (Хавсралт 6-д байгаа эх үүсвэрийг үзэх). Хэрэв боловсруулагч нь эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний өөр аргыг

ашиглах бол ингэж шийдсэн талаар үндэслэлтэй тодорхой тайлбарлана.

4. Урьдчилсан эрүүл мэндийн эрсдэл ба эрсдлийн үнэлгээний тодорхой бус байдлыг үгээр тайлбарлаж дүгнэх.

5. Эрсдлийг тодорхойлоход суурь мэдээлэл хангалтгүй байх тохиолдолд (ж-нь: хуулийн дагуу заавал дагаж мөрдөх үзүүлэлтүүд байхгүй, хоруу чанарын мэдээлэл эсвэл орон зай болон цаг хугацаанд ихээр өөрчлөгдөх параметрүүд байхгүй) энэ бодит байдлыг эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээнд дурдаж, арга хэмжээний зөвлөмжид эдгээр мэдээллийг эсвэл эрүүл мэндийн эрсдлийн байнгийн үнэлгээг (ажлын орчны хувьд) тодорхойлох саналыг нэмж оруулахыг зөвлөх.

Экологийн эрсдлийн үнэлгээг дараах тохиодолд ашиглана:

1. Бохирдол нь онцгой хамгаалалттай байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох байгалийн усны хуримтлал бүхий тусгай хамгаалалттай газар нутаг, газрын гүний болон гадаргын усыг, тэдгээрийн хамгаалалтын бүсийг, байгалийн эмчилгээний рашаан ус, мэдрэмтгий эмзэг газрууд, усанд сэлэх боломжтой, загас болон усны бусад амьтдын үржихэд тохиромжтой гадаргын усыг бохирдуулах аюултай.

2. Бохирдол нь тусгай хамгаалалттай экосистем болон бусад газар нутагт аюул учруулна.

3. Онцлог нөхцөлд экологийн эрслийг үнэлэх нийгмийн эрэлт хэрэгцээ үүсэх тохиолдолд.

Хууль эрх зүйн хязгаарлалт бүхий экосистемийн эрсдлийн үнэлгээ хийхэд эдгээр хязгаарыг ашиглах ба бусад онцлог үнэлгээ хийгдэхгүй.

7. Эрсдлийн анализын үр дүнгийн бүртгэл

Эрсдлийн анализын болон түүнтэй холбоотой геологийн судалгааны ажлын үр дүнг бохирдолтой газрын мэдээллийн санд нэмж оруулах шаардлагатай.

8. ХАВСРАЛТ 1 – ТОВЧИЛСОН ҮГҮҮД

ADD	Average Daily Dose – өдрийн дундаж тун (мг.кг.өдөр$^{-1}$)
ADI	Acceptable Daily Intake – хүлцэх боломжтой өдөр тутам хүлээн авах тун (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)
ATSDR	Agency for Toxic Substances and Disease Registry
CDI (мг.кг.өдөр$^{-1}$)	Chronic Daily Intake – удаан хугацааны өдөр тутам хүлээн авах тун
DNAPL бодисууд	Dense Non-Aqueous Phase Liquids - уснаас хөнгөн фазыг бүрдүүлдэг
ECAO	Environmental Criteria and Assessment Offce
ELCR	Excess Lifetime Cancer Risk – хорт хавдар үүсэх насан туршын эрсдэл
HEAST	Health Effects Summary Tables
HQ	Hazard Quotient - kvocient nebezpečnosti
IARC	International Agency for Research on Cancer
IRIS	Integrated Risk Information System (U.S. EPA)
LADD (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)	Lifetime Average Daily Dose – насан туршын өдөр тутам хүлээн авах тун
LNAPL бодисууд	Light Non-Aqueous Phase Liquids – уснаас хөнгөн фазыг бүрдүүлдэг
MŽP	Байгаль орчны яам
PAU	үнэрт нүүрсустөрөгч
PCB	полихлорбифенил
RAIS	Risk Assessment Information System (Oak Ridge National Laboratory)
RfD	Reference Dose – лавламж тун (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)
TEF	Toxic Equivalency Factor
TEQ	Toxic Equivalent
U.S. EPA	United States Environmental Protection Agency

9. ХАВСРАЛТ 2 – Эрсдэлийн үнэлгээний тайлангийн зайлшгүй шаардлагатай суурь мэдээлэл

Оршил

1. Талбайн мэдээлэл

1.1 Ерөнхий мэдээлэл
1.1.1 Талбайн газарзүйн хил
1.1.2 Талбайн одоогийн болон төлөвлөгдсөн ашиглалт
1.1.3 Талбайн хүн ам оршин суух байдал
1.1.4 Үл хөдлөх хөрөнгийн асуудал

1.2 Талбайн байгалийн нөхцөл байдал
1.2.1 Геоморфологийн ба цаг уурын байдал
1.2.2 Геологийн тогтоц
1.2.3 Гидрогеологийн нөхцөл
1.2.4 Гидрологийн нөхцөл
1.2.5 Талбайн геохими ба гидрохимийн мэдээлэл

2. Судалгааны ажлууд

2.1 Талбайн судлагдсан байдал
2.1.1 Талбайд өмнө хийгдсэн судалгаа, цэвэрлэгээний ажлын үр дүн
2.1.2 Бохирдуулагч эх үүсвэрүүд
2.1.3 Анхаарах бодисууд болон эрсдэлийн хүчин зүйлүүдийг тодорхойлох
2.1.4 Бохирдлын урьдчилсан загвар

2.2 Үргэлжилж буй судалгааны ажлууд
2.2.1 Судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ, аргачлал
2.2.2 Судалгааны ажлын үр дүн
2.2.3 Бохирдлын газрын гадаргуун болон орон зайн тархалтыг дүгнэх, хэмжээг тогтоох
2.2.4 Бохирдлын тархалтыг дүгнэх
2.2.4.1 Ханаагүй бүсэд бохирдол тархах
2.2.4.2 Ханасан бүсэд бохирдол тархах
2.2.4.3 Гадаргуун усаар бохирдол тархах
2.2.4.4 Байгалийн нөхөн сэргэх үйл явцаас хамаарах бохирдлын цаашдын явц
2.2.5 Бохирдлын тархалтыг дүгнэлт
2.2.6 Хязгаарлалт ба тодорхой бус байдал

3. Эрсдэлийн үнэлгээ

3.1 Эрсдэлийг тодорхойлох
3.1.1 Нэн тэргүүнд анхаарах бохирдуулагч болон бусад эрсдлийн хүчин зүйлүүдийн үндэслэл ба тодорхойлолт
3.1.2 Хүлээн авагчдын тодорхойлолт
3.1.3 Тархалтын замын дүгнэлт ба бодит нөлөөллийн хувилбарын тойм (шинэчлэгдсэн концептын загвар)

3.2 Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ
3.2.1 Нөлөөллийн дүгнэлт
3.2.2 Эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлох

3.3 Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ

3.4 Эрсдэлийн дүгнэлт

3.5 Хязгаарлалт ба тодорхойгүй байдал

4. Эрсдэлийг багасгах арга хэмжээ

4.1 Авах арга хэмжээний параметрын зөвлөмж

4.2 Санхүүгийн тооцоо бүхий бохирдолыг багасгах арга хэмжээний зөвлөмж

5. Төгсгөл ба зөвлөмж

Ашигласан ном хэвлэл

Товч үгийн тайлбар

Хавсралтуудын жагсаалт

9.1 Зайлшгүй шаардлагатай хавсралтууд:

1. Талбайн 1 : 25 000 ба бусад масштабын байршилзүйн газрын зураг
2. Үл хөдлөх хөрөнгийн бичгийн ба талбайн барилгын зураг бүхий кадастрын зургийн хуулбар талбайн баримжаалсан зураг
3. Мэргэжлийн агуулгатай, хийгдсэн ажлын хэмжилтийн цэгүүдийн байршил ба тэмдэглэл, шууд хэмжилт, дээж авалт, техникийн ажлын мэдээлэлтэй тусгай газрын зургийн нэг хэсэг (холбогдох архивын мэдээлэл)
4. Хэмжилт, туршилт ба анализын үр дүнгийн хүснэгт
5. Судалгааны геологийн баримтууд
6. Талбайн газар хэмжилтийн болон хайгуулын ажлын үр дүн (газар хэмжилтийн координатуудын жагсаалт, хэмжилтийн цэгүүдийн график схем)
7. Мэргэжлийн байгууллагаас боловсруулсан дэд асуудлыг шийдвэрлэх техникийн тайлан эсвэл дүгнэлт
8. Тусгай ажил тус бүрийг хийлгэх нөхцлийг дурдах, тэдгээрийн хэмжилт, туршилт, анализыг харьцуулсан протокол (ялангуяа лабораторийн протокол)
9. Мэдээллийн санд бохирдолтой талбайн мэдээллийг оруулсан тухай БОНХЯ-ны тодорхойлолт

9.2 Зайлшгүй бус санал болгох хавсралтууд:

1. Бохирдуулагч бодисын, бэлдмэлийн, организм ба микро организмын физик-хими, хоруу чанарын шинжийн тойм
2. Тооцооллын загварчлал, статистикийн тооцоо гм.
3. Талбайн эзэн эсвэл түрээслэгчийн гарын үсэгтэй устгах техник ажиллагааны

протокол

4. Гэрэл зургууд
5. Нийт мэдээллийн цахим хувь
6. Талбайн ашиглалтын ялгааг тусгасан газар ашиглалтын хүчинтэй хэтийн төлөв эсвэл талбайн ашиглалтын хэлбэрүүдийн талаарх мэдээлэлтэй газар ашиглалтын хэтийн төлөвийн зураг төслийн хувь (эсвэл зураг төслийн хэсэг)
7. Талйангийн бичгийн хэсгийн тайлбарлах, нэмэлт мэдээлэл оруулахад шаардагдах бусад баримтууд (тайлангийн текстийг уншихад хялбар болгохын тулд нэмэлт мэдээлэл оруулах шаардлагатай ба гэхдээ агуулгын утгын үргэлжлэх байдалд саадгүй, уншигчын анхаарлыг сарниулахгүй байх)

10. ХАВСРАЛТ 3 – Эрсдэлийн үнэлгээний тайлангийн бодит агуулга

Оршил

Оршилд даалгаврын нэр болон үе шатыг, судалгааны талбайн байршил зэрэг мэдээлэл багтана. Мөн ажлын захиалагч, шийдвэрлэх асуудлын тодорхойлолт, эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах ажлыг хэрэгжүүлэх болсон шалтгааныг зайлшгүй дурдана. Дараах мэдээллүүд багтана. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн багийн бүрэлдэхүүн, төсөл хэрэгжүүлэгчийн нэр, туслан гүйцэтгэгчдийн жагсаалт.
- Төслийн гол ажлуудын товч жагсаалт (төсөлд гарсан өөрчлөлтийг багтаасан).

1. Талбайн талаарх мэдээлэл

1.1 Ерөнхий мэдээлэл

1.1.1 Талбайн газарзүйн байршил

Энэ бүлэгт дараах мэдээлэл багтана. Үүнд:

- Талбайн байршлын тодорхойлолт, чухал ач холбогдолтой зайнуудыг багтаасан талбайн хэмжээний талаарх мэдээлэл.
- Засаг захиргааны харъяалал (кадастрын, сумын, аймгийн).

Эрсдэлийн үнэлгээний хавсралтанд судалгааны талбайг тэмдэглэсэн талбайн дэлгэрэнгүй байршилзүйн газрын зураг зайлшгүй байх шаардлагатай.

1.1.2 Талбайн одоогийн болон төлөвлөсөн ашиглалт

Талбайн ашиглалтын одоогийн болон ирээдүйн төлөвлөлтийн талаархи мэдээллүүд нь бодит загварчлал болон нөлөөллийн хувилбаруудыг боловсруулах, бохирдолтой талбайн ангилалыг тогтооход үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Тухайн талбайн газар төлөвлөлт болон газрын дүгнэлт зэрэг нь суурь баримт болох ба эдгээр баримтуудын үнэн бодит, баталгаатай эсэхийг шалгах (сонирхогч талуудтай уулзаж ярилцах хэлбэрээр) шаардлагтай ба талбайн одоогийн ашиглалтыг хээрийн судалгаа хийж тодруулна. Талбайн газар төлөвлөлтийн төлөвлөгөөнөөс гадна олон жилийн туршид бохирдолтой байгаа талбайн болон ажиллагаагүй болсон үйлдвэрийн технологийн талаархи дүгнэлт хийх, хог хаягдлын цэгийн байршлыг тогтоооход архивын агаарын зураг зэрэг нь чухал баримт болдог.

Талбайн тодорхойлолт товч байх ба эрсдэлийн болзошгүй хүлээн авагч байгаа тохиолдолд тодорхойлолтыг илүү дэлгэрэнгүй хийнэ. Бохирдолтой талбайн ашиглалтын хэлбэрүүдийг ажлын үр дүнгийн тайлангийн хавсралт газрын зурагт график хэлбэрээр оруулна.

Энэ бүлэгт дараах мэдээллүүд багтана. Үүнд:

- *Бохирдолтой талбай болон түүний ойролцоох талбайн ашиглалт*. Тодорхойлолт нь талбайн одоогийн ерөнхий ашиглалтын дүгнэлт хэлбэрээр хийгдэнэ. Мөн бохирдолын болзошгүй эх үүсвэр ба түүний нөлөөлөх хугацааг тодорхойлох

үүднээс талбайн ашиглалтын түүхийг анхаарах шаардлагатай.

- *Байгаль болон хүрээлэн буй орчны хамгаалал.* Бохирдол тархаж болзошгүй чиглэлийн дагуу байрлах ойролцоох тусгай хамгаалалттай газрын жагсаалтыг хийх (байгалийн буюу хурын ус хуримтлагдах хамгаалалттай бүсийг оролцуулан). Бодит эрсдэл тохиолдох нөхцөлд тэдгээрийн шинж чанар (экосистемийн төрөл) болон хамгаалалтын төрөл зэргийг илүү дэлгэрэнгүй дурдах шаардлагатай.
- *Усны эх үүсвэр, ашигт малтмал, техникийн байгууламжуудыг хамгаалах.* Эрсдэлд өртөх боломжтой усны эх үүсвэрийн хувьд дараах мэдээллүүд шаардлагатай: ашиглагдаж буй болон тухайн талбайд байрлах газрын гадаргын, гүний усны эх үүсвэр ба түүний хамгаалатын бүс, ашиглалт бүхий усны эх үүсвэрийн ус ашиглалтын хэмжээ, усны динамик түвшин, ашиглалтын түүх, усны эх үүсвэрийг ашиглагч, усны эх үүсвэрийн ажиллагааг хариуцагч болон усны чанарын талаарх мэдээлэл. Эмчилгээний чанартай усны эх үүсвэрт онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Ашигт малтмалын хувьд ашигт малтмалын төрөл, судалгаа хийгдсэн түвшин, олборлолт явагдах талбай зэргийг дурдана. Геологийн тогтоцын тодорхойлолтын талаар байгалийн нөхцөл байдлын бүлэгт тайлбарласан. Техникийн байгууламж хамгаалалтын бүсийн хувьд (ж-нь: төмөр зам) оператор байгууллагыг нэрлэх ба хамгаалалтын бүсэд үзүүлэх нөлөөг тусгайлан мөн судалгаа, цэвэрлэгээний ажил хэрэгжүүлэх нөхцөл боломжыг тодорхойлно.
- *Талбайн төлөвлөсөн ашиглалтын өөрчлөлт.* Талбайн төлөвлөлт болон өнөөгийн саналуудыг үндэслэн талбайн төлөвлөсөн ашиглалтын өөрчлөлтийн талаар дурдана. Талбайн ашиглалтын төлөвлөгөөг хавсралт хэлбэрээр оруулж болно. Газар өмчлөгчид, орон нутгийн байгууллага болон бусад сонирхогч талуудтай уулзаж талбайн төлөвлөсөн ашиглалтын талаарх мэдээллийг хянаж тодруулах шаардлагатай.

1.1.3 Талбайд хүн ам оршин суух байдлын тодорхойлолт

Энэхүү бүлэг нь нөлөөллийн хувилбарыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай тул одоогийн мэдээллийг (тайлангийн бусад бүлэгтэй адил) ашиглана. Ерөнхий мэдээллүүдээс гадна ж-нь: статистикийн мэдээ, суурь мэдээллүүдийг танилцах судалгаа хийж батталгаажуулах эсвэл оршин суугчидтай уулзаж шалгах шаардлагатай (ж-нь: газрын гадаргын ус ба худаг ашиглалтын хэлбэрийг тодруулахад талбайн оршин суугчдаас асууж шалгах).

Болзошгүй эрсдэлийн хувьд бохирдолтой талбайд амьдрах иргэдийн тоо, хүн амын бүтэц, үйл ажиллагааны төрөл зэргийг дурдана (оршин суугчид, ажиллагсад, амарч зугаалахаар ирсэн хүмүүс гм). Бохирдолтой талбай тус бүрийн ойролцоох барилга байгууламжын бохирдолын нөлөөлөлд хамаарагдах иргэдийн ойролцоо тоо, насны ангилал, тэдгээрийн талбайд байгаа зорилго зэрэг мэдээллийг оруулна.

1.1.4 Өмчийн эрхийн харилцааны асуудал

Талбай болон ойролцоох хамааралтай талбайн газар өмчлөгч болон ашиглагч хувь хүн, аж ахуйн нэгжийн жагсаалт байх шаардлагатай. Хавсралтанд кадастрын зураг зайлшгүй хавсаргана. Олон тооны (хэдэн арав болон түүнээс олон) эзэмшигч, ашиглагчтай томоохон хэмжээний талбайн хувьд нэрсийн жагсаалтыг гаргахгүй ба өмчлөлийн асуудлыг санал болгосон арга хэмжээний хүрээнд багтаана.

1.2 Талбайн байгалийн нөхцөл

Энэ бүлгийн зорилго нь талбайг орон нутгийн нөхцөл байдалтай холбож тодорхойлоход оршино (1 : 50 000 масштабын газрын зургийн мэдээллийн хэмжээнд). Бүс нутгийн талаарх товч мэдээлэл, талбай болон түүний ойролцоох талбайн мэдээллийг оруулах ба боломжтой бол үр дүнгийн тайлангийн хавсралтанд график зургууд хавсаргана.

Байгалийн нөхцлийг тодорхойлохдоо сүүлийн үеийн шинэ мэдээлэл ашиглах мөн эрсдэлийн шинжилгээний төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын мэдээллийг илүү анхаарах шаардлагатай. Эрсдэлийн шинжилгээний үед ашиглах мэдээлэлтэй адил мэдээллийг оруулах шаардлагатай – хийгдэх судалгааны ажлын хэмжээг тодорхойлоход, тэдгээрийн ажлыын үр дүнг дүгнэхэд, нөлөөллийн хувилбарыг дүгнэхэд.

1.2.1 Геоморфологи ба цаг уурын нөхцөл

Дараах мэдээллүүд нь нөлөөллийн хувилбарыг дүгнэхэд зайлшгүй шаардлгатай – нөлөөллийн параметрүүдыг тодорхойлоход цаг уурын бодит нөхцлийг харгалзан үзнэ. Энэ бүлэгт дараах мэдээллүүд багтана. Үүнд:

- Талбайн налуу болон далайн түвшингийн өндөр, хүний ажиллагааны дүнд өөрчлөгдөх талбайн гадаргуун хэлбэрийн өөрчлөлт (овоолго, хог хаягдолын цэг, ховил, уурхайн хонгил, уурхай гм.); бохирдолтой талбайн байрзүйн газрын зургийг хавсралтанд оруулбал зохистой.
- Сарын болон жилийн дундаж хур тунадасны хэмжээний мэдээллийг талбайн морфологитой адил орчинд байрлах ойролцоох хур тунадас хэмжилтийн газраас авна.
- Бодит агаарын температур, цасны хэмжээ, ууршилт зэрэг мэдээллийг эдгээр хүчин зүйлүүдээс хамааран бохирдол тархах хувилбаруудыг боловсруулахад ашиглана (агаар бохирдох, бохирдолтой хөрстэй харьцах, хөрсөнд нэвчих гм).
- Агаараар бохирдол тархах зам мөн хөрс, агаар, усны бохирдлын хоёрдогч шалтгааныг тодруулах үед салхины хурдыг үзүүлсэн хүснэгт эсвэл салхины чиглэлийн диаграммыг ашиглана.

Геоморфологи болон цаг уурын ерөнхий мэдээллийг мэргэжлийн хэвлэл болон ус цаг уурын хүрээлэнгээс авна.

1.2.2 Геологийн тогтоц

Геологийн тогтоцын талаарх товч мэдээлэл нь региональ геологийн мэдээллээс гадна дараах зүйлүүдийг багтаана. Үүнд:

- Бохирдолтой өртсөн болон бохирдол тархах боломжтой ойролцоох талбайн чулуулгийн тодорхойлолт.
- Хүний үйл ажиллагаанаас үүссэн хог, овоолгийн төрлийн ангилалыг бохирдол бохирдол хялбар тархах хийсвэр замыг харгалзан тодорхойлох.
- Тектоникийн нөхцөл байдал (хагарлын бүс болон бохирдол тархах байгалийн замын тодорхойлолт).

1.2.3 Гидрогеологийн нөхцөл

Геологийн нөхцөл байдлын тодорхойлолтын адил байх ба талбайн эрсдэлийн үнэлгээний анализтай холбоотой анхан шатны дараах мэдээллүүдийг дурдана. Үүнд:

- Бүс нутгийн газрын гүний ус агуулагч бүрдэлийн талаарх мэдээлэл.
- Бохирдолд өртөж болзошгүй гадаргуун усны эх үүсвэрүүдийн товч мэдээлэл (төрөл, тур, гүний усны түвшин ба түүний өөрчлөлт, ус агуулагч бүрдэлийн зузаан тэдгээрий хоорондын холбоо, ус нэвчих талбай, гидравлик градиент ба урсацын чиглэл, шүүрэлтийн ба дамжуулах коэффициент ба урсгалын ойролцоо ба бодит утга, ус зайлуулах талбай, газрын гадаргын ба гүний усны хоорондын холбоо).
- Бохирдолын шинж чанараас хамааран ус түвшингээс халих, тусгаарлагчыг нэвтлэх, тектоник болон бусад хагарал, уурхай, цооног, хүний үйл ажиллагаа зэргийн нөлөөг дүгнэх.
- Газрын гүний усны одоогийн болон болзошгүй хэрэглээний шинж- гүний худаг, томоохон булаг шанд, минерал усны эх үүсвэр байгаа эсэх.

10.2.4 *Гидрологийн нөхцөл*

Гидрогеологийн нөхлийг тодорхойлоход ойролцоох урсгал ба тогтмол усны эх үүсвэрийг дурдах ба бохирдолтой ус тархах боломжыг харгалзан үзэх (хурын ус болон газрын гүний усаар тархах) буюу ус нэвчихэд хэрхэн нөлөөлөхийг тооцно. Энэхүү тодорхойлолт нь геоморфологийн тодорхойлолттой нарийн хамааралтай ба учир нь хялбар нөхцөлд гидрологи ба геоморфологийн тодорхололтыг хооронд нь холбож ашиглах боломжтой байдаг.

Бохирдол голын ус болон бусад усны эх үүсвэрт дамжин тархах үед тэдгээрийн үндсэн тодорхойлолтыг дурдах шаардлагатай (усны эх үүсвэрийн ач холбогдол, урсгалын дундаж хэмжээ, урсгалын баталгаатай доод хэмжээ, усны талбай). Үүссэн бохирдолыг шийдвэрлэх асуудалтай холбогдуулан ус зайлуулах, нэвчихэд нөлөөлөх бусад шинж чанарын талаар зайлшгүй дурдах шаардлагатай (голын боргио байгаа эсэх, усны голдрилын гадаргын ба гүний түвшин, голын ёроолын бохирдол, олон жилийн урсгал, үерийн бүс, үерийн аюулын давтагдах хугацаа).

Шаардлагатай мэдээллүүдийг ус цаг уурын хүрээлэн, гидрогеолгоийн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаас авна. Болзошгүй бохирдолд өртөх боломжтой багахан гол горхийн хувьд газар дээр нь шууд хэмжилт хийж урсгалын хэмжээг тогтооно.

1.2.5 Талбайн геохими ба гидрохимийн мэдээллүүд

Гидрохимийн тодорхойлолтын хүрээнд гидрогеологийн дэд системүүдтэй харьцах хамаарлыг дүгнэх ба газрын гүний усны байгалийн химийн шинж (физик химийн үндсэн анализ) эсвэл тэдгээрийн бохирдолын талаар дурдана.

Бохирдолтой талбайн судалгааны үед хүний үйлдлээр ихээхэн бохирдсон тохиолдолд геохимийн үндсэн судалгааны үр дүнгийн мэдээллийг дараагийн 2.1 бүлэгт багтаана.

Газрын гадаргын болон гүний усны бохирдолын эрсдэлийн дүгнэлт гаргахад хүчинтэй норм, журмын дагуу чанарын шаардлага хангах эсэхийг дурдах ба цаг уурын хүрээлэн, гол

горхи, тогтмол ус зэрэг усны эх үүсвэрийн ашиглалтыг хариуцах байгууллагаас мэдээлэл авна.

Бохирдол тархах үед хөрс органик бодисоор хэмээн үзвэл ялангуяа литологийн төрлийн дагуу органик нүүрстөрөгчийг нэрлэх ба шаврын минералын найрлагыг бичнэ. Органик бус бохирдуулагч болон хөрсөнд явагдах химийн урвалын үед хөрсний химийн бүтцийг параметрийг дурдана.

Хог хаягдлын цэг, овоолго, далан болон бусад хүний үйлдлээс гаралтай хогтой хамааралтай эрсдэлийн үнэлгээний үед хогийн төрлийг ойролцоогоор урьдчилан тогтоох (олон төрлийн холимог хогийн химийн найрлага: олборлолтын хаягдал хөрсний далангийн төмрийн агуулга ихэссэн байх гм).

Энэхүү бүлэгт олдож байгаа мэдээллийн байдлыг дүгнэснээр эрсдэлийн үнэлгээний судалгааны ажлын үед тодорхой бус байдлыг тодруулах шалтгааны нэг болно.

2. Судалгааны ажлууд

2.1 Талбайн судлагдсан байдал

Талбайн судлагдсан байдлын түвшинг тодорхойлохдоо өмнө болон шинээр хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнг харгалзан үздэг.

Дүгнэлтэнд ашиглах архивын мэдээллүүдийг тухайн талбайн эзэн эсвэл ашиглалтыг хариуцдаг байгууллагаас авах шаардлагатай. Мөн талбайн мэдээллийг бохирдолтой газруудын мэдээллийн сан болон төрийн захиргааны байгууллагуудаас авна. Судалгааны ажил эхлэхээс өмнө архивын мэдээллийг хянахын тулд хээрийн судалгааны ажлыг зайлшгүй хийх шаардлагатай. Тухайн орон нутагт удаан оршин сууж буй иргэд бохирдолын талаарх мэдээллийн чухал эх сурвалж болдог. Талбайн судлагдсан байдлын түвшинг тодорхойлоход зөвхөн бодит мөн шаардлагатай чухал мэдээлэлд тулгуурлах хэрэгтэй. Хуучин хийгдсэн ажлуудын үр дүнг талбайн бохирдолын эрсдэлийн үнэлгээний одоогийн ажлын явцтай харьцуулалт хийх шаардлагатай (ж-нь: анхан шатны мэдээллүүдийг бусад мэдээлэлтэй харьцуулах, бүрдүүлсэн мэдээллийг хүчинтэй мөрдөгдөж буй журамд заагдсан хязгаартай харьцуулах).

2.1.1 Талбайд өмнө хийгдсэн судалгааны ба цэвэрлэх ажлын үр дүн

Энэхүү бүлэгт өмнө хийгдсэн ажлуудын үр дүн, талбайн одоогийн байдлын дүгнэлт, цаашдын болзошгүй өөрчлөлтийн таамаглал зэрэг мэдээллүүд багтана. Олдож байгаа мэдээллүүд нь шаардлага хангах мөн эрх зүйн шалгуур үзүүлэлттэй тохирох эсэхийг харьцуулах шаардлагатай. Архивын мэдээллийг ашиглах боломжтой эсэх мөн шинээр хийгдэх ажлын саналд тавигдах нэмэлт шаардлага зэргийг мэдээллийн тоймд оруулна. Бүлэгт дараах мэдээлэл байна. Үүнд:

- Өнөөг хүртэл хийгдсэн судалгааны ба цэвэрлэх ажлын он цагийн тойм (хэрэгжүүлэгч буюу гүйцэтгэгч байгууллага, захиалагч, ажил хэрэгжүүлэх шаардлага, хийгдэх ажлын хэмжээ, үргэлжлэх хугацаа, чухал дүгнэлтүүд гм) ба ажлын үр дүнгийн уялдаа холбоо, ач холбогдлыг дүгнэх, танилцуулах.
- Бохирдолтой талбай болон түүний орчимд хамааралтай төрийн захиргааны байгууллагын хүчинтэй тушаал, шийдвэрүүд.
- Ажлын одоогийн гүйцэтгэл (төрийн захиргааны байгууллагын тушаалын

биелэлтийн дагуух), хээрийн судалгааны ажлын үр дүн.

2.1.2 Бохирдолын эх үүсвэрийн тойм

Энэхүү бүлэг нь бохирдолын концепт загвар боловсруулах болон нэн тэргүүнд анхаарах бохирдуулагч бодисуудыг тодорхойлоход үндсэн ач холбогдолтой учир бохирдолтой талбай ба түүний орчмын бохирдолын болзошгүй эх үүсвэрийн түүх, түүний байршил зэргийг тогтооно. Мөн үйлдвэрлэлийн ажиллагаатай холбоотой чухал тодорхой бус байдлыг ба хортой бодис агуулсан бохирдолын болзошгүй байдлын талаар дурдах шаардлагатай. Бүлэгт дараах мэдээлэл багтана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх бохирдуулагч бодистой хамааралтай талбайн ашиглалтын түүхийн талаарх мэдээлэл.
- Ажиглалт хийх талбайн бохирдуулагч эх үүсвэрийн тойм мэдээлэл – бохирдуулагчын эх үүсвэрийн байршил, орчинд нөлөөлсөн хугацаа, бохирдуулагч бодисууд буюу ялангуяа усны орчинд аюул учруулж болзошгүй бохирдуулагч бодисуудын нийт тойм.
- Ажиглалтанд нөлөөлөх талбайгаас нэлээд зайдуу газрын бохирдолын болзошгүй эх талаарх олдох боломжтой мэдээлэл.

2.1.3 Анхаарах бодисыг тодорхойлох ба эрсдэлийн бусад хүчин зүйлүүд

Энэхүү бүлэгт талбайн ашиглалтын түүх болон бохирдолын талаархи мэдээллүүдийг үндэслэн нэн тэргүүнд анхаарах бодисуудыг тодорхойлох ба өмнөх бүлгийн шууд үргэлжлэл болно. Хууль эрх шалгуур үзүүлэлтийн хэмжээнээс (усны нөөцийн менежментийн байгууллагаас тогтоосон бөгөөд хүчинтэй гаргасан хязгаарлалтууд) илүү гарах тохиолдлыг анхны шалгуур үзүүлэлт болгох ба концентрацийн үндэслэлтэй хэмжээтэй харьцуулсан харьцааг ашиглана. Талбайн дүгнэлт гаргахад ямар ч тохиолдолд дан бодисууд мөн холимог бодисуудын ерөнхий жагсаалтыг бодит байдалтай холбоогүйгээр ашиглаж болохгүй. Энэ бүлэгт:

- Анхаарал хандуулах хортой бодисуудын жагсаалт ба тэдгээрийн физик-химийн үндсэн шинж чанар (дэлгэрэнгүй тайлбарыг хавсралтанд хавсаргах). Бодис тус бүрийн талаархи мэдээллийг аюулгүй байдлын хүснэгтээс эсвэл тохирох мэдээллийн сангаас авна (хавсралт 6-г үзэх). Тархалтын замын тоог тодорхойлох мөн тодорхой бус байдлын тооцооны дүгнэлт хийхэд уялдаа холбоотой олон төрлийн мэдээллийн сангийн параметрүүдтэй харьцуулах хэрэгтэй. Тооцоог хийхдээ физик-химийн шинж чанарын хязгаарыг авч үзэх шаардлагатай.
- Химийн бодисын нөлөөнөөс бусад талбайн бохирдолд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийн жагсаалт (ж-нь: хог хаягдлын цэгийн тогтвортой байдал, тоосжилт, бохирдолоос хамаарах элэгдэл, микробын бохирдол) эсвэл бохирдол тархах шинэ замыг үүсгэх байгалийн ердийн хүчин зүйлүүд (хөрсний нуралт, уурхайн усан бууны ажиллагаанас үүдсэн урсгалын чиглэлийн өөрчлөлт гм).

2.1.4 Концептын урьдчилсан загвар

Концептын урьдчилсан загвар нь эрсдлийн үнэлгээ ба судалгааны ажил хэрэгжүүлэх төслийн салшгүй хэсэг болно. Талбайн ашиглалтын байдлыг дүгнэлт, бохирдолтой

таалаархи мэдээлэл, нөлөөлөл тархах болзошгүй замын дүгнэлт зэрэг зайлшгүй шаардагдах мэдээллүүдийг ашиглаж загварыг боловсруулна.

Бохирдолтой талбайн концептын урьдчилсан загвар дараах мэдээллүүдийг багтаана. Үүнд:

- талбайн нөхцөл:
  - ялангуяа геологийн, гидрогеологийн, гидрологийн ба геохимийн шинж;
  - байгалийн нөхцөл байдал;
- бохирдолын бүх эх үүсвэрүүд ба голомтууд:
  - бохирдолын голомтуудын жагсаалт (усны, хөрсний, хурдасны, барилгын конструкцийн, хог хаягдлын цэгийн, овоолгын, хаягдлын далангийн, хаягдлын усан сан);
  - хортой бодис алдагдсанаас хүрээлэн байгаа орчинд үүсэх технологийн гаралтай бохирдлын жагсаалт;
  - хоруу чанарыг үндэслэн гаргасан хортой бодисуудын үндсэн шинж ба байгаль орчин дахь харилцаа, бохирдол байгалийн жамаар сэргэх үйл явц;
- тархалтын бодит зам:
  - бохирдлын эх үүсвэр буюу голомтоос бохирдуулагч бодис болон түүнтэй адил шинж чанартай бодис тархах замын тодорхойлолт;
- эрсдэл хүлээн авагчид:
  - талбайн одоогийн болон ирээдүйн ашиглалт;
  - оршин суугчдын жагсаалт, бохирдуулагч бодисуудын нөлөөллийн боломжтой хувилбар;

  эрсдэлийн хүчин зүйлүүд:
  - байгаль орчин, экосистем, хамгаалагдсан төрөл зүйлийн амьдрах орчны жагсаалт;
  - усны эх үүсвэр, гадаргын урсгал ус, тогтмол ус, байгалийн эмчилгээний рашаан ус ба бохирдолын нөлөөллийн хүрээнд өртөх боломжтой хамгаалалтын бүс.

Концептын урьдчилсан загвараар нөлөөлөл тархах болзошгүй буюу бохирдуулагчын эх үүсвэрээс эрсдлийг хүлээн авагчид хүртэлх замыг тодорхойлдог:

Өртөлт тархах зам = бохирдуулагч эх үүсвэр + тархах зам + эрсдэл хүлээн авагчын өртөлтийн хувилбар

Концептын урьдчилсан загвараар нөлөөлөл тархах болзошгүй замыг (бохирдолын эх үүсвэрээс хүлээн авагчид хүрэх бодит зам) тодорхойлох ба нөлөөлөл тархах зам тус бүрийн хувьд эрсдлийн үнэлгээ хйихэд мэдээлэл хангалттай эсэхийг дүгнэх ба тоон үзүүлэлтүүд илүү чухалчилж үздэг. Эрсдлийн анализын ажлын төсөлд дутуу байгаа мэдээллийг бүрдүүлэх судалгааны ажлын саналыг боловсруулна. Концептын загварчлал нь төсөл боловсруулах, судалгаа хийх, дээж авах ажлын хэмжээг тодорхойлох үндсэн баримт болох эдгээр ажлууд нь ихэвчлэн олон үе шатаар мэргэжлийн аргачлалын дагуу явагдана.

Нөлөөлөл тархах зам тус бүрийг дэс дугаарлаж, шинж чанарыг товч тодорхойлно (ойлгомжтой хүснэгтийн хэлбэрээр). Тус дугаарыг дамжих зам болон нөлөөллийн хувилбарыг дүгнэхэд ашиглана. Нөлөөлөл тархах замын чигийг харуулсан баримжаа

зураг схемийг (газрын зураг, зүсэлт) концептын загварт хавсралтаар оруулбал илүү үр дүнтэй. Концептын загвар боловсруулах жишээг хавсралт №5-д үзүүлэв.

Концептын урьдчилсан загвар нь сайн боловсруулсан эрсдлийн анализын үндэс байх ба төсөл боловсруулах ажлын явцад хийгдэх шаардлагатай. Эдгээр шалтгаанаас хамааран асуудалтай, олон нийтийн анхаарал татсан (их хэмжээний талбайтай, олон тооны бохирдлын голомт бүхий талбай) төслийн хувьд судалгааны ажлын санал бүхий концептын загварыг эрсдэлийн үнэлгээний анализ хийдэг бие даасан мэргэжилтнээр дүгнэлт хийлгэх шаардлагатай.

Эрсдлийн анализын дараагийн үе шатуудад концептын урьдчилсан загварт шинээр тогтоосон баримтууд ба судалгааны үр дүнг нэмж оруулна.

2.2 Хийгдэж буй судалгааны ажлууд

Эрсдлийн үнэлгээний ажлын үндсэн мэдээлэл болох учир энэхүү бүлэг нь тайлангийн хамгийн чухал хэсэгт багтана. Одоо хэрэгжиж буй судалгааны ажлууд нь хуучин мэдээллүүдийн дүгнэлтэнд зайлшгүй үндэслэх ба үе шаттайгаар төлөвлөх (бохирдолтой талбайн судалгааны мэргэжлийн аргачлалын дагуу) нөхцөлтэйгээр хийгдэнэ. Мөн байгаа мэдээлэл болон концептын урьдчилсан загварыг үндэслэн шаардлагатай үед судалгааны ажлын шаардлага, хэмжээ, аргачлал, зэргийг үндэслэлтэй болохыг хамгаалах хэрэгтэй тохиодол гарна.

2.2.1 Судалгаа шинжилгээний ажлын хэмжээ ба аргачлал

Судалгааны ажлын төслийг боловсруулахад инвазив ба инвазив бус аргачлалыг хослуулан ашиглана. Талбайн шинж чанар болон тодорхойлогдсон шаардлагын дагуу хайгуулын өрөмдлөгөөс (геологи, гидрогеологи эсвэл инженер-геологийн) өмнө геофизикийн хэмжилт, гадаргуун болон гүний усны эх үүсвэрээс дээж авах (ж-нь: худгаас), гүехэн тандалт хийх. Өрөмдлөгийн ажлын дараа гидродинамикын шахалт, усны түвшингийн ба цооногийн хэмжилт, байгалийн жамаар сэргэх явцыг дүгнэх мөн бусад шаардлагатай тохиолдолд хяналтын ажлууд явагдана. Эдгээр ажилтай зэрэгцээ барилга байгууламжуудын хэмжилт, судалгааны ажил хийгдэх ба тодорхой техникийн хязгаарлалтаас шалтгаалан хэмжилтийг хийлгүйгээр байгаа мэдээлэл, өгөгдлийг ашиглаж болно.

Тайлбаад химийн шинжилгээ, судалгаа болон бусад мэргэжлийн ажлыг явуулахдаа өмнө цуглуулсан мэдээлэл, талбайтай танилцах хээрийн судалгааны үр дүнг харгалзах ба эдгээр ажлын дүнг дараагийн үе шатны ажлуудад болон эрсдлийн үнэлгээний анализ хийхэд ашиглана.

Эрсдлийн үнэлгээний анализ хийхэд байгаль орчинд хортой нөлөөлөх бодис ба тэдгээрийн нийлмэл бодист анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай. Олон улсын хэмжээнд агшиглагддаг мэдээллийн сангийн хортой бодисуудын шинж чанарыг буюу ялангуяа хүний биед хавдар үүсэхэд нөлөөлөх тодорхойлолтыг ашиглах боломжтой.

Хэрэв судалгааны ажлын цар хүрээ их байвал судалгаа шинжилгээний ажлын үр дүнгийн тайланг бие даасан хавсралтын хэлбэрээр оруулна. Эрсдлийн үнэлгээний ажлын үр дүнгийн тайланд судалгаа болон дээж авалтын ажил хийгдэх үндэслэлийг тодорхойлох ба хийгдсэн ажлуулын талаар товч дурдана. Ажлын цар хүрээ нь шинжилгээний ажлын В ангилалд буюу - дэлгэрэнгүй судалгаанд хамаарна (Бохирдолтой талбайд судалгаа явуулах аргачлал ба Дээж авах, цэвэрлэх, нөхөн

сэргээх геологийн ажлын мэргэжлийн аргачлал цэвэршүүлэх геологийн ажлууд). Үүнээс доод түвшингийн судалгааны ажлыг дүнг эрсдлийн үнэлгээний урьдчилсан ажилд ашиглана.

Бие даасан тайлан бичих шаардлагагүй тохиолдолд энэ бүлэгт дараах мэдээллүүд байна. Үүнд:

- сонгосон аргууд, ханаагүй бүсэд хийгдэх судалгааны цар хүрээ ба судалгаа хийх талбайг сонгох зэргийг талбайн талаархи одоогийн мэдээлэлтэй холбох (геофизикийн хэмжилт, атомын геохими, өрөмдлөгийн ажил, хөрсний, барилгын гаралтай бодисын дээж авалт, лабораторийн шинжилгээний ажлын хэмжээ гм).
- сонгосон аргууд, ханасан бүсэд хийгдэх судалгааны цар хүрээ ба судалгаа хийх талбайг сонгох зэргийг талбайн талаархи одоогийн мэдээлэлтэй холбох (усны эх үүсвэрээс дээж авах, геофизикийн хэмжилт хийх, өрөмдлөгийн ажил – шинээр объект барих, дээж авах, усны түвшин хэмжих, лабораторийн анализын ажлын хэмжээг тогтоох, аливаа усны эх үүсвэр бохирдлын сөрөг нөлөөнд өртөхгүй байх арга хэмжээ).
- сонгосон аргачлал, талбай дахь хаягдал усны байршил зэргийг талбайн талаархи одоогийн мэдээлэлтэй харьцуулах (гадаргын ус болон тунамал хурдаснаас дээж авах, голын голидролын усны түвшингийн хэмжилт, усны урсацыг хэмжих, лабораторийн анализын ажлын хэмжээ гм).
- Шинжилгээ судалгааны ажилд ашигласан аргачлалын товч тайлбар (дээжтэй ажиллах заавар).
- Мэргэжлийн судалгааны ажлын хэмжээ (ж-нь: газар хэмжилтийн ажил, туршилтын агаар соролт, хяналтын дээж, цооногийн болон бусад геофизикийн хэмжилт, жийргэвчийн битүүмжлэлийг хянах, инженер-геологийн судалгаа, мэргэжлийн хээрийн судалгаа гм).
- Ашигласан статистикийн мэдээлэл, мэдээлэл боловсруулах арга, тодорхой бус байдал тодорхойлох ажлын хүрээнд цуглуулсан мэдээллийн хэмжээ тухайн ажлыг биелүүлэхэд хангалттай эсэх.
- Хууль эрх зүйн шалгуурт тавигдах шаардлагыг бүхий чанарын удирдлагын аргачлал (судалгаанд шаардагдах зөвшөөрөл, мэдэгдэх, бүртгүүлэх үүрэг, хог хаягдал болон устай хэрхэн харьцаж ажиллах, анхдагч баримт материалуудтай ажиллахад ашиглах холбоосуудын талаарх мэдээлэл).

2.2.2 Судалгааны ажлын үр дүн

Бохирдуулагчын концентраци болон хэмжилтийн үр дүнг хууль эрх зүйн шалгуур болон байгалийн суурь үзүүлэлттэй харьцуулах. Шаардлагатай тохиолдолд бусад харьцуулах аргыг ашиглах ба эдгээр харьцуулалтын үр дүнг хавсралтанд хүснэгт хэлбэрээр оруулах (газрын зурагт).

Үр дүнг хүснэгтээс гадна график, газрын зураг болон схем хэлбэрээр боловсруулна. Мөн холбогдох статистикийн мэдээллийг ашиглана. Энэхүү бүлэгт:

- Талбайн байгалийн нөхцлийг, судалгааны үр дүнг тоон болон чанарын хувьд тодорхойлох (техникийн хэмжилтийн дүнг, in-situ хэмжилт), шинжилгээний дүнг тодорхойлогдсон шалгуур – суурь үзүүлэлттэй харьцуулах (ж-нь: бохирдолтой

талбайн ойролцоох хөрсний болон усны бохирдуулагчын концентраци), хүчин төгөлдөр журам, зааврын зайлшгүй мөрдөх болон бусад холбогдох шалгуур үзүүлэлттэй харьцуулах, хавсралтыг ашиглах холбоосыг заах (хүснэгт,график, газрын зураг, техникийн мэдээ, протокол гм).

- Босго үзүүлэлтээс хамааран өөрчлөгдөх изогипс газрын зургийн тайлбарт нэмж оруулах шаардлагатай гидрогеологийн нөхцөлийг тодорхойлох (гадаргын болон гүний усны түвшин, уст давхаргын зузаан, голын голидрол дахь усны түвшин, ус үл нэвтрүүлэх хил хязгаар, дренажын систем (drainage base) болзошгүй тархалтын зам болох инженерийн шугам, ус нэвчих, шавхах үйл ажиллагааны талбайд үзүүлэх нөлөө гм), шийдэх асуудалд хүлцэх хэмжээний нөлөө үзүүлэх хэмжээнд, хамгийн олон тооны хэмжилтийн цэгийг ашигласан.
- Талбайд LNAPL, DNAPL - үед нотлогдсон эсвэл урьдчилан таамагласан бохирдуулагчыг тодорхойлоход илүү анхаарсан бохирдлын гадаргуун болон орон зайн хязгаарлалт; хавсралтын хэсэгтэй холбогдох холбоосыг зайлшгүй дурдана (ялангуяа тайлбар зураг, зүсэлт, схем).
- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн тус бүрийн бохирдлын баримжаа баланс.
- Судалгааны үр дүнг концептын урьдчилсан загвар, хуучин хийгдсэн судалгааны дүн, үргэлжлэх хугацааны дүгнэлт зэрэгтэй харьцуулах.
- Хавсралтанд багтсан мэдээллийн холбоос бүхий цуглуулсан бусад мэдээллийн дүгнэлт.

2.2.3 Бохирдлын цар хүрээний гадаргын болон орон зайн дүгнэлт

Дүгнэлтийг бичгийн болон график хэлбэрээр боловсруулна (зориулалтын газрын зураг ба үр дүнгийн хойлсон тайлбар схем гм). ханаагүй бүсийн бохирдлын голомтын хил хязгаарыг тодорхойлох, ханасан бүс болон гадаргын усанд – бохирлын шинж чанарын хувьд тодорхойлох. Бичгийн хэсэгт дараах мэдээлэл агуулагдана. Үүнд:

- Бохирдуулагч бодисыг ялгаж тодорхойлсон, бохирдлын хэмжээтэй (түүний тархалт) холбогдох хамгийн чухал мэдээллүүдийн дүгнэлт. Болзошгүй нөлөөллийн нөхцөлд бохирдлын голомт дахь байдал ба талбайн захын цэгийн байдлыг ялгаатай авч үзэх шаардлагатай.
- Хууль эрх зүйн шалгуур зайлшгүй мөрдөх шалгуур үзүүлэлт болон усны ашиглалт хариуцсан байгууллагын заавар журамд заасан үзүүлэлтийн хэмжээнээс илүү гарсан ба зөрчилтэй нөхцөл байдлын шинж чанарын тодорхойлолт (ж-нь: газрын гүний усны гадаргууд болон газрын тос илэрсэн).

2.2.4 Бохирдол тархалтын үнэлгээ

Энэ шатны судалгааны болон эрсдлийн үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд талбайн судалгааны ажлын бүрэн гүйцэтгэгдсэн үр дүн бэлэн байх шаардлагатай ба бохирдлын тархалтын хувьд ойлгомжгүй асуудал гарах үед нэмэлт буюу бусад ажлыг хийх шаардлагатай.

Бохирдлын тархалтын дүгнэлт гаргах нь чухал шаардлагатай, нэлээд хүндрэлтэй байдаг учраас мэргэжлийн байгууллагын ажил туршлага гүйцэтгэх үүрэгтэй байдаг. Концептын тодорхойлолт нь талбайн геологийн нөхцөл байдал, тархах байдал, бохирдлын шинж чанар зэргээс шалтгаална. Доор дурдсан дэд сэдвүүдэд хуваагдана. Тасралтгүй үргэлжлэх тархалтын замыг шаардлагагүйгээр салаалахгүйн тулд зөв ангилах шаардлагатай. Уусах бохирдуулагчын болон бие даасан шингэн фазын үед хязгаарлагдмал уусдаг бохирдуулагчын тархалтыг тусад нь судлах зайлшгүй шаардлагатай.

Бохирдол тархалтын замын үнэлгээний ажлын зорилго нь хүлээн авагчын тухайн геологийн орчинд өртөх боломжтой бохирдуулагч бодисын тоо хэмжээг тогтоосноор бохирдол дамжих замыг хаах боломж олгоход оршино. Тодорхой байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн урьдчилан таамагласан өртөлтийн бохирдуулагч бодисын тухайн үеийн концентраци нь шаардагдах үр дүнд багтах ба эдгээрийг өртөлтийн хувилбарын үнэлгээ хийхэд ашиглана.

Бохирдол тархах, дамжих замын тоон дүгнэлтийг судалгааны хуучин болон шинэ ажлын үр дүнг үндэслэн гаргадаг. Тархалтын замын тоог гаргахдаа тооцооны хялбар аргыг ашиглах болон математик загварчлалын 3-D загварыг ашиглана. Тэдгээрийг хэрхэн ашиглах нь шийдвэрлэж буй асуудлын хүнд хөнгөнөөс хамаарах учир ерөнхий тодорхойлох боломжгүй.

Математик загварчлалыг ашиглахдаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж зөвлөгөө авах ба интернетийн дараах хуудсыг ашиглаж болно (ж-нь: http://water.usgs.gov/software/, http://www.scisoftware.com/).

Бохирдолтой манангийн шугаман удаашрал мөн гүний усанд (гидродинамикийн хэлбэлзлийн нөлөөг тооцохгүй) органик бохирдуулагч тархах хурдыг тооцоход дараах тэгшитгэлийг ашиглана:

Удаашруулах хүчин зүйлийн тооцоо:

$$R = 1 + \rho_b \; x \; n^{-1} \; x \; K_d$$

R *удаашруулах хүчин зүйл (хэмжих нэгжгүй)*
ρ_b *хөрсний эзэлхүүн жин (г.см-^{3})*
n *сүвэрхэг байдал (%)*
K_d *хуваарилах коэффициент (см^3.г$^{-1}$)*

Хуваарилах коэффициентын хувьд:

$$K_d = K_{OC} \; x \; f_{OC}$$

K_d *хуваарилах коэффициент (см^3.г$^{-1}$)*
K_{oc} *ус- органик нүүрстөрөгчийн хуваах коэффициент (см^3.г$^{-1}$)*
f_{oc} *хөрсөнд органик нүүрстөрөгчийн эзлэх хувь (%)*

Гүний усны урсацын хурдыг Дарсигийн хуулиар тодорхойлно:

$$v = -k \times I$$

$$v = v / n_e$$

v *гүний усны урсацын шүүлтийн хурд (м.сек$^{-1}$)*
k *шүүлтийн коэффициент (м.сек$^{-1}$)*
I *гидравлик градиент (хэмжих нэгжгүй)*
n_e *efektivní pórovitost (%)*

Нэн тэргүүнд анхаарах бохирдуулагчын тархалтын хурд:

$$v_r = v_s / R$$

v_r *гүний усанд бохирдуулагч тархах хурд (м.сек$^{-1}$)*
v_s *гүний усны урсацын бодит хурд (м.сек$^{-1}$)*
R *удаашруулах хүчин зүйл (хэмжих нэгжгүй)*

Hodnocení transportních cest je potřebné zakončit také posouzením procesů přirozené atenuace, zejména ve vztahu k hodnocení rizik a následným návrhům nápravných opatření.

2.2.4.1 Ханаагүй бүсэд бохирдол тархах

Энэхүү бүлэгт нотлогдсон ба боломжит бохирдлын нийт эх үүсвэр ба голомтын ялангуяа шууд нөлөөллийн эх үүсвэр эсвэл ханасан бүсийн талаархи судалгааны баримтуудыг бүрдүүлнэ. Бохирдлын голомтууд ялангуяа хөрсний, барилга байгууламжын конструкцын (хаягдлын шинж чанар) бохирдол дамжих хялбар замын тэмдэглэгээг газрын зурагт зайлшгүй тэмдэглэнэ. Энэ бүлэгт зайлшгүй багтах мэдээлэл:

- Ханаагүй бүсийн шинж чанар (хатуу ба хатуу бус гадаргуу, давхаргын бүтэц, давхаргын зузаан) а ханаагүй бүсийн бохирдол тархалтыг дүгнэхэд чухал үүрэгтэй параметрүүдийн тодорхойлолт (,чийгшилт, ус, агаар нэвтрүүлэх чадвар).
- Бохирдол дамжих замын үүрэг гүйцэтгэх инженерийн шугам, газрын доорхи байгууламжын тодорхойлолт (ж-нь: газрын доорхи дамжуулах хоолойнууд, кабель утасны суваг шуудуу, барилга байгууламжын суурь гм).
- Бохирдол цаашид тархах баримжаалсан тооцоо (ханаагүй бүсэд, агаарт, хүн ам оршин суух газарт, газрын гадаргын ба гүний усаар).

2.2.4.2 Ханасан бүсэд бохирдол тархах

Энэхүү бүлгийн ажилд гидрогеологийн судалгаа, геофизикийн хэмжилтийн ажлын үр үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Гидродинамикын туршилт, усны түвшин хэмжилт, бохирдол тархах замд байрлах усны эх үүсвэрийн цэгийн (өрөмдлөг, зонд, худаг гм) усны химийн шинжилгээний дүн зэргийг үндэслэн бохирдол тархах бодит замыг бохирдолтой манантай талбайн (талбайн голомт болон түүний захын цэгт) хэмжээнд зайлшгүй тодорхойлох шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд бохирдол тархах чиглэл, хурд

зэргийг тодорхойлохын тулд сонгосон өрөмдлөгийн цооногт хэмжилт хийх, цэнэгтэй биетийн, гидродинмамикын параметрийн хэмжилт хийнэ. Гадаргуу дээрх уусдаггүй бохирдуулагчид онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Энэхүү бүлэгт дараах мэдээллүүд багтана:

- Уст давхаргын ба ханасан бүсийн бохирдол тархалтыг дүгнэхэд шаардагдах параметрүүдийн тодорхойлолт (шүүрэлтийн коэффициент, сүвэрхэг байдал, дамжуулах чанар, тархалт).
- Шингэн хэлбэрт шилжих бодис эй эсвэл уусдаг бохирдуулагчын тодорхойлолт (усны гадаргууд эсвэл ус нэвтрүүлэх сэвсгэр чулуулгийн), тогтвортой буюу хөдөлгөөнтэй байдлын, урсгалын массын дүгнэлт.
- Бохирдол тархалтын байгалийн болон хиймэл замуудын ба ус зайлуулалт, шүүрэлтийн нөлөөний тодорхойлолт (ж-нь: суваг, шуудуу, хуурай сайр гм).
- Бохирдол тархалтын таамаглал (ялангуяа ашигладаг гадаргын усны эх үүсвэрийн).

2.2.4.3 Гадаргуун усаар бохирдол тархах

Гидрологи, гидрогеологийн шинж чанар мөн геофизикийн хэмжилт болон химийн шинжилгээний үр дүн нь энэхүү бүлгийн суурь мэдээлэл болно. Гүний усны урсацын чиглэлийн изошугамыг тодорхойлох (газрын гүний болон гадаргын усны ус зайлуулалт ба шүүрэлтийн харьцааг тодорхойлох), голын гольдролын гидрогеологийн зүсэлтийг нэмж оруулах.

Энэхүү бүлгийн шаардлагатай мэдээллүүд:

- Ханасан ба ханаагүй бүсийн хооронд болон гадаргын усаар бохирдуулагч тархах боломжийг харгалзан гадаргын усны шинж чанарыг тодорхойлох (газрын гүний усны уст давхаргын зузаан, голын гольролын усны гүн тэдгээрийн хоорондын хамаарал, үерт автах боломжтой талбай, бохирдлын эх үүсвэрт усны үер хэрхэн нөлөөлөхийг дүгнэх).
- Бохирдол тархах таамаглал.

2.2.4.4 Байгалийн жамаар сэргэх үйл явцаас хамаарах бохирдлын тархалтын шинж чанар

Байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явц нь жам ёсны өргөн хүрээтэй иж бүрэн үйл явц бөгөөд чулуулгийн орчинд бохирдуулагчын нийт хэмжээ болон концентраци буурахад задрах механизм болох биологийн задрал, органик бус исэлдэх процесс, гидролизын урвалууд мөн задардаггүй механизм болох уусах, шингэрэх, уурших, сублимаци болон бусад үйл явцууд нөлөөлнө. Эрсдэлийн анализ нь эрдэм шинжилгээний ажил биш ба цаг хугацааны хувьд хязгаарлагдмал учраас гол механизмд анхаарлыг хандуулах нь чухал ба байгалийн жам ёсны сэргэлтийн үйл явцыг дүгнэлтийг эрсдэлийн үнэлгээний үед ашиглана. Гэхдээ байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцтай хамааралтай нөлөө бүхий дараах эрсдэлийг орхигдуулж болохгүй. Үүнд: бохирдлын голомтод анх судалж байсан бохирдуулагч бодисоос үүсэх илүү хор нөлөөтэй шинэ бодисыг мартаж болохгүй. Байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцыг дүгнэхэд экологийн хортой чанарын өөрчлөлт чухал үүрэгтэй.

Урвалын бүсэд явагдах байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явц нь бохирдлын манан аажмаар багасахад нөлөөлнө. Энэхүү үйл явцыг бохирдлын манангийн хэмжээ багасах

тодорхой хугацааны дараа тогтворжиж дараа нь багасах байдлаас ажиглах боломжтой (орчинд бохирдол ихсэхгүй болох эсвэл бохирдол ихсэх хурд нь байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцаас бага хурдтай байх). Урвалын бүс гэдэг нь ажиглалт хийж буй бодисын үзүүлэлтүүд нь ердийн үеийнхээс өөрчлөгдсөн талбайг нэрлэнэ.

Байгалийн жамаар нөхөн сэргэх явцыг дүгнэх явцад дараах асуудлуудыг тодорхойлох шаардлагатай:

- бохирдолтой манан тархалтын, тогтвортой байдалтай эсвэл багасах төлөвтэй байгаа эсэх;
- байгалийн жамаар нөхөн сэргэх явцад аюултай завсрын бүтээгдэхүүн үүсэх эсэх, эдгээр завсрын бүтээгдэхүүний хурдан, удаан боловсруулагдах байдал;
- хортой төмрийн бохирдлын тогтвортой байдал, чулуулгийн орчинд ямар нөлөө үзүүлэх (pH орчны өөрчлөлт гол байрыг эзлэх ба исэлдэх-буурах боломж);
- бохирдуулагч органик бус уусдаг давсыг микробын үйл явцад ашиглах боломжтой эсэх (ж-нь: азотын хүчлийн давс, нитрат, фосфат, сульфат, хлорид, ионтууд), чулуулгийн орчинд тогтвортой байх эсвэл өөрчлөгдөх (ж-нь: хлорид);
- байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцын боломжууд ба түүнийг хурдасгах үеийн эрсдэлийг байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцтай харьцуулах;
- бохирдуулагч манангийн өөрчлөгдөх байдал-манан сарних ба чулуулгийн орчинд бохирдол багасах болон түүний хугацааны талаархи тодорхойлолт.

Эрсдэлийн анализын хүрээнд цаг хугацааны хувьд авч үзвэл ихэнхдээ хязгаарлагдмал мэдээлэл авах боломжтой байдаг. Тиймээс байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцын дүгнэлт хийхэд скрининг загварыг ашиглахыг зөвлөдөг. Онолын хувьд интернэтээс шаардлагатай мэдээллийг олох боломжтой.

2.2.5 Бохирдлын тархалт ба үргэлжлэлийн дүгнэлт

Энэхүү бүлэг нь талбайд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлангийн хамгийн чухал хэсэг бөгөөд эрсдэлийн концепцын загварын бохирдол тархалтыг тодорхойлно. Тайланд дараах мэдээллүүд зайлшгүй багтана:

- Илрүүлсэн бохирдлын голомтоос бохирдол тархахтай холбоотой чухал багц мэдээллүүд, бохирдлын голомтоос нөлөөнд өртөх бодит болон боломжит талбайд бохирдол тархах замыг дахин авч үзэх.
- Байгалийн жамаар (эсвэл хурдасгасан) нөхөн сэргэх үйл явцыг харгалзсан бохирдол тархалтын урьдчилсан таамаглал.

2.2.6 Хязгаарлалт ба тодорхой бус байдал

Бохирдлын тархалтын хэмжээ, тархалтын цаг хугацааны тодорхойлолт, судалгааны үр дүнтэй холбоотой тодорхой бус байдал зэргийг мөн тодорхой бус байдлыг бууруулахтай холбоотой судалгааны ажилд нэмж оруулах саналыг энд дурдана. Энэ бүлэгт нөлөөлөх боломжгүй эсвэл эрсдэлийн анализын аргачлалын дагуу боловсруулсан ажлын даалгаврын хүрээнээс давсан дахин баталгаажуулах буюу хянах ажил хийгдэх шаардлагатай тохиолдолд холбоотой мэдээллийг оруулна. Тодорхой бус байдлын үндсэн хэсгүүд:

- Орон зайн хязгаарлалт (ж-нь: зөвшөөрөлгүйн улмаас гаднаас орох боломжгүй хаалттай талбай, ачаалал ихтэй талбай, газар доорхи байгууламжууд, үзэх боломжгүй техник технологи гм).
- Цагийн хязгаарлалт (ж-нь: давтан хэмжилт хийхэд цаг хугацаа хангалтгүй, технологийн шалтгаанаас ажил завсарлах гм).
- Техникийн хязгаарлалт (ж-нь: хэмжилтийн багажуудын мэдрэмж хангалтгүй, орохыг хориглосон хамгаалалтын бүс).
- Санхүүгийн хязгаарлалт (ж-нь: төслийн санхүүжилт нь шаардлагатай ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй, зарим параметрыг баталгаажуулахад их хэмжээний санхүүжилт шаардлагатай).
- Дээж авах программын алдаа буюу хязгаарлалт.
- Анализ буюу дүн шинжилгээний үед гарах алдаа (тодорхойлолтын үнэн зөв ба дүн шинжилгээний аргачлалын нарийвчлалыг харгалзсан).

10.2.4.1 Үр дүнгийн төлөөлөх байдал (ашигласан мэдээллийн хангалттай байдлыг харгалзсан, статистикын аргачлал ба мэдээллийн хэлбэлзэл).

3. Эрсдэлийн үнэлгээ

Энэхүү алхамыг гүйцэтгэхэд өмнө хийгдсэн танилцах, судалгааны ба үр дүнг тодорхойлох бүх ажлууд чиглэгдэнэ.

3.1 Эрсдэлийг тодорхойлох

Эрсдлийг тогтоох ажлын эхний шатанд судалгааны үр дүнг холбогдох хууль эрх зүйн шалгуур болон бусад чухал үзүүлэлтүүдтэй харьцуулах ажил хийгдэнэ. Дагаж мөрдөх хууль эрх зүйн хязгаарлалтыг зөрчсөн нь батлагдсан тохиолдолд залруулах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай.

Бохирдлын шинж байдлын талаархи хамгийн сүүлийн үеийн баталгаатай мэдээллийн дагуу мөн бохирдол тархалтын механизмыг тодорхойлж, байгалийн жамаар сэргэх үйл явцыг харгалзан үзэж бохирдлын нөлөөнд өртөх боломжтой хүлээн авагчдын талаархи хувилбаруудыг тодорхойлно (хүн ам ба экосист). Тус бүлэгт талбайн үнэлгээний **бохирдлын үзэл баримтлалын шинэчлэгдсэн загвар буюу концепцийг** боловсруулна. Энэ батлагдсан загварын хүрээнд бодит эрсдлийн дүгнэлт хийгдэнэ. Хэрэв бохирдлын үзэл баримтлалын шинэчлэгдсэн загвар буюу концепци өртөлтийн эрсдэл байхгүй тохиолдолд дараагийн үнэлгээний ажлуудыг явуулах шаардлагагүй.

3.1.1 Нэн тэргүүнд анхаарах бохирдуулагч болон эрсдлийн бусад хүчин зүйлсийг тодорхойлох

Судалгааны ажлын үед хууль эрх зүйн зайлшгүй мөрдөх хязгаарлалтуудыг (ялангуяа ундны болон гадаргын усны болон хуулийн бусад заалтууд) зөрчсөн нь батлагдсан эсвэл хүн амын эрүүл мэнд болон экосистемд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд дараагийн дүгнэлтэнд ашиглах үзүүлэлтүүдийн судалгааны (ж-нь: хүснэгт) тайлан боловсруулна. Энэ судалгаанд бүх төрлийн усны эх үүсвэрийн нефтийн бүтээгдэхүүний бохирдлыг (усны бохирдолтой байдлал) багтаана. Бодит эрсдлийн байдал нэн тэргүүнд анхаарах хортой, эрсдэлтэй хүчин зүйлүүдийг анхаарч арга хэмжээ

авах шалтгаан боно. Залруулах арга хэмжээ авах шалтгаан нь зөвхөн бохирдлыг тодорхойлох хязгааруудын зөрчлөөс хамаарахгүй. Бүлэг дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Бохирдлын шинж чанар, хэмжээ болон бохирдол тархах хэмжээнээс шалтгаалан нэн тэргүүнд анхаарах бохирдуулагчыг болон бохирдол хүлээн авагчыг тодорхойлох.
- Нэн тэргүүнд анхаарах бохирдуулагчын хоруу чанарын тайлбар болон мэдээллийн эх үүсвэрийг дурдах (энэхүү тайлбарыг хавсралтанд оруулж болно).
- Тухайн талбайн эрсдэлийн хүчин зүйлүүдийн жагсаалт, хууль эрх зүйн заалтын батлагдсан болон боломжит зөрчлийн мөн ялангуяа газрын гадаргын болон гүний усны ихээхэн хэмжээний бохирдолтой холбоотой мэдээлэл (эдгээр мэдээллүүд нь залруулах арга хэмжээг тодорхойлно).

3.1.2 Эрсдэл хүлээн авагчын үндсэн шинж чанар

Эрсдлийн анализын үед бодит үзэл баримтлалын загвар буюу концепцид – бохирдол тархалтын замууд ба өртөлтийн хувилбаруудыг тодорхой боловсруулна. Аюулд өртөх байгууламжууд буюу субъектууд ба экосистемийн шинж чанар, тоо, байршлыг тогтоох мөн аюулд өртөх оршин суугчдад боломжит өртөлтийн нөлөө хэрхэн нөлөөлөхийг хянаж үзэх нь энэ бүлгийн ажлын зорилго байна. Бүлэгт дараах мэдээллүүд багтана:

- Бохирдолд өртөх боломжтой бүх субъектыг тодорхойлж жагсаах (хүн ам болон экосистем), эрсдлийн эх үүсвэртэй ямар хамааралтай болох мөн тэдгээрийн байршлыг тодорхойлох.
- Бохирдлын боломжит нөлөө нь бохирдол хүлээн авагчид хэрхэн нөлөөлөхийг харуулсан бодит загварууд.

3.1.3 Өртөлтийн зам болон бодит хувилбаруудын дүгнэлт

Энэхүү бүлэг нь өнөөг хүртэл цуглуулсан мэдээллийн эцсийн тайлбар ба концепцийн загварын хамгийн сүүлчийн засварын болж өгнө. Хийгдсэн судалгааны үр дүнг үндэслэн тооцоолсон бохирдол тархалтын замууд, өртөлтийн бодит хувилбарууд, өртөлтийн параметрүүд буюу үзүүлэлтүүдийг тодорхой ойлгомжтой хэлбэрээр багтаана (зөвхөн концентрацийн хэмжээ бус өртөлтийн хэмжээ, хэлбэрүүдийг тодорхойлсон бусад үзүүлэлтүүдийг багтаана). Бүлэгт дараах мэдээллүүд багтана:

- Шинэчлэгдсэн концептын загвар –бохирдол хүлээн авагч ба бохирдол тархалтын цаашдын явцыг харгалзан бохирдол тархалтын гол гол механизмыг тодорхойлж дүгнэх.
- Бохирдлын нөлөөний бодит хувилбаруудын жагсаалт, тэдгээрийн параметрүүд ба өөрчлөлтийн тайлбар (одоогийн ба ирээдүйн арга хэмжээнүүд, газар ашиглалтын өөрчлөлтөөс цаашид хэрхэн хамаарах, тухайн талбайн одоогийн ашиглалт гм).
- Бохирдол тархалтын зам ба байршлыг харгалзан бохирдлын нөлөөний концентрацын жагсаалт гаргах өөрөөр хэлбэл концентрацын анхны хэмжээ буюу нөлөөллийн хувилбаруудын тоон илэрхийлэлд ашиглах концентрацын хамгийн

их ба бага утгыг статистикийн хувьд тайлбарлах.

3.2 Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ

Энэхүү бүлэгт нэн тэргүүнд анхаарах шаардлагатай тогтоогдсон бохирдол нь хүний эрүүл мэндэнд нөлөөлөх бодит ба боломжит нөлөөллийг дүгнэх шаардлагтай. **Судалгааны ажлын үед хууль тогтоомжид заагдсан хязгааруудаас илүү концентрацитай бодисуудын хувьд эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг хийх шаардлагүй**. Зөвхөн энэ байдал нь эрүүл мэндийн болон экологийн ноцтой эрсдлийг мөн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай ноцтой нөхцөл байдлыг илэрхийлэл болдог. Мөн ойрын хугацаанд хууль тогтоомжинд заасан хязгаарыг давах боломжтой бохирдол, хууль тогтоомжид заагдсан хязгааруудаас их хэмжээгээр давсан яаралтай арга хэмжээ авах шаардлагатай ноцтой нөхцөл байдлыг анхаарах шаардлагатай. Хууль тогтоомжид заагдсан хязгааруудаас илүү тохиолдлын хувьд концентрацийн хэмжээ нь нөлөөнд өртөх цэгт зөвхөн байгаль орчны бохирдлын илэрхийлэхгүй (төмрийн концентраци их байх нь төмрийн ордын ойролцоо буюу байгалийн ердийн нөхцөлд тохиолдоно) ба усны бохирдол нь чанарын илэрхийлэл байж болно (ж-нь: үнэр, амт өөрчлөгдсөн, усны гадаргууд бохир давхарга үүссэн).

Хууль тогтоомжид заагдсан хязгаарууд болон бусад харгалзах үзүүлэлтүүд байхгүй нөхцөлд хүний эрүүл мэндэд нөлөөлөх боломжит нөлөөг хоруу чанарын талаархи мэдээллийг бодит өртөлтийн хувилбаруудын тооцоолсон өртөлтийн тун хэмжээтэй харьцуулж гаргана. Эрүүл мэндийн эрсдлийг үнэлгээ хийхэд судалж байгаа бохирдуулагч ба тэдгээрийн нэгдлийн хоруу шинж чанарыг, нөлөөлөх тун хэмжээ-үзүүлэх нөлөө, бодит өртөлтийн үзүүлэлтүүд (өртөлтийн цэгийн бохирдлын концентраци) ба хүлцэх боломжтой эрсдлийн хэмжээг тодорхойлно. Зарим бодисын хувьд (ж-нь: PAU, диоксин ба фуран) хоруу чанарын түвшинг бусад бодисуудтай харьцуулсан хоруу чанарын хүчин зүйлсийг - Toxic Equivalency Factor тодорхойлсон байдаг. Эдгээр үзүүлэлтүүдийг ашигласны үндсэнд зарим бодисын нэгдлийн хоруу чанарын эквивалентыг (TEQ - Toxic Equivalent) тогтоох боломжтой. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний зарчмуудыг Хавсралт 4-д үзүүлэв.

3.2.1 Өртөлтийн үнэлгээ

Шинэчлэгдсэн концепцийн загварын дагуу мөн талбайн одоогийн ба ирээдүйн ашиглалтыг харгалзан үзэж бодит эрсдлийн өртөлтийн үнэлгээг хийдэг.

Тухайн талбайн хувьд хүчин төгөлдөр хууль тогтоомжын хүрээнд мөрдөх шаардлагатай хязгаарууд тодорхойлоогүй тохиолдолд өртөлтийн тооцоог (хүлээн авсан тун) өртөлтийн хувилбар тус бүрт тусгайлан өртөлтийн тэгшитгэлийн дагуу хийнэ. Өртөлтийн тоон утгын тооцоог хийхэд таамаглалын загварын - U.S. EPA аргачлалыг ашиглана. Өртөлтийн хувилбаруудын шинэчлэгдсэн жишээ, өртөлтийн тэгшитгэл, тогтмол тоонууд зэргийг тус аргачлалын Хавсралт 4-т тайлбарласан.

Хүлээн авсан ба шингээсэн тунгийн хэмжээний тооцоог нэн тэргүүнд анхаарах бохирдуулагч ба тэдгээрийн нэгдлийн хувьд өртөлтийн бодит хувилбарын тооцоог хүлээн авсан тун хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх нөлөө мөн хоруу чанарын

эквивалент хүчин зүйлийн талаархи мэдээлэл нэр хүндтэй баталгаатай мэдээллийн санд байгаа нөхцөлд хийгдэнэ. Өртөлтийн үнэлгээ нь өгөгдөл буюу орох мэдээлэл ба өртөлтийн үзүүлэлтүүдээс гадна хорт хавдар үүсгэхгүй нөлөөллийн үед хяналтын тунгийн болон концентрацын (RfD, RfC) судалгаа, хорт хавдар үүсгэх нөлөөллийн үед хүчин зүйлийн удирдамж (SF) зэрэг мэдээллүүдээс бүрдэнэ. Тун-нөлөөний харьцааны талаархи мэдээлэл байхгүй тохиодолд эрсдлийн үнэлгээний тоон утгыг тооцоолох боломжгүй тул зөвхөн чанарын үнэлгээ хийх эсвэл адил төстэй бодисын үзүүлэх нөлөөтэй харьцуулна.

Бохирдуулагчын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаархи мэдээлэл хомс тохиолдолд өртөлтийн хувилбаруудын загвар ба түүний өөрчлөлтөөс хамаарах тодорхой бус байдлын дүгнэлтийг Хязгаарлалт ба тодорхой байдлын бүлэг 3.5-т хүрээнд хийнэ.

3.2.2 Эрүүл мэндийн эрсдэлийг тооцоолох

Өртөлтийн тооцоолсон бодит эрсдлийг аюулын түвшинтэй адилтгаж үзэх ба эрсдлийг үнэлэх бусад ажил энэхүү төгсгөлийн бүлэгт хийгдэнэ. Үнэлгээний саналын хүрээнд хийгдэх ажлын дарааллыг аргачлалын Хавсралт 4-т дүгнэсэн байгаа. Хууль тогтоомжын хязгаарууд ыг давсан тохиолдолд эрүүл мэндийн эрсдлийг тооцоолох шаардлагүй.

3.3 Экологийн эрсдлийн үнэлгээ

Судалгааны ажлын үед бодисын концентраци нь холбогдох хууль тогтоомжын хязгаарыг давсан тохиолдолд экологийн эрсдлийн үнэлгээний ажил хийгдэхгүй. Зөвхөн энэ бодит байдал нь экологийн ноцтой эрсдлийн баталгаа болох ба үүссэн ноцтой байдлыг хурдан хугацаанд шийдвэрлэх шаардлагатай.

Байгаль орчны бие даасан бүрэлдэхүүн хэсгийн эрсдлийн үнэлгээний хувьд аюулд өртсөн экосистемийн шинж чанар ба болзошгүй эрсдлийн тоон болон чанарын тодорхойлолт, тэдгээрийн болзошгүй нөлөөллийн механизмыг тодорхойлох шаардлагатай.

Экосистемийн эрсдэлийг үнэлэх ажлын үед үүсэх эрсдлийг (бохирдлын экосистемд үзүүлэх сөрөг үр дагавар) мөн бохирдлын хязгаарууд ыг тогтоох зорилготой ба эдгээр зорилгыг биелүүлсэн нөхцөлд сөрөг үр дагавар нь багасна.

Хөдөө аж ахуйн газар, ойн газар, урсгал ус болон бусад ундны усны эх үүсвэр өртөх бол эрсдлийн үнэлгээнд холбогдох хууль тогтоомжийн хязгаарлалтыг харьцуулах байдлаар ашиглана.

Хэрэв эрсдлийн үнэлгээний шинжилгээний ажлын үед холбогдох хууль эрх зүйн хязгаарлалтаар тодорхойлсон мэдрэг экосистем аюулд өртсөн тохиолдолд эрсдлийн үнэлгээний ажлын хүрээний гадна мэргэжилтнүүдтэй хамтран холбогдох экосистем, амьтан, ургамлын судалгааг хийх нь зүйтэй юм.

Байгаль орчны эрсдэлийн үнэлгээтэй холбоотой аливаа тодорхой бус байдлыг Хязгаарлалт ба тодорхой бус байдлын Бүлэг 3.5-д заасан дүгнэх шаардлагатай.

3.4 Эрсдлийн дүгнэлт

Энэхүү бүлэгт мониторинг хийх дахин хянах эсвэл сөрөг нөлөөг арилгах арга хэмжээ авах шаардлагатай хүний эрүүл мэнд болон байгаль орчны бие даасан бүрэлдэхүүн хэсэгт учруулах тогтоогдсон эрсдлийн жагсаалт ба шинж чанарын талаархи мэдээллүүдийг агуулна. Өртөлтийн хувилбаруудыг тоон үзүүлэлтүүдээр илэрхийлэхээс гадна эрсдэл ба түүний өөрчлөгдөх байдлыг бичгийн хэлбэрээр тайлбарлана. Дүгнэлт болон үгээр тайлбарласан тайлан бохирдлын хэлбэр болон өртөлтийн замууд нь эрсдэл хүлээн авагчид учрах гол эрсдэл болон ямар арга хэмжээг эхний ээлжинд хэрэгжүүлэх талаарх тодорхой мэдээллийг багтаасан байна. Өмнөх бүлгийн эрсдлийн тоон үзүүлэлтүүдийг бусад нөхцөл байдалтай жишин дүгнэж, залруулах арга хэмжээний эцсийн зорилго болон хийгдэх ажлын төрөл зэргийг тодорхойлох шаардлагатай.

3.5 Хязгаарлалт ба тодорхой бус байдал

Энэ бүлэгт эрсдлийн анализын төслийн ажлын хүрээнд хийх боломжгүй эсвэл төслийн гүйцэтгэгч нөлөөлөх боломжгүй ойлгомжгүй болон тодорхой бус байдлын талаархи мэдээллийг оруулна.

Эрсдлийн анализын хүрээнд бохирдуулагч (тэдгээрийн нэгдлүүд) нь хүний эрүүл мэндэд хэрхэн шууд нөлөөлөлөхийг тодорхойлох боломжгүй ба шинэчлэгдсэн сүүлийн үеийн мэдээлэлтэй олон улсын мэдээллийн сангийн мэдээллийг ашиглана. Мэдээллийн сангийн мэдээлэл нь хязгаарлагдмал учраас загвар тохиолдолын хоруу чанарын талаархи мэдээллийг ашиглаж болно. Эрүүл мэндийн эрсдлийн тодорхой бус байдлын хувьд аюулгүй байдлыг илүү анхаарах шаардлагатай.

Энэ бүлэгт эрүүл мэндийн болон экологийн эрсдэлтэй холбоотой тодорхой бус байдлыг тайлбарлаж, төгсгөлд нь эрсдлийн анализын дүгнэлт ба зөвлөмжийг оруулна. Эрсдэлд дараах үндсэн мэдээллүүд багтана:

- Судалгааны үеийн тодорхой бус байдлын нөлөө (ялангуяа ашиглах мэдээллийн асуудал).
- Нөлөөлийн замуудын өөрчлөлтөөс хамаарах тодорхой бус байдал (хувилбаруудын таамаглал эсвэл цэвэршүүлэх ажлаас хамаарах эрсдлийг тооцоолж цэвэршүүлэх ажлын саналыг боловсруулна).
- Нөлөөллийн концентрацыг шууд хэмжих боломжгүй үеийн тодорхой бус байдал (ашигласан мэдээлэл, хийгдсэн тооцоотой холбоотой хязгаарлалтуудыг дурдах).
- Тун хэмжээ ба үйлчилгээтэй холбоотой тодорхой бус байдал (хяналтын тунг тодорхойлохын тулд ашигласан мэдээлэл болон тодорхой бус байдлын хүчин зүйлс, бусад хүчин зүйлсийн талаар зайлшгүй хэлэлцэх шаардлагатай).
- Нөлөөлөлд өртөх хүн ам ба өртөх хувилбараас хамаарах өртөлтийн параметраас хамаарах тодорхой бус байдал .
- Янз бүрийн бодисын нэгдмэл нөлөө, бодисын нэгдлүүд болон эрсдлийн бусад хүчин зүйлсийн үнэлгээнээс хамаарах тодорхой бус байдал тийн үнэлгээ.

4. Залруулах арга хэмжээний зөвлөмж

Шаардлагатай залруулах арга хэмжээний санал нь эрсдлийн анализын гол үр дүн байх ба хийгдэх цэвэршүүлэх ажлын хэмжээ, аргачлалыг сонгоход мэргэжлийн суурь мэдээллийн үүрэг гүйцэтгэнэ. Мөн ноцтой эсвэл онгцгой тохиолдох бохирдлын үед

бохирдолтой талбайн нөлөө нь хүний эрүүл мэнд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт учруулах сөрөг нөлөөг тогтоосон хүлцэх хэжээнд хүртэл багасгахын тулд эрх бүхий байгууллага залруулах арга хэмжээний авах шаардлагыг хэрэгжүүлэхэд дээрх саналыг ашиглана. Залруулах арга хэмжээний зорилгыг мөн хэрэгжүүлэх аргыг буюу техникийн болон захиргааны арга хэмжээ, санхүүжилт, ажилд зарцуулагдах хугацаа зэргийг тодорхой боловсруулна.

Залруулах арга хэмжэний зөвлөмж нь эрсдлийн үнэлгээтэй адил байна. Залруулах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулахдаа бохирдлын талаархи бүх мэдээлэл, бохирдлын төрөл, түвшин мөн эрсдлийн анализын үед тогтоосон болзошгүй эрсдлийн мэдээллийг харгалзах шаардлагатай. Тодорхой бус байдлын мэдээлэлд багтсан талбайн онцлог байдлыг мөн харгалзана. Боловсруулсан мэдээллийг ашиглахдаа тогтоосон абсолют тоон утгуудыг (концентрацын хэмжээ, хүснэгтээс авсан үзүүлэлтүүд, тогтмол тоонууд, математик загварын үр дүн гм) шууд утгаар нь ашиглахгүйгээр уян хатан хандах ба тодорхой нөхцөлд бохирдолтой талбайн мэдээллийг мэдрэмжтэй ашиглана.

4.1 Залруулах арга хэмжээний эцсийн үзүүлэлтүүд

Бохирдолтой талбайн сөрөг нөлөөг арилгах ажлыг 2 чиглэлээр хэрэгжүүлнэ:

Засаж залруулах арга хэмжээний үндэслэл тодорхойлох

Тухайн талбайн одоогийн болон төлөвлөсөн цаашдын ашиглалт эсвэл талбайд бохирдлын үлдэгдлийг үлдээхэд талбайн цаашдын ашиглалт хэрхэн нөлөөлөх зэргийг харгалзан зорилгуудыг тодорхойлно. Залруулах арга хэмжээний дараа зорилго хэрхэн биелэгдэхийг чанарын талаас томъёолох ба энэ арга хэмжээний хүрээнд дараах ажлууд хийгдэнэ:

- Усны бохирдлыг арилгах, усны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх.
- бохирдлын тогтоосон хилээс гаднах гадаргууд болон орон зайд бохирдол тархалтыг хязгаарлах.
- Хурын болон бусад гадаргын усаар ханаагүй бүсийн талбай угаагдахыг хязгаарлах.
- Ус ашиглалтын хувьд нөлөө бүхий усны эх үүсврийн усны чанарыг дахин сайжруулах.
- Хуучин болон газар доорхи тоног төхөөрөмжүүдээс аюултай бодисууд тархахыг зогсоох.
- Орох зөвшөөрөлгүй хүмүүсийг тухайн талбайд оруулахгүй байх.
- Экосистемд учрах тогтоогдсон эрсдлийг арилгах.
- Тогтоогдсон нөлөөллөөс хамаарах эрүүл мэндийн эрсдлийг арилгах (ж-нь: амаар залгих, амьсгалах, арьсаар хүрэх …).
- Бохирдолтой усны эх үүсвэрийг ашиглахыг хориглох.
- Учрах боломжит сөрөг нөлөөг тодорхойлохын тулд бохирдол тархалтын явцыг дахин хянах.

Эцсийн параметрүүдийг тодорхойлох

Эцсийн параметрүүд нь тодорхойлох, хэмжих боломжтой залруулах арга хэмжээний тоон үзүүлэлтүүд мөн залруулах арга хэмжээний төрөл зэргийг тодорхойлно. Мөн залруулах арга хэмжээ нь тусгайлан заасан газарт, тухайн цаг хугацаанд бохирдол дамжуулагчын нөхцөлд тохирсон байна. Эцсийн параметрүүдийг тодорхойлоход зайлшгүй мөрдөх хязгааруудыг ашиглах боломжгүй үед бусад холбогдох аргачлалыг (гидротехникийн болон бусад тооцоо, эрсдлийн бодит хувилбаруудын буюу эрүүл мэндийн эрсдлийн мэдээлэл, шаардлагатай үед мэргэжлийн шинжээчдийн тооцоо) ашиглана. Гаргасан тооцоо, эсвэл тооцооны арга нь баримтад тулгуурлсан, техникийн үндэслэлтэй байх ёстой.

Өртөлтийн бодит хувилбарын хувьд эрсдлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшингээс давсан тохиолдолд эрсдлийн тоон үзүүлэлтүүдийг ашиглан цэвэршүүлэлтийн ажлын эцсийн параметрүүдийг тодорхойлно. Эцсийн параметрүүдийг тооцоход өртөлтийн анхны хувилбаруудыг болон параметрүүдийг ашиглах ба тооцоолсон параметрүүд нь тухайн тодорхой арга ба өртөлтийн хувьд хийгдэнэ. Тоон үзүүлэлтүүдийн хэмжээнээс гадна ж-нь: эрсдлийн тодорхой бус байдлын үед эрсдлийн хүчин зүйлүүдийн нэгдмэл илүү хүчтэй үр нөлөө мөн санал болгож буй үзүүлэлтүүдийн бодит боломжын талаар үгээр тайлбарлах шаардлагатай. Эрүүл мэндийн эрсдлийн (хорт хавдар үүсгэх эсвэл хорт хавдар үүсгэхгүй) хүлээн зөвшөөрөгдөх түвшинг дурдах ба үүнийг үндэслэн цэвэршүүлэх ажлын параметрүүдийг тодорхойлно.

Усыг амаар уух хувилбар ба бохирдуулагчын хорт хавдар үүсгэхгүй нөлөөг хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн эрсдлийн хувилбарыг ашиглан усан дахь бохирдуулагч бодисын концентрацын эцсийн хязгаарыг тооцох жишээг Хавсралт 5-д үзүүлсэн.

Өртөлтийн талбайн байршил нь эцсийн параметрүүдийн хүрээнд тогтоосон бохирдлын голомтын цэгтэй буюу урьдчилан тооцоолсон цэвэршүүлэх ажил хийгдэх талбайн баршилтай таарахгүй тохиолдолд цэвэршүүлэх ажлын талбайн хувьд эцсийн параметрүүдийг ашиглан **цэвэршүүлэх ажлын тусгай хязгааруудыг** тогтооно. Энэхүү дүгнэлт тооцоог хийхдээ тухайн талбайн тодорхой нөхцөл, тухайн байгалийн нөхцөлд (техникийн хязгаарлалт, физик-химийн үйл явцууд, байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцын хүчин зүйлүүдийг харгалзах) бохирдол хэрхэн тархах, бохирдлын тархалтаас урьдчилан сэргийлэх, бохирдлын тархалтын замуудыг таслан хаах мөн цэвэршүүлэх ажлын технологийн боломжууд зэргийг харгалзан үзнэ.

Цэвэршүүлэх ажлын параметрүүд ба хязгааруудыг бохирдлыг илэрхийлэх “дохио” утгыг үндэслэн тооцоолж болохгүй. Эцсийн параметрүүд ба цэвэршүүлэх ажлын параметрүүдийг тодорхойлохдоо тухайн байдлын онцлогийг харгалзана.

Бодисын концентраци нь хууль эрх зүйн хязгааруудыг давсан тохиолдолд залруулах арга хэмжээний **эцсийн параметрүүд нь** (ж-нь: ундны усны бохирдол зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан гэхдээ цэвэр ус дамжуулах хоолойтой тохиолдолд хязгаарыг усалгааны усны хязгаарын хэмжээнд тохируулан ихэсгэх эсвэл өртөлтийн замыг таслан хаах бусад залруулах арга хэмжээний санал боловсруулна) эдгээр **хууль эрх зүйн хязгаарууд** байна.

Хууль эрх зүйн хязгаар байхгүй гэхдээ эцсийн параметрүүдийг тодорхойлох шаардлагатай үед өртөлтийн хувилбаруудыг эргүүлэн бодож параметрүүдийг тооцоолно. Дахин хийх тооцоо нь санал болгож буй эрсдлийн анализын хавсралтанд

орох ба сонгосон ажлын дарааалал, үнэн зөвийг шалгах ба дахин давтах боломжтой байна. Тооцоог ил тодоор дахин хийхэд шаардлагатай суурь мэдээлэл, цэвэршүүлэлтийн ажлын эцсийн параметрүүдийн үндэслэлийн талаархи мэдээллүүдийг Хавсралтанд оруулж өгнө.

Бохирдуулагчын (LNAPL эсвэл DNAPL) үе шатыг зайлуулах ажил эцсийн параметрүүдэд багтана. Эдгээр тохиолдолд эцсийн параметрийг биелүүлсэн эсэх, үе шатны тухай ойлголтын зэрэг нь тодорхойлолтын нэгэн хэсэг байна. Үе шатыг арилгахад зарим тохиолдолд бохирдолтой хөрсийг зайлуулах ба түүний зайлуулахтай холбоотой хязгаар нь эрсдлийн үнэлгээнд хамаарагдахгүй харин залруулах арга хэмжээний технологийн дарааллаас тодорхойлогдоно. Энэ тохиолдолд хөрсний бохирдлын хязгаарыг хортой бодисын агууламж нь үе шат үүсэхгүй байхаар тогтооно. Энэхүү тооцоо нь эрсдлийн анализын хавсралтанд багтах ба ажлын дараалал болон үнэн бодит байдлыг ил тодоор нотлох, хэзээ ч дахин давтах боломжтой байна.

Энэ нь техникийн хязгаарлалтыг ашиглах боломж байж болно (ж- нь: цианидын хувьд хөрсний бохирдлыг зайлуулахад гэх мэт). Эдгээр хязгаарлалтыг бохирдолтой хөрсний сэргээгдэх байдлаас шалтгаалан тогтоож болно.

Эцсийн зорилгыг биелүүлэх техникийн шалгуур ж-нь: аюултай бодис агуулсан хуучин технологи зайлуулах эсвэл эвдэрсэн суваг шуудуу сэргээн босгох ажил байж болно.

Мониторинг хийгдэж буй тухайн байгууламжын тогтоосон цагийн бохирдлын зогсонги байдал нь мониторингийн эцсийн параметр нь байна.

Эцсийн параметрүүд ба цэвэршүүлэлтийн хязгаар нь доорхи үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно:

- Ажиглалтын талбайн бохирдуулагчын концентрац (ус, хөрс, агаар, ханд гм) а баталгаатай тогтоогдсон талбайд (гадагш урсах профилийн дагуу, цэвэршүүлэлтийн голомтод гм);
- Физик-химийн эсвэл биологийн үзүүлэлтүүд (ж-нь: pH, судалгаанд хийгдэж буй байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн бичил биетний тоо);
- Техникийн нэгж үзүүлэлтүүд ба параметрүүд (ж-нь: идэвхгүй ба реактив цэвэршүүлэлтийн аргачлалын техникийн параметрүүд).

Талбай жигд бус байдлын (геологи ба гидрогеологийн нөхцөл мөн аюулд өртөх субъектын эрсдлийн адилгүй түвшингийн хувьд) шинжтэй үед талбайн гадаргууд болон орон зайд зорилтот параметрүүдийг төрөлжүүлэх аргыг сонгоно:

- Хот суурин, хөдөө орон нутгийн аж үйлдвэрийн газруудын хувьд;
- газар болон усны менежментийн асуудлын хувьд илүү хамгаалах шаардлагатай объектууд (ж-нь: гүний ус зайлуулах системийн хувьд), хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд (боломжит өртөлтийн талбай) гм;
- идэвхтэй ба идэвхгүй хамгааллын элементүүдээр хамгаалагдсан талбай болон голомтууд (гидравлик хаалтууд, газар доор байрлах идэвхгүй болон реактив хананууд гм).

Залруулах арга хэмжээний зорилтот үзүүлэлтийн зорилго нь оролцогч талуудын зөвшилцлийн гэрээнд заагдсан байх ёстой – байгаль орчны салбарын төрийн

захиргааны ба хяналтын байгууллагууд, нийтийн эрүүл мэндийн байгууллагууд, газар төлөвлөлтийн байгууллагууд (бүс нутгийн ба тухайн орон нутгийн), газар эзэмшигч ба эрсдлийн анализыг боловсруулагчид. Цаашид авах арга хэмжээний тухай шийдвэрлэхэд эрсдлийн анализын дүгнэлтийг үндэслэхгүй ба эдгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байдлыг зайлшгүй тодорхой тайлбарлана.

Цэвэршүүлэх ажлын эцсийн параметрүүдийн саналын салшгүй хэсгийн үндэслэлийг засаж залруулах арга хэмжээний талаархи шийдвэр гаргахад ашиглах боломжтойгоор бичсэн байх ёстой.

4.2 Санхүүжилтээс хамаарах залруулах арга хэмжээний зөвлөмж

Эрсдлийн анализын эрсдлүүдийг ба бохирдолтой газрын тэргүүлэх ангилалыг тодорхойлох ажлын дараалалтай бусад залруулах арга хэмжээ тохирох ёстой. Нарийн төвөгтэй, өртөг өндөртэй тохиолдолд дараагийн шатны ажлын хүрээнд **техник эдийн засгийн үндэслэл боловсруулахыг зөвлөмж** (Арга зүйн удирдамж – Бохирдсон талбайд хэрэгжүүлэх залруулах арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэлийн зарчим) болгодог**.**

Залруулах арга хэмжээг бодит байдлаар, зарцуулах хугацааг, хэрэгжүүлэх боломжтой үе шатуудтайгаар тодорхойлох ба эдгээр нь эрсдлийн анализын мэдээллүүдийн түвшинд, сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгаа, техник технологийн бодит боломж ба эдийн засгийн боломжид тулгуурлана.

Залруулах арга хэмжээ нь 2 хэсгээс бүрдэнэ: цэвэршүүлэх ажил ба цэвэршүүлэх ажлын дараах мониторинг. Цэвэршүүлэх ажлыг бүрэн хэмжээгээр эсвэл хэсэгчлэн захиргааны арга хэмжээгээр (бохирдсон талбайн ашиглалтыг өөрчлөх ба хязгаарлах гм), бусад арга хэмжээгээр (ж-нь: усны өөр эх үүсвэр ба орон байр) орлуулна. Аливаа шалтгааны улмаас бохирдолтой талбайн шийдвэрлэх асуудлыг хойшлуулахыг захиргааны арга хэмжээний онцгой тохиолдол хэмээн ойлгож болно.

Хялбар нөхцөлд боловсруулагдах идэвхтэй цэвэршүүлэх ажил хийгдэхгүй мониторингийн санал:

- боломжтой хугацаанд хугацаанд бохирдолтой талбайн тогтоосон эрсдлийг бууруулахад байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явц хангалттай;
- хамрах талбайн хэмжээ тогтвортой эсвэл ихэсдэг бодисын концентраци нь цэвэршүүлэх хязгаараас бага ба бохирдол тархалтын зам дагуух эрсдэл хүлээн авагч ихэсдэг өртөхгүй тохиолдолд;
- бохирдолтой талбай байгалийн буюу зохиомлоор тусгаарлагдсан эсвэл тодорхой хугацаанд хааж, тусгаарласан мөн стандарт нөхцөлд эрсдэл учруулахгүй үед гэхдээ талбайн цаашдын өөрчлөлтийг хянах шаардлагатай.


Асуудлын талаархи тухайн үеийн мэдээлэл нь эцсийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн залруулах арга хэмжээний санал боловсруулахад хангалтгүй үед цэвэршүүлэх ажлыг үе шаттай байхаар тодорхойлно. Энэхүү үе шаттай арга нь тухайн эрсдлийн анализын үед (цэвэршүүлэх ажил нь захиргааны шийдвэрийн дагуу хийгдээгүй үед хөрөнгө оруулагчдын тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх болон ажлын дараалалтай тодорхойлох үед) боловсруулагдаж дараа нь захиргааны арга хэмжээний тухай шийдвэрт тусгагдана

шаардлага. Дараах төрлийн бохирдолтой талбайн хувьд залруулах арга хэмжээний үе шаттай аргыг сонгоно:

- олон төрлийн бохирдуулагчтай томоохон талбай;
- адил бус геологийн орчин (гүний хагаралтай хэсэг, чухал үүрэгтэй тээврийн зам гм.);
- бохирдолд амархан өртөх боломжтой объект, барилга байгууламжын өндөр эрсдэл;
- тодорхойгүй байдлын чухал хүчин зүйлсүүд;
- бусад чухал ач холбогдолтой баримтууд.

Эхний ээлжинд хүний эрүүл мэндэд учрах гэнэтийн эрсдлийг арилгах арга хэмжээг шаардлагатай.

Цэвэршүүлэх арга хэмжээ нь дараах схемийн дагуу явагдана:



Ажлын хэрэгжүүлэлт гэсэн ойлголтонд урт хугацаанд хийгдэх залруулах арга багтана (цэвэршүүлэх ажил, мониторинг). Үе шаттай хэрэгжүүлэх ажлын үед бохирдолтой талбайд эерэг өөрчлөлт гарахаар эсвэл бохирдол тархах замыг хязгаарлахаар тооцоолно. Адил төстэй эерэг ба сөрөг өөрчлөлт гэнэтийн үйл явдлын (үер гм) үед мөн талбайн ашиглалтын хэлбэр өөрчлөгдөхөд эсвэл удаан хугацаагаар ажил зогсоход тохиолдох боломжтой. Эдгээр үйл явдлыг ажлын үе шатны хяналтгүй хэрэгжүүлэлтэнд тооцох ба бохирдолтой талбайн дараагийн ажил эхлэхээс өмнө эрсдлийн анализыг шинэчлэн боловсруулна.

Энэ бүлгийн 4.2 агуулгад дараах мэдээллүүд багтана:

Засаж залруулах арга хэмжээний концепци

Эцсийн параметрүүдийн зорилгыг биелүүлэх, хүн ам ба эрсдлийн харилцааг тодорхойлохын тулд алхам тус бүрийг тодорхойлох шаардлагатай.

Залруулах арга хэмжээний санал эсвэл ноцтой байдал буюу нотлогдсон эрсдлийг бууруулах эсвэл арилгах ажлын өөр аргуудыг харьцуулах

Бохирдолтой талбайн хувьд тодорхой залруулах арга хэмжээний санал боловсруулах боломжгүй үед өөр журмын санал боловсруулна. Энэ тохиолдолд санал болгох хувилбаруудыг бүх талаас нь дүгнэж боловсруулна (цэвэршүүлэлтийн ажлын үр дүн, хяналт тавих боломж, эдийн засгийн тооцоо ба шаардагдах цаг хугацаа, байгаль орчинд үзүүлэх хоёрдогч нөлөө, нийгмийн ба сэтгэл зүйн асуудлууд – ялангуяа эрсдэл ба тэдгээрийн арилгах асуудал, нийгмийн шаардлага). Бусад хувилбаруудын хэрэгжүүлэлт боломжгүйг тайлбарлах шаардлагатай.

Хэрэгжүүлэх дэс дарааллыг тогтоогоогүй залруулах арга хэмжээний хувилбаруудыг захиргааны шийдвэр гарахаас өмнө залруулах арга хэмжээний эцсийн хувилбарын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байхаар тооцоолж боловсруулна. Энэ тохиолдолд эрсдлийн анализын сүүлчийн шатанд техник эдийн засгийн үндэслэл боловсруулах шаардлагатай.

Эцсийн параметрүүд ба цэвэршүүлэх ажлын хязгаарын санал

Өмнөх бүлэгт эцсийн параметрүүд, өртөлтийн хувилбар болон хууль эрх зүйн шаардлагуудын дагуу цэвэршүүлэх ажиллагааны хязгаарыг тооцох аргыг тайлбарласан. Цэвэршүүлэх ажиллагааны хязгаарыг эцсийн саналыг боловсруулахад өртөлтийн хувилбарууд тус бүрийн ноцтой байдал, орон зайн олон талт байдал, цаг ба цэвэршүүлэх ажиллагааны хувилбаруудыг тооцох хэрэгтэй.

Бохирдолтой усыг унданд хэрэглэснээр эрүүл мэндэд эрсдэл учрах тохиолдолд айл гэрийн худгийн ус ашиглахыг хориглож, нийтийн усан хангамжаар хангаснаар эрсдлийг арилгана. Цэвэршүүлэх ажлын төслийг боловсруулахад өртөлтийн өөр (бага хохирол учруулах) хувилбар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

Venting in-situ аргачлалын хувьд эсвэл альтернатив аргачлал болох бохирдолтой хөрсийг сонгож олборлох тохиолдолд цэвэршүүлэх ажлын өөр хязгаарыг тогтооно.

Ажилд зарцуулах цаг хугацааны талаас авч үзэхэд энгийн цэвэршүүлэх соруулах ажлын аргачлал ба геологийн орчинд угаах буюу химийн исэлдэх урвалыг ашиглах аргачлалын (өмнө нь тухайн талбайд илэрч байгаагүй ч цэвэршүүлэлтийн хязгаарыг үнэрт нүүрсустөрөгч, хлортустөрөгчөөр нэмж оруулах) хувьд ажилд зарцуулах хугацаа нэлээд зөрүүтэй байна.

Эцсийн цэвэршүүлэлийн хязгаарыг тодорхойлоход өртөлтийн хувилбар тус бүрийн ноцтой байдал, тохирох цэвэршүүлэх технологийн боломж ба ажлын дарааллыг харгалзан үзнэ.

Хэрэв цэвэршүүлэх ажлыг үе шаттай явагдахаар тооцсон бол эхний шатуудад технологийн хувьд боломжтой хөнгөн хэлбэрийн цэвэршүүлэх ажлыг сонгох ба илүү ажлын үе шатуудын үед хуримтлуулсан мэдээлэл, туршлагад үндэслэн илүү сайжруулсан өөрчлөлт оруулах боломжтой биет ба журамтай тогтолцоог тодорхойлно. Хэрэв байгалийн жамаар нөхөн сэргэх үйл явцад тухайн талбайн бохирдол цэвэрлэгдэхээр тооцоолоогүй бол сүүлийн шатны ажлын цэвэршүүлэлтийн хязгаар нь зорилго биелэгдэх баталгаа болно.

Цэвэршүүлэх ажлын хязгаарууудын зэрэгцээ зорилгыг биелүүлэх оновчтой аргын санал боловсруулна.

Цэвэршүүлэх ажлын болзошгүй эрсдлийг дүгнэх ба тодорхойлох

Залруулах арга хэмжээний үед буюу цэвэршүүлэх ажлын явцын дунд цэвэршүүлэлтийн ажлын эрсдлийг, байгаль орчинд учрах хохирлыг ж-нь: аюултай химийн бодистой харьцахад (хамгаалалтын тусгай хэрэгсэл ашиглах) тооцох.

Тодорхой бус байдлыг багасгахад авах арга хэмжээний зөвлөмж

Эрсдлийн анализыг судалгааны тодорхой шатанд боловсруулна. Цэвэршүүлэх ажлыг хэрэгжүүлэх эхлүүлэх шийдвэр гаргахад, бохирдлын хэмжээг хангалттай тогтоох боломжгүй байдал зарим үед тохиолдоно (барилгын доорхи, газар доорхи байгууламжын бохирдлын голомт, эрсдэлтэй бодистой нүх суваг эсвэл үр дүнг урьдчилан таамаглах боломжгүй, цэвэршүүлэх ажлын санал өөрөөр хэлбэл аргачлалыг илүү оновчтой болгох шаардлагатай мэдээлэл байхгүй нөхцөлд). Цэвэршүүлэх өмнөх судалгаагаар шинэ мэдээлэл цуглуулах боломжгүй тохиолдолд тодорхой бус байдлын түвшинг бууруулахын тулд дараах шатчилсан цэвэршүүлэх ажиллагааны санал боловсруулах зайлшгүй шаардлагатай:

- Илрүүлсэн бохирдлын голомтын эх үүсвэрийн орон зайн болон концентрацын параметрүүдийг шалгах цэвэршүүлэх эсвэл нэмэлт судалгаа, олборлосон бохирдолтой хаягдлыг ялгахад шаардлагатай цэвэршүүлэлтийн тусгай онцлогтой мониторинг.
- Оновчтой техникийн тохиргоо хийх зорилгоор цэвэршүүлэх технологийн анхны туршилтын эсвэл үйлдвэрийн загварын туршилт хийх.

Мониторингийн аргачлалын зөвлөмж

Цэвэршүүлэх ажлын ба түүний дараах мониторингийн санал, хийгдэх ажлын хэмжээ (аргачлал, ажлын хэмжээ, хэдэн удаа хийгдэх, байгууламжуудыг хянах мониторингийн сүлжээ, хянах шаардлагатай үзүүлэлтүүдийн жагсаалт) ба ажлын үр дүнг тооцох зарчим, тавигдах хязгаарлалтууд буюу цэвэршүүлэлтийн хязгаарлалтууд зэрэг нь эрсдлийн анализын салшгүй хэсэг байна.

Санал болгосон хувилбаруудын зардлын тооцоо

Энэхүү бүлэгт залруулах арга хэмжээний хувилбаруудын санхүүгийн асуудлыг авч үзнэ. Эрсдлийн үнэлгээний бүлэгт тооцоо буюу цэвэршүүлэх арга хэмжээ болон бусад

шаардлагатай ажлын хувилбаруудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх зардлын мэргэжлийн тооцоог хэрхэн боловсруулахыг харуулсан байгаа.

5. Төгсгөл ба зөвлөмж

Энэхүү тайлангийн эцсийн бүлэгт судалгааны ажлын хамгийн гол үр дүнгийн дүгнэлт, эрсдлийн үнэлгээ ба дараа авах арга хэмжээний саналын зөвлөмжүүд, эцсийн үзүүлэлтүүд зайлшгүй байх шаардлагатай. Эдгээр үр дүнг нэн тэргүүнд анхаарах шаардлагатай бохирдолтой талбайг шинэчлэн тогтооход ашиглана.

Энэхүү бүлэг дараах мэдээллээс бүрдэнэ:

- Эрсдлийн үнэлгээний хүрээнд хийгдсэн геологийн ажлын үр дүн ба түүний дүгнэлт
- 3.4-р бүлгийн гол дүгнэлтүүдийг нэгтгэсэн дүгнэлт (Нийт эрсдлийг дүгнэх).
- 4.1 -р бүлгийн гол зөвлөмжүүдийн дүгнэлт (Эцсийн үзүүлэлтүүдийн зөвлөмж) ба 4.2 (Санхүүжилтээс хамаарах залруулах арга хэмжээний зөвлөмж).
- Ажлын зорилгоос хамаарах үр дүнг ашиглах боломжыг тайлбарлах эсвэл түүнтэй хамааралтай асуудлыг шийдвэрлэх санал (тодорхой бус байдлыг арилгахтай холбоотой).

Эрсдлийн үнэлгээний үр дүнгийн тайлангийн төгсгөлд хариуцан боловсруулсан хүний нэр, гарын үсэг байх ба тамга дарж, он, сар, өдрийг бичнэ.

Ашигласан ном хэвлэл

Товчилсон үгийн жагсаалт

Хавсралтуудын жагсаалт

11. ХАВСРАЛТ 4 – Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний зарчмууд

Энэхүү хавсралт нь байгаль орчны бохирдлын эрсдлийн үнэлгээний ажлын хүрээнд үнэлгээ хийх журмын ерөнхий тоймын үүрэг гүйцэтгэнэ. Хавсралт 6-д эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний арга, үнэлгээний зарчмын мэдээллийн эх үүсвэрийг ашиглах холбоосуудыг зааж өгсөн.

Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ (Health Risk Assessment) нь бохирдолтой талбайн эрсдлийн анализын нэг хэсэг бөгөөд шийдвэрлэх гаргах үйл явц болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний салшгүй хэсэг байна. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ нь тодорхой нөхцөлд хүний эрүүл мэндэд учрах боломжтой эрсдэлээс хамаарах ба эрсдлийн хэмжээ нь эрсдэлгүй байдлаас хамгийн дээд хэмжээ хүртэлх эрсдлийн хэмжээ нь үйл ажиллагааны төрлөөс хамаарах өөрөөр хэлбэл тухайн газарт байсан эсэх байгаль орчны нөхцөл байдал (ж-нь: газрын, усны, агаарын, хүнсний бүтээгдэхүүний бохирдлын хэмжээ) зэргээс шалтгаална. Эрүүл мэндийн эрсдэлгүй буюу 0 эрсдэлтэй нөхцөл нь энэхүү зорилгыг биелүүлэхэд шаардагдах ихээхэн хэмжээний эдийн засгийн зардлаас үл хамааран практикын хувьд боломжгүй. Эсрэгээр нь зайлшгүй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж тэвчишгүй эрсдэлийг бууруулж хүний эрүүл мэнд болон экологийн эрсдлийг тэвчих боломжтой түвшинд хүргэх шаардлагатай.

Бохирдолтой талбайн эрсдлийн анализын хүрээний эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ нь эдийн засгийн зардал ихтэй цэвэршүүлэх ажлыг тодорхойлдог. Тиймээс үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдээс зайлсхийж тодорхойгүй шийдвэр гарах магадлалыг багасгах хэрэгтэй. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг хийхдээ хөрсний бохирдлыг бусад төрлийн бохирдолтой эрх зүйн заалтуудтай харьцуулж тогтооход ажиглалт судалгаа хийж буй газрын ач холбогдол, хүлээгдэж буй эрүүл мэндийн үр нөлөөний талаарх бодит, логик дүгнэлтийг үндэслэнэ. Өртөлтийн үед дээж авахад ажлын зөв дарааллыг (тохиромжтой газрыг, авах дээжний төрөл, тоо зэргийг зөв сонгох) баримтлах нь маш чухал ба эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний ажлын үед нэгдсэн арга зүйн дагуу хамгийн сүүлийн үеийн жишиг лавламж мэдээлэл ашиглаж бусад хүчин зүйлүүдийг тооцох шаардлагатай.

Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний аргачлал нь 6 үндсэн алхамаас бүрдэнэ:

1. Аюулыг тодорхойлох (hazard identifcation)
2. Тун - хариу үйлчлэлийн харьцааг тодорхойлох (evaluation of dose - response relationship)
3. Өртөлтийн үнэлгээ (exposure assessment)
4. Эрсдлийн шинж чанар (risk characterisation)
5. Эрсдлийн удирдлага (risk management)
6. Эрсдлийн харилцаа (risk communication)

Энэ аргачлалын хүрээнд 4 алхамын асуудлыг авч үзнэ.

1. Аюулыг тодорхойлох

Хавсралт 3, Бүлэг 3.1-т Аюулыг тодорхойлох талаар тайлбарласан.

2. Тун хэмжээ – нөлөөний харьцааг тодорхойлох

Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээн хийхэд тун-хариу үйлчлэлийн харьцааг мэдэх зайлшгүй шаардлагатай. Үнэлгээ хийхэд босго үзүүлэлт байгаа эсэхээс хамааран 2 төрлийн аргыг ашиглана.

Босго үзүүлэлттэй бодисын (хорт хавдар үүсгэхгүй) концепцийн үнэлгээ

Хорт хавдар үүсгэх нөлөөгүй химийн бодисын хувьд физиологийн, дасан зохицох, хувирах үйл явц явагдыг тооцох ба эдгээрийн дүнд хүний бие организм олон төрлийн хортой бодисын өртөлтийн нөлөөтэй дасан зохицдог. Химийн бодис болон тэдгээрийн нэгдлүүд нь олон төрлийн нөлөөтэй учраас эрсдлийн таамаглалыг тооцохдоо өртөлтийн хамгийн бага түвшингийн аюул учруулах үйлчлэлийг анхаарна. Хэрэв аюул учруулах нөлөөгүй үед өртөлт (тун) с маш бага эрсдэлтэй байдаг.

Янз бүрийн өртөлтийн тунг авахад бодисын хоруу чанарыг тодорхойлж тун-хариу үйлчлэлийн харьцааны мэдээлэлд оруулна. Тун-нөлөөний харьцааг тодорхойлоход аюулгүйн хүчин зүйлийн (тодорхой бус байдлын хүчин зүйлүүд) аргачлалыг ашиглана. Үр удамд хортой нөлөөтэй бодисоос бусад хортой бодисуудын хувьд хамгийн бага болон эрсдэлгүй өртөлтийг тодорхойлсон байдаг. Энэхүү үзүүлэлтийг босго үзүүлэлт хэмээн нэрлэдэг.

Босго үзүүлэлт NOAEL (No Observed Adverse Effect Level) гэж нэрлэх ба ийм тохиолдолд үед сөрөг нөлөөгүй гэж үзэх ба амьтан дээр хийх туршлагаар тодорхойлж болно. Мөн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй болох нь батлагдсан бага хэмжээний өртөлтийн тунг авахад өөр арга болон LOAEL (Lowest Observed Adverse Effect Level) ашиглана. Эдгээр тунг ашиглаж тодорхой бус байдлын UF (Uncertainty Factors) болон хувиргах хүчин MF (Modifying Factors) зүйлсийг үндэслэн хүлцэх боломжтой өдрийн тунг мөн Дэлхийн эрүүл байгууллага WHO, U.S. EPA ашигладаг хяналтын тунг RfD (Reference Dose) тодорхойлдог. Тодорхой бус байдлын хүчин зүйлс нь NOAEL эсвэл LOAEL тодорхойлох үеийн тодорхой бус болон хувьсаж өөрчлөгдөх байдлыг тэнцвэртэй болгоно.

UF1 (үзүүлэлт 10) хүн амын янз бүрийн бүлэг, мэдрэмтгий бүлгийн хамгааллыг илүү анхаарах ;

UF2 (үзүүлэлт 10) хүн ба амьтны хариу үйлчлэлийн ойролцоо утгын тодорхой бус байдлыг харгалзах;

UF3 (үзүүлэлт 10) удаан хугацааны туршид явагдсан судалгаанаас илүүтэй хэсэгчилсэн судалгааг үндэслэх;

UF4 (үзүүлэлт 10) NOAEL оронд LOAEL үзүүлэлтүүдийг авч үзэх;

MF (үзүүлэлт 1 - 10) мэргэжлийн дүгнэлтээс үүсэх тодорхой бус байдлыг авч үзэх.

RfD тооцоход гарах утга нь анхны NOAEL ба LOAEL үзүүлэлтүүдээс хэдэн оронгоор бага байдаг. RfD нь (1 орны нарийвчлалтай) насан туршдаа өдөр тутам бохирдолд өртсөн ч эрүүл мэндийн эрсдэлгүй байх өндөр магадлал (хүн амын мэдрэмтгий бүлгийн хамруулсан). Хамгийн өндөр магадлалтай системийн хоруу чанарын хувьд RfD түвшингээс бага өртөлтийн тун авахыг эрсдэлд тооцохгүй. RfD - н тоон утга ихэвчлэн мг.кг$^{-1}$.өдөр хэмжих нэгжтэй байдаг ба нэр хүндтэй мэдээллийн сан болох IRIS, PPRTV, ATSDR, RAIS болон эх үүсвэрт (viz Příloha č. 6) jsou **амаар дамжих өртөлттэй** (залгих)

холбож үзсэн байдаг. Урт хугацааны амаар дамжих RfD - г 7 жилээс дээш үргэлжилсэн хорт хавдар үүсгэхгүй өртөлтийн үед ашигладаг (ойролцоогоор хүний амьдрах хугацааны 10 %).

Арьсаар хүлээн авсан жишиг тун Зарим тохиолдолд **а**маар дамжих өртөлтийн жишиг тун RfD_o – н утгыг ашиглан дараах тэгшитгэлийн дагуу RfD_{ABS} (EPA, 2004) тооцдог:

$$\mathbf{Rfd_{ABS}\ (мг.кг^{-1}.өдөр^{-1}) = Rfd_o\ (мг.кг^{-1}.өдөр^{-1})\ x\ ABS_{GI}}$$

ABS_{GI} – ходоод гэдэсний замд шингэсэн бохирдуулагчын фракц (ABS_{GI} - г Хавсралт 6 – гийн мэдээллийн сангаас олж болно). Энэ аргыг өртөлтийн газарт шууд нөлөөлөх зарим бохирдуулагчын хувьд ж-нь: бензопирентэй харьцахад арьсны хорт хавдар үүсэх боломжтой учир ашиглаж болохгүй. Аливаа хувиргах факторыг ашиглахдаа тухайн өөрчлөлт нь мэдээллийн сангийн хоруу чанарын жишиг мэдээлэлд хамрагдсан эсэхийг шалгах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд IRIS (Integrated Risk Information System) мэдээллийн санг ашиглах нь зүйтэй.

Одоогийн байдлаар **амьсгалаар дамжих өртөлтийн хувилбарт** RfD- н оронд жишиг концентраци RfC ($мг.м^{-3}$) ашиглаж ирсэн. Жишиг концентрацийг жишиг тунд шилжүүлэн тооцоход бохирдуулагчын концентраци RfC адил, 70 кг биеийн жинтэй, өдөрт 20 $м^3$.$өдөр^{-1}$ хэмжээний урьдчиласан таамагласан агаараар дамжих өртөлтөнд өртөх зэргийг тооцож дараах тэгшитгэлийг ашиглана:

$$\mathbf{Rfd\ (мг.кг^{-1}.өдөр^{-1}) = RfC\ (мг.м^{-3})\ x\ 20\ м^3.өдөр^{-1}\ x\ 70\ кг^{-1}}$$

Ойлгомжгүй болон өртөлт тархах олон замтай тохиолдолд тоон утгыг тооцоолох боломжгүй бөгөөд мэргэжлийн эмнэлгийн байгууллага мөн ECAO (U.S. EPA Environmental Criteria and Assessment Office) байгууллагын оффистой зөвлөсний үндсэнд эрсдлийн чанарын үнэлгээг хийнэ.

Босго үзүүлэлттэй (хорт хавдар үүсгэх нөлөөтэй) бодисын үнэлгээний зарчим

Хорт хавдар үүсгэх нөлөөтэй бодисуудын үйлчлэлийн дүнд гарах молекулын түвшингийн багахан хэмжээний өөрчлөлт нь нэг эс хяналтгүйгээр олон дахин үржих явцыг идэвхжүүлснээр хорт хавдар үүсэх нөхцлийг бүрдүүлдэг. Онолын хувьд эдгээр бодисын өртөлтийн аюулгүй түвшин гэж байдаггүй ба энэхүү үйлчлэлийг босго үзүүлэлт хэмээн нэрлэдэг. Хожмын үйлчлэлийг удаан хугацааны өртөлтийн эрсдлийн үед, хүн амьдралынхаа явцад тухайн бодисын нөлөөнд хэрхэн өртөх байдлыг харгалзан тооцно. Өртөлтийн өсөх явц ба хорт хавдар үүсэх насан туршын эрсдэл нь хоорондоо шугаман регрессийн хамааралтай байдаг.

K hodnocení vztahu dávka - účinek je všeobecně nejrozšířenější využití faktoru směrnice SF (Slope Factor), kterým se obecně rozumí biologicky možný horní okraj odhadu pravděpodobnosti vzniku zhoubného novotvaru vztažený na jednotku průměrné denní dávky přijímané po celý život. Určování faktoru směrnice je problematické pro nedostatek dat o rizicích spojených s expozicí v oblasti nízkých dávek. Z těchto důvodů se používají řady extrapolačních modelů, jejichž výběr modelu musí vycházet ze znalosti karcinogenního mechanismu. Hodnoty SF (nejčastěji pro **ingesční expozici**) jsou pro vybrané kontaminanty dostupné v renomovaných databázích (viz Příloha č. 6).

Арьсаар хүрэлцэх өртөлтийг EPA (2004) дагуу арьсны хүчин зүйлийн удирдамжыг SF_{ABS} амаар дамжих хүчин зүйлийн удирдамж SF_o ба ABS_{GI} коэффициентыг үндэслэн дараах тэгшитгэлээр бодно:

$$SF_{ABS}\ (мг.кг^{-1}.өдөр^{-1})^{-1} = SF_o\ (мг.кг^{-1}.өдөр^{-1})^{-1} \times ABS_{GI}^{-1}$$

SF нь тухайн бохирдуулагчыг хүлээж авах нэгж тунтай холбоотой ба 1 мг.кг$^{-1}$ тунг амаар хүлээн авах буюу дамжих үеийн тухайн бодисын хорт хавдар үүсгэх нөлөөний эрсдлийг тодорхойлох ба SF - нь хэмжих нэгжтэй байна (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)$^{-1}$.

Амьсгалын замын өртөлтийн үед Inhalation Unit Risk (амьсгалах нэгжийн эрсдэл) IUR ашигладаг ба 1 мг.м$^{-3}$ (эсвэл 1 µg.м$^{-3}$) концентрацитай бодисын өртөлтийн байнгийн нөлөөнд хорт хавдар үүсэх насан туршын эрсдлийн магадлалын дээд хязгаартай адил байх ба (мг.м$^{-3}$)$^{-1}$ хэмжих нэгжтэй.

Жишиг тун, концентраци буюу удирдамжын хүчин зүйл ба амьсгалах нэгжийн эрсдлийг эрсдлийн анализын шаардлагатай үед мэдээллийн сангийн эх үүсвэрээс авах ба холбогдох мэдээллийн сангийн мэдээллийн хүчинтэй байдлыг хянаж, ашигласан мэдээллийн эх үүсвэрийг бичнэ.

Онцгой тохиолдолд (мэдээллийн санд шаардлагатай мэдээлэл байхгүй, бохирдлын хэмжээ ноцтой ба залруулах арга хэжээний дараагийн ажил болох үйл ажиллагаа “тун-хариу үйлчилгээг” тодорхойлох үед зайлшгүй шаардлагатай) RfD эсвэл SF ойролцоо эсвэл шинэ утгыг тодорхойлох боломжыг тооцох ба адил үйлчилгээтэй бодисын үзүүлэлтүүдийг ашиглаж болно. Ингэж ашиглах болсон шалтгааны хангалттай үндэслэлийг зайлшгүй оруулна.

3. Өртөлтийн үнэлгээ

Хавсралт 3, бүлэг 3.2-т тайлбарласан. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ

4. Эрүүл мэндийн эрсдлийг тооцох (эрсдлийн шинж чанар)

Энэхүү өртөлтийн бодит тооцоо (хүлээн авсан буюу шингэх тун) бүхий эрсдлийн анализын сүүлийн шат нь эрсдлийн хэмжээтэй адил бөгөөд тогтоосон эрсдлийн аман үнэлгээг хийдэг.

Босго үзүүлэлттэй бодисын (хорт хавдар үүсгэдэггүй) эрүүл мэндийн эрсдлийг тооцох

Хорт хавдар үүсгэх нөлөөгүй өртөлтийн эрсдлийг тооцоход хүлцэх боломжтой хоруу чанартай бодисын өдөрт хүлээн авсан ба шингээсэн тунг жишиг тунг RfD эсвэл бохирдолтой агаарын концентрацийн тодорхойлсон утгыг жишиг концентрацитай харьцуулж тодорхойлно.Эрүүл мэндийн эрсдлийг тооцоход гэнэтийн, удаан ба хэсэг хугацааны өртөлтийг ялгах шаардлагатай ба холбогдох жишиг тун, концентрацийг ашиглана. Эрсдлийн хэмжээг аюултай байдлын харьцуулсан тоо (Hazard Quotient, хэмжих нэгжгүй) илэрхийлдэг ба дараах хялбар тэгшитгэлээр тооцно:

$$HQ = E / RfD$$

E удаан хугацаанд бохирдуулагчыг хүлээн авах өдрийн тун CDI (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$) эсвэл шингэх дундаж тун ADD

RfD жишиг тун (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)

Амьсгалаар дамжих өртөлтийн хувьд:

$$\mathbf{HQ = C_A / RfC \times 1000\ мг.м^{-1}}, \text{ эсвэл. } \mathbf{HQ = EC / RfC \times 1000\ мг.м^{-1}}$$

C_A гэнэтийн өртөлтийн үеийн агаар бохирдуулагчын хэмжсэн концентраци (мг.м$^{-3}$)
EC урт эсвэл хэсэг хугацааны өртөлтийн дундаж концентраци (мг.м$^{-3}$)
RfC жишиг концентраци /хоруу чанарын үзүүлэлт (мг.м$^{-3}$)

Олон тооны бохирдуулагч нөлөөлөх тохиолдолд аюултай байдлын хураангуй харьцуулах тоог авч үзнэ:

$$\mathbf{HQ_S = HQ_a + HQ + HQ + \ldots + HQ_n}$$

Аюултай тодорхой өртөлтийг HQ > 1 утга илэрхийлдэг.

Богино хугацааны өртөлтийн хувьд удаан ба хэсэг хугацааны үйлчлэлийн харьцуулсан тоог тусад нь тооцохыг зөвлөдөг. Удаан хугацааны туршид аюул учруулахгүй гэхдээ богино хугацааны өртөлтийн үед эрүүл мэндэд гэнэтийн эрсдэл учруулж, үхэлд хүргэж болзошгүй байдал нэлээд тохиолддог. Тиймээс хоруу чанарыг тодорхойлохдоо гэнэтийн аюул (ж-нь: гэнэтийн огцом хордлого, идэмхий чанар гм) учруулах шинжийг дурдах шаардлагатай. Эдгээр параметрүүд нь ажлын байранд эрсдлээс урьдчилан сэргийлэхэд (тохирох урьдчилан сэргийхлэх арга хэмжээ авахад, ажлын хамгаалах хэрэгслийг сонгоход гм) ялангуяа залруулах арга хэмжээний үед ашиглагдана.

Хорт хавдар үүсгэх нөлөөтэй бодисуудын эрүүл мэндийн эрсдлийн таамаглал

Хорт хавдар үүсгэх их хэмжээний **н**асан туршын эрсдлийг тооцоход ELCR - Excess Lifetime Cancer Risk (насан туршын өртөлтийн хавдар үүсэх магадлалд тулгуурласан нэгжгүй үзүүлэлт) ерөнхий хялбар тэгшитгэлийг ашиглана:

$$\mathbf{ELCR = LADD \times SF}$$

LADD өдөрт авах дундаж тун - 70 жилийн өртөлтийн хугацаанд (мг.кг-^{1}.өдөр$^{-1}$)
SF удирдамжын фактор (мг.кг-^{1}.өдөр-^{1})-^{1}

Энэхүү тооцоо лох арга нь бага эрсдлийн буюу 0,01 (100 хүн тутмын 1 хүнд хорт хавдар үүсэх магадлал) үед ашиглагдана. Их хэмжээний эрсдлийн үед хувиргасан тэгшитгэл ашиглахыг зөвлөмж болгодог:

$$\mathbf{ELCR = 1 - exp^{(-LADD \times SF)}}$$

Амьсгалын замын өртөлтийн үед тогтоогдсон буюу агаар дахь бохирдуулагчын концентрацийг амьсгалах нэгжийн эрсдлийн IUR амьсгалах нэгж (inhalation unit) утгаар үржүүлж бодно:

$$\mathbf{ELCR = C_A \times IUR} \text{ resp. } \mathbf{ELCR = EC \times IUR}$$

C_A агаар дахь бохирдуулагчын хэмжилт хийсэн концентраци (мг.м$^{-3}$)
EC өртөлтийн дундаж концентраци (мг.м$^{-3}$)
IUR амьсгалах нэгжийн эрсдэл (мг.м$^{-3}$)$^{-1}$

Өртөлтийн концентраци EC - г IUR -тай харьцуулахад өртөлтийн бодит хувилбарыг дүгнэж, цаг хугацаатай холбоотой үзүүлэлтүүдийг ашиглана. Эдгээр тооцоог өдрийн

хүлээн авах тунгийн тэгшитгэлтэй адил хийнэ (амьсгалсан хэмжээ ба биеийн жинг тооцохгүйгээр:

$$EC = C_A \times ET \times EF \times ED / AT$$

ET өртөлтийн хугацаа (цаг.өдөр$^{-1}$)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$)
ED өртөлтийн хугацаа (жил)

Үзүүлэх үйлчлэлийн магадлал 95% байдаг учраас тооцоолсон ELCR утга нь ихвэчлэн эрсдлийн дээд хязгаарыг илэрхийлэх ба бодит эрсдэл үүнээс ихгүй байна.

Хүлцэх боломжтой эрсдэлд дараах ELCR үзүүлэлтүүдийг тооцно:

1.10^{-6} (1 сая хүн тутмын 1 хүнд хорт хавдар үүсэх магадлал) бүс нутгийн үнэлгээний үед – ихэвчлэн 100 дээш тоотой хүн ам аюулд өртсөн

1.10^{-5} (100 000 хүн тутмын 1 хүнд хорт хавдар үүсэх магадлал) орон нутгийн үнэлгээний үед- 10 - 100 хүртэлх хүн ам аюулд өртсөн

1.10^{-4} (10 000 хүн тутмын 1 хүнд хорт хавдар үүсэх магадлал) 1-10 хүртэлх хүнд үнэлгээ хийхэд

SF утга тогтоогдоогүй бодис эсвэл өртөлтийн тархалтын олон зам холилдсон тохиолдолд , эрсдлийн тоон утгыг тооцохгүй ба зөвхөн чанарын үнэлгээ хийх эсвэл мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага болон ECAO (U.S. EPA Environmental Criteria and Assessment Office) байгууллагын оффистой холбоо барьж зөвлөгөө авна. Олон тооны бохирдуулагч (нэг эрхтэнд адил байдлаар нөлөөлөх) нэг зэрэг үйлчлэх үед хорт хавдар үүсгэхгүй нөлөөний үйлчлэлтэй адил тэдгээрийн илүү хүчтэй нэгдмэл үйлчлэлийг тооцох ба энэхүү нөхцлийг эрсдлийн үнэлгээ хийхэд анхаарах шаардлагатай.

11.1 Өртөлтийн хувилбаруудын ба тооцооны журмын жишээ

Хүний биед бохирдуулагч нөлөөлөх өртөлтийн ердийн хувилбарыг талаарх мэдээллүүдийг дараах хэсэгт багтаасан. Хүний хүлээн авсан болон хүний биед шингэсэн тунгийн хэмжээг тооцох үндсэн тэгшитгэлүүд мөн эдгээр тэгшитгэлд ашиглагдах тогтмол болон хувьсах тоонуудыг тухай оруулсан байгаа.

Хувилбаруудыг эцсийн, өөрчлөх боломжгүй хэмээн ойлгож болохгүй ба тухайн талбайн өртөлтийн бодит байдлыг дүгнэж, судалгаа шинжилгээний нь боломжит бүх мэдээлэл, эрдэм шинжилгээний ажлын сүүлийн үеийн үр дүн зэрэгт тулгуурлан өөрчлөх шаардлагатай.

Өртөлтийн хувилбар нь өртөлт тархах замын төгсгөлийн хэсэг бөгөөд бохирдлын голомтоос өртсөн газар хүртэлх өртөлт тархах замыг багтаасан байдаг. Тиймээс хувилбаруудыг хээрийн нөхцөлд хэмжилт хийсэн үзүүлэлтүүд эсвэл тээврийн замтай холбож үзэж болохгүй. Бохирдлын голомтоос өртсөн газар хүртэлх өртөлт тархах замыг мөн бохирдол тархалтын явцад гарах өөрчлөлтүүдийг тухайн орчны байгалийн нөхцөл (геологи, гидрогеологи, гидрологи, хур тунадасны ба температурын нөхцөл гм), техник технологийн (ж-нь: хүний үйл ажиллагааны хүчин зүйл, өртөлтийн талбайд хүрэх боломж, мэдээлийн байдал ба бохирдол хүлээн авагчын хамгаалал гм) нөхцлийг харгалзан тусгайлан дүгнэх шаардлагатай.

Эрсдлийн анализыг боловсруулагч нь үнэлгээ хийж буй талбайн тохирсон өртөлтийн тархалтын замууд ба хувилбаруудыг боловсруулж, холбогдох параметрүүдийг тодорхойлж, тэдгээрийн үндэслэлийг тайлбарлана. Ихэнх тохилдолд өртөлтийг шууд хэмжих боломжгүй ба өртөлтийн хувилбарууд нь өртөлтийн талбайн байгаль орчны бүрдэл хэсгүүдийн бохирдуулагчын концентрацийн тооцоог агуулсан байх шаардлагагүй. Тооцооны үр дүнгийн шаардлага хангах байдал нь тухайн талбайн тодорхой нөхцөл байдлаас, ашиглах хэмжилтийн, тооцож гаргасан мэдээллийн чанар, эрсдлийн анализ боловсруулагчын мэргэжлийн чадавхи зэргээс шалтгаална. Тухайн өртөлт дамжих замын хувьд орох мэдээллийн буюу өгөгдлийн мэдээллийн параметрүүдийг сонгох, дээд доод хязгаар үзүүлэлтүүдийг тодорхойлох, үндэслэлийг тайлбарлах ажлыг боловсруулагч хариуцан гүйцэтгэнэ.

Өртөлтийн хувилбарын тоймд хэд хэдэн янзаар хандах ба дараах хувилбаруудын ангилал хамгийн элбэг тохиолдоно:

- өртөгчийн төрөл (хөрс ба хатуу бодис, ус, агаар, хүнсний бүтээгдэхүүн);
- өртөлт дамжих зам (уух, амьсгалах, арьсаар хүрэлцэх, цацараг идэвхт нөлөө);
- газар ашиглалтын төрөл (хүн ам оршин суудаг, амралт зугаалгын, үйлдвэрийн, газар тариалангийн, холимог) ба хүн амын мэдэгдэж байгаа тоог нарийвчлах (насанд хүрэгсэд /эр, эм/, хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд ба бусад мэдрэмтгий бүлгүүд) эсвэл өртөлт үүсгэх үйл ажиллагааны үед (амралт, хөнгөн ажил, ердийн ажил,чөлөөт цагийн үйл ажиллагаа, биеийн хүчний болон спортын их ачаалалтай үйл ажиллагаа гм);
- бохирдуулагчын төрөл ба тэдгээрийн харилцан үйлчлэл (ж-нь: органик, органик бус, дэгдэмхий, дэгдэмхий бус, хорт хавдар үүсгэх нөлөөтэй, хорт хавдар үүсгэх нөлөөгүй).

Бодит хувилбар бүр нь дээр дурдсан хүчин зүйлүүдийн хамруулсан ба холбогдох тодорхойлолтуудаар баталгаажсан (үйл ажиллагааны явцад өртөлт үүсч болзошгүй байдлын тайлбар).

Дараагийн хүснэгт 4.1- т хамгийн түгээмэл хувилбарын матрицыг харуулсан ба хамгийн гол ангиллыг өртөлт дамжих хэлбэрийн (амаар дамжих, арьсаар дамжих, амьсгалаар дамжих) ангиллыг үндэслэн хийсэн. Үүний дараагийн хувилбар тус бүрийг бохирдолтой байгаль орчны орчны бүрдэл хэсгүүд, холбогдох өртөлтийн төрлийн дагуу жагсаасан.

Өртөлтийн хувилбарын параметр тус бүрийн хувьд тэдгээрийн ердийн утга мөн дээд, доод хязгаарыудыг зааж өгсөн. Эдгээр параметрүүдийг тухайн талбайн (ялангуяа цаг уурын байдлаас шалтгаалах өртөлтийн давтамж ба хугацаа) бодит байдлыг харгалзан илүү нарийвчлан тодорхойлж, үндэслэлийг тайлбарлах шаардлагатай.

Энэ **өртөлтийн аргачлалын** зааварт багтсан параметрүүдийг БН Чех Улсын Байгаль орчны яамны Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээний аргачлал мөн Exposure Factors Handbook U.S. EPA зэргийг үндэслэн тодорхойлсон бөгөөд **европ-америкийн хүн амын шинж чанарыг** агуулсан байдаг. Хүний биеийн жин, дундаж наслалт болон бусад параметрүүд нь Монголын хүн амын физиологийн онцлогт тохирохгүй байж болно. Мөн өртөлтийн хугацаа, давтамж зэрэг нь **төв европын уур амьсгалын нөхцөлд** тохирсон болно.

Өртөлтийн тунг тодорхойлоход ашиглах өртөлтийн параметрүүдийг зорилтот хүн ам болон онцгой нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх шаардлагатай.

Зөвлөмж болгож буй параметрийн үзүүлэлтүүд нь насанд хүрэгсэд (эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн дундаж үзүүлэлт) ба 6 хүртэлх хүүхдийн хувьд тодорхологдсон.

Тайлбар – Бага насны хүүхдүүдийг байгаль орчны өртөлтийн үед онцгой мэдрэмтгий бүлэгт тооцдог. Хүүхдийн өсөлтийн үед олон тооны хортой бодисын хувьд хүүхдийн бие организмын бодисын солилцоо ба хоргүйжүүлэх чадвар нь буурсан байдаг. Хүүхдийн биеийн аливаа эрхтний хортой бодисын нөлөөнд мэдрэмтгий чанар нь том хүнийхээс илүү байдаг. Хорт хавдар үүсгэх нөлөөтэй хүний генд хортой нөлөөлөх бохирдуулагчид (PAU) өртөх үед хувь хүний эрүүл мэнд, өсөлт хөгжилтөнд ноцтой үр дагавар үзүүлнэ.

Tab. 4.1 Өртөлтийн ердийн хувилбаруудын тойм

Өртөлтийн төрөл	**Өртөгчийн төрөл**	**Газар ашиглалт území**	**Өртөлтийн хувилбарын жишээ**
Уух	„ундны“ ус	байнга оршин суугч амрагч	Ус уух ба усаар бэлтгэсэн ундаа (бүтэн өдөр)
		үйлдвэрийн газар тариалангийн	Ус уух ба усаар бэлтгэсэн ундаа (заримдаа)
	бусад ус	байнга оршин суугч амрагч	Усанд сэлэх үед санамсаргүй уусан
		байнга оршин суугч амрагч	Усанд орох үед санамсаргүй уусан
	Хөрс эсвэл шороо тоос	байнга оршин суугч амрагч	Гадаа ажиллах үед шороо амаар дамжих (залгих) (том хүн, хүүхэд)
		газар тариалангийн	Улирлын чанартай ажлын үед хөрс болон тоосонцор амаар дамжих (залгих)
		үйлдвэрийн	Цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед санамсаргүй амаар дамжих (залгих)
	Жимс ба хүнсний ногоо	амрагч газар тариалангийн	Өөрийн бүтээгдэхүүнийг хэрэглэх
	мах	амрагч газар тариалангийн	Өөрийн бүтээгдэхүүнийг хэрэглэх
	Сүүн бүтээгдэхүүн	байнга оршин суугч газар тариалангийн	Өөрийн бүтээгдэхүүнийг хэрэглэх
	Загас	байнга оршин суугч	Орон нутагт барьсан загасыг хүнсэнд хэрэглэх

Арьсаар хүрэлцэх	ус	байнга оршин суугч амрагч	Усанд сэлэх үед арьсаар хүрэлцэх
		байнга оршин суугч амрагч	Усанд орох үед арьсаар хүрэлцэх
		үйлдвэрийн газар тариалангийн	Гар угаахад арьсаар хүрэлцэх
		үйлдвэрийн газар тариалангийн	Цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед арьсаар хүрэлцэх
	хөрс	үйлдвэрийн	Цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед арьсаар хүрэлцэх
		байнга оршин суугч амрагч	арьсаар хүрэлцэх (ж-нь: хүүхэд тоглох үед, насанд хүрэгсэд гадаа цэцэрлэгт ажиллахад)
Амьсгалах	Агаар мандал	байнга оршин суугч амрагч	Гадаа болон барилгын дотор бохирдолтой агаар амьсгалах
		үйлдвэрийн газар тариалангийн	Ажлын байранд бохирдолтой агаар амьсгалах
	Хөрсний агаар	үйлдвэрийн газар тариалангийн	Цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед бохирдолтой агаар амьсгалах
	Уснаас ялгарах агаар ба уур	байнга оршин суугч амрагч	Халуун усанд ороход уурыг амьсгалах
		байнга оршин суугч амрагч	Гадаа цэцэрлэгт усалгаа хийхэд уурыг амьсгалах

Ус уух

$$\mathbf{CDI = C_W \times IR \times EF \times ED / (BW \times AT)}$$

CDI удаан хугацааны өдөр тутмын хэрэглээ (мг.кг$^{-1}$.өдөр$^{-1}$)
C_W усан дахь бохирдуулагчын концентраци (мг.l^{-1})
IR өдөрт уусан усны хэмжээ (l.өдөр$^{-1}$)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$)
ED өртөлт үргэлжлэх хугацаа (жил)
BW биеийн жин (кг)
AT дундаж хугацаа (өдөр) – хорт хавдар үүсгэх нөлөөгүй : ED (жил) x 365 өдөр.жил$^{-1}$, хорт хавдар үүсгэх нөлөөгүй: 70 жил x 365 өдөр.жил$^{-1}$

Боломжит хувилбарууд:

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид/ ус уух ба усаар найруулсан ундаа уух

IR насанд хүрэгсдийн ердийн хэрэглээ: 1,4 - 2,0 l.өдөр$^{-1}$; бохирдолтой эх үүсвэрийн эзлэх хувийг тооцох (ж-нь: хэрэглээ: 60 % гэртээ, 40 % ажлын байранд)

Хүүхдийн ердийн хэрэглээ, 6 нас хүртэлх хүүхэд: 1,0 l.өдөр$^{-1}$

EF байнгийн өртөлтийн ердийн давтамж: 335 - 350 өдөр.жил$^{-1}$ (15- 30 өдөр гэрээс өөр газарт байрлах)*

Амрах үеийн ердийн давтамж: 45 - 75 өдөр.жил$^{-1}$ *

ED насан туршын өртөлт: 70 жил*

өртөлт үргэлжлэх хамгийн их хугацаа – тухайн газарт амьдрах хугацаа: 30 жил (20 - 40 жилийн хооронд)*,

амрагчын тухайн газарт амьдрах хугацаа: 9 жил*

хүүхдийн өртөлтийн хугацаа (6 нас хүртэл): 6 жил (дунджаар 3 жил)*

BW насанд хүрэгсдийн дундаж жин: 70 кг*

1 - 6 хүртэлх насны хүүхдийн дундаж жин: 15 кг (тухайн насны тодорхой жинг ашиглаж болно)*

<u>Үйлдвэр, худалдааны газруудад эсвэл газар тариаланд ажиллагсад/ ус уух ба усаар бэлтгэсэн ундаа уух</u> (савласан ус уухыг тооцоогүй)

IR насанд хүрэгсдийн ердийн хэрэглээ: 1 l.өдөр$^{-1}$, газар тариаланд 2 l.өдөр$^{-1}$, халуун орчин ба гадаах үйл ажиллагаанд: 4 – 11 l.өдөр$^{-1}$

EF өртөлтийн ердийн давтамж: 225 - 250 өдөр.жил$^{-1}$ („өрхийн фермерийн аж ахуй“ 350 өдөр.жил$^{-1}$ хүртэл)

ED 1 ажлын байранд байрлах урьдчилсан таамаглал: 25 жил*

** эдгээр үзүүлэлтүүдийг дараах ижил төрлийн хувилбаруудад ашиглах боломжтой*

<u>Жишээ</u>: Өртөлтийн уух хувилбар ба хорт хавдар үүсгэх нөлөөгүй бохирдуулагчын хүлцэх боломжтой эрүүл мэндийн эрсдлийг үндэслэн тооцоолсон бохирдуулагчын концентрацийн босго утга HI (ж-нь: HI = 1).

$$HI = CDI / RfD$$

$$CDI = C_W \times IR \times EF \times ED / (BW \times AT)$$

$$C_W = HI \times RfD / (IR \times EF \times ED / (BW \times AT))$$

Усанд сэлэх ба усанд орох үед ус уух

$$\mathbf{CDI = CW \times CR \times ET \times EF \times ED / (BW \times AT)}$$

C_W усан дахь бохирдуулагчын концентраци (мг.l^{-1})
CR уусан усны хэмжээ (l.цаг$^{-1}$)
ET өртөлтийн хугацаа (цаг.өдөр$^{-1}$)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$)
ED өртөлт үргэлжлэх хугацаа (жил)

Боломжит хувилбарууд:

Оршин суугчид – байнга ба амралтын үед оршин суугчид / усанд сэлэх үед санамсаргүй ус уух

CR ердийн хэрэглээ: 0,05 l.цаг$^{-1}$

ET өртөлтийн ердийн хугацаа (1 үйл явдлын үед): 1- 2,7 цаг.өдөр$^{-1}$

EF өртөлтийн ердийн давтамж: 7 – 45 өдөр.жил$^{-1}$ хүртэл

ED насан туршын өртөлт: 70 жил
өртөлт үргэлжлэх хамгийн их хугацаа – 1 талбайд амьдрах хугацаа: 30 жил (20 - 40 жилийн хооронд)
тухайн газарт амралтын үед байрлах дундаж хугацаа: 9 жил
хүүхдийн өртөлтийн дундаж хугацаа (6 нас хүртэл): 6 жил (дунджаар 3 жил

BW насанд хүрэгсдийн дундаж жин: 70 кг
1 - 6 хүртэлх насны хүүхдийн дундаж жин: 15 кг (тухайн насны тодорхой жинг ашиглаж болно)

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид / усанд ороход санамсаргүй ус уух
ердийн хэрэглээ: 0,05 l.цаг$^{-1}$

ET өртөлтийн ердийн хугацаа (1 үйл явдлын хувьд): 0,25- 0,58 цаг.өдөр$^{-1}$ насанд хүрэгсдийн хувьд; эсвэл 0,33 - 1,0 цаг.өдөр$^{-1}$ хүүхдийн хувьд

EF байнгийн өртөлтийн ердийн давтамж: 335- 350 өдөр.жил$^{-1}$
амралтын үед оршин суугчын өртөлтийн ердийн давтамж: 45 - 75 өдөр.жил$^{-1}$

Усанд арьсаар хүрэлцэх

$$\mathbf{CDI = C_W \times SA \times K_p \times ET \times EF \times ED \times CF / (BW \times AT)}$$

C_W усан дахь бохирдуулагчын концентраци (мг.l^{-1})
SA арьсны гадаргуу (см^2)
K_p арьсанд ус нэвчилтийн коэффициент (см.цаг$^{-1}$)
ET өртөлтийн хугацаа (цаг.өдөр$^{-1}$)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$)
CF литрийг см^3-д шилжүүлж бодоход ашиглах хувиргах коэффициент (0,001 l.см$^{-3}$)

Дээр дурдсан хялбаржуулсан тэгшитгэлүүд ихэнх органик бус бодисууд ба ионжсон органик бодисуудын хувьд хүчинтэй. Бусад бохирдуулагчын хувьд EPA (2004) арьсны эвэршсэн хэсэг болон эсүүдээр бохирдол нэвчихэд гарах саатлын хугацаа, молекулын жин ба бохирдол нөлөөлөх хугацаа зэргийг тооцоо хийхэд бодолцох шаардлагатай. Тооцоо хийхэд дараах тэгшитгэлүүдийг ашиглана (өөрчлөлт оруулсан):

$$\mathbf{DAD = DA_{ev} \times EV \times EF \times Ed \times SA / (BW \times AT)},$$

DA (мг.см$^{-2}$.тохиолдол$^{-1}$) Богино хугацааны ба удаан хугацааны үйл ажиллагааны үед тодорхойлогдоно:

Богино хугацааны үйл ажиллагаа ($T_{ev} \leq T_{st}$):

$$\mathbf{DA_{ev} = 2\ FA \times K_p \times C_W \times CF \times (6\ t \times T_{ev} / p)^{½}}$$

Эсвэл удаан хугацааны үйл ажиллагаа ($t_{event} > t_{st}$):

$$\mathbf{DA_{ev} = FA \times K_p \times C_W \times CF \times ((T_{ev} /(1 + B)) + (2\ t \times (1 + 3B + 3B^2)/(1 + B)^2))}$$

DAD арьсаар дамжин шингэсэн тун (мг.кг-^{1}.өдөр$^{-1}$)
DA_{ev} нэг тохиолдолд шингэсэн тун (мг.см-^{2}. тохиолдол$^{-1}$)
EV 1 өдөрт тохиолдох тоо (тохиолдол.өдөр$^{-1}$)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$)
FA шингэсэн хэмжээний эзлэх хувь (0 - 1, хэмжээгүй)
K_p арьсанд нэвчих ус нэвчилтийн коэффициент (см.цаг$^{-1}$)
CF хувиргах коэффициент (0,001 l.см$^{-3}$)
T_{ev} тохиолдол үргэлжлэх хугацаа (цаг. тохиолдол$^{-1}$); тайлбар: ET (цаг.өдөр$^{-1}$) = EV (тохиолдол.өдөр$^{-1}$) x T_{ev} (цаг.тохиолдол$^{-1}$)
t хожимдох хугацаа (цаг. тохиолдол$^{-1}$)
T_{st} тогтвортой байдалд хүрэхэд шаардагдах хугацаа (цаг); T_{st} = 2,4 т
B K_p арьсны эвэршсэн хэсэг ба арьсны эсээр дамжих харьцаа (хэмжээгүй);
Энэ коэффициентыг тооцоход ойролцоо утгын харьцааг ашиглахыг зөвлөдөг:

$$\mathbf{B = K_p \times MW^{½} / 2{,}6}$$

MW молекулын жин (г.мол$^{-1}$)

Тайлбар: Сонгосон зарим бодисуудын зөвлөмж параметрүүдийг K_p, B, t, t_{st} ба FA зэргийг гарын авлагад EPA (2004; хүснэгт B-3) оруулсан ба усанд орох үеийн арьсаар хүрэлцэх хувилбар, өртөлтийн уух болон уусах хэлбэрүүдийн харьцуулалтын жишиг загварын тооцоо хийх жишээг DA ба DAD үзүүлсэн байгаа.

Боломжит хувилбарууд:

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид / усанд орох үед арьсаар хүрэлцэх

SA арьсны гадаргуу: 18 000 см^2 - 20 000 см^2 (эмэгтэй: 16 900 см^2, эрэгтэй: 19 400 см^2)
хүүхдийн арьсны гадаргуу (6 хүртэлх насны): 6 600 см^2 (хүснэгт 4.2-с дэлгэрэнгүй үз)

K_p органик бус бодисын ус нэвчих чанарын утгатай ойролцоо: 0,001 см.цаг$^{-1}$, органик бодисын хувьд устай адилтгах чанарыг хязгаарлалттай ашиглана. АНУ-ын Байгаль орчин хамгаалах агентлаг U.S. EPA (2004) нь бодис тус бүрийн хувьд Flynn database ба урьдчилан таамагласан утга K_p (EPA, 2004, хүснэгт B-3) ашиглахыг зөвлөмж болгодог.

ET өртөлтийн ердийн хугацаа (нэг үйл явдлын): 1- 2,7 цаг.өдөр$^{-1}$

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид / усанд ороход арьсаар хүрэлцэх

ET өртөлтийн ердийн хугацаа (нэг үйл явдлын): 0,25 - 0,58 цаг.өдөр$^{-1}$ (15 - 35 минут) насанд хүрэгсдийн; 0,33 - 1,0 цаг.өдөр$^{-1}$ (20 - 60 минут) хүүхдийн (EPA, 1997, 2004). Зарим хуучин эх сурвалжид эдгээр үзүүлэлтүүд адил утгатай 0,2 цаг.өдөр$^{-1}$ (ж-нь: EPA, 1990) байдаг.

Үйлдвэрийн, худалдааны байгууллагын ба газар тариалангийн ажиллагсад/ угаах үед арьсаар хүрэлцэх

SA зөвхөн гар ба гарын шууны хувьд: сса 2 000 см^2 (хүснэгт 4.2 үз)

ET өртөлтийн ердийн хугацаа: 0,2 - 0,5 цаг.өдөр$^{-1}$

EF өртөлтийн ердийн давтамж: 225 - 250 өдөр.жил$^{-1}$ (өрхийн фермерийн аа 350 өдөр.жил$^{-1}$ хүртэл)

Ажиллагсад – цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед усанд арьсаар хүрэлцэх

SA ихэвчлэн эрэгтэй хүний гарын хувьд авч үзвэл: 1 000 см^2 (хүснэгт 4.2 үз)

ET нэг үйл явдлын өртөлтийн ердийн хугацаа: 4 - 8 цаг.өдөр$^{-1}$

EF өртөлтийн давтамж: тухайн ажлын онцлогоос хамааран ж-нь: газар шорооны ажлын үед арван хэдэн өдөр.жил$^{-1}$ (ихэвчлэн 20 өдөр.жил$^{-1}$)
цэвэршүүлэх ажлын үед 250 өдөр.жил$^{-1}$ хүртэл

ED нэг ажлын байранд ажилласнаар урьдчилан тооцох: 25 жил, цэвэршүүлэх ажлын үед

1 жил

Хүснэгт. 4.2 Биеийн тодорхой хэсгийн арьсны гадаргуу (см^2 / 50. хувь)

Насанд хүрсэн	**Эрэгтэй**	Эмэгтэй	Дундаж
Нийт	19 400	16 900	18 150
Нүүр	433	370	402
Гарын шуу	1 310	1 035	1 173
Гар	990	817	904
Хөл (өвдгөөс доош)	2 560	2 180	2 370
Хөлийн ул	1 310	1 140	1 225
Хүүхдүүд	**6 хүртэлх насны**	**6 - 18 настай**	Дундаж
Нийт	6 560	13 120	9 840
Нүүр	326	425	376
Гарын шуу	393	787	590
Гар	358	700	529
Хөл (өвдгөөс доош)	650	1 610	1 130
Хөлийн ул	451	949	700

Хөрс ба тоосонцор санамсаргүй амаар дамжих (залгих)

$CDI = C_S \times IR \times CF \times FI \times EF \times ED / (BW \times AT)$

C_S хөрсөн дахь бохирдуулагчын концентраци эсвэл тоосны (мг.кг$^{-1}$)
IR өдөрт амьсгалсан шороо тоосны хэмжээ (мг.өдөр$^{-1}$)
CF нэгж тооцоход ашиглах хувиргах коэффициент кг ба мг (10^{-6} кг.мг$^{-1}$)
FI бохирдолтой эх үүсвэрээр өртөхөд хөрсний эзлэх хувь (0 - 1, хэмжих нэгжгүй)

Боломжит хувилбарууд

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид / хөрс ба тоосонцор санамсаргүй амаар дамжих (залгих)

IR хүүхдийн амаар дамжсан хөрс шорооны ердийн хэмжээ: 100 - 250 мг.өдөр$^{-1}$ (1 - 6 насны), ихэвчлэн 200 мг.өдөр$^{-1}$ –г ашигладаг

насанд хүрэгсдийн амаар дамжсан хөрс шорооны ердийн хэмжээ: гадаа орчинд байх үед 50 - 480 мг.өдөр$^{-1}$, ихэвчлэн 100 мг.өдөр$^{-1}$ –г ашигладаг
хүүхдийн амьсгалсан тоосны хэмжээ: 50 - 100 мг.өдөр$^{-1}$ (2,5 нас хүртэлх), 3 мг.өдөр$^{-1}$ (6 нас)
насанд хүрэгсдийн амьсгалсан тоосны хэмжээ – байшин дотор: 0,56 мг.өдөр$^{-1}$
насанд хүрэгсдийн амьсгалсан тоосны хэмжээ – дээврийн хонгил, зоорь: 110 мг.өдөр$^{-1}$

CF кг нэгжийг мг-д шилжүүлэн тооцоход ашиглах хувиргах коэффициент: 10^{-6} кг.мг$^{-1}$

FI бохирдолтой хөрс, шороо амаар дамжсан залгисан хэмжээ: 0 - 1 талбайгаас хамааран (хэмжих нэгжгүй)

EF байнга оршин суугчын өртөлтийн ердийн давтамж (талбайгаас хамааран хүйтэн өдрүүд, цастай өдрүүд, бороотой өдрүүд + талбайгаас гадуур байрлах өдрүүдийг тооцох шаардлагатай):
байнга оршин суугчын гадаа байх хамгийн их хугацаа: 274 өдөр.жил$^{-1}$
гадаа их хугацаагаар байх (их хэмжээний өртөлт – гадаа цэцэрлэгт ажиллах гм): 43 өдөр.жил$^{-1}$
хүүхдийн гадааны үйл ажиллагаа: 130 - 152 өдөр.жил$^{-1}$
орон байранд - тоос: 335 - 350 өдөр.жил$^{-1}$
агуулах (дээврийн хонгил, зоорь) - тоос: 12 өдөр.жил$^{-1}$
амралтын үеийн өртөлтийн ердийн давтамж: 45 - 75 өдөр.жил$^{-1}$

ED өртөлт үргэлжлэх ердийн хуггацаа – насанд хүрэгсдийн нэг талбайд байрлах хугацаа: 24 нас (+ 6 хүүхэд насны үеийн)

Ажиллагсад – газар тариалан / улирлын чанартай ажлын үед санамсаргүй хөрс, шороо амаар дамжих (залгих)

IR насанд хүрэгсдийн амаар дамжсан (залгисан) хөрс, шорооны ердийн хэмжээ: 100 мг.өдөр$^{-1}$

EF өртөлтийн давтамж: улирлын чанартай ажлын онцлогоос хамаарах (өдөр.жил$^{-1}$), ихэвчлэн 225 - 274 байдаг өдөр.жил$^{-1}$ байдаг

Ажиллагсад – үйлдвэрийн газрууд/ цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед хөрс, шороо амаар дамжих

IR насанд хүрэгсдийн амаар дамжсан хөрс, шорооны ердийн хэмжээ: 50 - 480 мг.өдөр$^{-1}$, үйлдвэрийн ердийн орчинд 50 мг.өдөр$^{-1}$

EF өртөлтийн давтамж: ажлын онцлогоос шалтгаалан ихэвчлэн
эхний хэдэн арван өдрүүдэд өдөр.жил$^{-1}$ хааяа хийгдэх газар шорооны ажил (ихэвчлэн 20 өдөр.жил$^{-1}$)
тогтвортой ажлын үед **EPA** 225 - 250 өдөр.жил$^{-1}$ гэсэн утгыг ашиглахыг зөвлөдөг

ED цэвэршүүлэх ажлын ердийн өртөлтийн урьдчилсан таамаглал: 1 жил

Хөрстэй арьсаар хүрэлцэх

$$\mathbf{CDI = C_S \times CF \times SA \times AF \times ABSd \times EF \times ED / (BW \times AT)}$$

CF кг нэгжийг мг-д шилжүүлэн тооцоход ашиглах хувиргах коэффициент: (10^{-6} кг.мг$^{-1}$)
SA арьсны өртөх гадаргуу (см^2.өдөр$^{-1}$, эсвэл см^2.тохиолдол$^{-1}$)
AF хөрсний төрөл ба арьсны өртөх хэсгээс хамаарах наалдамхай хүчин зүйл (мг.см$^{-2}$)
ABS_d арьсны шингээх хүчин зүйл (0 - 1, хэмжээгүй)
EF өртөлтийн давтамж (өдөр.жил$^{-1}$, эсвэл тохиолдол.жил$^{-1}$)

Дараах хоёр тэгшитгэлийг өөр арга (EPA, 2004) болгон ашигладаг боловч дээрх тэгшитгэлтэй адил ба зөвхөн EV (тохиолдол.өдөр$^{-1}$) параметрыг нэмж оруулсан. Анхны тэгшитгэлд өдөрт нэг тохиолдол байхаар тооцоолсон.

$$\mathbf{CDI = DA_{ev} \times SA \times EV \times EF \times Ed / (BW \times AT)}$$

$$\mathbf{DA_{ev} = C_S \times CF \times AF \times ABS_d}$$

DAD арьсаар шингэх тун (мг.кг.өдөр$^{-1}$)
DA_{ev} тухайн тохиолдолд шингэх тун (мг.см$^{-2}$.тохиолдол$^{-1}$)
EV тохиолдлын давтамж (тохиолдол.өдөр$^{-1}$)

Боломжит хувилбарууд:

Ажиллагсад – үйлдвэрийн газрууд/цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед арьсаар хүрэлцэх

SA биеийн ил гарсан хэсгээр хүрэлцэхээр урьдчилан тооцоолсон: толгой + гарын шуу + 2 гар + хөл өвдөгнөөс доош – дунджаар нийт 5 700 см^2 (хүснэгт 4.2 үз); үйлдвэрийн газрын ба худалдааны зорилгоор газрыг ашиглах үед 3 300 см^2 (EPA, 2004) тоог ашиглахыг зөвлөмж болгодог. Мөн адил тоог цэвэршүүлэх ажлын үед хамгаалах хэрэгсэл заавал ашигласан хэмээн үзвэл хамгийн их хэмжээ болгож ашиглана.

AF биеийн ил гарсан хэсгээр хүрэлцэх хэсэг ба хөрсний төрлөөс ж-нь: энгийн хөрстэй гараар хүрэлцэх үеийн наалдах чанарын хүчин зүйл 1,45 мг.см$^{-2}$, каолин буюу нарийн шавар 2,77 мг.см$^{-2}$ (EPA, 1989); одоогийн байдлаар EPA (2004) ажилтнуудын хувьд дундаж утга 0,2 мг.см$^{-2}$ (эсвэл 0,07 - 0,6 мг.см$^{-2}$ хоорондох утгыг ашиглахыг зөвлөдөг, хөрсний ба ажлын шинжээс хамаарна; бусад дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт С-3 v EPA, 2004 үз)

AbS_d арьсанд шингэх хүчин зүйл - химийн бодис тус бүрийн тусгай тоо; хэрэв мэдээлэл байхгүй бол консерватив таамаг тооцоо ба чанарын үнэлгээг ашиглахыг зөвлөдөг; сонгосон бохирдуулагчын зөвлөмж болгох тоон утгыг EPA (2004) боловсруулсан хүснэгт 4.3-с үзэх, эсвэл хавсралт № 6 (RAIS, 2003) байгаа мэдээллийн санг ашиглах. Бусад мэдээлэл хангалтгүй үед органик бус бодисын хувьд 0,001 ба органик бодисын хувьд 0,01 (EPA, 1992b)

EF өртөлтийн давтамж: ажлын онцлогоос шалтгаалан тухайн газар шорооны ажлын үед эхний хэдэн арван хоног өдөр.жил$^{-1}$
тогтвортой ажлын (ихэвчлэн 20 өдөр.жил$^{-1}$) үед АНУ-ын Байгаль орчин хамгаалах агентлаг EPA 225 - 250 өдөр.жил$^{-1}$тоог ашиглахыг зөвлөдөг

ED цэвэршүүлэх ажлын ердийн өртөлтийн урьдчилсан тооцоо: 1 жил

Хүүхэд ба насанд хүрэгсэд / тухайн газрын байнга оршин суугч ба амрагч хөрстэй арьсаар хүрэлцэх

SA 6 хүртэлх насны хүүхэд бохирдолтой хөрсөнд арьс хүрэлцэхүйн замаар өртөхөд 2 800 см^2 тоог ашиглана; насанд хүрэгсдийн хувьд 5 700 см^2 (EPA, 2004)

EF хувилбарыг үз – хөрс ба тоос санамсаргүй амаар дамжих

AF хөрсний төрөл ба биеийн өртсөн хэсгээс хамаарах наалдах чанарын хүчин зүйл онцлог байна; АНУ-ын БОХА EPA (2004) 6 хүртэлх насны хүүхдийн хувьд 0,04 - 0,2 мг.см$^{-2}$ (0,2 мг.см$^{-2}$ шаварлаг хөрстэй үед), насанд хүрэгсдийн хувьд 0,01 - 0,07 мг.см$^{-2}$утгуудыг ашиглахыг зөвлөдөг

Хүснэгт 4.3 – Хөрстэй арьсаар хүрэлцэх үеийн ABS-н зөвлөмж болгох утга (EPA, 2004)

Нэгдлүүд	**ABS**	Ашигласан материал
Хүнцэл	0,03	Wester et al. (1993a)
Кадми	0,001	Wester et al. (1992a), U.S. ePA
Хлорден	0,04	Wester et al. (1992b)
2,4-Дихлорфеноксиоктаксилений хүчил	0,05	Wester et al. (1996)
DDT	0,03	Wester et al. (1990)
TCDD ба бусад диоксин	0,03	U.S. EPA (1992a)
Линдан	0,04	Duff and Kissel (1996)
Бензопирен ба бусад PAU	0,13	Wester et al. (1990)
Полихлоринатбифенил (Aroclors)	0,14	Wester et al. (1993b)
Пентахлорфенол	0,25	Wester et al. (1993c)
Хагас дэгдэмхий органик бодис	0,1	-

Тайлбар: Бохирдолтэй хөрсөөр дамжих эрсдлийн үнэлгээний үед 1-6 хүртэлх насны хүүхдүүд хамгийн мэдрэмтгий бүлэгт багтдаг. Энэ насны хүүхдүүд гадаа тоглох, мөлхөх, гарын хуруу болон тоглоомыг амандаа хийх (“hand-to-mouth”) зэрэг эрсдэлтэй

үйлдлийг байнга хийдэг. Олон судалгаанаас харахад энэ насны хүүхдүүдийн амаар хөрсний хэсгүүд дамжих нь элбэг тохиолддог. Том хүмүүстэй харьцуулахад хүүхдүүд ихэнх гадаа хөрстэй харьцаж өнгөрүүлдэг ба гадаа орчинд хийх аливаа үйл хөдөлгөөн нь хөрс амаар дамжих боломжыг ихэсгэдэг. Эдгээр хүчин зүйлүүдээс шалтгаалан хөрсний боломжит бохирдуулагчид өртөх ба зарим онцгой тохиолдолд том хүнийхээс илүү өртөлтөнд эрсдэх боломжтой. Хэрэв болзошгүй эрсдлийг хүлээн авагч нь бага насны хүүхдүүд байх тохиодолд энэ хувилбар нь концепцийн загварын нэг хэсэг байх ёстой.

Бохирдолтой агаарыг амьсгалах

$$\mathbf{CDI = C_A \times IR \times ET \times EF \times ED / (BW \times AT)}$$

C_A агаар дахь бохирдуулагчын концентраци (мг.м$^{-3}$)
IR амьсгалсан хэмжээ (м^3.цаг$^{-1}$)
ET өртөлтийн хугацаа (цаг.өдөр$^{-1}$)

Тайлбар: Хөрс, тоос, усны концентрацийг шилжүүлэхэд тусгай аргаар бодох зайлшгүй шаардлагатай – ж-нь: сайжруулсан шороон гадаргуу, зам зэргээс тоос тархах тооцоо, дахин тунах (resuspension) (U.S. EPA, 2009b).

Дараагийн хэсэгт дээр дурдсан тэгшитгэлийн дагуу хүлээн авах хэмжээг тооцоход ашиглах хамгийн их тохиолдох өртөлтийн хувилбаруудын параметрүүдийг жагсаасан байгаа. Амьсгалаар дамжих эрсдлийн үнэлгээ нь дахин шинэчлэгдсэн ба цаашид эрсдлийн үнэлгээ хийхэд агаар бохирдуулагчын хэмжиж тогтоосон концентрацийн хэмжээг амьсгалаар нөлөөлөх хоруу чанартай (viz EPA, 2009) харьцуулахыг зөвлөдөг.

Хорт хавдар үүсгэх нөлөөтэй бохирдуулагчын хувьд амьсгалах нэгжийн эрсдлийг IUR (Inhalation Unit Risk) эрсдлийн хэмжээгээр тооцдог ба “1 мг.м$^{-3}$ концентрацитай бодисын байнгийн өртөлтийн үед хорт хавдар үүсэх насан туршын эрсдлийн магадлал” хэмээн тодорхойлдог ба (мг.м$^{-3}$)$^{-1}$хэмжих нэгжтэй.

Хорт хавдар үүсгэхгүй нөлөөтэй бохирдуулагчын хувьд жишиг концентрацийг RfC “амьсгалын замын байнгийн өртөлтийн (мэдрэмтгий бүлгийн өртөлтийгоролцуулан тооцох) таамаглал бөгөөд насан туршын сөрөг нөлөөг тооцох боломжгүй” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ концентраци мг.м$^{-3}$хэмжих нэгжтэй.

Өртөлтийн концентраци EC (мг.м$^{-3}$) - г IUR утгатай харьцуулахад өртөлтийн бодит хувилбар ба цагаас хамаарах үзүлэлтүүдийг харгалзан дүгнэнэ. Эдгээрийг тооцоход өдөрт хүлээн авах тунг (амьсгалаар дамжих хэмжээ ба биеийн жинг тооцохгүй) тодорхойлох ашигладаг тэгшитгэлийг ашиглана:

$$\mathbf{EC = C_A \times ET \times EF \times ED / AT}$$

Өртөлтийн концентраци EC - г RfC утгатай харьцуулахад өртөлтийн бодит хувилбарыг үндэслэх ба гэнэтийн өртөлт (24 цагаас бага), хэсэг хугацааны өртөлт (30 хоногоос хүний амьдрах хугацааны 10%-тай тэнцэх 7 жилийн хугацаанд дахин давтагдах) эсвэл удаан хугацааны өртөлтийг (хүний амьдрах хугацааны 10%-с буюу 7 жилээс урт хугацааны) тусад нь үнэлгээ хийнэ. 1-30 хоногийн богино хугацааны өртөлтийг аюулгүй байдлыг илүүтэй харгалзан хэсэг хугацааны өртөлттэй адил үнэлгээ хийнэ. Гэнэтийн өртөлтийн концентраци нь хэмжилт хийсэн концентрацитай адил байна. Бусад тохиолдолд хорт хавдар үүсгэх нөлөөтэй эрсдлийг дараах тэгшитгэлийг ашиглан тооцно:

AT дундаж хугацаа (цаг) = өртөлтийн хугацаа (ED) жилээр x 365 өдөр.жил$^{-1}$ x 24 цаг.өдөр$^{-1}$

Боломжит хувилбарууд:

<u>Оршин суугчид – байнга оршин суугч ба амрагч/ бохирдолтой агаар амьсгалах</u>

IR насанд хүрэгсдийн амьсгалах хэмжээ: ихэвчлэн 20 м^3.өдөр$^{-1}$, 0,83 м^3.цаг$^{-1}$ үзүүлэлтүүдээр тооцдог; үйл ажиллагааны онцлогоос хамааран 0,3 - 4,8 м^3.цаг$^{-1}$ байна (хүснэгт 4.4 үз).

6 хүртэлх насны хүүхдийн амьсгалах хэмжээ: 0,3 - 1,9 м^3.цаг$^{-1}$

ET өртөлтийн хугацаа – бүтэн өдрийн турш: 21 - 24 цаг.өдөр$^{-1}$ эсвэл дунджаар 16,43 цаг.өдөр$^{-1}$ (гадаа эсвэл барилгын доторх орчинд байгааг эсвэл агаарын бохирдол, үйл ажиллагааны төрлийг харгалзан ялгаатай хандах шаардлагатай)

<u>Ажиллагсад – үйлдвэрийн эсвэл газар тариалангийн барилга байгууламжууд/ ажлын байранд амьсгалах, цэвэршүүлэх болон газар шорооны ажлын үед хөрсний агаар амьсгалах</u>

IR насанд хүрэгсдийн амьсгалах хэмжээ: дунджаар 20 м^3.өдөр$^{-1}$, 0,83 м^3.цаг$^{-1}$, дунд болон хүнд ажлын үед илүү их тоог 2,1 - 3,9 м^3.цаг$^{-1}$ (хүснэгт 4.4) хоорондох ашиглана.

ET өртөлтийн хугацаа: ихэвчлэн 8 цаг.өдөр$^{-1}$ (бохирдолтой болон өөр газарт байсан хугацааг ялгаж үзэх хэрэгтэй)

EF өртөлтийн давтамж: ихэвчлэн 225 - 274 өдөр.жил$^{-1}$ (тогтмол бус заримдаа хийгдэх газар шорооны ажлын үед жилд хэдэн арван хоног ба ажлын онцлог ж-нь: өрхийн фермерийн аж ахуйн хувьд 350 өдөр.жил$^{-1}$ байхаар тооцно)

Хүснэгт 4.4 Үйл ажиллагааны шинжээс хамаарах амьсгалсан хэмжээ (м^3.цаг$^{-1}$)

Хүлээн авагч / үйл ажиллагаа	**амралт (a)**	**Хөн гөн (b)**	**дунд (c)**	**хүнд (d)**
Насанд хүрэгсэд				
эрэгтэй	0,7	0,8	2,5	4,8
эмэгтэй	0,3	0,5	1,6	2,9
духдаж	0,5	0,6	2,1	3,9
хүүхдүүд				
6 хүртэлх насны	0,4	0,8	2,0	2,3
10 настай	0,4	1,0	3,2	3,9

(a) ж-нь: зураг үзэх, унших, унтах
(b) ж-нь: гэрийн ихэнх болон ердийн ажил, хобби ба засварын жижиг ажлууд
(c) ж-нь: их цэвэрлэгээ, гэрийн томоохон засвар, шатаар өгсөх гм.
(d) ж-нь: биеийн хүнд хөдөлмөр, дасгал хийх, шатаар ачаа үүрч өгсөх гм.

Бохирдолтой устай харьцах үед уур амьсгалах

Тайлбар: 2 x 10^{-7} атм/$м^3$/мол эсвэл үүнээс их Генригийн тогтмол тоотой дэгдэмхий бохирдуулагчыг авч үзэж болно.

$$CDI = C_A \times IR \times ET \times EF \times ED / (BW \times AT)$$

IR амьсгалсан хэмжээ ($м^3$.цаг$^{-1}$)

Боломжит хувилбарууд:

Оршин суугчид – байнга оршин суугчид ба амрагчид / усанд орох үед уур амьсгалах

C_A агаар дахь бохирдуулагчын концентрацийг шууд хэмжих боломжгүй бол бохирдуулагчын усан дахь концентрацийг ойролцоогоор хувиргаж ашиглана. Ж-нь: Risk*Assistant ашиглан хялбарчилсан тэгшитгэл:

$$C_A = (C_W \times f \times F \times t) / V / 2$$

C_W усан дахь концентраци (мг.$л^{-1}$)
f бохирдуулагчаас ялгарах фракц (0 - 1, хэмжих нэгжгүй); ихэвчлэн 0,75
F усны урсац (л.цаг$^{-1}$); ихэвчлэн 600 л.цаг$^{-1}$
t шүршүүрт орох хугацаа (цаг); ихэвчлэн 0,2 цаг
V угаалгын өрөөний эзэлхүүн ($м^3$); ихэвчлэн 9 $м^3$
IR шүршүүрт ороход амьсгалах хэмжээ: 0,6 $м^3$.цаг$^{-1}$

ET усанд ороход бохирдолтой усны уур амьсгалах өртөлтийн ердийн хугацаа: 0,25 - 0,58 цаг.өдөр$^{-1}$ (15 - 35 мин)
Насанд хүрэгсдийн хувьд; 0,33 - 1,0 цаг.өдөр$^{-1}$ (20 - 60 минут) хүүхдийн хувьд (EPA, 1997, 2004)
Зарим хуучны эх сурвалжид 0,2 цаг.өдөр$^{-1}$ гэсэн нэг тоог заасан байдаг (ж-нь: EPA, 1990)

Оршин суугчид – байнга оршин суугч эсвэл амрагч, газар тариалангийн үйл ажиллагаа / цэцэрлэгт усалгаа хийхэд уур амьсгалах

C_A агаар дахь бохирдуулагчыг шууд хэмжих боломжгүй үед бохирдуулагчын усан дахь концентрацийг ойролцоогоор хувиргаж ашиглана. Ж-нь: Risk*Assistant ашиглан хялбарчилсан тэгшитгэл:

$$CA = ((2/p)^{½}) \times (X^{(1-b)} / (a \times (1-b))) \times (Q / u)$$

$$Q = (C_W \times f \times F) / (X^2 \times 3600 \text{ сек/цаг})$$

Q эх үүсвэрийн ундарга (мг.сек$^{-1}$.$м^{-2}$)
f бохирдуулагчаас ялгарах фракц (0 - 1, хэмжих нэгжгүй); ихэвчлэн 0,5
F услалтын усны урсацын хэмжээ (л.цаг$^{-1}$); ихэвчлэн 600 л.цаг$^{-1}$
X усалгаатай квадрат хэлбэртэй талбайн тал (м)
p p = 3,141592
a, b босоо тархалтыг атмосферын тогтвортой байдлаас хамаарах тогтмол тоо: a = 0,15; b = 0,75
u гадаргуун ойролцоох салхины хурд (м.сек$^{-1}$); ихэвчлэн 2.0 м.сек$^{-1}$
IR усалгааны үед амьсгалах агаар: 1,4 - 1,67 $м^3$.цаг$^{-1}$
ET өртөлтийн ердийн хугацаа: 0,44 - 3,0 цаг.өдөр$^{-1}$ (бага утга нь жилийн дундаж тоо 7 хоногт 3 цаг, өвлийн улиралд ажил бага үед бага, зуны цагт их байна)

EF өртөлтийн давтамж: ихэвчлэн 90 - 120 өдөр (эсвэл 335 - 350 өдөр, хэрэв ЕТ хугацаанд ургамал ургах хугацааг авч үзвэл – хавраас намар хүртэлх хур бороогүй өдрүүд)

Бохирдолтой хүнс хэрэглэх

CDI = C x IR x FI x EF x ED / (BW x AT)

C хүнсний бүтээгдэхүүний бохирдуулагчын концентраци (мг.кг$^{-1}$)
IR хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ (кг.хоол хүнс$^{-1}$)
FI бохирдолтой эх үүсвэрийн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь (0 - 1, хэмжих нэгжгүй)
EF өртөлтийн давтамж (хоол хүнс.жил$^{-1}$)
ED өртөлтийн хугацаа (жил)

Тайлбар: Хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний хэмжээг ж-нь: “үндэсний хэрэглээний саг”-ыг тодорхойлдог статистикийн газраас авч болно.

Боломжит хувилбарууд:

Загасны мах, жимс, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн өндөг хүнсэнд хэрэглэх

IR европ-америкийн хүн амын хоол хүнсний нийтлэг хэрэглээ:
0,03 - 0,054 кг/хоол хүнс - загасны мах
0,1 кг/хоол хүнс - үхрийн мах
0,14 кг/хоол хүнс - жимс
0,2 кг/хоол хүнс - хүнсний ногоо
0,4 кг/хоол хүнс - сүү, сүүн бүтээгдэхүүн
0,064 - 0,15 кг/хоол хүнс - өндөг

FI бохирдолтой хоол хүнсний хэрэглээ:
0,44 - 0,75 үхрийн мах
0,2 - 1,0 загасны мах
0,2 - 0,3 жимс
0,25 - 0,4 хүнсний ногоо
0,4 - 0,75 сүү, сүүн бүтээгдэхүүн

Өөрийн бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэдэг газар тариалан эрхэлдэг, хүнсний ногоо тарьдаг иргэдэд чухал ач холбогдолтой.


EF өртөлтийн давтамж:
48 хүнс/жил – загасны мах
73 - 250 хүнс/жил - жимс, хүнсний ногоо
350 хүнс/жил - сүү, сүүн бүтээгдэхүүн ба мах

ED өртөлт үргэлжлэх хугацаа:
20 - 30 жил - сүү, сүүн бүтээгдэхүүн ба мах
9 - 30 жил - жимс, хүнсний ногоо ба загасны мах

12. ХАВСРАЛТ 5 - Концептын загварын жишээ

Концепцийн загварын үндсэн мэдээлэлд авч үзэх шаардлагатай өртөлтийн бүх замуудын жагсаалт багтах ба эдгээрт зориулан эрсдлийн анализын хүрээнд ажлын цар хүрээг боловсруулдаг. Тохиромжтой нэмэлт мэдээлэлд дамжих замыг нэг бүрчлэн харуулсан схем зураг эсвэл газрын зураг багтах ба энэхүү мэдээллүүд нь газар дээрх байдлыг мэдэхэд тусламж болно.

Концептын загварын жишээ 1




Өртөлтийн зам	Бохирдолын голомт	Тархалтын зам	Эрсдэлийг хүлээн авагч	Тайлбар
1	Будгийн цех	Уусгагч бодис алдагдсан ба гүний усанд шингэсэн гүний ус → гүний ус тархах зам → горхи руу урсах	Гадаргын ус ба загас барихтай холбоотой хүмүүс (амаар дамжих өртөлт)	Гүний усыг ашигласнаар гүний усыг түвшин их хэмжээгээр бууруулагүй
2	Будгийн цех	Уусгагч бодис алдагдсан ба гүний усанд шингэсэн гүний → гүний ус тархах зам → худгаас ус авах	Хот суурингийн хүн ам (ундны ус –амаар, арьсаар, амьсгалаар дамжих өртөлт)	Бүх бохирдол горхийн усанд угаагдаагүй нөхцөлд
3	Цутгалтын цех	Агаарт хортой металл агуулсан тоос тархах → тариалангийн талбайд агаарын бохирдол нөлөөлөх → ургац буурах, үр жимс бохирдох	Хүн ам (ойгоос түүсэн жимс идэх – амаар дамжих өртөлт)	
4	Цутгалтын цех	Хортой металл агуулсан тоос агаарт тархах → ойд бохирдолтой агаар нөлөөлөх	Ойн экосистем	Эрсдэл үүссэн, зарим моднууд хатаж ургахгүй болсон
5	Цутгалтын цех	Хортой металл агуулсан тоос агаарт тархах → ойд бохирдолтой агаар нөлөөлөх → ойн жимс бохирдох	Хот суурингийн хүн ам (ойгоос түүсэн жимс идэх – амаар дамжих өртөлт)	

6	Цутгалтын цех	Хортой металл агуулсан тоос агаарт тархах → газар тариалангийн талбай ба ойд агаарын бохирдол нөлөөлөх → хөрсний элэгдэл ихсэх → бохирдолтой хөрсийг гол горхи руу зөөх	Гадаргын ус, тунадас ба загас барихтай холбоотой хүмүүс (амаар дамжих өртөлт)	

Концептын загварын жишээ 2

U.S. EPA (1997): Ecological Risk Assessment Guidance for Superfund: Process for Designing and Conducting ecological Risk Assessments, Interim Final; Appendix A - example ecological Risk Assessment for Hypothetical Sites



Болзошгүй эх үүсвэр:

- Аюултай хог хаягдал (хатуу хог хаягдал нурах, хорт утаа),
- шатах тослох материал хадгалах савын хаягдлын цэг (гадаргуугаар ус зайлуулах, хөрсөнд хэвчих),
- хөдөө аж ахуй (гадаргуугаар ус зайлуулах, тоос ба тоосонцор).

Тархалтын дамжин өртөх замууд:

- хүнсээр дамжих (хог хаягдал, хог хаягдлын цэгийн ба түүний орчмын хөрс, шатах тослох материал хадгалах савын хаягдлын цэг),
- амьсгалаар дамжих (хөдөө аж ахуйн хог хаягдлын цэгийн тоос, тоосонцор),
- арьсанд хүрснээр дамжих (хог хаягдлын цэгийн орйролцоох хөрс, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, бохирдолын эс үүсвэрийн ойролцоох гадаргын ус).

Тархалтын болзошгүй замууд:

- агаар (шатах тослох материал хадгалах савын хаягдлын цэг ба хөдөө аж ахуйн үйл ажиллагааны талбайгаас тархах хий),
- хөрс (хог хаягдлын цэг болон хөдөө аж ахуйн талбайгаас гадаргуугаар ус

зайлуулах),

- гадаргуун ус – гол ба нуур (бохирдол аюултай хог хаягдлын цэгээс хөрсөнд нэвчих, хөдөө аж ахуйн талбайгаас гадаргуугаар ус зайлуулах),
- гүний ус (хаягдлын цэгээс бохирдол тархах).

Өртөж болзошгүй хүлээн авагчид:

- хөрс, гадаргын усны бохирдолтой намгархаг газрын ургамал ба амьтны аймаг,
- бохирдолтой ус газрын гадаргуугаар тархах, газрын гүнд нэвчихэд өртөх боломжтой газрын гол, нуурын системийн ургамал ба амьтны аймаг.

13. Хавсралт 6 – Ашиглах мэдээллийн эх үүсвэр зөвлөмж

Бохирдлын судалгаа ба цэвэрлэх ажил

Bedient P.B., Rifai H.S., Newell C.J. (1999): Ground Water Contamination, Transport and Remediation, 2nd edition, Prentice Hall PTR, Upper saddle River, NJ 07458.

Borden R.C., Gomez C.A., becker M.T. (1995): Geochemical Indicators of Intrinsic bioremediation, Groundwater, Vol. 33, No. 2, pp. 180 - 189.

Clement T.P., Sun Y. , Hooker b.S., Petersen J.N. (1998): Modeling Multispecies Reactive Transport in Ground water, Ground Water Monitoring and Remediation, 18(2), pp. 79-92.

Deutsch W.J. (1997): Groundwater Geochemistry, Fundamentals and Applications to Contamination, Lewis Publishers, Boca Raton, New York.

Fetter, C.W. (1999): Contaminant Hydrogeology, 2nd edition, Prentice Hall, Upper Saddle River, NJ 07458.

Howard, P.H. et al. (1991): Handbook of environmental Degradation Rates, CRC Press, Florida.

Sinke A.J.C., et al. (2002): Improved Remediation and Management of Contaminated Soils and Groundwater, TNO environment, energy and Process Innovation, The Netherlands.

ITRC (2008): In Situ bioremediation of Chlorinated ethene: DNAPL Source zones, Technical/Regulatory Guidance, Interstate Technology & Regulatory Council, DNAPL Team, Washington D.C.

ITRC (2004): Strategies for Monitoring the Performance od DNAPL Source zone Remedies, Technical/Regulatory Guidance, Interstate Technology & Regulatory Council, DNAPL Team, Washington D.C.

ITRC (2010): Use and Measurement of Mass Flux and Mass Discharge, Interstate Technology & Regulatory Council, Integrated DNAPL Site Strategy Team, Washington D.C.

U.S. EPA (2000): BioChlor, Natural Attenuation Decision Support System, User's Manual, Version 1, EPA/600/R-00/008, National Risk Management Research Laboratory, Offce of Research and Development, Cincinnati, OH.

U.S. EPA (1996): Bioplume III, Natural Attenuation Decision Support System, User's Manual, Version 1, EP-A/600/R-98/010, National Risk Management Research Laboratory, Offce of Research and Development, Cincinnati, OH.

U.S. EPA (2007): RemChlor, Remediation evaluation Model for Chlorinated Solvents, User's Manual, Version 1, EPA/600/C-08/001, National Risk Management Research Laboratory, Robert S. Kerr environmental Research Centre, ADA, OK.

U.S. EPA (1996): Bioscreen, Natural Attenuation Decision Support System, User's Manual, Version 1.3, EPA/600/R-96/087, National Risk Management Research Laboratory, Offce of Research and Develop-ment, Cincinnati, OH.

U.S. EPA (2008): FootPrint, A Screening Model for estimating the Area of a Plume Produced from Gasoline Containing ethanol, Version 1.0, EPA/600/R-08/058, Center for

Subsurface Modeling and Support Ground Water and ecosystem Restoration Division, ADA, OK.

U.S. EPA (2007): Monitored Natural Attenuation of Inorganic Contaminants in Ground Water, Volume 1 – eP-A/600/R-07/139, Volume 2 – EPA/600/R-07/140, National Risk Management Research Laboratory, Of-fce of Research and Development, Cincinnati, OH.

U.S. EPA (2008): Performance Monitoring of MNA Remedies for VOCs in Ground Water, EPA/600/R-04/027, National Risk Management Research Laboratory, Offce of Research and Development, Cincinnati, OH.

Эрсдэлийн үнэлгээ

Environment Agency UK (2005): The UK Approach for evaluating Human Health Risks from Petroleum Hydrocarbons in Soils, Science Report P5-080/TR3, Bristol.

MADEP (2003) Updated Petroleum Hydrocarbon Fraction Toxicity Values for VPH/ePH /APH Methodology - Final, Massachusetts Dept. of environment Protection, boston, MA.

STSC (2002): Derivation Support Document for Total Petroleum Hydrocarbons – PPTRV Support Issue SRC SF 01- 031/10-16-2002, EPA Superfund Technical Support Centre, Cincinnati, OH.

U.S. EPA (2005): Aging and Toxic Response: Issues Relevant to Risk Assessment, EPA/600/P-03/004A

U.S. EPA (2008): Child-Specifc exposure Factors Handbook, EPA/600/R-06/096F.

U.S. EPA (1997): Exposure Factors Handbook, EPA, August 1997.

U.S. EPA (2006): A Framework for Assessing Health Risks of environmental exposures to Children, EPA/600/R-05/093F.

U.S. EPA (2005): Guidelines for Carcinogen Risk Assessment, EPA/630/P-03/001F.

U.S. EPA (1998): Guidelines for ecological Risk Assessment, EPA/630/R-95/002F.

U.S. EPA (1989 - 2009): Risk assessment guidances for superfund. Volume I, parts A – F: http://www.epa.gov/oswer/riskassessment/human_health_exposure.htm

U.S. EPA (2009b): http://www.eea.europa.eu/publications/emep-eea-emission-inventory-guidebook-2009

U.S. EPA (2001): Risk Assessment Guidance for Superfund. Volume III - Part A, Process for Conducting Probabilistic Risk Assessment. http://www.epa.gov/oswer/riskassessment/rags3adt/index.htm

U.S. EPA (1996): Soil Screening Guidance: Technical Background Document, EPA/540/R95/128.

U.S. EPA (1997): Superfund Today. Focus on Risk Assessment.

U.S. EPA (2005): Supplemental Guidance for Assessing Susceptibility from early-life exposure to Carcinogens, EP-A/630/R-03/003F.

Чухал ач холбогдолтой интернетийн эх үүсвэр

International Agency for Research on Cancer (IARC) - Databáze karcinogenních látek: http://www.iarc.fr/en/publications/list/monographs/index.php http://monographs.iarc.fr/ENG/Classification/

The Risk Assessment Information System (RAIS) - Měsíčně aktualizovaná databáze toxikologických dat a modelů pro výpočet rizik: http://rais.ornl.gov/cgi-bin/tools/TOX_search?select=chem http://rais.ornl.gov/cgi-bin/tools/TOx_search?select=chem

U.S. EPA Risk-Based Screening Tables for Human Health Risk Assessment: http://www.epa.gov/reg3hwmd/risk/human/index.htm

U.S. EPA Human Health Risk Assessment Guidance: http://rais.ornl.gov/guidance/epa_hh.html

U.S.EPA Risk Assessment Guidelines: http://cfpub.epa.gov/ncea/cfm/recordisplay.cfm?deid=55907 http://www.epa.gov/oswer/riskassessment/human_health_exposure.htm

Байгаль орчны программ хангамж болон загваруудын мэдээллийн сан: http://www.scisoftware.com/

Ecological Risk Analysis (ORNL) – Экосистемийн эрсдэлийн үнэлгээний аргачлалын холбоос: http://www.esd.ornl.gov/programs/ecorisk/ecorisk.html

European Exposure Factors Sourcebook (ExpoFacts) – databáze, reference a literatura http://expofacts.jrc.ec.europa.eu/

Guide to Current Literature on exposure Factors: http://cfpub.epa.gov/ncea/cfm/recordisplay.cfm?deid=29187

Integrated Risk Information System (IRIS) – US EPA байгууллагын Хүний эрүүл мэндэд нөлөөлөх хоруу чанарын параметрийн мэдээллийн сан: http://www.epa.gov/iris/index.html

U.S. Geological Survey (USGS): Гидрогеологид ашиглах боломжтой программ хангамж болон загваруудын мэдээллийн сан: http://water.usgs.gov/software/

British Columbia - Guidance on Contaminated Sites: http://www.env.gov.bc.ca/epd/remediation/guidance/

Total Petroleum Hydrocarbon Criteria Working Group Series Online: Volumes 1-5: http://www.aehs.com/publications/catalog/contents/tph.htm

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

Methodological Guideline

The Principles of Working out Feasibility Studies for Measures to Remedy Objectionable Conditions in Contaminated Sites

CONTENTS

1. INTRODUCTION 3
2. PURPOSE AND CONTENT OF A FEASIBILITY STUDY 3
3. BASIC PRINCIPLES FOR WORKING OUT FEASIBILITY STUDIES 4
3.1 Introduction 4
3.2 Site characteristic 4
3.3 Survey works, tests and examinations carried out so far 5
3.4 Defining targets and target parameters for remedy measures 5
3.5 Basic alternatives of the remedy measures´ concept (strategy) 6
3.6 Identification of suitable remediation techniques and technologies 7
3.7 Quantification of areas and volumes to carry out remedy measures 7
3.8 Definition and primary selection of the remedy measures´ options 8
3.9 Detailed evaluation of the remedy measures´ options 9
3.10 Contrastive analysis of the options 11
3.11 Summary, conclusions and recommendations 11
4. FEASIBILITY STUDY'S OUTLINE 12
5. USED AND QUOTED SOURCES 13

ANNEXES

Example no. 1: An example of a well-arranged matrix of alternative techniques and technologies – example case with set remedial target values of contaminant in soil and groundwater

Example no. 2: A well-arranged matrix of a preliminary summarising evaluation of the remedy measures options (for groundwater)

1. INTRODUCTION

The text of these Methodological Guidelines deals with the principles of working out feasibility studies for the measures to remedy objectionable conditions in contaminated localities. Before a recommended outline of feasibility study there is a commentary that specifies the purpose, structure and content as well as the process to work out its single parts.

The Methodological Guidelines apply general principles of feasibility studies to the conditions that are usual during the technical solutions and management of the contaminated sites´ remediation, with respect to the Czech Republic´s legislative environment.

2. PURPOSE AND CONTENT OF A FEASIBILITY STUDY

A feasibility study is a source document for a responsible and final choice of the remedy measure option to be implemented. And the follow-up design of the remedy measures is also based on the feasibility study.

The main importance of a feasibility study consists in the fact that it can, as early as in the pre-design phase, reduce uncertainties and risks connected with remedy measures implementation substantially.

Generally, the feasibility study´s content consists in identification, work-out, evaluation and comparison of different options of remedy measures that can be taken into account for the given site in order to ensure the required level of risk reduction concerning contamination of the rock environment.

хамааран хэдхэн минут болдог. Хэдий тийм боловч, талбай дахь бохир усыг бүхэлд нь цэвэрлэх ажил хэдэн жил, сар ч байж болно. Цэвэрлэгээ-ний ажлын бодит хугацаа нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Жишээлбэл энэ нь арай урт хугацаа шаардаж болно.

- Бохирдлын агууламжууд өндөр байдаг ба ууссан бохирдуулагчийн эх үүсвэр нь бүрэн устгагдаагүй байна,
- Цэвэрлэх шаардлагатай усны хэмжээ маш их,
- Газар доорх ус хурдан шахагдахгүй байгаа,
- Эрдэс, бодисын ба замгийн хуримтлал бүхий материал нэмэгдэхээс сэргийлж байнга зайлуулах шаардлагатай,
- Эдгээр хүчин зүйлүүд нэг газраас нөгөө талбай хүртэл хувирч өөрчлөгдөнө.

3.4 Агаарын цэвэрлэгээ аюулгүй юу ?

Агаарын цэвэрлэгээний аргыг ашиглахад ерөнхийдөө аюулгүй гэж үздэг. Бохирдсон усыг цэвэрлэх байгууламж руу тээвэрлэн авчирах боломжгүй тул агаараар цэвэрлэгч багаж хэрэгслүүдийг тухайн газар авчирч болох юм. Бохирдсон усыг бүхэлд нь цэвэрлэх боломжтой байдаг, гэвч иргэд энд ирж түүнтэй харилцах боломж тун бага байдаг. Цэвэрлэсэн усыг гол төлөв газар доорх уст давхарга ба гадаргын усанд нийлүүлдэг. Агаарын цэвэрлэгээний үр дүнд бий болсон химийн уурыг хэрэв шаардлагатай бол, аюултай түвшинтэй уурыг баталгаажуулж гаргахгүй байдаг.

3.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Ялангуяа, томоохон бохирдол бүхий талбайд агаарын цэвэрлэгээний багаж хэрэгсэл ба цэвэрлэгээний тоног төхөөрөмж суурилуулах ажилд хүнд машин механизм ашиглах шаардлага гардаг. Хөрш зэргэлдээ газрын талбайд тоног төхөөрөмж тээвэрлэх зарим ачааны машины хөдөлгөөн нэмэгдэж байж болох юм. Баганан болон том савнууд олон жил үйл ажиллагаатай байж болох учраас гудамжинд ил харагдахаар байрлуулдаг. Гэсэн хэдий ч, агаарын цэвэрлэгээний багаж хэрэгслийг суурилуулахад аль болох дуу чимээгүй байх арга хэмжээ авах хэрэгтэй.

3.6 Яагаад агаарын цэвэрлэгээг ашигладаг вэ ?

Агаарын цэвэрлэгээ бол бохирдсон усан дахь дэгдэмхий органик нэгдлүүдийг арилгах үр дүнтэй арга бөгөөд улс орон даяар тухайн газрыг цэвэрлэх систем ба газар доорх ус шахуургын нэг хэсэг болгон ашигладаг. Тухайн талбайн ойр орчим дахь бохирдсон усыг шавхах хэрэгтэй ба агаарын цэвэрлэгээний багаж хэрэгслийг талбайд авчирч болох юм. Referring to a location other than the subject site. Тухайн байрлалд үндэслэсэн өөр талбайг хэлнэ.

3.7 Жишээ

Агаарын цэвэрлэгээ нь Аризона мужийн Хойд Энэтхэгийн тохой дээрх иж бүрэн цэвэрлэгээний талбай дээр үйл ажиллагаа явуулж байгаа газар доорх усны дөрвөн шахуурга ба цэвэрлэх системийн нэг хэсэг юм. Тухайн талбай дахь газар доорх ус аж үйлдвэрийн уусгагч гэж нэрлэдэг трихлорэтилин (TCE) болон бусад дэгдэмхий органик нэгдлүүдээр бохирдсон байна. Trichloroethylene нь өнгөгүй, ууршимтгай шингэн юм.

Шингэн трихлороэтилин нь агаарт маш хурдан ууршдаг, шатамхай бөгөөд сайхан үнэртэй байдаг. Бохирдол ойролцоогоор найман хавтгай дөрвөлжин миль (1609 м) талбайд, 100 фут (0.3048 м) гүнд үргэлжинэ. Эхний ус шахуурга ба цэвэрлэх систем 1944 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Үүний дараа өөр бусад цэвэрлэх үйл ажиллагааг нэмж сайжруулсан байна.

Агаар цэвэрлэгч тусгайлан бэлдсэн баганан сав усан дахь дэгдэмхий органик нэгдлүүдийн уурыг арилгах ба дараа нь идэвхжүүлсэн нүүрстөрөгч ба хэт ягаан туяаны исэлдэлт (ultraviolet oxidation) гэж нэрлэдэг аргаар цэвэрлэгээ хийгдэнэ. Хэт ягаан туяаны исэлдэлт гэдэг нь усан дахь органик бохирдуулагчийг исэлдүүлж устгах үйл явц юм. Энэ нь бохирдсон газар доорх усанд озон (O_3), эсвэл устөрөгчийн исэл (H_2O_2) гэсэн исэлдүүлэгч бодисуудыг нэмж ажилладаг. Цэвэрлэсэн ус усжуулалтын байгууламж ба усан сан руу ордог байна. 2011 оны байдлаар, 40,000-аас илүү фунтын жинтэй трихлорэтилинийг зайлуулж зарим газрыг бараг бүрэн цэвэрлэсэн байна. Тухайн газрыг бүрэн цэвэрлэхэд дахиад 40-70 жил хүртэл хугацаанд системийн үйл ажиллагааг явуулах хандлагатай байна.

3.8 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 хаягаар холбогдоно.

4 Био эмчилгээ

4.1 Био эмчилгээ (нөхөн сэргээлт) гэж юу вэ?


Био эмчилгээ нь бохирдсон хөрс ба газар доорх усыг цэвэрлэхэд бичил биетэн ашигладаг байна. Био нь "амь" гэсэн утгатай. Эдгээр бичил биетэн (амьд зүйлс нь) хөрс ба усан дахь хорт бодисыг задлах ба зайлуулах үүрэгтэй байдаг. Био эмчилгээнд ихэвчлэн ашигтай бичил биетнийг ашигладаг.

Бичил биетэнгүүд нь байгаль орчинд байгаагаараа амьдрах нян мэтийн маш жижиг организмууд байдаг. Био эмчилгээ нь зарим бичил биетнүүдийн өсөлтөд эрчим хүч ба хоол хүнсний эх үүсвэрийг бохирдуулагч байдлаар адилтган ашигладаг. Био эмчилгээг

ашиглан цэвэрлэгдсэн бохирдуулагч бодисуудад газрын тос ба бусад газрын тосны бүтээгдэхүүн, уусгагч болон хортон шавьжны хор зэрэг орно.

4.2 Энэ хэрхэн ажилладаг вэ ?

Зарим төрлийн бичил биетнүүд ихэвчлэн бохирдлыг идэж, шингээдэг ба тэдгээрийг бага хэмжээний ус, нүүрстөрөгчийн давхар исэл ба ethene гэх мэт хоргүй хийнүүд болгон өөрчилж байдаг. Хэрэв хөрс болон газар доорх усанд хангалттай бичил биетнүүд байхгүй бол тэнд “амьд биетийг нэмэгдүүлэх” гэж нэрлэдэг "bioaugmentation" үйл ажиллагааг нэмж хийдэг.



Microbe takes in oil, oxygen, and nutrients and releases gases and water.

Энэхүү био эмчилгээг үр дүнтэй болгохын тулд тохирсон температур, шим тэжээл, хоол хүнс заавал байх ёстой байдаг. Маш сайн нөхцөл бүрдүүлсэн бол бичил биетэн өсч үржих ба бохирдлыг ихээр идэх боломжийг олгодог. Хэрэв орчин нөхцлийг сайн бүрдүүлж чадаагүй бол бичил биетнүүд маш удаан өсөж үржих ба үхдэг учир бохирдлыг сайн цэвэрлэж чаддаггүй. Нэмэлтүүдийг хийж өгсөнөөр бичил биетэн үржих нөхцөл сайжрах боломжтой. Нэмэлтүүдэд цардуулын бурам, ургамлын тос, агаар ба хүчилтөрөгч үйлдвэрлэх химийн бодисууд гэх мэт айл өрхийн хэрэглэдэг янз янзын төрлийн эд зүйлс байдаг. Газар доорх ус ба хөрсийг цэвэрлэхийн тулд нэмэлтүүдийг гол төлөв худгаар дамжуулан шахдаг. Ийм газарт Байгаль орчныг хамгаалах агентлаг хөрсийг цэвэрлэхийн тулд түүнийг ухаж газар дээрх саванд хийх буюу эсвэл зөөлөн материал дээр тавьж байж болох юм. Ийм газар дээр нь EPA Бичигт эсвэл саванд нь (газрын гадаргаас дээш) "экс газар дээрх" цэвэрлэж хөрсийг ухаж байж болох юм. Хөрсний нөхцлийг сайжруулахын тулд түүнийг нэмэлтүүдтэй хольж хутгах буюу дараа нь халаадаг байж болно.

Газрын хөрсөнд хэдийгээр био эмчилгээ хийх шаардлагатай нөхцөл зайлшгүй боловч тэр бүр хийгдэж чаддаггүй. Зарим газруудад, тухайлбал уур амьсгал нь бичил биетнийг идэвхитэй ургуулахад хэт хүйтэн байж болно, эсвэл нэмэлтийг газар доогуур жигд

тараахад хөрс нь хэтэрхий өтгөн байж болох юм. Зарим газруудад, Байгаль орчныг хамгаалах агентлаг хөрсийг цэвэрлэхийн тулд түүнийг ухаж газрын гадарга дээр гаргаж саванд хийж байж болох юм. Дараа нь хөрсийг халааж, нэмэлт тэжээлтэй хутган холимог болгон хөрсийг сайжруулж болох юм.

Зарим тохиолдолд холимог хөрс нь бичил биетэн бохирдлыг идэхээс өмнө түүнийг ууршуулах шалтгаан болдог. Бохирдлыг агаарт ууршихаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөрсийг барилга дотор тусгай саванд хольдог ба барилга нь химийн бодисын уурыг цуглуулж, цэвэрлэх боломжтой байх ёстой. Талбайн байдлаас хамаарч, цэвэршүүлсэн усыг буцааж газар доорх шахдаг, эсвэл гадаргын ус руу, эсхүл орон нутгийн бохир усны системд нийлүүлдэг.

Тухайн газар дахь газар доорх бохир усыг цэвэрлэхэд, газрын гүнээс тодорхой тоо хэмжээний усыг шавхаж гадарга дээрх саванд юүлэх зориулалттай худгуудыг өрөмдсөн байна. Энэ усыг нэмэлт тэжээлтэй хольсны дараа газрын гүн рүү эргүүлэн шахдаг. Нэмэлт тэжээлээр баяжсан газар доорх ус бичил биетнүүдэд газар доорх усны бохирдлын үлдэгдэлд био эмчилгээ хийх боломжийг олгодог. Мөн түүнчлэн газар доорх усыг гадарга дээрх цэвэрлэгээнд зориулан “биореактор” руу шахдаг байж болно. Биореактор бол цэвэрлэгээнд бэлтгэсэн нэмэлтүүд ба бичил биетүүдийн холимог бүхий газар доорх устай савнууд байдаг. Газрын байрлалаас хамааран цэвэрлэгдсэн газар доорх ус магадагүй эргээд газрын гүн рүү, гадаргын ус руу болон орон нутгийн бохир усны систем рүү шахагдаж байж болно.

4.3 Хүчилтөрөгч бидэнд байнга хэрэгтэй байна уу?

Зарим бохирдуулагчууд зөвхөн хүчилтөрөгч агуулсан орчин дахь био эмчилгээ байж болох юм. Зарим бохирдуулагчид нь зөвхөн хүчилтөрөгч байхгүй орчин дахь био эмчилгээ байж болох юм. Хүчилтөрөгч шаардахгүй амьдардаг бичил биетнүүдийн өсөлтөд хүчилтөрөгч хэрэггүй байдаг.

4.4 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Бичил биетнүүдээр тухайн газрыг цэвэрлэх нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч хэдэн сар, тэр байтугай хэдэн ч жил болж мэднэ. Жишээлбэл энэхүү био нөхөн сэргээлт нь удаан хугацаа авч болно.

- Бохирдлын агууламж өндөр байгаа, эсвэл хөрс нь маш хатуу ба чулуулаг нь ан цавтай бол бохирдол тухайн газарт хүрч нэвтэрэхэд маш хэцүү байдаг.
- Бохирдсон газар нутгийн хэмжээ том, ихээхэн гүн,
- Температур, шим тэжээл болон бичил биетний тоо толгой өөрчлөгдсөн байх,
- Газар дээр цэвэрлэх ажиллагаа хийгдэнэ.

4.5 Био эмчилгээ (нөхөн сэргээлт) аюулгүй юу ?

Био нөхөн сэргээлтийг газар доорх ус ба хөрсөнд амьдарч байгаа байгалийн бичил биетнүүд дээр тулгуурлан хийдэг. Эдгээр бичил биетнүүд тухайн газар дахь болон орон нутгийн иргэдэд аюул занал учруулдаггүй. Тухайн газар дахь амьд биетийг нэмэгдүүлэхэд бичил биетнийг нэмж хийдэг ба эдгээр нь бохирдоод үхэх нь нийтлэг тул био нөхөн сэргээлтэд шаардлагатай орчин нөхцөл үгүй болсон байдаг. Био нөхөн сэргээлтийг дэмжихийн тулд химийн урвалж бодис нэмж өгөх нь аюулгүй байдаг. Жишээ нь, Цэцэрлэг, зүлэгт өргөн хэрэглэдэг бичил биетнийг ургуулахад шим тэжээлт бодисыг нэмж өгдөг ба зөвхөн био нөхөн сэргээлтэд хангалттай шим тэжээлийг нэмж байдаг. Цэвэрлэгээ амжилттай ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах ба хөгжин дэвжихийг хэмжих, газар доорх ус ба хөрсний дээжүүдэд тогтмол шинжилгээ хийж шалгана.

4.6 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Био нөхөн сэргээлт нь газар доогуур явагддаг бөгөөд тухайн газар болон эргэн тойрны олон нийтэд тэр бүр саад учруулах шалтгаан биш юм. Цэвэрлэгээний бусад аргуудтай харьцуулахад бохирдсон хөрс болон газар доорх ус нь тухайн газартаа байрлалтай, ачааны машины хөдөлгөөн багатай байдаг. Гэсэн хэдий ч орчин суугчид ба аж ахуй эрхлэгчид энэхүү био нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг эхлэх, нөхцөл байдлыг сайжруулахад ашиглах нэмэлт тэжээл оруулах шахуурга, зуурагч бусад барилгын тоног төхөөрөмжийн дууг сонсох болно. Мөн түүнчлэн гадарга дээрх био нөхөн сэргээлт хийхэд малталт ба шавхах ажил гарч болно. (Бохирдсон хөрсийг малтах тухай [EPA 542-F-12-007] иргэдийн гарын авлага үзнэ үү)

4.7 Яагаад био нөхөн сэргээлт хийдэг вэ ?

Био нөхөн сэргээлт нь тухайн газрыг цэвэрлэхэд байгалийн процессийг ашигладаг давуу талтай байна. Яагаад гэвэл энэ нь зарим нэг цэвэрлэх аргууд шиг олон тооны тоног төхөөрөмж, хөдөлмөр, эрчим хүч шаардахгүй учраас хямд байж болно. Өөр нэг давуу тал нь бохирдсон хөрс ба газар доорх усыг тухайн газарт нь малтлага хийхгүй, ус шахуурга ба тэдгээрийг хаа нэгтээ цэвэрлэгээний зориулалтаар тээвэрлэхгүйгээр цэвэрлэгээ хийж байгаа юм. Яагаад гэвэл бичил биетнүүд хортой химийн бодисыг бага хэмжээний ус болон хий болгон өөрчилдөг учраас цөөн ч гэсэн хаягдал дайвар бүтээгдэхүүн бий болгож байдаг. Био нөхөн сэргээлтээр маш олон бохирдсон газруудыг цэвэрлэсэн бөгөөд улс орон даяар 100гаруй цэвэрлэгээ хийх газрууд (Superfund) сонгогдоод ашиглагдаж байна.

4.8 Жишээ

Био нөхөн сэргээлтээр Нью Жерси дэх Исландийн “Coin” угаалгын талбайд хуурай цэвэрлэгээний уусгагч ашиглан газар доорх усыг цэвэрлэж байна. Био нөхөн сэргээлтийн талбай дахь нөхцлийг сайжруулахад нэмэлтүүдийг (тэжээл) нэмж өгдөг байна. Ургамлын тос ба натри бикарбонатыг гол төлөв өндөр агуулга бүхий

бохирдолтой газар нутаг дахь газар доорх усанд шахаж өгдөг шийдэл байдаг. Газар доорх усан дахь нянг нэмж өгсөнөөр одоо байгаа бичил биетнүүд-ийн тоо толгой нэмэгдэж байдаг. Цэвэрлэгээний талбайн хэмжээ 500 фут өргөн, 1800 фут урт, газраас доош 40 фут үргэлжилдэг. Газар доорх усны урьдчилсан туршилтаар энэхүү био нөхөн сэргээлт явагдаж байгаа ба бохирдлын агууламж буурч байна гэдгийг харуулж байна. Гол зорилго бол бохирдлын агууламжийг тэрбумын нэг хэсгээс багагүй,тэрбумын 10 буюу түүнээс ихгүй байхаар бууруулах ажлыг үргэлжлүүлэх явдал юм.

4.9 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 холбогдох буюу *www.cluin.org/biochlor; www.cluin. org/bioreactor ; www.cluin.org/bioventing-biosparging;* сайтуудыг үзнэ үү.

5 Хучилт хийх


5.1 Хучилт хийх гэж юу вэ?

Хог булах цэг дэх хаягдал ба бохирдсон хөрс адил бохирдсон материалуудыг хамарсан тэднийг дээрээс нь халхлан байрлуулсан хучилт юм. Иймэрхүү халхавчийг “хучилт” гэж нэрлэдэг. Хучилт нь бохирдлыг устгах буюу арилгадаггүй. Харин тэд хаягдлыг тусгаарладаг ба бохирдол тарахаас сэргийлж тухайн газарт нь хадгалж байдаг. Хучилт нь хүн ард болон зэрлэг ан амьтдыг бохирдолтой харьцахаас урьдчилан сэргийлдэг.

5.2 Энэ хэрхэн ажилладаг вэ?

Хучилт нь хэд хэдэн аргаар бохирдол тархахаас тусгаарлаж сэргийлдэг. Жишээлбэл дараах боломжтой хувилбарууд:

- Материалаар цасны болон бороony ус нэвчих, бохирдол газар доорх ус руу дамжихийг зогсоодог,
- Гаднаас үерийн усаар зөөгдөх бохир материалуудыг нуур, урсгал ус руу орохыг хорьж тогтоодог,
- Гаднаас салхиар үлээгдэж байгаа бохир материалуудаас урьдчилан сэргийлдэг,
- Дэгдэмхий химийн бодисын үйлдвэрлэл ба хаягдал агуулсан хий дамжихыг хянадаг (Тэдгээр нь ууршиx),
- Хүн ард болон зэрлэг ан амьтад ирж бохирдлын гаднах зам ба аюултай материалтай харьцахаас хамгаалдаг.



Example of a cover with several layers.

Тухайн талбайд сонгогдсон хучилтын зураг төсөл нь бохирдуулагчийн одоогийн агууламж ба төрөл, талбайн хэмжээ, талбай нь хэдий хэмжээний хур тунадас хүлээн авдаг, газрын ирээдүйн хэрэглээ зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Хучилтын барилга байгууламжид илүү их бохирдсон хаягдлыг тусгаарлах зорилгоор өөр өөр материалуудын хэд хэдэн давхаргыг байрлуулах ба хөнгөн бохирдсон хөрсний дээгүүр дан давхарга хучилт тавьж аль болох энгийн байрлалтай болгох хэрэгтэй.

Жишээ нь, хатуу хучилттай таг нь цаашид дахин ашиглах автомашины зогсоол шаарддаг эд хөрөнгийн хөрсний бохирдлын бага түвшинд хамгаалах сонгож болно. нь цаашид дахин ашиглах автомашины зогсоол шаарддаг газар байна.

Жишээ нь замын хар хучилт нь цаашид дахин ашиглах автомашины зогсоол болохыг хөрсний бохирдол бага түвшинг хамарсан үед сонгогддог байж магадгүй юм. Аюултай хог, хаягдал булах цэг дэх хучилт нь ургамлын, ус зайлуулах, геомембран, шаврын зэрэг хэд хэдэн давхаргыг шаардаж болох юм. Хучилтын тухай дараах сонголтуудын зарим нь:

- Замын хар ба бетон: Эдгээр материалуудын давхаргууд нь машины зогсоол болон барилгын суурийн хавтан болж чадна.
- Ургамлын давхарга: Өвс болон бусад ургамал тариалсан хөрсний дээд үе давхарга нь хөрсний элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ба тухайн газрыг илүү сайхан байгалийн мэт харагдуулдаг. Нийлбэр ууршилт буюу “ЕТ” нь бороо ба цасны хайлсан ус бохирдсон талбайг нэвт норгохоос хамгаалах дээд талын хөрс ба ургамлын хучилттай үе давхаргыг хамардаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг иргэдийн гарын авлага дахь нийлбэр ууршилтын хэсгээс үзнэ үү [EPA 542-F-12-006])
- Бохир ус зайлуулах үе давхарга: Хайрга буюу элсний үе давхарга нь гол төлөв дугуйлсан нүхтэй хоолойнуудын эгнээг агуулсан, энэ нь хучилтын дээд давхаргаар дамжих ямар ч усыг шавхрах ба ус цуглуулахаар барьсан.

- Геомембран давхарга: Маш хатуу хуванцар шиг материалаар хийгдсэн хуудасыг хий дээш алдагдах буюу бохир ус доош шавхагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг.
- Шавар давхарга: Нягтруулсан шаврын давхарга нь бохир ус доош шавхагдахаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Зарим хог булах, тухайлбал хотын хог булах цэгүүдэд газар доор бий болох метан хий болон бусад хийг гаргах системийг газар дор барьж болох юм.

5.3 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Хучилт хийх ажил нь хэдэн өдрөөс эхлэн хэдэн сар хүртэл хугацааг авдаг. Хучилтын ажил нь урт хугацаа авч болох юм.

- Бохирдсон талбай их байна.
- Хучилт хийх зураг төсөл зузаан буюу нарийн төвөгтэй байдаг.
- Цэвэр өнгөн хөрс, шавар, бусад хучилтын материалуудын хангамж орон нутагт байхгүй байдаг.

Хучилтыг зөв зохистой арчлах үед олон жилийн турш үр ашигтай байх болно. Тэдгээр нь сайн арчилгаанд байвал бохирдсон материалууд тухайн газартаа урт хугацаанд хадгалагдан үлдэнэ.

5.4 Хучилтын ажил нь аюулгүй байна уу ?

Хучилтыг зөв зохистой буюу сайн арчилж байвал хучилт нь тухайн газар дахь бохирдсон материалыг аюулгүй хадгалж чадна. Хучилтыг элээхгүй, ан цав үүсгэхгүй, нүх гаргахгүй байх нь бохирдолтой материалд ус хүргэхгүй урт хугацаанд тусгаарлаж байх болно. Цаг агаар, ургамлын үндэс, хүний үйл ажиллагаанаас болж хучилт гэмтээгүй эсэх, мөн ургамлын хучлага дээрх өвс ургамал ургаж байгаа эсэхийг тогтмол хянаж шалгаж байдаг. Мөн түүнчлэн хучилтын талбайн эргэн тойронд газар доорх усны хяналт, шинжилгээний цооногуудыг байрлуулдаг ба хэрэв ус нэвчиж байвал дээж авч тодорхойлдог.

5.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Тухайн талбайд хучилтын материалыг авчирах учраас оршин суугчид болон аж ахуй эрхлэгчид магадгүй түүнийг үзэхээр ирэхдээ ачааны машины хөдөлгөөн нэмэгдсэн мэт харагдаж болох юм. Хучилтын ажлыг хийхэд бульдозер, машинууд ба бусад дуу чимээ ихтэй тоног төхөөрөмжийг авчирч болох ба зарим үед хучилтад шаардлагатай малталт хийх шаардлагатай болдог. Малталтаас үүссэн тоос ба хучилтын ажлын үед малталтаас гарсан шороог овоолох буюу ус цацаж тоосыг багасган хянаж байдаг.

5.6 Яагаад хучилтыг хэрэглэдэг вэ ?

Хучилт нь бохирдол ба хог булах цэгийг тусгаарлах уламжлалт арга юм. Заримдаа энэ нь их хэмжээний эзлэхүүнтэй хөрс эсвэл бага хэмжээний бохирдолтой хаягдалд зориулан ашигладаг. Замын хар эсвэл бетоноор хийгдсэн юмуу, тэр байтугай өвсөн бүрхүүлтэй хөрсний давхаргатай хучилт нь зарим газруудад дахин ашиглах боломжийг олгодог. Хучилтыг орон даяар маш олон газарт (Superfund) ашиглахаар сонгосон байна.

5.7 Жишээ

Хучилт нь Нью Жерси дэх Roebling гангийн иж бүрэн цэвэрлэгээний талбай дээрх бохирдлоос байгаль орчин ба хүмүүсийг хамгаалахад ашиглагдаж байгаа хэд хэдэн аргын нэг юм. Талбайн нэг хэсэг болох таван акр торх ба бусад хог хаягдлуудтай газрыг тусад нь ялгасан. Талбайнуудын хоёр хэсэг газарт гангийн үйлдвэрийн бусад бохирдлууд ба металл агуулсан үлдэгдэл хоцорсон. Тухайлбал 2005 онд энэхүү хөрсөнд замын хар дэвссэн ба өвс тарьсан цэвэр хөрс суулгасан хоёр төрлийн хучилт хийгдсэн. Эдгээр хучилтуудын зорилго нь бохирдлын тархалтаас зайлсхийх ба хүмүүс ирж бохирдсон хөрстэй харьцахаас урьдчилан сэргийлэх юм. Хучилтыг тухайн газарт ирээдүйд ашиглахаар бодож зураг төслийг нь зохиосон байдаг. Нью Жерсигийн хөнгөн төмөр замын системд зориулсан станцыг тэрхүү газар дээр баригдсан ба замын хараар хийсэн хучлага нь авто машины зогсоол болж байна. Эргэн тойронд үлдсэн газрыг байгалийн байдалд ойртуулан өвч ургамал тарьж тохижуулдаг. Тухайн газар дахь энэ ажлын төлөвлөгөөнд хучилтыг урт удаан хугацаанд хэвээр хамгаалах ба хяналт шинжилгээний ажлууд орсон байдаг. Ирээдүйд хучилтын хөрсөнд малталт хийхийг зөвшөөрдөггүй.

5.8 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 утсаар холбогдоно уу.

6 Байгаль орчны сэргээлт

6.1 Байгаль орчны сэргээлт гэж юу вэ?

Байгаль орчны сэргээлт гэдэг нь бохирдсон газарт түүнийг өөрчлөхөөс өмнө байсантай төстэй байгаль орчинг эргүүлэн авчирах үйл явц юм. Үйлдвэрлэл, худалдаа болон бусад зориулалтаар газрыг ашиглах нь тэнд амьдарч байгаа амьтан, ургамлын газар нутгийг эзлэх ба (эдгээр амьтад нь тэр байгаль орчин ба өөр хоорондоо харилцан дасан зохицох аргуудтай) байгаль орчинд саад болох юм. Энэ газарт нуга, ой, чийглэг газар ба амьдрах орчин болон тухайн газрын байгалийн унаган шинж чанаруудыг сэргээх

боломжтой.Энэхүү үйл явц нь “байгаль орчны сэргээлт” буюу орон нутгийнханд цэцэрлэгт хүрээлэн бий болгож шинэ амьдрал өгөх эсвэл байгалийн унаган төрхийг бий болгож хадгалж үлдэх боломжтой.

6.2 Энэ хэрхэн ажилладаг вэ?

Байгаль орчны унаган төрхийг тухайн газарт авчирах нь өөр өөр хандлага, арга барил, тухайн газрын шинж чанараас шалтгаалах ба газрыг хөгжүүлэх ба ашиглах үеэр энэ нь хэрхэн яаж өөрчлөгдсөнийг хамрах юм. Байгаль орчны сэргээлт нь эхний ээлжинд өнгөрсөн ба одоо үеийн ургамал, амьтны төрөл зүйл, хөрсний төрлүүд, цаг агаар болон газрын бусад шинж чанаруудын тухай ойлголтыг шаарддаг. Энэ нь тухайн газрын зургууд ба хуучин гэрэл зургийг харж ойролцоо орших байгалийн газарт очиж, яг юу хийх талаар сайн ойлголттой болохын тулд орон нутгийн иргэдтэй ярилцах шаардлага гарч болно. Байгаль орчныг сэргээх маш чухал ажил гэж ту

хайн талбайг цэвэрлэх үйл ажиллагааг авч үздэг. Нийтлэг арга хэмжээнүүдийг авч үзвэл:

- Барилгууд ба бусад дэд бүтцийг нураах,
- Газрын гадаргууг өөрчлөх ба налууг дахин тогтоох,
- Одоо байгаа хөрсөнд “нэмэлт тэжээл” болох үржил шимтэй хөрс ба шим тэжээлт бодис эсвэл бусад байгалийн материалыг хөрсөнд хийснээр ургамал сайн ургахад тустай болох юм.
- Байгалийн голын голдрил ба чийглэг газруудыг хамгаалах ба шинээр бий болгох,
- Байгалийн мод, өвс болон бусад ургамлыг тарьж байх,
- Зэрлэг ан амьтдыг дахин тогтоох,

Шувуу, шавьж, тэр байтугай нүдэнд үл үзэгдэх организмууд, хөрс, ургамал, зэрлэг ан амьтдын хоорондын уялдаа холбоо байгаль орчныг сэргээх нэг чухал хэсэг болдог. Жишээ нь Америкийн Нэгдсэн Улсад байгальд цэцэглэдэг маш олон ургамалууд дахин ургах болон тэдний тархалтад зөгий, сарьсан багваахай, колибрууд болон бусад цэцгийн балаар хооллодог тоос хүртээгчид ихээхэн үүрэгтэй байдаг. Байгаль орчны сэргээлт нь ургамал ба ан амьтны аль аль нь хөгжих орчинг хангах явдал юм.

6.3 Байгаль орчны сэргээлт нь аюулгүй юу?

Ажлыг зөв зохистой төлөвлөж, удирдаж байх тохиолдолд байгаль орчны сэргээлт нь ямар нэгэн аюулгүй юм. Хэрэв тухайн талбайд бохирдсон хөрс болон газар доорх ус ямар нэгэн байдлаар үлдэж хоцрох боломж байгаа бол Байгаль орчныг хамгаалах агентлаг хүн ба ургамал, амьтдыг бохирдуулагч бодисоос тусгаарлах цэвэрлэгээний аргуудтай сэргээлтийн ажлыг хослуулж болох юм. Жишээлбэл, хамгаалалтын хучилтыг бохирдсон хөрсөнд байрлуулж болох бол бохирдсон хөрс болон газар доорх усны

эргэн тойронд босоо инженерийн хаалтыг байрлуулж болно. (А иргэдийн гарын авлагын Хучилт суулгах тухай хэсэг [EPA 542 F-12- 004], А иргэдийн гарын авлагын Инженерийн босоо хаалтын хэсэг [EPA 542-F-12-022] зэргийг үзнэ үү). Мөн түүнчлэн байгаль орчны сэргээлтийг бохирдлыг идэвхитэй цэвэрлэх аргаар тасралтгүй хийж болдог.

6.4 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Байгаль орчныг сэргээх төсөл нь хаашаа ч юм хэдэн сараас хэдэн жилийн хугацааг ч авч болно. Энэ нь байгалийн идээшсэн орчинг сэргээх хугацаа нь хэд хэдэн хүчин зүйлүүдээс хамаарна. Жишээ нь энэ нь удаан хугацаа авч болно:

- Ургамал нь урт удаан амьдралын мөчлөгтэй байх ба нас бие гүйцэхэд удаан хугацаа шаардагдана.
- Үрийн соёололт, ургамлын өсөлтөд таагүй цаг агаар (тухайлбал, ган гачиг гэх мэт) тохиолддог.
- Амьтан ба хорхой шавьжны идэж байгаа ургамлууд солигдох ёстой.
- Голын голдрилыг сэргээсэн байх ёстой ба мөн эргийг хүчтэй элэгдлээс хамгаалахын тулд тогтвортой болгосон байх ёстой, эсвэл ус намгархаг газар мэт идээшсэн орчинг эхнээс нь зохих түвшинд бий болгох хэрэгтэй.
- Температур, шим тэжээлт бодисын түвшин ба бичил биетүүдийн тоо толгой зэргээс хамааран хөрсний нөхцөл байдал өөрчлөгдсөн байх ёстой.

Эдгээр хүчин зүйлүүд нэг газраас нөгөө талбай хүртэл хувирч өөрчлөгдөнө.

6.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Ерөнхийдөө, байгаль орчныг сэргээх ажил нь эргэн тойрон дахь олон нийтэд үймээн дэгдээх шалтгаан учруулдаггүй. Эхний ээлжинд хөрсийг ангилах ба газар шорооны тоног төхөөрөмжөөр хөрсийг боловсруулах ажлууд хамрагдана. Тухайн газрын ойролцоох оршин суугчид ба аж ахуй эрхлэгчид тоног төхөөрөмж-ийн дуу чимээ сонсох ба хөрс нь модны хаягдал, малын өтөг, органик бордоо гэх мэт байгалийн нэмэлт тэжээлүүдтэй холилдсон үнэр хашаанд илэрч байдаг. Агаарт тархсан тоосыг услаж хөрсөн шингээх байдлаар хянадаг.

6.6 Яагаад байгаль орчны сэргээлт хийдэг вэ?

Байгаль орчны сэргээлт нь бохирдсон талбайн нөхцлийг сайжруулах ба ихэвчлэн хөрс ба газар доорх ус цэвэрлэх аргуудыг ашигладаг. Энэ бол бохирдсон талбайг цэвэрлэх ажлын явц эхлэх үед хамгийн амжилттай байдаг. Байгаль орчны сэргээлт нь гол төлөв үржил шим нь алдагдсан газрыг нөхөн сэргээх ба олон нийтэд зориулсан байгаль орчны таатай нөхцөл, нөөцийг бий болгох явдал юм. Энэ нь бохирдлыг хүн ба зэрлэг ан амьтдаас тусгаарлах ба зайлуулахад тусладаг, мөн түүнчлэн хөрсний элэгдлийг багасгадаг байна. Дахин сэргээсэн газрууд нь агаар, усны чанарыг сайжруулах, зэрлэг

ан амьтдын амьдрах орчинг бий болгоход туслах ба цэцэрлэгт хүрээлэн дэх ногоон талбай, амралт зугаалгын газар, байгалийн нөөцийг нэмэгдүүлнэ. Бохирдсон газруудыг буцааж үр ашигтай ашиглах нь газрын (үл хөдлөх хөрөнгө) үнэ цэнэ, амралт чөлөөт цагийн төвүүд болон нилээд шигүү суурьшсан талбай дахь хамгаалагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлдэг.

6.7 Жишээ

Хэсэг хугацааны өмнө, Delaware-ийн далайн нарийн булан дахь Армийн хог булах цэг нь орон нутгийн ус хангамжийн худгийн ойролцоо тонн тонн бохирдсон хогоор пиг дүүрсэн байсан. Delaware нь АНУ-ын Атлантын далайн эрэг дэх том гол юм. Газрыг цэвэрлэсэн ба хөнгөн бохирдолтой хөрсөн дээр хамгаалалтын хучилтыг барьсаны дараа Байгаль орчныг хамгаалах агентлагаас нүүдлийн шувуудын суурьших, амрах болон хооллох орчинг хангах өвс ургамал, зэрлэг цэцэгс болон бусад унаган ургамлыг тарьсан байна. Далайн нарийн булангийн дагуу шувуу үүрлэх хайрцагуудыг байрлуулсан ба тэдний хоол хүнсний эх үүсвэрийг дэмжих тошлой тарьсан байв. Шувуу үүрлэх улирал, амьдрах орчинд саад болохгүйн тулд тухайн газрын өвсийг жилд нэг удаа намар тайрдаг. Хавар, зуны туршид байх өндөр өвс шувуу болон жижиг амьтад мөн түүнчлэн ургамлын үр, шавьжийн хувьд амьдрах таатай орчин, шувуудын хооллох бас нэг эх үүсвэр орон байр болдог. Байгаль орчныг хамгаалах агентлаг ургамал, амьтан, шувуудын олон төрөл зүйлийн амьдрах орчныг хангах ус намгархаг газрыг барьсан байна. Байгаль орчны сэргээлт олон нийтэд зориулсан газрыг сайжруу-лан зэрлэг ан амьтдын амьдрал буцалсан талбай болгон өөрчилж байна.

6.8 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 холбогдох буюу www.cluin.org/ecotools сайтуудыг үзнэ үү.

7 Бохирдсон хөрсний малталт

7.1 Бохирдсон хөрсний малталт гэж юу вэ ?

Тухайн газар дахь бохирдсон хөрсний малталтад хог булах цэгт зайлуулах хаягдал ба хөрсийг ухаж гадарга дээр гаргах цэвэрлэгээ зэрэг хамардаг байна. Малталт нь химийн бодистой хуучин торхнууд ба бусад дарагдсан магадгүй бохирдсон хэмхэрхийнүүдийг зайлуулах ажлыг хамарч байж болох юм. Эдгээр их хэмжээний бохирдлын эх сурвалжийг зайлуулах нь магадгүй одоогийн газар доорх бохирдсон усыг хурдан цэвэрлэхэд туслах ба хүмүүсийг бохирдолтой харьцахаас хамгаалдаг.

7.2 Энэ хэрхэн ажилладаг вэ?

Газар шорооны ажлыг эхлэхийн өмнө бохирдсон талбайнуудыг ялгаж таних ажил хийгдсэн байх ёстой ба малталт эхлэх боломжтой. Энэ ажилд тухайн газраас магадгүй ямар бохирдол, хаана байж болохыг таньж тогтоох талаар өнгөрсөн үйл ажиллагааг судлах шаардлагатай. Дараа нь хөрсний бохирдол байгаа бол түүнийг илүү сайн тодорхойлох туршилт явуулж байдаг. Бохирдсон хөрсийг шанагат экскаватор, замын ажил хийдэг том ухдаг машин гэх мэт стандарт тоног төхөөрөмжийг ашиглан ухаж байна.



Soil piles are covered with plastic tarps during excavation.



Worker collects soil samples to confirm that soil left onsite is clean.

Сонгосон төхөөрөмж бохирдсон талбайн хэр том болон гүнээс хамаарах ба хүрэх боломжгүй барилга буюу бусад шилжүүлэх боломжгүй байгууламжийн аль алинаар хязгаарлагддаг байна. Урт гартай экскаватор газраас доош 100 фут гүнд хүрч чадах боловч, малтлага ерөнхийдөө ухсан нүхийг хамгаалах хүндрэлтэй ба аюулгүй байдлын улмаас маш бага гүнээр хязгаарлагдаж байдаг. Заримдаа хөрсийг уст үеийн түвшингөөс доош ухдаг, энд бохирдсон талбайн ханыг нураах хэрэгтэй болох ба шаардлагатай усыг шавхаж малтлагын үед хуурай байлгах арга хэмжээ авдаг. Ухаж гаргасан хөрсийг хог булах цэгт асгаж зайлуулдаг ба үүнийг шууд ачааны машин дээр ачиж тээвэрлэлтэд бэлтгэж болох юм. Хэрэв үүнийг өөр хаа нэгтээ зориулалтын талбайд хаях ба цэвэрлэх гэж байгаа бол ус нэвтрэхгүй хуванцар уут ба савand хийж өрж тавих хэрэгтэй юм. Ингэсэн хөрсийг дараа нь салхинд хийсэх, борооны усанд угаагдахаас урьдчилан сэргийлэх, бохирдсон хөрстэй ажилчдыг харьцахаас хамгаалах зорилгоор ус үл нэвтрүүлэх бэржээнх даавуу-гаар хучиж бүтээдэг. Ухсан нүхний эргэн тойронд үлдсэн

хөрсний шинжилгээний үр дүн цэвэрлэгээний түвшингийн утгатай яг таарч байх үед малталтыг бүрэн дууссан гэж үзнэ. Ухаж гаргасан хөрсийг талбайгаас зайлуулах ба талбайд авчирсан цэвэрлэгээний хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг ашиглан цэвэрлэж болох юм. Хэрэв хөрс талбай дээрээ цэвэрлэгдсэн бол ухсан газрыг дүүргэхэд хөрсийг ашиглаж болох юм. Ухсан нүхийг дүүргэхэд бусад газраас авчирсан цэвэр хөрсийг мөн ашиглах хэрэгтэй болно. Ухсаны дараа нүхийг дахин дүүргэж хөрсний элэгдлээс сэргийлэх ба газрыг сэтгэл татам болгох нь байгалийн байдалд хүргэнэ.

7.3 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Бохирдсон хөрсийг ухах ажил нь бага буюу нэг өдөр эсвэл олон жилийн хугацаа авч болох юм. Хөрсийг ухах ажлын бодит хугацаа нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Жишээ нь магадгүй энд нилээд урт хугацаа шаардагдаж болох юм.

- Бохирдсон газрын талбай маш том, тэгээд гүн ба газар доорх усны түвшингээс доогуур байгаа бол,
- Бохирдуулагчийн агууламж маш өндөр байгаа нь аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх нэмэлт арга хэмжээ шаардлагатай болдог,
- Бохирдсон хөрс маш их хэмжээний чулуу, хэмхэрхий агуулж байдаг,
- Барилга ба газрын үйл ажиллагаа нь тоног төхөөрөмжийн хөдөлгөөнийг хязгаарладаг,
- Газар нь цэвэрлэх ба зайлуулах байгууламжаас хол байна.

Эдгээр хүчин зүйлүүд нэг газраас нөгөө талбай хүртэл хувирч өөрчлөгдөнө.

7.4 Малталтын ажил нь аюулгүй юу?

Бохирдсон хөрстэй харьцахад аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шаарддаг. Талбай дээр ажиллагсад хөрсийг малтаж байх үед бохирдолтой харьцахаас зайлсхийх, талбайгаас бохирдол тархахаас урьдчилан сэргийлэхийн талаар аюулгүй ажиллагааны журмуудыг судалж бэлтгэгдсэн байна. Талбай дээр ажиллагсад голдуу резинэн бээлий, гутал, хатуу малгай болон ажлын комбинозон зэрэг хамгаалалтын хувцас өмсдөг.Бохирдсон хөрсийг тэдний гутал болон хувцас хунар тээж явахаас сэргийлэх үүднээс ажилчид талбайгаас гарахын өмнө эдгээр зүйлсийн аль алиныг угааж цэвэрлэх, эсвэл хаядаг. Ачааны машин түүний дугуй болон бусад газар шорооны тоног төхөөрөмжийн гадна талыг, талбайг орхихын өмнө ойролцоох гудамжинд зам мөр гараагүй байхад нь угааж байдаг. Ажилчдын амьсгалахад аюул учруулж болзошгүй тоос, бохирдсон уур байх түвшинд байхгүй байгаа бол түүнийг магадлах үүднээс хянах ба талбайн эргэн тойрон дахь агаар дахь тоос ба уур талбайг орхиж байгаа эсэхийг хянадаг. Малталтын талбайд ойр ажиллагсадад хиймэл амьсгалын аппарат хэрэгтэй болох ба энэ нь агаар дахь тоос болон бохирдуулагчийг шүүх шүүлтүүртэй нүүрний баг буюу “амны хаалт ” байдаг.

Бохирдсон хөрс гол төлөв түүнийг бохирдлыг цэвэрлэх болон устгах, агаараар тардаг тоос борооны усаар угаагдах хүртэл хадгалагдаж байдаг. Бохирдуулагч уур, хөөсөнцөр ба бусад материалуудад нуугдаж байж болох юм.

7.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Хөрсний малталтын үеэр ачааны машины хөдөлгөөн нэмэгдэх ба газар шорооны тоног төхөөрөмжийн дуу чимээ ихсэх үед ойролцоох оршин суугчид ба аж ахуй эрхлэгчид санал шүүмж гаргаж болох юм. Ухсан нүхийг дүүргэж, цэвэр хөрсөөр хучих хүртэл талбайд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх хашаа баригдсан байна.

7.6 Яагаад бохирдсон хөрсийг ухаж гаргадаг вэ ?

Малталт бол түгээмэл хэрэглэгддэг, харин газар дээрх цэвэрлэгээний арга нь хурдан биш бөгөөд үнэ ихтэй арга юм. Талбайгаас бохирдлыг зайлуулах ба газар дээрх цэвэрлэгээ нь ихэнхдээ хүн болон хүрээлэн буй орчинд шууд эрсдэл учруулж болох бохирдлын хэмжээ өндөр түвшинд байхад гол төлөв хамгийн хурдан цэвэрлэх аргуудын нэг юм. Хөрсний бохирдлын хэмжээ бага хэмжээтэй байхад малталтын арга нь харьцангуй зардал багатай цэвэрлэх арга юм.

7.7 Жишээ

Цэвэрлэгээний талбайн ойр орчмын ухсан хөрсний хаягдал Нью Жерси дэх Холбооны мод хамгаалах талбайд (Superfund) цэвэрлэх ажил хийгдэж байсан Мод цэвэрлэх тоног төхөөрөмж 1950-иад онд хаагдсаны дараа 50 акр газар дээр орон сууц, мөн худалдааны цогцолбор баригдсан байна. Химийн хаягдал бодис ба мод хамгаалах тосны хуримтлал цүлхэн үүссэнийг барилгын ажлын үеэр булж дарсан. Тэнд бохирдол байгааг 1990 онд нээсэн байна. Үүний дараа 2002 оноос 2008 оны хооронд 35 фут гүнтэй газрыг 93 айлын байшингийн ойролцоо ухсан байна. Зарим оршин суугчдыг нүүлгэн шилжүүлсэн бөгөөд 18 айлын байшингийн доорх бохирдсон хөрсийг авахын тулд байшингуудыг нураасан.Энэ бүс нутгаас нийтдээ 275,000 тонн хөрсийг тээвэрлэж гадна талбайд цэвэрлэх ажлыг гүйцэтгэж байна.Өөр нэг 177,000 тонн хөрсийг худалдааны төвийн газраас ухаж байжээ.Малтсан газрыг дүүргэх ажилд маш цэвэр хөрс ашиглагдсан. Ажлыг гүйцэтгэх бүхий л явцад ажилчид агаарын хянадаг. Мод илжрүүлэхгүй тосны үнэрийг багасгахын тулд хөрсийг хөөс болон хуванцар материалаар бүтээдэг байна. Талбайгаас ачааны автомашиныг хөдлөхөөс өмнө цэвэрлэсэн байна.

8 Газар дээрх химийн бодисын исэлдэл

8.1 Газар дээрх химийн бодисын исэлдэл гэж юу вэ?


Химийн бодисын исэлдэл нь химичдын нэрлэдэг “Хүчиллэг бодис”-ыг ашигладаг энэ нь хор хөнөөлтэй бохирдлыг бага хортой болгон өөрчилөхөд тусладаг. Энэ нь ихэвчлэн хөрсийг ухахгүй, газар доорх усыг шавхахгүй, тухайн талбай дээр буюу газар дээр

цэвэрлэгээ явуулдаг учраас нийтээр “газар дээрх” гэж тодорхойлон өгүүлсэн байдаг. Газар дээрх химийн бодисын исэлдэл “ISCO” нь түлш, уусгагч болон хортон шавьжны хор зэрэг олон төрлийн бохирдлыг цэвэрлэхэд ашиглаж болно. Газар дээрх химийн бодисын исэлдлийг гол төлөв бохирдол анх бий болсон газрын эх үүсвэр дэх газар доорх ус ба хөрсийг цэвэрлэхэд ашиглаж байна.Газрын эх сурвалж магадгүй бохирдлыг агуулж байж ч болох гэхдээ газар доорх ус руу хараахан тараагүй байна. Газар дээрх химийн бодисын исэлдлийн аргыг хэрэглэх нь бусад цэвэрлэгээний аргууд тухайлбал шахуурга ба цэвэрлэгээ арга нь байгалийн хяналтыг бууруулж, гол төлөв бага хэмжээний бохирдлуудыг цэвэрлэхэд ашиглаж байна.

Ийм насос, эмчлэх, эсвэл хяналт байгалийн бууруулж дараах ISCO, бусад цэвэрлэгээ хийх аргыг хэрэглэх, бохирдол орхиж жижиг хэмжээний цэвэрлэж ашиглаж байна. (А иргэдийн гарын авлагын Ус шахуурга ба цэвэрлэгээ, Байгалийн ажиглалтын бууралт хэсэг [EPA 542-F-12-017] А иргэдийн гарын авлагын цэвэрлэгээ хэсгийг үзнэ үү [EPA 542-F-12-014].)

8.2 Энэ хэрхэн ажилладаг вэ?

Бохирдсон газар доорх ус ба хөрсөнд хүчиллэг бодисуудыг нэмсэн үед химийн урвал явагдаж бохирдлуудыг устгах ба хоргүй дайвар бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг. Газар дээрх хөрс ба газар доорх усыг цэвэрлэхийн тулд ихэвчлэн хүчиллэг бодисыг худгаар дамжуулан шахуургаар газар доорх усанд шахдаг. Талбайн бохирдлын эх үүсвэрт худгууд янз бүрийн гүнд суурилагдсан бөгөөд уусдаггүй бохирдлыг аль болох их хэмжээгээр уусгахад хүрэх хэрэгтэй.



Нэгэнт хүчиллэг бодисууд худагт шахагдсан бол энэ нь бохирдуулагчтай урвалд орж хөрс ба газар доорх устай холилдон эргэн тойронд тархдаг. Газар доорх ус ба хүчиллэг бодисыг сайн холихын тулд худгийн доторх эргэлтийг сайжруулж болох юм. Эхлээд нэг худагт хүчиллэг бодисуудыг шахуургаар шахах ба дараа нь хүчиллэг бодисуудтай холилдсон худгийн усыг өөр нэг худгаас шавхах явдал юм. Холилдсон усыг худгаас шавхсаны дараа эхний худаг руу хүчиллэг бодисуудыг нэмж эргэлтэд оруулдаг. Газар доорх усны эргэлт нь том хэмжээний талбайг маш хурдан цэвэрлэхэд тусалдаг. Өөр нэг

арга нь тарих буюу механик хэрэгсэл ба газар ухах тоног төхөөрөмжийг ашиглан хүчиллэг бодисуудыг холих явдал юм. Энэ нь шавар хөрсний тухайд ашиг тустай байж болох юм. Газар дээрх химийн бодисын исэлдэл эсвэл “ISCO” тухайд дөрвөн гол перманганат, персульфат, устөрөгчийн хэт исэл, озоны хүчиллэг бодисууд байдаг. Эхний гурван хүчиллэг бодис нь гол төлөв шингэн хэлбэрээр шахаж байдаг. Озон нь маш хүчтэй исэлдүүлэгч бөгөөд энэ нь ашиглахад маш хэцүү хий юм. Ийм учраас энэ хийг маш бага хэргэлэж байна. Хурдасгуурыг заримдаа тодорхой исэлдүүлэгчидтэй ашигладаг. Хурдасгуур нь химийн урвалын хурдыг ихэсгэдэг бодис юм. Жишээ нь устөрөгчийн хэт ислийг төмрийн хурдасгуурт нэмсэн бол холимог илүү идэвхитэй болж дангаар байх устөрөгчийн хэт ислээс илүү бохирдлыг устгадаг. Хэрэв бохирдуулагчийн агууламж өндөр авч эхлэх буюу “дахин сэргэх” болж ирвэл цэвэрлэгээний хоёрдахь, гуравдахь удаагийн нэмэлтийг дагаж мөрдөх хэрэгтэй болох юм. Хэрэв шахаж байгаа хүчиллэг бодисууд бүх бохирдуулагчид хүрч чадахгүй бохирдол дахин сэргэх бол бүх бохирдлыг цэвэрлэхээс өмнө хүчиллэг бодисуудыг ашиглаж болно. Бохирдуулагч бодис хяналтын цооног хүрч бохирдол дахин сэргэж байгааг тодорхойлох хүртэл хэдэн долоо хоногоос сар хүртэл хугацаанд үргэлжилж болно. Газар дээрх химийн бодисын исэлдэл эсвэл “ISCO” нь газар доор магадгүй хангалттай дулааныг бий болгосноор хөрс ба газар доорх усан дахь бохирдол ууршиж газрын гадаргад гарч ирэх шалтгаан болдог. Исэлдүүлэгчийн хэмжээг хянаж байх нь хэт халуун үүсэхээс зайлсхийхэд туслах ба хэрэв нэлээд хэмжээний хий үйлдвэрлэж байгаа бол түүнийг тогтвортой барьж цэвэрлэж чадах боломжтой.

8.3 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Газар дээрх химийн бодисын исэлдэл эсвэл “ISCO” нь талбайн бохирдлын эх үүсвэрийг цэвэрлэх харьцангуй хурдан арга юм. Цэвэрлэх ажил нь хэдэн сар, жил ба нилээн хэдэн жил, хэдэн арван жилийн ч хугацаа авч болно. Цэвэрлэгээ-ний ажлын бодит хугацаа нэг газраас нөгөө талбай хүртэл хувирч өөрчлөгдөх бөгөөд хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Жишээ нь газар дээрх химийн бодисын исэлдэлд нилээд урт хугацаа шаардагдаж болох юм.

- Талбайн бохирдлын эх үүсвэр том,
- Бохирдуулагч бодис хүрэхэд хэцүү, ан цавтай, шавартай газарт хязгаар-лагдан оршиж байна.
- Хөрс ба чулуулаг нь исэлдүүлэгч хурдан жигд тархах боломжийг олгодоггүй.
- Газар доорх усны урсгал удаан байна.
- Исэлдүүлэгч газар доор удаан хугацаанд үргэлжлэн байдаггүй.

8.4 Газар дээрх химийн бодисын исэлдэл нь аюулгүй юу ?

Газар дээрх химийн бодисын исэлдэлтийг ашиглах нь эргэн тойрон дахь орон нутгийн иргэдэд бага эрсдэл учруулдаг. Исэлдүүлэгчтэй ажиллаж байх үед ажилчид

хамгаалалтын хувцас өмсөх ба түүнтэй зөв зохистой харьцаж байхад эдгээр химийн бодисууд хүн ба байгаль орчинд хор хөнөөлтэй биш юм. Бохирдсон хөрс ба газар доорх ус яагаад гэвэл газар доор цэвэрлэгдэх учраас химийн бодисын исэлдэлт эсвэл бусад талбай дахь бохирдол ажилчидад ил харагдахгүй юм. Ажилчид химийн бодисын исэлдэл явагдаж байгаа эсэхийг шалгах ба хөрсний болон газар доорх ус баталгаатай эсэхийг байнга шинжилдэг.

8.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ ?

Ойролцоохь оршин суугчид ба аж ахуй эрхлэгчид исэлдүүлэгч ачсан автомашин болон өрмийн машин, талбайд ирэх цэнэглэгч машин зэргийг харж болох юм. Оршин суугчид өрөмдлөгийн ажлын явцад болон ус шахуурга, бусад гол тоног төхөөрөмжүүдийг авчирах, хүчиллэг бодисуудыг шахах үед дуу чимээ сонсож болох юм. Бодисуудыг шахсаны дараа цэвэрлэх үйл явц газар доор тохиолдох ба хэдий ийм боловч газар дээр бага зэргийн саад учруулж болох юм. Ажилчид талбайд хөрс ба газар доорх усны дээжийг цуглуулах ба цэвэрлэгээний ажлын байдлыг хянахаар очиж болох юм.

8.6 Яагаад ISCO хэрэглэдэг вэ ?

Газар дээрх химийн бодисын исэлдэл эсвэл “ISCO” нь талбайн газар доорх эх үүсвэрийг цэвэрлэхэд гол төлөв сонгох ба газар дээрх цэвэрлэгээний тухайд газар доорх усыг шавхахгүй, талбайн хөрсийг ухахгүй бохирдлын дийлэнх хэсгийг устгадаг. Энэ нь цаг хугацаа, мөнгө хэмнэж чадна. Газар дээрх химийн бодисын исэлдэл нь маш олон бохирдсон газрыг цэвэрлэсэн бөгөөд ойролцоогоор 40 газарт ашигласан буюу улс орон даяар бусад олон газруудад ашиглахаар сонгогдоод байна.

8.7 Жишээ

Флорида дахь Тэнгисийн цэргийн агаарын станц “Pensacola” дахь хуучин бохир ус цэвэрлэх байгууламжийн ойролцоо газар доорх ус дамжуулагчаар бүрсэн ба будгийн ажлын хүчил болон уусгагчаар бохирдсон байна. Газар доорх усны шахуурга ба цэвэрлэх систем газар доорх усны шилжилт хөдөлгөөнийг хянаад 10 гаруй жил үйл ажиллагаа явуулаад байна. Гэсэн хэдий ч, энэ нь бохирдлын агууламжийг тийм ч сайн бууруулж чадахгүй байгаа юм. Газар дээрх химийн бодисын исэлдэл төмрийн хурдасгууртай устөрөгчийн хэт ислийг ашиглан талбайн газар доорх эх үүсвэр дэх бохирдлын агууламжийг багасгах, байгалийг доройтлыг бүрэн цэвэрлэх ажлыг хангалттай хянах боломжийг олгодог. Талбайн газар доорх усны байгалийн ердийн хими нь газрын гүнд шахсан хүчиллэг бодисуудын эхний үе шатны үр нөлөөг хязгаарлах хэрэгтэй болсоныг мэдсэн. Хоёр дахь үе шатанд исэлдүүлэгч холимогийг тогтворжуулахын тулд холилдсон урвалж бодис дээр химийн бодис нэмж өгдөг. Бохирдлын түвшин ихээхэн хэмжээгээр буурсан байна. Газар дээрх химийн бодисын исэлдлийг энэ талбайд амжилттай ашиглах нь цэвэрлэх ба байнга шахуурга хэрэглэхтэй харьцуулахад хэдэн сая доллар хэмнэх тооцоо гарсан байна.

8.8 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 утсаар холбогдох буюу www.cluin.org/chemox үзнэ үү.

9 Газар дээрх химийн бодисын бууралт

9.1 Химийн бодисын бууралт гэж юу вэ?

Газар дээрх химийн бодисын бууралт "ISCR" нь бохирдлыг хор багатай, хөдөлгөөн удаантай хэлбэрт өөрчлөн хувиргахад туслах “Бууруулах бодис” гэж нэрлэдэг химийн бодис ашигладаг. Энэ нь хөрсийг ухахгүй, газар доорх усыг соруулахгүй тухайн газарт нь цэвэрлэгээг явуулдаг учраас “газар дээр нь” гэж тодорхойлон өгүүлдэг. Газар дээрх химийн бодисын бууралт буюу "ISCR" нь газар доорх усанд ууссан хэд хэдэн төрлийн бохирдлыг цэвэрлэж чаддаг. Мөн үүнийг газар доорх усанд амархан уусдаггүй ба удаан хугацаанд бохирдлын эх үүсвэр байж чадах “Ус агуулсан нягт бус шингэн үе” буюу “DNAPLs” гэж нэрлэдэг бохирдлыг цэвэрлэхэд ашиглаж болно. "ISCR" нь ихэвчлэн металлын хром ба аж үйлдвэрийн уусгагч “trichloroethene” буюу “TCE” - ийг цэвэрлэхэд гол төлөв ашиглагдана. ISCR нь ихэвчлэн DNAPL Металлын хром, аж үйлдвэрийн уусгагч trichloroethene буюу "TCE"-ийг цэвэрлэхэд хэрэглэгддэг.

9.2 Энэ хэрхэн ажилладаг вэ?

Бохирдсон хөрс ба газар доорх усанд бууруулах бодисыг нэмж байгаа тохиолдолд химийн урвал явагдаж бохирдлыг өөр хэлбэрт хувирган өөрчилдөг. Жишээлбэл газар доорх усанд бууруулах бодисыг шахаж байх үед хром 6 буюу “hexavalent chromium” гэж нэрлэдэг маш хортой хэлбэр нь хром 3 хэлбэрт орж өөрчлөгдөнө. Харин хром 3 нь маш бага хортой металлын хэлбэр юм. Хром 3 нь маш удаан шилжиж хөдөлдөг учраас усанд амархан уусдаггүй. Нийтлэг бууруулах бодисууд нь тэдгээр нь цэвэр хэлбэрт байхдаа металл нь тэг валенттай байдаг. Газар дээрх химийн бодисын бууралт буюу "ISCR"-д хамгийн нийтлэг хэрэглэгддэг металл нь тэг валенттай төмөр буюу “ZVI” байдаг.

Тэг валенттай төмрийг газар дээрх химийн бодисын бууралтад ашиглах ба доторх жижиг талстууд гадаргуугийн өөд явж байдаг. Зарим тохиолдолд, бичил эсвэл нано (маш бага хэмжээтэй) өчүүхэн төдий хэсгүүд ашиглаж байна.




Illustration of the treatment of contaminated water with a PRB made of ZVI.

Жижиг хэсгүүдийн тоо хэмжээг нэмэгдүүлснээр бохирдолтой урвалд орох боломжтой төмрийн хэмжээг нэмэгдүүлдэг. Бусад нийтлэг бууруулах бодисуудад хоёр өөр төмөр хүртэл хийсэн байна, хүхрийн атомын гинж бүхий химийн нэгдэл (polysulfides), хүхрийн сулхан үнэртэй талст ширхэгтэй цагаан нутаг (sodium dithionite), натрийн dithionite, хоёр валент төмрийн нэгдэл (ferrous iron) болон хоёр металл нэгдсэн материал (bimetallic materials) зэрэг орсон байна. ISCR-д хамгийн өргөн хэрэглэдэг хоёр металл нэгдсэн материал нь мөнгө эсвэл палладины нимгэн үеэр бүрсэн нимгэн давхаргатай төмөр байдаг. Палладин гэдэг нь Pd химийн элемент юм.

Бохирдсон хөрс болон газар доорх устай харилцах бууруулах бодисуудыг авчирах хоёр арга зам байдаг. Үүнд: шууд шахах ба ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана барьж "PRB" байгуулах. Шууд шахах аргад бууруулах бодисыг устай хольж өтгөн цутан (эсвэл зарим тохиолдолд ургамлын тос) бэлтгэж өрөмдсөн цооногийн нүхээр хөрс ба газар доорх ус руу шахдаг. Энэ арга нь маш их бохирдолтой талбайн эх үүсвэрийг цэвэрлэхэд ашигладаг бөгөөд “Ус агуулсан нягт бус шингэн үе” буюу “DNAPLs” - ийг хамарч байдаг. Газар доорх усанд төмрийн уусмалыг шахахад гол төлөв нано хэмжээтэй тэг валенттай төмрийг,заримдаа том хэмжээтэй тэг валенттай төмрийг ашигладаг.

Ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаал бүхий ханыг гол төлөв газрын гадаргаас доош суваг ухаж барьдаг ба сувгийг бууруулах бодисоор дүүргэдэг. Тэг валенттай төмөр буюу “ZVI” -ийн том хэсгүүд нь төмрийн үенцэрүүд түгээмэл хэрэглэгддэг байна. Яагаад гэвэл хаалт бүхий хана "PRB" газар доорх усыг нэвтрүүлдэг, энэ нь бохирдол бууруулах бодистой урвалд орох боломжийг хангах ба цэвэрлэсэн ус хананы нөгөө талд урсан гардаг байна. Энэхүү хаалт бүхий хана нь газар доорх усанд ууссан бохирдлыг цэвэрлэхэд ашиглагдаж байна. Энэ нь зөвхөн ханаар дамжин урсах усыг цэвэрлэхэд зориулагдсан. (А Иргэдийн гарын авлагын Ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хананы гэсн хэсгийг [EPA 542-12-015] үзнэ үү.

9.3 Энэ нь хир удаан үргэлжлэх вэ ?

Хэдэн сарын хугацаанд талбайн эх үүсвэрийг цэвэрлэхэд бага шиг хэмжээний "ISCR" -ийг ашиглан шууд шахаж болох бөгөөд харин нэвчүүлж урвалд оруулах хаалт бүхий хана барьж "PRB" байгуулах нь хэдэн жилийн ч хугацаа зарцуулж болох юм. Цэвэрлэгээний ажлын бодит хугацаа нэг газраас нөгөө талбай хүртэл хувирч өөрчлөгдөх ба хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Эишээ нь газар дээрх химийн бодисын бууралт буюу "ISCR" -д нилээд урт хугацаа шаардагдаж болох юм.

- Талбайн бохирдлын эх үүсвэр том,
- Бохирдуулагч бодис хүрэхэд хэцүү, ан цавтай, шавартай газарт хязгаар-лагдан оршиж байна.
- Хөрс ба чулуулаг нь бууруулагч бодис хурдан жигд тархах боломжийг олгодоггүй.
- Газар доорх усны урсгал удаан байна.

9.4 Газар дээрх химийн бодисын бууруулах нь аюулгүй байна уу ?

Газар дээрх химийн бодисын бууралт буюу "ISCR" -ийг ашиглах нь эргэн тойрон дахь орон нутгийн иргэдэд бага эрсдэл учруулдаг. Бууруулагч бодисуудтай ажиллаж байх үед ажилчид хамгаалалтын хувцас өмсөх ба түүнтэй зөв зохистой харьцаж байхад эдгээр химийн бодисууд хүн ба байгаль орчинд хор хөнөөлтэй биш юм. Бохирдсон хөрс ба газар доорх ус яагаад гэвэл газар доор цэвэрлэгдэх учраас химийн бодисын бууралт эсвэл бусад талбай дахь бохирдол ажилчидад ил харагдахгүй юм. Хэрэв ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий ханын суурийг ухаж байх үед (PRB) бохирдсон хөрс гарч ирвэл ажилчид хамгаалалтын хувцас өмсөх хэрэгтэй болно. Тэд мөн ямар нэгэн задгай тавьсан бохирдсон хөрсийг зайлуулахаас өмнө, бохирдол ба тоос агаарт тархахаас хамгаалах шаардлагатай болдог. Ажилчид химийн бодисын бууралт буюу "ISCR" -ийг явагдаж байгаа эсэхийг шалгах ба хөрсний болон газар доорх ус баталгаатай эсэхийг байнга шинжилдэг.

9.5 Энэ надад хэрхэн нөлөөлж болох вэ?

Газар шорооны тоног төхөөрөмж,өрөмдлөгийн ажлын үед автомашины хөдөлгөөн нэмэгдэх болон бууруулагч бодисыг талбайд авчирах зэргийг ойролцоох оршин суугчид болон аж ахуй эрхлэгчид харж болох юм. Оршин суугчид ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана (PRB) болон шууд шахах тоног төхөөрөмжийг суурилуулж байх үед дуу чимээ сонсож болох юм. Ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана болон шууд шахах тоног төхөөрөмжийг суурилуулж дууссаны дараа, химийн бодисын бууралт буюу "ISCR" -д ямар нэгэн дуу чимээгүй тоног төхөөрөмж хэрэгтэй болдог. Цэвэр-лэгээний ажилчид хааяа талбайд очиж хөрс ба газар доорх усны дээжийг цуглуулах ба "ISCR" хэрхэн ажиллаж байгаа эсэхийг хянадаг.

9.6 Яагаад газар дээрх химийн бодисын бууралтыг хэрэглэдэг вэ ?

"ISCR" нь бусад аргаар цэвэрлэхэд хүндрэлтэй байдаг “Ус агуулсан нягт бус шингэн үе” буюу “DNAPLs” орсон байх зарим төрлийн бохирдуулагчийг цэвэрлэж чаддаг. Энэ нь газар доорх усыг шавхаж цэвэрлэх эсвэл хөрсийг ухаж хог булах цэг буюу цэвэрлэх байгууламж руу тээвэрлэхгүйгээр ихэнх бохирдлыг газар дээр устгах боломжтой байдаг. Энэ ажил цаг хугацаа болон мөнгө хэмнэдэг. Үүнээс гадна, ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана (PRB) нь ямар ч эрчим хүч шаардахгүй ажиллах бөгөөд энэ нь байгаль дахь газар доорх усны урсгал дээр тулгуурлан явагддаг байна. "ISCR" нь аюултай хог хаягдалтай газрыг цэвэрлэхэд харьцангуй шинэ арга бөгөөд улс орон даяар “Superfund” дахь газруудад ашиглах явдал ихэссээр байна.

9.7 Жишээ

"ISCR" нь Өмнөд Каролина дахь Macalloy корпорацийн “Superfund” талбай дээр хром 6 -аар бохирдсон хөрс, усыг цэвэрлэхэд ашиглаж байсан. Хуучин төмөр-хромын хайлш үйлдвэрлэх үйлдвэрээс зайлуулсан хог хаягдал ойролцоох горхи руу урсаж газар доорх усыг бохирдуулсан. 2005 оны 9 дүгээр сард, таван ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана (PRB) баригдсан (дараа нь өөр дөрөв) ба энэ нь горхи руу бохирдол орохоос өмнө тогтоон барих, газар доорх усыг цэвэрлэхэд хэрэглэдэг байжээ. Шуудуунаас ухаж гаргасан хөрс нь хайрга болон хар төмөр, натрийн dithionite-ийн хольцтой холимог байсан. Холимог нь ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий ханыг байрлуулах шуудуунд, өөрөөр хэлбэл хананы ард байхаар тавьсан. 2010 оны тойм, талбай дахь бохирдлын хэмжээ ба хром 6-ын агууламж буурч байгааг харуулж байна. Цэврэлэх ажлын зорилго нь ихэнх худгууд дахь шинжилгээтэй таарч байна. Ус нэвчүүлж урвалд оруулах зориулалттай хаалт бүхий хана (PRB) нь хром 6-г бууруулах төлөв ирэх таван жилийн хугацаанд үргэлжлэхээр байна.

9.8 Нэмэлт мэдээлэл олж авах нь

Энэ талаар илүү мэдээлэл болон “Иргэдийн гарын авлага” цуврал дахь бусад технологиудын хувьд: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн Технолог-ийн шинэтгэл ба Хээрийн үйлчилгээний хэлтэс, технологийн үнэлгээний салбарын (703) 603-9910 утсаар холбогдох буюу www.cluin.org/ISCR үзнэ үү.

10 Байгалийн (үйл явц) ажиглагдсан бууралт

10.1 Байгалийн (үйл явц) ажиглагдсан бууралт гэж юү вэ ?


The processing subject may take without objections and in to their own consideration with the priority code with the program only in the case of sites where no survey was conducted with sampling where there is no information on the actual contamination (category PR and DI sites according to the classification matrix in table R1 in Chapter 6.2. In all other cases, the

classification of the site into the respective category of the priority code according to the classification diagram (table R1) is always decided by the processing subject of the record (annotator) on the basis of their analysis of the conclusions of the site survey or on the basis of the conclusions of the risk analysis.

If the annotator, after the evaluation of the site priority, changes the data in the database on the basis of which the priority was evaluated or evaluates the partial priority of the site, a new evaluation of the site priority (the application automatically calls take such action) must be conducted.

If the computer proposes a priority category that is not in accordance with the expectation of evaluator, the evaluator will inspect all items on the basis of which the priority is evaluated. The change in the computer assumes the priority category is actioned when it is certain that that all input values correspond to reality. The change must be justified in the respective passport field of the site (see manual). The administrator has time to verify the automatically generated proposal for priority categorization vs. category selected by the client.

8.6 Approval of changes

After the evaluation of the priority, the responsible solution provider checks whether the role of the manager was assigned to them. If they are satisfied with the quality, they mark the record with the application for approval.

They have the option to withdraw their application and to process the record again. The record undergoes detailed checking for formal correctness, completeness and data integrity by the verifier. This employee may be, according to requirements, from the data supplier, as well as from the customer. Concerning the approval or non approval of the record, e-mail is automatically generated and sent to the address of the respective annotator and the responsible representative of the processing subject (manager). If the record is not approved, the justification is automatically added into the generated e-mail. The respective administrator has the option to enter in the system that they require to be informed of any returned records. In this case, e-mails justifying the return of the record are also sent to the respective administrator.

On accepted, it cannot be edited. The respective administrator conducts the inspection - making changes and approving the record or returning it with the justification of unaccepted changes. The administrator has the option to enter in the system that they want the respective verifier to also be informed of an unapproved record. In this case, an automatically generated e-mail will be sent, in addition to the annotator and the respective representative of the licence owner (manager) and also to the address of the respective verifier. By approval or non approval, the record is de-blocked and prepared for editing. The approved record copies the basic data contained in the site passport into the part which is accessible by the public. If there is an older version of the approved site record, this record is updated.

8.7 The main principles for the correct processing of the site record, including evaluation of the priority

First of all, it is recommended to process data in the CSIS database, to prepare a report on the basis of this data, not the opposite. This procedure ensures greater efficiency and quality – will not enable to omit important parts in the report and ensures high quality structuring. It will not enable multiple different indications of identical documentation points, etc.

Before entering a new record, the user must check the previously recorded records of evidence in the surroundings to prevent duplicated input. Without completing the compulsory minimum of items, it is not possible to enter the new site record into the database. The responsible solution provider of the survey for which the record is entered into the database, is also the responsible representative of the processing subject (role of manager) for the correctness of the records in the CSIS database and also for full compatibility with the final report of the event. The retrieval of the document of the event must be part of the respective records. Sites may be divided into partial sectors with the option of separate records of boreholes and an analysis within the sectors which is suitable for larger sites. During the implementation of a new event in an already recorded site, it is not possible to record a new site record although the respective event is recorded in the respective records which document the event into the "Documents" at the respective site and consequently update the record. At the top of the hierarchic CSIS structure are sites, not events. Events are assigned to sites as subordinated records. The events are recorded in the form of recording documents in the CSIS library. It is recommended to complete the record with a descriptive pictorial attachment as maps of contamination, hydroizohyps, etc. The processing subject will not omit to complete the descriptive name of the pictorial attachment.

Important documents or the most important parts are recommended to be attached to the retrieval record of the document in PDF format. This step is important for decisions by state bodies.

During the classification of priority, it is not recommended - with the exception of category PR, PI sites – to automatically accept the program offering the classification of the site into the category. It is necessary to critically take into consideration the results of the survey and the risk evaluation. The evaluation automatically offered by the program must be understood in the context with the other annotated data and if these do not match, it is necessary to first check all the data entered in the forms which may lead to a different evaluation of the priority category.. If this does not correspond to reality, the data must be corrected. If the modification of data would lead to variance with reality, it is necessary to adapt the resulting priority to the actual results of the survey and risk evaluation. The potential modification of the classification offered by the program must be justified in the respective field of the locality passport (see manual). The priority is repeatedly classified in the case of each edit of the compulsory completed fields for the site passport. When updating the completed records with new information in unlimited data fields, it is necessary to consider whether the original text was incorrect or not exact and, if so, it will be replaced or whether it concerns a description of the fact that changed. If the field is to be updated with the keeping of the original fact, then the annotator will add in front of the original text the "year/month" of the original character of the text /if this text was not mentioned) and in front of this text will start to newly edit the field with the indication of the time value in the format year/month. Newly written text must always be completed at the beginning of the stated field and the original text is indented by a paragraph and moved below.

9. Database administration

The administration of the system is based on:

- administration of indexes and assignment/taking rights for entering and modifying data at individual sites,
- checking and acceptance of records indicated for approval in relation to the type of work in the site and the type of event,
- checking the history of data annotation and checking the integrity and security of the database,
- updating the help, operating documentation and responses to system crisis statuses, acceptance of measures to prevent repeating he ascertained crisis statuses either from the viewpoint of the security of the system, as well as from the viewpoint of the quality of the processed data.

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

Аргачлалын удирдамж – Бохирдсон газрын бүртгэл, мэдээллийн систем (CSIS)

Гарчиг

1. АРГАЧЛАЛЫН АГУУЛГА БА ЗОРИУЛАЛТ 3

2. ҮНДСЭН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР 3

3. АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ НЬ 8

3.1 Чулуулгийн орчин ба гадаргын усны бохирдол 8

3.2 Хуучин бохирдол, түүнээс ангижрах зорилгоор авах арга хэмжээний сонголт хийхэд нөлөөлөх хүчин зүйлс, бохирдсон газрын тухай нийт улсыг хамарсан бүртгэл бий болгох шаардлага 9

4. БОХИРДСОН ГАЗРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ - АГУУЛГА 11

5. БОХИРДСОН ГАЗРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ МОДУЛЬ, ҮНДСЭН ҮЙЛДЛҮҮД (ФУНКЦ) 11

6. АЧ ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙН КОНЦЕПЦИ 15

6.1 Удиртгал 15

6.2 Ач холбогдлын зэрэглэл 16

6.3 Ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний болон хоёр дахь тоо 20

7. ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХӨД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ 23

8. ГАЗАР НУТГИЙН ТЭМДЭГЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ 25

8.1 Мэдээллийн сангийн программ хангамж ачаалж суурилуулах, тохиргоо хийх 26

8.2 Мэдээлэл авах эрх авах 26

8.3 Анхдагч мэдээлэл ашиглах – газрын тухай тэмдэглэл үүсгэх 26

8.4 Газар нутгийн тэмдэглэлийг шинэчлэх 28

8.5 Ач холбогдлын зэрэглэл тогтоох 28

8.6 Хийсэн өөрчлөлтийг батлах 29

8.7 Газар нутгийн тэмдэглэлийг зөв боловсруулах, түүнчлэн ач холбогдлыг нь зөв үнэлэн тогтоох үндсэн зарчим 29

9. МЭДЭЭЛЛИЙН САНГ УДИРДАН ЗАХИРАХ 31

1. Аргачлалын агуулга ба зориулалт

Аргачлалыг чулуулгийн орчин, газрын доорх болон гадаргын ус хамгаалах асуудлыг эрхэлж ажилладаг төрийн байгууллагуудын байгаль, орчин, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах газар, хэлтсийн албан хаагчдад зориулан боловсруулсан.

Бохирдсон, бохирдолтой байж болох газруудын болон тэдгээрийн ангиллын бүртгэлийн мэдээллийн сан хүрээлэн буй орчин дахь бохирдлыг алхам алхмаар багасгах процессыг системчилсэн аргаар эрчимтэй удирдах, улмаар тэдний харьяалагдах нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл мэнд болон экосистемд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийг багасгах үндэс суурь болох юм.

Тус аргачлал дараах агуулгатай байна. Үүнд,

- бохирдсон газруудын тухай үндсэн ойлголт, тэдгээрийг бүртгэх шаардлагатай болох тухай,
- бохирдсон, бохирдолтой байж болох газруудын бүртгэлийн системийн модулийн танилцуулга,
- хөрс, газрын доорх болон гадаргын усны бохирдолтой эсвэл бохирдолтой байж болох газруудын мэдээллийн санд мэдээлэл оруулах, шинэчлэх аргын тухай,
- дээрхи газруудыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлдэг нөлөөнөөс шалтгаалан хийгдэх арга хэмжээний шинж чанар, ач холбогдлын зэрэглэлийн талаас нь ангилах тухай.

Аргачлалыг тус системийг олон нийт, иргэдэд ашиглуулах, мэдээллийн сангийн агууламжийг зөв зохистой талаас нь ойлгуулах зорилгоор ашиглах боломжтой. Авагдах арга хэмжээний ач холбогдлын зэрэглэлийн үндсэн зарчмыг мэдээллийн сангийн мэргэжлийн бус хэрэглэгчдэд ойлгомжтой болох аргаар тайлбарсан.

Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох, сонголт хийх зэрэг мэдээллийн сан ашиглах тодорхой үйлдлүүд, мэдээллийн санг бөглөж, өгөгдөл оруулах дэлгэрэнгүй заавар тусгай гарын авлагад орсон.

2. Үндсэн нэр томъёоны тайлбар

Чулуулгийн орчин гэж хүний үйл ажиллагааны нөлөөнд өртдөг чулуун мандлын дээд хэсгийн чулуулгийн орчины бүрэлдэхүүн хэсгийг бүхэлд нь хэлнэ. Үүнд хөрс, шороо, чулуулаг, антропогенийн гаралтай хадгалалт зэрэг хатуу бүрхүүлээс гадна газар доорх болон гадаргын ус, хөрсний агаар зэрэг багтана.

Хөрс гэж уур амьсгалын нөхцөл байдал, газрын рельеф, бичил биетэн, хүний үйл ажиллагаа зэргийн нөлөөгөөр эх чулуулгаас үүссэн чулуулгийн орчны байгалийн гаралтай, дэлхийн гадаргын өнгөн сэвсгэр хэсгийг хэлнэ. Бохирдлын эрсдлийн үнэлгээний хувьд газрын гадаргуугаас 0-с 2 м гүнд оршин тогтно гэж үздэг.

Бохирдол гэж хатуу бүрхүүл, газар доорх ус, хөрсний агаар зэрэг чулуулгийн орчин эсвэл гадаргын ус хүний үйл ажиллагааны үр дүнд тухайн газар нутгийн байгалийн хэвийн түвшнээс хэтэрч бохирдсныг хэлнэ.

Хорт бодис гэж хүний эрүүл мэнд, экосистемд хорт нөлөөтэй бодисыг хэлнэ.

Бохирдуулагч бодис гэж хүний эрүүл мэнд эсвэл экосистемд сөрөг нөлөө үзүүлж буй эсвэл үзүүлж болзошгүй гадны буюу тухайн орчинд хүний үйл ажиллагааны үр дүнд (антропогенийн бохирдол) нэвтэрсэн зохисгүй бодисыг хэлнэ.

Бохирдлын анхдагч эх үүсвэр гэж чулуулгийн орчин болон гадаргын усанд нэвтэрсэн бохирдуулагч бодисыг үүсгэсэн объект, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж зэргийг хэлнэ.

Бохирдлын хоёрдогч эх үүсвэр гэж анхдагч эх үүсвэр бохирдол үүсгэхээ больсны дараа ч бохирдуулагч бодисыг ойр орчимд тархах эс үүсвэр болох бохирдсон чулуулгийн орчныг хэлнэ.

Бохирдуулагч үүл гэж чулуулгийн орчны бохирдолтой хэсгийг хэлнэ.

Бохирдлын голомт гэж хорт бодис хамгийн өндөр концентрацитай орших, бохирдлын массын балансын ихэнх хэсэг төвлөрсөн бохирдлын гол хэсгийг хэлнэ.

Тухайн газар нутгийн байгалийн хэвийн байдал/түвшин гэж тухайн газар нутагт байгалийн гаралтай бохирдлын хэвийн концентрацийг хэлнэ.

Байгалийн нөхцөл байдлаас үүдэлтэй хорт бодисын концентрацийн нэмэгдсэн хэмжээ гэж тухайн газар нутгийн байгалийн хэвийн түвшин боловч ашигт малтмалын орд зэргээс шалтгаалан хорт бодисын концентраци нь хэвийн гэж үздэг түвшнээс хэтэрсэн байдлыг хэлнэ.

Хүлээн зөвшөөрч болох бохирдол гэж хүний эрүүл мэнд эсвэл экосистемд зөвшөөрч болохоор нөлөө үзүүлэх бохирдлын түвшинг хэлнэ. Бохирдлын түвшин тухайн газар талбай, ойр орчим, газар доорх болон гадаргын ус зэрэг бохирдлын нөлөөнд өртсөн хүрээлэн буй орчны хэсгийн бодит ашиглалтад нөлөөлнө. Бохирдлыг хүлээн зөвшөөрч болох, үл болох тухай эрсдлийн судалгааны үнэлгээ дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

Хүлээн зөвшөөрч үл болох бохирдол гэж хүлээн зөвшөөрч болох бохирдлын эсрэг байдлыг хэлнэ. Мөрдөгдөж буй хууль тогтоомжинд заасан бохирдлын хэмжээнээс хэтэрсэн явдал мөн хүлээн зөвшөөрч үл болох бохирдолд тооцно.

Эрсдлийн судалгаа гэж чулуулгийн орчны бохирдлын судалгаа, судлагдаж буй газар нутаг болон бохирдлын нөлөөнд орших нутаг дэвсгэрийг тухайн нөхцөл байдалд одоогийн эсвэл төлөвлөсөн ашиглалтын улмаас хүний эрүүл мэнд болон/эсвэл экосистемд үзүүлэх нөлөөний үүднээс хийсэн үнэлгээ, дүгнэлт зэргийг багтаасан үйл явцыг (процесс) хэлнэ.

Бохирдлын нөлөө, бохирдлын улмаас үүсч болзошгүй нөлөөлөл гэж бохирдол эсвэл гарч болзошгүй бохирдлын хүрээлэн буй орчин эсвэл хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө.

Уг нөлөөг үнэлэхдээ бохирдлын шинж чанар, хэр хэмжээ, бохирдуулагч бодисын концентраци, бохирдлын ойр орчимд тархах нөхцөл байдал, бохирдол хүлээн авагчид бохирдлын нөлөөнд хэрхэн өртөх зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Бохирдол хүлээн авагчид бохирдлын нөлөөнд өртөх байдлыг тухайн газрын болон бохирдлын нөлөөнд орж болзошгүй нутаг дэвсгэрийн ашиглалтыг үндэслэн үнэлнэ.

Бохирдсон газар гэж хөрс, газар доорх эсвэл гадаргын усанд хүний үйл ажиллагааны улмаас үүссэн бохирдол илэрсэн газрыг хэлнэ.

Хаягдал эсвэл уул уурхайн гаралтай хаягдал усыг гол мөрөн эсвэл нуур руу асгах гэж гадаргын ус шууд бохирдуулахад хүрсэн бохирдсон газрын онцгой тохиолдлыг хэлнэ.

Бохирдсон байж болох газар гэж хүний үйл ажиллагааны улмаас бохирдсон тухай үндэслэлтэй сэжиг байх нөхцлийг хэлнэ. Тухайн газрын бохирдолтой эсэхийг ямар нэгэн дээж авалт, шинжилгээний үр дүнд хараахан тогтоогоогүй эсхүл найдвартай бус эсвэл хуучирсан (10-с дээш жил болсон) гэж үзсэн үр дүн бүхий шинжилгээгээр тогтоогдсон. Тухайн газар бохирдолтой байж болох гэсэн сэжиг таамаглал нь газар нутгийн ашиглалт, түүний түүх, аваар осол эсвэл хорт бодисын зохимжгүй ашиглалтын тухай тэмдэглэл, сэжигтэй объект, хаягдал, хөрсөн дээр ил харагддаг толбо, гадны нөлөөнд өртсөн мод, бут, ургамал, үнэр зэргийн ажиглалт дээр үндэслэдэг.

Бохирдсон эсвэл бохирдсон байж болох газар нутаг гэж бохирдсон эсвэл бохирдсон байж болох газартай ижил утга бүхий нэр томъёо.

Анхдагч мэдээлэл гэж бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай анхны мэдээллийг хэлнэ. Бодит байдлыг гол төлөв газар дээр хийсэн судалгаа шинжилгээгээр тогтоолгоно. Анхны мэдээллийг өөр мэдээллийн сангийн материал, онгоц эсвэл сансрын зураг, иргэдээс авсан мэдээлэл зэрэг эх үүсвэрээс олж авдаг.

Хасагдсан анхдагч мэдээлэл гэж бохирдсон болон бохирдсон байж болох газрын (Reg_ConSite) бүртгэлд оруулаагүй мэдээллийг хэлнэ. Уг газрыг бохирдсон эсвэл бохирдсон байж болох газарт тооцох үндэслэлгүй гэж тогтоогдсон (цаашид үзнэ үү).

Судлагдсан газар гэж бохирдолтой гэсэн утгаараа цаашид авагдах арга хэмжээний талаар эцсийн шийдвэр гаргахад хангалттай судалгаа хийгдсэн газрыг хэлнэ.

Судлагдаагүй эсвэл хангалтгүй судлагдсан газар гэж бохирдлын судалгаа хийгээгүй эсхүл судалгааг авагдах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад хангалттай хэмжээгээр хийгээгүй газрыг хэлнэ.

Цаашид авагдах арга хэмжээ гэж тухайн бохирдлын талаар цуглуулсан мэдээлэл болон бохирдлын улмаас үүсэх эсвэл үүсч болзошгүй үр дагаврыг харгалзан бохирдсон эсвэл бохирдсон байж болох газарт авах шаардлагатай арга хэмжээг ерөнхий утгаар нь хэлнэ. Үүнд дараагийн шатны судалгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт эсвэл ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй гэсэн ойлголтууд хамаарна.

Сэлбэн засах арга хэмжээ гэж бохирдлын хүний эрүүл мэнд эсвэл экосистемд үзүүлдэг нөлөөг багасгах эсвэл устгахад чиглэсэн ямар нэгэн арга хэмжээг хэлнэ.

Жич.: Сэлбэн засах зарим арга хэмжээ хүрээлэн буй орчны байдлыг сайжрахад хүрэхгүй (үүнд, бохирдсон газарт орохыг хориглох, газрын ашиглах зорилгыг өөрчлөх, тухайн газраас оршин суугчдыг нүүлгэх, газрын доорх бохирдсон усыг ундны зориулалтаар ашиглахыг хориглох гэх мэт арга хэмжээ орно).

Нөхөн сэргээлт гэж хогийн цэг, овоолго, лагийн талбай эсвэл ижил төстэй чанар бүхий газар зэрэг объектыг байгалийн зүй тогтолд нийцүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Нөхөн сэргээлтийн хамгийн түгээмэл арга хэмжээний тоонд Газрын тохижилт, булалт, ус зайлуулах байдлыг засах, ногоожуулах зэрэг ажлууд ордог. Зарим тохиолдолд нөхөн сэргээлт сэлбэн засан арга хэмжээний адил үр дүнтэй байдаг.

Цэвэрлэгээ гэж чулуулгийн орчны бүрэлдэхүүн хэсэгт агуулагдсан хорт бодисын концентрацийг бууруулах (decontamination) эсвэл бохирдолыг тархахаас сэргийлэх (бохирдлыг “боох” эсвэл тархахаас нь өөр аргаар урьдчилан сэргийлэх) арга хэмжээг хэлнэ.

Бохирдлын үүсгэгч гэж өөрийн үйл ажиллагааны улмаас бохирдлыг учруулсан эсвэл тусгай хууль тогтоомжийн дагуу бохирдсон газартай холбогдон хариуцлага хүлээсэн, эсхүл холбогдох төрийн байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрээр бохирдлын үүсгэгч болох нь тогтоогдсон этгээд эс бөгөөс эдгээр этгээдүүдийн хууль ёсны өв залгамжлагчийг хэлнэ.

Хуучин экологийн ачаалал гэж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу сэлбэн засах арга хэмжээ авах үүрэг хүлээлгэх боломжгүй дээр үед, тодорхой бус цагт үүссэн бохирдол бүхий газрыг ярианы хэлээр, ерөнхий утгаар нь хэлнэ. Бодит байдалд бохирдол үүсгэгч эсвэл түүний хууль ёсны өв залгамжлагч үгүйлж байгаа эсвэл бохирдлыг учруулсан үйл ажиллагаа тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн зөрчилгүй байсан учир бохирдол үүсгэгчид сэлбэн засах арга хэмжээ хийх үүрэг хүлээлгэх боломжгүй болсон зэрэг тохиолдлууд болно.

Бохирдсон газрын бүртгэлийн систем гэж бохирдсон болон бохирдсон байж болох газруудын тухай мэдээллийг цуглуулах, бүртгэх, хөтлөн захирах, толилуулахад зориулсан программ хангамж бүхий мэдээллийн сангийн товчилсон нэр юм. Тус бүртгэлийн систем Reg_ID болон Reg_ConSite хоёр үндсэн бүртгэлийг агуулсан. Дэлгэрэнгүйг цаашид үзнэ үү.

Ач холбогдлын зэрэглэл гэж мэдээллийн сангийн салшгүй хэсэг болох программ хангамжийн тусламжтайгаар эрсдлийн судалгааны үндсэн дээр тухайн газрын үнэлгээг хэлнэ. Ач холбогдлын зэрэглэл тогтоох функц нь бохирдсон болон бохирдсон байж болох бүх газрыг цаашид ямар арга хэмжээ авах ба асуудлыг хэрхэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай гэдгээс хамааран хэд хэдэн үндсэн зэрэглэлд хуваадаг. Дэлгэрэнгүйг цаашид үзнэ үү.

Ач холбогдлын зэрэглэл тогтоох бол газар нутгийн тухай бүртгэлийг боловсруулах, шинэчлэх үйлдлийн эцсийн шат бөгөөд газар нутгийн паспортод ач холбогдлын зэрэглэл тогтооход шаардлагатай бүхий л мэдээлэл, өгөгдлийг бөглөмөгц эсвэл шинэчилмэгц хийгдэнэ.

Ач холбогдлын зэрэглэлийн код гэж 2 үсэг, хоёр оронтой тооноос бүрддэг (жишээ нь, RD-3-2) ач холбогдлын зэрэглэл тогтоох үйлдлийн үр дүнг хэлнэ. Дэлгэрэнгүйг цаашид үзнэ үү.

CSIS – Contaminated Sites Information System буюу Бохирдсон газрын бүртгэл, мэдээллийн систем гэж бохирдсон болон бохирдсон байж болох газар, анхдагч мэдээллийн тухай өгөгдлийг боловсруулах, үнэлж дүгнэх, хадгалахад зориулсан программ хангамжийг хэлнэ.

CSIS **мэдээллийн сан** гэж бүтэцчилсэн дижитал өгөгдлийн сан = өгөгдлийн агуулахыг хэлнэ. CSIS мэдээллийн сан гурван хэсгээс бүрдсэн. Үүнд,

- боловсруулагдаж буй бүх мэдээлэл, өгөгдлийг хадгалдаг төв мэдээллийн сан
- олон нийтэд нээлттэй, батлагдсан мэдээлэл, өгөгдлийг агуулсан нээлттэй мэдээллийн сан

- төв мэдээллийн сангийн доторхи зориулалтын зөвшөөрөлд хамрагдсан хэсгүүдэд судалгааны газар дээр нь мэдээлэл, өгөгдөл боловсруулдаг ажлын мэдээллийн сан (бас дотоод мэдээллийн сан гэж нэрлэнэ). Нэгээс илүү харилцагчийн (клиентийн) мэдээллийн сангаас бүрдсэн.

CSIS мэдээллийн сангийн **хариуцагч байгууллага** гэж CSIS-ийн үйл ажиллагаа болон өгөгдийн чанарыг мэргэжлийн болон техникийн талаас нь хариуцдаг төрийн байгууллагыг хэлнэ.

Лиценз эзэмшигч гэж CSIS-д мэдээлэл, өгөгдөл боловсруулах зориулалтын редакторлах программ хангамжийг ашиглах эрх эзэмшиж буй мэргэжлийн байгууллагыг хэлнэ.

Системийн үүрэг гэж CSIS-ийн программ хангамжийн доторхи хэрэглэгчдийн үүргийг хэлнэ. Хэрэглэгч CSIS мэдээллийн санд дараах эрх, үүрэгтэй байж болно. Үүнд,

- superadmin гэж мэдээлэл, өгөгдлийн чанар, түүнийг хөтлөхтэй холбоотой дээд хэмжээний эрх бүхий мэдээллийн сангийн гол администратор (админ)-ийг хэлнэ.
- network manager гэж сүлжээ зохицуулагч, системийн администрыг хэлнэ.
- администратор (админ) гэж мэдээллийн сангийн администратор, ихэвчлэн газар нутгийн эсвэл мэргэжлийн аль нэг салбарыг хариуцдаг учир мэдээллийн сангийн холбогдох эрх болон мэдээлэл, өгөгдлийг хариуцдаг хариуцагч байгууллагын референтийг хэлнэ. Админ бас боловсруулсан өгөгдөл эцсийн шатны хяналт хийж баталдаг.
- тулган баталгаажуулагч (verificator) гэж боловсруулагч эсвэл хариуцагч байгууллагаас томилсон байж болох боловсруулсан мэдээлэл, өгөгдлийн үнэн зөвийн техникийн талаас нь хянан баталгаажуулдаг ажилтныг хэлнэ.
- менежер гэж мэдээлэл, өгөгдөл боловсруулдаг байгууллагын өмнөөс итгэмжлэгдэн хариуцсан мэдээлэл, өгөгдлийн чанарыг хариуцсан лиценз эзэмшигчийн мэргэжлийн төлөөлөгчийг хэлнэ.
- хураангуйлагч (epitomist) гэж тэмдэглэл боловсруулагч, өөрийн менежерээс олгосон эрхийг үндэслэн CSIS мэдээллийн санд анхдагч мэдээлэл, бохиродсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай өгөгдлийг үүсгэх, нэгэнт үүсгэсэн өгөгдөлд нэмэлт өөрчлөлт оруулдаг хураангуйлагчийг хэлнэ.
- хэрэглэгч (public) гэж мэдээллийн сангийн олон нийтэд нээлттэй хэсэгт агуулсан мэдээллийг үзэх эрх олгох зорилгоор и-мейл нь амжилттай шалгагдаж тэнцэж бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.
- хүлээж буй хэрэглэгч (waiting user) гэж и-мейл нь шалгагдаж, эрх олгож амжаагүй байдалтай бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

Газар нутгийн тэмдэглэл гэж CSIS мэдээллийн санд агуулсан анхдагч мэдээлэл, бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай иж бүрдэл мэдээлэл, өгөгдлийг хэлнэ. Газар нутгийн тэмдэглэл нь тухайн газрын нөхцөл байдлыг судалсан эсвэл орох

өгөгдөл боловсруулсан байдлаас хамааран анхдагч мэдээллийн Reg_ID бүртгэлд эсвэл бохирдсон газрын Reg_ConSite бүртгэлд бүртгэгдсэн байдаг.

Редакторлах горим гэж анхдагч мэдээлэл, бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай тэмдэглэлийн хаагдсан (блокдсон) байдлыг хэлнэ. Редакторлах горимд CSIS мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл, өгөгдөлд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой.

Мэдээлэгдсэн этгээд гэж тухайн газрын талаар нэмэлт эсвэл шинэ мэдээлэл өгөх магадлалтай этгээдийг хэлнэ. Ийм этгээд гол төлөв тухайн газрын одоогийн өмчлөгч, захирагч эсвэл ашиглагч болох ба зарим тохиолдолд төрийн байгууллага байдаг.

3. Асуудлыг танилцуулах нь

3.1 Чулуулгийн орчин ба гадаргын усны бохирдол

Хөрс, газрын доорхи болон гадаргын усны бохирдол байгаль орчинд хортой бодис ашигласан янз бүрийн үйл ажиллагааны улмаас үүсдэг. Бохирдол ихэвчлэн аж үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдон үүсдэг боловч цэрэг арми, газар тариалангийн салбар томоохон бохирдуулагчдад тооцогддогоос гадна олон тооны төрөл бүрийн хог хаягдал, түүнчлэн ахуйн хог хаягдлын хуучин цэгүүд багагүй асуудал үүсгэдэг.

Чулуулгийн орчны бохирдол үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:

- аваар осол (тоног төхөөрөмжийн аваар саатал, гэмтэл, зам тээврийн осол, гал түймэр гэх мэт), эсвэл
- тогтмол, аажимаар явагдах үйл ажиллагаа (хорт бодист болгоомжгүй хандах, тохиромжгүй байдалд хадгалах, хорт бодис технологи болон шугам хоолойноос аажмаар гоожиж асгарах, машин, тоног төхөөрөмжийн засвар хийх үед доторхи бодисыг асгах, түлш авах, залгаас нь нягт биш сав сан, ёмкость, ариутгах татуурга зэргээс хорт бодис алдагдах, хог хаягдал тээвэрлэх, булах, хаягдал эсвэл уул уурхайн ус асгах гэх мэт).

Хаягдсан үйлдвэрлэлийн газруудад дараах зүйлс оршон хэвээр байгаа нь ховор үзэгдэл биш. Үүнд,

- урьд өмнө явуулдаг байсан үйлвэрлэлээс үлдсэн хамаагүй хадгалагдаж байгаа хорт бодис,
- хуучин шингэний үлдэгдэл агуулсан газар доорхи эсвэл газар дээрхи төрөл бүрийн сав, сан, ёмкость,
- тосоор дүүргэсэн, зарим тохиолдолд бүр ч PCB-г агуулсан трансформатор, хамгаалагч,
- хуучин бохирын шугам, шугам сүлжээ, суваг хоолойд ч их хэмжээний бохирдлыг агуулсан байдаг.

Дээр дурдсан объектуудаас хөрс, газар доорхи усанд бохирдол нэвтэрсээр байж болох юм.

Урьд өмнө үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн хаягдлыг үйлдвэрийн нутаг дэвсгэр эсвэл ойр орчимд хамгаалалтгүй хогийн цэгт хадгалдаг байсан.

Үүгээр барахгүй, үйлдвэрийн зориулалтаар шинэ барилга байгууламж баригдах талбайд янз бүрийн хаягдал агуулсны улмаас хорт бодис агуулсан байж болох материалтай тэгшлэх нь олонтаа тохиолддог байсан.

Эдгээр хог хаягдлын цэг, материал бүхий талбайгаас хорт бодис ялгарч газар доорхи усыг бохирдуулах эх үүсвэр байсаар байж болзошгүй юм. Иймд, төмөрлөгийн, химийн болон хүдэр боловсруулах үйлдвэр, төрөл бүрийн лаг, үнс, үйлдвэрлэлийн гаралтай тоос, тоосонцор, зарим нэгэн технологи буулгаж задласны улмаас үүссэн хаягдал зэрэг нь аюултайд тооцогдоно. Тээвэрлэж авчирсан зарим материал цацраг идэвхт биш гэдгийг үгүйсгэж болохгүй.

Барилга байгууламжийн хийц, бүтээц ч бохирдолтой байж болох юм. Хуучин барилга байгууламжинд хамгийн ихээр тохиолддог хорт бодисоос шөрмөсөн чулуу (хана, дээвэр, шугам хоолой, төрөл бүрийн технологийн тусгаарлагч), хар тугалга агуулсан ган хийц, бүтээцийн бутаг, тоос, тоосонцор ихтэй болон гальваник үйдвэрийн хананд ууссан хорт бодис зэргийг дурдаж болно.

Аж үйлдвэрийн болон бусад төрийн үйл ажиллагаанд өргөнөөр хэрэглэгддэг өвөрмөц бүлэг хорт бодис байдаг ба тэдгээр мөн бохирдлын эх үүсвэр байж болзошгүй. Үүнээс гадна бараг үйлдвэр бүрт үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанаас гадна өөрийн гэсэн бүлэг хорт бодис ашигладаг туслах цехүүд ажилладаг гэдгийг анхааралдаа авалгүй орхиж болохгүй. Үндсэн үйл ажиллагаа ямар нэгэн сөрөг нөлөөгүй явагддаг боловч дээр дурдсан шалтгаанаар бохирдол үүссэн цөөнгүй тохиолдож байсан.

Жижиг үйлдвэр, цехүүдэд бохирдол бага байдаг гэсэн үзэл санаа нь эндүүрэл юм. Харин ч яг эсрэгээрээ, жижиг үйлдвэрт хорт бодис ашиглахдаа ажилчдын сахилга бат нэлээд доогуур байснаас гадна технологи нь боловсронгуй биш, хуучирсан, хаягдлыг шууд газар дээр нь хадгалдаг гэх мэт дутагдалтай байдаг байжээ.

3.2 Хуучин бохирдол, түүнээс ангижрах зорилгоор авах арга хэмжээний сонголт хийхэд нөлөөлөх хүчин зүйлс, бохирдсон газрын тухай нийт улсыг хамарсан бүртгэл бий болгох шаардлага

Аж үйлдвэрийн салбарт төдийгүй газар тариалан, цэрэг арми ч гэсэн байгаль орчинд хортой бодис өргөнөөр ашигладаг. Нэвтрүүлж буй шинэ хууль тогтоомж урьдчилан сэргийлэх талдаа маш их анхаарал тавьж, хорт бодисын хяналтгүй эсвэл ослын улмаас гарах алдалт гоожилт, түүнчлэн хорт хаягдлыг зохих хамгаалалтгүй хогийн цэгт хаяхыг хязгаарлах нөхцөл бүрдүүлж байна.

Урьд өмнө үүссэн хуучин хогийн цэг, хөрс, газар доорхи ус болон гол мөрөн, нуурын ёроолын тунадасны бохирдол хорт бодис анхдагч эх үүсвэрээс ялгарахаа больсноос хойш олон жилийн туршид ч байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Олон жилийн турш хуримтлагдсан бохирдлыг хязгаарлан устгах нь байгаль орчин хамгааллын ач холбогдол бүхий салшгүй хэсэг болно. Бохирдсон болон бохирдсон байж болох газар цөөнгүй байдаг учир нөхөн сэргээлт, цэвэрлэгээний ажил маш

хүндрэлтэй, их хэмжээний санхүүжилт шаарддаг процесс болох нь гарцаагүй юм. Бохирдсон бүх газрыг богино хугацаанд нэг мөсөн нөхөн сэргээнэ гэдэг бол баян чинээлэг улсын хувьд ч амаргүй асуудал учир бодит байдлыг харгалзан нэн түрүүнд цэвэршүүлэх, нөхөн сэргээх газрыг сонгож авах нь чухал.

Ач холбогдлыг нь харгалзан тогтоосон дэс дараалал бүхий нөхөн сэргээлт хийх хойшлуулшгүй шаардлагатай нөхцөлд үндэслэсэн зөв сонголт нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх төдийгүй зарцуулсан ажил, зардлын талаас ч үзэхэд хуучин бохирдлыг цэвэрлэн, нөхөн сэргээх процесс үр ашигтай болохын гол үндэс суурь мөн.

Иймд, энэхүү зааварчлагаар танилцуулан нэвтрүүлж буй ач холбогдлын зэрэглэлийн систем нь бохирдсон болон бохирдсон байж болох газар дээр цаашид авагдах арга хэмжээний талаар шийдвэр гаргах хэрэгсэл болно.

Зөв сонголтыг гагцхүү холбогдох нутаг дэсгэрийн нийт талбайг хамарч нөхөн сэргээх шаардлагатай газрыг аль болох бүрэн хэмжээгээр тогтоож бүртгэгдсэн нөхцөлд хийж болно.

Иймийн тулд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан бохирдсон газрын аль болох бүрэн бүтэн бүртгэлийг нэн богино хугацаанд хийх зайлшгүй шаардлагатай байна.

Бохирдсон болон бохирдсон байж болох газрын үндэсний бүртгэлийг урт удаан хугацаагаар ашиглах боломжтой болохын тулд түүнийг шинэчлэх, хамгийн сүүлийн үеийн мэдээллээр тогтмол баяжуулах нөхцөл хангагдсан байх шаардлагатай.

Уг бүртгэлд шалгалт, шинжилгээгээр тогтоогдсон бохирдол бүхий газар төдийгүй бохирдсон байж болзошгүй хэмээн үзэх үндэслэлтэй газрууд орсон байх нь чухал. Эдгээр газруудын ихэнх нь бохирдсон байж болзошгүй газрууд гэж тооцоолж болно. Урьдчилсан судалгаагаар аль болох богино хугацаанд бохирдлын бодит хэмжээг тогтоох нь зүйтэй хэдий ч үүнд их хэмжээний санхүүжилтийг богино хугацаанд төвлөрүүлэхээс гадна мэргэжлийн компанийн хүчин чадал шаардагдах тул хүндрэлтэй байх болно.

Иймд, бүрэн судлагдаагүй газруудыг нэн түрүүнд судлах, шаардлагын дагуу ангилах нь бас чухал байна. Ингэснээр судалгааны ажилд зориулсан санхүүжилт, мэргэжлийн өндөр түвшингийн хүчин чадлыг аль болох үр ашигтайгаар ашигласнаар хамгийн өндөр аюул учруулж болзошгүй газруудыг аль болох богино хугацаанд судалгаанд хамруулах боломжтой болно. Цаашилбал эдгээр газарт дэлгэрэнгүй судалгаа хийх, шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг дараагийн үе шатны явцад илүү анхаарна.

Бохирдсон болон бохирдсон байж болох газруудын мэдээллийн санг олон жилийн өмнө үүссэн бохирдлыг багасгах процессыг удирдах, хянах ажиллагаанд төдийгүй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, газар төлөвлөх, шинэ байшин барилга болон бусад байгууламж барих, гүний болон газар дээрх усны чанарын хамгааллыг удирдах, газар тариалангийн хөрс хамгаалах зэрэг салбарт төрийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулахад ашиглах боломжтой. Түүнчлэн газар өмчлөх эрхийг шилжүүлэхэд ч ашиглах боломжтой юм.

Эцэст нь дурдахад мэдээллийн сан, байгаль орчныг хамгаалахтай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгоход хувь нэмэр оруулах болно.

4. Бохирдсон газрын бүртгэл, мэдээллийн систем - агуулга

Бохирдсон болон бохирдсон байж болох газруудын бүртгэлийн системд (Contaminated Sites Information Systém – CSIS) чулуулгийн орчны хатуу матриц, газар доорхи ус эсвэл хөрсний агаарын тогтоогдсон эсвэл байж болзошгүй хэмээн үзсэн бохирдол бүхий газрын тухай мэдээлэл цуглуулж хадгалдаг. Үүнд байгаль орчинд сөрөг нөлөөтэй бодис ашиглагддаг төрөл бүрийн үйл ажиллагааны улмаас үүссэн (эсвэл үүссэн байж болзошгүй) бохирдлыг хэлж байна. Уг бохирдол ихэвчлэн аж үйлдвэр, түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны явцад үүсдэг хэдий ч цэрэг арми, газар тариалангийн үйл ажиллагааны улмаас бохирдол үүсэх тохиолдол цөөнгүй гардаг юм. Чулуулгийн орчны бохирдол цаашид гадаргын усыг бохирдуулах сөрөг үр дагавартай байдаг.

Бүртгэлийн системд хаягдал эсвэл уул уурхайн гаралтай хаягдал усыг гол мөрөн эсвэл нуур руу асгах тохиолдлууд бүртгэгдсэн. Харин хэдэн арав хэдэн зуу хүртэл км^2 бүхий талбайд тархдагаараа онцлог байдаг сарнисан бохирдлын тохиолдлыг батгаагаагүй. Сарнисан бохирдол дараах шалтгааны улмаас гардаг. Үүнд,

- агаарт ялгарсан аж үйлдвэрийн гаралтай тоосонсор унах, эсвэл
- газар тариаланд байгалийн гаралтай бордоо болон агрохимийн бодис ашиглах,
- ачаалал ихтэй зам дагуу замын хөдөлгөөний гаралтай бодис ялгарах.

Цаашилбал CSIS бүртгэлийн системд дараах газар, үйл ажиллагааны төрөл орохгүй. Үүнд,

- 20 м^3-с дээшгүй эзэлхүүн бүхий хууль бус бага хэмжээний ахуйн хогийн цэг,
- чулуулгийн орчинд хорт бодис алдагдахаас сэргийлэх зохих техник, технологиор хангагдсан орчин үеийн аргаар хариуцан удирдуулсан хогийн цэг,
- гүний уурхайн нөлөөнд газар доорхи хэт малтагдсан газар.

5. Бохирдсон газрын бүртгэл, мэдээллийн систем, түүний модуль, үндсэн үйлдлүүд (функц)

CSIS мэдээллийн сан нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээрх бохирдсон болон бохирдсон байж болох газрыг бүртгүүлэхэд зориулсан систем.[1] Хаягдал эсвэл уул уурхайн гаралтай хаягдал усыг гол мөрөн эсвэл нуур луу асгах цэгүүдийн тусгай бүлэг болгон бүртгэгдэнэ. Түүнчлэн цацраг идэвхт зэрэг байгалийн гаралтай хорт бодисын нэмэгдсэн хэмжээний концентраци бүхий газрын тухай мэдээллэл бүртгэгдэнэ. Үүнээс

[1] Бүртгэлийн учир шалтгааны тодруулгыг авч үзвэл уг бүлгийн нэр системийн үйл ажиллагааг бүрэн хамруулсан оновчтой болж чадаагүй нь илэрхий хэдий ч товчхон учир өдөр тутмын ажлын шаардлагад нийцэж байгаа юм. Бүртгэлийн системд бохирдсон болон бохирдсон байж болох газрууд ялгаагүй, нэгдсэн маягаар бүртгэгдэнэ.

үзвэл уг бүртгэлийн системийг газар нутгийн болон гадаргын усны экологийн ачааллыг хүний эрүүл мэнд, экосистемд үзүүлэх нөлөөний талаас цогцоор нь хянах зорилгоор ашиглах боломж нээгдэнэ.

Систем нь ач холбогдлын (асуудлыг шийдвэрлэх) зэрэглэлийг тогтоох, бүртгэгдсэн газрыг төрөл бүрийн шалгуурын дагуу ангилах, сонгох, улмаар сонголтыг газрын зураг дээр дүрслэн гаргах боломжтой.

Мэдээллийн санд мэдээллийг бөглөж оруулах, ач холбогдлын зэрэглэлийг тогтоох, ангилалт, сонголт зэрэг үйлдэл хийх, мэдээллийн санг захиран хөтлөх дэлгэрэнгүй заавар гарын авлагад орсон байна.

Мэдээллийн сангийн бүтэц, үйл ажиллагааны техникийн үзүүлэлтүүд, ач холбогдлын (асуудлыг шийдвэрлэх) зэрэглэлийг тогтоох бүрэн бүтэн алгоритм системийн үйл ажиллагааны баримтад орсон байна.

Мэдээллийн сан дараах үндсэн модулиас бүрдэнэ. Үүнд,

- мэдээллийн санг удирдан захирах веб интерфейс
- хэрэглэгчийн веб интерфейс
- төв GIS мепсервертэй холбохоор батлагдсан газруудын давхарга
- мэдээлэл, өгөгдөл боловсруулах модуль
- баримт бичиг, туслалцааны модуль.

Мэдээллийн сангийн дүрслэн танилцуулах болон удирдан захирах хэсгүүд нь php script-ын дэмжлэгтэйгээр нээгддэг түгээмэл хэрэглэдэг веб хөтөчөөр ажиллуулдаг веб программууд болох бөгөөд ингэснээр бохирдсон болон бохирдсон байж болох газрын тухай хамгийн чухал мэдээлэл мэргэжилтнүүдээр зогсохгүй олон нийтэд ч хүртээмжтэй болох нөхцлийг хангаж байдаг. Өгөгдлийн төв сан Reg_ID, Reg_ConSite, төв мепсерверт оруулахаар батлагдсан газруудын давхарга гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Анхдагч мэдээллийн Reg_ID бүртгэл (register)

Анхдагч мэдээллийн Reg_ID бүртгэл нь эхний шатанд бохирдсон эсвэл бохирдсон байж болох талаас нь хянан шалгах шаардлагатай газрын тухай тэмдэглэл буюу мэдээллийн сангийн анхдагч мэдээллийг бүртгэх хэсэг юм. Анхдагч мэдээллийн тухай тэмдэглэлд дор хаяж тухайн газрын солбицол, нэр болон тэмдэглэл үүсгэх үед автоматаар бөглөдөг өгөгдлийн эх үүсвэрийг агуулсан байна.

Анхдагч мэдээллийн Reg_ID бүртгэл энгийн хэрэглэгч (public) болон эрхийг хүлээж буй хэрэглэгч (waiting user)-д хаалттай. Гэтэл энгийн хэрэглэгч (public) өөрийнх нь илрүүлсэн бохирдсон газрын тухай мэдэгдэх хүсэлтэй үед бүртгэлийн нэг хэсгийг үзэх боломжтой. Ямар нэг газрын тухай анх мэдэгдэх үед бүртгэлд уг газрын тухай боловсруулаагүй тэмдэглэл буюу анхдагч мэдээлэл үүснэ. Шинэ мэдэгдэл оруулах бүрт бүртгэлд бүртгүүлэгдсэн ойр хавийн газрын тухай тэмдэглэл дүрслэгдэж, аль нэг нь мөн үү, биш үү гэсэн асуулт гарч ирнэ.

Шинэ тэмдэглэл үүсгэхийг зөвшөөрсөн тохиолдолд уг тэмдэглэлийг ахдагч мэдээллийг мэдэгдсэн хэрэглэгчийн ID-гаар тэмдэглэж, өгөгдлийн эх үүсвэр “public notification” буюу иргэдээс ирсэн мэдэгдэл, тэмдэглэлийн статус “without any evaluation” буюу одоогоор үнэлж дүгнээгүй мэдээлэл болж бүртгэгдэнэ.

Цаашид анхдагч мэдээлэлд ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх бүрт мэдээллийн статус “in progress” буюу боловсруулагдаж буй гэсэн байдалд орно. Тэмдэглэлийг боловсруулж буй ажилтан тухай мэдээллийг нэн шуурхай боловсруулах шаардлагатай гэж үзвэл „urgent“ эсвэл „high urgent“ гэсэн түвшин тогтоож, тухайн газрыг судалгааны төлөвлөгөөнд оруулах боломжтой.

Анхдагч мэдээллийн тухай тэмдэглэлд тухайн газрын гэрэл зураг болон өөр төрлийн зурагтай материал хавсаргах боломжтой.

Анхдагч мэдээллийн боловсруулалт дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд,

а) анхдагч мэдээлэл мэдээллийн санд урьд нь бүртгэгдсэн мэдээлэлтэй давхцсан эсвэл тухайн газрыг шаардлагад үл нийцэх гэж үзсэн тохиолдолд хасагдана (discarded indication). Энэ сонголт хийгдсэн бол мэдээлэл хассан үндэслэлийг заах шаардлагатай. Шинэ мэдээлэл үүсгэх үед ижил солбицол бүхий газрын тухай мэдээлэл шалгагдаж, хасагдсан мөн эсэхийг хянах боломжтой болох үүднээс тэмдэглэл шийдвэрлэж дуусгасан гэсэн статустай болоод бүртгэлд боловсруулах түүхийн хамт хадгалагдан үлдэнэ. Нэгэнт хасагдсан тэмдэглэлийг сэргээн боловсруулж болно.

б) анхдагч мэдээлэл Reg_ConSite бүртгэлд шилжүүлснээр хасагдана. Мэдээлэл боловсруулах ажилтан уг газрыг бохирдсон эсвэл бохирдсон байж болох гэж үзвэл анхдагч мэдээллийг Reg_ConSite бүртгэлд шилжүүлэх (хуулах) гэсэн шинж тэмдэгээр тэмдэглэнэ. Анхдагч мэдээллийг шилжүүлэхийн тулд тэмдэглэлийн бүх асуултыг бөглөсөн байна. Энэ шаардлага хангагдсан байвал анхдагч мэдээллийн статус “Reg_ConSite бүртгэлд бүртгэгдсэн” болж хувирах ба түүнд дахин нэмэлт өөрчлөлт оруулах боломжгүй болж байна. Тэмдэглэл хавсаргасан зургийн хамт Reg_ConSite бүртгэлд хуулагдснаар Reg_ConSite бүртгэлд шинэ тэмдэглэл үүснэ. Reg_ID бүртгэлд үүсгэсэн тэмдэглэл утгахгүй хагдалагдан үлдэх ба түүхэнд нь түүнийг хуулж Reg_ConSite бүртгэлд үүсгэсэн тэмдэглэлийн ID-г бичнэ. Цаашид уг тэмдэглэлд ямар нэг нэмэлт өөрчлөлтийг зөвхөн Reg_ConSite бүртгэлд оруулах боломжтой бөгөөд түүний эх болсон анхдагч мэдээлэл тэмдэглэлийн эх үүсвэр болох утгаараа Reg_ID бүртгэлд хадгалагдан үлдэж байгаа болно.

Үүнээс үзвэл анхдагч мэдээллийн бүртгэл урьд нь судлагдсан газрын бүртгэлийн үүрэг давхар гүйцэтгэдэг ба ингэснээр тухайн газар дахин дахин судлагдахаас сэргийлэх үүрэгтэй. Хавсралтад оруулсан гэрэл зургийг хооронд нь харьцуулсны үндсэн дээр тухайн газарт нэлээд их өөрчлөлт гарсан тохиолдолд хасагдсан анхдагч мэдээллийг сэргээн боловсруулах боломжтой.

Бохирдсон болон бохирдсон байж болох Reg_ConSite бүртгэл

Reg_ConSite бүртгэлд байгаа бохирдсон эсвэл бохирдсон байж болох газар бүр өөрийн гэсэн шинэ регистрийн кодтой байна. Тэмдэглэлийн бүрэн түүхийг хялбарчлах үүднээс

урьдын Reg_ID бүртгэлийн регистрийн код мөн хэвээр үлдэнэ. Reg_ConSite бүртгэлд хийсэн аливаа өөрчлөлт Reg_ID-д хадгалагдан үлдсэн тэмдэглэлд хуулагдахгүй.

Тус бүртгэл дэх **газрын тэмдэглэл** нь газар түс бүрийн тухай иж бүрэн бүтэцчилсэн мэдээллийн багц юм. Газрын тэмдэглэл нь хэрэглэгчийн интерфейсд бат бөх холбоо бүхий бүтэцтэй маягт болон хөдлөнги (динамик) хэсгээс бүрдэх бөгөөд хураангуйлагч (epitomist) эрх бүхий сургагдсан ажилтан хэмжилт хийх болон шалгах хэрэгтэй бусад утгыг боловсруулах зорилгоор өөрийн хүсэлт, шаардлагад нийцүүлэн маягт зохион бүтээх боломжтой.

Газар түс бүрийн тухай хамгийн ач холбогдол бүхий мэдээлэл тухайн газрын үндсэн маягт буюу газар нутгийн паспортод төвлөрсөн байна (цаашид үзнэ үү).

Үүнээс гадна газрын тэмдэглэлийн захирагдах хэсгүүдэд дор дурдсан мэдээлэл агуулагдсан байж болно.

- Секторууд – тухайн газар нутгийг шинж чанарын дагуу хэд хэдэн секторуудад хуваах, хэмжих болон шалгагдах утгыг тухайн сектор эсвэл нийт газар нутагтай холбогдох шинжилгээний хамт боловсруулах зорилгоор хэрэглэгчийн загвар зохиох боломжийг хангах боломжтой.
- Бичиг баримт – холбогдох бичиг баримтын хураангуйг агуулсан ба бичиг баримтыг бүрнээр нь PDF хэлбэрээр хавсаргах боломжтой. Бүх бичиг баримт, хэрэглэгчийн хайлтын тусламжтайгаар шаардлагатай бичиг баримтыг олж болох төвлөрсөн номын санд хадгалагддаг.
- Холбоо барих мэдээлэл – Холбогдох хүмүүс эсвэл байгууллагуудтай холбоо барих утас, хаяг зэрэг мэдээлэл. Холбоо барих мэдээллийн хэсэг мэдээллийн сангийн төв жагсаалттай холбоотой бөгөөд хэрэглэгч түүнээс шууд сонголт хийх боломжтой.
- Зурган хавсралт – фото баримт, бохирдлын тархацын газрын зураг, бүдүүвч, график гэх мэт агуулагдсан. Энэхүү хавсралтыг хэд хэдэн график хэлбэрээр хавсаргаж болно. Анхдагч мэдээллийн хамтаар оруулсан анхны фото баримтыг Reg_ConSite бүртгэл дэхь тэмдэглэлд мөн ашиглахаар зогсохгүй түүн дээр зурган хавсралтыг нэмж хавсаргах боломжтой.
- Баримтжуулалтын цэгүүд (судлагдаж буй объектууд) – X,Y,Z солбилцлоор тодорхойлогдсон байршил бүхий хэмжилт хийх эсвэл дээж авах зориулалтын цэгүүд, жишээ нь цооног, янз бүрийн гүнд орших дээж авалтын цэг бүхий судлагдаж буй газар, худаг, судлагдаж буй ус асгах газар гэх мэт. Баримтжуулалтын цэгийг газар нутгийн холбогдох сектортой холбох боломжтой.
- Шинжилгээ, шалгагдаж буй бусад өгөгдөл – баримтжуулалтын цэгүүд дээр авсан дээжийн бүртгэл. Бүртгэсэн дээжид хэмжилтийн болон ажиглалтын үр дүн, лабораторийн шинжилгээний хариу болон судласан бусад утга, үр дүнг холбон тэмдэглэх боломжтой.

Газар нутгийн паспорт (Site Passport) гэж ID код, ач холбогдлын зэрэглэл зэрэг газар нутгийн тухай хамгийн чухал мэдээллийг агуулсан газар нутаг түс бүрийн тэмдэглэлийн үндсэн маягтын нэршлийг хэлнэ. Паспортод агуулагдсан мэдээллийг утга агуулгын дагуу хэд хэдэн цэсүүдэд хуваасан.

Тэмдэглэлийг редакторлах (Edit) гэж газар нутгийн паспорт эсвэл тухайн газар нутгийн захирагдах аль ч хэсэгт буюу тодруулбал аль ч маягтад нэмэлт өөрчлөлт оруулахыг хэлнэ.

Газар нутгийн паспортын бүх хэсгүүдэд талбарыг бөглөж мэдээлэл оруулах зорилгоор гол төлөв сонголт бүхий цэсийг ашиглахыг эрмэлздэг бөгөөд хураангуйлагч (epitomist) урьдчилан суурилагдсан боломжуудаас сонголт хийж маягтыг бөглөнө. Үргэлжилсэн текстийг бичих талбар тодруулах, нэмэлт мэдээлэл оруулахад зориулагдсан.

6. Ач холбогдлын зэрэглэлийн концепци

6.1 Удиртгал

Төлөвлөсөн ач холбогдлын зэрэглэлийн систем нь газар нутгийн эрсдлийн судалгааны зарчимын дагуу хийсэн үнэлгээнд үндэслэсэн. Үүнд чулуулгийн орчны бохирдол, хаягдал эсвэл уул уурхайн гаралтай усыг гадаргын усанд асгасны улмаас үүссэн бохирдол болон байгалийн гаралтай хорт бодисын концентрацийн хэмжээ нэмэгдснээс үүссэн бохирдол тус бүрийн эрсдлийг үнэлж дүгнэнэ.

Тус систем нь бүртгэгдсэн бүх газар нутгийн ямар арга хэмжээ авах шаардлагатай гэдгээр ангилна. Зэрэглэл тус бүр бохирдлын хэмжээ, хор уршиг эсвэл үнэлэхэд мэдээлэл хангалтгүй байгаа гэдгээр тодорхойлогдсон бөгөөд үүнийгээ үндэслэн зэрэглэл тус бүрт хамааран авагдах шаардлагатай арга хэмжээний шинж чанар, түүнийг хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхойлно.

Сэлбэн засах арга хэмжээ авагдах зайлшгүй шаардлага, шинж чанар болон хэрэгжилтийг хойшлуулж болох эсэх байдлын үнэлгээ нь тухайн газар нутгийн бохирдлын хор уршиг эсвэл гарч болзошгүй хор уршиг буюу өөрөөр хэлбэл уг бохирдлын хүний эрүүл мэнд болон/эсвэл байгаль орчинд учрах эсвэл учирч болзошгүй эрсдэлээс шууд хамааралтай. Сэлбэн засах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн газарт судалгаа хийх зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд зайлшгүй хүрнэ.

Аливаа газар нутагт үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр доор заасанчлан үсгийн код, хоёр оронтой тооноос бүрдсэн **ач холбогдлын зэрэглэлийн код** өгнө.

Ач холбогдлын зэрэглэл – тэмдэг ба нэршил

нэр →	Ач холбогдлын код				
	Зэрэглэлийг заасан тэмдэг		**кодын эхний оронд буй тоо**		**кодын хоёрдахь оронд буй тоо**
утга санаа →	Тухай газар нутгийн байдал, цаашид авагдах арга хэмжээ		Хүний эрүүл мэндэд учруулах аюул – хүний тоо		(учирч болзошгүй) нөлөө
тэмдэг →	код – хоёр үсэг	-	0-с 3 хүртэл	-	0-с 4 хүртэл

Ач холбогдлын кодын жишээ: PI-2-1, DI-0-3, RD-3-4.

Кодын эхний хоёр үсэг нь бохирдлын хэмжээнээс болон сэлбэн засахад авагдах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл байгаа эсэхээс хамааран хийгдэх шаардлагатай алхмаас хамаарч оруулсан **зэрэглэлийг** заасан.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын дараа кодын хоёр оронтой тоо орно.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний оронд байгаа тоо нь тухайн бохирдлын **хорт нөлөөнд буй хүний тоог** заана. Үүнд, жишээ нь тухайн газар нутгийн эсвэл түүний ойр орчимын оршин суугчид, ашиглагчид эсвэл тухайн газрын газар доорхи эсвэл гадаргын усыг ундны усны зориулалтаар хэрэглэдэг хүнийг харгалзана. Уг тоогоор хүний бодит тоо биш, бодит тооны хэмжээний зэрэглэлийг заасан байна.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын хоёрдахь оронд байгаа тоо нь бохирдлын нөлөө буюу өөрөөр хэлбэл хүний тооноос хамаарахгүй бохирдлын хор уршиг, эрсдэлийг тодорхойлдог (уг бохирдлын нөлөөнд буй хүний тоо кодын эхний тоогоор тодорхойлогдсон)[2]. Хорт бодисын бодит концентрацийн тухай мэдээлэл байхгүй тохиолдолд үүнийг үүсч болзошгүй нөлөө эсвэл эрсдэл гэж ойлгоно.

6.2 Ач холбогдлын зэрэглэл

Reg_ConSite бүртгэлд орсон бүх газар нутгийг ач холбогдлын үнэлгээний дагуу хуваж оруулах зэрэглэлүүдийг R1 хүснэгтэд заасан зэрэглэлийн матрицаар иж бүрнээр дэлгэрэнгүй харуулсан.

R1 хүснэгтийн зэрэглэлийн матрицийн зохион байгуулалтын бүтэц болон зарчимыг ойлгож мэдэх нь нийт зэрэглэлийн системийг ойлгож, өдөр тутмын ажилдаа ашиглахад нэн чухал ач холбогдолтой.

Газар нутгийг хуваж оруулсан зэрэглэлийн тэмдэг R1 хүснэгтийн зүүн талын баганад заагдсан байна. Тэр нь ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний хоёр үсэг юм.

Газар нутаг судлагдсан эсэх, судалгаа эсвэл эрсдлийн судалгааны үндсэн дээр гаргасан түүний байдлын тухай ерөнхий дүгнэлт зэрэглэл тус бүрт R1 хүснэгтийн дунд баганад заасан байна.

Газар нутгийн ерөнхий байдлын дүгнэлттэй нийцүүлэн тухайн газарт хийгдэх шаардлагатай ерөнхий тодорхойлсон арга хэмжээний нэг нь тохирч байна. R1 хүснэгтийн баруун талын баганыг үзнэ үү. Зэрэглэл тогтоохын жинхэнэ утга учир яг газар нутгийг тодорхой аль нэг зэрэглэлд оруулах, шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл өгөхөд оршино.

Зэрэглэлийн кодын дараа орсон тоо тухайн зэрэглэлийн хүрээн дэх ач холбогдлын зэргийн тухай мэдээллэх үүрэгтэй. Үүний тул дараах дэд бүлгийг үзнэ үү.

Хүснэгт R1	Бохирдсон газрын ач холбогдлын үнэлгээний системийн зэрэглэлийн матриц

[2] Хорт нөлөөг хүний тооноос үл хамааран тусгайлан үнэлж, дүгнэхэд үндэслэл бий. Жишээ нь, ундны усны эх үүсвэрийн чанар бохирдлын нөлөөнд өртөж болзошгүй тохиолдолд худаг нь нэг өрх айл эсвэл зуун мянган иргэдийг усаар хангадгаас үл хамааран асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байдаг. Энэ жишээнд гарч байгааа нэг өрх айлын худгийн асуудлыг шийдвэрлэх нь том хотыг усаар хангадаг эх үүсвэрийн асуудлаас шийдвэрлэхээс арай хялбар гэсэн утгатай бөгөөд бохирдлын нөлөөнд өртөж болзошгүй хүний тоо зөвхөн нэмэлт мэдээллийн чанартай байна.

Зэрэглэлийн тэмдэг	Нөхцөл байдал (байдлын дүгнэлт)	Газар нутагт хийгдэх шаардлагатай арга хэмжээ
Үнэлгээ хийх боломжгүй	Газрын тухай мэдээлэл тун бага, бохирдлын тухай мэдээлэл байхгүй, урьдчилсан судалгаа хийх шаардлагатай эсэх дүгнэлт хийх боломжгүй, уг газар бохирдсон байж болох газрын тоонд орж байгаа эсэх нь тодорхойгүй. Тухайн газрыг анхдагч мэдээллийн бүртгэлд бүртгэсэн.	Газар дээрхи нөхцөл байдлын урьдчилсан судалгаа хийх шаардлагатай
PI	Тухайн газар бохирдсон болон бохирдсон байж болох газрын бүртгэлд бүртгэгдсэн, одоогоор бодит бохирдлын талаар ямар ч мэдээлэл байхгүй (дээж авалт хийгдээгүй)	Тухайн газарт урьдчилсан судалгаа хийх шаардлагатай (Аргачлалын удирдамжийн дагуу “C” зэргийн судалгаа)
DI	Тухайн газарт хийсэн урьдчилсан судалгааны үр дүн их хэмжээний бохирдолтой байж болзошгүйг харуулж байна.	Тухайн газарт нарийн судалгаа болон эрсдлийн судалгаа хийх шаардлагатай (Аргачлалын удирдамжийн дагуу “B” зэргийн судалгаа)
SI	Тухайн газарт хийсэн урьдчилсан судалгааны үр дүн гарсан хэдий ч сэлбэн засах арга хэмжээний талаар эцсийн шийдвэр гаргах боломжгүй байна.	Тухайн газарт нэмэлт судалгаа эсвэл мониторинг хийх шаардлагатай
RN	Тухайн газарт дэлгэрэнгүй судалгаа (түүнчлэн нэмэлт эсвэл нөхөн сэргээлтийн зэрэг дээд шатны судалгаа) явуулж, болж өгвөл эрсдлийн судалгаа хийгдсэн байна; цуглуулсан мэдээлэл цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх шаардлагатай эсэхийн талаар шийдвэр гаргахад хангалттай байна	Хүний эрүүл мэндэд хор уршиг учирч болзошгүй тул сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагатай байна
RD		Хүний эрүүл мэндэд учруулах аюул байхгүй боловч сэлбэн засах арга хэмжээ авбал зүйтэй
CR	Тухайн газарт сэлбэн засах арга хэмжээ хийгдэж, амжилттай болсон гэдгийг албан байгууллагын тогтоолоор батлагдсан, үлдэгдэл бохирдол нь хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээнээс хэтрэхгүй байна.	Сэлбэн засах, нөхөн сэргээх ажил амжилттай хийсэн учир дахин ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй болсон
AP	Хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээнээс хэтрээгүй бохирдолтой газар	Ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй
CL	Авсан дээжийг үндэслэн тухайн газарт ноцтой бохирдол илрээгүй байна (урьдчилсан судалгаа), эсвэл нарийн судалгааны үр дүнг авч үзвэл бохирдлын хэмжээ бага байна.	Ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй


Дээр дурдсан зэрэглэлийн бүдүүвчийг авч үзвэл бүртгэгдсэн бүх газрын үндсэн гурван хэсэгт хувааж болно. Үүнд,

- судалгаа хийгээгүй эсвэл хийсэн судалгаа нь хангалтгүй тул сэлбэн засах арга хэмжээ авах, түүнчлэн богино хугацаанд зайлшгүй авах эсэхийн тухай тодорхой дүгнэлт гаргах боломжгүй байна - PR, PI, DI, SI зэрэглэлийн газарт хамаарна,

- сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагатай - RN, RD зэрэглэлийн газарт хамаарна,
- сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагагүй - CR, AP, CL зэрэглэлийн газарт хамаарна.

Тухайн газар нутагтай танилцах шатны эсвэл нарийвчилсан судалгаа хийж, сэлбэн засах ямар нэг арга хэмжээ явуулсан явдал газар нутгийн зэрэглэлийг өөрчлөх үндэслэл болно. Үүнийг хавсаргасан зурган дээр дүрсэлсэн үе шатны схем харуулж байна.

MNG Бохирдсон газрын мэдээллийн сан



Энэхүү зэрэглэл тогтоох концепци нь судалгааны үе шатчилсан зарчмыг баримтлахыг дэмжиж байна. Бохирдсон эсвэл бохирдсон байж болох газарт ямар арга хэмжээ авах талаар мэргэжлийн өндөр түвшинд зөв шийдвэр гаргарын тулд тодорхой цар хүрээ бүхий мэдээлэлтэй байх зайлшгүй шаардлагатай. Гагцхүү ноцтой тохиолдолд цэвэрлэх, нөхөн сэргээх ажил хийх тухай шийдвэрийг урьдчилсан судалгааны дүгнэлтийг үндэслэн гаргаж болно.

Бүртгүүлж буй газрыг R1 хүснэгтэд заасан зэрэглэлийн бүдүүвчийн дагуу ач холбоглын зохих зэрэглэлд оруулах тухай шийдвэрийг мэдээлэл боловсруулагч (хураангуйлагч) тухайн газрыг судалсан тухай дүгнэлт эсвэл эрсдлийн судалгааг үнэлж гаргана.

Бохирдсон газрын бүртгэлийн мэдээллийн сангийн салшгүй хэсэг болох ач холбогдлыг үнэлэх программ хангамж тухайн газарт тохирох зэрэглэлийг санал болгож байгаа хэдий ч тухайн газарт урьд нь судалгаа, түүнчлэн хөрс, усны дээж авалт,[3] дээжийн шинжилгээ хийгдсэн бол хураангуйлагч түүнийг автомараар хүлээн авбал зохимжгүй.

Өөрөөсөө хийсэн ямар ч үнэлгээ, дүгнэлтгүйгээр программ хангамжийн санал болгож буй зэрэглэлийг зөвхөн урьд өмнө судлагдаагүй, бодит бохирдол байгаа эсэх талаар ямар ч мэдээлэлгүй буюу PR, PI зэрэглэлд хамаарагдах газрыг бүртгүүлэх үед автоматаар хүлээн авах боломжтой.

Зэрэглэлийн системийг зохион бүтээхдээ программ хангамжийг дээж авалт хийгдээгүй газар нутгийг хураангуйлагчийн оролцоо шаардахгүйгээр автоматаар бүртгүүлэх тал дээр онцлон анхаарсан. Бүртгүүлсэн газрын эхний үнэлгээ, түүнчлэн газар дээр нь очиж нөхцөл байдалтай нь танилцах ажлыг янз бүрийн мэргэжил бүхий аймаг, сумын мэргэжлийн байгууллагуудын ажилтнууд хийх нөхцөлд ийм зарчим илүү тохиромжтой болно.

Судалгаа эсвэл нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсний дараах байдлыг харгалзсан зэрэглэлийг тогтоох үе шатыг мэргэжилтнүүд гүйцэтгэж хариуцна. Энэхүү аргачлалын удирдамжийн дагуу эцсийн тайлан боловсруулагчид газар нутгийн тэмдэглэлийг бөглөх эсвэл түүнд нэмж мэдээлэл оруулахыг даалгаж байна. Ингэснээр мэргэжилтнүүд эсвэл эцсийн тайлан боловсруулагчдад судалгаа, эрсдлийн судалгааны үндсэн дээр тухайн газрын зэрэглэлийг зөв тогтооход хялбар болно. Хураангуйлагч программ хангамжийн автоматаар санал болгож буй кодыг өөрчлөх үндэслэлийн тухай тайлбарыг ямагт тухайн газрын тэмдэглэлд оруулна.

6.3 Ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний болон хоёр дахь тоо

Ач холбогдлын зэрэглэлийн кодын дараа орж буй хоёр тоо тухайн зэрэглэлийн доторх ач холбогдол буюу тухайн газарт холбогдсон асуудлыг шийдвэрлэх хэрхэн чухал байх талаас нь ангилах зорилготой. Тухайн газарт холбогдсон асуудлыг хэрхэн чухал шийдвэрлэх нь бохирдлын нөлөөллийн түвшин болон тухайн газар нутаг, түүний ойр орчимд буюу бохирдлын нөлөөнд өртөж болзошгүй хүний тоо зэргээс хамааралтай.

Кодын эхний болон хоёр дахь тоог программ хангамж автоматаар тогтооно. Тэгэхийн тулд бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тэмгдэглэлд нөлөө бүхий хүчин зүйлийг багтаасан нийт 23 талбарыг зайлшгүй бөглөх шаардлагатай (хаягдал эсвэл уул уурхайн гаралтай ус асгах тохиолдолд 12 талбарыг зайлшгүй бөглөх шаардлагатай).[4]

[3] Учир нь программ хангамж газрын зэрэглэлийг тогтоохдоо тухайн газрын тэмдэглэлд бүртгэсэн шинжилгээний үр дүнг тухайн бохирдлын хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээ зэрэг баримжаалсан шалгууртай харьцуулдаг. Гэвч шинжилгээний үр дүн шалгуур, дээд хэмжээ хэтэрсэн боловч судалгааны нийт дүгнэлт эсвэл эрсдлийн судалгаанаар харуулсан нийт нөхцөл байдлыг харгалзан ноцтой биш хэмээн дүгнэсэн нь түгээмэл тохиолдоно. Өөр зарим тохиолдолд хийгдсэн шинжилгээний үр дүн эцсийн дүгнэлт гаргахад хангалтгүй эсвэл найдваргүй хэмээн үзсэн байж болох юм

[4] Ер нь зайлшгүй бөглөх шаардлагатай бүх талбар бөглөгдсөн байх бөгөөд хураангуйлагч өөрөө бөглөөгүй тохиолдолд программ хангамж автоматаар хамгийн ноцтой байдлыг илэрхийлсэн сонголт

Ямар ч дээж авалт хийгээгүй газрын хувьд бохирдлын улмаас үүсч болзошгүй нөлөө болон түүнд өртсөн байж болзошгүй хүний тоог заана.

Доорхи хүснэгтээр ач холбогдлын кодын эхний тоог тайлах арга заасан байна.

Ач холбогдлын кодын эхний тоо				
Бохирдлын нөлөөнд өртсөн хүний тоо	Ямар ч хүн өртөөгүй	20 хүртэл	21-с 200 хүртэл	200-с дээш
үнэлгээ	0	1	2	3

Тухайн газрын нийт үнэлгээ хийхийн тулд тухайн газарт эсвэл түүний ойр орчимд оршин суудаг эсхүл түүнийг ашигладаг хүний тоо эс бөгөөс газар доорхи болон гадаргын усыг ундны зорилгоор ашигладаг хүний тооны хамгийн өндөр утгыг харгалзан кодын эхний тоог тогтооно.

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо нь нийт нөлөөг эсвэл учирч болзошгүй нөлөөг илэрхийлдэг тул утга өндөр байх тусам нөлөөлөл ноцтой болно гэсэн үг юм.

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо	**бага нөлөөтэй** **0 эсвэл < 1**	⇒	**ноцтой нөлөөтэй** **4**

Мэдээллийн сангийн хэрэглэгч, бүртгэлийн тэмдэглэл боловсруулагч нар хоёр дахь тоог бодох аргачлалыг нарийн ойлгох шаардлагагүй бөгөөд уг тоо нь доорхи бүдүүвчээр харуулсан эрсдлийн үнэлгээний үндсэн схемийн дагуу бохирдлын ноцтой эсвэл ноцтой байж болзошгүй нөлөөллийн интеграл илэрхийлэл болох ерөнхий утгыг ухаж ойлгоход хангалттай.

бохирдлын эх үүсвэр ⇒ тархалтын болон нөлөөллийн зам ⇒ бохирдол хүлээн авагч.

Уг тоог бодох аргыг доорхи хүснэгтээр арай бодитойгоор харуулсан байна. Хүснэгтийн зүүн талын баганад ач холбогдлын кодын хоёр дахь тоо бодоход нөлөөлж буй хүчин зүйлийг оруулсан бөгөөд нөгөө хоёр баганад үнэлж буй нөлөө бага эсвэл өндөр болоход нөлөөлдөг түгээмэл гардаг захын тохиолдлуудыг заасан.

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо – үнэлгээний утгыг харуулсан жишээ			
дүгнэдэг хүчин зүйл ↓	**бага нөлөөтэй жишээ ↓**	⇒	**ноцтой нөлөөтэй жишээ ↓**
хорт бодисын концентрацийн хэмжээ	бага	⇒	өндөр
бодисын хортой чанар	цайр эрдэст тос	⇒	мөнгөн ус пестицид
хорт бодисын тархах чадвар	пестицид	⇒	хлоржуулсан уусгагч

хийнэ. Ийм аргаар гарсан эцсийн үнэлгээ нь хамгийн ноцтой байдлыг илэрхийлснээс гадна бодит байдалд нийцэхгүй байх магадлалтай. Ер нь үнэлгээ ийм аргаар хийвэл бүх газар ижил үр дүнтэй гарах тул ач холбогдлын үнэлгээ учир утгаа алдахад хүрнэ. Зайлшгүй бөглөх мөрөнд бодит байдалд нийцсэн мэдээлэл олон оруулах тусам үнэлгээ нь бодит байдалд улам нийцэх магадлалтай байдаг.

бохирдуулсан тайлбайн хэмжээ	бага	⇒	их
бохирдлын тархалтын нөхцөл	бохирдсон газраас нэлээд холын зайд гол байхгүй шаварлаг чулуулаг бат бөх гадаргуутай газар	⇒	үер усны аюулт өртөх магадлалтай газар ус нэвтрүүлэх чанар сайтай хайрга хорт тоос, тоосонцор
газар нутаг, түүний ойр орчимын ашиглалт (хүлээн авагч нараар) – бохирдлын нөлөөнд эмзэг	аж үйлдвэрийн газар ус ашигладаггүй ил уурхай	⇒	хүүхдийн тоглоомын талбай үндны усны эх үүсвээр дархан цаазтай газар

Ач холбогдлын буюу сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагын зэрэглэлийг газар нутгийн нэг ангиллын хүрээн (зэрэглэлийн ижил кодтой газар нутгийн) дотор кодын эхний болон хоёр дахь тоог харгалзан үнэлнэ. Харин юуны түрүүн нэг газрын судалгаа хийх үү, өөр газарт нөхөн сэргээлтийн ажил хийх үү гэсэн шийдвэр зөв биш. Нэг талаас нөхөн сэргээлтийг шаардагдах тухай мэдээлэл хангалттай буй газар нутгийг нөхөн сэргээлт хийлгэхээр сонгох, нөгөө талаас мэдээлэл нь хомс тул нөхөн сэргээлт шаардагдах эсэх талаар дүгнэлт хийх боломжгүй хэсэг газраас судалгаа хийлгэхээр газрын сонгох нь зүй ёсонд илүү нийцнэ.

Судалгаа эсвэл сэлбэн засах арга хэмжээ авах зорилгоор газрыг сонгохдоо эхний шатанд ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний тоог, дараагийн шатанд тус кодын хоёр дахь тоог удирдлага болгон сонголт хийвэл зохино.

Уг зарчимыг нарийвчилсан судалгаа явуулах зорилгоор газар нутгийн ач холбогдлын дэс дарааллыг тогтоох жишээн дээр тайлбарлаж болно.

Нарийвчилсан судалгаа явуулах зорилгоор газар нутгийн ач холбогдлын зэрэглэлийн дагуу дэс дарааллыг нь тогтоох жишээ		
ач холбогдлын код	ач холбогдлын дэс дараалал	ач холбогдлын дэс дарааллын тайлбар
PI-3-2	1	Ач холбогдлын хамгийн өндөр зэрэглэл – хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлж болзошгүй, аюулд өртөж болзошгүй хүний тоо хамгийн өндөр байна
PI-2-4	2	хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлж болзошгүй, бохирдлын улмаас учирч болох хорт нөлөө түрүүчийн жишээнээс бүр илүү ч байж болох хэдий ч аюулд өртөж болзошгүй хүний тоо харьцангүй бага байна
PI-0-4	3	бохирдлын улмаас учирч болох хорт нөлөө түрүүчийн хоёр жишээнээс бүр илүү ч байж болох боловч хүнд хорт нөлөө үзүүлэх аюул илрээгүй байна
PI-0-2	4	хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлэх аюул байхгүй, сөрөг нөлөө түрүүчийн жишээнээс бага байна

Мэдээллийн сангийн программ хангамж дээрх схемийн дагуу аль ч зэрэглэлд багтаасан бүх газрыг болон тодорхой нэгэн нутгийн талбайгаар зогсохгүй нийт улсын хэмжээнд автомат сонголт, ач холбогдлын дэс дарааллыг тогтоох боломж олгодог.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын хоёр тоо нь тухайн газрын ач холбогдлын ерөнхий үнэлгээг илэрхийлж байна. Программ хангамж нь дотроо бүртгэсэн газрын нутаг дэвсгэр, түүний ойр орчим, газар доорхи ус болон гадаргын ус гэсэн хэсэг бүрт тусгайлсан үнэлгээ өгөх бөгөөд нийлбэр үнэлгээ автоматаар хэсэгчилсэн үнэлгээний хамгийн муу дүнд үндэслэнэ. Газрын нийлбэр үнэлгээ тогтооход хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйлийг сонирхсон тохиолдолд газар нутгийн паспортад байгаа хэсэгчилсэн үнэлгээтэй танилцах боломжтой. Үнэлгээг нарийвчлан шинжилж үзвэл хамгийн доод зэргийн үнэлгээ буюу хамгийн ноцтой нөлөө нь зөвхөн сэжиг, үүсч болзошгүй нөлөө төдий л, эсвэл дээж авалт, шинжилгээгээр тогтоогдсон (батлагдсан) нөлөө байх гэсэн мэдээлэл нь их чухал. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн гарын авлагаас үзнэ үү.

7. Газар нутгийн тухай тэмдэглэл хөтлөхөд шаардлагатай мэдээлэл цуглуулах

Бохирдсон болон бохирдсон байж болох газруудын бүртгэлийн систем (CSIS)-д мэдээлэл оруулах ажлыг сургалтад хамрагдсан төрийн байгууллагуудын орон нутгийн салбар газар, хэлтсийн мэргэжилтнүүд хангана. Эдгээр нь мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэгтэйгээс гадна байгууллагынхаа хариуцдаг газар нутгийг сайн мэддэг давуу талтай.

Уг ажлыг хариуцсан байгууллага болон зохион байгуулалтын нарийн асуудлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас тусгайлан гаргасан тогтоолоор тогтоогдоно.

Бохирдсон болон бохирдсон байж болох газруудын бүртгэлийн системд мэдээлэл, өгөгдөл боловсруулах ажил дараах үе шаттайгаар явагддаг.

- бохирдсон болон бохирдсон байж болох газрыг илрүүлж, тогтоох,
- бохирдсон болон бохирдсон байж болох газрын тухай мэдээлэл цуглуулах,
- бохирдсон байж болох газрын тухай анхдагч мэдээлэл цуглуулах, шалгах,
- бүртгэсэн газрын тухай мэдээлэл боловсруулах,
- бүртгэсэн газар тус бүрт цаашид авагдах арга хэмжээний хувьд нь ач холбогдлын үнэлгээ өгч, форматлах,
- боловсруулсан мэдээллийг батлах

Мэдээллийн санд оруулах гэж буй газар нутаг бүрт карт үүсгэх бөгөөд мэдээлэл боловсруулагч бүртгэж буй газрыг бохирдсон, бохирдсон байж болох, бохирдолтой огт холбоогүй эсвэл эхлээд шалгах шаардлагатай гэсэн газрын шинж чанарыг заана.

Бохирдсон болон бохирдсон байж болох газрын зэрэглэлд хамаарагдаж буй газрын бүртгэлийн эцэст тухайн бохирдлыг шийдвэрлэхэд шаардлагатай зэргийг тодорхойлно (дээж аваагүй газрын хувьд үүнийг программ хангамж автоматаар оруулна). Бохирдсон газруудыг ийм аргаар үнэлэх боломжтой болохын тулд маягтын заавал бөглөх гэсэн тэмдэглэгээтэй бүх мэдээллийг оруулах шаардлагатай.

Бохирдсон болон бохирдсон байж болох газрын зэрэглэлийн газрын заавал бөглөх шаардлагатай мэдээллийг оруулахын тулд газар бүрт биечлэн очиж, газар дээр нь үзлэг шинжилгээ хийх шаардлагатай болж магадгүй. Ихэнх тохиолдолд бохирдсон гэсэн

шинж тэмдэг бүхий газрын тухай олж авсан урьдчилсан мэдээллийг шалгахын тулд газар дээр нь очиж үзлэг шинжилгээ хийх хэрэгтэй байна.

Газрыг бохирдсон эсвэл бохирдсон байж болзошгүй гэдэг нь дараах зүйлээс илэрхий байдаг. Үүнд,

- хорт бодисын чулуулгийн орчин, түүнчлэн газар доорхи болон гадаргын усанд тогтмол эсвэл гэнэтийн тархалтын эх үүсвэр байж болзошгүй одоогийн эсвэл хуучин үйл ажиллагааны тухай мэдээлэл,
- хорт бодисын концентрацийн хэмжээ өндөр байгааг бодитойгоор тогтоогдсон судалгааны ажлын дүгнэлт, үр дүн,
- сэжигтэй объект, хог хаягдал, толбо, үнэр, хордсон ургамал, амьд организмд үзүүлсэн сөрөг нөлөө зэрэг бохирдлын улмаас үүссэн үр дагаварыг шууд ажигласан.

Газрын тогтоох, тодруулах мэдээллийг цуглуулах явцад хариуцсан байгууллагын ажилтнууд дараах зүйлийг ашиглаж ажиллана. Үүнд,

- өөрийн хариуцаж буй нутаг дэвсгэр дээрх хяналт, байцаалтын үйл ажиллагааны явцад бохирдсон болон бохирдсон байж болох газруудын тухай цуглуулсан мэдлэгийг,
- төрийн болон орон нутгийн засаг захиргааны доод түвшингийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг,
- бохирдсон болон бохирдсон байж болох газруудын эсвэл тийм газар байх магадлалтай тухай мэдээллийн анхдагч эх үүсвэр болох болзошгүй төрөл бүрийн мэдээллийн эх үүсвэрийг.

Бохирдсон, бохирдсон байж болох эсвэл бохирдсон байж болзошгүй шинж тэмдэг бүхий газрын тухай мэдээлэлд дараах эх үүсвэрийг ашиглах боломжтой. Үүнд,

- Байгаль орчны үндэсний мэдээллийн төвийн мэдээллийн сангийн зохих давхаргууд,
- газар доорхи усанд эсвэл чулуулгийн орчны газрын доорхи гадаргад агуулагдсан хорт бодисын тухай мэдээлэл агуулсан бол геохимийн болон ордны судалгааны дүгнэлт, тайлан,
- Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл зэрэг байгууллагаас газруудаас тодорхой бохирдуулагч бодисыг тогтоох зорилгоор урьд нь явуулсан зарим төслийн үр дүн (жишээлбэл, алт олборлолтын явцад ашиглагддаг цианидууд, мөнгөн ус, пестицидууд, ПХБ, үйлдвэрийн полихлорт бифенилууд, диоксинууд, фуранууд гэх мэт),
- агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл (хүрээлэн буй орчны бусад салбаруудад нөлөөлж болзошгүй бохирдуулагчтай холбоотой үйл ажиллагааны шинж тэмдэг мэдээлэл)
- хаягдал болон уул уурхайн бохир усыг газрын гадаргын усанд хаях зөвшөөрлийн бүртгэл,

- байгууллагуудын хяналт байцаалтын ажиллагааны баримт бичиг эсвэл аваар ослын баримтжуулалт гэх мэт
- төрөл бүрийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох тухай шийдвэр зэрэг баримт бичиг,
- судалгаа, эрэл хайгуул, бохирдсон газрын нөхөн сэргээлтийн ажлын баримтжуулалт,
- онгоцноос авсан гэрэл зургаас олж авсан мэдээлэл,
- орон нутгийн иргэдээс олж авсан мэдээлэл.

Нөхцөл байдлаас шалтгаалан дээр дурдсан жагсаалтад ороогүй мэдээллийн эх үүсвэр ашиглах боломжтой.

Бохирдсон болон бохирдсон байж болох газруудын бүртгэлийн системийг бодит амьдрал дээр бохирдлын ачааллыг хяналтанд байлгах, түүнийг багасгахад чиглэсэн ажлыг зохицуулах боломжтой болохын тулд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт оршдог бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай аль болох бүрэн дүүрэн мэдээллийг агуулах ёстой.

Шаардлагатай мэдээллийг тодорхой заасан хугацааны дотор цуглуулах зорилгоор эхний үе шатны тооллого явуулахаар төлөвлөж байна. БОНХЯ-аас тооллогын зохион байгуулалт, техникийн асуудал болон тооллого явуулах хугацаа тогтоохоос гадна тооллогын ажлыг мэргэжлийн талаас нь хариуцан зохицуулах этгээдийн томилж ажиллуулна.

Бохирдсон болон бохирдсон байж болох газрын бүртгэл хөтлөх нь холбогдох байгууллагуудын байнгын үүрэг болох бөгөөд цаашид ч урьд өмнө үүссэн бохирдол бүхий газар илрэхээс гадна шинээр ямар нэг бохирол үүснэ гэдгийг үгүйсгэж болохгүй юм. Эдгээрийг ямар ч тохиолдолд мэдээллийн санд бүртгэх буюу зохих мэдээлэл оруулж, ач холбогдлын зэрэглэл тогтоож ажиллана.

Холбогдох байгууллагууд бас иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгаж, бүртгэлийн системд оруулах үүрэгтэй. Иргэдээс ирүүлсэн мэдээллийг хэрхэн яаж бүртгэх, боловсруулах, хянан шалгах талаар БОНХЯ-аас гаргасан тусгай тушаалаар зохицуулна.

Мэргэжлийн судалгаа, бохирдсон газрын нөхөн сэргээлтийн ажлын явцад цуглуулсан мэдээлэл, түүний үр дүнг бүртгэлийн системд бүртгүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихыг холбогдох байгууллагуудад тусгай тушаалаар даалгана. Эдгээр мэдээлэл, тайлан судалгаа, нөхөн сэргээлтийн үр дүнг бүртгүүлэхийг БОНХЯ-ы тусгай тушаалаар гүйцэтгэгч байгууллагуудад даалгахаар төлөвлөсөн байна. Дээр дурдсан тусгай тогтоол хүчин төгөлдөр болтол судалгаа, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг бүртгээлэх ажлыг холбогдох байгууллагууд хариуцна.

8. Газар нутгийн тэмдэглэл боловсруулах үйл явц

Газар нутгийн тэмдэглэл боловсруулах үйл явц дараах үе шаттайгаар явагдана. Үүнд,

1) Мэдээллийн сангийн программ хангамжийг ачаалж суурилуулах, тохиргоо (конфигураци) хийх

2) Мэдээлэл, өгөгдөл цуглуулах эрх олж авах

3) Газар нутгийн тэмдэглэл хийх/шинэчлэх

4) Ач холбогдлын зэрэглэл тогтоох

5) Хийсэн өөрчлөлтийг батлах.

8.1 Мэдээллийн сангийн программ хангамж ачаалж суурилуулах, тохиргоо хийх

Аливаа хэрэглэгч CSIS бүртгэлийн системийг ашиглахын тулд системд бүртгэх үе шатнаас эхэлдэг. Системийн мэдээлэл, өгөгдөл боловсруулах, батлах эрхтэй болох гэж буй хэрэглэгчид бүртгүүлэхдээ ямар нэг байгууллага эсвэл байгууллагын салбарт нэгтгэж бүртгэнэ. Байгууллага, байгууллагуудын салбаруудыг системд нэмж оруулах боломжтой. Дараагийн шатанд хэрэглэгч мэдээллийн сангийн хариуцагч байгууллагаас менежерийн түвшингийн эрх авах хүсэлт тавьж, CSIS мэдээллийн сангийн администратораас менежерийн түвшингийн эрх олговол дараах эрх эдлэнэ. Үүнд,

1. мэдээлэл, өгөгдөл авах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах зориулалтын хэрэглэгчийн CSIS Editor программыг татах, компьютерт суурилуулах,
2. өөрийнх нь байгууллага эсвэл холбогдох салбарын дор бүртгэгдсэн хэрэглэгчдийг захирах.

Программ хангамжийг суурилуулах үед дотоод ажлын мэдээллийн сан, программ хангамжийг байршлын хувьд тус тусдаа суулгах боломжтой бөгөөд ингэснээр дотоод мэдээллийн санг компьютерийн дотоод сүлжээний хэд хэдэн хэрэглэгчид ашиглах боломжтой болно.

Менежер нь өөрийн багийн боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан мэдээлэл өгөгдлийн чанарыг хариуцаж, байгууллагынхаа системд бүртгүүлсэн хэрэглэгчдэд мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах эрх буюу хураангуйлагч (epitomist)-ын түвшингийн эрхийг өгөх, авах эрх эдлэнэ.

8.2 Мэдээлэл авах эрх авах

Менежер CSIS мэдээллийн сангийн администаас тодорхой ямар нэг бүс нутаг эсвэл тодорхой газарт холбогдон шинэ тэмдэглэл үүсгэх болон/эсвэл тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулах эрх олгох хүсэлт тавина. Админ систем дотроо холбогдох эрх олгохын ялдамд хэрэглэгчийн программ автоматаар лиценз эзэмшигчийн эрхийн дагуу өгөгдөл татаж авна. Тэмдэглэл нэмж оруулах эрхтэй бол эрхийн хүрээнд анхдагч мэдээллийн бүртгэлийн холбогдох хэсэг багтсан байна. Хэрэв тийм биш бол зөвхөн Reg_ConSite бүртгэлийн тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэмдэглэл үүсгэх эрх авсан хэрэглэгч зөвхөн Reg_ID бүртгэлд нэмэлт өөрчлөлт хийх боломжтой. Тэндээс нэмэлт өөрчлөлт оруулж болохуйц тэмдэглэлийг Reg_ConSite бүртгэлд шилжүүлмэгц түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эрх авсан байна.

8.3 Анхдагч мэдээлэл ашиглах – газрын тухай тэмдэглэл үүсгэх

Эхний шатанд ямар ч газрын тухай мэдээлэл Reg_ID бүртгэлд бүртгэгдэх бөгөөд тэмдэглэлийг гурван аргаар олж авах боломжтой. Үүнд,

- гадны өгөгдлийн эх үүсвэрээс шилжүүлж авснаар – иймэрхүү тэмдэглэл боловсруулаагүйд тооцно,
- иргэд эсвэл засаг захиргааны байгууллагаас авсан мэдэгдлийн үндсэн дээр; иймэрхүү тэмдэглэл мөн боловсруулаагүйд тооцно,
- мэргэшсэн тэмдэглэл боловсруулагчийн тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулах зориулалтын хэрэглэгчийн программын тусламжтайгаар олж авснаар; иймэрхүү тэмдэглэлийг үүсгэх үеэс эхлэн боловсруулагдаж буй статустай байна.

Шинэ газрын тэмдэглэл үүсгэхээс өмнө ойр хавийн анхдагч мэдээллийн бүртгэлийг шалгах хэрэгтэй. Учир нь байршил тодорхойгүй, буруу дутуу зааснаас биш, ижил төстэй газрын тэмдэглэл давхар давхар үүсгэснээс сэргийлэх нь чухал. Заримдаа нэг газрын байршлыг тодорхойгүй заасан эсвэл нэг газрыг өөрөөр нэрлэж тэмдэглэсэн явдал тохиолдож болзошгүй. Нөгөөтэйгүүр зөвшөөрөлгүй шинээр бий болсон хогийн цэг эсвэл нөхөн сэргээгдсэн хогийн цэгийн нэг хэсэгт зөвшөөрөлгүй шинэ овоолго үүссэн, бүртгэгдсэн уул уурхайн орчимд зөвшөөрөлгүй шинэ уурхай бий болсон зэрэг бүртгэгдсэн газрын ойр орчимд түүнээс өөр, шинэ газрыг тэмдэглэх шаардлага гарч болох юм. Иймд, дээрх зүйлийг онцгой анхаарах хэрэгтэй. Анхдагч мэдээллийг шинээр оруулах гэж буй бүртгэлтэй гадны хэрэглэгчид ч зохих анхааруулга гарч ирнэ.

Бүртгүүлэх шатандаа бохирдсон шинж чанар бүхий газрын тухай тэмдэглэл үүсгэхийн тулд дор газрын нэр, байршлын тухай мэдээллийг бөглөн оруулах шаардлагатай. Гадны хэрэглэгч бүртүүлж буй мэдэгдэлдээ тухайн газрын ойр хавьд орших сум, бохирдлын төрөл, түүний бодлоор тухайн газрын бохирдлыг учруулсан байж болох үйлдвэрлэлийн салбарын тухай мэдээллийг сонголт хийх хэлбэрээр оруулна.

Сансарын зургуудаас бохирдсон байж болох газрын шинж тэмдэг агуулсан хэмээн үнэлгээний жагсаалтыг татаж авсан зэрэг өгөдлийн ямар нэг эх үүсвэрээс татснаар шилжигдсэн эсвэл гадны хэрэглэгч (public)-ийн бүртгүүлсэн анхдагч мэдээлэл одоогоор үнэлэгдээгүй мэдээллийн үе шатанд буюу статустай байна. Харин хураангуйлагчийн бүртгэгдсэн тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулах программын тусламжтайгаар бүтгүүлсэн ахдагч мэдээлэл автоматаар боловсруулагдаж буй (in progress) үе шат буюу статустай болж байна. Газар дээр үзлэг судалгаа хийх (site visit necessary) шаардлагатай хэмээн боломжийг гараараа сонгож аваагүй бол нэмэлт өөрчлөлт оруулах горимд ямар нэг үйлдэл хийж, өөрчлөлтийг хадгалуулснаар анхдагч мэдээлэл мөн адил боловсруулагдаж буй үе шат буюу статустай болж байна.

Хураангуйлагч анхдагч мэдээллийг бохирдсон эсвэл бохирдсон байж болох газартай огт холбоогүй гэж үзвэл түүнийг хасагдсанд тооцож, хассаны шалтгааныг тэмдэглэнэ. Хураангулайгч ямар нэг газрыг хасах эсвэл Reg_ConSite бүртгэлд шилжүүлэх талаар шийдвэр гаргах боломжтой болохын тулд түүний тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор газар дээр нь очиж үзлэг, судалгаа хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэж болно.

Хэрэв хураангуйлагч тэмдэглэлд мэдээлэл нэмж оруулах үед эсвэл нэмэлт шалгалт шинжилгээний үндсэн дээр тухайн газрыг үнэхээр бохирдсон эсвэл бохирдсон байж болох газар мөн байвал тэмдэглэлд тогтоогдсон бусад мэдээллийг оруулсны дараа Reg_ConSite бүртгэлд шилжүүлж бүртгүүлнэ. Тэмдэглэлийг анхдагч мэдээллийн маягтыг бүрэн бөглөж байж шилжүүлэх боломжтой.

8.4 Газар нутгийн тэмдэглэлийг шинэчлэх

Reg_ConSite бүртгэлд бүтгэсэн тэмдэглэлийг бөглөх үед үндсэн маягт болох газар нутгийн паспортын заавал бөглөх бүх цонх бөглөсөн эсвэл шинэчилсэн байх шаардлагатай (CSIS – Өгөгдөл боловсруулах гарын авлага үзнэ үү).

Дараагийн шатанд тэмдэглэл үүсгэх, асуудлыг судлахад ашигласан бичиг баримтын агуулгын товч, хураангуй хадгалагддаг. Бичиг баримтын хэсэгт нэмэлт мэдээлэл оруулах, шинэчлэх шаардлагатай ба ялангуяа мэдээллийн санд тэмдэглэл оруулах үндэслэл болсон даалгаврын тайлангийн хугаангуй, даалгаврын хариуцлагатай гүйцэтгэгч, холбогдох тогтоол, шийдвэр зэргийг бичиж оруулна. Мэдээллийн санд тэмдэглэл оруулах үндэслэл болсон даалгаврын тайлангийн агуулгын товчийг бүртгүүлээгүй бол газар нутгийн шинэчилсэн тэмдэглэлийг батлах боломжгүй юм.

Газар нутгийн тэмдэглэлийн бусад мэдээллийг тухайн газар нутгийг судласан байдал, даалгаврын цар хүрээ, чиглэлийн дагуу бөглөж оруулна. Мэдээлэл бөглөж оруулах арга энэхүү аргачлалын удирдамжийн 1 дүгээр хавсралт болох CSIS – Өгөгдөл боловсруулах гарын авлагад дэлгэрэнгүй заасан байна.

Тэмдэглэлийн хэсэг тус бүрт засварлах буюу Edit горим эхлүүлэх, төгсгөх хэлбэрээр явагдана. Edit горим төсгөх бүрт засварласан хэсэгт автоматаар хураангуйлагчийн код, өөрчлөлт үйлдсэн огноо, цаг хугацаа хадгалагдана. Он-лайн горимд ажиллах үед үйлдсэн өөрчлөлтийн тухай мэдээлэл хураангуйн нэгдсэн түүхэнд бичигдэнэ.

Reg_ConSite бүртгэлийн холбогдох бүх хэсгийг бөглөж, шинэчилсний дараа тухайн газар нутгийн ач холбогдлын зэрэглэлийг тогтооно.

8.5 Ач холбогдлын зэрэглэл тогтоох

Reg_ConSite бүртгэлд бүртгэсэн газар нутгийн тэмдэглэлийг боловсруулах эсвэл шинэчлэхийн эцэст ач холбогдлын зэрэглэл тогтооно. Ач холбогдлын зэрэглэл газар нутгийн паспортын заавал бөглөх талбарыг засварлаж, шинэчлэх бүрт тогтоогдоно (газар нутгийн паспортын заавал бөглөх талбарын жагсаалтыг гарын авлагаас үзнэ үү).

Газар нутаг бүр үнэлгээ, дүгнэлтийн үндсэн дээр зэрэглэлийг тодорхойлох үсгийн код болон хоёр оронтой тооноос бүрдсэн **ач холбогдлын зэрэглэлийн кодоор** үнэлэгдэнэ, жишээ нь PI-3-2. Ач холбогдлын зэрэглэлийн утга учрыг энэхүү аргачлалын удирдамжийн 6 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан. Хураангуйлагч ач холбогдлын зэрэглэл тогтоох зарчим, системийн нийт бүтэцийн талаар ойлголт сайтай байх зайлшгүй шаардлагатай.

Өөрөөсөө хийсэн ямар ч үнэлгээ, дүгнэлтгүйгээр программ хангамжийн санал болгож буй ач холбогдлын зэрэглэлийг зөвхөн урьд өмнө судлагдаагүй, дээж авалт хийгээгүй, бодит бохирдол байгаа эсэх талаар ямар ч мэдээлэлгүй буюу 6.2 бүлэгт заасан R1 хүснэгтийн зэрэглэлийн матрицийн дагуу PR, PI зэрэглэлд хамаарагдах газрыг бүртгүүлэх үед автоматаар хүлээн авах боломжтой. Хураангуйлагч дээр дурдсан R1 хүснэгтийн дагуу зохих зэрэглэлийг тогтоох бусад бүх тохиолдолд тухайн газар нутгийн судалгааны тайлангийн эсвэл эрсдлийн судалгааны дүгнэлтийг шинжилж судлаад зэрэглэлийн талаар өөрөө шийдвэр гаргана.

Хэрэв хураангуйлагч ач холбогдлын зэрэглэлийн үнэлгээ хийж, мэдээллийн санд хадгалсны дараа ач холбогдлын зэрэглэлийг тогтооход үндэс суурь болсон мэдээлэлд өөрчлөлт хийсэн эсвэл тухайн газар нутгийн ач холбогдлын зэрэглэлийг хэсэгчлэн

тогтоох үйлдэл хийсэн тохиолдолд ач холбогдлын зэрэглэлийг шинээр тогтоох хэрэгтэй болж байна (ийм тохиолдолд программ ач холбогдлын зэрэглэлийг тогтоох үйлдэл хийхийг шаардана).

Программын санал болгож буй ач холбогдлын зэрэглэл хураангуйлагчийн санаанд нийцэхгүй бол ач холбогдлын зэрэглэл тогтоох үндэс суурь болсон бүх мэдээллийг шалгана. Оруулсан бүх мэдээлэл бодит байдалд нийцэж буйг хянаж шалгаж байж программын санал болгож буй зэрэглэлийг өөрчилж болох бөгөөд түүний үндэслэлийн тайлбарыг газар нутгийн паспортын зохих талбарт заана (гарын авлага үзнэ үү). Администратор хэзээд ч программын автоматаар гаргасан ач холбогдлын зэрэглэлийг хураангуйлагчийн сонголттой нь харьцуулах боломжтой.

8.6 Хийсэн өөрчлөлтийг батлах

Ач холбогдлын зэрэглэлийг тогтоосны дараа тэмдэглэлийг менежерийн түвшингийн эрх авсан хариуцлагатай гүйгүйцэтгэгч шалгаж, чанар нь хангалттай гэж үзвэл тэмдэглэлийг батлуулах хүсэлтэй гэсэн тэмдэгээр тэмдэглэнэ. Хүсэлтээ хэзээд ч эргүүлэн авч, тэмдэглэлийг дахин боловсруулах боломжтой. Дараагийн шатанд тэмдэглэлийн бүрэн дүүрэн, техникийн талаас нь зөв, өгөгдлийн нэгдмэл байдлыг тулган баталгаажуулагч (verificator) хянан шалгана. Энэ ажилтан нь шаардлагын дагуу өгөгдөл нийлүүлэгч талд ч, эсвэл хүлээн авагч талд ч ажиллаж болох юм. Тулган баталгаажуулагч тэмдэглэлийг баталсан эсэх тухай мэдэгдлийг автоматаар үүсгэж, холбогдох хураангуйлагч, боловсруулагчийн хариуцлагатай төлөөлөгч (менежер) нарт и-мейлээр ирүүлнэ. Тэмдэглэлийг батлаагүй тохиолдолд автоматаар үүсгэсэн и-мейлд үндэслэлийг оруулж явуулна. Администратор системийн тохиргоонд буцаасан бүх тэмдэглэлийн тухай мэдэгдэл авах хүсэлтэй гэсэн боломжийг сонгох боломжтой бөгөөд ингэсэн тохиолдолд адиминистратор тэмдэглэлийг буцаасан үндэслэл, тайлбар агуулсан и-мейл авах болно.

Нэгэнт батлагдсан тэмдэглэлд дахин орж нэмэлт өөрчлөлт хийх боломжгүй болж байна. Администратор түүнийг хянан шалгаж, нэмэлт өөрчлөлтийг хүлээн авч, батлах эсвэл хүлээн аваагүй нэмэлт өөрчлөлтийн талаар тайлбар бичээд дахин боловсруулахаар буцаана. Администратор системийн тохиргоонд тэмдэглэл батлагдаагүй тухай мэдэгдлийг тулган баталгаажуулагч (verificator)-д автоматаар ирүүлэх боломжийг сонгож болно. Ингэсэн тохиолдолд автоматаар үүсгэсэн и-мейл хураангуйлагч, лиценз эзэмшигчийн хариуцлагатай төлөөлөгч (менежер) нараас гадна тулган баталгаажуулагч (verificator)-д ирүүлнэ. Тэмдэглэл батлагдсан, эс батлагдсны улмаас цоож нь тайлагдаж тэмдэглэлийг дахин засварлах боломж олгоно. Тэмдэглэл батлагдснаар газар нутгийн паспортод агуулсан үндсэн мэдээллийг олон нийтэд нээлттэй хэсэгт хуулах бөгөөд тэнд тэмдэглэлийн өмнө үйлдсэн хуулбар байвал тэмдэглэл шинэчлэгдэнэ.

8.7 Газар нутгийн тэмдэглэлийг зөв боловсруулах, түүнчлэн ач холбогдлыг нь зөв үнэлэн тогтоох үндсэн зарчим

CSIS бүртгэлд эхлээд мэдээлэл өгөгдөл боловсруулах, түүнийг үндэслэн тайлан боловсруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Ийм дэс дарааллыг баримтласнаар тайланд чухал зарим хэсгийг мартаж орхих, баримтжуулалтын ижил төстэй цэгүүдийг хоорондоо ялгаатай аргаар давхар давхар тэмдэглэхээс сэргийлэхээр барахгүй түүнийг

чанартай зохион байгуулалт бүхий болгох буюу илүү үр өгөөжтэй, чанартай ажиллахын баталгаа болно.

Нэг газрын давхар бүртгүүлэхгүй тулд хэрэглэгч шинэ тэмдэглэл бүртгүүлэхээс өмнө тухайн газрын ойр орчимд оршдог бохирдсон гэсэн шинж тэмдэг бүхий газрын тухай бүртгэгдсэн анхдагч мэдээллийг шалгах үүрэгтэй. Шинэ тэмдэглэлд заавал оруулах шаардлагатай цөөн хэдэн мэдээлэл бөглөөгүй тохиолдолд мэдээллийн санд бүртгүүлэх боломжгүй. Мэдээллийн санд холбогдох мэдээллийг нь оруулах гэж буй судалгааны эсвэл нөхөн сэргээлтийн ажлыг хариуцсан гүйцэтгэгч ихэнх тохиолдолд CSIS мэдээллийн санд оруулсан тэмдэглэлийн үнэн зөв, хийгдсэн арга хэмжээний эцсийн тайланд бүрэн нийцсэн гэдгийг хариуцсан боловсруулагчийн төлөөлөгч (менежер түвшин) байдаг. Арга хэмжээний бичиг баримтын судалгаа холбогдох тэмдэглэлийн хэсэг болох ёстой. Газар нутгийг хэсэгчилсэн секторуудад хуваах ба сектор тус бүрт цооног, шинжилгээний бие даасан бүртгэлийг хөтлөх боломж ялангуяа том талбай бүхий газарт их үр өгөөж өгдөг юм. Нэгэнт бүртгэгдсэн газар нутагт ямар нэг шинэ арга хэмжээ хийх тохиолдолд газрын шинэ тэмдэглэл үүсгэхгүйгээр тухайн газар нутагт холбогдсон “Баримт бичиг” хэсэгт арга хэмжээг баримтжуулах мэдээллийг бүртгүүлж тэмдэглэлийг шинэчилснээр уг арга хэмжээ тэмдэглэлд бичигдэнэ. CSIS мэдээллийн сан шаталсан бүтцийн оргилдоо арга хэмжээ биш, газар нутгийг тавих бөгөөд арга хэмжээ нь газар нутагт харъяалагдах тэмдэглэл болж захирагдана. Арга хэмжээний бүртгэлийг CSIS мэдээллийн сангийн баримтын сан хэлбэрээр хөтлөнө. Тэмдэглэлд бохирдлын газрын зураг, гидроизогипсын зураг зэрэг зурагтай материал хавсаргах нь зүйтэй. Мэдээлэл боловсруулагч хавсаргасан зургийг оновчтой нэрээр нэрлэхийг мартаж болохгүй.

Чухал ач холбогдол бүхий баримт бичиг эсвэл баримт бичийн чухал хэсгийг бичиг баримтын иш татсан зүйлийн жагсаалтад бичиг баримтын судалгааг PDF файлаар хавсаргах нь зүйтэй. Энэ нь ялангуяа төрийн байгууллагуудын шийдвэрийн хувьд их чухал алхам болно.

Ач холбогдлын зэрэглэл тогтоохдоо PR, PI –ээс зэрэглэлд хамаарагддагаас бусад газарт программаар санал болгож буй зэрэглэлийг автоматаар хүлээн зөвшөөрөх нь буруу. Судалгааны ажил, түүнчлэн эрсдлийн судалгааны үр дүнд шүүмжлэлтэй үнэлэх хэрэгтэй. Программын санал болгож буй үнэлгээг бүртгэлд хураангуйлан оруулсан бусад мэдээлэлтэй холбогдуулан авч үзэх шаардлагатай бөгөөд бодит байдалд нийцээгүй тохиолдолд юуны түрүүнд бөглөсөн маягтыг шалгаж, тухайн газарт ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагын хувьд зэрэглэлийг нь зөрүүтэй тогтооход нөлөөлсөн байж болзошгүй мэдээлэл оруулсан эсэхийг тогтоох нь чухал. Бөглөж бүртгүүлсэн мэдээлэл бодит байдалд нийцэхгүй бол засварлах шаардлагатай. Мэдээлэл өгөгдөл зассны улмаас бодит байдалтай харьцуулвал зөрүүтэй байдал бүтгүүлэхэд хүрвэл эцсийн зэрэглэлийг судалгаа, эрсдлийн судалгааны бодит үр дүнд нийцүүлэх хэрэгтэй. Программын санал болгосон зэрэглэлийг хүлээн авалгүйгээр өөр зэрэглэлийг тогтоосон үндэслэлийг газар нутгийн паспортын зохих талбарт тайлбарлана (гарын авлага үзнэ үү). Ач холбогдлын зэрэглэл газар нутгийн паспортын заавал бөглөх талбарыг шинэчлэх бүрт шинээр тогтоогдоно. Өгөгдлийн хязгаараалгүй талбарт шинэ мэдээлэл бөглөснөөр тэмдэглэлийг шинэчлэх үед урьд өмнө оруулсан бичвэрийг буруу эсвэл хангалтгүй байх тул орлуулах эсвэл тухайн үеийн нөхцөл байдлыг харуулсан, хуучирсан мэдээлэл болох тул шинэчлэгдэх гэдгийг анхааралдаа авах шаардлагатай. Талбарыг урьд нь оруулсан мэдээллийг устгахгүйгээр шинэчлэх юм бол хураангуйлагч

хуучин бичвэрийн өмнө нь уг мэдээлэл оруулсан “он/сар”-ыг тавьж (урьд нь тавиагүй бол), хуучин бичвэрийн өмнө шинэ бичвэрийг оруулж буй огноог “он/сар” хэлбэрээр зааснаас эхлээд бичиж оруулна. Шинээр оруулж буй бичвэрийг ямагт тухайн талбарын эхэнд оруулж, хуучин текстийг доошоо явуулж шинэ догол мөр үүсгэнэ.

9. Мэдээллийн санг удирдан захирах

Мэдээллийн санг удирдан захирах ажил дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд,

- хэрэглэгчдийг захирах, газар нутагтай холбоотой мэдээлэл, өгөгдлийг үүсгэх, засварлах, шинэчлэх эрхийг олгох/хасах,
- газар нутаг дээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний төрөлтэй холбогдуулан батлуулахаар хүлээгддэг зориулалтын тэмдэг бүхий тэмдэглэлийг хянах, хүлээн авах,
- мэдээлэл, өгөгдлийн хураангуйн түүхийг хянах, мэдээллийн сангийн нэгдмэл болон аюулгүйн байдлыг хянах,
- тусламжийн цэс, мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт, системийн гэнэтийн хэвийн бус үйл ажиллагааны үед авагдах арга хэмжээ зэргийг шинэчлэх, системийн аюулгүй байдал, боловсруулдаг өгөгдлийн чанарын хувьд ч гэнэтийн хэвийн бус үйл ажиллагааг давтахаас сэргийлэх арга хэмжээ авах.

CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

GEOMIN s.r.o.
586 01 JIHLAVA, Znojemská 78

dekonta

Хүрээлэн буй орчны геологийн үндсэн ойлголтын толь бичиг

A: Хүрээлэн буй орчны геологи

B: CSIS – Бохирдолтой талбайн мэдээллийн сан

Glossary of basic concepts of environmental geology

A: Environmental geology

B: CSIS – Contaminated Sites Information System

A: Хүрээлэн буй орчны геологи/Environmental geology

Монгол/Mongolian	Англи/English	Тайлбар/Explanation
ажиглалтын худаг/цооног	**observation borehole**	бас ажиглалтын цооног гэж хэлнэ, газар доорх усны түвшинг хэмжих, дээж авах, хээрийн бусад төрлийн хэмжилт хийх зорилгоор машинаар өрөмдөж хийсэн гидрогеологийн байгууламж
ан цавын ус нэвтрүүлэх чанар	**fissure permeability**	гидравлик градиентын үйлчлэлээр шингэн урсахыг боломжтой болгож буй хоорондоо холбосон ан цаваас үүдэлтэй уул чулуулгийн ус нэвтрүүлэх чанар
анизотропи	**anisotropy**	орчны шинж чанарын өөрчлөгдөж буй чиглэлээс хамаарах байдал; орчны шинж чанар чиглэлээс хамааран ялгаатай байдаг, жишээ нь гидравлик дамжуулах чадварын коэффициентын утга өөр байдаг; изотропийн эсрэг байдал
артезийн уст үе	**artesian ground water body**	дээд талаасаа (изолятор, артезийн тааз) ус үл нэвтрүүлэх давхаргаар хучигдсан түрэлттэй гадарга бүхий уст үе; уг ус үл нэвтрүүлэх дээд талын давхаргад цооног өрөмдсөн тохиолдолд ус гадаргуугаас дээш орших пьезометрийн даралтын түвшинд өснө.
байгалийн рашаан	**natural healing water**	эмчилгээний зориулалттай ашиглах боломжтой шинж чанар бүхий, мөн рашаан сувилалын тухай хуулийн дагуу зохих гэрчилгээ олгосон байгалийн илэрцтэй эрдэст ус
байгалийн эрдэст ус	**mineral water**	газар доорх энгийн уснаас физик, химийн өвөрмөц шинж чанараараа ялгаатай газар доорх ус; Чех Улсын хууль тогтоомжийн дагуу (рашаан сувилалын тухай 163/2001 тоот хууль) эмчилгээний зориулалттай эрдэст ус гэж ууссан хатуу бодисыг 1 г/л-с доошгүй хэмжээгээр агуулсан эсвэл ууссан нүүрстөрөгчийн давхар исэл эсвэл эрүүл мэндэд эерэг нөлөөтэй химийн бодисыг 1 г/л-с доошгүй хэмжээгээр агуулсан эс бөгөөс булгаас илрэх үед 20 хэмээс доошгүй дулаан эсвэл радоны цацраг идэвх чанар 1,5 кБк/л-с доошгүй байх усыг хэлнэ.

байгалийн, жам ёсны бууралт шингэлэлт	**natural attenuation**	уул чулуулгийн орчин дахь бохирдлын бодисын агууламж эсвэл концентраци буурахад нөлөөлдөг байгалийн үйл явц (процессууд), жишээ нь, буурах, фаз хоорондын өөрчлөлт (ууршилт, уурын өтгөрөл буюу конденсаци), биологийн эсвэл химийн задрал, адсорбци, дифузи-дисперсийн үйл явц гэх мэт.
биозадрал	**biodegradation**	гол төлөв бичил биетийн тусламжтайгаар явагддаг бодисын биологийн задрал. Уг задралын явцад бичил биетүүдийн бодисын солилцооны үр дүнд янз бүрийн, ялангуяа органик бодис задарч энгийн бодис болж хувирдаг (жишээ нь, газрын тосны бүтээгдэхүүний биозадрал)
бохирдлын голомт	**contamination point**	чулуулгийн орчинд сөрөг нөлөө бүхий гадны бодисын анхдагч эсвэл хоёрдогч хуримтлал үүссэн газар
бохирдлын тархах чанар	**mobility of contamination**	сөрөг нөлөө бүхий гадны бодисын чулуулгийн орчны аль нэг хэсгээр тархан дэлгэрэх чанар
бохирдлын эх үүсвэр	**contamination source**	сөрөг нөлөөтэй гадны бодис байгаль орчны бүрэлдүүлэгч хэсгүүдэд нэвтрэх газар (газрын гадаргад эсвэл гүнд хог хаягдал орших явдал эсвэл барилгын хийцийн бохирдсон хэсгүүд бохирдлын эх үүсвэр байж болох юм)
бохирдол	**contamination**	ус, уул чулуулаг, хөрсний агаар зэрэг чулуулгийн орчны тухайн хэсэгт агуулагдсан сөрөг нөлөөтэй гадны бодис; хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд химийн бодис болон байгаль орчинд ер нь тохиолддоггүй шинж чанар, концентраци эсвэл хэмжээ бүхий сөрөг нөлөөтэй бусад бодис оршиж буй байдал
бохирдсон газар	**contaminated environment**	сөрөг нөлөө бүхий гадны бодис илэрч болзошгүй эсвэл илэрсэн газар талбай
бохирдуулагч бодис	**contaminant (pollutant)**	ус, уул чулуулаг, хөрсний агаар зэрэг чулуулгийн орчны тухайн хэсэгт агуулагдсан сөрөг нөлөөтэй гадны бодис
бохирдуулагч үүл	**contamination cloud**	тухайн газар нутгийн бохирдлын хэвийн хэмжээнээс хэтэрсэн гадны бодис илэрсэн чулуулгийн орчин дарь орон зай
булгийн (гидрогеологийн объектийн) ундарга	**yield of the spring (of the hydrogeological object)**	булаг эсвэл гидрогеологийн объектоос нэгж хугацаанд, голдуу нэг секундэд гардаг эсвэл шавхагддаг газар доорх усны хэмжээ

бүлэг	**set**	ашиг сонирхлыг илэрхийлэх бүх нэгж хэсгүүдийн нийлбэр.
буурцын нөлөөний хүрээ	**action dispersion radius**	ус шавхах объектын босоо тэнхлэг ба ус шавхалтаар нөлөөлөөгүй, газар доорх усны түвшин орших газрын хоорондох зай
буурцын хүнхээл	**depression cone**	буурцын талбай, газар доорх ус шавхагдсны улмаас буурсны өмнөх газар доорх усны түвшингийн хоорондох орон зай; газрын доорх усыг гидрогеологийн объектоос авах үед усны түвшин юүлүүр хэлбэртэй буурдаг
гадаргын урсац	**surface outflow**	сав газраас газрын гадаргуугаар урсаж гол мөрний сүлжээнд цутгаж ордог нийт урсацын бүрэлдүүлэгч хэсэг
газар доорх урсац	**underground water outflow**	1. гидравлик градиентын үйлчлэлээр тэжээгдлийн мужаас илрэлийн муж хүртэлх газар доорх усны хөдөлгөөн, 2. нэгж хугацаанд сав газар эсвэл өөр газраас урссан газар доорх усны эзлэхүүн
газар доорх ус	**underground water**	газар доорх ханасан бүсэд уул чулуулгийн шууд холбоотой шингэн төлөвт байгаа ус; ус шүүрүүлэх системээр дамжин урсах болон цооног, худгийн ус бас газар доорх усанд тооцогдоно. Гидрогеологийн талаас ханамал бүсээс гадна буюу капилляр ирмэг, ханаагүй бүсэд орших усыг мөн газар доорх усанд тооцно.
газар доорх усны баланс	**underground water balance**	газар доорх усны нөөцийн өөрчлөлтөд нөлөөлөх үзүүлэлтүүдийн тоон харилцааны цаг хугацаагаар өөрчлөгдөх зүй тогтол.
газар доорх усны горим	**underground water outflow regime**	цаг хугацаанд болон орон зайнд газар доорх усны тоон болон чанарын үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн дүрмүүд
газар доорх усны коллектор	**underground water collector**	чулуулгийн орчинд газар доорх ус хуримтлаж, уст үе үүсэх боломжтой орон зай

газар доорх усны түвшин	**underground water level**	1. геометрийн утгаар уст үеийн дээд хязгаар болох хавтгай гадаргуу (чөлөөт гадаргуу), түрэлттэй гадаргуугийн талаар уст үеийн түрэлттэй гадаргууг үзнэ үү 2. энергийн утгаар газар доорх усны хувийн энергийн хэмжээтэй тэнцэх тэнцвэрт талбай буюу өөрөөр хэлбэл тухайн уст үед хийсэн хуурмаг цооногийн пьезометрийн түвшингүүдээс (тогтонги түвшингүүдээс) бүрдсэн хавтгай талбай (түрэлтийн түвшин, пьезометрийн түвшин, потенциометрийн түвшин, чөлөөт гадаргуу) 3. цооног/худгийн усны түвшин (тогтонги түвшин, хөдөлгөөнт түвшин)
газар доорх усны түвшин	**underground water depth level**	газрын доорх ус, гадаргуу хоорондын босоо зай
газар доорх усны түвшингийн доошлолт	**underground water level decrease**	ус шавхах, (дренаж хийх) шүүрэх зэрэг гадны үйлчлэлээр газар доорх усны орших гүн гүнзгийрэх явдал
газар доорх усны усгүйжүүлэх суурь	**underground water drainage base**	ямар нэгэн уст системээс газар доорх ус урсан гарч, гадаргууд ил гарах буюу гадаргын усанд цутгаж буй газар; газар доорх усны усгүйжүүлэх байгалийн суурь нь гол төлөв гадаргын усны хөндийд оршдог; ингэхэд тухайн газрын газар доорх усгүйжүүлэх суурь нь элэгдлийн суурьтай төстэй байна.
газар доорх усны хагалбар	**groundwater distribution**	газар доорх усны пьезометрийн түвшингийн хамгийн дээд цэгүүдийг холбосон гидрогеологийн сав газрыг салгаж буй шугам; газарзүйн (уулзүйн) хагалбарын үйл явцаас ялгаатай үйл явцтай байж болно
газар доорх усны эх үүсвэр	**underground water source**	ус шавхах зорилгоор ашиглагддаг уст үе, усан цогцолбор зэрэг гидрогеологийн коллекторт орших газар доорх ус; цооног, худаг зэрэг ус хураах объектыг газар доорх усны эх үүсвэр гэж буруу нэрлэх нь түгээмэл байдаг
газрын гадаргуугийн урсац	**surface outflow**	сав газраас газрын гадаргуугаар урсаж, гол мөрний сүлжээнд цутган ордог нийт урсацын бүрэлдүүлэгч хэсэг
газрын гадаргын доогуурх ус	**under-surface water**	дэлхийн бүрхэвчинд агуулагдсан усны бүх төлөв
газрын гадаргын ус	**surface water**	газрын гадаргуугаар урсах эсвэл газрын гадарга дээр (хиймэл) усан санд эсвэл байгалийн нуурт тогтсон ус

гетерогенийн (нэгэн төрлийн бус) байдал	**heterogeneity**	чулуулгийн орчин, коллекторын ижил бус бүтэцтэй байх чанар; хоорондоо шинж чанараараа ялгаатай хэсгээс бүрдсэн цогцолбор
гидравлик градиент (налуу, хазайлт)	**hydraulic gradient (declination, gradient)**	урсацын чиглэлийн дагуу усрацын уртын нэгжид ногдох сонгогдсон харьцуулалтын хавтгай дээрх даралтын шугамын бууралт, даралтын шугамын налуугаар илэрхийлсэн байдаг
гидравлик дамжуулалтын илтгэлцүүр K	**coefficient of hydraulic conductance K**	тооны хувьд нэгжийн гидравлик градиентын Дарсийн хурдтай тэнцэнэ, хурдны хэмжээтэй бөгөөд м.с-1-аар илэрхийлдэг; урьд нь ижил утгаараа k эсвэл kf –р тэмдэглэсэн шүүрэлтийн илтгэлцүүр гэж хэрэглэгддэг байсан.
гидрогеологийн баланс	**hydrogeological balance**	тодорхой цаг хугацааны туршид сав газар, газар нутаг эсвэл усан цогцолбор дахь усны өсөлт, бууралт, усны нөөцийн өөрчлөлтийн харьцуулалт
гидрогеологийн бүрэн бус объект	**incomplete hydrogeological object**	нээлттэй хэсэг нь уст коллекторын нийт зузаанаар нэвт гарахгүй гидрогеологийн объект
гидрогеологийн бүрэн объект (байгууламж)	**full hydrogeological object**	нээлттэй хэсэг нь коллекторын (байгууламж)-ийн уст үеэр нэвт гардаг гидрогеологийн объект
гидрогеологийн изолятор	**hydrogeological insulator**	зэргэлдээх чулуулгийн орчинтой гидравликийн ижил нөхцөлтэй боловч ус нэвтрүүлэх чадвараараа муу учир гравитацийн усны нэвтрэлтийг саатуулдаг чулуулаг биет; зааглагдаж байгаа зэргэлдэх чулуулгийн орчноос ус нэвтрүүлэх чадвараараа нэлээд их хэмжээгээр доогуур байдаг чулуулаг биет
гидрогеологийн коллектор	**hydrogeological collector**	зэргэлдээх чулуулгийн орчинтой гидравликийн ижил нөхцөлтэй боловч ус нэвтрүүлэх чадвараараа илүү учир гравитацийн усны нэвтрэлт хялбар байдаг чулуулаг биет; гидрогеологийн коллектор энгийн болон нийлмэл хоёр янз байдаг; энэ газар доорх усыг чухал хэмжээгээр нөөцлөх, урсах, шавхах боломж олгодог орчин юм
гидрогеологийн объект	**hydrogeological object**	газар доорх усны коллекторт хүрч байгаа цооног эсвэл худаг; үүнийг газар доор ус судлах, хянах, мониторинг хийх эсвэл шавхах зорилгоор ашиглах боломжтой

гидрогеологийн тогтоц	**hydrogeological structure**	газар доорх усны тогтмол урсгал, эргэлт явагддаг геологийн орчны хэсэг; геологийн ертөнцийн бусад хэсгүүдээс тэжээгдлийн мужаас эхлээд тээвэрлэлт, илрэлийн муж хүртэлх газар доорх усны нэгдсэн болон цөгцгөр эргэлтээрээ ялгаатай геологийн тодорхой цогцолбор (геологийн орчны хэсэг)
гидрогеологийн хагас изолятор	**hydraulic semi-insulator**	пьезометрийн тухайн нөхцөлд заалгагдаж байгаа зэргэлдээх коллекторт газар доорх ус нэлээд их хэмжээгээр дамжин урсдаг чулуулгийн орчин дахь өвөрмөц байршилтай гидрогеологийн изолятор
гидродинамикийн туршилт	**hydrodynamic tests**	чулуулгийн орчны гидродинамик үзүүлэлт болон бусад шинж чанарыг тогтоох зорилгоор цооног, худаг зэрэг гидрогеологийн объект дахь уст системд гидравлик аргаар үйлчилж, уг үйлчлэлийн үр дүнг шинжлэх туршилт
гидроизогипс	**hydroisohypses**	усны чөлөөт гадаргууны далайн түвшингээс дээш ижил түвшинд орших нэг зэрэг хэмжсэн цэгүүдийг холбосон шугам.
гидроизопьез	**isopiestic line**	усны түрэлттэй гадаргууны пьезометрийн ижил түвшинд орших нэг зэрэг хэмжсэн цэгүүдийг холбосон шугам.
гиподермийн урсац	**hypodermic outflow**	газрын доорх усны түвшинг хүрэлгүйгээр газрын гадаргын доорхон гол мөрний сүлжээнд цутгадаг нийт урсацын бүрэлдүүлэгч хэсэг
Дарсийн хууль	**Darcy's law**	шүүлтийн хурд **v** (буюу усны урсгалын хэмжээ **Q**), пьезометрийн (гидравлик) градиент **I**-н шугаман хамаарал
дисперси	**dispersion**	газар доорх усанд шилжилтийн судалгаа хийх үеэр урсаж буй газар доорх усанд шилжиж буй бодисын сарнилын үйл явц. Орчны анизотропын дагуу ийм үйл явц дагуу, хөндлөн, босоо - хөндлөн чиглэлд явагддагаас хамааран ялгаатай байдаг.
дисперси чанар	**dispersivity**	нүх сүвтэй орчны шингэний хөдөлгөөний үед кинематик дисперси үүсгэх чадвар; дисперси чанарын тоон үзүүлэлтийг дагуу, хөндлөн эсвэл босоо зэрэг тухайн чиглэл дэх дисперси чанарын илтгэлцүүлээр илэрхийлдэг

диффузи	**diffusion**	бөөмсийн дулааны хөдөлгөөний үр дүнд молекул эсвэл ионууд өндөр концентрацитай орчноос бага концентрацитай орчин руу өөрөө нэвчих үзэгдэл
дээж	**sample**	их хэмжээтэй материалаас сонгож авсан хэсэг [IUPAC (1990); ISO11074-2]
дээж авалт	**sampling**	холбогдох нарийвчилсан тодорхойлолтын болон журмын дагуу дээж авах. Дээж авах ажилд дээжийг зөөх, тээвэрлэх үйл ажиллагаа багтана: дээжийг зориулалтын саванд хийх, хадгалах, лабораторийн шинжилгээнд өгөхөөр тээвэрлэх, гүйцэтгэсэн үйл ажиллагааны холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэх.
дээж авах	**sampling**	тухайн ажлын зорилгод тохиромжтой дээж болон төлөөлөх дээж авахад чиглэгдсэн үйл ажиллагаа
дээж авах газар	**place of sampling**	төсөл хэрэгжих талбайн дээж авах объектын хатуу тодорхойлсон ба сольж, өөрчлөх боломжгүй байршил
дээж авах объект	**sampling object**	тодорхой цаг хугацаанд дээжээр илэрхийлэгдэх тодорхой хэмжээний материал. Дээж авах объектыг хууль тогтоомжын дагуу тодорхойлж болно (ж-нь: багцын хэмжээ)
дээж авах төлөвлөгөө	**sampling plan**	дээж авах цэгийн байршлыг тодорхойлох, дээж авах үйл ажиллагаа, хадгалах, тээвэрлэх мөн аль хэсгийг дээжид авах зэргийг тодорхойлох урьдчилсан төлөвлөгөө.
дээж авах хөтөлбөр	**sampling design**	анхны алхмаас эхлэн эцсийн алхам хүртэлх ажлын явцыг тодорхойлсон мөн хөтөлбөрийн зорилго ба ажлын үр дүнг зорилготой харьцуулсан харьцуулалт зэргийг багтаасан дээж авах үйл ажиллагааны тодорхойлолт.
дээж авах хүн, дээж авах бүлэг	**sampling technician/group**	дээж авах болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох хувь хүн эсвэл хэсэг бүлэг (хадгалах, дээжийг хуваах, бэлтгэх, лабораторийн шинжилгээнд дээжийг хүргүүлэх, баримт бүрдүүлэх)

дээж авах цэг	**sampling spot**	орон зай болон цаг хугацааны координатаар тодорхойлогдсон солигдох боломжгүй дээж авсан цэг. дээж авах цэгийн тухай ойлголтонд туршилтын цооног, усны гадаргуу дахь цэг зэрэг багтана. дээж авсан цэг хэмээх ойлголтонд дээж авсан цэгийн гүний болон гадаргын тодорхой байршлын талаархи мэдээлэл, усан сангийн усны гадаргуу дахь цэг, дээж авах цэг: дээж авсан цэгийн гадаргуу дахь ба гүний байршлыг нарийн тодорхойлох, 1 газрын хувьд хэд хэдэн цэгээс дээж авч болно
дээжийн хэмжээ	**sample size**	дээжийг бүрдүүлэх материал болон бүрэлдэхүүн хэсэг, нэгжийн тоо
зай завсрын ус нэвтрүүлэх чанар	**interstitial permeability**	гидравлик градиентын үйлчлэлээр шингэн урсахыг боломжтой болгож буй хоорондоо холбосон зай завсраас үүдэлтэй уул чулуулгийн ус нэвтрүүлэх чанар
зонд	**probe**	гар багаж хэрэгслийн тусламжтайгаар усаар ханаагүй эсвэл ханасан бүсэд ухаж гаргасан объект (өрөмдсөн, цохиж суурилуулсан, ухсан зонд)
идэглэл, элэгдлийн суурь	**erosion base**	байнгын ус өгөмжийн өргөн хүрээ бүхий тодорхой нэгэн бүсийн усгүйжүүлэх түвшин болох ус урсгуурын хамгийн гүн хөндийн ёроол
ижил төрлийн (гомоген) байдал	**homogeneity**	ижил төрлийн материалаас бүрдсэн орчин (жишээ нь, чулуулгийн орчны эсвэл коллекторын гомоген байдал)
ижил төрлийн бус (гомоген бус) чулуулгийн орчин	**inhomogeneous geological environment**	судлагдаж буй талбайн чулуулгийн орчны бүрэлдүүлэгч хэсгийн эрс ялгаатай байдлын улмаас газар доорх усны ноцтой өөрчлөлт болон/эсвэл бохирдуулагч болон бусад хортой бодисын үйлчлэлд ноцтой нөлөөлөл гарж байна
илэрц	**out-flowing**	газрын доорх ус газрын гадаргууд ил гарч ирэх үзэгдэл эсвэл үйл явц
интерполяци	**interpolation**	хэмжилт хийсэн хоёр болон түүнээс илүү цэгийн хооронд утга гаргах аргаар бохирдлын хавтгай болон орон зайн байршлыг тодорхойлох үед үр дүнг тайлах

исэлдэн – ангижрах чадвар	**oxidation - reduction potential Eh**	вольт эсвэл миливольтоор илэрхийлсэн байгалийн ус эсвэл орчны исэлдэн-ангижрах төлөв байдлын тоон үзүүлэлт; нэмэх эсвэл хасах утгатай байж болно; элементын исэлдсэн болон ангижирсан хэлбэрүүдийн концентраци, уусмалын температур, тодорхой хэмжээгээр мөн pH-с хамаарч байдаг
капилляр ус	**capillary fringe**	капилярын хүчний үйлчлэлийн дор уулын чулуулагт орших даралт нь агаарын даралтаас бага байдаг хөдөлгөөнгүй ус
концепцийн загвар	**conceptual model**	математик загварыг зохиох үндэс болох физик, химийн процесс, гидрогеологийн тогтоцыг тодорхойлох, үзүүлэлтүүдийг тогтоохтой холбоотой чухал мэдээлэл (жишээ нь, газар доорх усны урсац эсвэл бохирдлын байршил, тархалттай холбоотой), хүлээн зөвшөөрөгдсөн хялбаршуулсан шалгуур зэргийг багтаасан багц
лабораторийн дээж	**laboratory sample**	лабораторид тушаах эсвэл лаборатори хүлээн авсан дээж эсвэл тасалж авсан дээж
ламинар урсгал	**laminar flowing**	шингэний бөөмийн траектори бараг зэрэгцээ байдаг урсгал; газар доорх ус бага хурдтай ингэж урсдаг бол илүү хурдтай урсах тохиолдолд урсгалын ламинар чанарыг эвдэж урсгал турбулент чанартай болж өөрчлөгддөг.
материал	**matrice**	бүх дээжийн матриц: ус, хөрс, хог хаягдал, хийн бүрэлдэхүүн хэсэг
мониторинг, хяналт	**monitoring**	тодорхой ямар нэг тогтолцооны зарим үзүүлэлтүүд, ажиллагаа эсвэл өөрчлөлтийг тасралтгүй эсвэл тогтмол давтан хянах ажиллагаа
мөрдөлтийн туршилт	**tracer tests**	гидравлик харилцаа, газар доорх хөдөлгөөний хурд байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийдэг туршилт; цооног эсвэл өөр объектод гэрэлтүүлэгч (мөрдөлтийн) бодис хийж урсгалын хүлээгдэж буй чиглэлд орших ажиглалтын объектод гэрэлтүүлэгч бодис байгаа эсэхээс гадна цаг хугацаанд түүний концентрацийн өөрчлөлтийг хянадаг
REG_ConSite-д анхан шатны баталгаажуулах процессд тэмдэглэлийн чанарыг баталгаажуулагч. Уг үүрэг нь жишээлбэл байгаль орчны байцаагчид тохиромжтой. Мөн өгөгдлүүдэд илүү өргөнөөр боловсруулалт хийдэг байгууллагын хариуцлагатай төлөөлөгчид байж болох юм. Баталгаажуулагч газарт баримт бичиг нөхөж хийх боломжтой. Газрын өгөгдлүүдийг өөр яаж ч өөрчлөх боломжгүй. Тэмдэглэлийг баталгаажуулсан болон баталгаажуулаагүй үед сонирхогч талд и-мейл автоматаар илгээгдэнэ. Ийм мэдээний текстэд нэмэлт хийж болно.

Дээж (sample)

Дээж гэдэг нь CSIS-д баримтжуулалтын цэгээр бүртгэгдсэн объектод ажиглагдсан, хэмжигдсэн эсхүл ажиглагдаж буй хэсэг юм. Дээжийг үргэлж газар нутаг дээр орших баримтжуулалтын цэгээс авсан байвал зохино. Дээж тус бүрт огноо, шаардлагатай бол дээж авсан цагийг дурдсан байна. Дээжийн бусад хэмжих/ажиглагдах утгууд хэрэглэгчийн шаардлагаас хамаарна.

Сонирхсон газар нутаг

CSIS-д бохирдсон байж болох газрын, эсвэл REG_ConSite-д бохирдсон газрын талбайг хязгаарлагч олон өнцөгт/полигон байна. Полигон нь дурын бөгөөд нэмэлт мэдээлэл өгч - газрын зураг дээрх байршлын цэгэн тэмдэглэгээг дэлгэрэнгүй болгоно. Газрын талбайн ийм хязгаарлалтыг судалгаа хийгдэж буй газар нутгийн захаар, ж.нь:

үйлдвэрлэлийн бүсийн хашааг дагуулан хийх нь тохиромжтой. Тодорхой бус хязгаартай газар нутгийн хувьд полигоныг бохирдлын хүрээнд дөхөм хязгаарлалт хийхэд ашиглаж болно. Сонирхсон газар нутгийн полигон судлагдаж буй хэсгийг бүхэлд нь хамрах албагүй. Ж.нь: үйлдвэрийн хашаа судлагдаж буй районыг хязгаарлах боловч бохирдол ба түүний тархалтыг ажиглаж буй баримтжуулалтын цэгүүд (ж.нь: цооногууд) уг хил хязгаараас хамаагүй хол оршиж байна. Энэхүү хязгаарлалт нь аж ахуйн бүс ба аж үйлдвэрийн район, хогийн цэг ба түүний ойр тойрон, ил уурхай ба түүнийг дагалдах овоолго зэргийн хилийг хязгаарлахад үр дүнтэй.

Дараагийн өөр талбайг хязгаарлах эсвэл сонирхсон газар нутгийг илүү дэлгэрэнгүй зураглах шаардлагатай байвал газар дээр өөр полигонуудыг тэдгээрийн тайлбарын хамт зурах боломжтой Сектор хэсгийг ашиглана уу

Газрын тэмдэглэл

Газрын тэмдэглэл гэдэг нь CSIS мэдээллийн сан дахь харилцан адилгүй тархацтай, тэмдэглэл үүсгэгчийн болон хэсэг тус бүртээ тэмдэглэлийн хамгийн сүүлийн боловсруулагчид болох аннотаторуудын баталгаажуулсан өгөгдлүүдийн багц юм. Газрын тэмдэглэгээ бол анхдагч мэдээлэл, бохирдсон ба бохирдсон байж болох, мөн зөвшөөрөгдсөн газруудын өгөгдлийн багцад зориулагдсан ерөнхий ойлголт. Анхдагч мэдээллүүдэд газрын тэмдэглэл зөвхөн өгөгдлүүд ба байршлуудын гарал үүслийг агуулдаг боловч өөр нэмэлт тайлбар ба фото баримтжуулалтыг хамруулж болно. Бохирдсон ба бохирдсон байж болох газруудын байршилд газрын тэмдэглэл нь үргэлж үндсэн тайлбартай байна. Өөр олон мэдээлэл, хавсралт материал, холбоо барих мэдээлэл, шинжилгээний баримт гэх зэргийг агуулж болно. Газрын зөвшөөрөгдсөн тэмдэглэл, үргэлж ач холбогдлын зэрэглэлийн дүгнэлтийг агуулна. CSIS-д газрын тэмдэглэлийг холбогдох доод шатны хүснэгтүүдийн тэмдэглэлүүдийн хамт, харгалзах бүртгэлийн дээд шатны хүснэгтүүдийн тэмдэглэл хэмээн ойлгодог.

Тэмдэглэл (өгөгдлийн)

Өгөгдлийн тэмдэглэл гэж уг материалд өгөгдлийн хүснэгтийн мөрийг хэлнэ (record).

5. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭСЭГ - ТОЙМ

CSIS Төв мэдээллийн систем нь хэрэглэгчдийн зүгээс хоёр хэсэгтэй:

- анхдагч мэдээллийн бүртгэл - REG_ID

- бохирдсон байж болох ба бохирдсон газруудын бүртгэл - REG_ConSite



5.1. Анхдагч мэдээллийн бүртгэл 

Анхдагч мэдээллийн бүртгэл нь байж болох бохирдол, бохирдсон газрууд болон бохирдсон байж болох газруудын цэгээр тэмдэглэгдсэн дохионуудад зориулагдсан, цорын ганц мэдээллийн ороолт юм. Энэ мэдээллийн санд алсдаа хоёр бүртгэлийн аль алинд ч ангилагдаж болох газар нутгууд орно. Баримтжуулалтанд анхдагч мэдээллийн бүртгэлийг бид REG_ID гэж товчилдог.

Энэ нь мэдээллийн санд байж болох бохирдлын зүйлсэд судлагдаж буй бүх газруудын тухай товчхон бүртгэл юм. Сэжиг бүхий газар болон мэдэгдэж байгаа бохирдсон газар бүр мэдээллийн санд анхдагч мэдээлэл хэлбэрээр нэвтэрнэ. Бүр энгийн мэдээлэл эсвэл буруу ташаа мэдэгдэл, шалгаж үзэх шаардлагатай, нотлогдохуйц бохирдсон газрууд эсхүл мэргэжилтнүүдийн үзэж буйгаар бохирдолтой газрууд, Дэлхий алсын судалгааны цэгүүд байж болох юм.

Анхдагч мэдээллийн бүртгэлд мэдэгдэж буй аль ч, одоог хүртэл шийдвэрлэгдээгүй тохиолдлууд, цаашлаад судалгааны эхний үе шатанд байгаа, бас аль хэдийн шийдвэрлэгдсэн тохиолдлууд байна. Шийдвэрлэгдсэн тохиолдлууд нь хоёр төрөл байж болно:

⇒ холбогдолгүй хэмээн үл хэрэгссэн анхдагч мэдээлэл

⇒ бохирдсон байж болох эсвэл бохирдсон газар хэмээн цаашид үргэлжлүүлэн шийдвэрлэгдсэн анхдагч мэдээлэл.

Холбогдолгүй хэмээн үл хэрэгссэн анхдагч мэдээллийг бохирдсон байж болох зүйлсэд шинжлэгдсэн газруудыг тодорхой байлгаж, ажил давхардуулах болон зурагжуулах үйл явцыг үр ашиггүй давтахгүйн тулд бүртгэлд бүртгэгдсэн хэвээр үлдээх юм. Үүний зэрэгцээ ийм бүртгэл газар нутгийн хяналт болон түүнд дахин үнэлгээ хийх боломжийг олгодог.

Бохирдсон байж болох эсвэл бохирдсон газар хэмээн шийдвэрлэгдсэн анхдагч мэдээллүүдийг дахин засварлах боломжийг хаасан байдаг бөгөөд тэдгээрийн шийдлийг цаашид REG_ConSite бүртгэлд гүйцэтгэнэ. Энд анхдагч мэдээллийн тэмдэглэл "зөвхөн унших" (RO) байдалд үлдэх ба анхдагч мэдээллийн тэмдэглэлээс REG_ConSite-д шинээр үүссэн бохирдолтой газрын идентификатор нөхөгддөг. Анхдагч мэдээлэлд сүүлчийн үнэлгээ тогтоогчийн тодорхойлолт, бас яаралтай байдлын зэрэглэл, өмнө нь хэрхэн шийдвэрлэгдэж байсан зэргийг хадгалж үлднэ.

Анхдагч мэдээллийн тэмдэглэл гурван аргаар үүсч болно:

а) www.eic.mn/csis портал дээр олон нийтэд мэдээлэх

б) бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд зориулсан программын тусламжтайгаар тэмдэглэл оруулах

в) Дэлхий алсын судалгааны мэргэжлийн дүгнэлтээс олж авсан өгөгдлүүдийг уншуулах гэх мэт аргуудаар.

Бүртгэлийн албаар дамжуулан www.eic.mn/csis нүүр хуудсан дээр оруулсан анхдагч мэдээллийн тэмдэглэл үүсэх үедээ "одоог хүртэл шийдэгдээгүй анхдагч мэдээлэл" гэж тэмдэглэгдсэн байх ба энэ нь CSIS-ийн итгэмжлэгдсэн мэргэжилтэн тэмдэглэл дээр

ажиллаж эхлэх хүртэл хэвээр байх юм. Тэмдэглэл оруулагч нь анхдагч мэдээллийг мэдэгдэхдээ үргэлж ямар нэгэн гарчиг, цаашлаад газар нутгийн нэр, товчхон тодорхойлолт болон эрсдэлийн тайлбар – яагаад бохирдсон газар хэмээн үзэж байгаа шалтгаан буюу яагаад уг газрыг мэдэгдэж байгаа тухай нөхөж бичих ёстой.

Тэмдэглэгдсэн байршлын дагуу систем автоматаар харгалзах сум болон аймгийг нөхнө. Удирдлага, ийм тэмдэглэлийг зохих мэргэжлийн байгууллагад эсвэл харгалзах засаг захиргаанд дамжуулан өгнө. CSIS-ийн мэргэжилтнүүдэд зориулагдсан засварлах программаар дамжуулан авсан анхдагч мэдээллийн тэмдэглэл үүсэхдээ "нарийвчлан боловсруулсан" гэсэн тэмдэгтэй байх буюу тэмдэглэлийн боловсруулалтын чанарыг хариуцагчийн гарт байна. Бусад талбарууд нь олж авсан мэдээллийн дагуу үе шаттайгаар нөхөгднө. Мэргэжилтэн тэмдэглэлийн доор гарын үсэг зурсан байх ба түүний боловсруулалтанд хариуцлага хүлээнэ.

Мэдээллийн системд багцаар уншуулсан анхдагч мэдээллийн тэмдэглэл үргэлж "одоог хүртэл дүгнэлт хийгдээгүй анхдагч мэдээлэл" гэж тэмдэглэгднэ. X,Y солбилцлуудын дагуу (газар зүйн уртраг ба өргөрөг) газар нутгийн харьяа сум ба аймгийн мэдээллүүд автоматаар нөхөгдөх юм. Уг тохиолдолд өөр бусад талбаруудыг бөглөх хэрэггүй. Удирдлагын зүгээс тэмдэглэлийг харгалзах мэргэжлийн байгууллагад эсхүл газарт боловсруулахаар олгох бөгөөд тэмдэглэлийг цаашид б) зүйлийн дагуу боловсруулна.

Шинээр үүссэн анхдагч мэдээлэл бүрт үндсэн тодорхойлолт ба тайлбар, шаардлагатай бол тэмдэглэлд энгийн фото баримтжуулалтыг нөхөж хийнэ. Уг бүртгэлд шинэ анхдагч мэдээлэл оруулахыг CSIS-ийн бүртгэлтэй аль ч хэрэглэгчид зөвшөөрнө. Энэхүү бүртгэлийг унших эсэх нь хэрэглэгч тус бүрийн эрхээс шалтгаална. Public хэрэглэгч буюу олон нийт мэдэгдсэн бүх газруудын жагсаалтыг тэдгээрийг шинжилж эхлэх хүртэл харах боломжтой. Мөн өөрийн мэдээллийн дагуу хэн нэгэн ажиллаж эхэлсэн хугацааг шалгах боломжтой.

REG_ID дэх газруудын өгөгдлийн тэмдгүүдийн жагсаалт:

- ⇒ одоог хүртэл дүгнэлт хийгдээгүй анхдагч мэдээлэл
- ⇒ боловсруулагдаж байгаа
- ⇒ зураглал шаардлагатай
- ⇒ REG_ConSite-д бүртгэгдсэн
- ⇒ хасагдсан анхдагч мэдээлэл

Хэрэгслүүдийн тайлбар ба удирдлагыг “CSIS хэрэглэгчийн интерфейс” сэдвийг үзнэ үү.

5.2. Бохирдсон ба бохирдсон байж болох газруудын бүртгэл



Энэ нь тэмдэглэл үүсэх үед бохирдол баталгаажсан эсвэл мэргэжилтний гаргасан шийдвэр, түүний газар нутгийн эсвэл холбогдох баримтжуулалтын мэдлэг дээр тулгуурлан үндэслэлтэйгээр сэжиглэгдсэн газруудын бүртгэл юм. Газар нутгууд энд өөрийн амьдралын мөчлөгийн туршид буюу REG_ID-ээс бүртгэгдсэн тэмдэглэл үүссэнээс хойш, шаардлагатай зураглал, судалгаа, засан сэлбэх арга хэмжээнээс эхлээд

засан сэлбэх арга хэмжээ дуусах болон дүгнэлт хийгдэж эрсдэлгүй газар болох хүртэл бүртгэгдсэн байна. Гэхдээ эрсдэлгүй газруудын хэсэг чанга горимд ажиглагдаж болно (“Ач холбогдлын үнэлгээ” сэдвийг үзнэ үү), өөрөөр хэлбэл мэдрэг шинж багатай тухайн газар нутгийн ашиглалтад газар эрсдэлгүй байж болзошгүй. Ж.нь: үйлдвэрийн район дахь цэвэрлэгдсэн газар хүний эрүүл мэнд эсхүл хүрээлэн байгаа орчинд хор хөнөөл учруулахааргүй боловч ихээхэн хэмжээний бохирдлын үлдэгдэлтэй байж болно. Газар нутгийн ашиглалтын өөрчлөлтөд, ж.нь: хүүхдийн тоглоомын талбай эсвэл цэцэрлэгтэй хувийн орон сууцнууд эсхүл хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлд эсхүл ахуйн хэрэглээнд зориулсан газар доорх усны шахуурга зэргийн тохиолдлуудад тухайн газар дахин эрсдэлтэй байж болох юм. Ийм учраас эдгээр газруудын байнгын бүртгэл шаардлагатай.

Энэ бүртгэл баримтжуулалтанд REG_ConSite хэмээн тэмдэглэгддэг. Уг бүртгэл дэх тэмдэглэл анхдагч мэдээллүүдийнхтэй харьцуулахад үргэлж төгс бичигдсэн байх ёстой. Бүртгэлд хангалтгүй бичигдсэн тэмдэглэл оруулахыг зөвшөөрөхгүй. Энэ нөхцөл, REG_ConSite руу оруулах тэмдэглэл зөвхөн хангалттай бөглөгдсөн анхдагч мэдээллийн тэмдэглэлийн хуулбараар үүсэх хэлбэрээр бүрдсэн. Хэрэв анхдагч мэдээлэл боловсруулагч бохирдсон газар байж болзошгүйг олж илрүүлвэл анхдагч мэдээллийн тэмдэглэлийн бүх талбарыг бөглөх бөгөөд тэмдэглэлийг REG_ConSite руу шилжүүлэхээр тэмдэглэнэ. Хэрэв бүх талбарууд бөглөгдсөн, анхдагч мэдээллийн тэмдэглэл зөвхөн уншихаар тэмдэглэгдсэн байвал түүнийг цаашид боловсруулах боломжгүй. Анхдагч мэдээлэл REG_ConSite руу хавсралт фото баримтууд эсхүл зургуудын хамт хуулбарлагдана. Энд цаашид бохирдсон эсвэл бохирдсон байж болох газар хэмээн боловсруулна. REG_ConSite дэх тэмдэглэлүүдийг зөвхөн тусгайлан бэлтгэгдсэн хэрэглэгчдэд CSIS эдитороор дамжуулан өөрчлөхийг зөвшөөрнө.

Хэрэгслүүдийн тайлбар ба удирдлагыг “CSIS хэрэглэгчийн интерфейс” сэдвээс үзнэ үү.

REG_ConSite-д газар тус бүр дараах хэсгүүдтэй байна:

Газрын паспорт (Site Passport) 

REG_ConSite дэх газрын тэмдэглэлийн цорын ганц заавал байвал зохих хэсэг. Үүнд газрын тухай үндсэн мэдээлэл, түүний дараагийн, бохирдлын төрөл ба түвшинтэй холбогдуулан авагдах шаардлагатай арга хэмжээний тухай (газрыг цаашид хэрхэх) мэдээллийг нэмсэн, шийдвэрлэлтийн ач холбогдол, судлагдсан түвшин, засан сэлбэх арга хэмжээний байдал, шилжилтийн нөхцлүүд, газрын ашиглалт, хор хөнөөл гэх мэт байна. Газрын паспорт дахь мэдээллүүд ач холбогдлыг дүгнэхэд ашиглагдна. Мөн өгөгдсөн өгөгдлүүдээс автоматаар дүгнэлт үүсдэг ач холбогдлын дүгнэлтэд зориулагдсан маягт нь паспортын нэг хэсэг болно. Дүгнэлтийг үргэлж одоогийн нөхцөл байдлыг тайлбарласан үндэслэлтэй буюу нөхцөл байдлын тодорхойлолттой хавсаргана (situation proposition). Энэхүү нөхцөл байдлын тодорхойлолт ба өгөгдлүүдийн дүгнэлтээс газар нутагт шаардлагатай дараагийн үйл ажиллагаа үүснэ. Хамгийн чухал мэдээллүүдийн нэг болох уг үйл ажиллагаа, газрын паспортын толгой хэсэгт ач холбогдлын зэрэглэлийн кодын хажууд, газрын нэрний доор дурдагдсан байна

Газар нутгийн хувьд идэвхтэй газар нутаг мөн эсэх, өөрөөр хэлбэл үйлчилгээ үргэлжилж байгаа эсэх эсвэл үйлчилгээ дууссан идэвхгүй эсэхийг дурдсан байна.

Газрын паспорт хэд хэдэн бүлэгт хуваарилагдна:

⇒ анхдагч мэдээллийн эх үүсвэрийнхтэй төстэй ихэнх мэдээллүүдийг агуулсан газрын тухай гол мэдээллүүд, зорилгын тухай гол мэдээлэл, шаардлагатай бол санаачлагдсан засан сэлбэх арга хэмжээ, тайлбар болон эдгээр арга хэмжээнүүдийн байдлыг санхүүгийн эх үүсвэрийн боломж бололцооны хамт нөхнө.

⇒ гадаргын ус, газар доорх ус болон хатуу матрицуудад зориулагдан хуваагдсан бохирдлын тухай ерөнхий мэдээлэл (хөрс, чулуулгууд, барилгын материалууд). Энэ хэсэгт мөн бохирдсон талбайн тархалтын ангилал дурдагдана.

⇒ бохирдлын шилжих боломж сав газрын нэр (basin), гадаргын усны хамгийн ойрын биетэд хүрэх зай ба шилжих нөхцлүүдийн бусад шинж чанар зэргийг агуулна.

⇒ газрын ашиглалт ба ашиглагдаж буй газрын мэдрэг чанар, мөн энд оршин суудаг, газар доорх болон гадаргын усны эх үүсвэрийг ашигладаг иргэдийн тоог харгалзан үзсэн түүний ойр орчим, хамгаалалттай газар нутаг гэх зэрэг.

⇒ шаардлагатай бол урьд өмнө тухайн газарт гарсан осол аваар ба аюулт бодисын алдагдлын тухай тайлбар агуулсан эрсдэл ба ач холбогдлын үнэлгээ, болзошгүй эрсдэл, дараагийн арга хэмжээний шаардлагын үүднээс одоогийн нөхцөл байдлыг тодорхойлсон тодорхойлолт, санаачлагдсан дараагийн алхам ба ач холбогдлын ангиллын үндэслэл. Энэ хэсэгт засварлах программд ач холбогдлыг үнэлэх үйлдэл байрлана.

REG_ConSite-д бас **сонирхсон байршлын газар нутгийн** хязгаарлагч полигоныг тодорхойлох боломжтой. Уг хязгаарлалт нь аж ахуйн бүс болон аж үйлдвэрийн район, хогийн цэг ба түүний ойр орчим, ил уурхай ба түүнийг дагалдах овоолго зэргийн хилийг хязгаарлахад үр ашигтай.

Секторууд

Секторууд нь REG_ConSite-д газрын талбайн хязгаарлагдсан хэсгүүд юм. Сектор тус бүр үргэлж газрын тодорхой хэсгийг хязгаарлагч полигоноор тодорхойлогддог. Газар нутаг дээрх мэдээллийг нь ижил бүлэгт ажиглахад тохиромжтой, аль ч нэгж байж болно (Ж.нь: урсацын шугам, бохирдлын төв, нөхөн сэргээсэн талбай, халдваргүйжүүлэх талбай, овоолгоны ойр орчим, овоолгоны биет, овоолго, уурхайн хонгил г.м). Сектор нь байршлын сонирхож буй газар нутгийг давж эсхүл бүр байршлын сонирхож буй газар нутгийг хязгаарлагч полигоноос (район) гадна оршиж болно. Сектор үргэлж тохиромжтой бөгөөд зохицсон нэрээр нэрлэгдэх бөгөөд тайлбар тодорхойлолтыг агуулна. Секторт баримтжуулалтын цэгүүдийг төдийгүй түүний хүрээнээс гадуур орших цэгүүдийг ч хуваарилж болно. Бохирдлын үүлийг тодорхойлогч сектор ч байж болно. Энэ үүлэнд түүний хүрээнээс гадуур уг үүлийг хүрээлэх баримтжуулалтын цэгүүд хамаарагдаж болно (хязгаараас доогуур утгуудтай).

Холбогдох баримтууд 

REG_ConSite-д байршил тус бүрт холбогдох баримтуудыг холбож болно. Баримтууд "номын сан" гэх мэдээллийн сангийн хэсэгт хадгалагддаг. Энэхүү бүтцийн хэлбэр нь баримт тухайн мэдээллийн санд зөвхөн нэг хувь хадгалагдахын зэрэгцээ олон газруудад холбогдох нөхцлийг бүрдүүлдэг. Үүний нэг жишээ нь: олон газруудыг судалсан эрсдэлийн судалгаа байж болно. Хэрэглэгч баримтыг номын санд хайх ба газрын байршил дээр шилжинэ. "Холбогдох баримтууд" хэсэгт номын сангаас зөвхөн тухайн газартай холбоотой баримтууд гарч ирнэ. Хэрэв баримт номын санд байхгүй байвал харъяалагдах эрх бүхий хэрэглэгч баримтыг номын санд нэмж болно. Дурдсан баримтын товчхон аннотацийг үргэлж бөглөнө. Баримтад PDF форматтай хавсралт хавсаргаж болно.

Холбогдох хаягууд 

REG_ConSite-д газар тус бүрт холбогдох хаягуудыг холбож болно. Эдгээр хаягууд нь мэдээллийн сангийн "Лавлах" гэсэн хэсэгт хадгалагдана. Энэхүү бүтцийн хэлбэр нь баримт тухайн мэдээллийн санд зөвхөн нэг удаа хадгалагдахын зэрэгцээ олон газруудад холбогдох нөхцлийг бүрдүүлдэг. Газар тус бүрт өөр функц (үйлдэл) биелүүлж болно. Үүний нэг жишээ нь: нэг газарт объектын эзэмшигчийн үүрэгтэй, нөгөө газарт судалгааны боловсруулагч, бас нэг газарт засан сэргээх арга хэмжээний хянагчийн үүрэг бүхий байгууллага байж болно. Хэрэглэгч холбоо барих хаягийг лавлах хэсэгт хайна. Хэрэв лавлахад хаяг байхгүй бол шинийг үүсгэж болно. Уг хаягууд дараа нь газар нутагт холбогдох ба энд хаяг илрэх эсхүл илэрсэн үүргийг нөхнө. Газар нутаг дахь уг үүргийн цаг хугацааны хязгаарлалтад зориулагдсан шаардлагатай талбарууд мэдээллийн санд бий.

Холбогдох зургууд 

Анхдагч мэдээллийнхтэй адилаар, REG_ConSite дахь газрын байршилд фото баримтжуулалт болон бохирдлын хөгжлийн график, изо шугамын зураг гэх мэт тохирох үзүүлэнгийн зурган хавсралтуудыг нэмэх боломжтой. Зурган хавсралтууд хадгалагдсан бүртгэлийн хүснэгт нь хоёр бүртгэлийн аль алинд зориулагдсан. Зурган хавсралт хадгалах үед төгс зураг хадгалах хэрэгцээ бус , нөхцөл байдлыг дүрслэх нь гол зорилго гэдгийг анхаарвал зохино. Том хэмжээний зурган хавсралтууд нь мэдээллийн сангийн ажлыг үр ашиггүй удаашруулна. Ийм учраас ойролцоогоор дэлгэцийн хамгийн дээд утга хүртэлх нягтаршилтай зургуудыг холбохын зөвлөж байна (хамгийн ихдээ ойролцоогоор 2MB хэмжээтэй). Ерөнхийдөө зургийн хэмжээ 1024x768 -аас 1600 x 900 пиксель байхад хангалттай. Фото баримтуудыг PNG эсвэл JPG форматтайгаар хадгалах нь тохиромжтой. График эсхүл газрын зургийн төрлийн тод өнгийн хязгаарлалттай зурган хавсралтуудыг GIF эсвэл PNG форматтайгаар хадгалах нь тохиромжтой. Учир нь: зураг боловсруулах маш олон төрлийн программууд байдаг, JPG болон бусад формат тус бүр өөр хоорондоо ялгаатай. Нийцтэй байдлыг хангах зорилгоор зургийг мэдээллийн санд уншуулахаас өмнө Windows үйлдлийн системийн стандарт программ болох "Paintbrush" (Зурах)-ын тусламжтайгаар хадгалахыг зөвлөдөг. Энэ нь ердийн

компьютерт Windows үйлдлийн системийн "Windows PhotoViewer" программаар нээгддэг стандарт форматтайгаар хадгалах боломжийг бүрдүүлдэг.

Баримтжуулалтын цэгүүд 

Мэдээллийн системийн "Баримтжуулалтын цэгүүд" хэсэг нь цооног, худаг, ухсан зондууд, ус зайлуулах объектын төрлийн ямар нэгэн ажиглалтын объектоор төлөөлөгдсөн цэгэн газрууд эсвэл хөрсний дээж авах газар г.м байж болно. Баримтжуулалтын цэг нь үргэлж өөрийн байршил болон нэрээр тодорхойлогддог. Цаашлаад төрлөөр (цооног, худаг, булан шанд, усны урсац дээр ажиглалтын цэг, өөр хэмжигдсэн/ажиглагдсан/дээжлэгдсэн газар. .), газар нутгийн хэсгүүдийн боломжит хуваарилалтаар - секторын, тайлбар оруулах боломжоор тэмдэглэгддэг. Газар нутаг дээр баримтжуулалтын цэг орших нь газар нутаг дээрх ажиглагдах утгууд ба хэмжилтийн боломжит өгөгдлийн нөхцөл болно. Хэрэв баримтжуулалтын цэг цооногийн төрлийн шугаман байгууламжийг төлөөлж байвал, цэгийн солбилцол түүний эхийг төлөөлнө. "Дээжүүд ба утгууд" гэсэн хэсэгт нэмэлт орон зайн үйл явцыг нөхөх боломжтой.

Анхаар, баримтжуулалтын цэг дээр авсан дээж болон баримтжуулалтын цэгийг андуурахаас зайлсхийх нь зүйтэй. Баримтжуулалтын цэг бүрт хязгааргүй олон дээжүүд, хэмжилт болон бусад ажиглагдах утгууд байж болно.

Ажиглагч загварууд 

Энэхүү хэсэг нь мэдээллийн сангийн динамик хэсгийн удирдлагад чухал ач холбогдолтой бөгөөд номын сангаас баримт эсхүл лавлахаас холбоо барих хаягууд хуваарилахтай төстэй аргаар, загвар гаргагчаас загваруудыг үүсгэх ба хуваарилах боломжийг олгодог.

Энэ хэсэгт REG_ConSite-д гүйцэтгэгдсэн мониторингийн төрөл болон давтамжийн тухай тэмдэглэлүүд хуваарилагдсан байна. Тэмдэглэл тус бүрт загвар гаргагчаас ажиглагч загвар хуваарилагдана. Хэрэв загвар гаргагчид тохирох загвар байхгүй бол ажиглагдах зүйлүүдийн каталогийн тусламжтайгаар шинийг үүсгэх боломжтой. Ажиглагдах зүйлүүдийн каталогийг CSIS-ийн удирдлагын талаас өргөтгөх боломжтой. Энэ динамик шинж чанар нь ерөнхийдөө ямар ч физикийн, химийн эсхүл тайлбар утгуудыг бүртгэх боломжийг бүрдүүлдэг. Газар нутаг дээр ажиглагч загваруудын хэсэгт холбогдсон загвар дараа нь "Дээжүүд ба утгууд" хэсэгт дурдсан мониторингийн төрөлд шаардлагатай утгуудыг оруулахад зориулагдсан маягтын автомат загварчлалд зориулагдна.



Мониторингийн болон холбогдох ажиглагч загварын тэмдэглэл бүр газар нутгийн аль нэг хэсэгт хуваарилагдаж болно. Тодорхой нэгэн секторт хуваарилагдаагүй байвал энэ нь ийм төрлийн мониторинг газар нутаг дээр секторуудаас хараат бус ашиглагдана гэсэн үг юм. Онолын үүднээс үзэхэд нэг ажиглагч загвар тухайн ижил байршил дээр мониторингийн олон төрлүүдэд хуваарилагдаж болно. Гэвч практик дээр ойр ойрхон ажиглалт хийхэд санхүүгийн шалтгааны улмаас цөөн тооны зүйлүүдийг ажигладаг, харин урт хугацааны туршид энэ тоо нь бусад ажиглагдах зүйлүүдээр нэмэгддэг.

Дээжүүд + утгууд 

"Дээжүүд + утгууд" хэсэгт "Ажиглагч загварууд" хэсэгт нэмэгдсэн загваруудын дагуу өөр бусад ажиглагдах утгууд хадгалагддаг. Дээжүүд ба тэдгээрийн утгууд нь зөвхөн ядаж нэг баримтжуулалтын цэг ба ядаж нэг төрлийн ажиглагч загвар оршдог газруудад өгөгдөж болно. Газар нутаг дээр оршдог баримтжуулалтын цэгүүдтэй хослон газар нутагт хуваарилагдсан, оршдог зарим ажиглагч загварууд дээр үндэслэн, тодорхойлсон зүйлүүдийн утгуудыг (физикийн эсхүл химийн хэмжигдэхүүн, тайлбар текст, хэмжилт гэх зэрэг) оруулах зориулалттай хүснэгтийн маягтыг (загвар) загварчилдаг.

Үүссэн хүснэгтийн маягтууд тэдгээрийг бүтээхэд ашиглагдсан загвараас бүрэн хамаардаг.

Хүснэгтийн мөр бүрийг газар нутаг дээрх аль нэг баримтжуулалтын цэгт хамаарах нэг дээж үүсгэнэ. Баримтжуулалтын цэг бүр хязгааргүй олон тооны дээжтэй байж болно. Баримтжуулалтын цэг бүр ажиглалтын олон загваруудтай байж болно.

Жишээ 1: Цооногт зориулан цооногийн тайлбартай загвар, геофизикийн хэмжилтийн бүртгэлд зориулан дараагийн загвар, богино хугацааны интервалд авсан органик бодисын шинжилгээний бүртгэлд зориулан бас нэг, мөн урт хугацааны интервалд авсан анорганик бодисын шинжилгээний бүртгэлд зориулан өөр нэгийг үүсгэнэ.


Жишээ 2: нуур цөөрөм ба түүний ойр орчимд амьдардаг зарим төрлийн хоёр нутагтнуудын тоог ажиглах зорилгоор нэг загвар, гидрогеологийн параметруудыг ажиглах зорилгоор дараагийн загвар, мөн бүх өгөгдлүүдийн уялдаа холбоог боломжтой байлгахын тулд ус цаг уурын мэдээллүүдийг бүртгэх зорилгоор дахин нэг загвар үүсгэнэ.

Жишээ 3: Хаягдал усны хяналтанд зориулан асгагдсан хэмжээний бүртгэл, үнэр ба өнгө, бас хийгдсэн шинжилгээний төрлүүдийн тайлбар текст бүхий цорын ганц загвар үүсгэнэ.

Батлагдсан газруud 

REG_ConSite-д чанарын шалгалтаар (буюу зөвшөөрөх үйл явц) амжилттай давж, олон нийтэд зориулан нийтлэгддэг - Validated Sites хэсэг рүү хуулбарлагдсан газруудын гол мэдээллүүд бий. Энэ нь газар нутгийн паспортод агуулагдах мэдээллүүд юм. Энэхүү хэсэг нь бас EIC-ийн бусад GIS мэдээллийн программуудад бие даасан мэдээллийн давхарга болон ашиглагддаг. Мэдээллүүд нь энэ хэсэгт газрын мэдээлэлд хамгийн сүүлийн үеийн баталгаажилт явагдах хүртэл өөрчлөлтгүйгээр үлднэ. Энэ нь баталгаажсан газрын боловсруулалтын хувьд, олон нийтэд зориулагдсан мэдээллүүд нь газрын мэдээллийн хэрэгжсэн өөрчлөлтүүд шинээр баталгаажих хүртэл, анхны зөвшөөрөгдсөн хэлбэртээ өөрчлөлтгүй хэвээр үлднэ гэсэн үг.

REG_ConSite дэх газрын мэдээллийн тэмдгүүдийн жагсаалт:



⇒ ач холбогдлын зэрэглэл ?? (одоог хүртэл үнэлэгдээгүй) – ач холбогдлын зэрэглэл шаардлагатай

⇒ ач холбогдлын зэрэглэл PI – урьдчилсан судалгаа шаардлагатай

⇒ ач холбогдлын зэрэглэл DI – дэлгэрэнгүй судалгаа, эрсдэлийн шинжилгээний хамт шаардлагатай

⇒ ач холбогдлын зэрэглэл SI – нэмэлт судалгаа эсвэл мониторинг шаардлагатай

⇒ ач холбогдлын зэрэглэл RD – газар нутгийн нөхөн сэргээлт хийх нь зүйтэй

⇒ ач холбогдлын зэрэглэл RN - газар нутгийн нөхөн сэргээлт шаардлагатай, хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй

⇒ ач холбогдлын зэрэглэл CR – амжилттай нөхөн сэргээгдсэн газар – ямар ч үйл ажиллагаа шаардлагагүй

⇒ ач холбогдлын зэрэглэл AP – хүлээн зөвшөөрч болохуйц бохирдолтой газар - ямар ч үйл ажиллагаа шаардлагагүй

⇒ ач холбогдлын зэрэглэл CL – судалгааны дагуу ямар ч эсвэл ач холбогдолгүй бохирдол - ямар ч үйл ажиллагаа шаардлагагүй.


6. CSIS ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛИЙН АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

6.1. Газар нутгийн амьдралын үйл явцын ерөнхий схем

CSIS мэдээллийн санд газрын тэмдэглэл үүсэх байдлаас харахад бохирдсон газар байж болзошгүй гэсэн ямар нэгэн таамаглалын үндсэн дээр газар мэдээллийн санд орно гэж таамагладаг. Энэхүү анхны тэмдэглэлийг бид анхдагч мэдээлэл хэмээн нэрлэдэг.

Уг анхдагч мэдээллийг харин дэлгэрэнгүй шинжлэх шаардлагатай. Хэрэв бохирдсон газар биш болох нь эргэлзээгүй нотлогдсон тохиолдолд анхдагч мэдээлэл цуцлагдах юм. Гэхдээ ирээдүйд тохиож болзошгүй үр дүнгүй дахин судалгаанаас зайлсхийхийн тулд бүртгэлд үлдсэн хэвээр байна. Таамаглал баталгаажсан тохиолдолд тэмдэглэл, илүү өргөн хүрээнд судлагддаг бохирдсон ба бохирдсон байж болзошгүй газруудын бүртгэлд хуулбарлагдана. Мэдэгдэж буй мэдээллүүд болон ач холбогдлын үнэлгээг бөглөсний дараа баталгаажуулах үйл явцаар дамжина. Баталгаажуулалтын дараа газрын паспортын хүрээнд мэдээллүүд олон нийтэд зориулагдан нийтлэгдэх бөгөөд тэмдэглэл дахин боловсруулагдаж болно. Энэ үйл явц олон удаа давтагдаж болно. Газар, урьдчилсан судалгааны төлөвлөлтөөр мэдэгдэж буй өгөгдлүүдийн анхны боловсруулалтын үе шатаар дамжина. Тэмдэглэлийг баталгаажуулсны дараа

урьдчилсан судалгааны үр дүнд үндэслэн дахин боловсруулна. Ач холбогдол дахин дүгнэгдэх бөгөөд тэмдэглэл дахин баталгаажих юм. Хэрэв ач холбогдол өөр ямар ч үйл ажиллагаа шаардахгүй бол газрын тэмдэглэл шийдвэрлэгдсэн хэмээн тэмдэглэгдэнэ. Эсрэг тохиолдолд газрын дэлгэрэнгүй судалгааг төлөвлөнө. Судалгааны үр дүнгийн үндсэн дээр тэмдэглэл дахин боловсруулагдаж, ач холбогдол ба тэмдэглэл баталгаажина.



Засан сэлбэх арга хэмжээ зайлшгүй тохиолдлуудад засан сэлбэх арга хэмжээнүүдтэй холбогдох ажлууд бүртгэгдсэн байх бөгөөд харгалзах үе шат дууссаны дараа ахин ач холбогдлыг дүгнэж, тэмдэглэлийг баталгаажуулна. Мөчлөг хоёр аргаар хаагдах боломжтой – газар нутаг дээр өөр ямар ч үйл ажиллагаа шаардлагагүй эсвэл бохирдлын үлдэгдлийн өндөр хэмжээний улмаас газар нутгийн ашиглалтын зориулалтыг илүү мэдрэг (оршин суух эсхүл хөдөө аж ахуйн салбар, спортын чиглэл гэх мэт. .) болгон өөрчлөх тохиолдолд газрыг цаашид ажиглах шаардлагатай.

CSIS системд газрын дамжиж буй үйл явцыг дараах хэлбэрээр тайлбарлан бичиж болно.

1. Анхдагч мэдээлэл нэг бол олон нийтийн мэдээлсний дагуу эсвэл CSIS-ийн мэргэжлийн ажилтны тэмдэглэлээр эсвэл баталгаажуулалтанд зориулагдсан гадны өгөгдлүүдийн импортоор үүснэ.
2. Талбай дээр, шаардлагатай бол бэлэн байгаа баримтуудаас анхдагч мэдээллүүдийн тухай мэдээллийг олж илрүүлэх.
3. Хэрэв анхдагч мэдээлэл ач холбогдолгүй байвал түүнийг цуцлана (үйл явцын төгсгөл) эсвэл бохирдсон ба бохирдсон байж болох газруудын бүртгэлд (REG_ConSite) хуваарилах ба энд үйл явц үргэлжлэх юм.
4. REG_ConSite-д шинээр үүссэн газрын тэмдэглэлийн хувьд, ядаж газрын паспортын мэдээллийг нөхнө. Шаардлагатай бол ялангуяа ашиглагдсан баримтууд, баримтжуулалтын цэгүүд болон шинжилгээ гэх зэрэг бусад хэсгүүдийг нөхнө.
5. Ач холбогдлын үнэлгээ дүгнэлт.
6. Тэмдэглэлийн зөвшөөрөл – баталгаажуулах тухай хүсэлт.
7. Газрын баталгаажилт ба хамгийн чухал мэдээллүүдийг олон нийтэд зориулан дэлгэх.

Баталгаажсан газрын ач холбогдол ямар нэгэн үйл ажиллагаа шаардаж байгаа тохиолдолд үйл явц, уг үйл ажиллагаа хийгдэж дууссаны дараа дахин 4-р дугаараас үргэлжилнэ.

6.2. REG_ID-д газрын амьдралын үйл явц

REG_ID бүртгэлд газрыг анхдагч мэдээлэл гэж нэрлэдэг. Энд CSIS дэх газар тус бүрийн тэмдэглэлийн нийт амьдралын үйл явц эхэлдэг. Хэрэв шинээр нэвтрүүлсэн анхдагч мэдээллийг бохирдсон газар гэж үзэж болохооргүй байвал, энд газрын тэмдэглэлийн амьдралын үйл явц бас дуусна. Энд газар дараах байдлуудыг олж болно:

⇒ одоог хүртэл үнэлгээ дүгнэлт хийгдээгүй анхдагч мэдээлэл (without any evaluation)

⇒ боловсруулагдаж байгаа (in progress)

⇒ зураглал шаардлагатай (site visit necessary)

⇒ REG_ConSite-д бүртгэгдсэн (registered in the Reg_ConSite)

⇒ цуцлагдсан анхдагч мэдээлэл (the indication discarded).

Одоог хүртэл үнэлгээ дүгнэлт хийгдээгүй анхдагч мэдээлэл

бол системд бүртгэгдсэн ямар ч этгээдийн веб хэрэглээний тусламжтайгаар оруулсан газрын тэмдэглэл (Public хэрэглэгч). Олон нийтийн зүгээс бохирдсон газрын тухай мэдэгдсэн мэдээлэл юм. Одоог хүртэл үнэлгээ хийгдээгүй анхдагч мэдээлэл үүсэх хоёр дахь арга бол гадны мэдээллийн эх үүсвэрээс импортлох арга, ж.нь: Дэлхийн алсын судалгааны дүгнэлт г.м.

Боловсруулагдаж байгаа анхдагч мэдээлэл

Боловсруулагдсан анхдагч мэдээллийн тэмдэглэл, CSIS мэргэжилтний (эпитомист үүрэгтэй) оруулсан шинэ тэмдэглэлээр шууд үүсч болно. Мөн одоог хүртэл үнэлгээ хийгдээгүй анхдагч мэдээлэлд CSIS-ийн эрх бүхий хэрэглэгч нэвтэрч, тэмдэглэлийг өөрчилснөөр анхдагч мэдээлэл боловсруулагдаж байгаа анхдагч мэдээлэл болно.

Талбайн баталгаажилтанд зориулагдсан анхдагч мэдээлэл (site visit necessary)

Анхдагч мэдээллийн тэмдэглэлийн энэхүү байдлыг тэмдэглэл боловсруулагч эсвэл зураглалын ажлыг удирдагч менежер тохируулна. Анхдагч мэдээллийн байдал үргэлж ялгаатай зураглалын тэмдгээр илэрхийлэгддэг, энэ нь зураглал хийх трассыг төлөвлөх боломжийг олгодог. Хэрэв одоо байгаа байдлыг сайн мэдэж байгаа, ж.нь: баримтууд бэлэн байгаа тохиолдолд, газрын уг байдлыг тохируулах шаардлагагүй. Тийм тохиолдолд баримтжуулалтын гол мэдээллүүд анхдагч мэдээллийн тэмдэглэлд боловсруулагдаж, үйл явц доор дурдагдсан сүүлийн цэгүүдийн аль нэгээр үргэлжилнэ.

REG_ConSite-д бүртгэгдсэн

Бохирдсон газар байж болно гэсэн таамаглал батлагдсан, эсвэл бэлэн баримтуудаар бохирдол байгаа эсхүл байсан гэж нотлогдсон анхдагч мэдээллүүдэд анхдагч мэдээллийн тэмдэглэлийг бүх хэсгүүдэд нөхөх бөгөөд анхдагч мэдээллийн боловсруулалт, түүний өөр бусад боловсруулалт өөр горимд хамаарагддаг REG_ConSite бүртгэлд орох хуваарилалтаар дуусгавар болно (“REG_ConSite дахь газрын амьдралын үйл явц” сэдвийг үзнэ үү). REG_ID дахь анхдагч мэдээллийн тэмдэглэл үүгээр өндөрлөх бөгөөд түүний амьдралын үйл явц энэхүү бүртгэлд дуусна. Ингэж хуваарилагдсан тэмдэглэл REG_ID-д цаашид зөвхөн уншихаар байх ба энд түүнийг өөрчлөх боломжгүй.

Хасагдсан анхдагч мэдээлэл

Хэрэв анхдагч мэдээллийн тэмдэглэл байж болох бохирдлын үүднээс буруу ташаа газрыг (ж.нь: орон сууцны байшингийн хуучин суурь, хиймлээр овоолсон чулуун овоолго, байгалийн намагшсан газар, цэвэрхэн хуучин барилгын чулуу, хямрал эсхүл явуулгын чанартай олон нийтийн мэдээлэл) төлөөлж байгаа нь илэрвэл анхдагч

мэдээллийн амьдралын үйл явцыг хуваарилснаар түүний амьдралын үйл явц дуусна. Уг хуваарилалт анхдагч мэдээллийн эрсдэлийн тайлбар хэсэгт үргэлж үндэслэлтэйгээр тайлбарлагдсан байвал зохино. Гэхдээ ингэж хуваарилагдсан анхдагч мэдээллийн тэмдэглэлийг дараа нь шинэчлэх боломжтой.

6.3. REG_ConSite дахь газрын амьдралын үйл явц

REG_ConSite-д газрын амьдралын үйл явц энэхүү бүртгэлд REG_ID-ээс бөглөгдсөн анхдагч мэдээллийн өгөгдлүүдийн шилжилтээр газрын тэмдэглэл үүссэнээр эхэлнэ. Хэрэв анхдагч мэдээлэл зурган хавсралтууд (фото баримт) агуулсан бол эдгээр хавсралтууд ч мөн холбогдох юм. Уг бүртгэл дэх газрын амьдралын үйл явцыг хоёр аргаар харж болно. Нэг талаас бохирдсон газрыг таньж мэдэх хөгжил ба нөхөн сэргээлт, нөгөө талаас тэмдэглэл боловсруулах байдал. Практик дээр хоёуланг нь ашигладаг. Эхнийх нь газар дээрх байгаа байдлын хөгжлийг, хоёр дахь нь газрын байгаа байдлыг илэрхийлэх газрын тэмдэглэлийн хөгжлийг анхаарч үздэг. Газрын тэмдэглэлийн амьдралын үйл явц, хоёр талын үйл явц дууссаны дараа л эцэслэн дуусгавар болно. Энэ нь газар нутаг нөхөн сэргээгдсэн эсвэл түүний бохирдол эрсдэлийн зүгээс хүлээн зөвшөөрч болохуйц байгаа бөгөөд газрын тэмдэглэл нэн сүүлийн үеийн ба баталгаажсан байна гэсэн үг юм.

6.3.1. Газрын амьдралын үйл явц, таньж мэдэх ба нөхөн сэргээлтийн үүднээс

Бохирдсон газрын таньж мэдэх ба нөхөн сэргээлтийн хөгжлийн үйл явц CSIS-д ач холбогдлын зэрэглэл дэх тэмдэглэлийн хуваарилалтад харгалздаг. Газар ба түүний тэмдэглэлийн дамждаг үе шатуудыг дараах маягаар тоймчилвол:

1. Бэлэн өгөгдлүүдийг боловсруулж, ач холбогдлын үнэлгээ дүгнэлт хийх шаардлагатай, одоог хүртэл боловсруулагдаагүй өгөгдлүүд бүхий REG_ID-с шилжсэн газар. Шаардлагатай үйл ажиллагаа: ач холбогдлыг үнэлэхн дүгнэх. ач холбогдлын зэрэглэл ??. Тэмдэглэл үргэлж 2 дугаарт шилжинэ.

2. Бэлэн боловсруулсан өгөгдлүүдтэй газар боловч бохирдлын тухай мэдээлэл батлагдаагүй. Шаардлагатай үйл ажиллагаа: урьдчилсан судалгаа хийж гүйцэтгэх. Ач холбогдлын зэрэглэл PI.

3. Гүйцэтгэсэн судалгааны ажлын нөхөгдсөн үр дүн дээр үндэслэн ач холбогдол ахин хэд хэдэн боломжуудтайгаар үнэлэгдэх нь тохиромжтой. Бохирдол бага эсхүл байхгүй тохиолдолд газрын тэмдэглэл 8 (сулхан бохирдол) эсвэл 9 (бохирдол байхгүй) дүгээр үе шат руу шилжинэ. Эрсдэлт бохирдол байгаа нь батлагдсан тохиолдолд дэлгэрэнгүй судалгаа явуулах шаардлагатай. Ач холбогдлын зэрэглэл DI.

4. Хэрэв дэлгэрэнгүй судалгаагаар хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл нотлогдсон бол үйл явц 5 дугаарт шилжинэ. Хэрэв хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл илрээгүй, харин экосистемд сөрөг нөлөө үзүүлж байвал үйл явц 6 дугаарт шилжинэ. Хэрэв дэлгэрэнгүй

судалгаагаар хүлээн зөвшөөрч болохуйц бохирдол буй нь батлагдвал үйл явц 8 дугаарт шилжинэ. Хэрэв дэлгэрэнгүй судалгааны үр дүн дээр ч үндэслэн дараагийн алхмыг шийдвэрлэж болохгүй байвал газрыг үргэлжлүүлэн ажиглах шаардлагатай. Ач холбогдлын зэрэглэл SI. Энэхүү үйл ажиллагаа нь газар дээр засан сэлбэх арга хэмжээ хийгдсэн, гэвч түүний үр дүнг баталгаажуулах шаардлагатай эсвэл тухайн засан сэлбэх үйл ажиллагааны үр дүн, газрын одоо байгаа мэдрэмтгий шинжээр (ж.нь аж үйлдвэр) бага ашиглалтанд л нийцсэн болох нь илэрхий байгаа тохиолдолд бас хийгдвэл зохино. Хэрэв газрын ашиглалтыг илүү мэдрэг (ж.нь: хүүхдийн тоглоомын талбай) болгон өөрчлөх бол ач холбогдлыг дахин дүгнэх шаардлагатай. Газрын ажиглалт гэдгийг зөвхөн үлдэгдэл бохирдлын хөгжил ба шилжилтийн цаг хугацааны ажиглалт гэж ойлгох бус, мөн бас газар нутаг дээрх үйл ажиллагаа ба газрын төлөвлөлтийн өөрчлөлтөд тавигдах захиргааны хяналтыг ойлгоно.

5. Хэрэв судалгааны ажлын үр дүн ба ялангуяа эрсдэлийн шинжилгээгээр хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй болох нь тодорхой болвол засан сэлбэх арга хэмжээ хийж гүйцэтгэх нь зайлшгүй чухал. Ач холбогдлын зэрэглэл RN.

6. Хэрэв судалгааны ба эрсдэлийн шинжилгээний үр дүнгээр (хэрэгжсэн засан сэлбэх үйл ажиллагааны дэд хэсгүүдэд хийгдсэн ч болно) хүний эрүүл мэндэд хор хөнөөл учрахгүй боловч хүрээлэн байгаа орчинд сөрөгөөр нөлөөлж байгаа нь тодорхойлогдвол засан сэлбэх арга хэмжээ хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал. Ач холбогдлын зэрэглэл RD.

7. Хэрэв газар дээр нөхөн сэргээлт амжилттай хэрэгжсэн, бохирдол хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд, хүмүүс төдийгүй экосистемд ач холбогдол бүхий хор хөнөөлгүй бол газрын амьдралын үйл явц, ач холбогдлын зэрэглэлийн CR үнэлгээтэйгээр дуусгавар болно. Өөр арга хэмжээ шаардлагагүй.

8. Хэрэв дэлгэрэнгүй эсхүл нэмэлт судалгаагаар ач холбогдолгүй эрсдэл бүхий хүлээн зөвшөөрөгдөхүйц бохирдол байгаа нь нотлогдсон бол өөр арга хэмжээ шаардлагагүй, мөн газрын амьдралын үйл явц дуусгавар болно. Ач холбогдлын зэрэглэл AP.

9. Хэрэв урьдчилсан судалгаагаар ямар ч бохирдол илрээгүй эсвэл бохирдол, судалгааны ажлын үндсэн дээр ач холбогдолгүй хэмээн үнэлэгдсэн бол мөн адил газрын амьдралын үйл явц дуусгавар болно. Ач холбогдлын зэрэглэл CL.

6.3.2. Газрын амьдралын үйл явц, тэмдэглэлийн боловсруулалтын үүднээс

REG_ConSite-д газрын тэмдэглэлийн амьдралын үйл явц, боловсруулалтын байдлын үүднээс өмнөх тохиолдлынхтой төстэй эхэлнэ. Иймээс газрын тэмдэглэлийн үүсэл анхдагч мэдээллийн бүртгэлээс шилжинэ. Энэхүү үе шатны үеэр хээрийн хайгуул болон баримтжуулалтын боломжит бүхий л баримтууд олдох ба газрын шийдвэрлэлт шаардагдаж буй хүн болон байгууллагын нэрийг нөхөх бөгөөд мэдээлэл олж авсан

бүхий л эх үүсвэрүүдийн судалгааг бас нөхнө. Мэдэгдэж буй бүх өгөгдлүүдийг боловсруулсны дараа газар нутаг дээрх дараагийн алхамд шаардлагатай тэмдэглэлийг нөхөх ач холбогдол үнэлэгддэг. Ач холбогдлын үнэлгээнд хариуцлагатай шийдвэрлэгч – менежер – тэмдэглэлийг хянан шалгаж, зөвшөөрөл олгоно. Зөвшөөрлөөр тэмдэглэлийн чанарыг шалгуулахын тулд хяналтын байгууллагад эрх олгогддог. Хяналтын эхний үе шат бол тэмдэглэлийн баталгаажуулалт. Тулган баталгаажуулагч нь өгөгдөл боловсруулагч, нийлүүлэгч байгууллагын талын төдийгүй хүлээн авагч талын хэрэглэгч байж болно. Энэхүү зохицуулалт нь тухайн үйл ажиллагааны тохиролцсон зохион байгуулалтын бүдүүвчээс хамаарна. Тус тусдаа боловсруулагдсан газрууд байвал уг үүргийг байгаль орчны хяналтын байцаагч, шаардлагатай бол EIC эсхүл Байгаль орчин ногоон хөгжлийн яамны эрх бүхий ажилтан гүйцэтгэх нь үр дүнтэй. Тулган баталгаажуулагчийн үүрэгтэй ажилтан тэмдэглэлийг хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзахаас гадна мөн тэмдэглэлд баримт хавсаргах боломжтой.


Хүлээн зөвшөөрөгдөөгүй тэмдэглэлийг дахин боловсруулна. Хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэглэлд цаашид өөрчлөлт орохоос сэргийлж түгжих бөгөөд системийн удирдлагад батлуулахаар шилжүүлнэ. Сүүлийн үе шат бол тэмдэглэлийн батлагаа. Батлагдсан тэмдэглэлийн гол хэсэг, өгөгдлүүд нь олон нийтэд зориулагдан нийтлэгдэж, EIC-ийн бусад GIS программуудад ашиглагдах мэдээллийн сангийн хэсэг рүү зэрэг хуулбарлагдана. Батлагдсан тэмдэглэлд дахин боловсруулалт хийх боломжтой. Газрын тэмдэглэл, түүний амьдралын үйл явц дахь байдлын хураангуй боловсруулалтын түвшний үүднээс дараах хэлбэртэй:

1. Анхдагч мэдээллээс үүссэн ConSite шинэ тэмдэглэл.
2. Сүүлийн үеийн бус/үнэлгээ дүгнэлт хийгдээгүй ач холбогдол бүхий ConSite боловсруулагдсан тэмдэглэл.
3. Ач холбогдлын үнэлгээ дүгнэлт хийгдсэн ConSite бүрэн гүйцэт тэмдэглэл.
4. Менежерийн үүрэгтэй хэрэглэгчийн хянасан зөвшөөрөгдсөн тэмдэглэл ConSite.
5. Хүлээн авсан тэмдэглэл, өөр өөрчлөлтөөс хамгаалагдсан.
6. Батлагдсан тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулахын тулд түгжээг тайлах ба 2 дугаараас эхлэн үргэлжлэхийн зэрэгцээ мэдээллүүд, олон нийтэд зориулагдан газрын паспортын хүрээнд нийтлэгдэнэ.
7. Хэрэв тэмдэглэл, баталгаажуулах үйл явцын үеэр тэнцэхгүй гэж тэмдэглэгдсэн бол байдал хүлээн аваагүй тэмдэглэл болж өөрчлөгдөх бөгөөд 2 дугаараар үргэлжилнэ.

Газрын амьдралын үйл явц энд батлагдсан тэмдэглэл байдлаар дуусгавар болно.

7. CSIS ХЭРЭГЛЭГЧИЙН ИНТЕРФЕЙС - ПРОГРАММ БА ТҮҮНИЙ УДИРДАХ ХЭРЭГСЛҮҮД

7.1. Гол веб хуудас – олон нийтийн зориулалттай программ ба удирдлага



Тайлбар ба удирдах хэрэгслүүд – “CSIS-ийн Удирдлага” сэдвийг үзнэ үү.

7.2. CSIS Эдитор – мэргэжлийн өгөгдлүүд оруулах зориулалттай программ

7.2.1. Программ суулгах ажил


Программ суулгах багц

CSIS Эдитор нь CSIS-ийн менежерүүд ба удирдлагуудад зориулагдан мэдээллийн системийн www.eic.mn/csis хуудсан дээрх меню цэсний "Download CSIS Editor" дээр байдаг.


Эдитор нь мэдээллийн системд зөвхөн тусгайлан бэлтгэгдсэн хэрэглэгчдэд зориулагдсан бөгөөд түүний үйл ажиллагаа, авсан өгөгдлүүд болон уг программаар

гүйцэтгэсэн мэдээллийн систем дэх өөрчлөлтийг харгалзах байгууллагын менежер хариуцна.

Программ суулгах багцад үргэлж суулгах тухай заавар хавсрагдсан байна. Янз бүрийн хувилбаруудыг өөр өөр аргуудаар суулгадаг учир зааврыг сайтар уншихыг зөвлөж байна. Эхний хувилбарт Step1 ба Step2 (алхам 1 ба алхам 2) гэсэн тэмдэглэгээгээр эхэлсэн нэртэй хоёр хавтас бий.



Программ суулгах ажил



Step1 тэмдэглэгээтэй хавтасаар Postgre SQL төрлийн мэдээллийн сантай аюулгүй харилцах боломжийг бүрдүүлдэг, нийцэлгүй ODBC driver-ыг суулгана. Драйверыг ерөнхийдөө өөр зорилгоор ч ашиглах боломжтой. Ямар ч тохиргоо агуулаагүй.

Step2 тэмдэглэгээтэй хавтасаар хувийн засварлах программ суулгана. Суулгахын өмнө software ашиглах тухай лицензийн зөвшөөрлийг бататгах шаардлагатай бөгөөд энэ нь цаашид Байгаль орчин ногоон хөгжлийн яамны өмч болж үлдэнэ. Мөн хэрэглэгч, мэдээллүүд нь энэхүү яаманд харъяалагдах ба тэдгээрийн аюулгүй хадгалалт, удирдлагыг тухайн software хэрэглэгчийн харъяалагдах Environmental Information Center (EIC) хариуцах болохыг анхаарах нь зүйтэй.




Суулгах ажлыг урьдчилсан тохируулсан хавтсанд гүйцэтгэхийг зөвлөж байна. Учир нь CSIS Эдитор өөрийн ажлын мэдээллийн санг ашигладаг тул хэрэглэгч, эдитор суулгасан хавтсанд нэвтрэх бүрэн эрхтэй байх нь чухал (хавтас үүсгэх болон устгах).

Эдиторт зөвхөн CSIS системд бүртгэгдсэн хэрэглэгч нэвтрэх боломжтой бөгөөд түүнд эпитомист эсвэл менежерийн үүрэг оногдсон байна.

Харгалзах эрхийг олгох талаар CSIS (www.eic.mn/csis) порталаар дамжуулан EIC-д хандана уу.

CSIS Эдитор софтвейрыг суулгаснаар Windows үйлдлийн системийн Start цэсэнд CSIS Эдиторыг ажиллуулах CSIS хавтас үүснэ. Хэрэв эдиторыг байнга ажиллуулах бол, дэлгэцийн десктоп дээр ж.нь: хулганаар зөөж төлөөлөгч үүсгэнэ үү.

Программыг нээхийн тулд CSIS Эдитор программын төлөөлөгч дээр товшино (хоёр удаа дарж). Программыг анх удаа нээхэд мэдээллийн сангийн ажлын хэсгийн ашиглалтад бэлгэж баталгаажуулна. Хэрэв уг үйлдлийн үеэр алдаа заавал CSIS Эдитор хавтсанд бүрэн эрхийг тохируулаагүй байх магадлалтай.

Хэл тохируулах 

Программ ачаалж эхэлсний дараа болон CSIS Эдитор программдаа нэвтрэхийн өмнө харилцах хэлээ монгол, англи эсвэл чех хэлээр тохируулах боломжтой. Урьдчилан тохируулсан хэл бол англи хэл. Программ, дууссаныхаа дараа үргэлж таны хамгийн сүүлд ажиллаж байсан хэлний сонголтоор асах болно.

Нэвтрэх

Хэрэглэгч, CSIS-ийн гол веб хуудсанд бүртгэлийн үеэр оруулсан өөрийн нэрээр (логин) нэвтэрнэ. Хэрэв CSIS Эдитор программыг интернэтийн холболтгүй үеэр (офф-лайн горимд) ж.нь: хээр, талбай дээр ашиглахыг хүсвэл, программд хэрэглэгчийг таниулан баталгаажуулахын тулд нэн түрүүнд онлайн горимд нэг удаа нэвтэрнэ. Үүнээс хойш хэрэглэгч хэсгийн мэдээллийн санд хадгалагдах бөгөөд дараагийн нэвтрэлт офф-лайн горимд хийгдэх боломжтой болно.

7.2.2. Удирдах хэрэгслүүд

Программын удирдах хэрэгслүүдэд товчлуурууд, нүд (чагтлан тэмдэглэх талбар) болон ажиллагаатай гар орно. Ажиллагаатай гар ерөнхийдөө нэг удаагийн үйлдлийг хийдэг бол (ж.нь: газрын зураг дээрх байршлын дээр F7 товчлуурыг дарснаар программ тухайн газрыг томруудж харна), товч болон нүд нь ерөнхийдөө тухайн ижил товчийг дахин дарах эсвэл чагтыг арилгах хүртэл ямар нэгэн үйл явцыг эхлүүлдэг.

Программын хэсэг дэх чиг баримжаа – товчнуудыг гэрэлтүүлэх


Товчны идэвхжилтийг шар гэрэлтүүлэг илтгэнэ (“CSIS эдиторын Хүснэгтийн цонх”-ыг үзнэ үү). Бүртгэлийн самбарт шараар асах товчлуур яг одоо ашиглагдаж буй бүртгэлийг илтгэнэ. Хүснэгтүүдийн самбарт шараар асах товчлуур яг одоо нээлттэй байгаа хүснэгтийг илтгэнэ. Хэрэгслүүдийн самбарт асаж буй товчлуур яг одоо идэвхтэй байгаа хэрэгслийг илтгэнэ.



Жишээ:

Бохирдсон газруудын бүртгэлийг нээснээр уг бүртгэлийн товчлуур асна. Газрын гол хүснэгтийг хүснэгтүүдийн самбар дээр гэрэлтэж буй " Газар нутгийн паспорт" (Site passport) товчийг дарж унтраана. Хүснэгтүүдийн самбар дээрх "Секторууд" (sectors) товчлуурыг дарснаар газрын секторуудыг засах зориулалттай хүснэгт нээгдэх бөгөөд "Секторууд" товчлуур шараар асна.

Хэрэгслүүдийн самбар дээрх "одоогийн тэмдэглэлийг өөрчлөх" (modify this record / тухайн тэмдэглэлийг засварлах) товчлуур дээр дарснаар төв мэдээллийн сан дахь тэмдэглэл түгжигдэж, өгөгдлүүдийг засварлахад зориулагдсан талбарууд нээгдэнэ. Өөрчлөлтийн товчлуур шараар гэрэлтнэ. Түүнийг дахин дарснаар өөрчлөлтүүд хадгалагдаж, товчлуурын гэрэл унтарна.



"Секторууд" товчлуурыг дахин дарснаар тухайн газрын секторуудын хүснэгт хаагдана.

7.2.3. CSIS Эдиторын хэрэглэгчийн гол интерфейс


CSIS Эдитор хэрэглэгчийн гурван интерфейстэй:

а) ачаалах үеийн дэлгэц

б) маягтын цонх

в) газрын зургийн цонх - CSIS Map editor.

Аль ч бүртгэлийг нээсний дараа ачаалах үеийн дэлгэцийн удирдах хэрэгслүүд ачаалах үеийн дэлгэцэн дээр байхгүй болох боловч хүснэгтийн болон газрын зургийн цонх автоматаар нээгднэ. Системийн үйл ажиллагааг хоёр мониторын систем дээр, өөрөөр хэлбэл нэг дэлгэцэн дээр газрын зургийг нээж, харин хоёр дахь дэлгэц дээр холбогдох хүснэгтүүдийг нээж ажиллуулна.



Нэг мониторын систем дээр ажиллах үеэр систем автоматаар шаардлагатай цонхонд шилжинэ. Хэрэв хэрэглэгч цонхыг өөрөө шилжүүлэхийг хүсвэл дараах алхмуудыг хийж болно:

⇒ Windows системийн цонхонд шилжихийн тулд Alt-Tab товчлууруудыг зэрэг дарах

⇒ Windows системийн цонхны доод мөрөнд цонхыг идэвхжүүлэх

⇒ хулганаар цонхыг шууд идэвхжүүлэх.

7.2.4. CSIS Эдиторын ачаалах үеийн дэлгэц



Бүртгэлийн самбар

Ачаалах үеийн дэлгэцийн зүүн дээд буланд бүртгэлийн самбар байрлана. Түүний дээр зүүн талаас программын ажлыг дуусгах "Төгсгөл" (End) , анхдагч мэдээллүүдтэй ажиллах "Анхдагч мэдээллийн бүртгэл" (Registry of Indications) болон бохирдсон ба бохирдсон байж болох газруудтай ажиллахад зориулагдсан "Бохирдсон газрын бүртгэл" (Registry of Cont. Sites) гэсэн товчнууд байрлана. Бүртгэлийн аль нэг товчлуурыг дарснаар, хэрэв өмнө нь нээлттэй байгаагүй тохиолдолд, харгалзах хэрэгслүүдийн самбартай хүснэгтийн цонх, тухайн бүртгэл дэх газрын гол хүснэгт ба Map editor-ын газрын зургийн цонх нээгднэ. Хүснэгтийн цонхон дахь аль ч хүснэгтийг нээх үеэр Төгсгөл гэсэн товчлуур идэвхгүй байна. Хэрэв программыг дуусгахыг хүсвэл ашиглагдаж буй хүснэгтээ хаах хэрэгтэй (доор үзнэ үү).

CSIS Эдитор программыг хаах

CSIS Эдитор программыг "Төгсгөл" (End) товчлуураар хаана. Хэрэв ямар нэгэн хүснэгт нээлттэй байвал товчлуур идэвхгүй байна.

CSIS Эдитор программын ажлыг дуусгахыг хүсвэл, өгөгдлүүдийн засварлалтыг дуусгаж, бүх хүснэгтүүдийг хаагаад "Төгсгөл" товчлуур дээр дарна. Программ, төв мэдээллийн сантай холбоогоо дуусгаж, шаардлагатай бол түр дуурын хавтаснуудыг устган Map Editor-ын газрын зургийн болон хүснэгтийн цонхнуудыг хааж, Ctrl-C тусламжтайгаар ямар нэг зүйл хадгалсан санамжийн хайрцагнаас бусад хувьсагч санамжуудыг устган хаагдана.

Программ дуусах үеэр томруулах шилний хамт газрын зургийн цонхны, тохируулсан давхаргуудын ба ашиглагдсан газрын зургийн материалын сүүлийн тохируулгууд хадгалагддаг. Хэлний тохируулга болон ашиглагдсан ажлын хавтаснуудад хүрэх мөр ба хадгалагдсан хэвээр үлднэ.

Чухал анхааруулга! Программыг унтуулж эсвэл жижигрүүлэн үлдээх боломжгүй, харин түүнийг бүрэн гүйцэт унтраах шаардлагатай. Хэрэв программ ажиллагаатай байвал төв мэдээллийн сантай холбоотой хэвээр байх боловч удаан хугацааны туршид идэвхгүй байсан гэсэн шалтгаанаар серверийн зүгээс тасална. Үүний зэрэгцээ бүхий л идэвхжүүлэлт ба өөрчлөлтүүд нь программыг асаах үеэр шалгагдна. Хэрэв та мэдээллийн сангийн зарим нэг хүснэгтүүдийг засварлаж байгаа бөгөөд тухайн үед түүнийг бүрэн гүйцэт бөглөхөд хангалттай өгөгдөл мэдээлэлгүй бол өөрчлөлтүүдийг хадгалж, хүснэгтийг хаагаад программын ажлыг дуусгах нь зүйтэй. Өгөгдлүүдийг олж авсныхаа дараа ажлаа асуудалгүй үргэлжлүүлж болно. Программыг ашиглалгүйгээр асаалттай хэвээр үлдээх нь төв мэдээллийн системд үр ашиггүй ачаалал учруулж, аюулгүй байдлын эрсдэл үүсгэнэ.

Баруун талын самбар – тохируулга ба засварын самбар

Хэрэглэгчийн бүртгэлийн үеэр оруулсан нэвтрэх нэрээр (логин) нэвтрэн орсны дараа ачаалах үеийн дэлгэцний баруун талд удирдах хэрэгслүүд бүхий хэрэгслүүдийн самбар байна:



- ⇒ газрын зургийг анхны байдалд нь оруулах
- ⇒ тэмдэглэлүүдийн түгжээг тайлах
- ⇒ тэмдэглэлүүдийг устгах
- ⇒ төвөөс мэдээллийг сэргээх
- ⇒ мэдээллийн сангий засвар (хэсгийн)
- ⇒ мэдээллийн сангийн бүтэц
- ⇒ хэсгийн мэдээллийн санд холбогдох.

Газрын зургийг анхны байдалд нь оруулах (map reset)

Газрын зургийн анхны байдал газрын зургийн цонхны одоогийн тохируулгыг арилгана. CSIS Эдитор программын ажлыг бүрэн дуусгаснаар түүнийг дараа асаах үед тохируулга дахин уншигдах боломжтой байхын тулд газрын зургийн сүүлчийн тохируулга үргэлж хадгалагдаж үлднэ. Хэрэв танд тохируулга таарамжгүй байвал ж.нь: сүүлчийн тохируулгаар маш жижиг зүсэлттэй байсан ба харин танд одоо ассан даруй Монголыг бүхэлд нь харах шаардлагатай байгаа бол газрын зургийн анхны байдлыг (нийт Монгол улсын замын сүлжээ бүхий газрын зураг) гаргах алхмыг хийж гүйцэтгээрэй. Газрын зургийн анхны байдал, мөн түр зуух хадгалагдсан газрын зургийн зүсэлтийг арилгах, газрын зурагтай ажиллах ажлыг түргэсгэх үүднээс вебээс хэсэгчилэн татах боломжуудыг өгдөг. Эдгээр материалуудыг арилгаснаар ажил үл ялиг удаашрах боловч нэн сүүлийн үеийн шинэ газрын зургийн үндсэн материалаар хангагдах боломжийг олгодог. Уг сонголт, эдитортой ялангуяа газрын зурган материалын зарим нэг хэсэгт шинэчлэлт хийгдсэн байж болзошгүй маш удаан хугацааны туршид ажиллаагүй үед хэрэгтэй. Мөн бас уг сонголтыг газрын зургийн цонхны стандарт бус үйлдлүүдийн үеэр ашиглах нь тохиромжтой. Үндсэн газрын зургууд нь Windows үйлдлийн системийн CSIS хавтасны хэрэглэгчийн түр зуурын хавтас руу хадгалагддаг.

Тэмдэглэлүүдийн түгжээг тайлах

Тэмдэглэлүүдийн түгжээг тайлах үйлдэл нь мэдээллийн системийн бүх хэсэгт тухайн хэрэглэгчийн түгжсэн байсан тэмдэглэлүүдийг нэгэн зэрэг тайлдаг. Түгжээ тайлах үйлдэл бусад хэрэглэгчдийн түгжсэн тэмдэглэлүүдэд хамаарахгүй. Уг үйлдэл, өгөгдөл мэдээллүүдийг боловсруулах үеэр осол аваар тохиолдох эсвэл интернэтийн сүлжээ гэнэт тасрах үед ашигтай. Тийм тохиолдлуудад төв мэдээллийн системд өөрчлөгдсөн тэмдэглэл өгөгдөл боловсруулагчийн түлхүүрээр түгжигднэ. Өгөгдөл боловсруулагч түүнийг нэг бол тухайн тэмдэглэлд шинээр засвар эхлүүлэн дуусгах замаар эсвэл уг үйлдлээр ачаалах үеийн дэлгэцэн дээр түгжээг тайлж болно.

Хэрэв өөр хэрэглэгчийн офф-лайн горимд боловсруулсан тэмдэглэл биш гэдэг нь тодорхой, өөр хэрэглэгч тэмдэглэлийг урт хугацааны турш түгжээтэй байлгасан бол түгжээг тайлах удирдлагад хандах шаардлагатай.

Тэмдэглэлүүдийг устгах

Тэмдэглэл арилгах үйлдэл хэсгийнх дээр ажиллахаас гадна, төв мэдээллийн сан дээр ажилладаг учир үүнийг тун болгоомжтой ашиглавал зохино. Түүний ашиглалт бүрийг засварлалтын төвлөрсөн түүхэд бүртгэгддэг. Тэмдэглэлүүдийн бүрэн устгалыг зөвхөн менежерийн үүрэгтэй хэрэглэгч ашиглах эрхтэй.

CSIS Эдиторын тусламжтайгаар өгөгдлүүдийг засварлах ердийн ажлын үеэр тэмдэглэлүүдийг зөвхөн устгахаар тэмдэглэж, хогийн саванд хийх боломжтой. Уг үйлдэл тэмдэглэлүүдийг хогийн савнаас бүрэн устгах боломжийг олгодог (empty recycle bin). Тэмдэглэлүүд нь тэдгээрийн дэд тэмдэглэлүүдийн хамт төвөөс төдийгүй, хэрэглэгчийн хэсгийн дискэн дээрээс бүрэн устах юм. Жишээлбэл, баримтжуулалтын цэгийг тэмдэглэх үеэр уг цэгт холбогдох бүхий л дээжүүд болон утгууд устгагдахаар тэмдэглэгдэх юм. Баримтжуулалтын цэгийг бүрэн устгах нөхцөл нь эдгээр бүх дээжүүд болон утгуудыг устгах болно.

Чухал анхааруулга! Тэмдэглэлүүдийг устгахаар сонгох үеэр, жишээлбэл нэг газрын байршлыг устгахаар тэмдэглэснээр түүнд дагалдах бүх дэд тэмдэглэлүүд устна гэдгийг анхаарвал зохино! Өөрөөр хэлбэл, холбогдох зургууд, холбоо барих хаягууд, баримтууд, баримтжуулалтын цэгүүд, секторууд, дээжүүд мөн бүх ажиглагдсан утгууд. **Тэмдэглэлийн сонголтыг болиулсан ч дэд тэмдэглэлүүд устгагдахаар сонгогдсон хэвээр үлднэ**.

Уг сонголт (тэмдэглэлийг хогийн сав руу хаях) зөвхөн хэсгийн мэдээллийн санд хамаарна. Тэмдэглэлүүдийг устгах үйлдлийн тусламжтайгаар устгал гүйцэтгэгдэх хүртэл, төв мэдээллийн санд ямар ч өөрчлөлт илрэхгүй.

Газрыг устгахаар тэмдэглэхэд хэдийгээр холбогдох хаягууд болон баримтууд устгагдахаар тэмдэглэгддэг боловч зөвхөн эдгээр холбогдлууд л устна. Лавлахын ямар ч хаяг, номын сангийн ямар ч баримтууд устахгүй.

Хэрэв тэмдэглэлүүдийг устгах үйлдлийг офф-лайн горимд буюу интернэтийн сүлжээгүйгээр гүйцэтгэвэл тэмдэглэлүүд зөвхөн таны хэсгийн мэдээллийн сангаас устгагдах болно.

Хэрэв та тэмдэглэгээний сонголтын зөв эсэхэд эргэлзэж, тэмдэглэлүүдийг сонгон тэмдэглэхийг хүсэхгүй байвал Өгөгдлүүдийг төвөөс сэргээх үйлдлийг ашиглаарай.

Төвөөс өгөгдөл сэргээх

Төвөөс өгөгдөл сэргээх үйлдэл хэсгийн бүх өгөгдөл мэдээллийг устгах бөгөөд тэдгээрийг төв мэдээллийн сангийн өгөгдлүүдээр солино. Зөвхөн хэрэглэгчийн ядаж унших эрхтэй өгөгдөл мэдээллүүдийг л татаж авна. Үйлдлийг ашиглах үеэр хэрэглэгч газрын бүрэн өгөгдлүүдийг шинжилгээний бүх утгуудын хамт татаж авахыг хүлээх эсвэл эдгээр дэлгэрэнгүй утгуудгүйгээр зөвхөн гол мэдээллийг татаж авахаар шийдэх

боломжтой. Ажиглагдах утгууд нь ажлын үеэр харгалзах загварын ашиглалтын дагуу байнга шинэчлэгдэж байна.

Хэрэв хэрэглэгч нийт Монгол улсын утгуудад нэвтрэх эрхтэй бол эдгээр мэдээллүүд нь үргэлж нийт төв мэдээллийн сангийнх байна. Хэрэв хэсгийн эрхтэй бол өгөгдлүүд газрын байршил бүрт тус тусдаа, сонгогдсон хэмжээгээр татагдна.

Хэрэв хэрэглэгч интернэтэд холбогдоогүй бол анхааруулга гарч ирэх бөгөөд түүнийг баталснаар хэсгийн мэдээллийн сангийн бүх өгөгдөл мэдээллүүд устна.

Чухал анхааруулга! Хэрэв татаж авсан өгөгдлүүдтэйгээ хээр талбай дээр гарах гэж байгаа, эсвэл хэсгийн мэдээллийн сандаа төв мэдээллийн санд хуваарилагдаж амжаагүй талбайгаас боловсруулсан мэдээллүүдийг оруулсан бол "төвөөс өгөгдөл сэргээх" үйлдлийг бүү ашиглаарай! Бэлтгэгдсэн өгөгдөл мэдээллүүдээ алдахад хүрнэ.

Мэдээллийн сангийн засвар

Мэдээллийн сангийн засвар гэсэн үйлдэл (database maintanance) хэсгийн ажлын мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдлыг хянах зориулалттай. Түүнийг CSIS Эдитор программын стандарт бус ямар ч төгсгөлийн үед ашиглах нь тохиромжтой.

Үйлдэл мэдээллийн сан дахь холбоосуудыг шалгах (харилцаа) ба бүх хүснэгтүүдийг дахин индексжүүлнэ. Мэдээллийн сангийн динамик хэсэг дэх бүх хавтаснуудын байгаа эсэхийг баталгаажуулж, дутуу хавтаснуудын үүсгэж нөхнө. Үйлдэл нь программыг анх эхлүүлэх үеэр автоматаар ажиллаж эхлэх бөгөөд мэдээллийн сангийн динамик хэсэгт орох өөрчлөлийн үеэр үргэлж ажиллана.

Хэрэв мэдээллийн сангийн динамик хэсэгт гэнэтийн доголдол тохиолдвол ж.нь: өгөгдлүүдийг засварлах үеэр интернэтийн холболт тогторгүй болж тасалдсанаар мэдээллийн сангийн динамик хэсэг дэх хүснэгтүүд гэмтэх үед:

1. CSIS Эдитор программыг хаана
2. Мэдээллийн сангийн DB_CSIS хавтаснаас медиа тус бүрийг тэмдэглэсэн буюу GW, SM ба SW гэсэн дэд хавтаснуудыг устгана.
3. CSIS Эдитор программыг дахин ажиллуулж, нэвтрэн орсны дараа Мэдээллийн сангийн засвар гээн үйлдлийг ажиллуулна.
4. Төвөөс өгөгдлүүдийг сэргээх гэсэн үйлдлийг ажиллуулна.

Мэдээллийн сангийн бүтэц

Мэдээллийн сангийн бүтцийн үйлдэл нь системийн дэлгэрэнгүй судалгаанд зориулагдсан бөгөөд энгийн хэрэглэгчид шаардлагагүй юм.

Үйлдэл нь хэсгийн мэдээллийн сангийн бүтэц болон ашиглагдсан тоон агуулгыг тайлбарладаг багц хүснэгтүүдийн заасан байрлалд үүснэ.

Хэсгийн мэдээллийн сангийн холболт (Local database connect)

Уг үйлдэл нь хэрэглэгч нэвтрэхээс өмнө ч бэлэн байдаг. Программыг хэсгийн мэдээллийн санд өмнөх тохируулгынхаас өөр байршилд холбох боломжийг өгдөг. Ердийн хэрэглэгчид үүнийг ашиглах шаардлага бараг гарахгүй. Харин ж.нь: хэсгийн компьютерийн сүлжээний удирдлагад хэсгийн өгөгдөл мэдээллийг автоматаар нөөцөлдөг дискэн дээр байршуулж, шаардлагатай бол CSIS-ийн өгөгдлүүдийг боловсруулсан дискний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх болон хэсгийн мэдээллийн санг системийн дискнээс гадуур нүүлгэн шилжүүлэх боломжийг олгоно.

7.2.5. CSIS Эдиторын харилцах цонх

CSIS Эдиторын харилцах цонх ямар ч самбарын товчлуурыг дарснаар нээгддэг. Газрын зургийн цонх хараахан нээгдээгүй тохиолдолд самбарын гол цонхны хамт газрын зургийн цонх мөн адил нээгдэнэ.

Маягтын харилцах цонхны маягт бүрт дараах зүйл агуулагддаг:

⇒ Хураангуйлсан / Epitomist. Тухайн маягтын өгөгдөлд хамгийн сүүлд өөрчлөлт хийсэн (маягтын өгөгдөл хадгалсан) хураангуйлагч (epitomist) үүрэг бүхий ажилтны нэр, түүний байгууллагын нэр зэрэг мэдээлэл орно. Системд нэвтэрсэн хэрэглэгчийн хувийн мэдээллийг үндэслэн уг мэдээллийг автоматаар оруулна. Мэдээлэл газар нутагт хамаарахгүй, маягт болгон ялгаатай байж болно. Учир нь баримт бичгийг нэмж оруулсан, секторуудыг тэмдэглэж өгсөн, шинжилгээг оруулсан, ажлын яаралтайн түвшинг тодорхойлсон хүн өөр өөр байж болно.


⇒ Он, сар, өдөр /Timestamp. Маягтад сүүлд хийгдсэн өөрчлөлтийн хугацааны тамгыг систем автоматаар оруулна. Энэ тамга маягт бүрт өөр өөр байдаг. Газар нутгийн байдалд сүүлд хийгдсэн өөрчлөлтийн огноо газар нутгийн паспортод заагдсан байдаг.

Маягтын харилцах цонх хоёр самбартай байдаг.

<u>Маягтын самбар</u>


Маягтын самбар нүүр хуудасны бүртгэлийн самбарын баруун талд байрласан байна. Самбарт бүртгэлийн хэсэг тус бүрт орох товчлуурууд байна. Эхний холбоос тухайн бүртгэлийн газар нутгийн гол маягтын холбоос болох ба бусад товчлуурууд бүртгэлээс сонгож авааД нээгдсэн газар нутгийн захирагдах хэсэгт холбогдоно. Уг товчлуурыг ашиглан газар нутгийн хэсэг тус бүрийн маягтууд нээгдэнэ.

Тухайн бүртгэлд ажиллах үед эхлээд ямагт газар нутгийг сонгож, түүний гол маягтыг нээнэ. Маягтыг бас газрын зургийн цонхноос газар нутгийн полигоны эсвэл цэгийн дүрслэлийг бүрэн тодорхойлж (full identify) нээх боломжтой. Маягт тус бүрийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг REG_ID болон REG_ConSite бүртгэлийн тухай өгүүлсэн хэсгээс үзнэ үү.



REG_ConSite бүртгэлийн маягтын самбар дэлгэцийн нарийвчлал бага байх нөхцөлд түүний хүрээнээс хэтэрч болох тул товчлуурыг багасгах функцаар тоноглогдсон. Хулганы баруун товч дээр товчлууруас гадуур дарвал бүх товчлуурууд түүн дээр байгаа дүрсний хэмжээтэй ижил болж багасна. Самбар дээр дахин дарахад товчлуурууд хуучин хэмжээндээ орно. Багасгасан товчлуур тайлбар, тэмдэглэлийн тоогүй байх ба мэдээллийг зөвхөн дүрснээс мэдэж болно. Уг функцийг товчлуурыг нэгбүрчлэн багасгахад ашиглах боломжтой. Тухайн үед ашиглах шаардлагагүй товчлууруудыг хулганы баруун товчоор нэгбүрчлэн багасгаж томсгох боломжтой. Идэвхтэй товчлуурыг шараар гэрэлтүүлсэн байна. Бүртгэлийн самбарын товчлуураас бусад идэвхтэй товчлуурыг ажлаа дуусгахаас өмнө дахин дарснаар идэвхгүйжүүлэх (унтраах) шаардлагатай.

Хэрэгслийн самбар



Хэрэгслийн самбар дэлгэцийн баруун талд буюу маягтын цонх нээгдэхээс өмнө тохируулга, нүүр хуудасны засварын самбар байсан хэсэгт байна. Хэрэгслийн самбар газар нутгийн өгөгдөлтэй ажиллах боломж олгодог.

Хэрэгслийн самбар дараах товчлууртай байна:

⇒ Газар нутгийн жагсаалт / List of localities. Хэрэглэгчийн тухайн бүртгэлийн нэвтрэх эрхтэй газар нутгийн жагсаалтыг харуулж, сонголт, шүүлт хийх боломжийг олгоно. Энэ товчлуурыг дахин дарснаар жагсаалтыг хүснэгт хэлбэрээс гаргана. Товчлуурыг газар нутгийн гол маягт эсвэл дагуух маягтыг нээлгүйгээр бүртгэл нээсэн байх үед ашиглаж болно.

⇒ Өмнөх газар / Previous locality. Аль ч бүртгэлийн газар нутгийн гол маягт нээгдсэн байх тохиолдолд уг товчлуурыг дарснаар өмнөх газар нутгийн тэмдэглэл байвал нээгдэнэ.

⇒ Дараагийн газар / Next locality. Аль ч бүртгэлийн газар нутгийн гол маягт нээгдсэн байх тохиолдолд уг товчлуурыг дарснаар дараагийн газар нутгийн тэмдэглэл байвал нээгдэнэ.

⇒ Шинэ тэмдэглэл үүсгэх / Add new record. Уг товчлуурын тусламжтайгаар газар маягтуудын самбараас нээгддэг нутгийн паспортоос бусад маягтад шинэ тэмдэглэл нэмж үүсгэх боломжтой. REG_ConSite бүртгэлд газар нутгийн тэмдэглэлийг зөвхөн анхдагч мэдээлэл шилжүүлснээр нэмэх боломжтой. Уг товчлуур дээр дахин дарсан тохиолдолд товчлуур идэвхжиж, текст нь "шинэ тэмдэглэл хадгалах" / save this new record болж хувираад шинэ тэмдэглэл хадгалагдана.

⇒ Тухайн тэмдэглэлийг засварлах / modify this record. Уг товчлуур газар нутгийн тэмдэглэлийг бусад хэрэглэгчид засварлахаас хамгаалан түгжигдэх ба тухайн үед нээгдсэн маягтын засварлах боломжтой талбаруудын түгжээг өөрчлөлт хийх зорилгоор тайлна. Хэрэглэгч тухайн газрыг засварлах эрхгүй, газрыг өөр хэрэглэгч түгжсэн, оффлайнаар хүлээн

зөвшөөрөгдөөгүй засварлалт гарсан, тэмдэглэл батлагдан баталгаажуулах процесс явагдаж байгаа тохиолдолд товчлуурыг ашиглах боломжгүй. Маягтад өөрчлөлт хийж эхэлмэгц товчлуур шар өнгөөр гэрэлтэж, нэр нь „энэ тэмдэглэлийг хадгалах“ / „save this record“ болж хувирна. Товчлуур дээр дахин дарахад хийгдсэн өөрчлөлт дотоод мэдээллийн санд хадгалагдахын зэрэгцээ төв мэдээллийн санд шилжиж тэмдэглэлийн түгжээ дараагийн өөрчлөлт хийхээр тайлагдана. Мөн түүнчлэн тэмдэглэл шинэчлэгдсэн огноо маягтад төдийгүй газар нутаг сүүлд шинэчлэгдсэн талбарт бичигднэ. Ихэнх тохиолдолд хийгдсэн өөрчлөлтийг хадгалах үед болиулах, өөрөөр хэлбэл түрүүчийн тэмдэглэлд буцах боломжтой. ReG_ConSite бүртгэлд батлагдсан тэмдэглэлийн аль ч хэсэгт өөрчлөлт оруулах бүрт тэмдэглэл боловсруулагдаж буй байдалд шилжихийг анхааралдаа авах шаардлагатай. Ингэсэн тохиолдолд уг тэмдэглэл батлагдсан тэмдэглэлийн каталогт шинээр батлагдтал, сүүлд батлагдсан хэлбэрээр үлдэнэ.

⇒ Устгахаар гэж тэмдэглэх / mark to deletion. Уг товчлуур зөвхөн засварлалт (edit)-ын товчлуур асаалттай байвал идэвхтэй байна. Уг товчлуураар хийгддэг өөрчлөлт зөвхөн ажлын дотоод мэдээллийн санд хамаарч, төв мэдээллийн санд шилждэггүй. Төв мэдээллийн санд гагцхүү товчлуурыг хэн, хэзээ, хэрхэн, аль хэсэгт хэрэглэсэн тухай мэдээлэл бичигднэ. Уг товчлуур нээгдсэн маягтын гол идэвхтэй тэмдэглэлийг устгахаар тэмдэглэхэд зориулагдсан. Тэмдэглэлийг тэмдэглэснээр захирагдсан бүх хүснэгт ч устгахаар тэмдэглэгдэнэ. Жишээ нь, баримтжуулалтын цэгийг тэмдэглэснээр түүнээс авсан бүх дээж, тэдгээрийн утга мөн адил устгахаар тэмдэглэнэ. Харилцах хүн, бичиг баримт эсвэл загварыг тэмдэглэснээр газар нутгийн тухайн харилцах хүн, бичиг баримт, загвар зэрэгт холбогдох харилцааг мөн устгана. Тэмдэглэлийг харилцах хүмүүсийн жагсаалт, номын сан, загварчлах системээс хасахын тулд администраторын зөвшөөрөл шаардагдах тул эдгээр хэсэг өөрчлөлтгүй үлдэнэ. Иймээс эдгээр хэсэгт товчлуурыг ашиглах боломжгүй. Товчлуур идэвхтэй болсны дараа текст нь „тэмдэглэл сэргээх“ / „restore this record“ болох ба товчлуур дээр дахин дарснаар нээгдсэн маягтын идэвхтэй тэмдэглэлийг сэргээх боломжтой. **Чухал анхааруулга!** Тэмдэглэлийг дотоод мэдээллийн санд сэргээсэн хэдий ч захирагдах тэмдэглэлүүд устгахаар тэмдэглэгдсэн хэвээр байх учир тэдгээрийг нэгбүрчлэн эсвэл төвөөс сэргээх шаардлагатай. Устгахаар тэмдэглэсэн тэмдэглэлийг зөвхөн хариуцлагатай менежер нүүр хуудсан дээр устгах эрхтэй („Тэмдэглэл устгах” сэдвийг үзнэ үү).

⇒ Газрын зураг дээр харуулах / show in the map. Уг товчлуурыг зөвхөн газрын зургийн план зураг агуулсан гол тэмдэглэл бүхий маягтад ажиллах үед ашиглаж болно. Тэр нь анхдагч мэдээлэл, consites, секторууд, баримтжуулалтын цэгүүд болно. Товчлуурыг дарснаар газрын зургийн цонх нээгдэж, холбогдох цэг эсвэл полигоныг томруулан дүрслэгдэж буй зүйлийн төвийг тойргоор эргэлдэн график элементын нэр, ялгагч тэмдэг (identificator), цэгийн солбилцол, полигоны талбай, периметр зэрэг хамгийн чухал мэдээлэл агуулагдсан цонх гарч ирнэ.

⇒ “Баримтжуулалтын цэг”, “дээж, утга” зэрэг маягт мэдээллийг экспортлоход зориулсан товчлуур бий.

⇒ “Дээж, утга” маягт гадны хүснэгттэй ажиллах нөхцөлд гадны хүснэгтэд өгөгдөл шилжүүлэх, гадны хүснэгтээс CSIS мэдээллийн санд өгөгдөл оруулахад зориулсан

товчлууpаар тоноглогдсон. Өгөгдлийг төв мэдээллийн санд шилжүүлэхээс өмнө түүний форматыг шалгах боломжтой болох үүднээс энэ аргыг нэвтрүүлсэн юм.

⇒ Баталгаажуулалт (Autorisation). Уг функц байгууллагын өмнөөс өгөгдлийн чанарыг хариуцсан ажилтан (менежер)-т системд оруулсан өгөгдөл болон ач холбогдлын зэрэглэл тогтоосны үнэн зөвийг биечлэн батлах боломж олгож байна. Consite баталгаажуулалт хийснээр тэмдэглэл баталгаажуулах үйл явцад хүлээн авах хүсэлт гаргасан гэж тэмдэглэсэн. Баталгаажуулалтын веб сайтад ч хийж болно. Нэгэнт баталгаажсан тэмдэглэлийг дахин засварлах боломжтой. Харин баталгаажсан тэмдэглэлийг администрацийн зүгээс тулган баталгаажуулсан бол өмнө нь засварлахаас сэргийлж түгжсэн байсан тул эцсийн баталгаажуулалт давсны дараа түгжээ тайлагдана.

7.2.6. Анхдагч мэдээллийн REG_ID бүртгэл

Анхдагч мэдээллийн бүртгэлийг бүртгэлийн самбар дахь холбогдох товчлуурыг дарснаар онгойно. Маягтын самбарыг авч үзвэл бүртгэлд хэрэглэгчийн хоёр маягт бий:

⇒ Анхдагч мэдээллийн маягт (газар нутгийн гол маягт)

⇒ Холбогдох зургийн маягт (related images).

Анхдагч мэдээллийн бүртгэлд бохирдсон биш гэж илэрхий болсон газруудыг багтаан системд оруулсан бүх газар агуулагдсан байна. CSIS дахь газар нутаг бүрийн амьдралын мөчлөг анхдагч мэдээллийн бүртгэлээс эхэлдэг.

Анхдагч мэдээллийг маягт

Анхдагч мэдээллийн маягт дараах талбартай байна. Үүнд,

⇒ Анхдагч мэдээллийн нэр / Name of the indication. Газар нутгийн онцлогийг илэрхийлсэн эсвэл түүний олны дунд дэлгэрсэн нэр. Дэлгэрэнгүй тайлбарыг үзэхийн тулд “Газар нутгийн нэр” нэр томъёог үзнэ үү. Газар нутгийн нэр 80 оронтой үсгээс хэтрэхгүй.

⇒ Нутгийн нэр / Territory name. Газар нутаг ямар нэг багийн нутаг дэвсгэр дээр оршдог бол хамгийн ойрхон багийн нэр, эсвэл морфологийн биет газрын түгээмэл нэр үгүй бол ойрх гадаргын усны биетийн нэр. Нутгийн нэр 40 оронтой үсгээс хэтрэхгүй. Жишээ нь: "Ноот Нуурын энгэрийн дэргэд", "Хорго-Тариат", гэх мэт.

⇒ Солбилцол анхдагч мэдээлэлд газрын байршлыг газрын зураг дээр заах үед автоматаар уншигдана. Хэрэглэгч X,Y-ы байршил буюу уртраг, өргөргийг газрын зургийн цонхонд засах боломжтой. Далайн түвшингээс дээш түвшинг заах Z-г анхдагч мэдээллийн маягтад ч засч болно.

⇒ Бүртгүүлж буй газар аль сум, аль аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог тухай мэдээлэл газрын байршлыг заах үед газрын зураг дээрээс автоматаар уншигдана.

⇒ Бохирдлын эх үүсвэр / Pollution Source. Бохирдлын эх үүсвэрийн төрлийг цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Аж үйлдвэрийн салбар / Pollution Production Sector. Бохирдлын эх үүсвэр байж болзошгүй аж үйлдвэрийн салбар. Жишээ нь, бохирдлын эх үүсвэрт “хогийн цэг” гэж оруулсан бол аж үйлдвэрийн салбарт ахуйн, цэргийн, аж үйлдвэрийн гэх мэт байж болно.

⇒ Шинж чанар / Characteristics. Газар нутгийн шинж чанарын тухай оновчтой, товч мэдээлэл, чулуулгийн орчны бохирдол, түүний төрлийг тодорхойлоход нөлөө бүхий ашиглалтын түүх. Талбарын хэмжээнд хязгаар байхгүй хэдий ч бичвэр цонхны урьдчилан тохируулсан хэмжээнээс хэтрэхгүй байх нь зүйтэй.

⇒ Үүсч болзошгүй эрсдэл / Posssible hazards. бохирдлын улмаас үүсч болзошгүй эрсдэлийн талаар тэмдэглэл боловсруулагчийн санал - бохирдлын улмаас байгаль орчин, эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөө. Тэмдэглэл боловсруулагч ажилтан анхдагч мэдээлэл ямар ч эрсдэлгүй байх ба бохирдсон газар биш болох нь эргэлзээгүй бол уг талбарт тайлбар бичиж, анхдагч мэдээллийн байдлыг “хасагдсан анхдагч мэдээлэл / the indication discarded”-д шилжүүлнэ. Анхдагч мэдээллийг хассан бол цаашид боловсруулахгүй. Уг талбарын хэмжээнд хязгаар байхгүй боловч цонхны урьдчилан тохируулсан хэмжээнээс хэтрэхгүй байх нь зүйтэй.

⇒ Тэмдэглэлийн боловсруулсан байдал / Record state of elaboration. Цэснээс сонголт хийнэ. Хэрэглэгч тэмдэглэлийг боловсруулж эхэлсэн бол систем анхдагч мэдээллийн байдлыг боловсруулж эхлээгүй шатанд шилжүүлэхээс сэргийлсэн байна. Хэрэглэгч уг цэсээр анхдагч мэдээллийг газар дээр нь шалгах шаардлагыг тавьж, зураглалын ажлыг удирдах боломжтой. Анхдагч мэдээллийн боловсруулалтыг уг цэсээр дуусгаж анхдагч мэдээллийг шаардлага хангаагүйн улмаас хасах (“Үүсч болзошгүй эрсдэл” сэдвийг үзнэ үү) эсвэл бохирдсон газрын бүртгэлд шилжүүлнэ. Анхдагч мэдээллийг бохирдсон газрын бүртгэлд шилжүүлснээс хойш REG_ID дэх түүний тэмдэглэлийг дахин засварлах боломжгүй.

⇒ Шуурхай боловсруулах шаардлага / Urgency of elaboration. Цэснээс сонголт хийнэ. Хэрэглэгч, менежер, админ анхдагч мэдээлэл боловсруулах явцад яаралтайн түвшинг зааснаар нөлөөлөх боломжтой. Яаралтайн түвшинг заах боломжийг тооллого, зураглалыг удирдах үед ашиглах боломжтой. Бүртгэлийн шалтгаанаар яаралтайн түвшинг анхдагч мэдээллийг боловсруулж дууссаны дараа устган, арилгах шаардлагагүй.

⇒ Өгөгдлийн эх үүсвэр / data source. Цэснээс сонголт хийснээр өгөгдлийн эх үүсвэр буюу анхдагч мэдээллийг хаанаас мэдээлсэн тухай мэдээллийг заана. Өөрчлөлтийг өгөгдөл болосвруулагч гагцхүү урьд нь заасан мэдээлэл бодит байдалд нийцэхгүй тохиолдолд хийнэ.

⇒ Холбогдох ConSite_ID / Child ConSite_id. Бохирдсон газрын тухай тэмдэглэл анхдагч мэдээллийг REG_ConSite бүртгэлд шилжүүлснээр үүссэн бол бохирдсон газрын ялгах тэмдэг. Анхдагч мэдээллийн тэмдэглэлийг “REG_ConSite –д бүртгэгдсэн” боловсруулах түвшинг тавьмагц автоматаар бөглөгдөнө.


Зурагт хавсралтын маягт

Хоёр бүртгэлд хоёуланд нь байгаа газар нутгийн тэмдэглэлд зураг хавсаргах боломжтой. Зураг мэдээллийн чанартай байгаа ба 1024 x 768 пиксель орчим нягтралтай

дэлгэцэнд гаргахад зориулагдсан. Өгөгдөл түргэн шуурхай шилжүүлэх боломжтой болохын тулд зургийг системд суурилуулахаас өмнө системийн багцад орж буй Windows Paintbrush-д нээж, хэмжээг нь дэлгэцийн хэмжээнд тааруулан өөрчилж upload-д зориулагдсан файлд хадгалахыг зөвлөж байна. Уг программ тусгай зориулалтын график программууд хангана гэсэн баталгаагүй зургуудыг стандарт форматтай болох нөхцлийг хангана. JPEG (JFIF), GIF а PNG зэрэг нь зөвлүүштэй форматууд байна. График, газрын зураг болон түүнд ижилсэх эрс тэс ялгаатай (контраст) энгийн өнгөтэй зургийг GIF форматаар хадгалахыг чанд зөвлөж байна. Гэрэл зураг, түүнд ижилсэх эрс тэс ялгаагүй өнгөтэй шилжвэр бүхий зурганд JPEG, PNG формат тохиромжтой байна. Файлын хэмжээ 300-с 800 хүртэл kb-тай байхыг зөвлөж байгаа бөгөөд том хэмжээний өгөгдлийн мэдээлэл системийг нэлээд их удаашруулж ажиллуулдаг тул файл ямар ч байсан 2MB-аас хэтрэхгүй байна.

Программ автоматаар татагдаж буй файлын нэрийг зургийн нэр болгон оруулна. Гэвч үүнийг оновчтой, маш товчхон нэрээр солих хэрэгтэй, жишээ нь “1-р ухмал нүхний баримт бичиг”. Зургийн нэр 100 орноос, татаж буй файлын нэр 120 орноос хэтрэхгүй байна. Зургийн файлын нэрэнд файлын төрлийн өмнө тавьдаг цэгээс өөр цэг оруулахгүй байх нь зүйтэй.


Анхдагч мэдээлэлд хавсаргасан зурган хавсралт түүнийг REG_ConSite рүү шилжүүлсний дараа тухайн бохирдсон газрын тэмдэглэлд ч мөн адил хавсаргасан байна.



7.2.7. Бохирдсон болон бохирдсон байж болох газрын REG_ConSite бүртгэл

Газар нутгийн паспорт

Газар нутгийн паспортод бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тухай хамгийн чухал мэдээлэл агуулагдсан бөгөөд эндээс ач холбогдлын зэрэглэлийг тогтооход шаардлагатай бүх мэдээллийг олж болно. Бусад маягтуудын адилгүйгээр энэ маягтын шинэчилсэн цагаас гадна газар нутгийн тухай тэмдэглэлд сүүлд өөрчлөлт хийсэн буюу хамгийн сүүлд шинэчилсэн маягтын цаг заагдсан байна.



Маягтын толгой хэсэгт дараах зүйл байна.

⇒ Системийн автоматаар олгодог газар нутгийн ялгагч тэмдэг (ялгагч тэмдэг “identificator”-ыг үзнэ үү).

⇒ Сонирхсон газар нутгийн байршил, полигоны план зургийг хийхэд зориулагдсан товчлуур („Сонирхсон газар“ сэдвийг үзнэ үү). **Чухал анхааруулга!** Газар нутгийн байршлыг цэгэн планы тусламжтайгаар өөрчлөх бүрт сонирхсон газар нутгийн полигонд цэгийн шинэ байршил багтсаныг анхаарах хэрэгтэй. Цэгийн байршил нэлээд их өөрчлөгдсөн тохиолдолд сонирхсон газрын байршлыг засах хэрэгтэй. Анхдагч мэдээллийн хүрээнд мэдэгдсэн байршил хяналтын шалтгаанаар хэзээ ч өрчлөгдөхгүйг анхаарах нь зүйтэй.

⇒ Солбилцол. X, Y-ийн байршлыг зөвхөн CSIS Editor-д өөрчлөх боломжтой. Z олбилцлыг (далайн түвшингээс дээш метр) энэ маягтад ч өөрчилж болно.

⇒ Гурвалжин хэлбэртэй дүрслэл ач холбогдлын зэрэглэлийг зааж байна

⇒ Дөрвөлжин хэлбэртэй дүрслэл тэмдэглэлийн боловсруулсан эсвэл батлагдаж буй байдлыг зааж байна.

⇒ **Газрын нэр** – газрын нэрийг үндсэн анхдагч мэдээллээс хуулбарладаг. Нэрийг үндсэн анхдагч мэдээллийн нэрийг өөрчлөлгүйгээр засч болно (“Газрын нэр”-ийг үзнэ үү).

⇒ Ач холбогдлын зэрэглэл, түвшингээс бүрдсэн ач холбогдлын зэрэглэлийн код. Кодыг систем ач холбогдолд үнэлгээ өгсний дараа автоматаар гаргана (Байгаль орчин, ногоон хөгжлийн ямны “CSIS мэдээллийн сангийн аргачлалын удирдамж”-г үзнэ үү).

⇒ Ач холбогдлын зэрэглэлийн үндсэн дээр газар дээр хийх шаардлагатай арга хэмжээ. Үүнийг систем бас автоматаар бөглөнө (дээр дурдсан аргачлалын удирдамжийг үзнэ үү)

⇒ Газар дээрх үйл ажиллагааны байдал гэдгээр тухайн газар нутагт үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг зааж байна. Цэснээс сонголт хийнэ (Идэвхтэй / Идэвхгүй).

Паспортод заасан бусад мэдээлэл дараах **багцад** хуваагдсан:

⇒ **Үндсэн мэдээлэл / Main info**

⇒ **Бохирдсон байдал / Pollution info**

⇒ **Шилжин тархах боломж / Migration possibility**

⇒ **Газрын ашиглалт / Locality usage**

⇒ **Эрсдэл ба ач холбогдол / Hazards and Priority.**

Үндсэн мэдээлэл / Main info

⇒ Нутгийн нэр / Territory name. Уг мэдээллийг үндсэн анхдагч мэдээллээс шилжүүлсэн байх бөгөөд түүнийг засварлах боломжтой. (“Анхдагч мэдээлэл”-ийг үзнэ үү)

⇒ Газар нутаг аль сум, аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог тухай мэдээлэл анхдагч мэдээллийн тэмдэглэл бөглөх үед байршлыг нь заангуут газрын зурганаас автоматаар уншигдана. Газрын зурган дээрх байршлыг өөрчилснөөр засварлах боломжтой. Цэгийн эсвэл полигоны байршлыг засварлахад зөвхөн нэгийг нь засварлаж болохгүй гэдгийг анхаарна уу.

⇒ Бохирдлын эх үүсвэр / Pollution Source. Уг мэдээлэл анхдагч мэдээллээс шилжиж байгаа боловч түүнийг цэснээс сонголт хийх аргаар өөрчилж болно.

⇒ Аж үйлдвэрийн салбар / Pollution Production Sector. Уг мэдээлэл анхдагч мэдээллээс шилжиж байгаа боловч түүнийг цэснээс сонголт хийх аргаар өөрчилж болно.

⇒ Судалсан байдал / Investigation status. Цэснээс сонголт хийнэ – газар нутаг дээр дээжлэлт хийгдсэн эсэх, судалгаа хийсэн бол урьдчилсан, нарийвчилсан эсвэл нэмэлт судалгаа байсан, эрсдэлийн судалгаа боловсруулсан эсэх. **Чухал анхааруулга!** Энэ талбарыг хэрхэн бөглөснөөс ач холбогдлын зэрэглэлийг зөв

тогтоох эсэх шалтгаална. Талбарт заасан мэдээлэл сэлбэн засах арга хэмжээний байдал, арга хэмжээ яаралтай авах шаардлагатай эсэх, ямар арга хэмжээ хамгийн тохиромжтой болох зэрэг газрын тухай бусад мэдээлэлтэй нийцсэн байхыг анхаарах хэрэгтэй.

⇒ Шинж чанар / Characteristics. Уг талбарын агуулгыг үндсэн анхдагч мэдээллээс хуулбарласан: газар нутгийн товч, оновчтой танилцуулга, чулуулгийн орчны бохирдол, түүний тархалттай холбогдсон уг газрын ашиглалтын түүхийн тухай танилцуулга. Тухайн газар нутагт урьд нь ямар нэг судалгаа хийж гүйцэтгэсэн бол үүнд холбогдох хамгийн чухал мэдээллийг судалгааны тайлангаас маш товч хэлбэрээс иш татаж оруулна. Мэдээллийг арай дэлгэрэнгүй оруулах шаардлагатай гэж үзвэл үүнийг (тайлангийн дүгнэлт) “Холбогдох бичиг баримтууд / Related documents” бүлэгт оруулж энэ талбарт тухайн бичиг баримтын холбоосыг заана. Газар нутгийн тэмдэглэлд зурган хавсралтын холбоосыг ч оруулж болно. Уг талбарын хэмжээнд хязгаар байхгүй боловч цонхны урьдчилан тохируулсан хэмжээнээс хэтрэхгүй байх нь зүйтэй.

⇒ Сэлбэн засах арга хэмжээний зорилго / Target of a corrective action. Сэлбэн засах арга хэмжээг хэрэгжүүлсэнээр ямар зорилгод хүрэх шаардлагатай болох тухай мэдээлэл. Жишээ нь, охирдсон ус уусны улмаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, эсвэл: бохирдсон бэлчээрт бэлчсний улмаас мал сүрэгт үзүүлэх сөрөг нөлөөг таслан зогсоох, эсвэл: .тухайн газар нутгаас хортой тоосыг ойр орчимын хүнсний ногоо тарих талбайд тараахаас урьдчилан сэргийлэх. гэх мэт. Тухайн газар нутагт урьд нь ямар нэг судалгаа хийж гүйцэтгэсэн бол үүнд холбогдох хамгийн чухал мэдээллийг судалгааны тайлангаас маш товч хэлбэрээр иш татаж оруулна. Энэ тохиолдолд ч хэрэглэгч хавсаргасан бичиг баримт, PDF файл, зураг зэргийг ашиглах боломжтой болохыг анхаарна уу.

⇒ Сэлбэн засах арга хэмжээний тухай / Description of a Corrective Action. Сэлбэн засах арга хэмжээний тухай товч тайлбар. Жишээ нь, газар доорх ус цэвэрлэх, эсвэл: айлуудыг ус хангамжийг шугам сүлжээнд холбож өгөх, эсвэл: бохирдсон лагийг зайлуулж, битүүмжилсэн цэгт зөөн тээвэрлээд цэвэр хөрсөнд булах гэх мэт. Тухайн газар нутагт урьд нь ямар нэг судалгаа хийж гүйцэтгэсэн бол үүнд холбогдох хамгийн чухал мэдээллийг судалгааны тайлангаас маш товч хэлбэрээр иш татаж оруулна. Энэ тохиолдолд ч хэрэглэгч хавсаргасан бичиг баримт, PDF файл, зураг зэргийг ашиглах боломжтой болохыг анхаарна уу.

⇒ Monitoring / Мониторинг. Хэрээсээр тэмдэглэх талбар: тухайн газар нутагт тогтмол дээжлэлт хийгддэг эсэх тухай мэдээлэл (жишээ нь, газар дээрх болон газар доорх усны).

⇒ Нөхөн сэргээлтийг санхүүжүүлэх байгууллага / Remediation funded by 80 орноос дээшгүй бичвэр талбар төлөвлөж буй, хэрэгжүүлж буй эсвэл хэрэгжүүлж дуусгасан сэлбэн засах арга хэмжээг санхүүжүүлэх байгууллагын нэрийг товчхон заахад зориулагдсан. Уг байгууллагын тухай мэдээллийг бас „Харилцах мэдээлэл“ / „Related Contacts“ талбарт бөглөх хэрэгтэй. Сэлбэн засах ажлыг санхүүжүүлэх байгууллага нэгээс илүү байвал үүнийг “харилцах мэдээлэл” бүлэгт заасны дагуу бөглөөд, харилцах этгээдийн маягтад байгууллагын үүргийг “сэлбэн засах ажлын санхүүжүүлэгч” болохыг бичнэ.

⇒ Газар нутгийн нөхөн сэргээлтийн байдал / Statement of the corrective action. Нөхөн сэргээлтийн ажил хийж байгаа бол түүний одоогийн байдал – цэснээс сонголт хийнэ.

Энэ хэсэгт газар нутгийн тэмдэглэлд холбогдсон бусад чухал мэдээлэл орсон байна. Үүнд,

⇒ Газар нутгийн тэмдэглэл боловсруулах үе шат / Stage of the Locality record processing. Уг байдлыг эдиторт (editor) зөвхөн боловсруулагчийн хариуцлагатай төлөөлөгч өөрчлөх боломжтой. Менежер тэмдэглэлийн бүрэн байдал, өгөгдлийн үнэн зөвийг хянаж, тэмдэглэлийг хэрэгслийн зурвасаас “Баталгаажуулалт” (Autorisation) хэрэгслийн тусламжтайгаар баталгаажуулна. Энэ талбарт хийх цаашдын өөрчлөлт батлах үйл явцаас хамаарч байгаа бөгөөд уг талбарт хийгдсэн аливаа өөрчлөлт мөн маягтын толгой хэсэг дэх дөрвөлжин дүрсээр илэрхийлэгдсэн байна.

⇒ Өгөгдлийн эх үүсвэр / data source. Анхдагч мэдээллээс шилжсэн уг өгөгдлийн эх үүсвэрийн тухай мэдээлэл. Түүнийг болон үндсэн анхдагч мэдээллийн ялгагч тэмдэг (identificator)-ыг засварлах боломжгүй.


⇒ Тэмдэглэлийн шинэлэг байдал / Data recency. Захирагдах маягтуудад оруулсан өөрчлөлтийг багтаасан газар нутгийн тэмдэглэлийн нийт шинэлэг байдал гэж ойлгоно. Газар нутгийн аль ч маягтад өөрчлөлт хийснээр уг талбарын огноо болон цаг шинэчлэгдэнэ. Зөвхөн энэ маягтын өгөгдөлд өөрчлөлт хийсэн тухай мэдээлэл маягтын доод хэсэгт заагдсан байна. Өөрөөр хэлбэл уг талбарт заагдсан огноо болон цаг хамгийн сүүлд өөрчлөгдсөн (шинэчлэгдсэн) хэсгийн огноо болон цагтай ижил байна.

Бохирдсон байдал / Pollution info

“Бохирдсон байдал” багц сонголтын гурван цэс, гурван хүснэт байна. Гурван хүснэгтэд гадаргын усны бохирдол (SWpolut), газар доорх усны бохирдол (Gwpolut), гол төлөв хөрс, барилгын хийц бүтээцийн өрлөг, лаг, голын тунамал чулуулаг зэрэг хатуу матриц (SMpolut,) –ийн талаарх мэдээллийг тус тус оруулна. Уг хүснэгтэд өгөгдлийг хүснэгт дээр байрлуулсан товчлууруудын тусламжтайгаар нэмж оруулахаар зогсохгүй нэн даруй устгах боломжтой.

Бохирдлын хүснэгтэд тэмдэглэлийг устгахдаа засварлах (edit) горимд хүснэгтийн устгах гэж буй эгнээний эхний нарийн талбарыг хулганаар дарснаар тэмдэглэнэ. Эгнээний эхний талбар хар өнгөтэй болно. Мөн дээрх аргаар тэмдэглэсэн талбарыг тэмдэглэлгүй болгоно. Тэмдэглэсэн эгнээнүүд маягтад өгөгдөл хадгалах хүсэлтийг батламагц устгагдана. Ингэснээр төв мэдээллийн сангийн мэдээлэл ч устгагдах бөгөөд CSIS Editor-ын хүрээнд төв мэдээллийн санд нөлөөлөх ганц хэрэгслэл юм.

Хүснэгт бүрт бохирдлын төрөл (бохирдуулагч бүлгийн нэр), бохирдлын түвшинг сонгодог цэс байна. Хийсэн сонголтын үндсэн дээр хортой болон тархах чанарын түвшин автоматаар бөглөгдөнө. Бохирдлын зарим төрлийн хувьд энэ нь тийм ч тодорхой зүйл биш байж болох тул ач холбогдлын зэрэглэл тогтоох үед систем түвшинг таамаглаж өгөх хүсэлт гаргах магадлалтай.



Тухайн газар нутагт ямар нэгэн дээжлэлт хийгдсэн бол тэмдэглэл боловсруулагч дээжлэлтийн тайлан, дүгнэлтийг үндэслэн бохирдлын түвшинг тодорхойлно. Бохирдлын түвшинг тодорхойлох ажлыг бохирдлын шинжилгээний үр дүнг тал талаас нь үзэх үүрэгтэй мэргэжилтэн хийх нь зохимжтой. Учир нь гэвэл дээжийн тоо хэмжээ илүү байвал ямар нэг бохирдуулагч бодисын шинжилгээний үр дүн өргөн хүрээнд хэлбэлзэх тохиолдол бий тул мэргэжилтэн хүн тухайн бодисын улмаас үүссэн бохирдлын өндөр, дунд, бага хэмжээний аль нь болохыг тогтооно (жишээлбэл, шинжилгээний статистик үнэлгээний үндсэн дээр). Бохирдсон газрын тухай тэмдэглэлийг хийсэн судалгааны тайлан зохиосон мэргэжилтэн бөглөвөл бүр сайн байна.

Тухай газар дээрх бохирдлыг устгасан тохиолдолд зохих хүснэгтэд тусгагдсан бохирдлын төрлийг заагаад, бохирдлын түвшинг заах цэснээс „ямар ч бохирдолгүй эсвэл бохирдолт багатай“ / „none or negligable pollution“ боломжийг сонгоно.

Тухайн газрын бохирдлын тухай ямар ч мэдээлэл байхгүй тохиолдолд хүснэгтэд мэдээлэл оруулахгүй. Харин тухайн газарт явуулж байсан үйл ажиллагааны төрлийг үндэслэн бохирдлын төрлийг өндөр магадлалтай таамаглах боломжтой бол зохих хүснэгтэд таамаглаж болох бохирдлын төрөл, түүний түвшинг тодорхойлох талбарт „тодорхойгүй“ / „no information“ гэдгийг тус тус бөглөнө. Үүнийг ядаж ойролцоо дээж авсны дараа тодруулна. Тухайн газарт нэгээс илүү төрлийн бохирдол илэрсэн тохиолдолд ажиглагддаг орчны (GW, SW, SM) хүснэгтийн нэг мөр бохирдлын төрөл бүрийг оруулахад зориулсан.

⇒ Бохирдсон газрын нийт талбай / All-round Pollution Area Size. Багцны дээд хэсэгт байгаа талбарт бохирдсон талбайн ойролцоо хэмжээг заана. Цэснээс сонголт хийж бөглөнө. Сонголт хийх үед 100 м^2 нь 10 x 10 м, 2 500 м^2 нь 50 x 50 м, 250 000 м^2 нь 0,5 x 0,5 км тус тус талбайтай дөрвөлжин болохыг анхаарах хэрэгтэй.

Шилжин тархах боломж / Migration possibility

Энэ багцанд бохирдсон газар нутгийн ойр орчимд бохирдол тархах магадлалд нөлөөлж буй хүчин зүйлийн тухай мэдээлэл төвлөрүүлсэн байна (энэ багцанд заасан хүчин зүйлээс гадна программ бохирдлын төрөл бүрийн шинж чанарыг автоматаар харгалздаг юм). Тухайн газар нутагт урьд нь бохирдлын ямар нэг судалгаа хийгдсэн бол энэ багцанд оруулах бүх мэдээлэл уг судалгааны эцсийн тайлангаас олдох боломжтой байх ёстой.

⇒ Гол мөрөн, нуурын нэр - сав газар / Name of drainage/river/lake basin. Хэрэглэгч гол мөрний үндсэн сав газрын нэрийг бичнэ. Программын арай шинэлэг хувилбарууд тухайн газар нутгийн байршлын дагуу сав газрын нэрийг автоматаар оруулна.

⇒ Гадаргын усны биет хүртэлх зай / Distance to Surface Water Body. Гол, нуур зэрэг гадаргын ус хүртэлх зай – цэснээс сонголт хийж тодорхойлно.

⇒ Үерт автах газар / Site in inundation-flooded area. Цэснээс сонголт хийж тухайн газар нутаг үерт автах газарт оршдог эсэхийг тодорхойлно.

⇒ Газрын доорх усаар тархах боломж / Groundwater Migration Conditions. Бохирдол газар доорх усаар тархах боломжтой эсэхийг чулуулаг, хөрсний ус нэвтрүүлэх чанар, газар доорх усны түвшин хүртэлх зай, усны чөлөөт эсвэл түрлэгтэй гадаргуу, налуугийн түвшин зэргийг үндэслэн таамаглана. Мэдээлэл бөглөж буй хүний мэргэжлийн түвшин, туршлагад тавигдах шаардлагын хувьд тус багцын хамгийн хэцүү хэсэг юм.

⇒ Бохирдуулагч бодисын тархах чанар – шингэн / Pollution Intrinsic Mobility-Fluid. Тус газарт шингэн буюу тархах чанар сайтай бохирдуулагч бодис багаас илүү хэмжээгээр байх тухай мэдээлэл – цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Бохирдуулагч бодисын тархах чанар – тоос/агаар / Pollution Intrinsic Mobility-Dust. Бохирдуулагч тоос буюу тархах чанар сайтай бохирдуулагч бодис багаас илүү хэмжээгээр задгай талбайд хадгалагдсан байх тухай мэдээлэл – цэснээс сонголт хийж бөглөнө.


⇒ Далдлалт/гадаргын бэхжилт / Site Surface Cover. Тухайн газар нутаг бохирдсон хөрснөөс хамгаалж, шингэн, хур тунадас шингээхээс сэргийлсэн асфальт эсвэл бетон хучилттай эсэх тухай мэдээлэл. Шаардлагатай боломжийг цэснээс сонгож оруулна.

⇒ Нэмэлт мэдээлэл Газрын доорх усаар тархах боломж / Supplementary information of Migration Conditions. Уг талбар бохирдуулагч бодисын тархалтад нөлөөлдөг байгалийн нөхцөл байдлын тухай мэдээлэл бичихэд зориулсан талбар. Газар нутгийн байршлын геоморфологийн шинж чанар (голын хөндий, өндөрлөг дэнж, түүнчлэн бохирдол газар доорх усаар хэрхэн тархаж болох (гидрогеологийн шинж чанар), гадаргын усанд нөлөөлөх, агаараар тархаж болох эсэхийн талаарх мэдээлэл.

Газрын ашиглалт / Locality usage

Энэ багцанд тухайн газар нутгийн бохирдол юунд болон хэнд хортой нөлөө үзүүлэх эсэхэд нөлөөлөх хүчин зүйлийн тухай мэдээлэл төвлөрүүлсэн байна. Тухайн газар

нутагт урьд нь бохирдлын ямар нэг судалгаа хийгдсэн бол энэ багцад оруулах бүх мэдээлэл уг судалгааны эцсийн тайлангаас олдох боломжтой байх ёстой. Газар нутаг, түүний ойр орчимыг ашиглах байдал цэсэнд байгаа нэгээс илүү боломжинд тохирч байгаа бол тухайн бохирдлын хувьд хамгийн их нөлөө бүхий зүйлийг нь сонгоно (цэсний сонголт бүрийн эцэст буй мэдрэг байдал өндөр, дунд зэрэг, бага зэрэг тодорхойлолтыг үзнэ үү).



Бохирдолд мэдрэг байдал багатай газрын жишээ: газрыг аж үйлдвэрийн зориулалтаар ашиглаж байгаа, бохирдолд мэдрэг байдал өндөртэй газрын жишээ: цэцэрлэгийн хажуудах тоглоомын талбай.

⇒ Тухайн газрын ашиглалт / Site use - sensitivity of use. Газар нутгийг ашиглаж байгаа байдлыг цэснээс сонголт хийж тодорхойлно.

⇒ Ойр орчмын ашиглалт / Neighbourhood use. Газар нутгийн 0,5 км доторх ойр орчмыг ашиглаж байгаа байдлыг цэснээс сонголт хийж тодорхойлно.

⇒ 1 км дотор зайд газар доорх усны ашиглалт / GroundWater use up to 1km downstream. Тухайн газар нутгаас 1 км дотор зайд газар доорх усыг бодит эсвэл таамаглагдаж буй урсгалын дагуу ашигладаг байдлыг цэснээс сонголт хийж тодорхойлно. Дээр заасан зайн дотор усны эрүүл ахуйн хамгаалалтын бүс мөн усны ашиглалтанд тооцогдоно.

⇒ 5 км дотор зайд газар доорх усны ашиглалт / Surface Water use up to 5km down. Тухайн газар нутгаас 5 км дотор зайд газар доорх усыг урсгалынх нь чиглэлийн дагуу ашигладаг байдлыг цэснээс сонголт хийж тодорхойлно. Дээр заасан зай дотор усны эрүүл ахуйн хамгаалалтын бүс мөн усны ашиглалтанд тооцогдоно.

⇒ Хамгаалалттай газар - Тухайн газар ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй / Protected Area Network - Possible Conflict on Site. Тухайн газар нутаг байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтанд буй нутаг дэвсгэрт оршдог тухай мэдээллиийг цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Хамгаалалттай газар - 0,5 км дотор зайд ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй / Protected Area Network - Possible Conflict in Neigbourhood up to 0,5 km. Тухайн газар нутгийн ойр орчим (0,5 хүртэл зайд) байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтанд буй нутаг дэвсгэрт оршдог тухай цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Тухайн газар нутагт амьдарч ажилладаг хүний тоо өдрөөр / Daily number of people living or working on the site. Үүнийг цэснээс сонгож бөглөнө.

⇒ 1 км-с дээшгүй ойр орчимд амьдарч ажилладаг хүний тоо өдрөөр / Daily number of people living or working in the 1 km neighbourhood. Үүнийг цэснээс сонгож бөглөнө.

⇒ Тухайн газраас 1 км хүртэлх нутаг дэвсгэрт эсвэл усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд газар доорх усаар хангагддаг хүний тоо / Number of GW users on the Site or up to 1km from it or conflict with SPZ / Тухайн газар нутагт, түүнээсс 1 км хүртэлх зайд эсвэл усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс нь тухайн газраас 1 км-с дээшгүй зайд оршдог газар доорх усны эх үүсвэрээс усаар хангагддаг хүний тооны ангилал. Цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Голын урсгалын дагуу 5-с дээшгүй км-т гадаргын усаар хангагддаг иргэд / SW users up to 5km downstream or conflict with SPZ. Тухайн газар нутагт, урсгалын дагуу түүнээс 5 км хүртэлх зайд эсвэл усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс нь тухайн газраас 5 км-с дээшгүй зайд оршдог газар доорх усны эх үүсвэрээс усаар хангагддаг хүний тооны ангилал. Цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Газар, түүний ойр орчмыг ашигладаг тухай нэмэлт мэдээлэл / Further information about Site Use and its Neighbourhood. Газар нутаг, түүний ойр орчмын болон тухайн газар, ойр орчмын газар доорх болон гадаргын усны ашиглалтын нэмэлт мэдээлэл бичвэр хэлбэрээр оруулахад зориулсан талбар.

Эрсдэл ба ач холбогдол / Hazards and Priority

Энэ багцад тухайн газар нутагт урьд нь гарсан аваар осол, эрсдэлийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл ордогоос гадна уг маягтын толгой хэсэгт ач холбогдлын зэрэглэлийн үндэслэлийн илүү нарийвчлалтай тайлбар, түүнд орсон дэлгэрэнгүй мэдээлэл, хийсэн үнэлгээг шинэчлэх боломжтой. Уг багцанд дараах зүйл орсон байна. Үүнд,

⇒ Бохирдлын ноцтой алдалтын тохиолдол / Serious Release of Pollutants during Site History. Тухайн газар нутагт урьд нь аваар осол гарсан бол тэр үед бохирдол алдалтын тохиолдол гарсан эсэх тухай мэдээллийг цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Тухайн газрын түүхэнд тохиолдсон аваар осол / Specification of accidents and disasters in the Site history. Зохих мэдээлэл байвал аваар ослын улмаас хортой бодис хүрээлэн буй орчинд алдсан тухай дэлгэрэнгүй боловч товч, оновчтой тайлбар.


⇒ Гарч болзошгүй хор хөнөөлийн тухай товчхон мэдэгдэх / Short description/characteristics of possible risk and hazards. Бохирдлын улмаас гарч

болзошгүй эсвэл бодит эрсдэлийн тухай тэмдэглэл боловсруулагч ажилтны санал бодол: тухай газар нутаг байгаль орчин, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж эсвэл нөлөөлж болзошгүй вэ. Тухайн газар нутагт урьд нь ямар нэг судалгаа хийгдсэн бол уг мэдээллийг судалгааны тайлангийн дүгнэлтээс иш татаж оруулна.

⇒ Ач холбогдлын зэрэглэл / Priority Code. Ач холбогдлын зэрэглэлийг тогтоосны дараа газар нутгийн тэмдэглэлийн толгой хэсэгт автоматаар ач холбогдлын зэрэглэлийн код гарч ирэх бөгөөд ач холбогдлын зэрэглэлийн тэмдэг, үгэн тайлбар, хийх шаардлагатай арга хэмжээний тухай мэдээлэл дүрслэгдэнэ (Аргачлалын удирдамжийн R1 хүснэгтийг үзнэ үү).


⇒ Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох/Мэдээллийг дэлгэрэнгүй харуулах / Priority Classifying/See Detail. Боловсруулагч ажилтан системд ач холбогдлын зэрэглэлийг тогтоох комманд өгөхөд зориулсан товчлуур. “Дэлгэрэгэнгүйг харуулах” сонголтыг тэмдэглэснээр шинээр нээгдсэн цонхонд зэрэглэлийг өөрчлөх боломж бүхий ач холбогдлын зэрэглэлийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирнэ (Аргачлалын удирдамжийн R1 хүснэгтийг үзнэ үү). Хэрэглэгч ач холбогдлын зэрэглэлийг өөрчлөх хүсэлтэй байвал засварлах (edit) горимд ажиллах ёстой. Ач холбогдлын зэрэглэлийг тогтооход нөлөө бүхий мэдээлэл дутуу бөглөсөн бол системд зохих анхааруулга өгнө. Ийм тохиолдолд ач холбогдолд үнэлгээ өгөх боломжгүй байна. **Чухал анхааруулга!** Ач холбогдлын зэрэглэлийг тогтоохоос өмнө хийсэн өөрчлөлтийг хадгалж, хадгалагдсан өгөгдлийн засварлах (edit) горимд асаах шаардлагатай. Энэ шаардлага ач холбогдлын зэрэглэлд өөрчлөлт хийх шаардлагагүйгээр үнэлгээг дэлгэрэнгүй харуулахад хамаарахгүй.

⇒ Дурдсан эрсдэлийн үнэлгээнд тайлбар өгөх / Reasons for that Priority Classification. Энэ маягтын талбарт өөрчлөлт хийх боломжгүй. Агуулгыг нь ач холбогдлын зэрэглэл тогтоох дэлгэрэнгүй маягтаас шилжүүлсэн байх бөгөөд ач холбогдлын зэрэглэл үнэлгээ өгч буй ажилтан системээс автоматаар санал болгосноос өөр зэрэглэлийг тогтоохоор шийдсэн тохиолдолд талбар өөрчлөлт (edit) хийх зорилгоор чөлөөлөгдөж байна.



Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох / Priority Classification

Энэ багц шууд харагдахгүй, “Эрсдэл ба ач холбогдол” багц дотроос “Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох/Мэдээллийг дэлгэрэнгүй харуулах / Priority Classifying/See Detail“ товчлуур дээр дарснаар харагдах болно. Цэнхэр хүрээтэй талбарын хамгийн дээд талын мөрөнд боловсруулагч ажилтны бөглөсөн мэдээллийн үндсэн дээр системийн автоматаар санал болгосон ач холбогдлын зэрэглэл гарч ирсэн байна. Ач холбогдлын зэрэглэлийн утга учрыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны CSIS системийн аргачлалын удирдамжид дэлгэрэнгүй тайлбарласан байна. Товч тайлбарыг “Ач холбогдолд үнэлгээ өгөх – зэрэглэлийн системийг тайлбарлах, ач холбогдлын зэрэглэлийн кодын утга учрыг тайлах” бүлгээс үзнэ үү.



Цэнхэр хүрээтэй талбарын бусад мөрүүдэд тэмдэглэл боловсруулагч эсвэл мэргэжсэн хэрэглэгчид зориулсан тухайн газар нутгийн талаар ач холбогдлын зэрэглэлийг тогтооход чухал хүчин зүйлсийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл тавьсан байна. “Хорт нөлөөнд автаж болзошгүй хүмүүс” баганыг үзвэл газар доорх болон гадаргын усны бохирдол, тухайн газрын бохирдол эсвэл бохирдлыг ойр орчинд (0-с 3 хүртэлх зэрэглэл – тоо нь өндөр тусам хүний тоо их байна – ач холбогдлын зэрэглэлийн кодын тайлбарыг үзнэ үү) тархалтын улмаас хорт нөлөөнд автаж болзошгүй хүний тоо мэдэж авах боломжтой. “Нөлөөллийн ач холбогдол” баганад бохирдол юунд хамгийн ноцтой нөлөө үзүүлж байгаагаас гадна газар нутгийн бохирдсон байдал, бохирдлын ойр орчимд тархсан явдал хэр ноцтой (0-с 4 хүртэлх зэрэглэл – тоо нь өндөр тусам бохирдлын нөлөө их байна) болохыг заасан байна.

Тухайн газар нутагт ямар нэг дээжлэлт (судалгаа) хийгээгүй тохиолдолд дээрх аргаар зөвхөн цэнхэр хүрээтэй талбарын дунд хэсэг бөглөгдсөн байна (дээжлэлт хийгдээгүй газар = болзошгүй нөлөөлөл). Болзошгүй нөлөөлөл гэдэг бол газар нутаг үнэхээр бохирдсон гэж илэрсэн тохиолдолд түүний учруулж болзошгүй нөлөө. Тухайн газар

нутагт судалгаа хийсэн бол ач холбогдлын зэрэглэл тогтоох үед дээжлэлтийн бодит үр дүнг харгалзсан байх ба систем ач холбогдлын зэрэглэлийг судалгааны үндсэн дээр үнэлж тогтоодог. Үүний тулд тэмдэглэл боловсруулагч “бохирдол” багцыг дээрх үр дүнг үндэслэн зөв бөглөсөн байх шаардлагатай. Ач холбогдлын зэрэглэлийн үнэлгээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг цэнхэр хүрээтэй талбарын “Бохирдлын улмаас үүсч болзошгүй хэмээн батлагдсан үр дагавар” доод хэсэгт заасан байна (дээжлэлт хийсэн газар нутаг = “батлагдсан үр дагавар”).

Цэнхэр хүрээтэй талбарын доор санал болгож буй ач холбогдлын зэрэглэлийн буюу кодын эхний хоёр үсгийн тайлбар байх бөгөөд тэр нь тухайн газар нутгийн нөхцөл байдал, түүнийг үндэслэн хийвэл зохих арга хэмжээний талаар бичсэн байна.

Тэмдэглэл боловсруулагч ажилтан системээс санал болгож байгаа ач холбогдлын зэрэглэлийн саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол түүнийг багцын мөрүүдэд байгаа боломжийг сонгож авснаар (бөглөсөн өгөгдлийн үндсэн дээр бодит байдалд нийцэж болзошгүй боломжуудаас л сонгох боломжтой) өөрчилж болно. Тэмдэглэл боловсруулагч ажилтан ач холбогдлын зэрэглэлд яагаад өөрчлөлт хийсэн учир шалтгааныг багцын доод талын бичвэр оруулахад зориулсан талбарт тайлбарлана.

Системээс санал болгосон ач холбогдлын зэрэглэл болон хувилбарт саналууд бодит байдалд нийцээгүй тохиолдолд газар нутгийн паспортын ямар нэг талбарт оруулсан мэдээлэл бодит байдалд нийцэхгүй байж болзошгүй тул системд оруулсан мэдээллийг шалгах шаардлагатай. Ийм тохиолдолд паспортод хуучирсан мэдээлэл эсвэл мэдээллийг оруулаагүй орхигдуулсан байж болох юм. Судалгаа хийгээгүй газар нутгийн тэмдэглэлд газар нутгийн байдлыг болон санал болгож буй сэлбэн засах арга хэмжээг тодруулсан талбар, мөн бохирдол багц дахь талбарууд хэрхэн бөглөгдсөн байгааг шалгах шаардлагатай. Бохирдлын түвшин тодорхойгүй байж таарна.

Газар нутагт судалгаа хийсэн бол зарим талбарт “тодорхойгүй” гэж заасан эсвэл зарим мэдээлэл хоорондоо зөрж байгаа эсэхийг хянах шаардлагатай. Жишээ нь, хэмжээнээс хэтэрсэн бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний зэрэгцээ сэлбэн засах арга хэмжээ шаардагдахгүй эсвэл тухайн газрыг судлагдаагүй гэж заасан тохиолдолд.

Эцсийн шатанд багцын дээд хэсгийн баруун талд байгаа товчлуур дээр дарж өөрчлөлтийг батлана.

Секторууд

Зарим газар нутгийг янз бүрийн шалтгаанаар хэд хэдэн хэсгээр буюу секторуудад хуваах нь зохимжтой байдаг. Жишээлбэл, уул уурхайн нэг газрын хүрээнд лагийн нуур, машин, тоног төхөөрөмжийн ШТС-ыг тус тусд нь шийдвэрлэнэ. Товчлуурын нэрийн ард талд хаалтан дотор байгаа тоо нь тухайн газар нутаг хэдэн секторуудад хуваагдсныг зааж өгч байна. Хэрэгслийн самбар дахь Шинэ тэмдэглэл үүсгэх / Add new record товчлуур дээр дарснаар газрын зурган дээр полигоныг тэмдэглэн секторыг нэмж үүсгэнэ. Энэ товчлуур дээр дарснаар газрын зургийн цонх идэвхжиж идэвхтэй газрыг томруулан харуулна. Хулгана дээр хоёр дарж полигоныг түгжинэ (CSIS Map Editor-ын газрын зургийн цонхыг ашиглахыг үзнэ үү). Полигон түгжигдсний дараа автоматаар шилжиж ирсэн маягтын цонхонд секторын нэрийг бөглөнө. Секторын нэр 120 оронтой үсгээс хэтрэхгүй байна. **Чухал анхааруулга!** Ямар ч тохиодолд ямар ч бичвэр талбарт,

түүнчлэн нэрт, хашилт бичихийг хориглоно. Газрын нэрийн доор ямар нэг тайлбар – секторын тодруулга бичиж болно. Секторыг хадгалсны дараа хянахын тулд газрын зурган дээр дахин дүрслэгдэх нь зүйтэй. Секторыг тэмдэглэх зорилгоор доорх товчлуурыг ашиглана.

⇒ Байршлыг өөрчлөх / Change location. Уг хэрэгслийг ашиглан урьд нь үүсгэсэн эсвэл шинэ полигон зурах боломжтой газрын зургийн цонхонд шилжиж орно.

Секторууд газар нутгийн паспортод заасан сонирхол бүхий нутаг дэвсгэрийн хүрээнээс хэтэрсэн байж болно. Жишээ нь, секторт хорт нөлөөнд өртсөн байж болох газар доорх усны эх үүсвэр хамрагдах бол газар нутгийн сонирхол бүхий нутаг дэвсгэрт зөвхөн бохирдлын эх үүсвэр болох газар хамрагдана. Шаардлагатай тохиодолд секторууд давхцаж болно. Жишээлбэл, нэг хэсэг секторуудыг эзэмшигчдийн дагуу үүсгэж, нөгөө нэгийг нь нөхөн сэргээгдсэн талбай эсвэл бохирдлын голомтын дагуу үүсгэх боломжтой. Секторуудыг нэлээд эмзэг эсвэл хамгийн ноцтой хорт нөлөөнд өртсөн талбайг тэмдэглэх зорилгоор ашиглах боломжтой.

Холбогдох бичиг баримтууд / Related Documents

Газар нутагтай холбоотой бичиг баримт, тэдгээрийн жагсаалтыг агуулсан хүснэгтийн хамт хадгалах хэсэг. Энд газар нутгийн судалгааны эцсийн тайлан, сэлбэн засах арга хэмжээний үе шатны тайлан, тухайн газар нутагт холбогдсон албан тоот зэргийг хадгалдаг бөгөөд хүснэгтэд бичиг баримтын нэр, зохиогч, бичсэн он, сар өдөр зэргийг зааснаас гадна бичиг баримтын хураангуй зэрэг агуулгыг нь товч тайлбарлахад зориулсан бичвэр талбар бий. Уг маягтад хавсралтыг PDF файлаар хавсаргах боломжтой. Ийм хавсралтыг мэдээллийн сангаас дотоод компьютерт татаж, PDF файлын энгийн браузерээр үзэх боломжтой.

Бичиг баримт “Холбогдох бичиг баримтууд” гэсэн маягтад хадгалагдаагүй, харин мэдээллийн сангийн тусгай хэсэг болох бичиг баримтын номын санд хадгалагдсан байна. “Холбогдох бичиг баримтууд” гэсэн хэсэг номын санд хадгалагдсан бичиг баримттай холбох холболтын үүрэг гүйцэтгэж байгаа тул нэг бичиг баримт нэгээс илүү газар нутагт холбоотой байх боломжтой. Үүнийг бичиг баримтыг засварлахад анхааралдаа авч ажиллана.

“Холбогдох бичиг баримтууд” хэсэгт шинэ тэмдэглэл үүсгэх үед эхлээд номын санд байгаа бичиг баримтуудаас сонгох боломж олгоно. Шаардлагатай бичиг баримт номын санд байгаа тохиолдолд түүнийг сонгож аваад номын сангаас гарах үед уг баримт бичгийг тухайн газар нутагтай холбож өгнө. Тийм бичиг баримт номын санд байхгүй бол номын сангийн маягтын товчлуураар шинийг үүсгэж болно.

⇒ Номын санд оруулах шинэ бичиг баримт / New Document into Bookcase. Номын санд шинэ тэмдэглэл үүсгэсэн байна. Товчлуур гэрэлтсэн байх ба дээр нь дараах бичвэр гарна.

⇒ Номын санд хадгалах / Save into Bookcase. Бичиг баримтыг номын санд хадгалсны дараа маягтаас дараах товчлуурын тусламжтайгаар гарч болно.

⇒ Номын сангаас гарах / Exit Bookcase. Номын сангаас гарах үед систем баримт бичгийг газар нутагт холбож өгөхийг хүсч байгаа эсэхийг хэрэглэгчээс асууна.

Баримт бичгийг тухайн газар нутагт холбосон байвал түүнд нэмэлт өөрчлөлт хийхийн тулд номын санд орох шаардлагагүй. Засварлахаас сэргийлэх үүднээс түгжигдсэн бичиг баримтад өөрчлөлт хийх боломжгүй.

Хэрэглэгч баримт бичигтэй холбогдох дараах талбаруудыг бөглөнө.

⇒ Бичиг баримтын нэр / Document Name. Баримт бичгийн бичвэр хэлбэр бүхий нэр 200 оронтой үсгээс хэтрэхгүй. Нэр нь түүнээс илүү үсгээс бүрдсэн байвал талбарт түүний хамгийн оновчтой хэсгийг оруулна.

⇒ Бичиг баримтын төрөл / Type of the Document. Цэснээс сонголт хийж бөглөнө.

⇒ Бичиг баримтын зохиогч / Document Authors. 120 оронтой үсгээс илүүгүй бичвэр талбарт зохиогчийн овогийн үсгийн дараа цэг тавиад бүрэн нэрийг нь бичнэ. Зохиогч нэгээс илүү хүн байвал нэрийнх нь ард таслал тавина. Бүх зохиочдын нэр нь уг талбарт багтахгүй, олон байх тохиолдолд гол зохиогчдын нэрийг бичээд хамтын бүтээл болохыг илэрхийлсэн товчлолыг бичнэ. Жишээ нь, „Torricelli E., Viviani V. et al.“

⇒ Гаргасан / published. Бичиг баримтыг гаргасан огноо. Зөвхөн он нь тодорхой байвал огноо тухайн оны сүүлийн өдрийг оруулна (жишээ нь, 31.12.2015.). Бичиг баримтыг гаргасан он, сар тодорхой байвал тухайн оны тухайн сарын сүүлийн өдрийг оруулна (жишээ нь, 28.02.2015).

⇒ Гаргасан байгууллага / Published by. Бичиг баримтыг гаргасан байгууллагын нэрийг оруулна. Гаргасан байгууллага нь нэгээс илүү байгаагаас гадна байгууллагын нэр нь урт байх тохиолдолд байгууллагыг харилцах этгээдийн бүлэгт оруулаад уг талбарт холбоосыг нь бөглөнө. Уг талбарт оруулах бичвэр 120 оронтой үсгээс илүүгүй байна.

⇒ Дугаар - байвал / Reference Number - if exist. Энэ нь ялангуяа шийдвэр, тогтоол, бусад албан тоотод чухал байдаг. Уг талбарт оруулах бичвэр 180 оронтой үсгээс илүүгүй байна.

⇒ Архивын дугаар / Archive No. Уг талбарт мэдээлэл заавал оруулах албагүй. Энгийн архивуудад хадгалагддаг баримт бичгийн дугаарыг оруулахад тохиромжтой. Уг талбарт дугаарыг оруулсан тохиолдолд тайлбарт бичиг баримт хадгалагддаг архивын газрын нэрийг тодруулах шаардлагатай. Уг талбарт оруулах бичвэр 50 оронтой үсгээс илүүгүй байна.

⇒ Бусад шинж тэмдэг / Further characteristics. Баримт бичгийн хураангуйг оруулахад зориулсан талбар. Товч хураангуй, хамгийн чухал дүгнэлтийг оруулна.

⇒ Filename. Хавсрагдсан файл оруулсан бол түүний нэрийг бичнэ. Хэрэглэгч үүнийг бөглөхгүй, хавсралт бөглөсөн байвал систем автоматаар бөглөнө.

⇒ Appendix. PDF формат бүхий бичиг баримтын хавсралт. Энэ хавсралтыг хожим төв мэдээллийн сангаас татаж аваад дотоод компьютерийн сонгосон хавтсанд хадгалах боломжтой бөгөөд шаардлагатай үед PDF файлд ашигладаг браузераар нээнэ. Хавсралтыг дараах товчлуураар өөрчлөх боломжтой.

⇒ Хавсралтыг шинэчлэх / update the Appendix.

⇒ Баримт бичгийн хавсралтыг татаж авахад маягтын ногоон сумтай илгээмжийн дүрсийг ашиглана.

Газар нутгийн судалгааны эцсийн тайлангийн товч хураангуйн жишээ:

Байгаль орчны бохирдлыг цэвэршүүлэх ажилд ноу-хау нэвтрүүлэх" CzDA-MN-2012-18-41010 төслийн хүрээнд Dekonta ХК ба Geomin ХХК-ны нэгдсэн баг бохирдлын урьдчилсан /анхан шатны/ судалгааг хийсэн. Судалгааны ажлын хүрээнд 2014 оны 8-р сарын 9-ний өдөр тухайн газрын хөрснөөс 8 дээж авсан /газрын гадарганаас болон 0,8 м-ийн гүнд сорьцын профилоос/ ба мөн гадаргын уснаас 2, газрын гүний уснаас 1 дээж авсан. Тухайн газрын хөрс нь хамгийн багадаа 180 см-ийн гүн хүртлээ бохирдсон ба гадаргын уснууд нь нефтийн нүүрстөрөгчүүд болох ТРН, РАН болон хүнд төмөрлөгүүдээр бохирдсон нь тогтоогдсон. Нарийвчилсан судалгааны ажил хийхийг санал болгосон.

Харилцах мэдээлэл / Contacts 

Газар нутагтай ямар нэгэн байдлаар холбоотой хувь хүн, байгууллагын нэр болон харилцах мэдээлэл (эзэмшигч, үйл ажиллагаа эрхлэгч, бохирдол үүсгэгч, мэдээлэл авсан аль нэг байгууллагын этгээд, г.м). Баримт бичгүүдийнхтэй мөн адил, харгалзах харилцах мэдээллийн маягтуудад шууд хадгалагддаггүй, харин төв лавлах санд хадгалагддаг учир нэг харилцах мэдээлэл олон газруудтай холбогдож болно. Баримт бичгээс ялгаатай нь гэвэл газар тус бүрт харилцах мэдээллийг олон удаа холбох боломжтойн зэрэгцээ харилцах мэдээлэл бүрт аль газар нутаг дээрх үүргийг, бас газар нутаг дээр дурдсан үүргийг гүйцэтгэх ёстой эсхүл гүйцэтгэх байсан хугацааг нөхөж болно. Жишээ: ABC компани лавлах санд бүртгэгдсэн. Х газар дээр 1996-аас 1998 он хүртэл судалгааны байгууллага үүрэгтэйгээр ажилласан бөгөөд тус газар дээр 2014 оноос эхлэн одоог хүртэл нөхөн сэргээх байгууллагын үүрэгтэй ажиллаж байгаа. Y газар дээр 2004 оноор хойш одоог хүртэл эзэмшигчийн үүрэгтэй болно.

Лавлах сангийн хүснэгт дараах талбаруудыг агуулна:

⇒ Байгууллага/Хүний нэр / Company/Person Name. Хувь хүн эсвэл албан байгууллагын нэр. 150 хүртэлх тэмдэгт бүхий текст.

⇒ Улс / Country. Улсын нэр. 50 хүртэлх тэмдэгт бүхий текстийн талбар.

⇒ Гудамж, байр / Street and number. 120 хүртэлх тэмдэгт бүхий текстийн талбар.

⇒ Аймаг, сум, нийслэл / Municipality. Суурьшил эсвэл оршин суугаа газрын тэмдэглэгээ. 80 хүртэлх тэмдэгт бүхий текст.

⇒ Шуудангийн код / Zip code. Газрын таних код. 10 хүртэлх тэмдэгт бүхий текст (текст гэж үсгэн тэмдэгтүүд юм).

⇒ Хүн / Person. Шаардлагатай бол албан байгууллагын тодорхой нэгэн хүний тухай нөхөж бичихэд зориулсан талбар. Хариуцлагатай төлөөлөгч. 120 хүртэлх тэмдэгт бүхий текст.

⇒ Утас / Phone No. Утасны дугаар бичихэд зориулсан хоёр талбар. Тус бүр 25 хүртэлх тэмдэгттэй.

⇒ И-мейл 1, 2 / e-mail 1, 2. Хоёр и-мейл хаяг бичих боломж. Хоёр текстийн талбар, 120 хүртэлх тэмдэгттэй.

⇒ Бусад шинж тэмдэг / Further characteristics. Харилцах мэдээлэлд нэмэлт мэдээлэл оруулахад зориулсан текстийн талбар.

Харгалзах харилцах мэдээллийн маягтад холбогдсон мэдээлэлд дараах талбаруудыг оруулах боломжтой:

⇒ Газар дээр гүйцэтгэсэн үүрэг / Role/function on the Site. Дурдсан хугацааны туршид газар нутаг дээр гүйцэтгэсэн үүргийн тодорхой нэршил. 50 хүртэлх тэмдэгттэй текст.

⇒ эхэлсэн огноо / date from. Газар нутаг дээрх тухайн харилцах мэдээллийн үүрэг гүйцэтгэгдэж эхэлсэн огноо. Хэрэв зөвхөн он нь мэдэгдэж байвал оны эхний өдрийг бичнэ.

⇒ дууссан огноо / date until. Газар нутаг дээрх тухайн харилцах мэдээллийн үүргийн дууссан огноо. Хэрэв үүрэг хэрэгжсэн хэвээр байгаа бол талбарыг бөглөхгүй. Хэрэв зөвхөн дууссан он нь мэдэгдэж байвал оны сүүлийн өдрийг бичнэ.

Фото баримтын зурган хавсралт / Hooked ilustrations Photos 

Зөвшөөрөгдсөн формат бүхий зурган хавсралт оруулахад зориулагдсан хүснэгт (фото зураг, график, газрын зураг гэх мэт). Зургуудыг шууд нээн үзэж болно. Зураг дээр товшсоноор түүний хэмжээ зургийн нягтралын хэмжээгээр томорно. Дахин товшсоноор түүний анхны хэмжээнд буцна. Хүснэгт нь анхдагч мэдээллийн бүртгэлтэй төстэй. Зурган хавсралтын хүснэгтийг үзнэ үү.

Баримтжуулалтын цэгүүд / Documentation Points 

Таних тэмдэглэгээ болон баримтжуулалтын цэгүүдийн солбилцлуудад зориулсан хүснэгт – бохирдлын шинжилгээнд зориулан дээж авсан хамгийн түгээмэл газрууд (цооногийн эсвэл ус түгээх өөр цэг эсхүл объектуудын) эсхүл ажиглалтын цэгүүд. Баримтжуулалтын цэгүүд орших нь дээжүүд ба ажиглагдах утгуудын бүртгэлийн нөхцөл юм. Шинэ баримтжуулалтын цэгийг үргэлж газрын зургийн цонхон дээр, хүснэгтийн цонхны хэрэгслүүдийн самбараас „Шинэ тэмдэглэл нэмэх“ товчлуурыг дарсны дараа оруулна. Хүснэгтэнд мөн цэгийн байршлыг өөрчлөх боломжтой товчлуур бий. Далайн түвшний солбилцол Z газрын зургаас шууд автоматаар хасагдана. Гэхдээ хэрэглэгч түүнийг хүснэгтэнд нарийвчлан тодорхойлж болно.

Баримтжуулалтын цэг дараах зүйлүүдийг агуулна:

⇒ Баримтжуулалтын цэгийн нэр / Documentation Point Name. Баримтжуулалтын цэгийн товч бөгөөд тодорхой нэршил. Текстийн урт 25 хүртэлх тэмдэгттэй байна. Зөвлөхүйц тэмдэглэгээ нь үсгэн товчлол, дундуур зураас, тоон тэмдэглэгээ зэргээс бүрдсэн, шаардлагатай бол нэмэлт текстгүй байж болох бөгөөд зайгүй байна. Форматын экспорт, импортын улмаас нэр ямар нэгэн зайтай байх нь тохиромжгүй. Зайны оронд доогуур зураасыг ашиглаж болно. Жишээ: „HB-27c_North“.

⇒ төрөл / type. Баримтжуулалтын цэгийн төрөл. Меню цэснээс сонгоно. Хүснэгтэнд зөвхөн дөрвөн тэмдэгтээс бүрдсэн, цэгийн төрлийн товчлолыг оруулна.

⇒ Секторууд/ sectors. Талбарыг бөглөхгүй байж болно. Гэвч баримтжуулалтын цэг бүр энэхүү аргаар сонгогдсон секторт ангилагдах боломжтой. Меню цэснээс сонгоно.

⇒ Бусад шинж тэмдэг / Further characteristics. Чөлөөт текстийн талбар, ж.нь: цооногийн тэмдэглэл гэх зэргийг бичих боломжтой.

Ашигласан мониторингийн загварууд / Used monitoring models 

Мониторингийн хүснэгт системийн хамгийн хүнд хэсэгт багтдаг. Энд газар нутаг дээр хийж гүйцэтгэгдсэн ажиглалт, судалгааны төрлүүдийн жагсаалт бий. Эдгээр параметруудын ажиглалт, судалгаануудыг мониторинг хэмээн нэрлэдэг. Мониторинг тус бүрт ажиглалт хийгдсэн (зайлшгүй бус) сектор болон мониторингийн давтамжийг нарийн тодорхойлох боломжтой.

Мониторинг тус бүр:

⇒ Мониторингийн нэр / Monitoring Name. Дүрсэлсэн нэр, ж.нь: шалтгаан эсвэл тодорхой газар. 200 хүртэлх тэмдэгттэй.

⇒ давтамж / frequency. Цэснээс сонгоно.

⇒ Сүүлийн утгууд / Last values. Энэхүү мониторингийн утгуудын сүүлийн тэмдэглэлийн огноо ба цаг. Систем автоматаар бөглөдөг. Хэрэв мониторинг ашиглагдаагүй бол талбар хэрээсээр дарагдсан байна.

 Мониторингийн тэмдэглэл тус бүрт мониторингийн нэг загвар холбогдоно. Ажиглалтын загварууд загварын санд хадгалагдана. Үүний зэрэгцээ нэг загварт олон тэмдэглэл оруулах боломжтой. Ажиглалтын загвар үргэлж тодорхой орчинд (орчин – GW, SW, SM) зориулсан мониторинг хийвэл зохих зүйлүүдийн жагсаалтаар тодорхойлогддог. Энэхүү загварын тусламжтайгаар дээжийн ба утгуудын хэсэгт хүснэгтийн маягт үүсч, түүнд утгуудыг оруулан бичдэг. Хүснэгтийн багануудын дарааллыг загварын тусламжтайгаар өөрчлөх боломжтой, түүнийг дахин ашиглах үеэр өөрчлөгдсөн маягт үүснэ. Загвар шинэ тэмдэглэл нэмснээр эсвэл ямар нэгэн мониторинг байгаа бол мониторингийн хүснэгт дээрх товчлуурыг ашигласнаар нээгдэнэ:

⇒ Загварын дэлгэрэнгүй агуулга / Model Detail. Уг товчлуураар загвар тус бүрийн каталог нээгдэнэ. Каталогд загваруудыг зөвхөн сонгогдсон орчинд зориулан шүүж болно.

Загвар тус бүр дараах утгуудтай байна:

⇒ Загварын нэр / Model Name. Ажиглагдаж буй зүйлүүдийн товч тайлбар . Ж.нь: „Гүний усан дахь хүнд металл“ Хэрэв тэмдэглэл хэт өргөн биш бол мониторинг хийгдэж буй зүйлүүдийн жагсаалтыг ч ашиглаж болно. 240 хүртэлх тэмдэгттэй текст.

⇒ Судлагдаж буй бодис / Monitored medium. Судлагдаж буй бодисын товчлол (орчин – GW, SW, SM – “Орчин” сэдвийг үзнэ үү).

⇒ Утгын нэр / Item name. Химийн эсхүл физикийн хэмжигдэхүүн байж болох утгын англи нэр эсвэл тайлбарын талбар. Меню цэснээс сонгоно.

⇒ нэгж / units. Сонгосон орчин ба сонгогдсон утгууд дээр үндэслэн систем автоматаар бөглөнө. Өгөгдсөн орчинд ажиглагдсан утгуудын нэгжүүд. Хэрэв утгууд хэмжээсгүй бол автоматаар „dimensionless“ гэсэн илэрхийлэл нөхөгдөх юм.

⇒ товчлол / abbreviation. CSIS-д уг утгад зориулсан товчлол ашиглагддаг. Товчлолууд нь нэг талаас мэдээллийн сангийн динамик хэсгийн удирдлагад, нөгөө талаас загвараар бүтээсэн хүснэгтийн маягтуудын баганын товч гарчигт шаардлагатай. Систем утгуудын сонголт дээр үндэслэн автоматаар нөхөгднө.

⇒ бусад нэр / other names. Систем автоматаар нөхөгднө. Зарим химийн хэмжигдэхүүнүүдэд олон янзын нэр болон товчлол ашиглагддаг. Энэ мэдээлэл нь утгуудыг хялбархан хайж олох шалтгааны улмаас дурдагддаг.

⇒ дэс дараалал / order. Утгуудын дэс дарааллыг хэрэглэгч өөрийн хэрэгцээний дагуу өөрчилнө. Утгуудын дэс дараалал хэрэглэгч утгуудыг загварт хэрхэн оруулснаар өгөгднө. Энэхүү дарааллыг дараа нь сонгосон утга тус бүрт дээшээ доошоо чиглэсэн сумаар өөрчилж болно. Дэс дарааллыг загвар ашигласны дараа болон шинжилгээний маягт үүсгэсний дараа ч өөрчлөх боломжтой. Түүнийг өөрчлөгдсний дараа маягт шинээр үүснэ.

Загвар бүтээж эхлэхийн тулд загваруудын каталогоос дараах товчлууруудыг ашиглана:

⇒ Каталоги - шинэ загвар / Catalog - New Model.

Уг товчийг дарснаар **загварчлах систем - загвар бүтээх ба өөрчлөх хүснэгт**

Загварчлах систем нь загвар үүсгэж эхлэх ба өөрчлөх зориулалттай хоёр хүснэгт, нэг товчлууртай:

⇒ CSIS-ийн бүртгэгдсэн утгуудын каталог бүхий зүүн талын хүснэгт. Энэ каталог системийн удирдлагыг зохицуулдаг. Хэрэв хэрэглэгч шаардлагатай утгаа олохгүй бол удирдлагаас түүнийг нөхөх тухай хүсэлт гаргана. Ийм тохиолдолд утгуудын нэр, түүний ашиглагддаг товчлол, байж болох бусад нэрс, хэрэв байдаг бол түүний CAS (Chemical Abstracts Service) дугаар, орчин тус бүрт хэвийн ажиглагдаж буй утга бүхий нэгжүүд (зөвхөн заримд нь л ажиглаж болохуйц), хэрэв орчин тус бүрт хязгаар утгууд байдаг бол эдгээр хязгаарууд, CSIS-ийн дагуу түүнд утгыг ангилан оруулбал зохих бүлэг.

⇒ сонгогдсон утгуудтай баруун талын хүснэгт. Хэрэглэгч уг хүснэгтэнд зүүн талын хүснэгтээс өөрийн эцсийн хүснэгтэндээ бүртгэлийн зорилгоор оруулахыг хүссэн утгуудыг сонгоно. Эдгээр утгуудыг эцсийн хүснэгтийн баганууудын байвал зохих дэс дарааллаар сонгоно. Сонголтыг „Өөрчлөлтийг эхлүүлэх / Start Modifying“ товчлуурыг дарж эхлүүлнэ. Сонголтыг зүүн талын хүснэгтийн эцсийн баганад өөрчлөлт эхэлсний дараа харагдах ногоон сумаар гүйцэтгэнэ. Энэ хүснэгтэн дэх мөрний дэс дараалал утгуудын (шинжилгээ гэх зэрэг) эцсийн хүснэгт дэх баганууудын дэс дараалалтай нийцсэн байна. Хэрэв хэрэглэгч дэс дараалал

өөрчлөхийг хүсч байвал тухайн мөрний баруун талд байрлах мөрийг дээш зөөх сум эсвэл мөрийг доош зөөх сумыг ашиглана.

⇒ Өөрчлөлтийг эхлүүлэх товчлуур / Start Modifying. Энхүү товчлууруар хэрэглэгчийн загварыг эхлүүлж, цаашлаад хадгална. Загварын өөрчлөлтийг эхлүүлэх үед танд нэн түрүүнд загварын нэрийг бүрэн гүйцэт, товч тодорхой бөглөхийг сануулна. Мөн товчлууруар загварыг хадгална. Загварт байж болох утгуудын зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээ 60. Гэвч бид хүснэгтийг утгуудаар үргэлж бүрэн гүйцэт дүүргэсэн байх, мөн мэдээллийн санд хоосон талбар дэмий оруулахгүйн тулд олон жижиг загварууд үүсгэхийг зөвлөж байна. Ийм арга цөөн хэдхэн утгууд оруулсан том хүснэгтүүдэд элбэг тохиолддог.

Загварчлах системээс гарахдаа дараах товчлууруудыг ашиглана

⇒ Загварчлах системээс гарах / Exit modeler.

Загварчлах системээс гарсны дараа хэрэглэгчид хамгийн сүүлд боловсруулсан загвар бүхий каталогийн хүснэгт дахин харагдах болно. Утгуудын жагсаалтыг хянан шалгах үүднээс үзэх боломжтой. Утга тус бүрийн тухай дэлгэрэнгүй агуулга хүснэгтийн зүүн доод хэсэгт дүрслэгдэнэ.

⇒ Утгын дэлгэрэнгүй агуулга / Item detail.


Дээж + утга / Samples + Values

Оршиж буй баримтжуулалтын цэгүүд ба оршиж буй газар нутгийн мониторинг дээр үндэслэн баримтжуулалтын цэг бүрт сонгогдсон мониторингд харгалзах угуудыг нөхөн оруулж болно. „Дээж + утга“ товчлуурыг дарсны дараа хүснэгтийн самбар дээр (Хүснэгтийн самбар-ыг үзнэ үү) нэн түрүүнд газар дээр орших **мониторингийн жагсаалт бүхий сонголтын хүснэгт** гарч ирнэ. Хэрэглэгч загварын дэлгэрэнгүйг загваруудын каталогийн хүснэгтэнд байдагтай ижилээр үзэж болно. Мониторинг тус бүрийн мөрүүд ажиглагдаж буй орчныхоо төрлөөс шалтгаалан өнгөний хувьд харилцан адилгүй байна. Хэрэв хэрэглэгч ямар ч загвар дээр үргэлжлүүлэн ажиллахыг хүсэхгүй байвал „Дээж + утга“ гэсэн гэрэлтэй товчлуурыг дарж хүснэгтийг хаана. Хэрэв загвар тохирч байвал хэрэглэгч дараах товчлуурыг даран үргэлжлүүлнэ:

⇒ Дээж / Samples.

Товчлуурыг дарсны дараа программ маягтын загварын тусламжтайгаар хүснэгт бий болгож түүн дээр үндэслэн дээжүүд ба тэдгээрийн утгуудыг оруулахад зориулсан хэрэглэгчийн хүснэгт үүсгэнэ. Хүснэгтийн мөр тус бүр нэг дээжийг төлөөлнө. Заавал байвал зохих эхний баганыг эс тооцвол хүснэгтийн багана тус бүр хэрэглэгчийн загварт тодорхойлогдсон ажиглагдах утгыг төлөөлнө. Хүснэгтийн ойлгомжтой байдлын үүднээс зөвшөөрөгдөх баганын тоо хамгийн ихдээ 60. Утга тус бүрийн тайлбар (химийн бодис гэх мэт) зөвхөн англи хэл дээр байна.

Хүснэгтэн дээр дараах хоёр товчлуур бий:



⇒ Database “Мэдээллийн сан”

⇒ External Table „Гаднах хүснэгт”

Хүснэгтийг нээсний дараа „Database“ гэсэн товчлуур гэрэлтэх бөгөөд энэ нь хэрэглэгч хүснэгтийн маягтын түүнд олгож буй мэдээллийн сангийн утга бүрт нийцэн ажиллаж байгаа гэсэн үг юм. Энд хүснэгтийн багана бүр үнэн хэрэг дээрээ мэдээллийн сангийн огт өөр хэсэгт оршдог болохыг анхаарах нь зүйтэй. Хэрэв хэрэглэгч энэхүү цонхноос жинхэнэ хүснэгт үүсгэхийг хүсвэл „External Table“ товчлуурыг ашиглах бөгөөд хүснэгтийн хуулбарыг дискэн дээр, зөвхөн нэг хавтсанд хадгалж болно. Энэ сонголт өгөгдлийн экспорт, импорт хийх боломжийг олгодог.

Хэрэв хэрэглэгч тэмдэглэл оруулахыг хүсвэл хэрэгслийн самбараас „Шинэ тэмдэглэл үүсгэх / Add new record“ товчлуурыг ашиглана.

Нэн түрүүнд газар дээрх **баримтжуулалтын цэгийн сонголтын хүснэгт** гарч ирнэ.

Сонголтын хүснэгт хоёр хүснэгтээс бүрддэг. Зүүн талд газар дээр орших баримтжуулалтын цэгийн жагсаалт, баруун талд хэрэглэгчийн сонгосон баримтжуулалтын цэгүүд байна. Сонголтыг загварчлах системийнхтэй адилаар, зүүн талын хүснэгтийн сүүлчийн багана дахь ногоон сумны тусламжтай хийж гүйцэтгэнэХэрэв хэрэглэгч тэмдэглэл оруулахыг хүсвэл хэрэгслийн самбараас „Шинэ тэмдэглэл үүсгэх / Add new record“ товчлуурыг ашиглана.

Нэн түрүүнд газар дээрх **баримтжуулалтын цэгийн сонголтын хүснэгт** гарч ирнэ.

> Сонголтын хүснэгт хоёр хүснэгтээс бүрддэг. Зүүн талд газар дээр орших баримтжуулалтын цэгийн жагсаалт, баруун талд хэрэглэгчийн сонгосон баримтжуулалтын цэгүүд байна. Сонголтыг загварчлах системийнхтэй адилаар, зүүн талын хүснэгтийн сүүлчийн багана дахь ногоон сумны тусламжтай хийж гүйцэтгэнэ.

Дараах товчлуур дээр дарснаар

⇒ Энэ баримтжуулалтын цэгүүдэд дээжийг хавсаргах / Add samples to this documentation points

дээжийн хүснэгтэнд сонгогдсон баримтжуулалтын цэг бүрт нэг мөр нэмэгдэнэ. Нэмэгдсэн эгнээнүүд хадгалагдах хүртэл болон ихээхэн хэмжээний дээжүүд байх тохиолдолд хэрэглэгчийг хүснэгтэнд чиг баримжаа сайтай байлгах үүднээс өнгөөр ялгагдсан байна.

⇒ Цуцлах / Cancel гэсэн товчлууруар

үйлдлийг зогсоож болно.

Дээж тус бүрт дээжлэлт хийгдсэн огноо ба цагийг дурдсан байх ба дээж авсан цэг – баримтжуулалтын цэгийг тодорхойлсон байна. Хэрэв гүн, урт гэх мэтийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол эдгээр параметруудыг хүснэгтийн маягт үүсгэх зорилгоор загварт нэмж оруулах нь зүйтэй.

Хүснэгтэд курсор, табелатор, Enter товч гэх зэргээр шилжих боломжтой. Тэгээс бага утгатай тоон талбарыг зөвхөн аравтын таслалаар, таслалын арын утгаар оруулан бичиж болно. Өмнөх тэгийг бичих шаардлагагүй. Огноог мөн адил тусгаарлагч тэмдэггүйгээр бичиж болно. Өөрөөр хэрбэл, өгөгдлийн талбарт бичсэн „311204 нь автоматаар „31.12.2004“ болж хувирах бол „010485“ нь 01.04.1985 болж хувирна.

Утгаас бага „<” тэмдэг нь тоон талбарт бичигдэж болохгүй текстийн тэмдэгт юм. Хэрэв хязгаараас доогуур утга буюу <0,001 бичих шаардлагатай байвал шууд 0.001, харин талбарт -0,001 гэсэн утгыг бичээрэй.

Чухал анхааруулга! Шинжилгээ хийгдээгүй болон тэг гэсэн утга нь огт ялгаатай зүйлүүд болохыг анхаарна уу. Тэг гэсэн утга нь жишээлбэл тухайн бодисын бохирдол байхгүй эсвэл мэдээллийн сангийн талбарын мэдрэг чанараас бага утгатай байгаа гэсэн үг. Хоосон талбар (зурааслан дарсан) нь утга байхгүйг төлөөлж буй хэрэг. Дээжлэлт хийгдээгүй гэх мэт. Энэ утгыг мэдээллийн санд „NULL“ гэсэн тусгай тэмдгээр хадгалдаг ба дээгүүр нь зурааслан дарсан талбараар илэрдэг. Хэрэв та тоон талбарт санаандгүй утга оруулсан, түүнийг арилгах өөрөөр хэлбэл талбарт „NULL“ гэсэн утга оруулах шаарлагатай байвал талбар дээр ердийн гарнаас Ctrl-0 гэсэн товчийг хослуулан дарна (тоон хэсэгт бус).

Дээжийн импорт

Дээжийн импорт зөвхөн гадны хүснэгтэнд хэрэгжих боломжтой. Уг хүснэгтийг дээжийн маягт дээрх „External Table“ товчийг дарж үүсгэнэ. Хүснэгт нь загварын үүсгэсэн маягтын дагуу бат бэх бүтэцтэй. Талбарын бүтэц нь мэдээллийн сангийн бүтэцтэй төстэй учир импортлосон хавтасыг мэдээллийн сангийн гадуур ч аюулгүй шалгах боломжтой.

Импортын өмнө гадны хүснэгт рүү ямар нэгэн дээжийн тэмдэглэлийг оруулж, түүнийг CSV (comma separated values) болон XLS форматуудад экспортлох нь тохиромжтой. Хэдийгээр өөр бусад форматууд руу экспортлох боломжтой боловч импортыг зөвхөн энэ стандарт форматуудаас хийхийг зөвшөөрдөг, цаг хугацааны туршид өөрчлөгддөггүй боловч XLS ба XML форматууд нь тоо томшгүй олон байдаг бөгөөд ашиглагдаж буй программ хангамжийнхаа төрлөөс төдийгүй, үйлдлийн системийн үндэсний тохируулгаас хамаарч ялгаатай байдаг.

Хүснэгтийн бүх баганууд экспортлогдох болно. Харин импортлоход экспортлогдсон бүх баганыудыг ашиглах шаардлагагүй. Баганууд нь тухайн форматыг дэс дарааллаас эхлээд ажиглагдаж буй орчны товчлолыг (GW, SW, SM) тэмдэглэсэн багана хүртэл яг хэвээрээ хадгалагдах шаардлагатай. Үүнээс хойш орших бүх баганыудыг арилгана уу. Хэрэв та импортлосон утгуудын баримтжуулалтын цэгүүдийн нэршил тодорхой эсэхэд эргэлзэж байвал (ж.нь: ижилхэн нэрлэгдсэн хоёр цэг) „dcmntpt_id“ баганад баримтжуулалтын цэгүүдийн ялгах тэмдгийг нөхөж оруулна уу. Багана хүснэгтийн дурдагдсан дарааламд хэвээр үлдэх ёстой.

Хэрэв та N утгуудаас загвар үүсгэвэл уг загварын дагуу үүссэн гадны хүснэгт дараах форматад байвал зохино:

1. Баримтжуулалтын цэгийн нэр CSIS мэдээллийн сан дахь нэрийн дагуу байна
2. CSIS мэдээллийн сангийн дагуу дээжийн дугаар (бөглөх хэрэггүй! импортын дараа автоматаар нөхөгдсөн байна)
3. дээж авсан огноо ба цаг DD.MM.YYYY HH:MM:SS форматаар, буюу ж.нь: 03.11.2014 00:00:00
4. N хүртэлх – ажиглах утгууд загварт дурдагдсан сонголт ба дарааллын дагуу

N+1 орчны товчлол

N+2 загварын ялгагч тэмдэг (бөглөх хэрэггүй, баганын агуулгыг арилгаж болно)

N+3 мониторингийн ялгагч тэмдэг (бөглөх хэрэггүй, баганын агуулгыг арилгаж болно)

N+4 баримтжуулалтын цэгийн ялгагч тэмдэг (Хэрэв та баримтжуулалтын цэгүүдийн нэрс мэдээллийн сан дахь нэрстэй таарч байгаа эсэхэд эргэлзэж байгаа эсвэл мэдээллийн санд ийм нэртэй хоёр баримтжуулалтын цэг байвал бөглөнө үү.)

N+5 ба бусад баганууд ыг арилгаж болно.

Хэрэв та импортод хүснэгт бэлтгэж байгаа бол экспортлогдсон XLS ба CSV хавтасуудыг шалгаж үзнэ үү. Талбар бүр цэгтэй таслалаар, аравтын орон аравтын таслалаар тусгаарлагдсан, текстүүд ишлэлээр хаагдсан эсэхийг тус тус нягтлан үзнэ үү.

Огноо ба цаг DD.MM.YYYY HH:MM:SS форматтай байх ёстой буюу ж.нь: 03.11.2014 00:00:00

Чухал анхааруулга! Дээжийн дугаарын баганыг бөглөх хэрэггүй. Баганыг хоосон үлдээнэ үү. Шинэ дээжүүдийн дугаар мэдээллийн санд уншигдаж дууссаны дараа нөхөгдөх юм. Хэрэв та зарим утгуудыг оруулахыг хүсэхгүй, талбарыг хоосон үлдээх шаардлагатай байвал шууд цэгтэй таслал бичнэ үү. Хоосон талбар нь хоёр цэгтэй таслалын хоорондох хоосон утгаар илэрхийлэгдэнэ (;;).

Жишээ:

Хэрэв лабораторооос ирсэн хөрсний задлан шинжилгээний XLS хүснэгтэн дэх утгууд дараах дэс дараалалтай байвал:

1. дээжийн тэмдэглэгээ
2. дээж авсан цаг
3. As
4. Cd
5. Cr

SM орчинд „дээжийн тэмдэглэгээ, As,Cd, Cr" агууламжинд нийцсэн, дурын дэс дараалалтай загварыг хайна уу (дээж авсан цаг үргэлж өөрчлөгдөшгүй байх бөгөөд дээжийн бүртгэлийн зайлшгүй хэсэг юм). Лабораторооос ирсэн хүснэгтээс ялгаатай нь гэвэл баримтжуулалтын цэгийн тэмдэглэгээ (эсвэл ялгагч тэмдэг) зайлшгүй хэсэг мөн. Хэрэв ийм загвар байвал лабораторын хавтсанд нийцүүлэн дарааллыг засна уу, өөрөөр хэлбэл эхнийх нь арсен, сүүлийнх нь хром. Хэрэв ийм загвар байхгүй бол SM-д зориулан шинийг үүсгэнэ үү.

Загвар дараах агуулгатай:

1. дээжийн тэмдэглэгээ лабораторын дагуу (текст бол текстийн талбар ашиглагдсан байна)
2. As
3. Cd
4. Cr
5. Дээжийн хүснэгтийг уг загварын тусламжтайгаар нээнэ үү. Дурдагдсан дараалал бүхий баганууудтай шинэ маягтыг загварчлана.
6. Гадны хүснэгт үүсгэж түүнийг XLS форматад экспортолно уу. Байвал зохих дэс дараалал

1. Баримтжуулалтын цэгийн нэр CSIS мэдээллийн сан дахь нэрийн дагуу байна
2. CSIS мэдээллийн сангийн дагуу дээжийн дугаар (бөглөх хэрэггүй !)
3. дээж авсан огноо ба цаг
4. лабораторийн дагуух дээжийн тэмдэглэгээ (текст бол текстийн талбар ашиглагдсан байна)
5. As
6. Cd
7. Cr

Лабораториос ирсэн хүснэгтийг ижил дараалалтай баганууд тай болгон өөрчлөх буюу дээжийн тэмдэглэгээ ба дээж авсан цагийн байрыг солино. Хүснэгтийг экспортлосон хавтас руу огноо ба цаг гурав дугаар баганад байхаар хуулна уу. Эхний баганад баримтжуулалтын цэгүүдийн нэрсийг яг мэдээллийн сан дахь нэрсийн дагуу нөхөж бичнэ үү. Хэрэв та нэрсийн нарийвчлалд итгэлгүй байвал N+4 баганад ялгагч тэмдгүүд нөхөж болох буюу бидний 4 зүйлийн хувьд баримтжуулалтын цэгүүдийн ялгагч тэмдгүүд найм дахь баганад бичигдэнэ. Хэрэв баримтжуулалтын цэгийн ялгагч тэмдгүүд бичигдсэн байвал тэдгээрийн нэрсийг огт ашиглаж болохгүй. Практикаас үзэхэд хэрэглэгчид нааштай хүлээж авч болохуйц нэрсийг нөхөх нь зөвхөн ялгагч тэмдгүүдтэй ажилласнаас ашигтай байдаг.

Бага гэсэн тэмдгийг (<) нийтэд нь (Ctrl-H) хасах тэмдгээр орлуулна уу (-).

XLS хавтаснуудыг талбар тусгаарлагч болох цэгтэй таслал ашиглан CSV болгож экспортлоно.


CSIS Editor-ын гадны хоосон хавтаснуудад CSV хавтаснуудыг импортлох бөгөөд баримтжуулалтын цэгүүдийн хуваарилалт болон зөв уншигдсан эсэхийг шалгана уу. Хэрэв хавтас үзэхээр байвал түүнийг CSIS мэдээллийн санд импортлож болно. Дээж тус бүрт энэ агшинд шинэ ялгагч тэмдэг хуваарилагдна.

Үйлдэл болон өгөгдлүүдийн төв рүү шилжсэн шилжүүлэг зөв эсэхийг та CSIS мэдээллийн сангаас өгөгдлүүдийг бүрэн шинэчилж программыг асаах үеэр шалгаж болно.

7.2.8. Газрын зургийн цонх - CSIS Map Editor

Газрын зургийн цонхыг нээхэд татаж авсан дэвсгэр газрын зургуудын хамт бүх давхаргууд уншигдаж, дүрслэгдэх хүртэл бага зэрэг хүлээх шаардлагатай. Хэрэв программ хэвийн дууссан бол газрын зургийн цонхыг баруун дээд талын чагт төдийгүй меню цэсээр ч унтраах шаардлагагүй. **Газрын зураг хаах үйлдлийг CSIS editor-ын бүртгэлийн самбараас „Төгсгөл“ / „End“ товчлуураар гүйцэтгэнэ**. Ийнхүү CSIS Editor-ын хэрэглэгчийн бүх интерфэйс хаагдана. CSIS Editor-ын ажиллагааны үеэр газрын зургийн цонхыг хүчлэн хаахыг зөвшөөрөхгүй.

CSIS Map Editor программын удирдах болон мэдээллийн хэрэгслүүд



Удирдах хэрэгслүүд нь:

⇒ Меню (цэс)

⇒ Ажлын талбай (газрын зураг)

⇒ Давхаргуудын самбар (баруун талд).

Мэдээллийн хэрэгслүүд нь

⇒ Төлөвийн самбар (доод зурвас)

⇒ Графикийн масштаб (доор газрын зураг дээр)

⇒ Чавхдах цэс (гүйцэтгэж буй үйлдлээс шалтгаалан газрын зураг дээр хулганы баруун товчлуурыг дарснаар саналууд гарч ирнэ).

Меню (цэс) – Төгсгөл. Хэрэв CSIS Editor программ дууссаны дараа цонх хэвийн хаагдаагүй тохиолдолд газрын зургийг меню цэснээс эсвэл программын баруун дээд булан дээрх чагтыг олон удаа дарж албадан хааж болно. CSIS Map Editor дуусах үеэр газрын зургийн одоогийн тохируулгыг хадгалах бөгөөд программын энэ хэсгийг дуусгана.

Меню (цэс) – Үзүүлэх.

⇒ **ойртуулах / Zoom in**: Идэвхтэй харагдацыг хулганы курсор байрлаж буй газарт дэлгэцийн төвд ойртуулна. Ойртуулж болох дээд түвшин нь 20 боловч газрын зургийн зарим материалууд ийм хэмжээнд хүртээмжтэй байхгүй. *Хувилбарууд*: F7 товчилбор эсвэл CTRL товчлуурыг дарсан хэвээр хулганы хүрдийг дээш нь эргүүлэх эсвэл уг сонголтыг чавхдах цэснээс дуудаж болно.


⇒ **холдуулах / Zoom out**: Идэвхтэй харагдацыг хулганы курсор байрлаж буй газарт дэлгэцийн төвөөс холдуулна. *Хувилбарууд*: F8 товчилбор эсвэл CTRL товчлуурыг дарсан хэвээр хулганы хүрдийг доош нь эргүүлэх эсвэл уг сонголтыг чавхдах цэснээс дуудаж болно.

⇒ **Гүйлгэх / Pan locked**: Хулгана дээр дарж, чирэх аргаар („drag and drop“ буюу „аваад тавих“ техник) ж.нь: ESC товчлуурын тусламжтай үйлдлийг болиулах хүртэл харагдацыг олон дахин зөөх боломжийг олгодог. *Хувилбарууд*: F5 товчилбор эсвэл зай авах товчлуурыг дарсан хэвээр, drag and drop техникээр зургийг гүйлгэх эсвэл уг сонголтыг чавхдах цэснээс дуудаж болно.

⇒ **Шилжих / Pan**: Харагдацыг хулгана дээр дарж, чирэх аргаар („drag and drop“ буюу „аваад тавих“ техник) нэг удаа зөөх боломжийг олгодог. *Хувилбарууд*: F6 товчилбор эсвэл зай авах товчлуурыг дарсан хэвээр, drag and drop техникээр зургийг гүйлгэх эсвэл уг сонголтыг чавхдах цэснээс дуудаж болно.

⇒ **Харагдах түвшин / Zoom**: Тодорхой харагдах түвшинд түргэн шилжих боломж олгодог (ойртуулах эсхүл холдуулах).

⇒ **Цонх / Window**: Хулгана дээр дарж, чирэх аргаар хийсэн сонголтын дагуу харагдацыг харагдах хамгийн тохиромжтой түвшинд ойртуулна. *Хувилбарууд*: CTRL товчлуурыг дарсан хэвээр + хулганы зүүн товчлуур дээр дарж + хулганаа чирэх эсвэл эсвэл уг сонголтыг чавхдах цэснээс дуудаж болно.



⇒ **Байршил хайх / Search location**: Байршлыг текст оруулан хайх боломжийг олгодог. Газрын нэр, хаягийг бүрнээр нь эсхүл WGS-84 солбилцлын системд солбилцлыг нь

оруулах боломжтой. Доор дурдсан форматууд боломжтой. Солбилцол оруулах тохиолдолд чиглүүлэх хэрээс харагдана. Товчилбор: CTRL + F

Ижил нэртэй олон газар илэрсэн тохиолдолд байгаа газруудын жагсаалтаас шаардлагатай газрыг сонгоно.

Хаягуудын тусламжтай оруулах:

WGS-84 солбилцлын системд солбилцол оруулах боломжтой форматуудын тойм доорх хүснэгтэнд бий. Аравтын орны тусгаарлагч нь уг тохиолдолд үргэлж цэг, солбилцлын тусгаарлагч нь таслал байна. Илэрхийллийг зайтай эсвэл зайгүй ч оруулсан болно.

49.8703442,16.3115764 *(тэмдэглэл: энд сөрөг утгуудыг ч оруулж болно)*
49.8703442°N, 16.3115764°E
49°52.22065'N, 16°18.69458'E
49°52'13.239"N, 16°18'41.675"E
16.3115764°E, 49.8703442°N
16°18.69458'E, 49°52.22065'N
16°18'41.675"E, 49°52'13.239"N

⇒ **Өмнөх / Previous**: Өмнөх харагдацыг дүрсэлнэ. Товчилбор: SHIFT + CTRL + Z

⇒ **GPS-д шилжих / Move to GPS**: Хэрэв GPS идэвхтэй байвал харагдацыг GPS-ийн буцаах идэвхтэй байршилд түргэн шилжих боломж олгодогы.

⇒ **Дахин зурах / Redraw**: программын идэвхтэй харагдацыг дахин зурна (ж.нь: хэрэв программ идэвхтэй харагдацыг зөв зурахгүй байвал тохиромжтой). Товчилбор: CTRL + R

⇒ **Газрын зураг ачаалах / Reload Map**: Дэвсгэр газрын зургийг программын санамжинд урьд өмнө хадгалагдаж байсан эсэхээс үл хамааран дахин татна (программын санамжинд урьд өмнө хадгалагдсан дэвсгэр газрын зураг арчигдах болно). Товчилбор: CTRL + F5

⇒ **Нэвт харагдах талбай / Transparent Areas**: Уг сонголт вектор талбайг (полигонууд) ил тод дүрслэх боломжийг олгодог, уг сонголтын тусламжтайгаар доод давхаргын объектууд эсвэл дэвсгэр газрын зургийг талбайгаар нэвт харах боломжтой. Бас уг сонголтыг зурааслсан талбайн сонголттой хослуулж болно. Товчилбор: CTRL + T

⇒ **Зурааслсан талбай / Hatch areas**: Уг сонголт вектор талбайг (полигонууд) зурааслагдсан хэлбэрээр дүрслэх боломжийг олгодог, уг сонголтын тусламжтайгаар доод давхаргын объектууд эсвэл дэвсгэр газрын зургийг талбайгаар нэвт харах боломжтой. Бас уг сонголтыг нэвт харагдах талбайн сонголттой хослуулж болно. Товчилбор: CTRL + H

GPS

⇒ **GPS – асаах**: Хэрэв тохиргооны хэсэгт тохируулсан байвал GPS-ийг асаана.

⇒ **GPS – унтраах**: GPS-ийг унтраана.

⇒ **GPS – тохиргоо**: Программ болон GPS-ийн холболтыг тохируулах боломжийг олгодог. CSIS mapeditor программд тохиргоо хийхийн өмнө та GPS modul-ыг компьютертайгаа нийцүүлэх нь зүйтэй. Windows 7 үйлдлийн системд нийцүүлэх арга (“GPS modul-ыг bluetooth-ээр Windows 7-д холбох” сэдвийг үзнэ үү).

⇒ **GPS - Өөрийн компьютерийн COM портуудад автоматаар GPS хайх**: Хэрэв та COM портын дугаарыг мэдэж байвал уг утгыг тохиргооны сонголтонд гар аргаар тохируулж болох бөгөөд энэхүү тохиргооны дараа GPS-ийг туршиж үзэх нь тохиромжтой.

⇒ **GPS – GPS-ийн дагуу газрын зураг зөөх**: GPS-ийн дагуу газрын зураг зөөх сонголтыг зөвхөн өндөр хурдтай интернэтэд холбогдсон тохиолдолд эсвэл газрын зураг компьютерийн санамжинд хангалттай хадгалагдсан тохиолдолд, эсвэл газрын зургийг унтраасан тохиолдолд асаах нь тохиромжтой.

Хэрэв GPS олдож, байршлыг буцааж байвал хяналтын солбилцлууд бүртгэгдсэн байна. Харин одоо газрын зурагт эргэн очих эсвэл GPS курсорын байрлаж буй байршилд газрын зураг руу очих боломжтой.

Тохиргоо / Settings

⇒ **Хэл / Language**: программын хэлийг сонгох ба тохируулах боломж олгодог.

⇒ **Газрын зургийг санамжаас устгах / Clear maps cache**: Программын өмнөх ашиглалтын үеэр татсан байсан газрын зургийг устгана. Санамжинд татаж авсан дэвсгэр газрын зураг нь программ дахь газрын зургийн материалуудыг хурдан ачаалж уншихад тустай. Энэ сонголт мөн Google map (хавтан) эсхүл OpenStreetMaps зэргийн ашиглалтанд ч хүчинтэй.


⇒ **Цонх үргэлж дээр / Window stay on top**: Уг сонголт нь CSIS mapeditor-ын цонхыг үргэлж бусад программуудын дээр байлгана.

Map Editor-ын ажлын талбай

WMS эсхүл WMTS серверүүд болон CSIS мэдээллийн сангийн график хэрэгслүүдийн агуулгын дагуу давхаргуудын самбарт дурдагдсан вектор хэрэгслүүдээс уншигдсан газрын зургийн растер зургийг дүрслэх зориулалттай. Программын ажлын талбай дээр дурын газар хулганы баруун товчлуурыг дарснаар ажлын талбай дээрх ажиллах үйлдлийг идэвхжүүлж болох чавхдах цэсийг дуудах боломжтой.

Давхаргын самбар

Давхаргын самбар нь векторын болон растерын давхаргуудыг удирдах зориулалттай. Уг самбарт дээр дурдагдсан давхаргууд нь доор дурдагдсан давхаргуудын дээр зурагддаг. Давхаргуудыг асааж эсхүл унтрааж, растерын газрын зургийн хувьд эх үүсвэрүүдийн хооронд зөвхөн шилжиж болно.



Google maps (static)-ыг газрын зургийг нэг удаа түргэн дүрслэх тохиолдолд ашиглах нь тохиромжтой, газрын зураг Google maps (tiles = хавтан) сонголтын тохиолдлоос харьцангуй бага нягтшилтай байдаг боловч илүү хурдан.

Google maps (tiles)-ыг өгөгдсөн орон зайг олон удаа дүрслэхэд ашиглах нь тохиромжтой. Уг сонголтын дэвсгэр газрын зураг Google maps (static) сонголтын тохиолдлоос илүү их нягтшилтай байдаг боловч түүнийг татаж авах нь анхны хүсэлтийн үеэр удаан үргэлжилдэг. Дараагийн дүрслэл бүрт газрын зургийн уншилт компьютерийн санамжаас, дэвсгэр газрын зургийг интернэтийн сүлжээнээс татаж авах шаардлагагүйгээр буюу офлайн горимд явагдах юм. Хэрэв дэвсгэр газрын зураг компьютерийн санамжаас уншигдвал тэдгээрийн дүрслэл нь унших эхний хүсэлтийн тохиолдлоос, мөн бас Google maps (tiles) сонголтын тохиолдлоос ч илүү хурдан явагдах болно.

Yandex maps ба OpenStreetMap нь Google maps газрын зургийн адил хувилбарууд юм. Зарим газруудад газрын зургийн дэлгэрэнгүй дүрслэлийг үзүүлж болно. OpenStreetMap нь компьютерын санамжинд хадгалагдах ба өөрөөр хэлбэл дараагийн удаа асаах үед илүү хурдан дүрслэгдэнэ.

Мөн самбарын доод хэсэгт сонгогдсон элемэнтийн бүрэн эсхүл хэсэгчилсэн тодорхойлолт хийгдэх эсэхийг тохируулах боломжтой. Хэсэгчилсэн тодорхойлолт нь CSIS mapeditor-т хялбаршуулсан мэдээллүүдийг үзүүлдэг, бүрэн тодорхойлолт нь CSIS editor-ын цонхонд цогц мэдээлэл үзүүлнэ.

Status bar



Status bar буюу программын цонхны доод хэсэг дэх мэдээллийн самбар. Уг мэдээллийн самбар дараах мэдээллүүдийг үзүүлнэ:

⇒ Ойртуулах түвшин (зүүмийн зэрэг)


⇒ UTM солбилцол, бүсүүд ба бөмбөрцгийн хагасын тэмдэглэгээний хамт

⇒ WGS84-ийн солбилцол

⇒ GPS дагуулын тоо

⇒ Мэдээллийн жагсаалт, түргэн зөвлөгөө, анхааруулга.

Графикийн масштаб



Графикийн масштаб нь идэвхтэй дүрслэгдсэн газрын зураг дээр алслагдсан зайг төсөөлөхөд хялбар болгодог.

Чавхдах цэс

Pop-up / чавхдах цэс нь программын ажлын талбайн хаана ч хулганы баруун товчийг дарахад дуудагддаг.

⇒ **Зургийг ойртуулах / Zoom in**: чавхдах цэс дуудагдсан, дарсан газарт ойртуулах (F7).

⇒ **Зургийг холдуулах / Zoom out**: чавхдах цэс дуудагдсан, дарсан газраас холдуулах (F8).

⇒ **Зургийг гүйлгэх / Pan locked:** хулгана дээр дарж, чирэх маягаар олон удаа гүйлгэх (F5 – зай авах товчлуураар идэвхжүүлж болно). ESC товчлуураар цуцалж болно.

⇒ **Зураг зөөх / Pan**: хулгана дээр дарж, чирэх маягаар нэг удаа (F6 - зай авах товчлуураар бас идэвхжүүлж болно). ESC товчлуураар цуцалж болно.

⇒ **Цонх / Window**: Хулгана дээр дарж, чирэх аргаар хийсэн сонголтын дагуу харагдацыг харагдах хамгийн тохиромжтой түвшинд ойртуулна (CTRL товчлуураар бас идэвхжүүлж болно). ESC товчлуураар цуцалж болно.


⇒ **Identify (ялгаж олох)**: Элемэнт эсвэл газрын ялгагч тэмдэг. Хэрэв уг сонголт нь чавхдах цэсийг дуудсны дараа дурын дүрслэгдсэн цэгээр эсхүл полигоноор газрын зураг дээр дуудагдсан бол уг элемэнтийн шинж чанарын харилцах цонх хэлбэрээр (таних дугаар ба элемэнтийн нэр, солбилцол эсхүл талбай болон хүрээ) харагдах бөгөөд энэ нь давхаргын самбарын доод хэсэг дэх **бүрэн тодорхойлох / full identify** гэсэн сонголт чагтлагдсан эсэхээс хамаарч нэг бол хялбаршуулсан эсхүл цогц хэлбэрээр харагдах болно.



Газрын зураг дээр ямар ч цэг эсхүл полигон байхгүй дурын газар дарснаар бүс нутаг эсхүл тойргийн нэртэй харилцах цонх (дүрс томруулах идэвхтэй түвшний дагуу) болон чавхдах цэс дарж дуудсан цэгийн солбилцол гарч ирнэ. Бүс нутаг эсхүл тойрог нь ялгагч тэмдгийн үеэр бусад бүс нутаг эсхүл тойргуудаас графикийн хувьд ялгарна.


Гарч ирсэн солбилцлыг децимал / аравтын ба гексагесимал / жартын хэлбэрүүдийн хооронд шилжүүлэх боломжтой.

Полигонд өөрчлөлт гүйцэтгэгдсэн тохиолдолд чавхдах цэс өөрчлөгдсөн полигоныг засах боломжийг олгох утгаар өргөтгөгдсөн байна. Утгууд нь чавхдах цэсний дуудагдсан газарт идэвхтэй байх ба харгалзах үйлдлийг гүйцэтгэж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг полигон өөрчлөх бүлгээс харж болно.




Вектор нэгжүүд үүсгэх ба засах

⇒ **Цэг нэмэх**: Хэрэгслүүдийн самбар дээр хүснэгтийн цонхонд тэмдэглэл нэмэх товчлуур дээр дарсны дараа цэг нэмэх боломжтой. Уг үйлдэл нь анхдагч мэдээлэл ба баримтжуулалтын цэгт ашиглагдах боломжтой. Үүний дараа газрын зургийн цонх идэвхжих бөгөөд цэг нэмэх зориулалттай курсор харагдах ба мэдээллийн самбарт энэхүү үйлдлийн тайлбар бичигднэ. Газрын зургийн дурын газар дарж цэг нэмнэ. Мөн бас тодорхой солбилцол дээр шууд цэг нэмэх боломжтой. Чиглүүлэх хэрээсэнд маш ойрхон дарагдсан бол тухайн цэг чиглүүлэх хэрээсний солбилцол (буюу оруулсан солбилцол) дээр холбогдох эсэхийг асууна. Чиглүүлэх хэрээсийг идэвхжүүлэх тухай Меню > Байршил хайх бүлэгт үзнэ үү.



Шууд дарж эсвэл солбилцлоор цэг нэмсний дараа оруулсан цэгийн солбилцлыг баталгаажуулах хүснэгт гарч ирнэ. Далайн түвшин зөвхөн интернэтийн сүлжээнд холбогдсон тохиолдолд хүртээмжтэй. Дэлхийн өргөрөг ба уртрагийн солбилцлыг мөн адил децимал / аравтынхаас гексагецимал / жартын хэлбэрт шилжүүлж болно.



⇒ **Цэгийн байршлыг өөрчлөх**: Цэгийн байршлыг өөрчлөхдөө шинээр цэг нэмэхтэй ижил зарчим баримтална. Зөвхөн хүснэгтийн цонхон дахь „Байршлыг өөрчлөх / Change location“ хэрэгсэл ашиглагдана“.

⇒ **Полигон нэмэх**: Полигон үүсгэхдээ түүний хугарлын цэг байрлах газарт дарна. Полигоны хугарлын цэгүүд буруу байрласан тохиолдолд BACKSPACE товчлуурын тусламжтайгаар нэг алхам ухрах боломж үргэлж байна. Полигоны сүүлийн цэгийг хоёрлосон товшилтоор үүсгэх а полигон битүүрэх ба үйлдэл дуусна. Полигон үүсгэхдээ зааврыг харна уу.

⇒ **Полигон өөрчлөх:** Өөрчлөхөөр сонгогдсон полигоны хугарлын цэгүүд ба талуудын тэнхлэг онцлон тэмдэглэгдсэн байна. Полигоны хугарлын цэгүүдийг шилжүүлж, нэмж бас арилгаж болно. Үүнээс гадна полигоныг бүхлээр нь зөөх, мөн дахин цоо шинээр зурах боломжтой.


⇒ **Полигоны хугарлын цэг зөөх:** түүний графикийн хэсэгт хулганаар дарж сонгоод шаардлагатай байрлал руугаа чирч зөөх.


⇒ **Полигонд хугарлын цэг нэмэх:** полигоны цэг нэмэхийг хүсэж буй талын тэнхлэг дээр хулганы баруун товчийг дармагц цэг нэмэх сонголт буй чавхдах цэс гарч ирнэ.

⇒ **Полигоны цэгийг авах:** полигоны цэг хасахыг хүсэж буй талын тэнхлэг дээр хулганы баруун товчийг дармагц цэг хасах сонголт буй чавхдах цэс гарч ирнэ.

⇒ **Бүх полигоныг зөөх:** SHIFT товчлуур дээр дарсан хэвээр (санамсаргүй шилжүүлгийн эсрэг хамгаалалт) болон „аваад тавих“ техникийн тусламжтай полигоныг шилжүүлнэ.

⇒ **Полигоны шинэ цэгүүд**. Полигоны шинэ цэгүүд үүсгэхийн тулд (шинэ зургийн) хулганы баруун товчлуураар чавхдах цэсийг дуудаж полигоны шинэ цэгүүд гэсэн утгыг сонгох бөгөөд цаашид шинэ полигон үүсгэхтэй ижил зарчмаар үргэлжлүүлнэ.





Харагдацын удирдлагын тойм

⇒ **Харагдацыг босоо чигт зөөх**: хулганы хүрдийг дээш эсхүл доош эргүүлнэ

⇒ **Харагдацыг хэвтээ чигт зөөх**: SHIFT товчлуурыг дарсан хэвээр + хулганы хүрдийг дээш эсхүл доош эргүүлнэ.

⇒ **Харагдацыг дурын чигт зөөх** хэд хэдэн боломж бий: Товчилбор F5 (олон удаа), ESC товчлуураар цуцлах эсвэл товчилбор F6 (нэг удаа), хэрэгжилт цуцлах эсвэл ESC-ийн тусламжтай эсвэл ЗАЙ АВАХ товчлуур + хулганыг дараад чирэх эсвэл

хулганы баруун товчлуурын дэд цэснээс Гүйлгэх эсвэл Зөөх сонголт хийх эсвэл Меню -> Харагдац -> Гүйлгэх эсвэл Меню -> Харагдац -> Зөөх сонголтыг хийх.

⇒ **Харагдацын хэмжээг өөрчлөх – ойртуулах / ZOOM +** : товчилбор F7 эсвэл CTRL товчлуур дээр дарсан хэвээр + хулганы хүрдийг дээш чиглүүлэн эргүүлэх эсвэл хулганы баруун товчлууpаас "Ойртуулах" дэд цэсийг дуудах эсвэл Меню -> Харагдац -> Ойртуулах эсвэл Меню -> Харагдац -> Харагдах түвшин

⇒ **Харагдацын хэмжээг өөрчлөх – холдуулах / ZOOM -** : товчилбор F8 эсвэл CTRL товчлуур дээр дарсан хэвээр + хулганы хүрдийг доош чиглүүлэн эргүүлэх эсвэл хулганы баруун товчлууpаас "Холдуулах" дэд цэсийг дуудах эсвэл Меню -> Харагдац -> Холдуулах.


⇒ **Өмнөх харагдац / Previous**: товчилбор CTRL+SHIFT+Z эсвэл программын Меню-> Харагдац -> Өмнөх харагдац

Товчилборуудын жагсаалт

F5	Харагдацыг г?йлгэх
F6	Харагдацыг з??х
F7	Харагдацыг ойртуулах
F8	Харагдацыг холдуулах
CTRL+R	Харагдацыг дахин зурах
CTRL+F5	Газрын зургийг шинээр унших
SHIFT+CTRL+Z	?мн?х харагдац
CTRL+T	Нэвт харагдаж талбай
CTRL+H	Зурааслсан талбай
CTRL+F	Байршил эсх?л солбилцол хайх
MEZERNÍK + stisknutí a táhnutí myši	Харагдацыг г?йлгэх эсх?л з??х
CTRL + stisknutí a táhnutí myši	Сонголтын дагуу харагдацыг ойртуулах (цонх)
ESC	Зарим ?йлдлийг цуцлах
ENTER	Зарим ?йлдлийг батлах
BACKSPACE	Полигон ??сгэх ?еэр нэг алхам ухрах

GPS modul-ыг bluetooth-ээр Windows 7-д холбох

Start -> Удирдах самбар -> Төхөөрөмж нэмэх -> цаашид харилцах цонхнуудын дагуу үргэлжлүүлэх


GPS settings
Set automatically
COM port
Find GPS
Set manually
Port: COM34
Interval: 1
Test GPS
GPS
Latitude:
Longitude:
Altitude:
Auto scroll (moving map)
OK
Cancel

8. ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ – АЛХАМ АЛХМААР

8.1. Ажлын ерөнхий журам

Ажлын үндсэн журам бол CSIS системтэй бүрэн танилцах явдал юм. Текстийн талбарт текст оруулахдаа текстэд ямар ч ишлэл болон өөр форматын тэмдэгтүүд байхгүй байх ёстойг анхаарна уу. Текстийн талбар тус бүрийн агууламж ишлэлээр хашигдсан хатуу сүлжээ мэт SQL командын тусламжтайгаар дамжина. Хэрэв та текстийн аль нэг хэсгийг тодотгохыг хүсч байвал түүнийг ж.нь: тэмдэгтүүд >текст< , [text] төрлийн хаалтууд гэх зэргээр хааж болно.

Хавсралтын нэрс цорын ганц байх буюу хавтасны төрлийг тодорхойлогч өргөтгөл тусгаарлагч цэгээс өөр цэг агуулах ёсгүй.

Жишээ: MiniiFailXavsraltuud.GIF

Буруу жишээ: Minii. Fail. Xavsraltuud.Gif.Gif

Ажлын үеэр засварлах горим ажиллагаатай хэвээр удаан байх ёсгүйд ихээхэн анхаарал хандуулна уу. Ажлын идэвхгүй байдлаас хамаарч холболт тасарч болно. Иймээс өгөгдлүүдээ тогтмол хадгалж байна уу. Хэрэв та программыг удаан ашиглахгүй гэдгээ мэдэж байгаа тохиолдолд түний хүснэгтүүдийг хааж, программыг унтраана уу.

Чухал анхааруулга! Программ асаалттай байх үеэр компьютерээ бүү унтуулаарай!

Одоо байгаа мэдээллүүдийг боловсруулах үеэр хүснэгтүүдийн агуулгатай танилцах, мэдээлэл унших үеэр олж авсан өгөгдөл мэдээллийг мэдээллийн сангийн харгалзах газарт нөхөх нь тохиромжтой. Хүснэгтийн бүх талбарыг бөглөхийг хичээхгүй, мэдээллийг уншсаны дараа л мэдээлэл дэх дутуу өгөгдлүүдийг хайж олох нь зүйтэй.

Ажлын журам өгөгдөл материалууд болон үйлдлийн төрлөөс хамаарч ялгаатай байна.

Өгөгдөл боловсруулж эхлэхээс өмнө уг материалтай сайтар танилцаж, CSIS дэх газрын амьдралын мөчлөгийг ойлгох нь зүйтэй. Өгөгдлийг мэргэжлийн үүднээс боловсруулах зорилгоор өгөгдөл боловсруулагчид болон менежерүүдийн сургалтанд дүүргэхийг зөвлөж байна.

Бүх тохиолдолд дараах анхны алхмууд хүчинтэй:

а) CSIS мэдээллийн системд харгалзах үүргийн дагуу бэлтгэгдэх.

б) CSIS-д бүртгүүлэх ба байгууллагад нэвтрэх

в) Менежерт "хураангуйлагч" эсвэл CSIS администраторт "менежер"-ийн үүргийг харгалзах эрхийн хамт хуваарилах хүсэлт.

г) CSIS Editor программыг татаж суулгах.

Бэлэн байгаа тайлангийн өгөгдлүүдийг боловсруулах үеэр баримтлах журам

Хэрэв танд бохирдсон нэг эсвэл олон газруудыг тэмдэглэсэн мэргэжлийн тайлан, мэдээллүүд бэлэн байгаа бол дараах алхмуудыг баримтална уу:

1. Өмнөх үг (газрын тухай ерөнхий мэдээлэл) болон тайлангийн дүгнэлтийг үзнэ үү. Ингэснээр асуудлын талаарх ерөнхий ойлголттой болно.
2. Газар бүртгэлд орсон эсэхийг нягтлан үзнэ үү. Хэрэв үгүй бол түүнийг анхдагч мэдээлэл хэлбэрээр оруулж түүний бүх мэдээллүүдийг нөхөж бичээрэй. Хэрэв газар бүртгэгдсэн байвал 4 дүгээр цэгийн дагуу үргэлжлүүлнэ үү.
3. Анхдагч мэдээллийг REG_ConSite-д шилжүүлнэ үү.
4. REG_ConSite-д газрыг нээж Холбогдох баримт бичгүүдийн хэсэгт номын санг нээж судлагдсан тайлан мэдээлэл хайж үзнэ. Хэрэв номын санд ийм тайлан байхгүй бол түүний аннотацийг нөхөж газартай холбоно уу. Хэрэв олон тайлан бичгүүд байвал бүгдийг нь холбоно.
5. Холбогдох баримт бичгүүдийн хүснэгтийг нээж лавлах санд тайлан боловсруулагчийг хайна уу. Хэрэв байхгүй бол түүнийг лавлах санд нөхөж, газар дээр нэмж оруулна.
6. Та CSIS систем болон хүснэгт нэг бүрийн агуулгатай сайтар танилцсан тул тайланг мөн сайтар уншина уу. CSIS-д бүртгэгдсэн мэдээлэл олсон даруй түүнийг харъяалагдах газар нь, хүснэгтэнд нөхөж бичээд нэн даруй хадгалаарай. Ямар ч тохиолдолд нэг хүснэгтийн араас хоёр дахийг нь бөглөх – үр дүнгүй аргаар тайланд мэдээлэл хайх гэж оролдох хэрэггүй.
7. Та тайланг бүрэн уншиж дууссаны дараа түүний агуулгад чиг баримжаатай болсон байна. Одоо CSIS Editor-ын нэг хүснэгтийг нөгөөгийнх нь араас нээж бөглөгдөөгүй талбар байгаа эсэхийг шалгана. Хэрэв талбарын мэдээлэл тайлангийн өөр хаа нэгтээ дурдагдсан болохыг анзаарвал түүнийг хайж олоод хүснэгтэнд нөхөж оруулна уу.
8. Тайлангаас бүх мэдээллийг нөхөж оруулсны дараа ач холбогдлыг үнэлнэ үү. Хэрэв ач холбогдол таны төсөөлж байсантай нийцэхгүй байвал өгөгдлүүдийн хаа нэгтээ алдаа гарсан эсвэл зарим өгөгдлүүдийг дутуу нөхсөн байж болох юм. Газрын паспортын өгөгдлүүдийг шалгаж үзнэ үү.
9. Хариуцлагатай боловсруулагч тэмдэглэлийг хянан шалгаж эрх олгоно.
10. Тэмдэглэл дахин боловсруулагдах анхааруулгатай буцна, эсвэл батлагдаж олон нийтэд нээлттэй болно. Ингэснээр дараагийн шинэчлэлд бэлэн болох юм.

8.2. Судалгааны эсвэл засан сэлбэх арга хэмжээний хэрэгжилтийн үеэр баримтлах журам

Хэрэв боловсруулагч, судалгааны эсвэл засан сэлбэх арга хэмжээний үе шатанд байгаа газрын бохирдлын асуудлыг шийдвэрлэж буй багийн гишүүн бол олж авсан бүхий л мэдээллээ CSIS системд нэн даруй бичнэ. Ингэж боловсруулсан өгөгдлүүдээс ямар ч мэдээлэл дутаалгүй тайлан бичиж болно.

Энэ журам нь урвуу – буюу тайлангаас мэдээллийн сан руу тэмдэглэл үүсгэн оруулах арга барилаас хамаагүй илүү үр дүнтэй болно. Хэрэв мэдээллийн сангийн тэмдэглэл

тайлангаас өмнө боловсруулагдсан байвал түүний дараах тайлан ямар ч мэдээлэл дутаагүй, маш нарийн нямбай байх нь тодорхой бөгөөд бүх баримтжуулалтын объектууд, анализ шинжилгээнүүд төлөөллийн хүснэгтэнд хялбархан экспортлогдох болно.

Лавлах санд өөрийн байгуллага болон холбогдох бүхий л чухал субъектуудыг нөхөж бичихээ мартуузай. Мөн баримт бичгийн аннотаци ба бохирдлын изошулуун гэх зэрэг чухал график-зурган хавсралтуудыг нөхөж оруулахаа бүү мартаарай. Ийм график хавсралтуудыг GIF форматаар оруулах нь хамгийн тохиромжтой.

Боловсруулалтыг ач холбогдлын шинэчлэл идэвхжүүлэлт болон тэмдэглэлийн эрх олголтоор дуусгавар болгоно.

8.3. Бохирдсон газрын зураглал / тооллогын үеэр баримтлах журам

Ийм хүндхэн үйл ажиллагаа удирдлагын талаас анхны алхмуудыг шаарддаг.

1. Үйл ажиллагааны зохион байгуулалтын бүдүүвчийг үүрэг тус бүрийн боловсон хүчний орон тоо ба ажлын баг тус бүрийн өрсөлдөх чадварын хамт үүсгэнэ. Өрсөлдөх чадварын хуваарилалтын явцад газар нутгийн үйлчлэх хүрээг администратор, хянан батагаажуулагч нар болон менежерүүдэд хуваарилна. хянан батагаажуулагчид уг тохиолдолд хэрэглэгчдийн талд эсхүл боловсруулагчийн талд байхыг та шийднэ. Томоохон хэмжээний өгөгдлүүдийн улмаас энэхүү батлах болон чанарын хариуцлагын үе шат боловсруулагчийн талд байх нь ашигтай.
2. Гадаад эх үүсвэрээс REG_ID хэсэг рүү газруудын жагсаалтыг уншуулах боломжийг бүрдүүлнэ үү.
3. Менежер – байгууллагын газрын зураг боловсруулах багуудыг ахлагч ажилтан хуваарилагдсан газар нутгийн газрын зураг төлөвлөлтийг гаргана.
4. Яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа газруудад (усны эх үүсвэрийн хамгааллын бүс гэх зэрэг илт тохиолдол) яаралтайн зэргийг тэмдэглэнэ.
5. Бэлэн баримт бичигтэй газруудыг боловсруулсан хэмээн шилжүүлнэ – өгөгдлүүдийн боловсруулалт нэн даруй, талбай дээр очих шаардлагагүйгээр хэрэгжиж болно.
6. Газрын зурагжуулах зориулалттай газруудыг "Боловсруулагдсан байдал / Record State" цэсний тусламжтай "газар дээр үзлэг судалгаа хийх шаардлагатай / site visit necessary" гэсэн шинж тэмдгээр тэмдэглэнэ.
7. Төлөвлөгөөний дагуу зургийн баг одоогийн зурагжуулах трассд зориулан газрын зурагнууд болон бэлэн өгөгдлүүдийг татаж авч зураглах ажлыг хийж гүйцэтгэнэ. Илэрсэн үндсэн мэдээллүүдийг фото баримтуудын хамтаар анхдагч мэдээлэлд нөхөж хийнэ.
8. Буцсаны дараа бүх өгөгдлүүдийг шалгаж, шаардлагатай бол нөхөх бөгөөд шалгасны дараа төв мэдээллийн санд шилжүүлнэ (онлайн горимд хадгална).

9. Бохирдсон байж болзошгүй газар биш нь тодорхой бүх анхдагч мэдээллүүдийг цуцална. Ингэснээр газрын зураг дээр цуцлагдсан газруудыг тэмдэглэнэ.
10. Бохирдсон газар мөн эсвэл байж болох анхдагч мэдээллүүдийг бохирдсон газрын бүртгэлд оруулна.
11. Менежер тэмдэгнүүдийн байгаа төлөвийг шалгах ба дараа дараагийн өдрүүдийн трассын төлөвлөлтөд шилжинэ. *одоог хүртэл үнэлэгдээгүй анхдагч мэдээлэл / without any evaluation* **эсвэл** *боловсруулагдаж буй / in progress* гэсэн тэмдэг үлдэж буй цэгүүдийг нарийн нямбай шалгана.
12. Шинээр илэрсэн, хараахан судлагдаагүй бохирдсон газруудын хувьд мэдэгдэж буй мэдээллүүдийг нөхөн оруулах бөгөөд ач холбогдол PI – урьдчилсан судалгаа шаардлагатай гэсэн ангилалтай байна.
13. Бохирдсон газрын тэмдэглэлд хариуцлагатай менежер эрх олгоно.
14. Бохирдсон газрын тэмдэглэлийг байгууллагын хянан баталгаажуулагч шалгах ба батласны дараа хэрэглэгчид шилжинэ.
15. Хэрэглэгчийн админ тэмдэглэлийг батлах ба ингэснээр түүнийг олон нийтэд нээлттэй хэсэгт шилжүүлнэ.

9. АЧ ХОЛБОГОЛД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ – ЗЭРЭГЛЭЛИЙН СИСТЕМИЙГ ТАЙЛБАРЛАХ, АЧ ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙН КОДЫН УТГА УЧРЫГ ТАЙЛАХ

9.1. Газар нутгийн ач холбогдлын зэрэглэлийг тогтоох

Тус систем нь бүртгэгдсэн бүх газар нутгийн ямар арга хэмжээ авах шаардлагатай гэдгээр ангилна. Зэрэглэл тус бүр бохирдлын хэмжээ, хор уршиг эсвэл үнэлэхэд мэдээлэл хангалтгүй байгаа гэдгээр тодорхойлогдсон бөгөөд үүнийгээ үндэслэн зэрэглэл тус бүрт хамааран авагдах шаардлагатай арга хэмжээний шинж чанар, түүнийг хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхойлно.

Сэлбэн засах арга хэмжээ авагдах зайлшгүй шаардлага, шинж чанар болон хэрэгжилтийг хойшлуулж болох эсэх байдлын үнэлгээ нь тухайн газар нутгийн бохирдлын хор уршиг эсвэл гарч болзошгүй хор уршиг буюу өөрөөр хэлбэл уг бохирдлын хүний эрүүл мэнд болон/эсвэл байгаль орчинд учрах эсвэл учирч болзошгүй эрсдэлээс шууд хамааралтай. Сэлбэн засах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн газарт судалгаа хийх зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд зайлшгүй хүрнэ.

Аливаа газар нутагт үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр доор заасанчлан үсгийн код, хоёр оронтой тооноос бүрдсэн **ач холбогдлын зэрэглэлийн код** өгнө:

Ач холбогдлын зэрэглэл – тэмдэг ба нэршил

нэр →	Ач холбогдлын код				
	Зэрэглэлийг заасан тэмдэг		**кодын эхний оронд буй тоо**		**кодын хоёрдахь оронд буй тоо**
утга санаа →	Тухай газар нутгийн байдал, цаашид авагдах арга хэмжээ		Хүний эрүүл мэндэд учруулах аюул – хүний тоо		(учирч болзошгүй) нөлөө
тэмдэг →	код – хоёр үсэг	-	0-с 3 хүртэл	-	0-с 4 хүртэл

Ач холбогдлын кодын жишээ: PI-2-1, DI-0-3, RD-3-4.

Кодын эхний хоёр үсэг нь бохирдлын хэмжээнээс болон сэлбэн засахад авагдах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл байгаа эсэхээс хамааран хийгдэх шаардлагатай алхмаас хамаарч оруулсан **зэрэглэлийг** заасан.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын дараа кодын хоёр оронтой тоо орно.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний оронд байгаа тоо нь тухайн бохирдлын **хорт нөлөөнд буй хүний тоог** заана. Үүнд, жишээ нь тухайн газар нутгийн эсвэл түүний ойр орчимын оршин суугчид, ашиглагчид эсвэл тухайн газрын газар доорхи эсвэл гадаргын усыг ундны усны зориулалтаар хэрэглэдэг хүнийг харгалзана. Уг тоогоор хүний бодит тоо биш, бодит тооны хэмжээний зэрэглэлийг заасан байна.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын хоёрдахь оронд байгаа тоо нь бохирдлын нөлөө буюу өөрөөр хэлбэл хүний тооноос хамаарахгүй бохирдлын хор уршиг, эрсдэлийг

тодорхойлдог (уг бохирдлын нөлөөнд буй хүний тоо кодын эхний тоогоор тодорхойлогдсон). Хорт бодисын бодит концентрацийн тухай мэдээлэл байхгүй тохиолдолд үүнийг үүсч болзошгүй нөлөө эсвэл эрсдэл гэж ойлгоно.

9.2. Ач холбогдлын зэрэглэл

Reg_ConSite бүртгэлд орсон бүх газар нутгийг ач холбогдлын үнэлгээний дагуу хуваааж оруулах зэрэглэлүүдийг R1 хүснэгтэд заасан зэрэглэлийн матрицаар иж бүрнээр дэлгэрэнгүй харуулсан.

R1 хүснэгтийн зэрэглэлийн матрицийн зохион байгуулалтын бүтэц болон зарчимыг ойлгож мэдэх нь нийт зэрэглэлийн системийг ойлгож, өдөр тутмын ажилдаа ашиглахад нэн чухал ач холбогдолтой.

Газар нутгийг хуваааж оруулсан зэрэглэлийн тэмдэг R1 хүснэгтийн зүүн талын баганад заагдсан байна. Тэр нь ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний хоёр үсэг юм.

Газар нутаг судлагдсан эсэх, судалгаа эсвэл эрсдлийн судалгааны үндсэн дээр гаргасан түүний байдлын тухай ерөнхий дүгнэлт зэрэглэл тус бүрт R1 хүснэгтийн зүүн гар талаас хоёр дахь баганад заасан байна.

Газар нутгийн ерөнхий байдлын дүгнэлттэй нийцүүлэн тухайн газарт хийгдэх шаардлагатай ерөнхий тодорхойлсон арга хэмжээний нэг нь тохирч байна. R1 хүснэгтийн зүүн талаас гурав дахь баганыг үзнэ үү. Зэрэглэл тогтоохын жинхэнэ утга учир яг газар нутгийг тодорхой аль нэг зэрэглэлд оруулах, шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл өгөхөд оршино. Зэрэглэлийн кодын дараа орсон тоо тухайн зэрэглэлийн хүрээн дэх ач холбогдлын зэргийн тухай мэдээллэх үүрэгтэй. Үүний дэлгэрэнгүй тайлбарыг дараах дэд бүлгээс үзнэ үү.

Хүснэгт R1	**Бохирдсон газрын ач холбогдлын үнэлгээний системийн зэрэглэлийн матриц**		
Зэрэглэлийн тэмдэг	Нөхцөл байдал (байдлын дүгнэлт)	Газар нутагт хийгдэх шаардлагатай арга хэмжээ	Ач холбогдолд үнэлгээ өгөх зорилго
Анхдагч мэдээлэл	Газрын тухай мэдээлэл тун бага, бохирдлын тухай мэдээлэл байхгүй, урьдчилсан судалгаа хийх шаардлагатай эсэх дүгнэлт хийх боломжгүй, уг газар бохирдсон байж болох газрын тоонд орж байгаа эсэх нь тодорхойгүй.	Газар дээрхи нөхцөл байдлын урьдчилсан судалгаа хийх шаардлагатай	Ач холбогдлын зэрэглэл тогтоогддоггүй, газар дээрх нөхцөл байдлын судалгааг хэр яаралтай хийх шаардлагатай асуудлыг шийдвэрлэх
PI	Тухайн газар бохирдсон болон бохирдсон байж болох газрын бүртгэлд бүртгэгдсэн, одоогоор бодит бохирдлын талаар ямар ч мэдээлэл байхгүй (дээж авалт хийгдээгүй)	Тухайн газарт урьдчилсан судалгаа хийх шаардлагатай	Бохирдол хэр зэрэг ноцтой байж болзошгүй тухай мэдээлэл, урьдчилсан судалгаа хийх шаардлагатай эсэх, хийх шаардлагатай бол хэр яаралтай хийх шаардлагатай болох асуудлыг шийдвэрлэх

DI	Тухайн газарт хийсэн урьдчилсан судалгааны үр дүн их хэмжээний бохирдолтой байж болзошгүйг харуулж байна.	Тухайн газарт нарийн судалгаа хийх шаардлагатай болохоос гадна эрсдлийн судалгаа хийх нь зүйтэй	Бохирдол хэр зэрэг ноцтой байж болзошгүй тухай мэдээлэл, нарийн болон эрсдэлийн судалгаа хийх шаардлагатай эсэх, хийх шаардлагатай бол хэр яаралтай хийх шаардлагатай болох асуудлыг шийдвэрлэх
SI	Тухайн газарт хийсэн урьдчилсан судалгааны үр дүн гарсан хэдий ч сэлбэн засах арга хэмжээний талаар эцсийн шийдвэр гаргах боломжгүй байна.	Тухайн газарт нэмэлт судалгаа эсвэл мониторинг хийх шаардлагатай	Бохирдол хэр зэрэг ноцтой байгаа тухай мэдээлэл, нэмэлт судалгаа эсвэл мониторинг хийх шаардлагатай эсэх, хийх шаардлагатай бол хэр яаралтай хийх шаардлагатай болох асуудлыг шийдвэрлэх
RD	Тухайн газарт дэлгэрэнгүй судалгаа (түүнчлэн нэмэлт эсвэл нөхөн сэргээлтийн зэрэг дээд шатны судалгаа) явуулж, болж өгвөл эрсдлийн судалгаа хийгдсэн байна; цуглуулсан мэдээлэл цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх шаардлагатай эсэхийн талаар шийдвэр гаргахад хангалттай байна	Хүний эрүүл мэндэд хор уршиг учирч болзошгүй тул сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагатай байна	Бохирдол хэр зэрэг ноцтой байгаа тухай мэдээлэл, Сэлбэн засах арга хэмжээ хэр яаралтай хийгдэх шаардлагатай тухай асуудлыг шийдвэрлэх *
RN		Хүний эрүүл мэндэд учруулах аюул байхгүй боловч сэлбэн засах арга хэмжээ авбал зүйтэй	
CR	Тухайн газарт сэлбэн засах арга хэмжээ хийгдэж, амжилттай болсон гэдгийг албан байгууллагын тогтоолоор батлагдсан, үлдэгдэл бохирдол нь хүлээн зөвшөөрөх болохуйц хэмжээнээс хэтрэхгүй байна	Сэлбэн засах, нөхөн сэргээх ажил амжилттай хийсэн учир дахин ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй болсон	Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох шаардлагагүй
AP	Хүлээн зөвшөөрөх болохуйц хэмжээнээс хэтрээгүй бохирдолтой газар	Ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй	
CL	Авсан дээжийг үндэслэн тухайн газарт ноцтой бохирдол илрээгүй байна (урьдчилсан судалгаа), эсвэл нарийн судалгааны үр дүнг авч үзвэл бохирдлын хэмжээ бага байна.	Ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй	Ач холбогдлын зэрэглэлийг тогтоох шаардлагагүй
* Хаягдал эсвэл уул уурхайн гаралтай усыг гадаргын усанд асгасан тохиолдолд сэлбэн засах арга хэмжээ нөхөн сэргээлтийн чанартай биш, үйлдвэрлэлийн явцад эсвэл хаягдал эсвэл уул уурхайн гаралтай ус цэвэршүүлэх аргад өөрчлөлт оруулах чанартай байна.			

9.3. Ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний болон хоёр дахь тоо

Ач холбогдлын зэрэглэлийн кодын дараа орж буй хоёр тоо тухайн зэрэглэлийн доторх ач холбогдол буюу тухайн газарт холбогдсон асуудлыг шийдвэрлэх хэрхэн чухал байх талаас нь ангилах зорилготой. Тухайн газарт холбогдсон асуудлыг хэрхэн чухал шийдвэрлэх нь бохирдлын нөлөөллийн түвшин болон тухайн газар нутаг, түүний ойр орчимд буюу бохирдлын нөлөөнд өртөж болзошгүй хүний тоо зэргээс хамааралтай.

Кодын эхний болон хоёр дахь тоог программ хангамж автоматаар тогтооно. Тэгэхийн тулд бохирдсон эсвэл бохирдсон байж болох газрын тэмгдэглэлд нөлөө бүхий хүчин зүйлийг багтаасан нийт 23 талбарыг зайлшгүй бөглөх шаардлагатай (хаягдал эсвэл уул уурхайн гаралтай ус асгах тохиолдолд 12 талбарыг зайлшгүй бөглөх шаардлагатай).

Ямар ч дээж авалт хийгээгүй газрын хувьд бохирдлын улмаас үүсч болзошгүй нөлөө болон түүнд өртсөн байж болзошгүй хүний тоог заана.

Доорхи хүснэгтээр ач холбогдлын кодын эхний тоог тайлах арга заасан байна:

Ач холбогдлын кодын эхний тоо				
Бохирдлын нөлөөнд өртсөн хүний тоо	Ямар ч х□н □рт□□г□й	20 х□ртэл	21-с 200 х□ртэл	200-с дээш
үнэлгээ	0	1	2	3

Тухайн газрын нийт үнэлгээ хийхийн тулд тухайн газарт эсвэл түүний ойр орчимд оршин суудаг эсхүл түүнийг ашигладаг хүний тоо эс бөгөөс газар доорхи болон гадаргын усыг ундны зорилгоор ашигладаг хүний тооны хамгийн өндөр утгыг харгалзан кодын эхний тоог тогтооно.

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо нь нийт нөлөөг эсвэл учирч болзошгүй нөлөөг илэрхийлдэг тул утга өндөр байх тусам нөлөөлөл ноцтой болно гэсэн үг юм:

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо	**бага н□л□□тэй** **0 эсвэл <1**	⇒	**ноцтой н□л□□тэй** **4**

Мэдээллийн сангийн хэрэглэгч, бүртгэлийн тэмдэглэл боловсруулагч нар хоёр дахь тоог бодох аргачлалыг нарийн ойлгох шаардлагагүй бөгөөд уг тоо нь доорхи бүдүүвчээр харуулсан эрсдлийн үнэлгээний үндсэн схемийн дагуу бохирдлын ноцтой эсвэл ноцтой байж болзошгүй нөлөөллийн интеграл илэрхийлэл болох ерөнхий утгыг ухаж ойлгоход хангалттай.

бохирдлын эх үүсвэр ⇒ тархалтын болон нөлөөллийн зам ⇒ бохирдол хүлээн авагч.

Уг тоог бодох аргыг доорхи хүснэгтээр арай бодитойгоор харуулсан байна. Хүснэгтийн зүүн талын баганад ач холбогдлын кодын хоёр дахь тоо бодоход нөлөөлж буй хүчин зүйлийг оруулсан бөгөөд нөгөө хоёр баганад үнэлж буй нөлөө бага эсвэл өндөр болоход нөлөөлдөг түгээмэл гардаг захын тохиолдлуудыг заасан.

Ач холбогдлын кодын хоёр дахь тоо – үнэлгээний утгыг харуулсан жишээ			
дүгнэдэг хүчин зүйл ↓	**бага нөлөөтэй жишээ ↓**	⇨	**ноцтой нөлөөтэй жишээ ↓**
хорт бодисын концентрацийн хэмжээ	бага	⇨	□нд□р
бодисын хортой чанар	цайр эрдэст тос	⇨	м□нг□н ус пестицид
хорт бодисын тархах чадвар	пестицид	⇨	хлоржуулсан уусгагч
бохирдуулсан тайлбайн хэмжээ	бага	⇨	их
бохирдлын тархалтын нөхцөл	бохирдсон газраас нэлээд холын зайд гол байхг□й шаварлаг чулуулаг бат б□х гадаргуутай газар	⇨	□ер усны аюулт □рт□х магадлалтай газар ус нэвтр□□лэх чанар сайтай хайрга хорт тоос, тоосонцор
газар нутаг, түүний ойр орчимын ашиглалт (хүлээн авагч нараар) – бохирдлын нөлөөнд эмзэг	аж □йлдвэрийн газар ус ашигладагг□й ил уурхай	⇨	х□□хдийн тогтлоомын талбай ундны усны эх □□свээр дархан цаазтай газар

Ач холбогдлын буюу сэлбэн засах арга хэмжээ авах шаардлагын зэрэглэлийг газар нутгийн нэг ангиллын хүрээн (зэрэглэлийн ижил кодтой газар нутгийн) дотор кодын эхний болон хоёр дахь тоог харгалзан үнэлнэ. Харин юуны түрүүн нэг газрын судалгаа хийх үү, өөр газарт нөхөн сэргээлтийн ажил хийх үү гэсэн шийдвэр зөв биш. Нэг талаас нөхөн сэргээлтийг шаардагдах тухай мэдээлэл хангалттай буй газар нутгийг нөхөн сэргээлт хийлгэхээр сонгох, нөгөө талаас мэдээлэл нь хомс тул нөхөн сэргээлт шаардагдах эсэх талаар дүгнэлт хийх боломжгүй хэсэг газраас судалгаа хийлгэхээр газрын сонгох нь зүй ёсонд илүү нийцнэ.

Судалгаа эсвэл сэлбэн засах арга хэмжээ авах зорилгоор газрыг сонгохдоо эхний шатанд ач холбогдлын зэрэглэлийн кодын эхний тоог, дараагийн шатанд тус кодын хоёр дахь тоог удирдлага болгон сонголт хийвэл зохино.

Уг зарчимыг нарийвчилсан судалгаа явуулах зорилгоор газар нутгийн ач холбогдлын дэс дараалыг тогтоох жишээн дээр тайлбарлаж болно:

Нарийвчилсан судалгаа явуулах зорилгоор газар нутгийн ач холбогдлын зэрэглэлийн дагуу дэс дараалыг нь тогтоох жишээ		
ач холбогдлын код	ач холбогдлын дэс дараалал	ач холбогдлын дэс дараалын тайлбар
PI-3-2	1	Ач холбогдлын хамгийн өндөр зэрэглэл – хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлж болзошгүй, аюулд өртөж болзошгүй хүний тоо хамгийн өндөр байна
PI-2-4	2	хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлж болзошгүй, бохирдлын улмаас

		учирч болох хорт нөлөө түрүүчийн жишээнээс бүр илүү ч байж болох хэдий ч аюулд өртөж болзошгүй хүний тоо харьцангүй бага байна
PI-0-4	3	бохирдлын улмаас учирч болох хорт нөлөө түрүүчийн хоёр жишээнээс бүр илүү ч байж болох боловч хүнд хорт нөлөө үзүүлэх аюул илрээгүй байна
PI-0-2	4	хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлэх аюул байхгүй, сөрөг нөлөө түрүүчийн жишээнээс бага байна

Мэдээллийн сангийн программ хангамж дээрх схемийн дагуу аль ч зэрэглэлд багтаасан бүх газрыг болон тодорхой нэгэн нутгийн талбайгаар зогсохгүй нийт улсын хэмжээнд автомат сонголт, ач холбогдлын дэс дарааллыг тогтоох боломж олгодог.

Ач холбогдлын зэрэглэлийн кодын хоёр тоо нь тухайн газрын ач холбогдлын ерөнхий үнэлгээг илэрхийлж байна. Программ хангамж нь дотроо бүртгэсэн газрын нутаг дэвсгэр, түүний ойр орчим, газар доорхи ус болон гадаргын ус гэсэн хэсэг бүрт тусгайлсан үнэлгээ өгөх бөгөөд нийлбэр үнэлгээ автоматаар хэсэгчилсэн үнэлгээний хамгийн муу дүнд үндэслэнэ. Газрын нийлбэр үнэлгээ тогтооход хамгийн их нөлөө үзүүлсэн хүчин зүйлийг сонирхсон тохиолдолд газар нутгийн паспортад байгаа хэсэгчилсэн үнэлгээтэй танилцах боломжтой. Үнэлгээг нарийвчлан шинжилж үзвэл хамгийн доод зэргийн үнэлгээ буюу хамгийн ноцтой нөлөө нь зөвхөн сэжиг, үүсч болзошгүй нөлөө төдий л, эсвэл дээж авалт, шинжилгээгээр тогтоогдсон (батлагдсан) нөлөө байх гэсэн мэдээлэл нь их чухал. Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, ногоо хөгжлийн яамны CSIS-н аргачлалын удирдамжаас үзнэ үү.

10. CSIS МЭДЭЭЛЛИЙН САНГ УДИРДАН ЗАХИРАХ

CSIS мэдээллийн санг http://www.eic.mn/csis веб интерфейсээр удирдан захирах боломжтой. Систем гадны зочид, хакеруудын халдлагаас системийн нүүр хуудсанд байрлуулсан бүртгэлийн маягтын тусламжтайгаар хамгаалагдсан. Бүргэлгүй хэрэглэгч системд нэвтрэх боломжгүй ("Хэрэглэгчийн бүртгэл"-ийг үзнэ үү).

Бүртгэл хоёр янзаар явагддаг. Олон нийтэд зориулсан бүртгэлд энгийн хүн бүртгүүлж болох бөгөөд бүртгүүлэхдээ овог, нэр, нэвтрэх нэр зэрэг хувийн мэдээллийг оруулан бүртгүүлнэ. Мэдээллийн санд бүртгэгдсэн газар нутгийн талаар мэдээлэл оруулдаг мэргэжилтэн, CSIS системийг удирдан захирдаг администуудад зориулсан тусгай бүртгэл гэж бий.

Системийн ашиглалтыг тав тухтай болгох үүднээс олон хэлтэй зохион бүтээсэн тул хэрэглэгч нүүр хуудсан дээр харилцах хүсэлтэй хэлээ сонгох боломжтой. Одоогийн байдлаар систем монгол, англи хэлний хувилбараар ажилладаг. Системийн хэл компьютерийн хэлний тохиргоонд нийцүүлэн автоматаар сонгогддог. Та монгол хэл дээрх компьютертэй бол системийн нүүр хуудас монгол хэлээр гарна. Өөр хэлээр ажилладаг компьютерт нүүр хуудас автоматаар англи хэлээр гарна. Хэрэглэгчийн CSIS системд нэвтрэх үед хийсэн хэлний сонголт хадгалагдаж, нүүр хуудас дараачийн удаа нэвтрэх үед урьд нь сонгогдсон хэлээр гарна. Өөр хэлний сонголт хийх болтол систем хэрэглэгчийн нэвтрэх бүрт автоматаар анх сонгогдсон хэлээр ажиллана.


10.1. Хэрэглэгч, байгууллагуудыг удирдан захирах

Хэрэглэгч бүртгүүлэх

Хэрэглэгч анх CSIS системд нэвтрэх үед бүртгүүлэх шаардлагатай. Тэгэхийн тулд системийн нүүр хуудсанд байгаа бүртгэлийн маягтыг бөглөж, овог, нэр, и-мейл хаяг, **логин/нэвтрэх нэр (login)** зэрэг заавал оруулах мэдээллийг оруулна (логин сэдвийг үзнэ үү). Хэрэглэгч нь хураангуйлагч (epitomist), менежер (manager) эсвэл админ (administrator) эрхийг авахыг хүсвэл өөрийгөө бүртгүүлэхээс гадна байгууллагын нэр, улс, хот суурин газрын нэр, гудамж, тоот, и-мейл хаяг, утас зэрэг байгууллагын мэдээллийг бүртгүүлэх ёстой. Хэрэглэгч бүр бусадтай давхцахгүй и-мейл, нэвтрэх нэртэй байна. Бүртгэлд бүртгэгдсэн и-мейл, нэвтрэх нэртэй давхцсан и-мейл, нэвтрэх нэрийг бүртгүүлэхийг хориглосон байна. Ийм нөхцөл үүссэн тохиолдолд хэрэглэгч давхцсан мэдээллийн оронд өөр, ялгаатай мэдээлэл оруулна. **Чухал анхааруулга!** Хэрэглэгчийн бүртгэлийн явцад түүний бөглөж оруулсан и-мейлийн үнэн зөвийг шалгах бөгөөд худал и-мейл оруулсан хэрэглэгчийг системд бүртгүүлэх боломжгүй.

Хэрэглэгчийн бөглөсөн мэдээлэл бүртгэлд нэгэнт байгаа мэдээлэлтэй зөрсөн тохиолдолд хэрэглэгчид оруулсан мэдээллээ засах тухай шаардлага илгээнэ. Тийм асуудал байхгүй тохиолдолд хэрэглэгч дэлгэцэнд гарч буй бөглөсөн мэдээллийг шалган баталснаар бүртгэлийн эхний үе шатыг төгсгөнө. Байгууллагын ажилтан болж бүртгэгдэж буй хэрэглэгчид мэдээллийн санд урьд нь оруулсан байгууллага, компаниудын жагсаалтаас өөрийн байгууллага, компанийг сонгох боломжтой.

Бүртгэлгүй компани, байгууллагыг бүртгүүлнэ. Сонгож авсан байгууллага, түүний тухай мэдээллийг мөн болохыг баталснаар бүртгэлийн эхний үе шатыг төгсгөнө.


Od csis@progeo-sys.cz
Předmět Registration of new users to the system CSIS
Komu já <ondrej@pavlikovi.cz>
Odpovědět | Přeposlat | Archivovat | Nevyžádaná pošta | Smazat
16:24
Další akce

CSIS Contaminated Sites Information System


Registration of new users to the system CSIS

Hello,
You have registered to CSIS. First you need to activate your account.
Link to activate your user account
http://csis.progeo-sys.cz/verify-user/139.0ba30b6779e70f990e5c8e83cc0425d4
After activation you may login by these credentials.
Login credentials
Username: **sherpa**
Password: **B3QKOU9F**

The password can be changed anytime after logging in.
You are registered as a new organisation. The verification organisation will confirm the contact details through which system administrators CSIS communicate with organisations.
Therefore him, please also pay speci alattention and confirm by clicking the confirmation link.
Clicking on this link will be verified by the organisation. Link verification organisation.
http://csis.progeo-sys.cz/verify-organisation/28.
Until one link to the organisation confirmed some functions are not available on the system.

Sincerely team of administrators CSIS

Бүртгэлийн хоёр дахь үе шатанд хэрэглэгчийн бүртгүүлэх үед заасан и-мейл хаягаар нэвтрэх нэр, нууц үгийн хамт явуулсан линк дээр дарж бүртгэлийг батлах шаардлагатай. Линк дээр дарснаар дэлгэцэнд и-мейл хаягийн үнэн зөвийг баталсан, системд анх удаа нэвтрэх боломжийн тухай мэдээлэл агуулсан CSIS системийн нүүр хуудас нээгдэнэ.




Байгууллагын тухай мэдээлэл бүхий хэрэглэгчийг бүртгүүлсэн тохиолдолд батлах и-мейлд байгууллагын үнэн зөвийг батлах линк илгээнэ. Администууд мэдээллийг шалгаж линк дээр дараад байгууллагын мэдээллийг батлах шаардлагатай.

CSIS системд амжилттай нэвтэрснээр бүртгэл төгсөнө. Бүртгэгдсэн хэрэглэгч энгийн хэрэглэгч буюу „public“ үүрэгтэй батлагдсан хэрэглэгч болох бөгөөд уг үүргийн эрхийн дагуу CSIS системээс мэдээлэл авч ашиглах эрхтэй.

Мартагдсан нууц үг

Хэрэглэгч системд нэвтрэх нууц үгээ мартсан тохиолдолд шинэ нууц үг авах боломжтой. Системийн нүүр хуудсан дээр бүртгүүлэх маягтын доор “Нууц үгээ мартсан уу?” гэсэн талбарт бүртгүүлсэн үед заасан и-мейл хаягаа оруулна. Заасан и-мейл системд байгаа и-мейлтай нийцсэн бол тухайн хэрэглэгчид шинэ нууц үгийг олгож заасан и-мейл хаягаар нь илгээнэ. Шинэ нууц үгээр системд нэвтрэх боломжтой. Системээс олгосон шинэ нууц үгийг санахад хялбар нууц үгээр солих нь зүйтэй гэдгийг анхааруулж байна. Нууц үгээ хэрэглэгчийн профайлд сольж болно.



Хэрэглэгчийн профайл

Хэрэглэгчийн профайлыг бүртгүүлсэн хэрэглэгчид ашиглаж болох бөгөөд программын дээд талын самбар дээр хүний дүрсний дор байрлуулсан байна.

Хэрэглэгчийн профайлд хэрэглэгчийн овог нэр, и-мейл хаяг, олгосон үүрэг, анхдагч мэдээлэл (indications), бохирдсон болон бохирдсон байж болох газар нутгийн (consites) тухай мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах эрх тус бүрийн тухай мэдээлэл харагдаж байна.



Хэрэглэгч профайлдаа овог, нэр, нууц үгээ солих боломжтой.

Хэрэглэгчдийг удирдан захирах

Менежер (manager), админ (administrator), суперадмин (superadmin), сүлжээ зохицуулагч (network manager) үүрэгтэй хэрэглэгчид хэрэглэгчдийг удирдан захирах эрхтэй.


Энэ хэсэгт дарснаар бүртгэгдсэн хэрэглэгчдийн жагсаалт гарч ирнэ. Хэрэглэгчийг хуудасны дээд талд байрласан хайлтын талбарын тусламжтайгаар хайх боломжтой. Хэрэглэгчдийг хайлтын талбарт оруулсан овог, нэр, нэвтрэх нэр, и-мейлээр нь хайна.



Хэрэглэгчдийг жагсаалтад нэр, байгууллага, нэвтрэх нэр, и-мейл хаяг зэргийн дагуу өсөх эсвэл буурах эрэмбээр төрөлжүүлэх боломжтой. Хэрэглэгчдийн жагсаалт нэг хуудсанд 20 хэрэглэгч багтаан гарч ирдэг. Нэг хуудаснаас нөгөө хуудсанд хэрэглэгчийн жагсаалтын дор байрласан тоноглолын зурвасны тусламжтайгаар шилжиж болно.

Хэрэглэгчийн талаарх мэдээлэл (User detail)

Хэрэглэгчийн талаарх мэдээллийг түүний нэрийн зүүн гар талд байгаа сум дээр дарснаар харж болох бөгөөд системд хэрэглэгчийн тухай байгаа бүхий л мэдээлэл орсон байна.



Хэрэглэгчийн талаарх мэдээллийг редакторлах (Edit user)

Харандааны дүрсний тусламжтайгаар хэрэглэгчийн талаарх мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. Үүнд, хэрэглэгчийн овог, нэр, үүргийг өөрчилж, байгууллагад холбох эсвэл өөр байгууллага руу шилжүүлэх боломжтой юм.

Баталгаажуулалтын и-мейл

Шинээр бүртгүүлсэн хэрэглэгч системд нэвтрэх мэдээлэл, бүртгэл идэвхжүүлэх линкийг агуулсан и-мейл аваагүй тохиолдолд “баталгаажуулалтын и-мейл илгээх” товчлуурыг дарж и-мейлийг илгээх боломжтой. Дээд талд байрласан товчлуурын самбарт байрлах хэрэглэгчид засвах оруулах товчлуурын хажууд буй уг товчлуур зөвхөн баталгаажуулагдаагүй хэрэглэгчдэд харагдана.

Хэрэглэгчийг баталгаажуулах



Бүртгүүлсэн хэрэглэгчдийн үнэн бодит байдлыг хангах үүднээс бүртгүүлсэн боловч админ, суперадмин эсвэл менежерээр батлагдаагүй хэрэглэгчийг хэрэглэгчийн жагсаалтад анхааруулах тэмдэгээр тэмдэглэдэг. Иймд өөрийн байгууллагын хүрээнд мэдээлэл боловсруулдаг хураангуйлагч (epitomist) үүрэг бүхий ажилтан нарын ажлыг хариуцсан менежер эдгээр хэрэглэгчдийн мэдээллийн үнэн зөв, холбогдох байгууллагын ажилтан мөн болохыг батлах нь зүйтэй.

Хэрэглэгчийн эрхийг хаах



Шаардлагатай тохиолдолд админ, суперадмин эсвэл менежер хэрэглэгчийн CSIS системийн хүрээнд эдлэх эрхийг хаах боломжтой. Хэрэглэгчийн эрхийг хэрэглэгчийн талаарх мэдээллийн дээд талын самбарт байгаа дүүжин цоожны зурагтай “Хаах” товчлуур дээр дарж хаана. Ингэснээр хэрэглэгчийн системд нэвтрэх эрхийг сэргээх болтол хаагдана. Нэгэнт хаагдсан хэрэглэгчийн эрхийг зөвхөн дээр дурдсан үүргийн эрх бүхий ажилтан нар сэргээх эрхтэй. Хэрэглэгчийн эрхийг хааснаар түүний өгөгдөл, мэдээлэл гэмтэхгүй, устахгүй, системд нэмэлт өөрлөлт хийх эрхэд нөлөөлөхгүй.

Хэрэглэгчийг устгах



CSIS системээс хэрэглэгчийг эрхээс нь хамааран сүлжээ зохицуулагч буюу network manager, суперадмин, админ эсвэл менежер устгах боломжтой. Хэрэглэгчийг системээс хасах шаардлагатай бол хэрэглэгчийн талаарх мэдээллийн дээд талын самбарт байгаа (хасах тэмдэгтэй) “Устгах” товчлуурыг дарна. Энэ үйлдэл эргэлт буцалтгүй байна, нэгэнт устгасан хэрэглэгчийг системийн дотроос сэргээх боломжгүй (устгагдсан хэрэглэгч дахин системд бүртгүүлэх шаардлагатай) тул хэрэглэгчийг утсгаж буй тохиолдолд “Устгах” товчлуурыг дарсны дараа дэлгэцэнд хэрэглэгчийг устгах гэж байгаа тухай анхааруулга гарна. Үйлдлийг батласан тохиолдолд устгагдсан хэрэглэгчийн нэвтрэх үг, и-мейл, нууц үг зэрэг хувийн мэдээлэл мөн адил устгагдана. Харин устгагдсан хэрэглэгчийн CSIS системд хийсэн өөрчлөлтийн (өөрчлөлтийн түүх, consite болон анхдагч мэдээллийн бүртгэлд байгаа газар нутгийн тухай мэдээлэлтэй холбоотой) тухай мэдээллийг хадгалах зорилгоор хэрэглэгчийн тухай мэдээлэл устгагдахгүй. Устгагдсан хэрэглэгч хэрэглэгчийн жагсаалтад харагдахгүй.

10.2. Хэрэглэгчийн эрх

Системийн хүрээнд хоёр янзын эрх байна. Нэг нь хэрэглэгчийн үүрэгт холбогдсон эрх, нөгөө нэг нь нутаг дэвсгэрийн нэгж эсвэл газар нутагт холбогдсон эрх болно.


⇒ Хэрэглэгчийн үүрэгт холбогдсон эрхийг системийн хүрээнд тохируулах боломжгүй, системийн өгөгдмөл (default) тохиргоогоос хамааралтай байна.

⇒ Нутаг дэвсгэрийн нэгжид холбогдсон үүргийг сүлжээ зохицуулагч (network manager), суперадмин, администратор, менежер зэрэг тохируулах боломжтой.

Хэрэглэгчийн үүрэгт холбогдсон эрх

CSIS-д өгөгдөл редакторлах эрхийг доор дурдсан үүрэг бүхий хэрэглэгчид дараах дэс дарааллаар олгох эрхтэй. Үүнд хамгийн бага тоогоор системийн хамгийн өндөр эрхтэй хэрэглэгчийг заасан байна (4 – тулган баталгаажуулагч буюу verificator, 5, 6-рт заасан үүрэгтэй хэрэглэгчдийн эрх дээрх дүрмээс бага зэрэг гадуур байна).

1. network manager (сүлжээ зохицуулагч, системийн техникийн администратор)
2. superadmin (CSIS мэдээллийн системийн гол администратор)
3. administrator (CSIS мэдээллийн систем эсвэл түүний хэсгийн администратор)
4. тулган баталгаажуулагч - verificator (байцаагч, өгөгдлийн чанар баталгаажуулагч)
5. менежер - manager (байгууллага эсвэл багийг төлөөлж өгөгдөл боловсруулах чанарыг хариуцсан ажилтан)
6. хураангуйлагч - epitomist (өгөгдөл оруулагч, тэмдэглэл боловсруулагч)
7. олон нийт - public (CSIS-д үндсэн бүртгэл хийсэн хэрэглэгч – иргэн, олон нийт)



Практикт системийг суперадмин болон администратор үүрэгтэй хэрэглэгчид удирдан захирдаг бөгөөд эдгээр нь гол болох эрхийг олгох, хасах асуудлаас гадна системийг хэрхэн ажиллуулах асуудлыг шийдвэрлэдэг. Ингэхэд сүлжээ зохицуулагчийн (network manager) системийн технологид орох эрх дээд түвшинд байгаа ч дээрх асуудлын хувьд суперадминд захирагдана. Гэтэл энэхүү эрх нь мэдээллийн системийн үйл ажиллагааг удирдан захирах ажилд хамаарахгүй, гагцхүү техникийн чанартай зохицуулалтыг хийх буюу технологийн аюулгүй болон саадгүй үйл ажиллагааг хангахад зориулагдсан.

Суперадмин үүрэгтэй ажилтан мэдээллийн системийн үйл ажиллагааны дүрмийг системийн мэргэжлийн зориулалтын талаас нь тодорхойлдог, мөн аргачлалын болон зохион байгуулалтын бүх асуудал, түүнчлэн үйл ажиллагааг удирдах асуудлыг шийдвэрлэнэ.

Сүлжээ зохицуулагч (network manager) технологи болон аюулгүй байдлын дүрмийг тодорхойлж өгч, суперадмины шаардлага хүсэлтийн дагуу системийн үйл ажиллагааны техникийн хангамжийн асуудлыг хариуцдаг. Үүнд бас өгөгдлийн аюулгүйн болон техникийн нэгдмэл байдал (өгөгдлийн техникийн чанар) хамаарна.

Администратор үүрэгтэй ажилтан мэдээллийн системийн үйл ажиллагааг мэргэжлийн зориулалт болон түүний мэргэжлийн агуулгын талаас нь удирдаж, өгөгдлийн мэргэжлийн чанарын эцсийн хяналт хийж, газар нутгийн тухай боловсруулсан тэмдэглэлийг баталж ажилладаг.

Тулган баталгаажуулагч (verificator) дэс дарааллын хувьд администратор, менежерын дунд оршдог хэдий ч хэрэглэгчдийг захирахын хувьд менежерийг захирахгүй, харин өгөгдлийнх нь хяналтын хувьд захирна. Өөрөөр хэлбэл 4-рт тавигдсан тулган баталгаажуулагч (verificator) 5, 6, 7 буюу менежер, хураангуйлагч, иргэд зэрэг үүрэг бүхий хэрэглэгчдийг захирдаггүй юм.

5-рт тавигдсан меженер өөрт нь захирагдах 6-рт тавигдсан хураангуйлагч (epitomist) үүрэг авсан ажилтнуудыг захирах эрхтэй болохоос биш өөрийнх нь байгууллагад холбогдоогүй олон нийт (public) үүрэгтэй хэрэглэгчдийг захирах эрхгүй.

6-рт тавигдсан хураангуйлагч (epitomist) үүрэг бүхий ажилтан овог, нэр, нүүц үг зэрэг өөрийн профайлын мэдээллээс бусад хэрэглэгчдийг захирах эрхгүй.

Нутаг дэвсгэрийн нэгж, газар нутагт холбогдох эрх

Нутаг дэвсгэрийн нэгж, газар нутагт холбогдох эрх хэрэглэгчийн CSIS системийн хүрээнд өөрчлөлт хийх боломжтой салбар, хэсгийг тодорхойлно. Ингэснээр CSIS системд мэдээлэл оновчтой оруулах, бусад хэрэглэгчдийн түгжсэн тэмдэглэлийг редакторлах боломжгүйгээс ажилтнуудад саад болохоос сэргийлэх үүднээс хэрэглэгч (менежер) тус бүрт нутаг дэвсгэрийн нэгж, газар нутагт холбогдох эрхийг олгож болно.

Нутаг дэвсгэрийн нэгжид холбогдох дээд зэргийн эрхийг доод зэргийн үүрэг бүхий хэрэглэгчийг захирдаг дээд зэргийн үүрэгтэй хэрэглэгч тохирч олгодог.

1. Жишээ нь, нийт Монгол Улсыг хамарсан тэмдэглэл редакторлах эрхтэй суперадминистратор бусад администратор тус бүрт ямар ч аймаг эсвэл суманд холбогдох эрх олгох боломжтой.

2. Ямар нэг аймаг (сум)-д холбогдох эрх авсан администратор менежерт тодорхой ямар нэг газар нутаг эсвэл аймаг (сум)-д холбогдох эрхийг өгч болно. Гэтэл суперадминистраторын зүгээс администраторт олгосон эрхэд хамаарсан нутаг дэвсгэрийн нэгжид орсон газар нутгийн эрхийг олгох боломжтой.

3. Менежер администраторын адилаар өөрт нь олгосон эрхийг байгууллагынхаа хүрээнд өөрийнхөө захирдаг хураангуйлагч (epitomist) үүрэгтэй хэрэглэгчдэд өгөх боломжтой.

Системийн хүрээнд нутаг дэвсгэрийн нэгжид холбогдох гурван янзын эрх бий.

R = read – read (унших) эрх авсан хэрэглэгч тухайн газар нутгийн талаар ConSite эсвэл анхдагч мэдээллийн бүртгэлд бүртгэгдсэн бүх мэдээллийг үзэх боломжтой боловч түүнд нэмэлт өөрчлөлт оруулах боломжгүй.

A = append – append (нэмж оруулах) эрх авсан хэрэглэгч тухайн бүс нутагт холбогдох анхдагч мэдэлэл оруулах боломжтой болохоос гадна түүнд нэмэлт өөрчлөлт оруулж, бохирдсон газрын бүртгэлд шилжүүлэх боломжтой. Харин цаашид REG_ConSite бүртгэлд оруулсан тэмдэглэлийг редакторлах боломжгүй.

M = modify – modify (нэмэлт өөрчлөлт оруулах, редакторлах) эрх авсан хэрэглэгч тухайн газар нутгийн хүрээнд аливаа өгөгдөлд өөрчлөлт хийх эрхтэй.

Хэрэглэгчид эрх олгох жүрам



Хэрэглэгчийн талаарх мэдээллийн цонхны баруун хэсэгт тухайн хэрэглэгчид олгосон эрхийн цэс байх бөгөөд тэнд ямар төрлийн болон ямар нутаг дэвсгэрийн нэгжид холбогдох эрх олгосон тухай мэдээллийг олж болно. Үүнээс гадна тэнд (суперадмины зүгээс) үүрэгт холбогдож олгосон эрх, дээд түвшингийн нутаг дэвсгэрийн нэгжээс шилжиж авсан эрх гэсэн эрхийн төрлийн тухай мэдээлэл орсон байна.

Нутаг дэвсгэрийн нэгжийн төрлийн дэргэд “нэмэх” тэмдгийн дүрс байх бөгөөд түүн дээр дарснаар тухайн нутаг дэвсгэрийн нэгжид холбогдох эрхийг нэмж олгоно. Эрхийг өөрчлөх шаардлагатай тохиолдолд “өөрчлөлт хийх” гэсэн утгатай “харандаа”-ны дүрс ашиглана. Түүн дээр дарснаар өөрчлөлт хийх эсвэл эрхийг устгах боломжуудыг багтаасан цэс гарч ирнэ.

10.3. Байгууллага, харилцах хүмүүсийн бүртгэлийг захирах

Байгууллагыг бүртгүүлэх / үүсгэх

Байгууллагыг гурван янзаар үүсгэх боломжтой. Үүнд,

1. Хэрэглэгчийг CSIS системд бүртгүүлэх үед байгууллагыг үүсгэх;
2. Администратор (эсвэл суперадминистратор)-ын зүгээс CSIS-ын веб интерфейсын тусламжтайгаар байгууллага үүсгэх;
3. CSIS Editor-ын тусламжтайгаар байгууллага (холбогдох хүний) бүртгэлийг үүсгэх.



CSIS системийн хүрээнд байгууллага, холбогдох хүмүүсийн бүртгэлийг өгөгдлийн нэг хүснэгтэд нэгтгэсэн. Ийм учраас нэгэнт ямар нэг байгууллагыг бүртгүүлсэн газрын холбогдох байгууллага болгож CSIS Editor-ын тусламжтайгаар оруулсан бол CSIS системийн веб сайтад байгууллагын жагсаалтад мөн орсон байна. Байгууллагын жагсаалтыг “Байгууллага” талбарт дарснаар харуулах боломжтой (менежерүүд үүнд “Менежмент” дэд цэснээс орж болно).

Байгууллагыг хэрэглэгчийг бүртгүүлэх үед үүсгэж байгаа бол түүний заавал оруулах бүх мэдээллийг бөглөх шаардлагатай. Байгууллагыг системд оруулсны дараа түүний харилцах и-мейлээр баталгаажуулах линк илгээгдэх бөгөөд хэрэглэгч уг линкийг ашиглан бөглөсөн харилцах мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулна. Ийм үе шатыг давж бүртгүүлсэн байгууллага системд баталгаажсан, харилцах ажилтан бүхий байгууллага болж харагдана. Дараагийн шатанд администратор веб интерфейсд байгаа өөрчлөлтийн хэсгийн (detail) тусламжтайгаар тухайн байгууллагын мэдээллийг хянан шалгаж үнэн зөвийг нь баталгаажуулах боломжтой.

Администратор байгууллагыг CSIS веб сайтаар шинэ байгууллага үүсгэхийг хүсвэл “Байгууллага” талбар дээр дарж (менежер үүнийг “Менежмент” дэд цэснээс олно) байгууллагуудын жагсаалт гарч ирнэ. Хэрэглэгчдийн жагсаалтын дээд хэсэгт байгаа “нэмэх” товчлуур дээр дарж шинэ байгууллагыг нэмэхэд зориулсан маягт нээгдэнэ. Үүнийг хэрэглэгч бөглөж дууссаны дараа “Үүсгэх” товчлуураар баталмагц байгууллагын жагсаалтад шинэ байгууллага бий болно.

Бохирдсон газрын тухай мэдээлэлд орсон харилцах байгууллагыг ашиглан CSIS Editor-ын тусламжтайгаар жагсаалтад шинэ байгууллагыг нэмж үүсгэх боломжтой.

Байгууллагуудыг удирдан захирах

Байгууллагуудыг CSIS веб сайтаар удирдан захирах боломжтой. CSIS Editor-ын тусламжтайгаар байгууллагуудын мэдээлэлд өөрчлөлт хийх боломжтой хэдий ч тэдгээрт олгосон эрх, салбар байгууллагуудын дэс дараалал зэрэгт өөрчлөлт хийх, хариуцлагатай төлөөлөгчид, менежерүүдийн бүртгэл хөтлөхөд хангалтгүй байна.

Администратор системийн гол веб сайтын цэсэнд “Байгууллага” талбар дээр (менежер үүнийг “Менежмент” дэд цэснээс олно) дарвал системийн бүртгэлд байгаа байгууллагуудын жагсаалт нээгдэнэ. Жагсаалтыг байгууллагуудын нэр, хариуцлагатай ажилтан, харилцах и-мейл зэргээр жагсаах боломжтой. Байгууллагын нэрийн зүүн талд байгаа сум дээр дарснаар байгууллагын тухай мэдээлэл нээгдэнэ.

Үүнд байгууллагын тухай олдож буй бүх мэдээлэл орсон байна. Мэдээллийн цонхны дээд хэсэгт байгууллагыг баталгаажуулах, заасан и-мейл хаягаар нь баталгаажуулах и-мейл илгээх, эрхийг нь хаах, байгууллага устгах зэрэг товчлуурууд байна.

Байгууллагыг бүртгүүлэх үед түүний хаягаар и-мейл илгээгдээгүй тохиолдолд и-мейл агуулагдсан баталгаажуулах линк дээр дарж баталгаажуулалт хийх хүртэл и-мейл дахин дахин илгээх боломжтой.




Байгууллага баталгаажуулах товчлуур (ногоон чагт) администраторын зүгээс бусад мэдээллийн үнэн зөвийг батлах зориулалтай. Администратор нь одоогоор баталгаажаагүй байгууллагад засварлалтын ямар нэг хэмжээний эрх олгох эсвэл менежер үүрэг өгөх бүрт энэ товчлуурыг хэрэглэх нь зүйтэй. Администратор “Менежер” үүрэг өгснөөр засварлагч программд нэвтрэх эрх олгохын зэрэгцээ төв мэдээллийн сангийн өгөгдөл засварлах боломжийг нээж байдаг тул эрх хүссэн байгууллага, түүний мэдээллийн үнэн зөв, ялангуяа хариуцлагатай ажилтан, менежер үүрэгтэй бүх ажилтнууд, и-мейл хаягийнх нь үнэн зөвийг хянан шалгах зайлшгүй шаардлагатай. Администратор дээрх ажилтнууд, байгууллагуудын тухай мэдээллийг өөрөө сайн мэдэхгүй байвал тухайн байгууллагад хандаж сайтар хянан шалгах хэрэгтэй. Нарийн хяналт шалгалт хийсний дараа байгууллагыг баталгаажуулах товчлууpаар батална. Байгууллагын эрх хаах зориулалттай цоожны дүрстэй товчлуурыг тухайн байгууллагад холбогдсон бүх хэрэглэгчдийн эрхийг нэг мөсөн хаах зорилгоор ашиглах боломжтой. Эрх нь хаагдсан байгууллагын бүх хэрэглэгчид CSIS системд нэвтрэх боломжгүй болсон байна. Эрх нь хаагдсан байгууллагын эрхийг сэргээхийн тулд системийн удирдлагууд зориулалтын товчлуурыг ашиглана.

Хасах тэмдгийн дүрстэй баруун гар талын хамгийн сүүлийн товчлуурыг байгууллагыг устгахад ашиглана. Байгууллагад газар нутгийн ямар ч тэмдэглэл, мэдээлэл эсвэл хэрэглэгч холбогдоогүй тохиолдолд устгах боломжтой. Байгууллагад холбогдсон бүх мэдээлэл устгагдаагүй байтал түүнийг устгах боломжгүй байна.

Байгууллагын салбарууд

Байгууллага бүр салбартай байж болно. Системд улсын хэмжээнд нэгээс илүү салбартай ажилладаг том байгууллагуудын шаардлагыг харгалзан дээрх боломжийг нэвтрүүлсэн. Иймийн тулд системд ижил нэр, улсын бүртгэлийн дугаар бүхий боловч захирагдах байгууллагад холбогдсон байгууллагыг үүсгэх боломжтой.

Байгууллага үүсгэх эсвэл засварлах үед байгууллагын засварлах маягтын доод хэсэгт байгаа **“Өөр толгой байгууллагыг хайх”** талбарын тусламжтайгаар тухайн үед засварлаж буй охин байгууллагад хамаарах байгууллагыг хайх боломжтой.




Ийм үе шатчилсан дэс дарааллаар байгууллагын тухайн салбарын хэрэглэгчдийг менежерүүдийн дунд эрх мэдлийнх нь дагуу хуваарилах боломжтой. Салбарын менежер гагцхүү өөрийн салбарын (хураангуйлагч, иргэн) хэрэглэгчдийн эрх, түүнчлэн системд нэвтрэх эрхэд өөрчлөлт хийх, хэрэглэгчийг устгах эрхтэй байдаг.

10.4. Хэрэглэгч, байгууллагын холбоо харилцаа



Хэрэглэгч зөвхөн нэг байгууллагад харъяалагдан бүртгүүлэн боломжтой. Хэрэглэгчийг байгууллагад CSIS системд бүртгүүлэх үед эсвэл администраторын зүгээс администраторын интерфейсээр хэрэглэгчийн мэдээллийг засварлах үед харъяалах боломжтой.



Хэрэглэгчийг түүний мэдээллийн цэсэнд агуулагдсан засварлах маягтын тусламжтайгаар байгууллагад холбож өгөх боломжтой. Эхний шатанд байгууллагыг нэр эсвэл улсын бүртгэлийн дугаараар нь хайлт хийж олно. Хайсан байгууллага олдсон

бол хэрээсний талбарыг тэмдэглэж, хэрэглэгчийн засварласан өгөгдөл бүхий маягтыг хадгална. Хэрэглэгчийг нэгээс илүү байгууллагад харъяалуулах шаардлагатай нөхцөлд тэр нь нэгээс илүү нэвтрэх нэр, и-мейл хаягтай байна.

10.5. Ажиглагдах үзүүлэлтүүдийн каталоги

CSIS мэдээллийн системийн администраторууд веб интерфейсээр дамжуулан системд **ажиглагдах үзүүлэлтүүдийг** шаардлага хэрэгцээнд нийцүүлэн тохируулах боломжтой. Өөрчлөлт нь мэдээллийн сангийн бүтцэд нөлөөлдөг мэдээллийн сангийн хөдлөнгө хэсгийг тохируулахыг хэлж байна. Үүнд шинэ үзүүлэлтийг ажиглах зорилгоор өгөгдлийн шинэ хүснэгт эсвэл урьд ажиглалтад байлгасан үзүүлэлтийг шинэ орчинд нь ажиглагдах зорилгоор шинэ хүснэгтийг зохиох боломжтой. Ийм үйлдлээр мэдээллийн санд ноцтой өөрчлөлт хийх учир администратор каталогийн үйлдлүүдтэй төгс танилцсан байхаас гадна нэмж буй үзүүлэлтийн шинж чанар, ялангуяа хими эсвэл физикийн утга байвал шинж чанартай нь сайтар танилцсан байна. Ямар нэгэн утгыг заахад түгээмэл хэрэглэдэг нэгж, ямар төрлийн орчинд, ямар нэгжээр оруулж болох талаар мэдлэгтэй байна. Түүнчлэн үзүүлэлт, утгын тухай тайлбар, утгын хайлт хийхэд түүний тохиолдож болох өөр бусад нэр, товчлол зэргийг оруулна. Жишээ нь, PCE товчлолыг оруулбал тетрахлор, тетрахлорэтилен, перхлор зэрэг хувилбар нэрийг бичнэ.

CSIS-ын хүрээнд ажиглагддаг үзүүлэлт ямар нэг физикийн эсвэл химийн тоон утга, ямар нэг төрлийн тохиолдлын тоо хэмжээ, ус цагуурын утга эсвэл товч бичвэр ч байж болохоос үзвэл мэдээллийн сан ямар ч зүйлийг бараг хязгааргүй ажиглах боломжтой болгодог. Ингэхэд лабораторийн шинжилгээний үр дүнгээр зогсохгүй каталогит төрөл бүрийн санхүүгийн зардал, устах аюул нүүрлэсэн амьтад эсвэл ургамал, цаг агаарын өөрчлөлтөөс хамаарах хамаарал зэргийн ажиглалтыг нэмж оруулж болно.

Администратор “Ажиглагдах үзүүлэлтүүд” линк дээр дарвал одоогоор оруулсан үзүүлэлтийг багтаасан хүснэгт нээгдэнэ. Ажиглагдах үзүүлэлтүүдийг ялгагч тэмдэг (identifier), тэмдэг, нэр эсвэл бүлгээр цэгцлэх боломжтой. Утгын хайлтыг мөн хувилбар нэр эсвэл олон улсын CAS дугаарын дагуу хийж болно. Администраторууд ажиглагдах үзүүлэлтүүдийн тухай мэдээлэл, түүнчлэн оновчтой танилцуулга, эрсдэл, хорт чанар эсвэл хорт хавдар үүсгэх шинж чанарын тухай мэдээлэл зэргийг хүснэгтэд аль болох бүрэн оруулсан байх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй.

Шинэ үзүүлэлтийг “нэмэх” дүрстэй “Шинэ үзүүлэлт” (New item) гэсэн тайлбартай товчлуур дээр дарснаар нэмэх боломжтой. Энэ товчлуур дээр дарсны дараа шинэ үзүүлэлт (утга) үүсгэх маягт нээгдэх бөгөөд уг маягтын заавал бөглөх бүх талбарыг бөглөнө.




Үзүүлэлтийг засварлах (Edit)

Үзүүлэлтүүдийг цаашид зөвхөн CSIS-ын хөдлөнги хэсэгт хадгалагдсан өгөгдөлд нөлөө үзүүлэхгүй талаас нь өөрчлөн засварлах боломжтой. Иймм учраас нэгэнт заасан нэгжийг өөрчлөх боломжгүй.



Адимнистратор утгын үзүүлэлтийг өөрчилсний улмаас бөглөж оруулсан утгын учир өөрчлөгдөнө гэж анхааралдаа авах шаардлагатай учир аливаа өөрчлөлтийг мэргэжлийн талаас сайтар бэлтгэж, болгоомжилж хийх нь зүйтэй. Хэтэрч болохгүй хэмжээг мөн адил сайтар бэлтгэл хийж оруулна.

10.5.1. Үзүүлэлт ба утгын хүснэгтийн хоорондын холбоо.




Шинэ үзүүлэлтийг оруулснаар мэдээллийн санд нэгж эсвэл “хэмжээшгүй” буюу "dimensionless" гэсэн нэр томъёогоор тодорхойлсон орчин (газар доорх ус = GW, гадаргын ус = SW, хатуу бодис = SM) тус бүрийн дээжийн утгын шинэ хүснэгт үүснэ.

Дээрх шалтгаанаар бодис/орчны засварлалт хийх үед нэгжийг өөрчлөх боломжгүй. Администратор өөрчлөлтийг хадгалах үед оруулсан өгөгдлийг сайтар шалгахыг хатуу анхааруулсан байна. Өгөгдлийг хянан шалгаж үнэн зөв болох тухай “тийм” гэсэн үгийг дарж баталгаажуулна. Энэ алхам мэдээллийн сангийн бүтцэд ноцтой нөлөөтэй учир үүнийг дутуу үнэлэлгүй, өндөр анхаарал хандуулж ажиллана уу.


10.6. Анхдагч мэдээллийг удирдан захирах

Хэрэглэгч CSIS системээр дамжуулан анхдагч мэдээллийг үүсгэснээр бохирдсон байж болох сэжиг бүхий газрын тухай анхны тэмдэглэл бий болно. Веб интерфейсийн тусламжтайгаар бүртгэгдсэн бүх хэрэглэгчид анхдагч мэдээллийг үүсгэх боломжтой. Анхдагч мэдээлэл бий болмогц цаашид ямар арга хэмжээ авах асуудлыг мэргэжилтнүүд (хураангуйлагч, менежер, администратор, суперадмин зэрэг үүрэг бүхий хэрэглэгчид) шийдвэрлэнэ. Системд анхдагч мэдээлэлд дүгнэлт хийгдсэн эсэх мэдээлэл харагдаж байгаа учир бохирдсон байж болох газрын тухай анхны мэдээлэл өгсөн хэрэглэгч түүний өгсөн мэдээллийн дагуу шалгалт хийгдсэн эсэхийг мэдэх боломжтой. Анхдагч мэдээлэл шалгагдаж эхэлсэн бол ямар үр дүн гарсныг мэдэж болно.

10.6.1. Анхдагч мэдээллийг үүсгэх



(Анхдагч мэдээллийн бүртгэлийг үзнэ үү). Хэрэглэгч цэснээс “Газрын тухай мэдэгдэл өгөх”-ийг сонгож авахдаа дэлгэцэнд нээгдэх газрын зурган дээр тухайн газрыг олж тэмдэглэх боломжтой. Газрын нэрийг мөн хайлтын талбарт оруулж хот суурин газар, тосгон (газар)-ы дотроос олж болно. Газрыг олмогц алдалгүй зааж өгөхийн тулд газрын зургийг томруулах нь зүйтэй. Газрын зурган дээр хулганаар дарж өгсөн газарт цэг үүсч, түүний эргэн тойрон системд урьд нь оруулсан бүх анхдагч мэдээлэл, бохирдсон газрыг багтаасан дөрвөлжин гарч ирнэ. Цаашид, уг дөрвөлжинд хэрэглэгчийн тэмдэглэж өгсөн газар байгаа эсэх асуулт гарч ирнэ. Тийм байвал хэрэглэгчийн мэдэгдэж өгөх гэж байгаа газар системд бүртгэгдсэн байгаа тул цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй. Уг дөрвөлжин зааж өгөх гэж байгаа газар байхгүй тохиолдолд хэрэглэгч заасан газар мөн гэдгийг батлана. Газрыг тэмдэглэж өгсний дараа систем түүний тухай заавал оруулах мэдээллийг бөглөж оруулахыг шаардах бөгөөд газар нутгийн нэр, газрын нэр, бохирдлын төрөл, эх үүсвэр, шинж чанар, гарч болзошгүй эрсдэл зэргийг бөглөнө. Маягтыг бөглөж өгөхөд “боловсруулагдаагүй” гэсэн системээс өгсөн үе шаттай шинэ анхдагч мэдээлэл үүснэ. Хэрэглэгч газрын тухай дэлгэрэнгүй мэдээллийн маягт руу орж тухайн газрын зураг, гэрэл зураг зэргийг нэмж оруулах боломжтой.



10.6.2. Миний мэдэгдсэн газрууд

“Миний мэдэгдсэн газрууд” (My reported Sites) талбарт дарвал хэрэглэгч өөрийнхөө оруулсан анхдагч мэдэгдлийн тухай мэдээллийг шалгах боломжтой. Үүнд боловсруулан шалгагдаж буй байдлыг харж болох, анхдагч мэдээлэл бохирдсон газар болж шилжсэн тохиолдолд түүнд орох линкийг өгсөн байна. Анхдагч мэдээллийн дэргэдэх суманд дарвал түүний дэлгэрэнгүй мэдээлэл нээгдэнэ.

Анхны мэдэгдэл хийсэн газрын тухай дэлгэрэнгүй мэдээлэл

Анхдагч мэдээллийн дэлгэрэнгүй хэсэгт “Эмхэтгэсэн мэдээ”, “Газрын зураг”, “Зураг” цэснүүд байх бөгөөд администраторууд “Анхдагч мэдээллийн боловсруулагдсан байдал” цэсийг ашиглах боломжтой.

“Зураг” цэсэнд хэрэглэгч өөрийн эрхээс хамааран зураг нэмэх, хасах боломжтой, “Эмхэтгэсэн мэдээ” цэсэнд анхны мэдээлэлд заасан газрын тухай мэдээллийг засварлах боломжтой.

Администраторууд “Анхдагч мэдээллийн байдал” хэсэгтээ түүний байдал, дүгнэлт хийх шаардлагын түвшинг өөрчлөх боломжтой. Яаралтайн түвшинг тодорхойлсноор (компаниудын) ажилтнуудын судалгаа, зураглалын ажлыг удирдах боломжтой бөгөөд үүнийг администратор, менежерүүдийн аль аль нь хийх эрхтэй. Анхдагч мэдээллийн байдал “REG_Consites бүртгэлд шилжүүлсэн” болмогц сэжиг бүхий газар бохирдсон газар болж хувирч байгаа ба уг мэдээлэл үүнээс хойш зөвхөн уншихад зориулагдсан.

Чухал анхааруулга! Дээрх алхам дахин засагдашгүй болохыг анхаарна уу!

10.6.3. Бүх анхдагч мэдээлэл

Системд бүртгэгдсэн бүх анхдагч мэдээллүүдийг цэснээс “Бүх анхдагч мэдээлэл” сонголт хийж харуулах боломжтой бөгөөд үүнд CSIS-д бүртгэгдсэн бүх хэрэглэгчид

нэвтрэх эрхтэй байдаг. Нутаг дэвсгэрийн нэгжид холбогдсон эрхийн дагуу мэдээлэлд өөрчлөлт хийх эрхийг хураангуйлагчид (epitomist) эдлэнэ.

10.6.4. Анхдагч мэдээллийг боловсруулах, шалгах шаардлагын түвшинг тодорхойлох, Reg_ConSite бүртгэлд шилжүүлэх

Анхдагч мэдээллийг шалгах шаардлагыг тодорхойлох

Анхдагч мэдээллийг шалгах шаардлагыг менежер, администратор эсвэл суперадминистратор тодорхойлох боломжтой. Анхдагч мэдээллийн дэлгэрэнгүй хэсэг дэхь “Анхдагч мэдээллийн байдал” талбар нээгдсэний дараа анхдагч мэдээллийг шалгах шаардлагад өөрчлөлт оруулж болох сонголтын цэс гарч ирнэ.

Анхдагч мэдээллийн байдлыг тодорхойлох

Анхдагч мэдээллийг шалгах шаардлагыг менежер, администратор эсвэл суперадминистратор тодорхойлох боломжтой. Анхдагч мэдээллийн дэлгэрэнгүй хэсэг дэхь “Анхдагч мэдээллийн байдал” талбар нээгдсэний дараа анхдагч мэдээллийн шалгагдсан байдалд өөрчлөлт хийж, анхдагч **мэдээллийг REG_ConSites бүртгэлд шилжүүлэх боломжтой. Мэдээллийн байдлыг 4-рт REG_ConSites рүү шилжүүлэх шатанд тавьбал анхдагч мэдээлэл REG_ConSites бүртгэлд шилжинэ.**

10.7. REG_ConSites бүртгэл



10.7.1. Газар нутгийн жагсаалт

Газар нутгийн бүх мэдээллийг веб интерфейсээр удирдан захирах болон үзэх боломжтой. Хэрэглэгч түүний хоёр хэсгээр хуваагдсан байдлаар харна. Эхний бүлэгт боловсруулсан болон батлагдсан бүх газар нутаг багтах ба хоёр дахь бүлэгт батлагдсан газар нутаг орно. Газар нутгийн тэмдэглэл засварлагдах явцад системийн администраторын зүгээс тэр болгон батглагдахгүй тул администратор газар нутгийн тэмдэглэлийг батласан тохиолдолд тэр нь эхний бүлгээс батлагдсан тэмдэглэлийн бүлэгт шилжинэ.

Уг жагсаалтууд цэсэнд “Бохирдсон болон бохирдсон байж болох газрын бүртгэл” хэсэг талбарт оршдог. Аль ч талбарын дэлгэрэнгүй хэсэг дээр дарсан тохиолдолд дээр нь хайлтын шүүлтүүр байрлуулсан газар нутгийн жагсаалт байна. Уг хайлтын тусламжтайгаар шаардлагатай газар нутгийг жагсаалтаас түргэн шуурхай олох боломжтой.

10.8. Батлагдсан газар нутгийн жагсаалт



Батлагдсан газар нутгийн жагтсаалтыг CSIS системийн бүх хэрэглэгчид үзэх боломжтой. “Олон нийт” („public“) үүрэгтэй хэрэглэгчид батлагдснаас бусад үе шатанд боловсруулагдаж буй газар нутгийг үзэх боломжгүй, гагцхүү батглагдсан газар нутгийг үзнэ.

Газар нутгийг засварлах эрхтэй хэрэглэгчид буюу хураангуйлагч, менежер, администратор, суперадминистратор үүрэгтэй хэрэглэгчид батглагдсан газар нутаг (бүртгүүлсэн хэрэглэгчдийн үзэх боломжтой), бүх газар нутгийн жагсаалтын аль алиныг үзэх боломжтой.

10.8.1. Газар нутгийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл 

Газар нутгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг газар нутгийн нэрийн зүүн талд байгаа суманд дээр дарж харуулна. Дэлгэрэнгүй мэдээлэл нээгдсний дараа хэрэглэгч өөрийн сонирхсон мэдээллийн бүлгээс сонгож авах боломжтой. Бүлэг тус бүр хуудасны дээд хэсэгт багцаар тэмдэглэгдсэн байна. Хэрэглэгч дараах боломжоос сонголт хийж болно. Үүнд,

- ⇒ Газар нутгийн тухай эмхэтгэсэн мэдээ
- ⇒ Газрын зураг
- ⇒ Секторууд
- ⇒ Баримтжуулалтын цэгүүд
- ⇒ Баримт бичгүүд
- ⇒ Зураг
- ⇒ Дээж / утга
- ⇒ Батлах үйл явц (гагцхүү баталгаажуулагч, администратор, суперадминуудад зориулсан)

Бүлэг тус бүрийн хүрээнд газар нутгийн тухай олдсон бүх мэдээлэл харагдаж байна. Системийн веб хэсгийн хэрэглэгчид дээрх мэдээллийг зөвхөн унших боломжтой боловч “Батлах үйл явц”, “Зураг”, “Баримт бичиг” зэргээс бусад зүйлд өөрчлөлт хийх эрхгүй.

Программын веб хэсэгт газар нутгийн өгөгдөл засварлах (edit) боломж байхгүй, программын энэ хэсэг системийн өгөгдлийг олон нийтэд толилуулах, хянах зориулалттай.

10.8.2. Зураг, баримт бичиг

Энэ багцад газар нутагт холбогдсон зураг, бичиг баримтын жагсаалт харагдана. нутаг дэвсгэр эсвэл үүрэгт холбогдсон газар нутгийг засварлах эрхтэй хэрэглэгч жагсаалтын доор байрлуулсан маятыг ашиглан тухайн газар нутагт зураг (баримт бичиг) нэмж хавсаргах эсвэл хасах боломжтой. Тийм эрх байхгүй хэрэглэгчид мэдээллийг зөвхөн уншиж болно.


Газар нутгийн талаарх тэмдэглэл батлах үйл явцын хүрээнд баталгаажуулагч (администратор) шийдвэр гаргахад үндэс болсон материалыг нэмж оруулах шаардлагатай тохиолдолд зураг, баримт бичгийг хавсаргах боломж их ашигтай байдаг. Ийм аргаар бас албаны шийдвэр, тогтоолыг хавсаргах боломжтой.

10.8.3. REG_ConSite бүртгэл дэх газар нутгийг батлах үйл явц

Газар нутгийн боловсруулагдсан жагсаалтан дээр системд агуулагдсан өгөгдлийн чанарын баталгаа болох газар нутгийг баталгаажуулах үйл явц зохиогдсон байна. Газар нутгийг төв мэдээллийн санд оруулахад дараах 5 үе шатнаас бүрдсэн баталгаажуулах процессоор дамжина.

1. боловсруулагдаж буй / record in process
2. тулган баталгаажуулахад бэлтгэсэн / authorized for validation
3. тулган баталгаажуулагдсан, батлуулахад бэлэн болсон тэмдэглэл / validated for ratification
4. батлагдсан тэмдэглэл / ratified record
5. дахин боловсруулах шаардлагатай / record to rectification

Эхний үе шатанд байгаа тэмдэглэл засварлах (edit) горимд байгаа ба түүнийг “хураангуйлагч” („epitomist“) эсвэл менежер засварладаг. Хоёр дахь үе шатанд менежер газар нутгийн тэмдэглэлд хийгдсэн өөрчлөлтийг батлаж “тулган баталгаажуулагчид” (verificator) баталгаажуулахаар шилжүүлнэ. Тулган баталгаажуулагч боловсруулсан тэмдэглэлийн чанарыг мэргэжлийн талаас нь дүгнэх үүрэгтэй. Тэмдэглэл дутагдалтай боловсруулагдсан тохиолдолд түүнийг хэрэглэгчид засахаар буцаах боломжтой – тэмдэглэлийн байдлыг 5 дээр тавина. Тэмдэглэл ямар нэгэн дутагдалгүй зөв байгаа бол түүнийг 3 дээр тавьснаар администраторт тэмдэглэлийг зөв байгаа учир батлах боломжтой гэдгийг мэдээлж байна. Гэтэл администратор тэмдэглэлийг батлахаас татгалзах ямар нэгэн үндэслэл, шалтгаан байвал тэмдэглэлийн байдлыг 5 дээр тавина. Үгүй бол түүнийг батлаж, байдлыг нь 4 дээр тавина. Ингэмэгц тэмдэглэл баталсан газар нутгийн жагсаалтад хувилагдана.



Тулган баталгаажуулагч (verificator), администратор (суперадминистратор) тэмдэглэл батлах процессын явцад газар нутгийн дэлгэрэнгүй хэсэг дэх “Батлах процесс” багцыг ашиглах боломжтой.

